БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧИЙГ МЭРГЭШҮҮЛЭХ АХИСАН ШАТНЫ СУРГАЛТЫН ГАРЫН АВЛАГА

(III ЦУВРАЛ)

Байгаль орчны хяналтын улсын байцаагч, улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч, байгаль хамгаалагч нарт зориулав.

Захиалагч:

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ

Санхүүжүүлж, зохион байгуулсан:

WWF

ДЭЛХИЙН БАЙГАЛЬ ХАМГААЛАХ САН (WWF)-ИЙН МОНГОЛ ДАХЬ ХӨТӨЛБӨРИЙН ГАЗАР

Гүйцэтгэсэн:

ОЛОН УЛСЫН УЛААНБААТАРЫН ИХ СУРГУУЛЬ

OTGONTENGER UNIVERSITY SINCE 1991

ОТГОНТЭНГЭР ИХ СУРГУУЛЬ

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

Хамтран ажилласан:

МОНГОЛЫН БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧДЫН ХОЛБОО

германы хамтын ажиллагаа DEUTSCHE ZUSAMMENARBEIT

KFW

БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ ТӨСӨЛ

USDA FOREST SERVICE

ЗЭРЛЭГ АМЬТАН, УРГАМЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ ТӨСӨЛ

германы хамтын ажиллагаа DEUTSCHE ZUSAMMENARBEIT

ГЕРМАНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ НИЙГЭМЛЭГ (GIZ)

Улаанбаатар хот
2025 он

ДАА: 351.84
ННА: 20.18
Б-174

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ:

Ерөнхий редактор:
Б.Чимэддорж, Ц.Уранчимэг, С.Пүрэвсүрэн

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн:
С.Баярхүү, С.Цэндсүрэн, П.Сайнбилэг, О.Баярмаа, М.Амгалан, Ч.Бат-Өлзий, Маркус Пеш

Хянаж, хэвлэлд бэлтгэсэн:
Зөвлөх С.Пүрэвсүрэн

Зохиогчийн эрх:
© Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
© Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар

Хавтас, хавчуулга зураг:
© Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар, М.Уганбаяр

ISBN: 978-9919-9323-2-9

ЗОХИОГЧИД:

М.Эрдэнэбаяр
Олон улсын Улаанбаатарын их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал, хууль зүйн доктор (Ph.D), дэд профессор

Г.Бямбадорж
Отгонтэнгэр их сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн багш, хууль зүйн доктор (Ph.D)

Д.Бадамцэцэг
Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, хууль зүйн доктор (Ph.D)

Х.Тэрбиш
Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Биологийн тэнхимийн зөвлөх профессор, доктор (Ph.D)

С.Пүрэвсүрэн
Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газрын зөвлөх

ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ 6

Үндэслэл ба зорилго 7
Сургалтын хэлбэр ба хэрэглэгдэхүүн 8
Зөрчил болон зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн бодлого бодох аргачлал 9
Байгаль хамгаалагчийн үүргээ хэрэгжүүлэх “найман алхамт” дараалал 12

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЗӨРЧИЛ ИЛРҮҮЛЭХ, ШАЛГАХ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ, ОНЦЛОГ 14
1.1. Гэмт хэрэг ба зөрчлийн ялгаа, онцлог 15
1.2. Зөрчил илрүүлэн шалгах эрх зүйн үндэслэл 17
1.3. Зөрчлийн тухай ойлголт, шинж, зөрчил үйлдсэн хугацаа ба газар, шийтгэл болон албадлагын арга хэмжээ, тэдгээрийн төрөл 24
1.3.1. Зөрчлийн тухай ойлголт, шинж 24
1.3.2. Зөрчил, түүнийг үйлдсэн хугацаа ба газрын тухай ойлголт 28
1.3.3. Шийтгэл, түүний төрөл ба шийтгэл хүлээх хүн, хуулийн этгээдийн тухай 28
1.3.4. Албадлагын арга хэмжээ, түүний төрөл 32
1.4. Зөрчлийн тухай хуульд заасан зарчим, үйлчлэх нутаг дэвсгэр, хөөн хэлэлцэх хугацаа 33
1.4.1. Зөрчлийн тухай хуульд заасан зарчим 33
1.4.2. Зөрчлийн тухай хууль үйлчлэх нутаг дэвсгэр 33
1.4.3. Зөрчлийн хөөн хэлэлцэх хугацаа 34
1.5. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны тухай 36
1.5.1. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны хэл, бичиг 36
1.5.2. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны хугацаа тоолох журам 37
1.5.3. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны нууцлал 37
1.5.4. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харъяалал 38
1.6. Зөрчлийн хэрэг бүртгэлт 39
1.6.1. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах үндэслэл 39
1.6.2. Зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл хүлээн авах журам 39
1.6.3. Зөрчлөө илчлэн мэдээлэх 40
1.6.4. Зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлэх 41
1.6.5. Зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзах 41
1.6.6. Хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх 41
1.6.7. Зөрчлийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээх 42
1.6.8. Зөрчлийн хэрэг бүртгэлтийн хугацаа 43
Мэдлэг сорих тест 44

ХОЁРДУГААР БҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧИН, АМЬТАН, УРГАМЛЫГ ХАМГААЛАХ ЖУРМЫН ЭСРЭГ ХЭРЭГ ЗӨРЧЛИЙН МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ, ҮЗЛЭГ ХИЙХ АРГА ТЕХНИК 51
2.1. Мэдээллийн эх сурвалж 52
2.1.1. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын мэдээлэл 53
2.1.2. Төрийн байгууллагын мэдээлэл 57
2.1.3. Сошиал буюу нийтийн мэдээлэл 59

2.2. Мэдээлэл цуглуулах арга, ажиллагаа 60
2.3. Хамтын ажиллагаа 63
2.4. Хэргийн газрын үзлэг, арга техник ба аюулгүй ажиллагаа 67
2.5. Тээврийн хэрэгсэлд хийх үзлэг, арга техник ба аюулгүй ажиллагаа 79
2.5.1. Тээврийн хэрэгслийн тухай ойлголт, түүний төрөл 79
2.5.2. Тээврийн хэрэгсэлд үзлэг хийх эрх зүйн үндэслэл 79
2.5.3. Тээврийн хэрэгсэлд үзлэг хийсэн тэмдэглэл хөтлөх 80
2.5.4. Тээврийн хэрэгслийг зогсоож шалгах 81
2.5.5. Тээврийн хэрэгсэл, ачаа тээшинд үзлэг хийх арга тактик ба аюулгүй байдлыг хангах ажиллагаа 81
2.6. Галт зэвсэгт хийх үзлэг, арга техник ба аюулгүй ажиллагаа 85
2.6.1. Галт зэвсгийн тухай ойлголт, түүний зориулалт ба төрөл 85
2.6.2. Галт зэвсэгт үзлэг хийх эрх зүйн үндэслэл 87
2.6.3. Галт зэвсэг илрүүлвэл анхаарах зүйлс 87
2.6.4. Галт зэвсэгт үзлэг хийсэн тэмдэглэл хөтлөх 88
2.6.5. Галт зэвсэг бүхий сэжигтэй этгээдийг шалгах ажиллагаа 89
2.6.6. Галт зэвсгийн аюулгүй ажиллагаа ба шалгах арга, техник 90
2.7. Эд мөрийн баримтад хийх үзлэг, арга техник 94
2.7.1. Нотлох баримтыг бэхжүүлэх 96
2.7.2. Биологийн гаралтай эд зүйлийг хураан авах ажиллагаа 97
2.7.3. Биологийн гаралтай эд эрхтэн, зүйлсийг хадгалах 99
2.8. Шинжилгээ хийлгэх ажиллагаа 100
2.9. Мэдүүлэг авах, ярилцлага хийх арга техник 111
Дадлага, дасгал 118
Мэдлэг сорих тест 126

ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧИН, АМЬТАН, УРГАМЛЫГ ХАМГААЛАХ ЖУРМЫН ЭСРЭГ ЗӨРЧЛИЙН ШИНЖ, ОНЦЛОГ, АНХААРАХ АСУУДАЛ 133
3.1. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль зөрчих, зөрчлийн шинж, онцлог, анхаарах асуудал 134
3.1.1. Шийтгэл, эрх бүхий албан тушаалтан ба харьяалал, нэр томъёоны тайлбар 134
3.1.2. Зөрчлийн ойлголт, шинж ба төсөөтэй гэмт хэргээс ялгагдах шинж 135
3.1.3. Зөрчлийн зүйлчлэл 138
3.1.4. Зөрчлийг шалгах тодорхой ажиллагаа 139
3.1.5. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд анхаарах асуудал 140
3.2. Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль зөрчих, зөрчлийн шинж, онцлог, анхаарах асуудал 154
3.2.1. Шийтгэл, эрх бүхий албан тушаалтан ба харьяалал, нэр томъёоны тайлбар 154
3.2.2. Зөрчлийн ойлголт, шинж ба төсөөтэй гэмт хэргээс ялгагдах шинж 155
3.2.3. Зөрчлийн зүйлчлэл 158
3.2.4. Зөрчлийг шалгах тодорхой ажиллагаа 158
3.2.5. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд анхаарах асуудал 160
3.3. Агаарын тухай хууль зөрчих, зөрчлийн шинж, онцлог, анхаарах асуудал 173
3.3.1. Шийтгэл, эрх бүхий албан тушаалтан ба харьяалал, нэр томъёоны тайлбар 173
3.3.2. Зөрчлийн ойлголт, шинж ба төсөөтэй гэмт хэргээс ялгагдах шинж 177
3.3.3. Зөрчлийн зүйлчлэл 181
3.3.4. Зөрчлийг шалгах тодорхой ажиллагаа 181
3.3.5. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд анхаарах асуудал 183

3.4. Амьтны тухай хууль зөрчих, зөрчлийн шинж, онцлог, анхаарах асуудал 190
3.4.1. Шийтгэл, эрх бүхий албан тушаалтан ба харьяалал, нэр томъёоны тайлбар 190
3.4.2. Зөрчлийн ойлголт, шинж ба төсөөтэй гэмт хэргээс ялгагдах шинж 193
3.4.3. Зөрчлийн зүйлчлэл 202
3.4.4. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа ба анхаарах асуудал 202
3.5. Байгалийн ургамлын тухай хууль болон Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль зөрчих, зөрчлийн шинж, онцлог, анхаарах асуудал 217
3.5.1. Байгалийн ургамлын тухай хууль зөрчих зөрчлийн ойлголт, шинж, харьяалал ба төсөөтэй гэмт хэргээс ялгагдах шинж 217
3.5.2. Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль зөрчих зөрчлийн шинж, онцлог, шийтгэл ба харьяалал 223
3.5.3. Байгалийн ургамлын тухай хууль зөрчих зөрчлийг шалгахад анхаарах зарим асуудал 229
3.6. Ойн тухай хууль зөрчих, зөрчлийн шинж, онцлог, анхаарах асуудал 240
3.6.1. Шийтгэл, эрх бүхий албан тушаалтан ба харьяалал, нэр томъёоны тайлбар 240
3.6.2. Зөрчлийн шинж, онцлог ба төсөөтэй гэмт хэргээс ялгагдах шинж. 244
3.6.3. Ойн тухай хууль зөрчих зөрчлийг шалгахад анхаарах зарим асуудал 249
3.7. Газрын хэвлийн тухай хууль зөрчих, зөрчлийн шинж, онцлог, анхаарах асуудал . . . 257
3.7.1. Шийтгэл, эрх бүхий албан тушаалтан ба харьяалал, нэр томъёоны тайлбар 257
3.7.2. Зөрчлийн ойлголт, шинж ба төсөөтэй зөрчлөөс ялгагдах шинж 260
3.7.3. Зөрчлийн зүйлчлэл 264
3.7.4. Зөрчлийг шалгах тодорхой ажиллагаа 265
3.7.5. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд анхаарах асуудал 266
3.8. Усны тухай хууль зөрчих, зөрчлийн шинж, онцлог, анхаарах асуудал 274
3.8.1. Шийтгэл, эрх бүхий албан тушаалтан ба харьяалал, нэр томъёоны тайлбар 274
3.8.2. Зөрчлийн ойлголт, шинж ба төсөөтэй гэмт хэргээс ялгагдах шинж 278
3.8.3. Зөрчлийн зүйлчлэл 288
3.8.4. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд анхаарах асуудал 288
3.9. Тусгай хамгаалалттай газар нутагт хориглосон үйл ажиллагаа явуулах, түүний шинж, онцлог, анхаарах асуудал 294
3.9.1. Шийтгэл, эрх бүхий албан тушаалтан ба харьяалал, нэр томъёоны тайлбар 294
3.9.2. Зөрчлийн ойлголт, шинж ба төсөөтэй гэмт хэргээс ялгагдах шинж 295
3.9.3. Зөрчлийн зүйлчлэл 302
3.9.4. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд анхаарах асуудал 302
Мэдлэг сорих тест. 309
Тестийн зөв хариулт 335

ХАВСРАЛТ 337
Хавсралт 1. Зөрчлийн тухай хуулийн Долдугаар бүлгийн Байгаль орчин, амьтан, ургамлыг хамгаалах журмын эсрэг зөрчил (7.1-7.18)-ийг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан, түүний харьяалал 338
Хавсралт 2. Байгаль хамгаалагчийн хяналт шалгалт явуулах процесс ажиллагааны талаар хууль тогтоомжоор олгосон эрх хэмжээ. 366
Хавсралт 3. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны А/189 дүгээр “Байгаль хамгаалагчийг мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр батлах тухай” тушаал ба хавсралтууд . 368

ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын байгаль орчныг хамгаалах үйл хэрэг, түүний төлөөх зүрх сэтгэл эрхэм. Энэ үйлсэд, энэ зорилгод хүч хөдөлмөрөө зориулан ажиллаж буй “Байгаль хамгаалагч” Та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны гуравдугаар сарын 29-ний өдрийн А/189 тоот тушаалаар **“Байгаль хамгаалагчийг мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр”**-ийг батлан, хэрэгжүүлж эхлээд байгаа билээ. Уг хөтөлбөрийн хүрээнд байгаль хамгаалагчдыг мэргэжлийн ур чадвар, мэдлэг боловсрол, хандлага, хариуцлагын түвшнээр нь тогтмол хөгжүүлэн чадавхжуулж, мэргэшүүлэх зорилгыг зарчим болгосон бөгөөд **анхан, дунд, ахисан шатны сургалтын гарын авлагуудыг** боловсруулан бэлтгээд байна.

Энэ нь зөвхөн байгаль хамгаалагч нарт зориулсан сургалтын хэрэглэгдэхүүн төдийгүй байгаль орчныг хамгаалах хүсэл эрмэлзэлтэй, ухамсартай иргэн бүрд нээлттэй. Мөн хүртээмжтэй түгээгдэж буйгаараа онцлог юм. Эл хандлага, зохион байгуулалт нь байгаль орчныг хамгаалах үйл хэрэг зөвхөн тодорхой салбарын бус, нийгмийн нийт цуг хамтын оролцоотой, хариуцлагатай үйлс, зарчимт мөрдлөг гэдгийг харуулж байна.

Мөн уг гарын авлага нь байгаль хамгаалагчдыг чадавхжуулахад чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдийн сургалтын үндсэн хэрэглэгдэхүүн болж, олон талт хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалтыг үр дүнтэй, оновчтой хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ гэдэгт итгэж байна.
Бид байгаль орчныг хамгаалах үйлсэд бодит хувь нэмэр оруулж буй хүн бүрийн идэвх санаачилга, дэмжлэгт гүн талархалтай ханддаг. Иймд гарын авлагыг өдөр тутмын ажилдаа өргөнөөр ашиглаж, мэдлэг ур чадвараа байнга дээшлүүлэн, эх орныхоо байгалийг хамгаалах нэр хүндтэй үйл хэрэгт улам их амжилт гаргахыг хүсэн ерөөе.

Энэхүү сургалтын хөтөлбөр, гарын авлагыг боловсруулах ажилд мэргэжлийн зөвлөгөө, техникийн туслалцаа үзүүлэн хамтран ажилласан холбогдох бүх байгууллага, хамт олон, эрдэмтэн, судлаач, багш нарт гүн талархал илэрхийлье.

Цаашид бид хамтын ажиллагаагаа шинэ шатанд гаргаж, байгаль хамгаалагчдын чадавхыг бүх талаар бэхжүүлэн, Монгол Улсын газар нутгийн хамгаалалтын “30х30” зорилтыг амжилттай хэрэгжүүлнэ гэдэгт гүн бат итгэж байна.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН, ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН,
БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД

Б.БАТБААТАР

ҮНДЭСЛЭЛ БА ЗОРИЛГО

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь заалт, Байгаль хамгаалагчдын хоёрдугаар чуулганы зөвлөмжийн 1.1, 2.2 дахь заалт болон байгаль орчны салбарын хууль, эрх зүйн орчны шинэчлэл, байгаль хамгаалагчдын дунд явуулсан судалгааны үр дүнг үндэслэн энэ сургалтын хөтөлбөр болон гарын авлагыг боловсруулласа. Тухайлбал, 2023 онд 700 гаруй байгаль хамгаалагчдаас авсан асуулга судалгаагаар, тэдний 90% нь хууль, эрх зүйн орчны мэдлэг чадвараа сайжруулж, хэрэг зөрчил илрүүлсэн тохиолдолд хэргийн газрын үзлэгийг зөв, тодорхой гүйцэтгэх сонирхолтой байгаагаа илэрхийлсэн байдаг.

Байгаль орчны доройтолд хүн, хуулийн этгээдийн үзүүлж буй гэм буруутай үйлдэл, эс үйлдэлтэй уялдан гарч буй эрх зүйн орчны өөрчлөлттэй холбоотойгоор байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч, экологийн асуудал хариуцсан алба хаагч нар улс, эх орныхоо экологийн аюулгүй байдлыг хангах, байгаль орчныг хамгаалах, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд мэдэгдэхүйц үр дүн гаргаж, унаган байгалиа хойч үедээ өвлүүлэн үлдээх зайлшгүй шаардлага тулгарсаар байна.

Монгол Улсад уул уурхай, ашигт малтмал, техник технологийн салбар идэвхтэй хөгжихийн хэрээр түүнийг даган гарч буй байгаль орчныг сүйтгэх, байгалийн тэнцэл алдагдуулах, хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхэнд халдах, байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, байгаль орчныг нөхөн сэргээхтэй холбоотой хүн, хуулийн этгээдийн үйлдсэн зөрчлийг хуулийн дагуу шалган шийдвэрлэж, шийтгэл оногдуулах, зөрчлийн үр дагаврыг арилгах хэрэгцээ шаардлага улам бүр нэмэгдэж байна.

Иймд улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч, байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, экологийн асуудал хариуцсан алба хаагчид зэрэг энэ төрлийн зөрчлийг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнуудад хүрээлэн буй орчны эсрэг зөрчлийн шинж, онцлог, зөрчлийг нотлох ажиллагаа болон шалган шийдвэрлэх ажиллагаанд оролцогчийн эрх, гүйцэтгэх үүрэг, зөрчил үйлдэгчид хүлээлгэх хууль зүйн хариуцлага, зөрчлийн үр дагаврыг арилгах зэрэг ажиллагааг хэрэгжүүлэх ур чадвар эзэмшүүлэх шаардлага зайлшгүй тулгарч байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны А/189 дүгээр тушаалаар батлагдсан “Байгаль хамгаалагчийг мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр”-ийн ахисан шатны сургалтын хэрэглэгдэхүүн болгож улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч, байгаль хамгаалагч нарт Зөрчлийн тухай хуулийн агуулга, ач холбогдол, тус хуулийн 7 дугаар бүлэгт заасан Байгаль орчин, амьтан, ургамлыг хамгаалах журмын эсрэг зөрчлийн ойлголт шинж, бүрэлдэхүүн, түүнчлэн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, түүний онцлог, үе шат, хэрэгжүүлэгчийн эрх, гүйцэтгэх үүрэг, зөрчлийн холбогдогчид хүлээлгэх хууль зүйн хариуцлагын талаар мэдлэг олгох, зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагааны үед хийгдэх ажиллагааг бие даан хэрэгжүүлэх ур чадварыг эзэмшүүлэх, аливаа зөрчлийг хууль зүйн үндэслэлтэй шалгаж шийдвэрлэх дадал, чадвар эзэмшүүлэхэд энэ гарын авлага чиглэсэн бөгөөд тодорхой үе шаттай, богино хугацааны системтэй хөтөлбөрөөр байгаль хамгаалагчдын албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүргийг гүйцэтгэхтэй холбоотой практик мэдлэг, ур чадварыг сайжруулж, чадавхжуулах зорилготой юм.

Мөн түүнчлэн энэ ахисан шатны сургалтын гарын авлагаар зөрчил илрүүлэх, шалгах хууль эрх зүйн үндэслэл, онцлог, байгаль орчин, амьтан ургамлыг хамгаалах журмын эсрэг хэрэг, зөрчлийн мэдээлэл цуглуулах, үзлэг хийх арга техникийн талаарх практик мэдлэг, ур чадвар олгож, чадавхжуулахад онцгойлон анхаарав.

СУРГАЛТЫН ХЭЛБЭР БА ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

Байгаль хамгаалагчийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтыг тухайн орчин нөхцөлд нь оролцооны аргад тулгуурлан дадлага ажил, бодит жишээ, үзүүлэн таниулах материал, хэрэг зөрчлийн тохиолдол дээр хэлэлцүүлэг өрнүүлэх, ярилцах, газрын зураг, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж дээр ажиллуулах зэрэг хэлбэрээр зохион байгуулахаар тусгасан байдаг.

Иймд, энэ сургалтын гарын авлагад байгаль хамгаалагчийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, мэдлэг олгох лекц, ур чадвар олгох дадлага ажил, бодлого, тест, схем зураглал, хэрэг зөрчлийн тохиолдол дээр хэлэлцүүлэг өрнүүлэх, ярилцах зэрэг сургалтын хэлбэрээр 30%-ийн лекц (16 цаг), 70%-ийн дадлага (24 цаг) байхаар нийт 40 цагийн сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсруулж, оруулав.

Суралцагч нарт зориулсан лекцийг боловсруулахдаа хууль тайлбарлах аргыг ашиглан хамгийн энгийн ойлгомжтой өгүүлбэрээр хуулийн агуулга, тодорхой бус заалтыг тайлбарлан илэрхийлсэн болно. Хуулийн хэм хэмжээг зөвхөн зөрчлийн хуулиар хязгаарлалгүйгээр байгаль орчны салбарын хуулиудыг холбон тайлбарлах аргаар лекцийг бэлтгэв. Тухайлбал, Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан *“Мод бэлтгэх, эсхүл ойн дагалт нөөц ашиглахдаа технологийн горимыг зөрчсөн”* гэдэгт ойд мод бэлтгэх гэрээ байгуулж, зөвшөөрөл авсан мод бэлтгэгч мод бэлтгэх үйл ажиллагааг эхлэхээс өмнө технологийн картыг загварын дагуу боловсруулж батлуулах, ойгоос мод бэлтгэх технологийн үйл ажиллагаанд арчилгаа, цэвэрлэгээ, үйлдвэрлэлийн ашиглалтын огтолттой холбоотой стандартыг мөрдөж ажиллах зэрэг мод бэлтгэх, ойн дагалт нөөцийг ашиглах технологийн горимыг зөрчиж байгаа үйлдэл эс үйлдлийг ойлгоно гэх мэтээр тайлбарласан болно.

Мөн тухайн зөрчлийг шалгахад юунд онцгойлон анхаарах талаарх практик туршлагуудыг зөвлөмж болгон хэрэглэх байдлаар оруулснаас гадна, танхимаар олж авсан мэдлэгээ бататгах тухайн зөрчилтэй холбоотой бодлогыг асуултын хамт бэлтгэсэн бөгөөд 4 алхамт дарааллаар эрх зүйн бодлого бодох шинэ аргачлалыг тайлбарын хамт боловсруулан ашиглалаа. Ингэж эрх зүйн зөрчлийг шүүхийн практик болон тодорхой тохиолдлоор бодлогын хэлбэрт оруулж бодлого бодуулах нь суралцагчид эрх зүйн мэдлэг чадвараа ашиглан хууль зүйн үндэслэлтэй дүгнэлт гаргахад чухал нөлөөтэй сургалтын нэг арга юм.

Суралцагчдын эрх зүйн мэдлэг, чадварыг бататгах зорилгоор зөрчил бүртэй холбоотой мэдлэг сорих тестийг зөв хариултын хамт бэлтгэсэн бөгөөд зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнаас практикт гаргаж буй алдаа, цаашид онцгойлон анхаарах бодит жишээг Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан (https://shuukh.mn/)-аас түүвэрлэн авч хураангуйлан сургалтад ашиглаж болохуйцаар бэлтгэв. Мөн Улсын ерөнхий прокурорын Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн хэлбэрийн жагсаалт, загварыг шинэчлэн батлах тухай 2021 оны А\77 дугаар тушаалаар батлагдсан эрх зүйн хэлбэрийн загвараар зөрчил шалгах хэргийн бичиглэл зэргийг жишээ болгон боловсруулж, бэлтгэсэн болно.

ЗӨРЧИЛ БОЛОН ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН БОДЛОГО БОДОХ АРГАЧЛАЛ

Зөрчил болон зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн бодлого нь тухайн салбарын хүрээнд хууль хэрэглэж шийдвэрлэх, эрх зүйн үнэлэлт дүгнэлт өгөх, суралцагчийн мэдлэг чадварыг сориход чиглэгдэнэ.

Суралцагч бүр юуны түрүүнд бодлогын өгөгдлийг сайтар уншиж ойлгох хэрэгтэй. Үүний дараа хэрэглэх хуулийн заалт, хуулийн тайлбарын хүрээ хязгаарыг тогтоох замаар эх сурвалжаа тодорхойлох ёстой. Зөрчил болон зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн бодлогыг практик ажилтнуудад зориулж 4 алхамтаар бодохоор зохиомжлов. Үүнд:

1-р ахлам. Дээрх үйлдэл нь ямар хууль тогтоомж зөрчсөн вэ?

Энэ хүрээнд тухайн зөрчилтэй холбоотой материаллаг хуулийн ямар ямар зүйл, заалтууд зөрчигдсөн болохыг нэг бүрчлэн гаргаж, тайлбарлана.

2-р ахлам. Энэ зөрчлийг шалгах ажиллагааны үед ямар ажиллагаа явуулах вэ?

Энэ алхамд зөрчил шалган шийдвэрлэх нийтлэг ямар ажиллагаа явуулах үүнээс гадна, зөрчлийн онцлог шинжээс шалтгаалан ямар ажиллагаа нэмэлтээр хийх, юун дээр анхаарах талаар тодорхойлно.

3-р алхам. Дээрх хууль бус үйлдэл нь Зөрчлийн тухай хуульд заасан ямар зөрчил болох вэ? Зөрчлийг зүйлчилнэ үү?

Энэ алхамд хууль хэрэглээ буюу зөрчлийн тухай хуулийн ямар зүйл, хэсэг, заалтаар зүйчлэгдэхийг тодорхойлж, тайлбарлана.

4-р алхам. Зөрчил үйлдэгчид ямар шийтгэл оногдуулах вэ?

Төгсгөлийн алхамд зөрчил үйлдэгч нарт оногдуулах шийтгэл, хохирол, нөхөн төлбөрийг тогтоох эсэх тухай асуудлууд багтана.

Бодлого бодсон жишээ

Зөрчлийн тухай хуулийн 7.10 дугаар зүйл. Газрын хэвлийн тухай хууль зөрчих зөрчил

Байгаль орчны хяналтын улсын байцаагч “А” нь “Тариа” ХХК-ийн Дархан уул аймгийн Сант нэртэй газарт орших полиметалийн баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааг шалгах төлөвлөгөөт удирдамжийн дагуу шалгалт явуулав. Шалгалтаар баяжуулах үйлдвэрийн хаягдлын далангийн газар нь уурхайн эдэлбэр газарт ордоггүй, газар ашиглах эрхийн гэрчилгээ болон орон нутагтай байгуулсан гэрээ байгаа боловч хугацаа нь дууссан, сунгуулаагүй, хаягдлын далангийн зураг төсөл нь “Тариа” ХХК-ийн зураг төсөл гэх боловч хянан баталгаажилт хийгдээгүй, хятад ханз бүхий зургийг орчуулгагүйгээр тэр чигт нь хуулбарлан тавьсан, хаягдлын даланд ашигласан флёнк буюу гоемембран давхарга дэвсэхдээ очлуурт шалгалт хийгээгүйн улмаас шаардлага хангахгүй материалаар хийгдэж нэлэнхийдээ урагдаж салбарсан, цаашид хаягдлын даланд хуримтлагдсан технологийн бохир ус нэмэгдэж байгальд хаягдаж болзошгүй нөхцөл байдал тогтоогдов.

Асуулт

1. Дээрх үйлдэл нь ямар хууль тогтоомж зөрчсөн вэ?
2. Энэ зөрчлийг шалгах ажиллагааны үед ямар ажиллагаа явуулах вэ?
3. Дээрх хууль бус үйлдэл нь Зөрчлийн тухай хуульд заасан ямар зөрчил болох вэ? Зөрчлийг зүйлчилнэ үү?
4. Зөрчил үйлдэгчид ямар шийтгэл оногдуулах вэ?

Хариулт

1. Дээрх үйлдэлд ямар хууль тогтоомж зөрчигдсөн бэ?

“Тариа” ХХК-ийн Дархан уул аймгийн Сант нэртэй газарт үйл ажиллагаа явуулсан нь Газрын тухай хуулийн 37.1. эрхийн гэрчилгээний хүчин төгөлдөр байх хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө эзэмшигч нь хугацаа сунгуулах тухай хүсэлтээ цахим системээр гаргах бөгөөд дараах баримт бичгүүдийг хавсаргана, 56.5. газар эзэмших, ашиглах хугацаа дууссан, тэрчлэн зохих зөвшөөрөлгүй барилга байгууламж барьсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар чөлөөлөх тухай мэдэгдлийг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас өгсөн тохиолдолд тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага заасан хугацаанд багтааж газар чөлөөлөх үүрэгтэй. Газрын хэвлийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн Газрын хэвлийг ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар ашиглах журам 1. ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барилга байгууламж барих, ашиглах болон бусад ийм зорилгоор газрын хэвлийг ашиглахдаа эрх бүхий байгууллагын зөвшөөрч баталсан зураг төслийг баримтална гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

2. Энэ зөрчлийг шалгах ажиллагааны үед ямар ажиллагаа явуулах вэ?

Уг зөрчлийг шалгах ажиллагаа “Тариа” ХХК-ийн Дархан уул аймгийн Сант нэртэй газрын доор барих хаягдлын далангийн барилга байгууламжийн зураг төсөл хаанахын ямар компаниар хийлгэсэн болох, хэрхэн баталгаажуулсан, хаягдлын далан барих захиалгын гэрээ, гүйцэтгэл, ашиглалтад өгсөн баримт, хуульд заасан барилгын тусгай эрхтэй гүйцэтгэгч байсан эсэх, барилгын явцад хийгдсэн ажил гүйцэтгэх гэрээ, туслан гүйцэтгэгчийн гэрээ, бараа материалын захиалгын хуудас, үйлдвэрлэгчийн баталгаа, ажлын явцыг шалгасан төрийн байгууллагын комиссын шийдвэр, дүгнэлт, ашиглалтад хүлээн авсан акт, шийдвэр, тэдгээрийн заалт, ашиглалтад өгөх үед комисс хүлээн авсан бичиг баримтын жагсаалт, архивын нэгж болсон бичиг баримтууд зэргийг үзэн шалгаж,

шаардлагатайг нь хуулбарлаж авна. Мөн Зөрчлийн газарт бусад зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд дурдсан аргачлалын дагуу үзлэг хийнэ. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд оролцох хохирогчийг тогтоолгон мэдүүлэг авах ажиллагааг явуулна.

3. Дээрх хууль бус үйлдэл нь Зөрчлийн тухай хуульд заасан ямар зөрчил вэ? Зөрчлийг зүйлчилнэ үү?
Дээрх үйлдлийг Зөрчлийн тухай хуулийн 7.10 дугаар зүйлийн 1-д 1. газрын хэвлийг дур мэдэн ашигласан, Зөрчлийн тухай хуулийн 5.1. зураг төсөл зохиох; 5.2. тэдгээрийг барих, ашиглалтад оруулах талаар хуульд заасан шаардлагыг зөрчсөн гэж үзэж Зөрчлийн тухай хуулийн 7.10 дугаар зүйлийн 1, 7.10 дугаар зүйлийн 5.1, 5.2-д зааснаар зүйлчилж шийтгэл оногдуулна.

4. Зөрчил үйлдэгчид ямар шийтгэл оногдуулах вэ?
Үйлдэгдсэн зөрчилд хүлээлгэх хариуцлага: Зөрчлийн тухай хуулийн 7.10 дугаар зүйлийн 1-д зааснаар “..... аймгийн ..... сумын ..... нэртэй газарт орших полиметалийн баяжуулах үйлдвэрийн хаягдлын далангийн газарт “газар ашиглах эрхийн гэрчилгээ болон орон нутагтай байгуулсан гэрээ” байгаа боловч хугацаа нь дууссан, сунгуулаагүй нь газрын хэвлийг дур мэдэн ашигласан гэж үзэж хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Зөрчлийн тухай хуулийн 7.10 дугаар зүйлийн 5.1, 5.2-д зааснаар “Хаягдлын далангийн зураг төсөл нь хянан баталгаажилт хийгдээгүй, хаягдлын далан барих, ашиглалтад оруулахдаа технологийн шаардлага хангаагүй” үйлдэл нь “Ашигт малтмал олборлох, эрдэс түүхий эдийг боловсруулах, ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барих барилга байгууламжийн зураг төсөл зохиох, тэдгээрийг барих, ашиглалтад оруулах талаар хуульд заасан шаардлагыг зөрчсөн” гэж үзээд хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧИЙН ҮҮРГЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ “НАЙМАН АЛХАМТ” ДАРААЛАЛ

Байгаль хамгаалагч нь байгаль орчныг хамгаалах салбарын хууль тогтоомжид өөрийн гэсэн тодорхой эрх үүрэгтэй оролцдог, төрийн эрх бүхий байгууллагын субъект юм. Тийм учраас байгаль орчныг хамгаалах 30 гаруй салбар хуулиудад тэдгээрийн эрх, үүргийг тусгайлан хуульчлан өгсөн байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 4-д “байгалийн баялгийг хууль бусаар ашигласан, гэмтээсэн, хөнөөж сүйтгэсэн үйлдлийг олж мэдсэн иргэн тэр тухайгаа тухайн орон нутгийн Засаг дарга, улсын байцаагч, байгаль хамгаалагчид нэн даруй мэдэгдэх” үүргийг тухайлан зааж өгчээ.

Мөн байгаль хамгаалагч хээрийн нөхцөлд хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах үедээ галт зэвсэг, бие хамгаалах тусгай хэрэгсэл биедээ авч явах эрхтэй бөгөөд хяналт, шалгалт хийх үедээ илэрсэн зөрчил, гаднын халдлагыг өөр арга хэрэгслээр таслан зогсоох боломжгүй тохиолдолд галт зэвсэг хэрэглэж болохыг заасан байна.

Байгаль хамгаалагч нь хуульд заасан шаардлага хангасан тохиолдолд байгаль орчны хяналтын улсын байцаагчийн эрхийг эдэлж болох талаар хуульд тусгайлан хуульчлан өгсөн байна. Энэ тохиолдолд байгаль хамгаалагч нь Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны эрх бүхий албан тушаалтан болно гэсэн үг юм. Байгаль хамгаалагчийг хийж гүйцэтгэх ажлыг дээр заалтаас шалтгаалан улсын байцаагчийн эрхтэй, эрхгүй байгаль хамгаалагчийн гэж эрх, үүргийг зааглан авч үзэх шаардлагатай.

Иймд байгаль хамгаалагч нь хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн үед ямар ажиллагааг шат дараалан хийх талаар дараах найман алхамтаар тодорхойлон авч үзэж болно.

Нэгдүгээр алхам: Мэдээллийг хүлээн авах, мэдээлэх. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 4-д заасны дагуу “байгалийн баялгийг хууль бусаар ашигласан, гэмтээсэн, хөнөөж сүйтгэсэн үйлдлийг олж мэдсэн иргэн тэр тухайгаа байгаль хамгаалагчид нэн даруй мэдэгдэх” үүргийн дагуу мэдээлэл хүлээн авсан байгаль хамгаалагч нь тухайн мэдээлэл нь гэмт хэргийн эсвэл зөрчлийн мэдээлэл эсэхийг нягтлан дүгнэн үзээд гэмт хэргийн шинжийг илэрхийлж байвал хууль сахиулах байгууллагад, зөрчлийн шинж байвал байгаль орчны улсын хяналтын байцаагчийн алинд нь мэдээлэх шийдвэрээ эхлэн гаргаж, холбогдох албан тушаалтан, байгууллагад нь шуурхай мэдэгдэнэ.

Хоёрдугаар алхам: Хэрэг, зөрчлийн газрыг хамгаалах. Хэрэв гэмт хэрэг, зөрчлийн үйлдэл дээр очсон тохиолдолд хэрэг, зөрчлийн газарт бусад хүмүүсийг оруулахгүй байх, ул мөрийг баллуулахгүй байх, тухайн газар оронд байгаа хүмүүсийн нэр, хаягийг тодруулах. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг, зөрчлийн газрыг хамгаалалтад авч, эрх бүхий албан тушаалтны хэргийн газар оронд ажиллахад туслалцаа, дэмжлэг үзүүлэх хойшлуулшгүй арга хэмжээг авна.

Гуравдугаар алхам: Бичиг баримт, эд зүйлийг шалгах, үзлэг хийх, хураах. Хууль тогтоомж зөрчсөн сэжиг бүхий иргэний бичиг баримтыг шалгах, түр хураах, шаардлагатай гэж үзвэл унаа хөсөгт нь үзлэг хийх, зэвсэг хэрэгсэл, агнасан, түүсэн, бэлтгэсэн зүйлийг хураан авах ажиллагааг хууль, журамд заасны дагуу хийж гүйцэтгэнэ.

Дөрөвдүгээр алхам: Амь нас, эрүүл мэндээ хамгаалах. Байгаль хамгаалагчийн амь нас, эрүүл мэндэд гэмт этгээд хохирол учруулж болзошгүй байдал бодитоор бий болсон эсвэл амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй байдлаар зэрлэг амьтан довтолсон тохиолдолд хуульд заасны дагуу галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэж болно.

Тавдугаар алхам: Мэдээллийг бүртгэж авах. Байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасан “хариуцсан нутаг дэвсгэртээ байгалийн баялгийн өөрчлөлтийн ажиглалт хийж, мэдээг мэдээллийн санд тусгуулах” заалтыг үндэслэн гэмт хэрэг, зөрчлийн улмаас учирсан хохирол, дүр төрх байдал, өөрчлөлтийн талаарх мэдээллийг бэлтгэн захирах дээд шатны албан тушаалтанд өгнө.

Зургаадугаар алхам: Хойшлуулшгүй арга хэмжээг авах. Байгалийн гамшиг, гэнэтийн аюул гарсан даруйд зохих шатны Засаг даргад мэдээлж, хор уршгийг арилгах арга хэмжээг өөрийн нөөц хүч бололцооны хэмжээгээр авна.

Долдугаар алхам: Хууль хэрэгжүүлэх. Өөрийн эрх хэмжээний хүрээнд гэмт хэрэг, зөрчлийг цаашид даамжруулахгүй байх зорилгоор хууль тогтоомж, хамгаалалтын горимыг зөрчиж байгаль орчинд сөрөг нөлөөлөх үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг түр зогсоох, тэдгээрт хугацаатай үүрэг, даалгавар өгөх, шаардлага тавина.

Наймдугаар алхам: Хууль хэрэгжүүлж, хариуцлага тооцох. Байгаль орчныг хамгаалах бусад хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг таслан зогсоож, гэм буруутай этгээдэд зохих хариуцлага хүлээлгэх зэрэг хуулиар олгогдсон үйл ажиллагаа явуулна.

Байгаль хамгаалагч нь албан үүргээ гүйцэтгэх үедээ дүрэмт хувцас, ялгах тэмдэг, зэвсэг, хэрэгсэлтэй байх шаардлагатай.



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ЗӨРЧИЛ ИЛРҮҮЛЭХ, ШАЛГАХ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ, ОНЦЛОГ

1.1 ГЭМТ ХЭРЭГ БА ЗӨРЧЛИЙН ЯЛГАА, ОНЦЛОГ

Хүн төрөлхтний өмнө байнга тулгамдаж байдаг асуудлуудын нэг бол аргагүй гэмт явдал бөгөөд гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх нь төрийн дотоод чиг үүрэг болдог. Төр нь эрүүгийн бодлогыг тодорхойлж хуульчлан баталгаажуулснаар хэрэгжих нөхцөл нь бүрдэнэ.

Эрүүгийн бодлого нь хүн, төр, нийгэм, байгууллага, аж ахуйн нэгжийн хууль ёсны эрх, эрх ашиг, сонирхлыг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор нийгэмд аюултай ямар үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох, оногдуулах эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээ, эсхүл чөлөөлөх үндэслэл, журмыг тогтоох, түүнчлэн гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг судалж тогтоох, энэ үндсэн дээр урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, үр өгөөжтэй арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэх, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг төгөлдөржүүлэх талаар төрөөс баримталж буй чиглэл, удирдамж юм[1].

Нөгөө талаар Эрүүгийн бодлого нь иргэн, нийгэм, төр, байгууллага, аж ахуйн нэгжийн эрх, ашиг сонирхолд хохирол учруулдаг нийгмийн сөрөг үзэгдэл болох гэмт явдалтай хийх тэмцэл, нийгмийн дэг журмыг сахиулах үйл ажиллагааны үндсэн чиглэл, арга замыг тодорхойлдог. Нийгмийн хөгжлийн шаардлагаар хууль тогтоомжийг боловсронгуй болгох нь тасралтгүй хэрэгжих байнгын үйл явц бөгөөд энэ нь зөвхөн хууль тогтоомжийг шинээр батлах, тэдгээрт зохих нэмэлт өөрчлөлт оруулах төдий асуудал биш нэгэнт батлагдсан хуулийг амьдралд хэрэгжүүлэх, хуулиудын хоорондын уялдаа холбоог хангах явдал маш чухал юм. Иймд уламжлан ирсэн эрүүгийн эрх зүй, криминологи салбар, мөн шинэлэг дэд салбар болох пенологийн тухай зайлшгүй судлах хэрэгцээ шаардлага үүсэж байна.

Crime science шинжлэх ухааны хувьд гэмт явдал судлал, ялын бодлогын хувьд гурвалсан дэд салбараас бүрдэх төрийн эрүүгийн бодлого байх учиртай. Манай улстай ижил түвшний хөгжилтэй зарим орнуудын тухайд энэ асуудлыг хэдийн шийдсэн бөгөөд цагдаа, зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллага, прокурор, шүүх гэсэн нийгэмд шударга ёсыг тогтооход тэргүүлэх үүрэг гүйцэтгэдэг гурван институт тус бүрийн хувьд судлан хөгжүүлсэн байна.

Схем 1.1. *Зөрчлийн онолын үндэслэл*

Crime science	Crimology	Penology
Гэмт хэргийн шинжлэх ухаан	Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх шинжлэх ухаан	Шийтгэл судлал
Хууль сахиулах байгууллага эрх бүхий албан тушаалтан гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх цаашдын чиг хандлага арга зам, түүнтэй тэмцэх ажлыг боловсронгуй болгохыг судална.	Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг яллах байгууллага хэрэг бүртгэх, мөрдөн шалгах ажиллагаанд хяналт тавьж урьдчилан сэргийлэх шалтгаан нөхцлийг судална.	Шүүх ял шийтгэл, түүний үр нөлөөг судалж, цаашид баримтлах ялын бодлого, албадлагын арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх талаар бодлого боловсруулна.

1 Жанцан, С. (2022). Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. Ерөнхий анги. 24 дэх тал. Улаанбаатар

Crimology шинжлэх ухаан гэмт хэрэг үйлдсэн этгээдийг яллах байгууллага хэрэг бүртгэх, мөрдөн шалгах ажиллагаанд хяналт тавьж урьдчилан сэргийлэх шалтгаан нөхцлийг судална.

Penology шинжлэх ухаан Шүүх ял шийтгэл, түүний үр нөлөөг судалж, цаашид баримтлах ялын бодлого, албадлагын арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх талаар бодлого боловсруулна.

Дээр дурдсан шинжлэх ухаануудын харилцан хамаарлын хүрээнд гэмт явдлын тодорхой төрлийг төрөөс тогтооно. Гэмт хэрэг, гэмт хэрэг биш гэж юу болохыг улс орон бүрд ялгаатай ойлгоно. Тухайн улс оронд гэмт явдал цаг хугацаа (он) ба орон зай (нутаг дэвсгэр)-аар өөрчлөгдөж байдаг бөгөөд хүн ардын амьдралын тодорхой нөхцөлд гарч байгаа өөрчлөлтөөс шалтгаална. Хүмүүсийн нийгмийн амьдрал, үйлийн нийгэмд аюултай үр дагавар нь гэмт явдал бөгөөд нийгэмд хор хөнөөлтэй байдаг учраас түүнтэй тэмцэх шаардлагатай болдог.

Эрүүгийн эрх зүй нь хуульд заасан тодорхой төрлийн гэмт хэрэг үйлдлийг гэмт хэрэгт тооцож, тус бүрийн бүрэлдэхүүнд тал бүрийн тайлбар өгч, түүнийг шүүхийн практикт хэрхэн хэрэглэх тухай асуудлыг тусгасан байдаг[2].

Харин Зөрчлийн хуульд зөрчлийг тодорхойлж хүлээлгэх хариуцлагын эрх зүйн санкцуудын харьцааг тодорхойлох, гэмт хэргийг эрүүгүйжүүлэх замаар захиргааны зөрчлийн төрөлд хамааруулах, эсхүл захиргааны зарим зөрчлийг гэмт хэрэгт тооцож эрүүжүүлэх зэрэг асуудал дээр энэ хоёр эрх зүй хоорондоо холбогдоно[3].

Хууль тогтоогч ямагт хамгийн үнэ цэнэтэй эрх ашиг, сонирхлыг эрүүгийн хуулийн хамгаалалтад авдаг. Тухайлбал, улс орны амин чухал үнэт зүйл болох тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, эв нэгдэл, гадаад аюулгүй байдал, хил хязгаарын халдашгүй дархан байдал, хүний амьд явах эрх, хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайван зэрэг онцгой үнэ цэнэтэй объектуудад халдсан үйлдэл, эс үйлдэхүйг эрүүжүүлэх, тэдгээрийг хүнд, онц хүнд гэмт хэргийн ангилалд хамааруулна.

Гэмт хэрэг, аливаа зөрчлүүд тэр тусмаа Зөрчлийн тухай хуульд заасан зөрчлүүд нь объект, объектив тал, субъектив тал, субъект гэсэн бүрэлдэхүүний хувьд адил шинжүүдтэй байдгаараа нийтлэг учир зарим тохиолдолд тэдгээрийг ялган зүйлчлэх шаардлага гардаг.

Гэмт хэрэг, зөрчлийг **о**бъектын шинж байдал, **нийгмийн хор аюулын шинж чанар, хэр хэмжээ,** хууль зөрчсөн байдал болон оногдуулж буй хууль зүйн хариуцлагын төрөл гэсэн дөрвөн шалгууруар ангилж үзнэ.

Гэмт хэрэг, зөрчлийн ялгагдах шинж. Гэмт хэрэг хэмээх ойлголтыг Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанаар тодорхойлдог бөгөөд Монгол Улсын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох бөгөөд дараах шинжээрээ ялгаатай. Үүнд:

- **Хуульд заасан бүрэлдэхүүний шинж**
- **Үйлдэл эс үйлдэхүйн** нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, үйлдлийн арга (учруулсан хохирлын хэмжээ)
- **Оногдуулж болох хууль зүйн хариуцлага (ял)-ын төрөл, хэмжээ**
- **Ял болон шийтгэлийг оногдуулах субъект**
- Ял оногдуулсан, шийтгэл хэрэглэсний улмаас үүсэх эрх зүйн үр дагавар зэрэг шинжүүдээр хоорондоо ялгагдана.

Дэлгэрэнгүйг зөрчлийн тухай ойлголт, шинж, зөрчлийн тухай хуулийн агуулга, ач холбогдол сэдвээс үзнэ үү.

2 Совд, Г. (1973). БНМАУ-ын Эрүүгийн эрхийн курс. 18 дахь тал. Улаанбаатар
3 Нарангэрэл, С. (1999). Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. Ерөнхий анги. 8 дахь тал. Улаанбаатар

1.2 ЗӨРЧИЛ ИЛРҮҮЛЭН ШАЛГАХ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

Улсын байцаагчийн зөрчил илрүүлэх үйл ажиллагааг Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжоор тодорхойлсон.

Байгаль хамгаалагч өндөр уулын бүсэд 100.0, ойт хээрийн бүсэд 120.0, тал хээрийн бүсэд 500.0, цөлөрхөг хээрийн бүсэд 600.0, цөлийн бүсэд 800.0 мянга хүртэл га, улсын төсвийн хөрөнгөөр зориудаар тарьж ургуулсан ойн зурваст 30 км тутамд нэг байгаль хамгаалагч байх ба энэ нормативийг хот орчмын ногоон бүсэд 70 хувиар багасгаж тооцно. Тухайн бүсчлэлд хамрагдах сумдын нэрийн жагсаалт, дархан цаазат болон байгалийн цогцолборт газарт нэг байгаль хамгаалагчийн хариуцах талбайн хэмжээг тухайн тусгай хамгаалалттай газрын ангилал, хамгаалалтын дэглэм, онцлог, ачаалал зэргийг харгалзан Засгийн газар тогтооно.

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд улсын байцаагч зөрчил илрүүлэх болон байгаль орчныг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заажээ. Үүнд:

- Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад харьяалал харгалзахгүйгээр хянан шалгах
- Хяналтад шаардагдах мэдээ, баримтыг холбогдох иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаар гаргуулах
- Хууль тогтоомж, стандарт, зөвшөөрөгдөх дээд хэмжээг зөрчиж байгаль орчинд хортой нөлөөлөл үзүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад уг зөрчлийг арилгахыг шаардах, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу үйл ажиллагааг нь түр зогсоох
- Хяналт, шалгалт хийхээр аж ахуйн нэгж, байгууллагад нэвтрэн орох, сорьц, дээж авах, тэдгээрийг өөрийн хяналтын дор шинжлүүлэх
- Байгалийн гамшиг, гэнэтийн аюулын үед шаардлагатай бол нийтийн тээврийн хэрэгслээр дараалал харгалзахгүйгээр зорчих, бусад тээврийн хэрэгслийг дайчилж хөлсийг нь төлөх
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах явцдаа тухайн иргэний болон тээврийн хэрэгслийн баримт бичгийг шалгах, зөрчил илэрсэн тохиолдолд баримт бичиг, хууль бусаар агнасан, түүсэн, бэлтгэсэн, олборлосон байгалийн баялаг, ашигласан техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг хураах
- Зөрчлийн тухай хууль зөрчсөн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах, албадлагын арга хэмжээ авах
- Байгаль хамгаалагчийн ажлыг шалгах, заавар өгөх
- Хууль тогтоомж, технологийн зөрчил гаргаж байгаль орчинд хохирол учруулсан аж ахуйн нэгж, байгууллагын зөвшөөрлийг хүчингүй болгуулах, үйл ажиллагааг түр болон бүрмөсөн зогсоох саналаа тухайн эрх олгосон байгууллагад тавьж шийдвэрлүүлэх
- Байгаль орчны тухай хууль тогтоомжийг зөрчсөн шийдвэр гаргасан байгууллага, албан тушаалтны шийдвэрийг хүчингүй болгохыг шаардах, эсхүл дээд шатны байгууллагад гомдол гаргаж, шийдвэрлүүлэх.

Улсын байцаагч дараах үүрэгтэй байна. Үүнд:

- Байгаль орчныг хамгаалах үүргээ биелүүлэхдээ хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг чанд сахин биелүүлэх
- Илрүүлсэн зөрчлийг таслан зогсоох, арилгах арга хэмжээ авахдаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, үйлдвэрлэлийн нууцыг хадгалах

- Байгаль орчныг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, хяналт тавих үйл ажиллагаанд орон нутгийн иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний идэвх санаачлагыг өрнүүлэх, зөвлөн туслах, зохион байгуулах, хамтарч ажиллах.

Байгаль хамгаалагч дараах эрхтэй байна. Үүнд:

- Хариуцсан нутаг дэвсгэртээ байгаль орчинд учирч болзошгүй аюулаас сэргийлэх, байгалийн баялгийг хамгаалах арга хэмжээ авах
- Хууль тогтоомжид заасан тохиолдолд байгалийн баялгийн нөөц ашиглах эрхийн бичиг олгох
- Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад гэрээ, зөвшөөрлийн дагуу тухайн баялгийг ашиглах газрыг зааж өгөх, хяналт тавих
- Хариуцсан нутаг дэвсгэртээ байгалийн баялгийн өөрчлөлтийн ажиглалт хийж, мэдээг мэдээллийн санд тусгуулах
- Байгалийн гамшиг, гэнэтийн аюул гарсан даруйд зохих шатны Засаг даргад мэдээлж, хор уршгийг арилгах арга хэмжээ авах
- Хариуцсан нутаг дэвсгэртээ байгалийн баялгийг нөхөн сэргээх ажлыг зохион байгуулах
- Хариуцсан нутаг дэвсгэртээ ажиллах нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах
- Уул, ой модонд бүгсэн оргодол яллагдагч, ялтныг эрэн сурвалжилж байгаа цагдаагийн албанд газар орны онцлог, байгалийн тогтоц, байршлын талаар мэдээлэл өгөх, газарчлах, хамтран ажиллах
- Хариуцсан нутаг дэвсгэртээ орших гол, мөрөн, нуурт усан замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавих.

Байгаль хамгаалагч, улсын байцаагч нар нь Байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасан дээрх эрх, үүргийг хэрэгжүүлж дараах аргаар зөрчил илрүүлж болох юм.

Төрийн хяналт шалгалтын тухай хууль. Төрийн хяналт шалгалт нь иргэн, хуулийн этгээдийн явуулж байгаа үйл ажиллагаа үйлдэл, эс үйлдэхүй түүнчлэн үйлдвэрлэж байгаа болон борлуулж байгаа бараа, бүтээгдэхүүн, үзүүлж байгаа ажил, үйлчилгээ хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг дүгнэхэд чиглэсэн хянан шалгах арга хэмжээний цогцолбор юм.

Төрийн хяналт шалгалт явуулахад дараах зарчмыг баримтална.Үүнд

- Хүний амь нас, эрүүл мэнд, нийгмийн болон орчны аюулгүй байдал нь бусад аливаа сонирхол, зорилгоос илүүд байх
- Хяналт шалгалтыг хуульд заасан үндэслэлийн дагуу явуулах бөгөөд энэхүү хяналт шалгалт нь хараат бус, шударга, хяналт шалгалтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын үйл ажиллагаа нээлттэй, ил тод байх
- Хяналт шалгалттай холбоотой зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх бөгөөд хуульд зааснаас бусад тохиолдолд хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбоотой аливаа төлбөрийг шалгуулагч этгээдээс шаардахгүй байх
- Шалгуулагч этгээдэд адил тэгш хандаж, түүний хууль ёсны эрх, ашиг сонирхол, нэр төрийг хүндэтгэн харилцах
- Хяналт шалгалтыг төлөвлөхдөө тухайн объектын эрсдэлийн ангиллыг үндэслэх
- Хяналт шалгалтыг зөвхөн хууль болон нийтээр дагаж мөрдөхөөр бүртгэгдсэн эрх зүйн актыг үндэслэн явуулах ба гагцхүү хуулиар эрх олгосон хяналт шалгалтын байгууллага, албан тушаалтан хэрэгжүүлэх

- Хяналт шалгалтыг давхардуулахгүй бөгөөд төрийн эрх бүхий байгууллагаас хийсэн шинжилгээний дүн, дүгнэлтийг хяналт шалгалтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага харилцан хүлээн зөвшөөрөх.

Төрийн хяналт шалгалтын төрөл. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5-р зүйлд зааснаар төрийн хяналт шалгалт нь дараах төрөлтэй байна. Үүнд:

1. Төлөвлөгөөт хяналт шалгалт. Эрх бүхий албан тушаалтан төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухайгаа шалгуулах этгээдэд таваас доошгүй хоногийн өмнө шуудангаар, утсаар эсхүл биечлэн мэдэгдэх бөгөөд мэдэгдэлд шалгалт хийх байгууллагын нэр, шалгалт эхлэх ба дуусах хугацааг шалгалтын төлөвлөгөөнд тусгана.

Төлөвлөгөөт хяналт шалгалтын үргэлжлэх хугацаа ажлын 15 өдрөөс илүүгүй байх бөгөөд үүнд шалгалтын дүнг гаргах хугацаа болон санхүүгийн хяналт шалгалт хамаарахгүй.

Төлөвлөгөөт хяналт шалгалт хийхэд тухайн хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтныг байлцуулах бөгөөд тухайн албан тушаалтан ирээгүй нь уг шалгалтыг хойшлуулах үндэслэл болохгүй.

2. Төлөвлөгөөт бус хяналт шалгалт. Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр, түүнчлэн осол аваар, халдварт өвчин, хордлого зэрэг хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд шууд буюу шууд бусаар хор хохирол учруулсан тохиолдолд болон хууль тогтоомжид заасан бусад үндэслэлээр хийнэ.

Төрийн хяналт шалгалтын хуулийн 5^2.1-д заасан дээр дурдсан төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг явуулахыг хориглоно.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5^2.1-д заасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээллийг зохих нотлох баримтын хамт хяналт шалгалтын байгууллагад ирүүлэх бөгөөд уг өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэл нь үндэслэлтэй гэж хяналт шалгалтын байгууллага үзсэн тохиолдолд хяналт шалгалтыг ажлын 5 өдрийн дотор эхлүүлнэ.

Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг гагцхүү түүнийг явуулах болсон үндэслэл, удирдамжид заасан асуудлын хүрээнд хийнэ. Хуульд өөрөөр заагаагүй бол тухайн объект дээр хийх төлөвлөгөөт бус хяналт шалгалтын үргэлжлэх хугацаа ажлын 10 өдрөөс илүүгүй байх бөгөөд үүнд шалгалтын дүнг гаргах хугацаа хамаарахгүй.

3. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хүний амь нас, эрүүл мэнд, нийтийн болон орчны аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдэл, хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох зорилгоор хийнэ. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг тухайн асуудлыг хариуцсан хяналт шалгалтын байгууллагууд хамтран гүйцэтгэх нь илүү үр дүнтэй.

4. Гүйцэтгэлийн шалгалт. Гүйцэтгэлийн шалгалтыг өмнөх шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгуулах талаар хяналт шалгалтын байгууллагаас өгсөн албан шаардлагын биелэлтийг хянах зорилгоор явуулна. Гүйцэтгэлийн шалгалтыг өмнөх шалгалтаар илэрсэн зөрчил, түүний шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар өгсөн албан шаардлагын хүрээнд хийнэ. Гүйцэтгэлийн шалгалт хийхдээ шалгуулагч этгээдэд ажлын хоёроос доошгүй хоногийн өмнө урьдчилан мэдэгдэнэ.

Төрийн хяналт шалгалтын тухай хуульд зааснаар дээр дурдсан шалгалтын ажиллагааг явуулахаас гадна, тус хуулийн 5[6] дугаар зүйлд шинжилгээнд дээж авах ажиллагааг хуульчилсан байна.

Хяналт шалгалтын явцад бүтээгдэхүүнээс дээж (цаашид «дээж» гэх) авах бол улсын байцаагч тусгайлан акт бичих бөгөөд түүнд дараах зүйлийг тусгана. Үүнд:

- Дээж авах тухай акт бичсэн он, сар, өдөр, газар
- Шалгуулагч этгээдийн нэр, хаяг
- Дээж авахад байлцсан шалгуулагч этгээдийн төлөөлөгчийн нэр, албан тушаал
- Дээж авсан улсын байцаагчийн эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал
- Дээж авах үндэслэл, шаардлага
- Импортолсон улс болон үйлдвэрлэгчийн нэр
- Дээж авсан хугацаа, бүтээгдэхүүний нэр, төрөл, савлалт, цувралын дугаар, үйлдвэрлэсэн болон хадгалалтын дуусах хугацаа, нийт импортолсон болон дээж авсан тоо хэмжээ, дээжийн үнэ зэргийг тусгана.

Мөн тус актыг гурван хувь үйлдэх бөгөөд шалгуулагч этгээд болон итгэмжлэгдсэн лабораторид тус тус нэг хувийг өгч, үлдэх хувийг шалгалтын хувийн хэрэгт хавсаргана.

Улсын байцаагч холбогдох журмын дагуу дээж авч тухайн дээжийн бүрэн бүтэн байдал, ариун чанар, хадгалалт болон тээвэрлэлт, температурын горимыг хангана.

Дээж авах, түүнийг хадгалах, тээвэрлэхтэй холбогдсон журмыг стандартчилал, хэмжил зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Шалгуулагч этгээд дээж авах явцад байлцаж санал, гомдол гаргах эрхтэй. Мөн бүтээгдэхүүний дээж, загвар авснаар шалгуулагч этгээдийн үйлдвэрлэлийн горимын хэвийн үйл ажиллагаа алдагдах тохиолдолд түүнийг шинжилсэний дараа буцаан олгоно.

Хяналт шалгалтын байгууллага шинжилгээнд авах дээжийн үнийг төлөх бөгөөд тухайн бүтээгдэхүүний үнийг тодорхойлох аргачлалыг санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. Бүтээгдэхүүний үнийг тодорхойлохдоо тухайн бүтээгдэхүүний сүүлийн зургаан сарын бөөний (зах зээлийн) үнийг харгалзана.

Шинжилгээний дүнгээр дээж нь хууль тогтоомж, стандартад заасан шаардлагыг хангаагүй, түүнчлэн тухайн бүтээгдэхүүнд давтан шинжилгээ хийсэн, хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлт гарсан тохиолдолд шинжилгээний төлбөрийг шалгуулагч этгээдээс гаргуулна.

Төрийн хяналт шалгалтын тухай хуульд хяналт шалгалтыг салбарын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч хэрэгжүүлэхээр хуульчилсан байна.

Салбарын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн эрхийг эрхлэх асуудлынх нь хүрээнд тухайн салбарын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх чиг үүрэг хамаарч байгаа Засгийн газрын гишүүн Засгийн газраас баталсан журмын дагуу олгож, цуцална. Хуульд өөрөөр заагаагүй бол хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий төрийн захиргааны төв байгууллагын хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын нэгжийн дарга нь салбарын улсын ерөнхий байцаагч байна.

Хяналт шалгалтын байгууллагад улсын ахлах байцаагч, улсын байцаагч ажиллана. Улсын байцаагч нь Засгийн газраас загварыг нь баталсан, уг улсын байцаагчийг томилох эрх бүхий

албан тушаалтнаас олгосон албаны болон хувийн дугаар бүхий үнэмлэх, тэмдэг, түүнчлэн албан шаардлага, дүгнэлт, акт, торгуулийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Улсын байцаагч дараах нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Хууль тогтоомжоор болон түүнийг үндэслэн төрийн эрх бүхий байгууллагаас удирдлагын тодорхой салбарт нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон тусгай журмын биелэлтэд хяналт тавих
- Хяналт шалгалт хийх объектод саадгүй нэвтрэн орох
- Хяналт шалгалтын ажилд шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах
- Хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд шууд буюу шууд бусаар хор хохирол учруулж байгаа буюу учруулж болох нь зохих ёсоор нотлогдсон, түүнчлэн осол аюул гарч болох тохиолдолд холбогдох ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг бүхэлд нь буюу хэсэгчлэн уг зөрчлийг арилгах хүртэл түр зогсоох, шаардлагатай зүйлийг ариутгах, хоргүйжүүлж цэвэршүүлэх, тухайн барилга байгууламж, машин, тоног төхөөрөмжийн ашиглалтыг зогсоох, холбогдох бүтээгдэхүүнийг худалдах, борлуулахыг хориглох, устгах буюу зохих шаардлагад харшлахгүй бол өөр зориулалтаар ашиглах шийдвэр гаргах, энэ тухай олон нийтэд зарлан мэдээлэх
- Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах
- Улсын байцаагч хийсэн хяналт шалгалт, гаргасан дүгнэлт, бичсэн танилцуулга, албан шаардлага, тоо, баримтын үндэслэл, нотолгооны үнэн зөвийг бүрэн хариуцах
- Хуулийн дагуу Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага оногдуулах
- Хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

Түүнчлэн улсын байцаагч нь хууль тогтоомжийг чанд сахих, хөндлөнгийн нөлөөнд үл автан албан үүргээ үнэнчээр гүйцэтгэх, төр, байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтны хууль ёсны ашиг сонирхол, нэр төрийг хүндэтгэх, өөртэйгээ болон эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүн, садан төрлийн хүмүүст холбогдох асуудлыг шалгахаас татгалзах, хяналт шалгалтыг бүрэн гүйцэд хийх үүрэгтэй.

Салбарын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.9-д заасан нийтлэг бүрэн эрхээс гадна, дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.Үүнд:

- Холбогдох байгууллагатай тохиролцон зохих мэргэжлийн хүмүүсийг хяналт шалгалтын ажилд татан оролцуулах, шаардлагатай асуудлыг магадлах зорилгоор лабораторийн буюу магадлан шинжилгээг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх
- Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хууль бусаар олсон орлого, эд хөрөнгийг акт үйлдэж улсын орлого болгох, түүнчлэн бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх
- Энэ хуулийн 10.9.7-д заасан шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд хуульд өөрөөр заагаагүй бол улсын байцаагчийн шийдвэрийг шүүхээр баталгаажуулан албадан гүйцэтгүүлэх, эсхүл тухайн үйлдвэрлэл, үйлчилгээг бүрмөсөн зогсоох тухай санал, дүгнэлтээ холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх
- Ноцтой осол аюул гарсан, хүний амь нас, эрүүл мэнд хохирсон, их хэмжээний хор хохирол учирсан тохиолдолд болон илэрсэн зөрчил нь гэмт хэргийн шинжтэй бол шалгалтын акт, холбогдох баримт бичгийг эрх бүхий байгууллагад шилжүүлэх
- Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын удирдамжийг батлах

- Улсын байцаагчийн үйл ажиллагаа болон хяналт шалгалттай холбогдуулан гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.12.2, 10.12.3-т заасан бүрэн эрхийг улсын ахлах байцаагчгүй суманд сумын улсын байцаагч хэрэгжүүлнэ.

Схем 1.2. *Зөрчил илрүүлэх ажиллагааны схем*

Иргэн байгууллагаас ирүүлсэн мэдээлэл	• Байгаль хамгаалахад туслах сайн дурын иргэд, байгууллагаас мэдээ баримт ирүүлсэн.
Хууль сахиулах бусад байгууллагаас ирүүлсэн мэдээ, материал	• Цагдаа, тагнуул, хилийн цэрэг, авилгатай тэмцэх газар гэх мэт байгууллагуудаас байгаль орчны эсрэг зөрчлийн талаар ирүүлсэн баримт, мэдээ материал
Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон Байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх	• Төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх, гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх • Эргүүл ажиглалт хийх. Үүнд: - явган ажиглалт хийх - морьтой ажиглалт хийх - завьтай ажиглалт хийх - техник хэрэгсэл (камер, дрон) ашиглаж ажиглалт хийх - машинтай ажиглалт хийх - мотоциклтай ажиглалт хийх; • Байгаль орчны эсрэг зөрчил үйлдэгдэж болзошгүй цэг газруудын судалгаа хийж хяналт шалгалт хийх • Байгаль орчны эсрэг зөрчил үйлдэгдэж байсан нутаг дэвсгэр, байр, барилга байгууламж, өрөө тасалгаа, тоног төхөөрөмж, бусад объект, тээврийн хэрэгсэл, ачаа бараанд үзлэг хийх, бүтээгдэхүүн болон тухайн үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны орчноос дээж авч шинжлэх, турших, учирсан хор хохирол болон гаргасан зөрчлийн хоорондох уялдаа холбоог тогтоох зорилгоор шинжилгээ явуулах гэх мэт хяналт шалгалт хийх хуульд заасан арга хэрэгслийг ашиглана.

Улсын байцаагчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх баталгаа

Улсын байцаагч Төрийн албаны тухай хууль тогтоомжид заасан төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгаа, нэмэгдэл баталгаа, түүнд олгох цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, шагнал урамшил, тэтгэвэр, тэтгэмжээс гадна, дор дурдсан нэмэгдэл баталгаагаар хангагдана. Үүнд:

- Хяналт шалгалт хийх бүрэн эрхээ хэрэгжүүлж явахдаа хот, суурингийн доторх нийтийн тээврийн хэрэгсэл (таксинаас бусад)-ээр зорчсон тохиолдолд хувиас гарсан зардлыг тогтоосон журмын дагуу тухайн байгууллага нь нөхөн олгох
- Хяналт шалгалт хийх бүрэн эрхээ хэрэгжүүлж яваад хөдөлмөрийн чадвараа түр алдсан бол хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж, албан тушаалын цалингийн зөрүүг хөдөлмөрийн чадвараа түр алдсан хугацааны туршид, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр, албан тушаалын цалингийн

зөрүүг хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авч байгаа хугацааны туршид тус тус авах
- Хяналт шалгалт хийх бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй нь холбогдуулан амь насыг нь хохироосон тохиолдолд түүний албан тушаалын гурван жилийн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламжийг хохирогчийн ар гэрт олгох
- Улсын байцаагч нь хянан шалгах үүргээ гүйцэтгэхэд шаардагдах хөдөлмөр хамгаллын хувцас болон техник хэрэгслээр хангагдах, бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй нь холбогдуулан доромжилсон, гүтгэсэн, дарамталсан, амь нас, эрүүл мэндэд нь бодит аюул заналхийлсэн бол цагдаагийн байгууллагаар аюулгүй байдлаа хангуулах арга хэмжээ авахуулах
- Хуульд заасан үндэслэл журмын дагуу тэтгэвэр, тэтгэмж болон албан тушаалын цалингийн зөрүү, буцалтгүй тусламжийг улсын төсвөөс олгож, уг хөрөнгийг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

Хяналт шалгалтын шийдвэрийн талаар гомдол гаргах

Улсын байцаагч, улсын ахлах байцаагчийн шийдвэртэй холбоотой гомдлыг дээд шатны улсын байцаагч хуульд заасан хугацаанд шийдвэрлэнэ. Хэрэв гомдол гаргагч уг шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргаж болно.

1.3 ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН АГУУЛГА, АЧ ХОЛБОГДОЛ, ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ШИНЖ

1.3.1. Зөрчлийн тухай ойлголт, шинж

Монгол Улсын Их Хурлаас 2017 онд баталсан Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга нь 16 бүлэг, 165 зүйл, 833 хэсэг, 115 заалттай бөгөөд 1500 гаруй үйлдлийг зөрчилд тооцохоор тусгасан байдаг. Энэ хууль нь 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж, нийтээр даган мөрдөж байгаа бөгөөд тухайлбал, 2023 онд 3214414 зөрчил, 2024 оны 6 дугаар сарын байдлаар 1483102 зөрчил тус тус бүртгэгдсэн байна. Зөрчлийн тухай хуулийг бүхий л салбарт үйлдэгдсэн зөрчлийг шалган шийдвэрлэхэд нэг мөр дагаж мөрдөнө.

Зөрчлийн тухай хуулийн зорилго нь хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг зөрчилд тооцох, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах замаар шударга ёсны тогтолцоог бэхжүүлэхэд оршино.

Зөрчлийн тухай хуулийн 2.1 дүгээр зүйлд Зөрчил гэж хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, энэ хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхүй хэмээн тодорхойлсон байна. Зөрчил нь эрх зүйн зөрчил болохын хувьд дараах үндсэн шинжтэй байна. Үүнд:

- Эрх зүйн эсрэг чиглэсэн байх (эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн, хууль зүйн үүргээ үл биелүүлэх)
- Хүн, нийгэм, төр, аж ахуйн нэгж байгууллагад (хуулийн этгээдэд) хор аюултай байх (гэм хор учруулах, бусад аюултай байдал үүсэх)
- Гэм буруутай зан үйл байх (гэм буруугийн санаатай болон болгоомжгүй хэлбэртэй байна)
- Эрх зүйн эсрэг үйлдэл, эс үйлдэхүй байх (хүний хүсэл зоригоос үл хамаарах үйл явдал ба санаа бодол үл хамаарна)
- Эрх зүйн хариуцлага хүлээлгэхээр хуульчлагдсан байх (эрх зүйн зохих санкц хэрэглэх үндэслэлтэй байна) зэрэг болно.

Зөрчил гэдэг ойлголтыг олон улсад Delict, Conflict, Violence зэрэг үгсээр илэрхийлдэг бөгөөд улс орон бүр дотоодын хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүддээ тодорхой тусгаж, зохицуулж байна. Зөрчил хэмээх ойлголтыг эрдэмтэн, судлаачид янз бүрээр тодорхойлж, тайлбарласан байдаг. Тухайлбал, Ж.Руссо “Зөрчил гэдэг нь захиргааны үйл ажиллагаанаас эхтэй, эдгээр нь төрийн болон захиргааны эрх ашгийн эсрэг үйлдэгддэг үйлдэл, эс үйлдэхүй юм”, харин судлаач Carrara “Зөрчил нь хувь хүний эрх чөлөө, аюулгүй байдлын эсрэг үйлдэл”, Alimena “Зөрчил гэдэг нь ирээдүйд учирч болох том аюулыг зогсоох үйлдэл”, Grafala “Зөрчил нь иргэншлээр үүссэн хүний эрхэд халдах үйлдэл, субьектив эрхэд үл хамаарах ойлголт юм” хэмээн тус тус тайлбарласан байдаг.

Герман улсад 18-р зууны дунд үеэс зөрчлийг гэмт хэргээс тусдаа ойлголт хэмээн авч үзэх болсон. Энэ жишгээр бусад улс орнууд зөрчлийн тухай ойлголтыг хэрэглэж эхэлжээ. Ингэхдээ зөрчлийг улс орон болгон өөрийн хууль тогтоомжид тохируулан “захиргааны хариуцлага (шийтгэл)”-ын тухай хуулиндаа тусган оруулж, хэрэгжүүлж байна.

Манай улсын хувьд албан ёсоор Захиргааны хариуцлагын тухай хуулийг 1992 онд баталж, хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээр захиргааны албадлагын арга хэмжээ, түүний дотор шийтгэлийн төрөл хэмжээг нарийвчлан тогтоож, захиргааны зөрчил гаргасан этгээдэд захиргааны хариуцлага хүлээлгэхтэй холбогдон үүссэн харилцааг зохицуулах болсон юм.

Үүнээс өмнө Ардын Их Хурлийн тэргүүлэгчдийн зарлиг, тогтоол зөрчсөн үйлдлийг зөрчилд тооцож шийтгэл хүлээлгэж байжээ. Харин 2017 онд батлагдсан Зөрчлийн тухай хуульд “Хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, энэ хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхүйг **зөрчил гэнэ**” хэмээн тодорхойлжээ.

Захиргааны хэм хэмжээ зөрчсөн гэж “Хуулиар эрх олгосон хүрээнд Төрийн эрх бүхий байгууллага Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу боловсруулж, баталсан нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам” зөрчсөн үйлдэл эс үйлдэхүй юм. Эдгээр дүрэм, журмуудыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлсэн байх шаардлагатай. Зөрчил нь хүн, хуулийн этгээдийн идэвхтэй үйлдэл буюу эс үйлдэл зан үйлээр дамжин илэрдэг.

Үйлдэл хийх гэдэг нь хүн, хуулийн этгээдийн идэвхтэй байдал, үйл хөдлөлөөр илэрхийлэгдэнэ. Жишээ нь, Дархан цаазат газар ан агнах г.м.

Эс үйлдэл нь тухайн хүн тодорхой нөхцөлд өөрийн хийх ёстой байсан буюу гүйцэтгэх үүрэгтэй байсан үйлдлийг хийгээгүйгээс нийгэмд аюултай хор уршиг бий болгох явдал юм. Жишээ нь, хөдөлмөр хамгаалал хариуцсан ажилтан ажлын талбай дээр ажиллаж байгаа хүмүүс хөдөлмөр хамгааллын журам зөрчиж байгааг мэдсээр байж түүнийг засаж залруулах, зөрчлийг таслан зогсоохгүй үл тоож байгааг хэлнэ.

Зөрчил нь эрх зүйн зөрчил болохын хувьд дараах шинжтэй байна. Үүнд:

- Эрх зүйн зөрчил нь эрх зүйн эсрэг чиглэсэн буюу эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй мөн. Өөрөөр хэлбэл, хууль тогтоомжоор хийхийг нь урьдчилан хориглосон үйлдлийг хийсэн, эсвэл заавал хийх үйлдлийг хийгээгүй байна.
- Эрх зүйн зөрчил нь нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүй бөгөөд төр, нийгэм, иргэнд материаллаг болон материаллаг бус хор уршиг учруулдаг үйлдэл, эс үйлдэхүй гэж ойлгож болно.
- Эрх зүйн зөрчил нь үйлдэл, эс үйлдэхүйгээр илэрдэг.
- Эрх зүйн зөрчил нь хууль зүйн хариуцлага хүлээлгэхээр хууль тогтоомжид заасан үйлдэл, эс үйлдэхүй мөн. Эрх зүйн зөрчил гаргасан байх нь хууль зүйн хариуцлага хүлээлгэх бодит үндэслэл болно.
- Эрх зүйн зөрчил нь хууль зүйн хариуцлага хүлээх чадамжтай этгээдийн хууль бус үйлдэл, эс үйлдэхүй юм.

Зөрчлийн тухай хуульд “Тодорхой үйлдэл, эс үйлдэхүйг зөрчилд тооцсоныг мэдээгүй нь тухайн зөрчлийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг шийтгэл, албадлагын арга хэмжээ хэрэглэхээс чөлөөлөх үндэслэл болохгүй” хэмээн тодорхой тусгасан байдаг. Мөн бичиг үсэг мэдэхгүй, хууль олж уншаагүй, ийм хууль батлагдсаныг мэдээгүй, хуулийг буруу ойлгосон, мэргэжлийн хүнээс асуухад энэ үйлдлийг хууль бус үйлдэл биш гэж хэлсэн, бүх хүмүүс л хууль зөрчдөг гэсэн буруу ойлголт, миний мэдэхийн энэ үйлдлийг хууль бус гэж үздэггүй гэх мэт тайлбартай хууль зөрчсөн үйлдэлд Зөрчлийн тухай хуульд зааснаар шийтгэл оногдуулна.

Зөрчлийн тухай хуульд зааснаар зөрчил тус бүрд шийтгэл оногдуулна. Тухайлбал, ах дүү хоёр тарвага агнахыг хориглосон хугацаанд тарвага агнасан бол тус тусад нь Зөрчлийн тухай хуульд зааснаар шийтгэл оногдуулна.

Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулийн уялдаа холбооны өөр нэг чухал асуудал бол гэмт хэрэг, зөрчил нь нийгмийн хор аюулын шинж чанар, хэр хэмжээгээрээ ялгагдах хэдий боловч харилцан бие биенийгээ нөхөх замаар хоорондоо харилцан нөхцөлдсөн байдагт оршино.

Учир нь гэмт хэргийн нийгэмд аюултай шинж байнга хувьсан өөрчлөгдөж байдаг ойлголт бөгөөд үүнтэй холбоотойгоор Эрүүгийн хууль гэмт хэргийн шинж, Зөрчлийн тухай хуулиар зөрчлийн шинжийг ялган зааглана.

Зөрчлийн тухай хуулийн 2.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хууль, захиргааны хэм хэмжээний актыг биелүүлэх боломжтой ч түүнийг хангах талаар зохих арга хэмжээг хэрэгжүүлээгүй бол зөрчил үйлдсэн гэж үзнэ” гэсэн нь зөрчил үйлдэх хэлбэрийг заасан хэрэг юм. Урьд бидний үзэж байсанчлан зөрчлийн гэм буруу гэсэн ойлголт байхгүй болсон бөгөөд санаатай, болгоомжгүйгээр зөрчил гаргасан нь зөрчлийн зүйлчлэлд нөлөөлөхгүй бөгөөд шийтгэл хүлээлгэнэ.

Аливаа эрх зүйн зөрчил нь өөрийн гэсэн онцлог шинжийг агуулдаг бөгөөд үүнийг хууль зүйн болон эрх зүйн шинжлэх ухаанд зөрчлийн бүрэлдэхүүн гэж тайлбарласан байдаг. Зөрчлийн бүрэлдэхүүн гэдэг нь тухайн үйлдэл, эс үйлдэхүйг эрх зүйн зөрчил мөн болохыг тодорхойлж, эрх зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй гэдгийг илэрхийлдэг объектив ба субъектив шинжүүдийн нийлбэр бүрдэл бөгөөд дараах хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

- Объект (өртөгдөхүүн)
- Объектив тал (гадаад шинж)
- Субъект (эзэн этгээд)
- Субъектив тал (дотоод шинж).

Объект гэдэг нь эрх зүйн зөрчил гаргагчийн үйлдэл, эс үйлдэхүйд өртөгдөн зөрчигдсөн бөгөөд эрх зүйгээр хамгаалагдсан хүн, төр, нийгмийн эрх, ашиг сонирхол юм. Жишээ нь, хүний амьд явах, өмчлөх, сурч боловсрох, чөлөөтэй зорчих, хөдөлмөрлөх эрх, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, Монгол Улсын тусгаар тогтнол, Үндэсний аюулгүй байдал, хилийн халдашгүй дархан байдал, байгаль орчин гэх мэт.

Объектив тал гэдэг нь эрх зүйн зөрчлийн гадаад илрэх байдал бөгөөд эрх зүйн зөрчил гаргагч этгээдийн хууль бус зан үйл, түүнтэй холбоотой бусад шинжээс бүрдэнэ. Эрх зүйн зөрчил нь объектив талын хувьд субъектын хууль бус зан үйл болох үйлдэл, эс үйлдэхүйгээр илэрнэ. Үүнийг эрх зүйн зөрчлийн объектив талын үндсэн шинж гэнэ. Харин объектив талын нэмэгдэл шинжид хор уршиг, шалтгаант холбоо, эрх зүйн зөрчил гарсан цаг хугацаа, газар, нөхцөл байдал, арга зэвсэг хэрэгсэл гэсэн элементүүд хамаарна.

Үйлдэл - субъектын ухамсарт үйл ажиллагаагаар хэрэгжсэн, идэвхтэй зан үйл, үйлдэл нь биеийн хөдөлгөөн болон эд зүйл, амьтан, техник хэрэгсэл, хэрэг хариуцах чадваргүй буюу бага насны хүүхэд ашигласан явдлаар ч илэрч болно. Жишээ нь, хүнийг зодох, буудах, хутгалах, боох гэх мэт.

Эс үйлдэхүй - тодорхой нөхцөлд заавал хийх ёстой эсхүл хийж болох байсан үйлдлийг хийгээгүй идэвхгүй зан үйл юм. Жишээ нь, эх нь нярай хүүхдээ хөхүүлэхгүй байсаар байгаад алах, жолооч дайрсан хүндээ эмнэлгийн тусламж үзүүлэхгүй орхих, татвар төлөхөөс зайлсхийх гэх мэт.

Хор уршиг - эрх зүйн зөрчлийн улмаас үүссэн үр дагавар бөгөөд энэ нь хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, мөн эдийн бус шинжтэй (нэр төр, алдар хүнд, сэтгэл санаа г.м) бага бус, үлэмж, их, онц их хэмжээний байж болно.

Шалтгаант холбоо - үйлдэл, эс үйлдэхүй ба хор уршиг хоорондын объектив бодит холбоо хамаарал.

Цаг хугацаа - эрх зүйн зөрчил гаргасан үе, эрх зүйн зөрчлийн хор уршиг хэзээ илэрснээс үл хамаарч тухайн зөрчил гаргасан үеийг эрх зүйн зөрчил үйлдсэн цаг хугацаанд тооцно. Цаг хугацаа нь тухайн зөрчлийн хуульд заасан шинж болж заагдсан буюу зөрчил гэж үзэхэд хамаарах хуанлын он, сар, өдөр, цаг минутаар болон хууль зүйн нэр томъёогоор илэрдэг бөгөөд эрх зүйн зөрчлийн эхлэл ба төгсгөлийг тогтоох үндэс болно. Жишээ нь, тарвага агнахыг хориглосон үе гэх мэт.

Газар - эрх зүйн зөрчил гаргасан, хуульд заагдсан нутаг дэвсгэр, ийм нутаг дэвсгэрт хуурай газар, газрын хэвлий, усан мандал, агаарын орон зай хамаарна.

Нөхцөл байдал - тодорхой орон зай, цаг хугацааны хүрээнд хамаарах эрх зүйн зөрчил гаргах үеийн бодит ахуй орчин. Энэ нь эрх зүйн зөрчилд түүний нийгмийн аюулын шинж чанарыг ихэсгэх буюу багасгах байдлаар нөлөө үзүүлдэг объектив нөхцөл бөгөөд заримдаа зориудаар бий болгосон юм уу тохиолдлын шинжтэй байж болно. Тухайлбал, нийтэд учирсан гамшигт байдлыг далимдуулан эрх зүйн зөрчил үйлдэх гэх мэт.

Арга - эрх зүйн зөрчил гаргагчийн зүгээс өөрийн эрх зүйн зөрчил үйлдэх санаа зорилгоо биелүүлэхээр сонгон авсан үйл хөдлөлийн тодорхой журам, түүнийг хэрэгжүүлэх дэс дараллыг багтаасан ойлголт.

Зэвсэг хэрэгсэл – субъект эрх зүйн зөрчил үйлдэхдээ учруулж болох хор аюулыг ихэсгэх, түргэсгэх, хүч нэмэгдүүлэх, хохирогчийн эсэргүүцлийг няцаах, учирч болох саадыг зайлуулах, эрх зүйн зөрчлийн үйлдлээр олж авсан эд зүйлийг тээвэрлэх, хэргийн газраас зугтаах зэрэгт хэрэглэсэн төрөл бүрийн галт болон хүйтэн зэвсэг, тээврийн бүх төрлийн хэрэгсэл, хориотой үйлдвэрлэл, үйлчилгээ явуулсан техник тоног төхөөрөмж, түүхий эд, багаж хэрэгсэл, барилга байгууламж зэрэг хамаарна.

Субъект. Эрх зүйн зөрчил гаргагч эзэн этгээд. Эрх зүйн зөрчлийн субъектэд иргэн, аж ахуй нэгж байгууллага, төрийг хамааруулж үзнэ. Хувь хүн эрх зүйн зөрчлийн субъект болох шинжийг авч үзвэл;

- Эрх зүйн зохих зөрчил гаргасан байх
- Хэрэг хариуцах чадвартай байх
- Хуулиар тогтоосон насанд хүрсэн байх
- Гаргасан эрх зүйн зөрчилдөө гэм буруутай байх ёстой.

Субъектив тал эрх зүйн зөрчлийн дотоод агуулгын шинж бөгөөд зөрчил гаргагчийн гэм буруу, сэдэл, зорилго, сэтгэл санааны байдал гэсэн элементээс бүрддэг.

- Гэм буруу гэж субъектээс өөрийн үйлдэл, эс үйлдэхүй, түүний улмаас бий болох хор уршигт хандсан сэтгэхүйн харьцааг хэлдэг бөгөөд гэм буруу нь санаатай ба болгоомжгүй гэсэн 2 хэлбэртэй байна.
- Гэм буруугийн санаатай хэлбэр нь субъект өөрийн үйлдэл, эс үйлдэхүйг ухамсарлан ойлгосон бөгөөд өөрийн үйлдэл эс үйлдэхүйн улмаас учрах хор уршгийг мэдсээр атал хүсэж буюу эсхүл тэр хор уршигт зориудаар хүргэсэн байхыг хэлнэ.
- Санаатай хэлбэр нь шууд ба шууд бус санаа гэж 2 ангилагдана. Шууд санаа гэдэг нь хүсэж үйлдсэн, шууд бус гэж хүсээгүй боловч хор уршигт зориуд хүргэсэн байхыг хэлнэ.
- Болгоомжгүй хэлбэр гэдэг нь субъект өөрийн үйлдэл, эс үйлдэхүйг ухамсарлан ойлгосон боловч хор уршиг гаргахгүй байж чадна гэж хөнгөмсгөөр найдсан эсхүл эрх зүйн хэм хэмжээ зөрчинө, хор уршиг учирна гэдгийг урьдаас мэдэх ёстой, мэдэх бололцоотой байсан атал мэдээгүй үйлдсэн байхыг хэлнэ.

- Болгоомжгүй хэлбэр нь хөнгөмсгөөр найдсан, хайхрамжгүй хандсан гэж 2 ангилагдана. Хөнгөмсгөөр найдсан гэдэг нь эрх зүйг зөрчихгүй байж чадна гэж баттай итгэсэн боловч хор уршиг учруулсан явдал юм. Хайхрамжгүй хандсан гэж гэмт үйлдлийнхээ нийгмийн хор аюулыг ухамсарлаагүй, мөн ухамсарлах, урьдчилан харах ёстой байтал урьдаас харж чадаагүй зэрэг байдлаар илэрнэ.

Дээрх шинжүүд нь Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил нэг бүрд яригддаг хууль зүйн ойлголт юм. Аливаа зөрчлийн бүрэлдэхүүний шинжийг тодорхойлох нь тухайн зөрчлийг хууль зүйн үндэслэлтэй нотлох, зөрчил үйлдэгдсэн этгээдэд шийтгэл хүлээлгэх үндэс нь болдог.

1.3.2. Зөрчил, түүнийг үйлдсэн хугацаа ба газрын тухай ойлголт

Хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, энэ хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхүйг **зөрчил** гэнэ. Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд нь хууль, захиргааны хэм хэмжээний актыг биелүүлэх боломжтой байсан боловч түүнийг биелүүлэх зохих арга хэмжээг хэрэгжүүлээгүй бол зөрчил үйлдсэнд тооцно. Хуулийн этгээдийг төлөөлөн, түүний ашиг сонирхлын төлөө энэ хуульд заасан зөрчил үйлдсэн бол хуулийн этгээдэд энэ хуулийн тусгай ангид заасан шийтгэл оногдуулна.

Хуулийн этгээдэд шийтгэл оногдуулсан, албадлагын арга хэмжээ хэрэглэсэн нь тухайн зөрчлийг үйлдсэн хүнийг эрүүгийн хариуцлага, шийтгэл, албадлагын арга хэмжээнээс чөлөөлөх үндэслэл болохгүй. Зөрчлийг хамтран үйлдсэн хүн, хуулийн этгээд тус бүрд шийтгэл оногдуулна.

Зөрчлийн тухай хуулийн 2.4 дүгээр зүйлд *Зөрчил үйлдсэн хугацаа* гэж зөрчлийн үр дагавар хэзээ илэрснээс үл хамааран тухайн зөрчил үйлдэгдсэн үеийг, мөн зөрчил тодорхой хугацаанд үргэлжилсэн бол үйлдэгдэж дууссан, эсхүл таслан зогсоогдсон үеийг зөрчил үйлдсэн хугацаанд тус тус тооцохоор заасан байдаг.

Мөн түүнчлэн тус хуулийн 2.5 дугаар зүйлд *Зөрчил үйлдсэн газар* гэж зөрчил үйлдэгдсэн, түүний үр дагавар илэрсэн газрыг зөрчил үйлдсэн газарт тооцно хэмээн заасан байдаг.

1.3.3. Шийтгэл, түүний төрөл ба шийтгэл хүлээх хүн, хуулийн этгээдийн тухай

Шийтгэл оногдуулах үндэслэл. Шийтгэлийн зорилго нь хүн, хуулийн этгээдийг зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, зөрчил үйлдсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэх, шударга ёсыг тогтооход оршино.

Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд зөрчлийн шинжийг харгалзан энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу шийтгэл оногдуулна. Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийг үүргээ биелүүлээгүйтэй нь холбогдуулж шийтгэл оногдуулсан нь уг үүргээ биелүүлэхээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

Нэг үйлдэл, эс үйлдэхүй нь энэ хуулийн тусгай ангид заасан хоёр, эсхүл түүнээс дээш зөрчлийн шинжтэй бол аль хүнд шийтгэл оногдуулахаар заасан зөрчилд нь шийтгэл оногдуулна. Энэ хуулийн тусгай ангид заасан бол энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан зөрчилд оногдуулах үндсэн шийтгэл дээр нэмж бусад зөрчилд оногдуулахаар заасан нэмэгдэл шийтгэл, албадлагын арга хэмжээг оногдуулна.

Шийтгэлийн төрөл. Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуулийн 3.3 дугаар зүйлд зааснаар торгох шийтгэл, нийтэд тустай ажил хийлгэх, баривчлах болон эрх хасах шийтгэл оногдуулна. Харин торгох, баривчлах шийтгэлийг үндсэн, нийтэд тустай ажил хийлгэх, эрх хасах шийтгэлийг нэмэгдэл шийтгэлийн хэлбэрээр оногдуулна.

Торгох шийтгэл. Зөрчлийн тухай хуулийн тусгай ангид заасан хэмжээгээр шүүх, эрх бүхий албан тушаалтнаас мөнгөн төлбөр оногдуулахыг торгох шийтгэл гэнэ.

Торгох шийтгэлийн хэмжээ нь хүнд арваас хорин мянган торгуулийн нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, хуулийн этгээдэд нэг зуугаас хоёр зуун мянган торгуулийн нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна.

Шүүх, эрх бүхий албан тушаалтан зөрчил үйлдэгчийн хөрөнгө, цалин хөлс, бусад орлогыг харгалзан торгох шийтгэлийг нэг жил хүртэл хугацаанд хэсэгчлэн төлүүлэхээр шийдвэрлэж болно. Зөрчийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд хөрөнгө, орлого, нөхөн төлбөр, хохирлын тодорхой хувиар тооцсон хэмжээгээр торгох шийтгэлийг оногдуулна.

Энэ хуулийн тусгай ангид заасны дагуу торгох шийтгэлийг сонгож оногдуулахаар заасан зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол эрх бүхий албан тушаалтны саналаар шүүх баривчлах шийтгэлээр солино.

Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний акт зөрчсөнтэй холбогдуулан эрх бүхий этгээдээс оногдуулсан торгох шийтгэлийг хуульд заасан хугацаанд биелүүлээгүй бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх авах, сунгах, ангилал нэмэх, өөрчлөх, нөхөн авах, тээврийн хэрэгслийн эзэмшлийн шилжилт хөдөлгөөн хийх эрхийг хязгаарлана. Хүн, хуулийн этгээд эрх бүхий этгээдээс оногдуулсан торгох шийтгэлийг энэ хуулийн 3.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан хугацаанд биелүүлээгүй бол цагдаагийн алба хаагч тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг торгох шийтгэлийг биелүүлж дуусах хүртэл хугацаанд хязгаарлана. Энэ тохиолдолд тээврийн хэрэгслийг хуульд заасан журмын дагуу тусгай талбайд хүргэх, эсхүл холбогдох хууль тогтоомжид заасан бусад аргаар хөдөлгөөнийг нь хязгаарлана.

Шийтгэлийн хэмжээг хөнгөрүүлэх, нэмэгдүүлэх үндэслэл. Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд нь эрх бүхий албан тушаалтан, шүүхээс оногдуулсан торгох шийтгэлийг хуулиар тогтоосон хугацаанд биелүүлэх бол шийтгэлийн хэмжээг 50 хувиар хөнгөрүүлнэ. Зөрчийн хуульд заасан шийтгэлийн хэмжээг хөнгөрүүлсэн нь зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд албадлагын арга хэмжээ авахгүй байх үндэслэл болохгүй.

Хуульд заасны дагуу шийтгэлийн хэмжээг хөнгөрүүлэх үндэслэл Зөрчлийн тухай хуулийн 5.2, 5.3, 5.4, 5.5, 5.6, 5.7, 5.8, 5.10, 5.11, 5.12, 5.13, 5.14, 5.15, 5.18, 5.20, 6.4, 6.5, 6.6, 6.7, 6.8, 6.10, 6.11, 6.12, 6.14, 6.15, 6.17, 6.18, 6.20, 6.22, 6.23, 6.26, 6.27 дугаар зүйл, Долдугаар бүлэг, 8.1, 8.6, 8.7, 8.8, 8.9, 9.7, 10.3, 10.7, 10.15, 10.25 дугаар зүйл, Арван нэгдүгээр бүлэг, 12.1, 12.2, 12.3, 12.4, 12.5, 12.6, 12.8, 12.9, 12.10, 12.11, 13.1, 13.2, 13.4, 13.5, 13.6, 14.1, 14.2, 14.3, 14.4, 14.5, 14.6, 14.8, 14.9, 14.10, 14.11, 14.12, 14.13 дугаар зүйл, Арван тав, Арван зургадугаар бүлэг, 17.1 дүгээр зүйлд заасан зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд хамаарахгүй.

Эрх бүхий албан тушаалтнаас оногдуулсан торгох шийтгэлийг энэ хуульд заасан хугацаанд биелүүлээгүй бол шийтгэлийн хэмжээг 50 хүртэл хувиар нэмэгдүүлнэ.

Нийтэд тустай ажил хийлгэх шийтгэл. Зөрчил үйлдсэн хүн энэ хуулийн 3.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу торгох шийтгэлийг биелүүлээгүй бол шүүхээс тогтоосон нийтийн ашиг сонирхолд тустай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэхийг нийтэд тустай ажил хийлгэх шийтгэл гэнэ.

Шүүх нийтэд тустай ажил хийлгэх шийтгэлийг өдөрт наймаас дээшгүй цагаар, нийт хоёр зуун дөчөөс долоон зуун хорин цагаар тогтооно. Зөрчийн хуулийн 3.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан торгох шийтгэлийг биелүүлээгүй бол торгох шийтгэлийн арван таван нэгжийг найман цагийн нийтэд тустай ажил хийлгэх шийтгэлээр тооцож солино.

Нийтэд тустай ажил хийлгэх шийтгэлийг хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүнд, биеийн эрүүл мэндэд шууд нөлөөлөхүйц нийтэд тустай ажил хийлгэх шийтгэлийг жирэмсэн эмэгтэй, тавин таваас дээш насны эмэгтэй, жараас дээш насны эрэгтэй хүнд оногдуулахгүй.

Баривчлах шийтгэл. Зөрчил үйлдсэн хүнийг долоо хоногоос гуч хоногийн хугацаагаар тусгай зориулалтын байранд саатуулахыг баривчлах шийтгэл гэнэ. Баривчлах шийтгэлийг шүүгч оногдуулна.

Шүүх баривчлах шийтгэлийг энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд оногдуулах ба жирэмсэн эмэгтэй, арван дөрөв хүртэлх насны хүүхэдтэй ганц бие эцэг, эх, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн, баривчлах шийтгэл эдлүүлэхэд саад болохуйц өвчтэй хүнд оногдуулахгүй. Баривчлах шийтгэл оногдуулахгүй тохиолдолд нэг хоногийг арван таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тооцож торгох шийтгэл оногдуулж болно.

Эрх хасах шийтгэл. Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн тодорхой мэргэжлийн үйл ажиллагаа явуулах, эсхүл бусад тодорхой эрхийг гурван сараас хоёр жил хүртэл хугацаагаар хязгаарлах, эсхүл зөвшөөрлийг хүчингүй болгохыг эрх хасах шийтгэл гэнэ. Хууль, захиргааны хэм хэмжээний актад заасан журмын дагуу тооцсон онооны бүртгэлийг үндэслэж эрх хасах шийтгэлийг оногдуулж болно.

Зөрчлийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд эрх хасах шийтгэлийг торгох шийтгэл дээр нэмж оногдуулна. Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд тусгайлан олгогдсон зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулах, эрхээ хэрэгжүүлэх хууль, захиргааны хэм хэмжээний актаар тогтоосон журмыг байнга, эсхүл ноцтой зөрчсөн, эсхүл тусгайлан олгогдсон зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулах, эрхээ хэрэгжүүлэх журмыг зөрчсөн зөрчилд нь оногдуулсан шийтгэлийг биелүүлэхээс санаатайгаар зайлсхийсэн бол эрх хасах шийтгэлийг үндсэн шийтгэл дээр нэмж оногдуулна.

Зөрчлийн үр дагаврыг арилгах. Хууль, эсхүл энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд эрх бүхий албан тушаалтан зөрчлийн үр дагаврыг арилгах, учирч болзошгүй хохирол, хор уршгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авна. Хуульд заасны дагуу зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагааг зөвшөөрөлгүйгээр эрхэлсэн бол зөрчил илэрсэн өдрөөс үйл ажиллагааг зогсооно.

Шийтгэл хүлээх хүн, хуулийн этгээд. Зөрчлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлд зөрчил үйлдсэн, зөрчил үйлдэх үедээ арван зургаан насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай хүнд энэ хуульд заасан шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэх, мөн Зөрчлийн тухай хуулийн тусгай ангид заасан тохиолдолд хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах, түүнчлэн энэ хуульд өөрөөр заагаагүй бол зөрчил үйлдсэн арван дөрвөөс арван найман насны хүний

хувийн байдал, зөрчлийн шинж, зөрчил үйлдэгдсэн нөхцөл байдлыг харгалзан шийтгэлээс чөлөөлж, албадлагын арга хэмжээ хэрэглэж болно хэмээн тус тус заасан байдаг.

Гадаад улсын дипломат эрх ямба, дархан эрх эдэлж байгаа хүнд шийтгэл оногдуулах, албадлагын арга хэмжээ хэрэглэх эсэхийг Монгол Улсын олон улсын гэрээ, хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

Зөрчил үйлдсэн хуулийн этгээд өөрчлөн байгуулагдсан, түүнийг санаатайгаар дампууруулсан, татан буулгасан бол доор дурдсан журмаар шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэнэ. Тухайлбал, (5.1) бусад хуулийн этгээдтэй нийлүүлэн нэг хуулийн этгээд үүсгэсэн бол шинээр бий болсон хуулийн этгээдэд, (5.2) бусад хуулийн этгээдэд нэгтгэсэн бол нэгтгэж авсан хуулийн этгээдэд, (5.3) хуваах, тусгаарлах замаар өөр хуулийн этгээд үүсгэн байгуулсан бол үйлдсэн зөрчилд холбогдох эд хөрөнгө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх, үүрэг, үйл ажиллагааг шилжүүлэн авсан хувь хэмжээгээр нь зохих хуулийн этгээдэд, (5.4) хуулийн этгээдийн зохион байгуулалтын төрөл, хэлбэр, үндсэн зорилгоо өөрчлөх замаар өөрчлөгдсөн бол тухайн өөрчлөгдөн зохион байгуулагдсан хуулийн этгээдэд, (5.5) компани нь толгой компани, түүний үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийн ашиг сонирхлын үүднээс зөрчил үйлдсэн нь тогтоогдсон бол толгой компанид, (5.6) зөрчлийн хэргийг шалган шийдвэрлэх явцад хуулийн этгээдийг санаатайгаар татан буулгасан бол торгох шийтгэл, хохирол, хор уршиг нөхөн төлүүлэх албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх зардлыг эд хөрөнгө хуваарилагдсан хувьцаа эзэмшигчид, (5.7) аливаа хэлбэр, арга, хэрэгслээр эд хөрөнгө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрхийг үндэслэлгүйгээр тухайн хуулийн этгээдээс шилжүүлэн авсан нэгдмэл сонирхолтой этгээдэд, эсхүл эд хөрөнгө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрхийг хариу төлбөргүйгээр шилжүүлэн авсан бусад хуулийн этгээдэд шилжүүлэн авсан хөрөнгийн хувь хэмжээгээр тус тус шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэнэ.

Хуулийн этгээдэд энэ зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэх нь шийтгэлийн зорилгыг хангах боломжгүй бол шүүгч зөрчил үйлдэгдэх үед тухайн зөрчилд холбогдох эд хөрөнгө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх, үүрэг, үйл ажиллагааг бүхэлд нь хариуцаж байсан хуулийн этгээдэд шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэнэ. Энэ зүйлд заасан хуулийн этгээд өөрчлөн байгуулагдахаас өмнө тухайн зөрчлийн талаар мэдсэн эсэхээс нь үл хамааран шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэнэ.

Гадаад улсын хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар Монгол Улсын нутаг дэвсгэрт зөрчил үйлдсэн бол хуулийн этгээдийн нэгэн адил шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэнэ.

Мөн арван дөрвөөс арван зургаа хүртэл насны хүн Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийн 5.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 5.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 5.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 8.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 14.7 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан зөрчил үйлдсэн бол түүнд шийтгэл хүлээлгэнэ.

1.3.4. Албадлагын арга хэмжээ, түүний төрөл

Хөрөнгө, орлогыг хураах, шилжүүлэх. Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулж, зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлогыг эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хураана. Хураасан хөрөнгө, орлогыг хохирол нөхөн төлөхөд зарцуулах, эсхүл устгах, шилжүүлэх эсэхийг холбогдох хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

Зөрчлийн тухай хуульд өөрөөр заагаагүй бол энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хөрөнгө, орлогоос хохирол нөхөн төлөхөд зарцуулж, үлдсэн хэсгийг улсын төсөвт төвлөрүүлнэ. Тайлбар: *“Зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлого” гэж зөрчил үйлдэн олж авсан мөнгө, эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, тэдгээрийг арилжаалж бий болгосон бусад эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, тэдгээрийг түрээслэх, ашиглах замаар олсон бүх төрлийн орлогыг ойлгоно*.

Зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгслийг хураах. Зөрчлийн тухай хуулийн тусгай ангид заасан тохиолдолд эрх бүхий албан тушаалтан зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, зэвсэг, хэрэгслийг хураана. Зөрчил үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, уналгыг хураах, эсхүл түүний үнийг гаргуулах эсэхийг шүүх шийдвэрлэнэ. Зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл нь зөрчил үйлдсэн хүний амьжиргааны эх үүсвэр болсон эд зүйл, хэрэгсэл бол тэдгээрийг хураахгүй.

Зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл гэдэгт зөрчил үйлдэхдээ ашигласан зэвсэг, хэрэгсэл, эд зүйл, тээврийн хэрэгсэл, уналга, зөрчилтэй бараа, бүтээгдэхүүн, эд зүйлийг ойлгоно. Хүн, хуулийн этгээд энэ хуулийн 7.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 11.19 дүгээр зүйлийн 10 дахь хэсэг, 14.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 14.7 дугаар зүйлд заасан зөрчил үйлдэж торгох шийтгэлийг хугацаанд нь төлөөгүй нь энэ хуулийн 3.4 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу автотээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах үндэслэл болно.

Хохирол, нөхөн төлбөр гаргуулах. Зөрчлийн тухай хуулийн тусгай ангид заасан тохиолдолд зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдээс учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, зөрчлийн улмаас учирсан хохирол барагдуулах, хор уршгийг арилгах арга хэмжээнд зарцуулж, үлдсэн хэсгийг улсын төсөвт төвлөрүүлнэ. Тайлбар: *Энэ бүлэгт заасан «эрх бүхий албан тушаалтан» гэж зөрчлийг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтныг ойлгоно*.

Албадан эмчлэх. Зөрчил үйлдсэн хүн донтох сэтгэцийн эмгэгтэй болох нь эмнэлгийн дүгнэлтээр тогтоогдсон бол шүүх түүнийг албадан эмчилгээнд хамруулахаар шийдвэрлэж болно. Албадан эмчлэхтэй холбогдсон харилцааг хуулиар зохицуулна.

Албадан сургалт. Зөрчлийн тухай хуулийн тусгай ангид өөрөөр заагаагүй бол шүүх баривчлах шийтгэл оногдуулахаар заасан зөрчил үйлдсэн хүнд албадан сургалтад хамруулах албадлагын арга хэмжээг хэрэглэж болно. Албадан сургалтыг баривчлах шийтгэлийг эдэлж байх хугацаанд эрх бүхий байгууллага хэрэгжүүлнэ.

Албадан сургалт арван цагаас тавин цагийн хугацаатай байна. Албадан сургалттай холбоотой харилцааг хуулиар зохицуулна.

1.4 ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН ЗАРЧИМ, ҮЙЛЧЛЭХ НУТАГ ДЭВСГЭР, ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦАА

1.4.1. Зөрчлийн тухай хуульд заасан зарчим

Зөрчлийн тухай хуулийн зорилго нь хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг зөрчилд тооцох, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах замаар шударга ёсны тогтолцоог бэхжүүлэхэд чиглэдэг бөгөөд улмаар хүний жам ёсны эрх, эрх чөлөө, шударга ёсыг бэхжүүлэн хамгаалж, нийтлэг хүсэл зоригийг илэрхийлж, нийгмийн харилцааг зохицуулах, хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх, хор уршиг, үр дагаварыг арилгах тогтолцооны нэг хэсэг юм. Энэ хуулийн 1.2 ба 1.3 дугаар зүйлд дараах зарчимд нийцсэн байх шаардлагыг тавьсан байдаг.

Хууль ёсны зарчим. Зөрчлийн шинжийг энэ хууль, бусад хууль, захиргааны хэм хэмжээний актаар тодорхойлно. Зөрчил, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээг энэ хуулиар тогтооно.

Тодорхой үйлдэл, эс үйлдэхүйг зөрчилд тооцсоныг мэдээгүй нь тухайн зөрчлийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг шийтгэл, албадлагын арга хэмжээ хэрэглэхээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

Энэ хуулийг төсөөтэй хэрэглэхгүй. Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хуулийн этгээдэд түүний төрөл, хэлбэр, өмч хөрөнгө, оршин байгаа газар, үйл ажиллагааны чиглэлээс үл хамааран шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэнэ.

Шударга ёсны зарчим. Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээ нь зөрчил үйлдэгдсэн нөхцөл байдал, зөрчлийн шинж, хохирлын хэр хэмжээнд тохирсон байна. Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил тус бүрд шийтгэл оногдуулна.

1.4.2. Зөрчлийн тухай хууль үйлчлэх нутаг дэвсгэр

Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын нутаг дэвсгэрт зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд энэ хуулиар шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэнэ.

Монгол Улсын нутаг дэвсгэрт хамаарах хилийн чанадад байгаа дипломат төлөөлөгчийн газрын эзэмшил нутаг, усан болон агаарын орон зайд байгаа Монгол Улсын усан онгоц, агаарын хөлөгт зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд энэ хуулиар шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэнэ.

Монгол Улсын нутаг дэвсгэрийн хязгаарыг газрын гадаргуу, усны мандал дээр хил залгаа улсын нутаг дэвсгэрийн хязгаараас зааглаж, Монгол Улсын олон улсын гэрээгээр тодорхойлж, тогтоосон шугамыг Монгол Улсын хил гэнэ. Уг шугамаас эгц дээш агаарын, мөн шугамаас эгц доош газрын хэвлийн хил байна. Агаар мандалын дээд хязгаарыг газрын хөрснөөс дээш 60-150 км гэж үздэг. Газрын хэвлий нь түүний өнгөн хөрсний мандал буюу халуун лав, цааш нь цөм буюу төв хүртэл үргэлжлэнэ.

Иймд Монгол Улсын нутаг дэвсгэрт зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуульд заасан шийтгэл оногдуулах үндэслэлтэй бөгөөд тухайн зөрчлийг шалган тогтоох, зөрчил үйлдсэн этгээдэд шийтгэл оногдуулах эсэхийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан журмаар хэрэгжүүлнэ.

Дипломат харилцааны тухай Венийн конвенцод "*Төлөөлөгчийн газрын байр гэж хэн өмчилж буйг үл харгалзан төлөөлөгчийн газрын тэргүүний өргөөг оролцуулан төлөөлөгчийн газрын зорилгод ашиглаж буй барилга буюу барилгын хэсэг, мөн тухайн барилга буюу барилгын хэсгийн эзэлж буй газрыг хэлнэ"* хэмээн тодорхойлжээ. Ер нь олон улсын дипломат ёсонд маш чухал ач холбогдолтой Вена хотноо батлагдсан "Дипломат харилцааны тухай конвенц (1961 он) болон "Консулын харилцааны тухай конвенц (1963 он)" гэх хоёр олон улсын гэрээ байдаг.

Зөрчилд тооцох, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээг тухайн зөрчил үйлдэх үед дагаж мөрдөж байсан хуулийн дагуу шийдвэрлэнэ.

Харин Дипломат эрх ямба, дархан эрх эдэлж байгаа хүнд холбогдуулан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах зөвшөөрлийг Улсын ерөнхий прокурор Монгол Улсын гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар уламжлан тухайн улс, олон улсын байгууллагаас хүснэ. Дипломатуудын хувийн халдашгүй дархан байдал гэдэг нь дипломат ажилтныг өөрийн албан үүргээ гүйцэтгэж буй улсад нь ямар нэгэн байдлаар баривчлах эсхүл хорьж саатуулж болохгүй гэсэн үг юм.

Зөрчилд тооцохгүй болсон, оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээг хөнгөрүүлсэн, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийг буцаан хэрэглэнэ. Харин шинээр зөрчилд тооцсон, оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээг хүндрүүлсэн, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулсан хуулийг буцаан хэрэглэхгүй.

Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хууль хүчин төгөлдөр болохоос өмнө шийтгэл оногдуулах, албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шийдвэрийг гүйцэтгэсэн бол хуулийг буцаан хэрэглэхгүй, харин шийтгэл оногдуулах, албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шийдвэрийг гүйцэтгээгүй байгаа тохиолдолд буцаан хэрэглэнэ.

1.4.3. Зөрчлийн хөөн хэлэлцэх хугацаа

Аливаа хэргийн хөөн хэлэлцэх хугацааны талаарх ойлголт анх эртний Ром улсад бий болсон бөгөөд улмаар эх газрын эрх зүйн тогтолцоотой улс орнуудын хууль тогтоомжуудад тусгалаа олж эхэлсэн байна. Өнөөгийн байдлаар хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай зохицуулалтууд Ром-германы эрх зүйн тогтолцоотой ихэнх улс орнууд хэрэглэж байна. Харин Англи-саксоны эрх зүйн тогтолцоотой улс орнуудад хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх нь хязгаарлагдмал байдаг бөгөөд зөвхөн зарим төрлийн хөнгөн ангиллын гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэдэг онцлогтой.

Зөрчлийн хэргийн хөөн хэлэлцэх хугацаа бол зөрчил үйлдэгчид шийтгэл оногдуулахгүй байх үндэслэлтэй. Зөрчлийн хэргийн хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсний дараа шийтгэл хүлээлгэх, төр, байгууллага, хуулийн этгээдийн болон хохирогчийн зөрчигдсөн эрхийг сэргээх, шударга ёс тогтоох боломж хязгаарлагдана. Иймд зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан

тушаалтнууд аливаа зөрлийг түргэн шуурхай илрүүлж, хөөн хэлэлцэх хугацааны дотор шалгаж шийдвэрлэх шаардлагатай.

Зөрчил үйлдсэн хугацааг тооцох. Зөрчлийн үр дагавар хэзээ илэрснээс үл хамааран тухайн зөрчил үйлдэгдсэн үеийг зөрчил үйлдсэн хугацаанд тооцно. Тухайлбал, зохих зөвшөөрөлгүйгээр байгалийн ургамал түүж бэлтгэх журам зөрчсөн мэдээллийн дагуу шалгахад, Зохих зөвшөөрөлгүйгээр байгалийн ургамал түүж бэлтгэх журам зөрчсөн зөрчил гурван сарын өмнө үйлдэгдсэн нь тогтоогдвол зөрчил үйлдэгдэж байгаа талаарх мэдээлэл ирсэн өдрөөр бус хууль зөрчиж эхэлсэн үеийг зөрчил үйлдсэн хугацаа гэж тооцно.

Харин зохих зөвшөөрөлгүйгээр байгалийн ургамал түүж бэлтгэх журам зөрчсөн зөрчил нь тодорхой хугацаанд үргэлжилсэн бол үйлдэгдэж дууссан эсхүл таслан зогсоосон үеийг зөрчил үйлдсэн хугацаанд тооцно.

Хөөн хэлэлцэх хугацаа. Хуульд өөрөөр заагаагүй бол зөрчил үйлдсэнээс хойш дараах хугацаа өнгөрсөн бол зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахгүй. Үүнд:

1. Зөрчлийн хуульд хүнд арваас таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулахаар заасан зөрчил үйлдсэнээс хойш зургаан сар өнгөрсөн
2. Зөрчлийн хуульд хүнд таван зуугаас дээш арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулахаар заасан зөрчил үйлдсэнээс хойш нэг жил өнгөрсөн
3. Зөрчлийн хуульд хүнд арван мянгаас дээш хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулахаар заасан зөрчил үйлдсэнээс хойш хоёр жил өнгөрсөн
4. Зөрчлийн хуулийн тусгай ангид баривчлах шийтгэл оногдуулахаар заасан зөрчил үйлдсэнээс хойш зургаан сар өнгөрсөн бол зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа тус тус явуулахгүй.

Хугацаа тоолох журам. Зөрчлийг хуулийн этгээд үйлдсэн бол энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан торгох шийтгэлийн хэмжээг арав дахин нэмж дүйцүүлэн хөөн хэлэлцэх хугацааг тогтооно. Зөрчлийн хуулийн тусгай ангид зөвхөн хуулийн этгээдэд шийтгэл оногдуулахаар заасан бол торгох шийтгэлийн хэмжээг арав дахин багасгаж энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан торгох шийтгэлийн хэмжээтэй дүйцүүлэн хөөн хэлэлцэх хугацааг тогтооно.

Хэд хэдэн зөрчил үйлдсэн бол зөрчил бүрд хөөн хэлэлцэх хугацааг тус тусад нь тоолно. Хөөн хэлэлцэх хугацааг зөрчил үйлдсэн өдрөөс эхлэн зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагаа эхлүүлэх өдрийг хүртэл тоолно. Өөрөөр хэлбэл, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа эхэлснээр хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсооно. Харин зөрчлийг хөөн хэлэлцэх хугацааг өөр хуулиар тогтоосон бол тухайн хуулийг дагаж мөрдөнө.

Хэрэв хүн, хуулийн этгээдийн хууль бус үйлдэл, эс үйлдэхүй эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бөгөөд энэ хуулийн дагуу шийтгэл оногдуулах үндэслэлтэй бол хөөн хэлэлцэх хугацааг эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах тухай шийдвэр гарсан өдрөөс эхлэн тоолно.

1.5 ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн зорилт нь зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны үндэслэл, журмыг тогтоож, зөрчлийг шалгах, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах, энэхүү ажиллагааны явцад хүн, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад оршино.

Хуульд заасан үндэслэл, журмын дагуу зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдолтой нотлох баримт илрүүлэх, цуглуулах, бэхжүүлэх, хураан авах зэрэг тодорхой ажиллагаа явуулах үндэслэл журам, зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтны эрх үүрэг, шүүхээр зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаа зэргийг зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан байна.

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа нь зөрчил үйлдэгдсэн газар, хүн, хуулийн этгээдийн эзэмшил газар, барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, хүний бие, эд зүйлд үзлэг хийх, баримт бичиг, мэдээлэл гаргуулан авах, эд зүйл, баримт бичгийг хураан авах, эд хөрөнгийг битүүмжлэх, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, мэдүүлэг авах, шинжилгээнд зориулж хэв загвар, дээж авах, шинжилгээ хийлгэх ажиллагаанаас бүрдэнэ.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд *“зөрчил шалган шийдвэрлэх”* гэж зөрчлийн хэрэг бүртгэлт, түүнд тавих прокурорын хяналт, зөрчил шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагааг, *“зөрчлийн хэрэг бүртгэлт”* гэж зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийг тогтоох, шийтгэл оногдуулах эсэхийг шийдвэрлэх зорилгоор эрх бүхий албан тушаалтны явуулах энэ хуульд заасан ажиллагааг, *“оролцогч”* гэж зөрчилд холбогдогч, хохирогч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг, “*хувийн баримт бичиг”* гэж Монгол Улсын иргэний үнэмлэх, үндэсний гадаад паспорт, албаны болон жолоодох эрхийн үнэмлэх, гадаадын иргэний паспорт, эсхүл тэдгээртэй адилтгах баримт бичгийг ойлгоно хэмээн тус тус тодорхой тусгасан байдаг.

1.5.1. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны хэл, бичиг

Монгол Улсын Үндсэн хуулийн хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна”, мөн хуулийн 8 дугаар зүйлд “Монгол хэл бол төрийн албан ёсны хэл мөн” гэж тус тус заасан байдаг.

БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1945 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн “Бүх хэвлэл ба албан хэргийг шинэ үсгээр байгуулах тухай” 31/27 тоот тогтоолд “Бүх хэвлэл ба улсын албан хэргийг 1946 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн шинэ үсгээр явуулсугай” хэмээн зааснаар крилл монгол бичиг төрийн албан хэрэг хөтлөх албан ёсны бичиг болжээ.

Иймд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг Монгол хэлээр явуулж, төрийн албан ёсны хэл, бичгээр хөтөлж, баримтжуулна.

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны оролцогч этгээд нь Монгол хэл мэддэггүй бол өөрийн эх буюу мэддэг хэл, бичгээр, хэлгүй, дүлий зэрэг хөгжлийн бэрхшээлтэй этгээд дохио, зангаа, тусгай тэмдэгт ашиглан орчуулагч, хэлмэрчийн тусламжтайгаар мэдүүлэг өгөх, гомдол гаргах, шүүх хуралдаанд үг хэлэх, холбогдох материалтай бүрэн танилцах эрхээр хангагдана.

1.5.2. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны хугацаа тоолох журам

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан хугацааг минут, цаг, хоног, сар, жилээр тоолно. Хугацааг тоолж эхэлсэн минут, цаг, хоногийг хугацаа тоолоход оруулахгүй. Хугацааг цагаар тоолоход уг хугацаа нь сүүлийн цаг, минутад дуусна. Хугацааг хоногоор тоолоход уг хугацаа нь сүүлийн хоногийн 24 цагт дуусна. Хугацааг ажлын өдрөөр тоолоход уг хугацаа нь тухайн ажлын өдрийн сүүлийн цаг, минутад дуусна. Хугацааг сараар тоолоход сүүлийн сарын мөн өдөр уг хугацаа дуусна. Хэрэв энэ сард тохирох өдөр байхгүй бол мөн сарын эцсийн хоногт хугацаа дуусна.

Хугацааг жилээр тоолоход хугацаа нь дараа оны тухайн сарын тухайн өдөр дуусна. Хэрэв хугацааны төгсгөл ажлын бус өдөр тохиолдвол хугацааны сүүлийн өдрийг түүний дараагийн ажлын эхний өдрөөр тоолно.

Гомдол, бусад баримт бичгийг хугацаа дуусахын өмнө шууданд өгсөн, саатуулагдсан хүн тухайн байгууллагын, эсхүл саатуулах байрны захиргаанд өгсөн бол хугацаа хэтэрсэнд тооцохгүй. Мөн хуульд “даруй“ гэсэн хугацаа хэрэглэсэн бөгөөд энэ хугацааг тухайн ажиллагааг хийж гүйцэтгэх боломжит хамгийн богино хугацаа гэж ойлгоно.

Хэрэв хугацааны төгсгөл ажлын бус өдөр тохиолдвол гэдэгт Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 96 дугаар зүйлийн Долоо хоног бүрийн амралт (долоо хоног бүрийн бямба, ням гарагт нийтээр амарна) болон тус хуулийн 97 дугаар зүйлийн Нийтээр амрах баярын өдрүүдийг ойлгоно. Иймд энэ хуульд заасан хугацааг ажлын өдрөөр тоолоход уг хугацаа нь тухайн ажлын өдрийн сүүлийн цаг, минутад дуусна гэж заасан ба ажлын өдөр гэж Даваагаас Баасан гаригийг ойлгоно.

1.5.3. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны нууцлал

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч, прокурор, зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах болон эрх бүхий албан тушаалтан нар нь олж мэдсэн хүний эмзэг мэдээлэл, төрийн болон албаны нууцыг задруулахгүй байх, түүнийг хамгаалах үүрэгтэй. Мөн түүнчлэн эдгээр зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгч нар нь хүний эмзэг мэдээлэл, төрийн болон албаны нууцтай холбоотой ажиллагаанд оролцсон, байлцсан хүнд нууцыг задруулахгүй байх үүргийг сануулж, бичгээр баталгаа гаргуулж авна.

2021 онд шинэчлэн найруулсан Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд ***“хүний эмзэг мэдээлэл”*** гэж хүний үндэс, угсаа, шашин шүтлэг, итгэл үнэмшил, эрүүл мэнд, захидал харилцаа, генетик болон биометрик мэдээлэл, тоон гарын үсгийн хувийн түлхүүр, ял эдэлж байгаа болон ял эдэлсэн эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, бэлгийн харьцааны талаарх мэдээллийг, *“хүний хувийн мэдээлэл”* гэж хүний эмзэг мэдээлэл болон хүний эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, төрсөн газар, оршин суугаа газрын хаяг, байршил, иргэний бүртгэлийн дугаар, хөрөнгө, боловсрол, гишүүнчлэл, цахим тодорхойлогч, хүнийг шууд болон шууд бусаар тодорхойлох, эсхүл тодорхойлох боломжтой бусад мэдээллийг, *“эрүүл мэндийн мэдээлэл”* гэж хүний бие махбод, сэтгэцийн эрүүл мэнд болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авсан тухай мэдээллийг, *“хөрөнгийн мэдээлэл”* гэж мэдээллийн эзний өмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа эд хөрөнгийн талаарх мэдээллийг, *“захидал харилцааны мэдээлэл”* гэж захидал, илгээмж, цахим шуудан, харилцаа холбоо, мэдээллийн технологи ашиглан солилцож байгаа мэдээллийг ойлгоно хэмээн тус тус тодорхойлсон.

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 5 дугаар зүйлд ***"төрийн нууц"*** гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төрийн нууцад хамааруулсан, задруулах, үрэгдүүлэх тохиолдолд үндэсний аюулгүй байдал, үндэсний ашиг сонирхолд аюул, занал, хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээллийг, харин ***"албаны нууц"*** гэж задруулах, үрэгдүүлэх тохиолдолд салбарын болон төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн ашиг сонирхолд хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээллийг ойлгоно хэмээн заасан байдаг.

1.5.4. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харъяалал

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлд зөрчлийг шалган шийдвэрлэх, шийтгэл оногдуулах эрх бүхий албан тушаалтан, шүүхийн харьяалал, тэдгээрийн хянан шийдвэрлэх зөрчлийн харьяаллыг тус тус тогтоосон байна.

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг уг зөрчил үйлдэгдсэн нутаг дэвсгэр, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8-д заасан харьяаллын дагуу явуулна. Тухайн зөрчил хэд хэдэн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн бол сүүлчийн зөрчил үйлдэгдсэн нутаг дэвсгэрийн эрх бүхий байгууллага шалган шийдвэрлэнэ. Хуульд заасан тохиолдолд зөрчлийн хэрэг бүртгэлтийн тодорхой ажиллагааг прокурорын зөвшөөрлөөр харьяалах нутаг дэвсгэрээс гадна явуулж болно.

Монгол Улсын нутаг дэвсгэрт хамаарах хилийн чанадад байгаа Дипломат төлөөлөгчийн газрын эзэмшил нутаг, усан, агаарын орон зайд байгаа Монгол Улсын усан онгоц, агаарын хөлөгт гарсан зөрчлийг шалган шийдвэрлэх харьяаллыг Улсын ерөнхий прокурор тогтооно.

Мөн зөрчил үйлдэгдсэн газрыг тогтоох боломжгүй, зөрчлийн хэргийг тухайн орон нутагт шалгахад нөлөөлөл үзүүлж болохуйц нөхцөл байдал тогтоогдсон эсхүл эрх бүхий албан тушаалтан хуулиар хүлээсэн чиг үүргээ хэд хэдэн аймаг, сум, дүүрэгт хэрэгжүүлэх явцад зөрчил илрүүлсэн бол зөрчлийн хэрэг бүртгэлтийн харьяаллыг прокурор тогтооно.

Улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч, байгаль орчны улсын байцаагч нар Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлд зааснаар дараах харьяаллын дагуу зөрчлийг шалган шийдвэрлэнэ. Үүнд:

- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.27-д улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч Зөрчлийн тухай хуулийн 7.7 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 7.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 7.9 дүгээр зүйлийн 1, 3, 4, 5, 7, 8, 10, 11 дэх хэсэг, 7.15 дугаар зүйл, 7.16 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 7.17 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил
- Тус хуулийн 6.37-д байгаль орчны хяналтын улсын байцаагч **Зөрчлийн тухай хуулийн 5.11** дүгээр зүйлийн 1.4, 1.5, 1.6, 1.7, 1.8, 1.9, 2.1, 2.2 дахь заалт, 3, 4, 5, 6 дахь хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 1, 4, 5 дахь хэсэг, 6.1, 6.2, 6.3, 6.4, 6.5, 6.6, 6.7 дахь заалт, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20, 21, 22, 23, 24, 25, 26, 27, 28 дахь хэсэг, 6.24 дүгээр зүйл, 6.30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 7.1, 7.2, 7.4, 7.6, 7.7, 7.8, 7.9 дүгээр зүйл, 7.10 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7 дахь хэсэг, 7.13 дугаар зүйлийн 13 дахь хэсэг, 16.1, 16.3, 16.4, 16.8, 16.10 дахь заалт, 7.15 дугаар зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсэг, 5.2, 5.3 дахь заалт, 6, 7, 8, 9 дэх хэсэг, 7.16 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 7.17, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчлийг тус тус шалган шийдвэрлэнэ.

1.6 ЗӨРЧЛИЙН ХЭРЭГ БҮРТГЭЛТ

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль 2017 онд батлагдахаас өмнө салбарын хүрээнд баталсан журам, дүрмийн дагуу зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааг хэрэгжүүлж байсныг өөрчилж, нэгдсэн журмыг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн Зургадугаар бүлэгт тодорхой тусгасан.

Ийнхүү зөрчил шалгах ажиллагааны төрөл, түүнийг хэрэгжүүлэх журмыг нарийвчлан тусгаснаар эрх бүхий албан тушаалтан ямар төрлийн зөрчилд холбогдуулан хүн, хуулийн этгээдийг шалгаж байгаагаас үл хамааран нийтлэг журмаар ажиллах, хууль хүн бүрд тэгш үйлчлэх эрх зүйн үндэс бүрдсэн.

1.6.1. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах үндэслэл

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд (энэ хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэг) заасан эрх бүхий албан тушаалтан дараах тохиолдолд прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагааг эхлүүлнэ. Үүнд:

- Хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх явцад энэ хуулиар шалган шийдвэрлэхээр харьяалуулсан зөрчлийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйг илрүүлсэн
- Хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас зөрчлийн талаар гомдол гаргасан, эсхүл мэдээлсэн
- Зөрчил үйлдсэн хүн өөрийгөө илчилж ирсэн
- Байгууллага, албан тушаалтнаас харьяаллын дагуу зөрчлийн талаарх холбогдох баримтыг шилжүүлэн ирүүлсэн зэрэг тохиолдол болно.

Зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл, зөрчлийн хэрэг бүртгэлтийн хэрэг тухайн байгууллагын харьяаллын биш болох нь тогтоогдвол прокурорт танилцуулж, харьяаллыг шийдвэрлүүлнэ.

Эрх бүхий албан тушаалтан зөрчлийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйг илрүүлсэн эсхүл гомдол, мэдээллийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор шалгаж, дараах шийдвэрийн аль нэгийг гаргасан даруй прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлнэ. Үүнд:


- Гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзах
- Гомдол, мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлэх
- Хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх
- Зөрчлийн хэрэг нээх зэрэг болно.

1.6.2. Зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл хүлээн авах журам

Эрх бүхий байгууллага нь хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас гаргасан зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг амаар, бичгээр болон харилцаа холбооны хэрэгслээр дамжуулан хүлээн авна.

Бичгээр гаргасан гомдолд гомдол гаргагч эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг эсхүл шуудангийн хаяг, утасны дугаараа бичиж, гарын үсэг зурсан байна.

Амаар шууд эсхүл утас, факс, цахим шуудангаар ирүүлсэн гомдол, мэдээллийг тэмдэглэл үйлдэн хүлээн авна. Тэмдэглэлд бичгээр гаргасан гомдолтой адил мэдээллийг тусгаж, хүлээн авсан эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурна.



Байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд гомдол, мэдээллийг бичгээр гаргах бөгөөд түүнд холбогдох баримт, материалыг хавсаргаж болно.

Эрх бүхий байгууллага, албан тушаалтан зөрчлийн талаарх гомдлыг хүлээн авахдаа дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Гомдол гаргагчид эдлэх эрх, хүлээх үүргийг танилцуулж, санаатай худал мэдээлбэл хуулийн дагуу хариуцлага хүлээх талаар сануулах
- Гомдлыг амаар гаргаж байгаа бол зөрчлийн талаар тэмдэглэлд тусган гомдол гаргагч саналаа оруулж, гарын үсэг зурах боломжоор хангах
- Харилцаа холбооны хэрэгслээр дамжуулан гомдлыг хүлээн авсан бол бэхжүүлэх
- Хүлээн авсан гомдолд тухайн гомдол гаргагч гарын үсэг зурсан эсэхийг нягталж, хүлээн авсан он, сар, өдөр, цаг, минутыг тэмдэглэн бүртгэх дэвтэрт бичих.

Эрх бүхий байгууллага, албан тушаалтан гомдол гаргагч, мэдээлэл өгсөн хүн, мэдээллийн нууцыг хадгалж, шаардлагатай бол мэдээлэгчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авна.

Зөрчлийн талаарх мэдээллийг төлбөртэй авч болох бөгөөд журмыг сангийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батлахаар хуульд тусгажээ.

1.6.3. Зөрчлөө илчлэн мэдээлэх

Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд үйлдсэн зөрчлөө сайн дурааараа хүлээсэн мэдээллийг бичгээр болон амаар гаргаж болно.

Зөрчил үйлдсэн хүн өөрийгөө илчилж ирсэн тохиолдолд эрх бүхий албан тушаалтан түүнд өөрийнхөө болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах эрхтэй болохыг нь танилцуулна.

1.6.4. Зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлэх

Зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл тухайн байгууллагын харьяаллын биш болох нь тогтоогдвол зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан ажлын 3 өдрийн дотор харьяаллын дагуу шилжүүлж, прокурорын нэгдсэн бүртгэлд даруй бүртгүүлнэ.

Эрх бүхий албан тушаалтан зөрчлийг хянан шалгах явцад гэмт хэргийн шинжтэй болохыг тогтоовол холбогдох баримтыг харьяаллын дагуу шалгуулахаар прокурорт даруй шилжүүлнэ.

Эрх бүхий албан тушаалтан, зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан гомдол, мэдээллийг шилжүүлэхдээ шаардлагатай бол зөрчлийг таслан зогсоох, зөрчлийн ул мөрийг хамгаалах, бэхжүүлэх арга хэмжээ авна. Илэрсэн зөрчил нь зөрчлийн хэрэг бүртгэх хэд хэдэн байгууллагад харьяалагдахаар бол прокурорт танилцуулж, өөрийн харьяалах зөрчлөөс бусад гомдол, мэдээллийг харьяаллын дагуу шалгуулахаар даруй шилжүүлнэ.

1.6.5. Зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзах

Хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас ирүүлсэн гомдол, мэдээлэлд хуульд заасан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж болохгүй (Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.9 дүгээр зүйлд заасан) нөхцөл байдал тогтоогдвол хүлээн авахаас татгалзаж, прокурорын нэгдсэн бүртгэлд даруй бүртгүүлж, шийдвэрийг гомдол, мэдээлэл гаргагчид мэдэгдэнэ.

Зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл гаргасан хүн, хуулийн этгээд, албан тушаалтан нь зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзсан эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол гомдлоо прокурорт Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу гаргана.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.9 дүгээр зүйлд зааснаар дараах тохиолдолд зөрчлийн хэрэг нээж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулдаггүй байна. Үүнд:

- Зөрчлийн шинжгүй
- Зөрчлийн тухай хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн
- Тухайн зөрчилд хариуцлага тооцсон хуулийн зүйл, хэсэг, заалт хүчингүй болсон
- Зөрчил үйлдсэн хүн нас барсан
- Тухайн зөрчлийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулсан эрх бүхий албан тушаалтны эсхүл шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр бол
- Зөрчлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт зааснаас бусад зөрчил үйлдсэн этгээд нь арван зургаан насанд хүрээгүй бол
- Зөрчлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт заасан зөрчил үйлдсэн этгээд нь арван дөрвөн насанд хүрээгүй бол тус тус зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг явуулахгүй бөгөөд дээрх үндэслэлийн аль нэг тогтоогдвол тухайн зөрчлийн материалд зөрчлийн хэрэг нээхгүй Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 2.2-д зааснаар гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэнэ.

1.6.6. Хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх

Дараах үндэслэлийн аль нэг нь тогтоогдвол эрх бүхий албан тушаалтан хялбаршуулсан журмаар зөрчлийг шалган шийдвэрлэнэ. Үүнд:

- Зөрчил үйлдэгдсэн нь ил тодорхой, зөрчил, учирсан хохирлыг нотлох талаар зөрчлийн хэрэг бүртгэлт явуулах шаардлагагүй бол

- Зөрчил үйлдэгдсэн, учруулсан хохирол нь нотлох баримтаар тогтоогдож холбогдогч зөрчил үйлдсэнээ сайн дураараа хүлээн зөвшөөрсөн бол
- Зөрчил үйлдсэн болох нь стандартаар баталгаажсан хэмжилт-хяналтын төхөөрөмжөөр нотлогдсон бол хялбаршуулсан журмаар зөрчлийг шалган шийдвэрлэнэ.

Зөрчлийн хэрэг бүртгэлтийн явцад холбогдогч зөрчил үйлдсэнээ сайн дураараа хүлээн зөвшөөрсөн эсхүл зөрчил үйлдсэн нь тогтоогдож байгаа бол эрх бүхий албан тушаалтан хуульд заасан шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ авна.

Харин зөрчлийн холбогдогчийг зөрчил үйлдсэн болохыг хүлээн зөвшөөрүүлэхээр тулган шаардах, албадахыг хориглоно.

Эрх бүхий албан тушаалтан хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэж, шийтгэл оногдуулахдаа дараах нөхцөл байдлыг тогтоосон байна. Үүнд:

- Тухайн хүн, хуулийн этгээдийн зөрчил үйлдсэнийг нотлох баримт бүрдсэн эсэх
- Зөрчлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу зөрчил үйлдсэн хуулийн этгээдийн хариуцлагыг нөхөн хүлээх этгээд байгаа эсэх
- Тухайн үйлдэл, эс үйлдэхүй нь Зөрчлийн тухай хуульд заасан шийтгэл оногдуулах зүйл, хэсэг, заалтад нийцэж байгаа эсэх
- Торгох шийтгэлийг хэсэгчлэн төлүүлэхээр шийдвэрлэх үндэслэлтэй эсэх
- Зөрчлийн тухай хуульд хохирол төлүүлэх, нөхөн төлбөр гаргуулахаар заасан бол хохирол, нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох
- Зөрчлийн тухай хуулийн 3.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан үндэслэлээр эрх хасах шийтгэл оногдуулах үндэслэлтэй эсэх.

Схем 1.3. *Хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа*



Эрх бүхий албан тушаалтан хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэсэн даруй прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлнэ.

1.6.7. Зөрчлийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээх

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд **“Зөрчлийн хэрэг бүртгэлт”** гэж зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийг тогтоох, шийтгэл оногдуулах эсэхийг шийдвэрлэх зорилгоор эрх бүхий албан тушаалтны явуулах энэ хуульд заасан ажиллагаа хэмээн тодорхойлсон байдаг.

Эрх бүхий албан тушаалтан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан зөрчлийн хэрэг нээхгүй тохиолдол үүсээгүй бол зөрчлийн хэрэг нээж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулна.

Харин дараах тохиолдолд зөрчлийн хэрэг нээхгүй. Үүнд:

- Зөрчлийн шинжгүй
- Зөрчлийн тухай хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн
- Тухайн зөрчилд хариуцлага тооцсон хуулийн зүйл, хэсэг, заалт хүчингүй болсон

- Зөрчил үйлдсэн хүн нас барсан
- Тухайн зөрчлийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулсан эрх бүхий албан тушаалтан эсхүл шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр зэрэг тохиолдол болно.

Эрх бүхий албан тушаалтан зөрчлийн хэрэг нээсэн даруйдаа прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлнэ.

1.6.8. Зөрчлийн хэрэг бүртгэлтийн хугацаа

Зөрчлийн хэрэг нээсэн өдрөөс эхлэн зөрчлийн хэрэг бүртгэлтийн хугацааг тоолох бөгөөд хуульд доорх байдлаар тусгасан байдаг. Үүнд:

Захиргааны хариуцлагын тухай хууль	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль
11 дүгээр зүйл. Зөрчлийг хянан шалгах 1. Зөрчлийг хянан шалгах эрх бүхий албан тушаалтан зөрчлийн тухай гомдол, мэдээлэл, үйл баримтыг үндэслэн зөрчлийг хянан шалгах ажиллагааг 14 хоногийн дотор явуулна. 2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаанд зөрчлийг хянан шалгах ажиллагааг дуусгах боломжгүй бол уг хугацааг тухайн эрх бүхий байгууллагын удирдлагын шийдвэрээр 14 хүртэл хоногоор сунгаж болно.	**6.8 дугаар зүйл.** Зөрчлийн хэрэг бүртгэлтийн хугацаа 1. Эрх бүхий албан тушаалтан 14 хүртэл хоногийн дотор зөрчлийн хэрэг бүртгэлт явуулна. 2. Зөрчил шалгах нэмэлт ажиллагаа явуулж нотлох баримт цуглуулах шаардлагатай бол зөрчлийн хэрэг бүртгэлтийн хугацааг зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан 14 хүртэл хоног, прокурор 30 хүртэл хоногоор сунгаж болно.

Зөрчлийн хэргийг харьяаллын дагуу шилжүүлсэн тохиолдолд хэрэг бүртгэлтийн хугацааг үргэлжлүүлэн тоолно.

Мэдлэг сорих тест

1. Зөрчилд оногдуулах шийтгэлийн зорилго эдгээрээс аль нь вэ?
   а. Хүн, хуулийн этгээдийг зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх
   б. Зөрчил үйлдсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэх
   в. Шударга ёсыг тогтоох
   г. Дээрх бүгд зөв

2. Зөрчилд оногдуулах шийтгэлийн төрлөөс илүүцийг ол.
   а. Эрх хасах шийтгэл
   б. Нийтэд тустай ажил хийлгэх шийтгэл
   в. Торгох шийтгэл
   г. Баривчлах шийтгэл

3. Зөрчил үйлдсэн хүнд баривчлах шийтгэлийг ямар хугацаагаар оногдуулах вэ?
   а. 1 сараас 3 сар хүртэлх
   б. 7 хоногоос 30 хоног хүртэлх
   в. 3 сараас 6 сар хүртлэх
   г. 6 сараас 1 жил хүртлэх

4. Зөрчлийн тухай хуулийн ерөнхий ангид баривчлах шийтгэл оногдуулахгүй гэж заасан субьектээс илүүцийг ол.
   а. Жирэмсэн эмэгтэй
   б. Арван дөрөв хүртэлх насны хүүхэдтэй ганц бие эцэг, эх
   в. 50-аас дээш насны эмэгтэй, 55-аас дээш насны эрэгтэй
   г. Баривчлах шийтгэл эдлүүлэхэд саад болохуйц өвчтэй хүн

5. Тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлгүйгээр эрхэлсэн бол тухайн үйл ажиллагааг хэзээ зогсоох вэ?
   а. Зөрчлийн хэрэг бүртгэлт дууссаны дараа
   б. Зөрчлийн хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэний дараа
   в. Зөрчил илэрсэн өдрөөс
   г. А, Б хариулт зөв

6. Зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл нь зөрчил үйлдсэн хүний амьжиргааны эх үүсвэр болсон эд зүйл, хэрэгсэл бол тэдгээрийг хураах уу?
   а. Хураана
   б. Хураахгүй
   в. Зөрчлийн шинжээс шалтгаална
   г. Эд зүйл, хэрэгсэл хурааж буй хүн өөрөө шийдвэрлэнэ

7. “Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээ нь зөрчил үйлдэгдсэн нөхцөл байдал, зөрчлийн шинж, хохирлын хэр хэмжээнд тохирсон байна” гэсэн ойлголт нь ямар зарчимд хамаарах вэ?
   а. Шударга ёсны зарчим
   б. Хууль ёсны зарчим
   в. Хууль дээдлэх зарчим
   г. Гэм буруугүйд тооцохгүй байх зарчим

8. Хэд хэдэн зөрчил үйлдсэн бол зөрчил бүрд хөөн хэлэлцэх хугацааг тус тусад нь тоолно.
   а. Үнэн
   б. Худал
   в. Эргэлзээтэй
   г. в ба г хариулт зөв

9. Гадаад улсын хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар Монгол Улсын нутаг дэвсгэрт зөрчил үйлдсэн бол хуулийн этгээдийн нэгэн адил шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэх үү?
   а. Хэрэглэхгүй
   б. Ямар улсын хуулийн этгээд гэдгийг харгалзан үзнэ
   в. Хэрэглэнэ
   г. Эрх бүхийй албан тушаалтан өөрийн үзэмжээр шийдвэрлэнэ

10. Зөрчлийн тухай хуулийн тусгай ангид заасан хэмжээгээр эрх бүхий албан тушаалтнаас мөнгөн төлбөр оногдуулахыг ……. шийтгэл гэнэ.
   а. Баривчлах шийтгэл
   б. Эрх хасах шийтгэл
   в. Торгох шийтгэл
   г. Бүгд зөв

11. Зөрчил хамтран үйлдсэн хүн, хуулийн этгээдэд хэрхэн шийтгэл оногдуулах вэ?
   а. Хуулийн этгээдийг шийтгэлээс чөлөөлж, хүнд шийтгэл оногдуулна
   б. Хүнийг шийтгэлээс чөлөөлж, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулна
   в. Хүн, хуулийн этгээд тус бүрд шийтгэл оногдуулна
   г. Хүн, хуулийн этгээд хоёуланд нь шийтгэл оногдуулахгүй

12. Зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл гэдэгт хамаарах ойлголтыг дугуйлна уу.
   а. Зэвсэг, хэрэгсэл, эд зүйл
   б. Тээврийн хэрэгсэл, уналга
   в. Зөрчилтэй бараа, бүтээгдэхүүн
   г. Дээрх бүгд зөв

13. Зөрчил үйлдсэн, зөрчил үйлдэх үедээ 15 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай хүнд зөрчлийн тухай хуульд заасан шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэнэ.
   а. Үнэн
   б. Худал
   в. Эргэлзээтэй

14. Зөрчлийн тухай хуульд нэмэгдэл шийтгэл байхаар заасан шийтгэлийн төрлийг сонгоно уу.
   а. Баривчлах шийтгэл
   б. Торгох шийтгэл
   в. Эрх хасах шийтгэл
   г. Дээрх бүгд зөв

15. Шинээр зөрчилд тооцсон, оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээг хүндрүүлсэн, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулсан хуулийг буцаан хэрэглэх үү?
   а. Хэрэглэнэ
   б. Хэрэглэхгүй

в. Ямар ч тохиолдолд зөрчлийн тухай хуулийг буцаан хэрэглэхгүй
г. Зөв хариулт алга

16. Хөөн хэлэлцэх хугацааг зөрчил үйлдсэн өдрөөс эхлэн ..... өдрийг хүртэл тоолно.
а. Зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагаа эхлүүлэх
б. Зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагаа дуусах
в. Зөрчлийг шүүхэд шилжүүлэх
г. Зөрчлийг шүүхээр шийдвэрлэх

17. Хуулийн этгээдэд шийтгэл оногдуулсан, албадлагын арга хэмжээ хэрэглэсэн нь тухайн зөрчлийг үйлдсэн хүнийг эрүүгийн хариуцлага, шийтгэл, албадлагын арга хэмжээнээс чөлөөлөх үндэслэл болно.
а. Үнэн
б. Худал
в. Нөхцөл байдлаас шалтгаалан
г. Мэдэхгүй

18. Зөрчлийн үр дагавар хэзээ илэрснээс үл хамааран тухайн зөрчил үйлдэгдсэн үеийг зөрчил үйлдэгдсэн хугацаанд тооцно.
а. Үнэн
б. Худал
в. Эргэлзээтэй асуулт байна

19. Зөрчил үйлдэгдсэн, түүний үр дагавар илэрсэн газрыг зөрчил үйлдсэн ..... тооцно.
а. Орон зайд
б. Нутаг дэвсгэрт
в. Газарт
г. Цэгт

20. Нэг үйлдэл, эс үйлдэхүй нь зөрчлийн тухай хуулийн тусгай ангид заасан хоёр эсхүл түүнээс дээш зөрчлийн шинжтэй бол ямар журмаар шийтгэл оногдуулах вэ?
а. Аль хөнгөн шийтгэл оногдуулахаар заасан зөрчилд нь шийтгэл оногдуулна
б. Зөрчил тус бүрд нь шийтгэл оногдуулна
в. Аль хүнд шийтгэл оногдуулахаар заасан зөрчилд нь шийтгэл оногдуулна
г. Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдээр сонгуулна

21. Гадаад улсын дипломат эрх ямба, дархан эрх эдэлж байгаа хүнд шийтгэл оногдуулах, албадлагын арга хэмжээ хэрэглэх эсэхийг ямар хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх вэ?
а. Монгол Улсын Үндсэн хууль
б. Зөрчлийн тухай хууль
в. Эрүүгийн хууль
г. Монгол Улсын олон улсын гэрээ, хууль тогтоомж

22. Хууль эсхүл зөрчлийн тухай хуулийн тусгай ангид заасан тохиолдолд эрх бүхий албан тушаалтан зөрчлийн үр дагаврыг арилгах, учирч болзошгүй хохирол, хор уршгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.
а. Үнэн
б. Худал
в. Аль нь ч биш

23. Торгох шийтгэлийн хэмжээ нь хүнд хэдээс хэдэн нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байхаар зөрчлийн тухай хуульд хуульчилсан бэ?

а. Таваас хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байхаар
б. Арваас хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байхаар
в. Хориос хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байхаар
г. Тавиас хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байхаар

24. Зөрчлийн шинжийг зөрчлийн тухай хуулиас гадна, бусад хууль, захиргааны хэм хэмжээний актаар тодорхойлж болох уу?

а. Болно
б. Болохгүй
в. Сайн мэдэхгүй байна

25. Хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн зөрчлийн тухай хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхүйг ..... гэнэ.

а. Гэмт хэрэг
б. Хууль бус үйлдэл
в. Зөрчил
г. Зөв хариулт алга

26. Зөрчлийн шийтгэл хүлээх субьектыг дугуйл.

а. Зөрчил үйлдсэн, зөрчил үйлдэх үедээ арван зургаан насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай хүн
б. Зөрчил үйлдсэн, зөрчил үйлдэх үедээ арван дөрвөн насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай хүн
в. Зөрчил үйлдсэн, зөрчил үйлдэх үедээ арван найман насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай хүн
г. Зөрчил үйлдсэн, зөрчил үйлдэх үедээ хорин нэгэн насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай хүн

27. Шүүх, эрх бүхий албан тушаалтан зөрчил үйлдэгчийн хөрөнгө, цалин хөлс, бусад орлогыг харгалзан торгох шийтгэлийг хэдий хугацаанд хэсэгчлэн төлүүлэхээр шийдвэрлэж болох вэ?

а. 3 сар хүртэл
б. 6 сар хүртэл
в. 1 жил хүртэл
г. 2 жил хүртэл

28. Баривчлах шийтгэлийг хэн оногдуулах вэ?

а. Прокурор
б. Зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан
в. Шүүх
г. Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан

29. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны үед саатуулагдсан хугацааг баривчлах шийтгэл эдлүүлэх хугацаанд оруулан тооцох уу?

а. Тооцно
б. Тооцохгүй
в. Нөхцөл байдлыг харгалзана
г. Зөв хариулт алга

30. Зөрчлийн тухай хуульд албадан сургалтын хугацааг хэдэн цаг байна гэж заасан бэ?
    а. Зуун цагаас зуун хорин цаг
    б. Далан цагаас зуун цаг
    в. Тавин цагаас далан цаг
    г. Арван цагаас тавин цаг

31. Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд..... харгалзан зөрчлийн тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу шийтгэл оногдуулна.
    а. Зөрчлийн цаг хугацааг
    б. Зөрчлийн байдлыг
    в. Зөрчил үйлдэгдсэн газрыг
    г. Зөрчлийн шинжийг

32. Зөрчлийн тухай хуулийг буцаан хэрэглэх үү?
    а. Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийг буцаан хэрэглэнэ
    б. Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулсан хуулийг буцаан хэрэглэнэ
    в. Ямар ч тохиолдолд зөрчлийн тухай хуулийг буцаан хэрэглэхгүй

33. Зөрчлийн тухай хуульд үндсэн шийтгэл хэлбэрээр оногдуулна гэж заасан шийтгэлийг дугуйлна уу.
    а. Торгох шийтгэл
    б. Баривчлах шийтгэл
    в Эрх хасах
    г. а ба в хариулт

34. Нэг торгуулийн нэгж нь ……. мянган төгрөгтэй тэнцүү
    а. Хорин мянган
    б. Таван мянган
    в. Арван мянган
    г. Нэг мянган

35. Зөрчлийн тухай хуулийг төсөөтэй хэрэглэх үү?
    а. Хэрэглэнэ
    б. Хэрэглэхгүй
    в. Хуульд заасан бол болно

36. Зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагаа эхэлснээр хөөн хэлэлцэх хугацааг тоолохыг зогсооно.
    а. Үнэн
    б. Худал
    в. Зөрчлийн тухай хуульд тусгагдаагүй зүйл байна

37. Хүн, хуулийн этгээд нь хууль, захиргааны хэм хэмжээний актыг биелүүлэх боломжтой байсан боловч түүнийг биелүүлэх зохих арга хэмжээг хэрэгжүүлээгүй бол зөрчил үйлдсэнд тооцох уу?
    а. Тооцохгүй
    б. Тооцно

в. Зөрчлийн тухай хуульд энэ талаар тусгаагүй байдаг
г. Дээрх бүгд зөв

38. Зөрчил тодорхой хугацаанд үргэлжилсэн бол ..... үеийг зөрчил үйлдсэн хугацаанд тооцно.
а. Зөрчил үйлдэгдэж эхэлсэн
б. Зөрчлийн үр дагавар илэрсэн
в. Үйлдэгдэж дууссан, таслан зогсоогдсон
г. Зөв хариулт алга

39. Зөрчил үйлдсэн хэдээс хэдэн насны хүнд түүний хувийн байдал, зөрчлийн шинж, зөрчил үйлдэгдсэн нөхцөл байдлыг харгалзан шийтгэлээс чөлөөлж, албадлагын арга хэмжээ хэрэглэж болох вэ?
а. Арван зургаагаас арван найм
б. Арван наймаас хорин нэг
в. Хорин нэгээс гуч
г. Гучаас дөч

40. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн зорилт нь .....оршино.
а. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны үндэслэл, журмыг тогтоож, зөрчлийг шалгах, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах, энэхүү ажиллагааны явцад хүн, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад
б. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны үндэслэл, журам, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд хорьж шийтгэл оногдуулах, энэхүү ажиллагааны явцад хүн, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хангахад
в. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны үндэслэл, журмыг тогтоож, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулахад
г. Бүгд зөв

41. Зөрчлийн хэрэг нээхгүй байх тохиолдлын илүүцийг ол.
а. Зөрчлийн шинжгүй
б. Холбогдогч нь олдоогүй
в. Зөрчлийн тухай хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн
г. Бүгд зөв

42. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгчид аль нь хамаардаггүй вэ?
а. Прокурор
б. Эрх бүхий албан тушаалтан
в. Өмгөөлөгч
г. Шүүгч

43. Эрх бүхий албан тушаалтан хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд зөрчил шалган шийдвэрлэх явцад дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
а. Хуулиар харьяалуулсан зөрчлийг өөрөө илрүүлсэн, эсхүл зөрчлийн тухай гомдол, мэдээлэл ирүүлснийг хүлээн авч хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх
б. Оролцогчийн гаргасан гомдол, бусад үндэслэлээр зөрчлийн хэргийг хянах;
в. Хуульд заасны дагуу зөрчлийн хэрэг бүртгэлтийн хугацааг сунгах
г. Зөрчлийн хэрэг бүртгэлт явуулах үүргийг нэг, эсхүл хэд хэдэн эрх бүхий албан тушаалтанд даалгах

44. Зөрчил үйлдсэн гэж .....холбогдогч гэнэ.
    а. Зөрчил үйлдсэн байж болох этгээдийг
    б. Буруутгагдаж байгаа хүн, хуулийн этгээдийг
    в. Гэмт хэрэг үйлдэж газар дээр нь баригдсан этгээдийг
    г. Зөрчил үйлдсэн байж болох үндэслэлтэй хүн, хуулийн этгээдийг

45. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны оролцогч хохирогчийн хэрэгжүүлдэг бүрэн эрхэд аль нь хамаардаг вэ?
    а. Эх хэлээрээ, эсхүл сайн мэдэх хэлээрээ мэдүүлэг өгөх, орчуулагч, хэлмэрч авах
    б. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахгүй байх
    в. Оролцогчид нөлөөлөхгүй байх
    г. Зөрчлийн хэргийн талаар үнэн зөв мэдүүлэх

46. Эрх бүхий албан тушаалтан ..... зорилгоор мэдүүлэг авна
    а. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах
    б. Зөрчлийн тухай мэдээлэл шаардлагатай бол түүнийг хуулийн дагуу явуулах
    в. Холбогдогчийн хувийн байдлыг тогтоох
    г. Зөрчил гарсан байдлыг тодруулах, зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдол бүхий баримт, мэдээллийг олох

ХОЁРДУГААР БҮЛЭГ.

БАЙГАЛЬ ОРЧИН, АМЬТАН, УРГАМЛЫГ ХАМГААЛАХ ЖУРМЫН ЭСРЭГ ХЭРЭГ ЗӨРЧЛИЙН МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ, ҮЗЛЭГ ХИЙХ АРГА ТЕХНИК



2.1 МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ

Хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй нь ил болон далд хэлбэрээр үйлддэгдэг. Зөрчлийн тухай хуульд зааснаар эрх нь зөрчигдсөн талаар иргэн, хуулийн этгээд гомдол, мэдээлэл гаргаснаар зөрчлийг шалгаж, шийдвэрлэх ажиллагаа явагддаг. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага гомдол, мэдээлэл гаргахаас гадна, аливаа зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан нь хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд зөрчлийг илрүүлэн шалган шийдвэрлэж, хуулийг хэрэгжүүлж, биелүүлдэг.

Аливаа зөрчил нь иргэд, хуулийн этгээдийн эрх ашиг нь зөрчигдөж гомдол гаргадаг бол аж ахуйн нэгж, байгууллага нь чиг үүргийнхээ хүрээнд хууль ёс зөрчигдөж байгааг мэдээлж, хууль зөрчсөн үйлдлийг таслан зогсооход хувь нэмрээ оруулж байдаг. Хэдийгээр зөрчил нь иргэд, хуулийн этгээдийн гомдол мэдээллээр ил тодорхой болж байдаг хэдий ч ямар нэгэн хүн, байгууллагад мэдэгдэхгүй, нууц далд байдлаар зөрчил үйлддэгдэж, хууль ёс гажуудна.

Тийм учраас тэдгээр далд байдлаар үйлдэгдэж байдаг зөрчлийг илрүүлж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг явуулах нь төрийн байгууллага, эрх бүхий албан тушаалтны үүрэг юм. Иймд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд эрх бүхий албан тушаалтан хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд хуулиар харьяалуулсан зөрчлийг өөрөө илрүүлэх[4] эрх, үүргийг тодорхой заасан байдаг. Илрүүлсэн тодорхой зөрчилдөө зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааг хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулах, зөрчилд шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ авах зэргээр зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг явуулна.

Зөрчлийн хэргийг илрүүлэх, шалгахад өөрийн гэсэн арга зүй, тактик байх бөгөөд энэ сэдэвт Зөрчлийн тухай хуулийн 7 дугаар бүлэг буюу Байгаль орчин, амьтан, ургамлыг хамгаалах журмын эсрэг зөрчлийг илрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийн эх сурвалжийг тодорхойлох талаар ойлголт өгөх юм.

Аливаа зөрчлийг шалгахад эн тэргүүнд чиглэл, баримжаа авах, үр ашигтай, жишиг зөвлөмж буюу зөрчил шалган шийдвэрлэх аргачлал чухал шаардлагатай. Зөвлөмж нь практикаас урган гарсан, түүгээр дамжин туршсан шинжлэх ухааны үндэслэлтэй байдгаараа чухал ач холбогдолтой.

Байгаль орчин, амьтан, ургамлыг хамгаалах журмын эсрэг зөрчил нь ихэвчлэн ой тайга, хээр тал зэрэг хүний нүднээс далд газар оронд үйлдэгдэг учраас тэр бүр ил байх боломж бага байдаг. Нөгөө талаар тухайн зөрчлийг үйлдэгч нар нь бусдын нүдэн дээр ил үйлддэггүй, нуух, далдлах, ул мөрөө баллах зэргээр зөрчлийг нуун далдлахыг оролддог. Тийм учраас энэ төрлийн зөрчлийн талаарх мэдээллийг олж авахаар идэвхтэй үйл ажиллагаа явуулах нь зүйтэй.

Аливаа зөрчлийн талаарх мэдээллийг урсгалаараа аяндаа ирнэ гэж байгууллагын ажилтан алгуурлаж, хүлээн сууж хэрхэвч болохгүй. Мэдээллийг янз бүрийн эх сурвалжаас авч болох бөгөөд доорх мэдээллийн эх сурвалж нь зөрчлийн хэргийг илрүүлэх боломжуудын нэгээхэн хэсэг юм. Мэдээллийн эх сурвалжид дүн шинжилгээ хийх, ашиглах нь энэ төрлийн зөрчилтэй тэмцэхэд чухал ач холбогдолтой.

4 2.4 дүгээр зүйл.Эрх бүхий албан тушаалтан

1. Энэ хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасан эрх бүхий албан тушаалтан хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд зөрчил шалган шийдвэрлэх явцад дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1.1. хуулиар харьяалуулсан **зөрчлийг өөрөө илрүүлсэн**, эсхүл зөрчлийн тухай гомдол, мэдээлэл ирүүлснийг хүлээн авч хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх.


Мэдээллийн эх сурвалжийг иргэн, аж ахуйн нэгж байгууллага, төрийн байгууллага, сошиал буюу нийтийн мэдээлэл гэх мэтээр ангилах бөгөөд дараах субъект нь мэдээллийн чухал эх сурвалжид тооцогдоно. Үүнд:

Иргэд, аж ахуйн нэгжийн мэдээлэл:

- Орон нутгийн иргэдийн мэдээлэл
- Нутгийн иргэдийн нөхөрлөл
- Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн сурвалжлагчид
- Аялагчид
- Төрийн бус байгууллага (олон улсын болон дотоодын)
- Судалгаа шинжилгээний байгууллага, судлаачдын мэдээлэл
- Аж ахуйн нэгж *(аялал жуулчлал, хөдөө орон нутагт ажилладаг геологи, уул уурхай, ан агнуурын компани г.м).*

Төрийн байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд ирүүлж болох мэдээлэл:

- Гаалийн хяналт шалгалт
- Авто тээвэр, төмөр зам, иргэний нисэхийн байгууллага
- Гадаадын иргэн харьяатын албаны мэдээлэл
- Авилгатай тэмцэх газар
- Цэргийн байгууллагын мэдээлэл (хил хамгаалах, цэргийн анги салбар)
- Төрийн захиргааны байгууллага - төрийн захиргааны төв байгуллага, орон нутгийн байгууллага, орон нутгийн төр.



2.1.1. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын мэдээлэл

Иргэдийн хувьд байгаль орчноо хамгаалах гэсэн чин хүсэл эрмэлзэл ихэнх иргэдэд байдаг. Тэд оршин суугаа газрынхаа байгалийг хамгаалах, тэнд гарч буй хууль бус үзэгдлийн талаар өөр хоорондоо ярилцаж, зарим нь хууль хяналтын байгууллагад хүртэл гомдол, мэдээлэл гаргаж байдаг. Ам дамжсан “хууль бус үйлдэл”-ийн тухай яриа нь нарийн тодорхой мэдээлэл болохгүй ч тэдгээр нь зөрчил шалгах ажлын эхлэл болох тэдийгүй, тухайн гэмт хэргийн гаралтыг тодорхойлох чиг баримжаа болдог.

Байгаль орчны зөрчил ихэвчлэн хөдөө орон нутагт үйлддэг учраас тухайн орон нутгийн иргэдээс тодорхой төрлийн зөрчлийн талаарх мэдээллийг олж авч болно. Иргэдийн мэдээлэл бүрийн учиг сэжүүрийг сайтар нягт шалгах шаардлагатай. Учир нь зарим таамаг, сураг, хов жив, нэгнийгээ чадах, саад хийх гэсэн батлагдаагүй цуурхлын шинжтэй байж болзошгүй юм.

Иргэдийн мэдээлэл гаргах нь эрх зүйн хувьд нээлттэй байна. Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2-д Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй хэмээжээ.

Тус хуулийн Арван зургадугаар зүйлд Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдлэх бөгөөд тухайлбал, (2) эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах, (17) төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах зэрэг эрхтэй байна. Мөн Арван долдугаар зүйлд Монгол Улсын иргэн шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн (2) ...байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн бөгөөд энэ үндсэн үүргийг ёсчлон биелүүлж байхаар тусгасан байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлд зааснаар иргэн байгаль орчныг хамгаалах талаар (1) гэм буруутай этгээд байгаль орчинд хортой нөлөөлснөөс эрүүл мэнд, эд хөрөнгөндөө учирсан хохирлыг түүгээр нөхөн төлүүлэхээр нэхэмжлэх эрхийг эдэлдэг бол (1) байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийг сахин биелүүлэх, (3) байгаль орчинд хортой нөлөөлөхөөс сэргийлэх, өөрийн буруугаас учруулсан хортой нөлөөлөл, түүний хохирлыг арилгах буюу нөхөн төлөх зэрэг үүргийг хүлээж, (4) байгалийн баялгийг хууль бусаар ашигласан, гэмтээсэн, хөнөөж сүйтгэсэн үйлдлийг олж мэдсэн иргэн тэр тухайгаа тухайн орон нутгийн Засаг дарга, **улсын байцаагч, байгаль хамгаалагчид** нэн даруй мэдэгдэнэ хэмээн тус тус заасан байдаг.

Эдгээр хууль зүйн хэм хэмжээнд иргэдийн байгаль орчны талаарх гэмт хэрэг, зөрчлийг мэдээлэх эрхийг тодорхойлж өгчээ.

Мөн иргэдийн байгаль орчны талаарх гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, таслан зогсооход тэдний үүрэг оролцоог нэмэгдүүлэх, урамшуулал хөшүүрэг болгохын тулд тухайлбал, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 4-д Байгаль орчны хууль тогтоомж зөрчсөн тухай үнэн бодит мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд өгсөн, түүнчлэн зөрчлийг илрүүлсэн, илрүүлэхэд бодиттой туслалцаа үзүүлсэн иргэнд зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн орлогын дүнгийн 15 хувьтай тэнцэх мөнгөн урамшууллыг сум, дүүргийн Засаг дарга байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос олгоно хэмээн байгаль орчныг хамгаалах эдийн засгийн хөшүүргийн хэм хэмжээг тусгасан байна.

Түүнчлэн энэ хуулийн 54 дүгээр зүйлийн 8-д Байгаль орчны хууль тогтоомж зөрчсөн тухай үнэн бодит мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд өгсөн иргэн, нөхөрлөл, төрийн бус байгууллагад 150,000 төгрөгийн мөнгөн урамшууллыг сум, дүүргийн Засаг дарга ажлын 10 өдөрт багтаан байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос олгож урамшуулахаар заасан нь чухал ач холбогдолтой заалтууд юм.

Мөн байгаль орчны гол хууль болох Байгаль орчныг хамгаалах тухай хуулиас гадна, салбар хуулиудад энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээлэх, илрүүлэхэд туслалцаа үзүүлэхэд урамшуулал олгох талаар заасан байна. Тухайлбал, Амьтны тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1-д Амьтны тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийг илрүүлсэн, илрүүлэхэд туслалцаа үзүүлсэн буюу түүний тухай мэдээлэл өгсөн иргэнд уг мэдээлэл нь батлагдсан тохиолдолд зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн хэмжээний 15 хувиар тооцож мөнгөн шагналыг сум, дүүргийн Засаг дарга олгохоор, түүнчлэн Ойн тухай хуулийн 20.2-д иргэн ойн баялгийг хууль бусаар ашигласан, гэмтээсэн, устгаж сүйтгэсэн зөрчлийн талаар тухайн шатны Засаг дарга, улсын байцаагч, байгаль хамгаалагчид нэн даруй мэдэгдэх үүрэгтэй хэмээн тус тус тусгайлан зааж өгчээ.

Иргэний мэдээлэл өгөх эрхийг ингэж баталгаажуулж өгсөн байдаг бөгөөд байгаль хамгаалагч нь мэдээлэл өгч байгаа иргэд мөнгөн урамшуулал авах зорилготой мэдээлэл өгч байна уу эсвэл журамт үүргээ биелүүлж чин сэтгэлээсээ санаа нь зовниж өгч байна уу эсхүл байгаль

орчинд хортой нөлөөлөхөөс сэргийлэх, байгалиа хамгаалах, өөрийнхөн эрх дам байдлаар зөрчигдсөний улмаас мэдээлэл өгч байгаа эсэхийг тааварлаж мэдэх нь цаашид хийх ажлаа төлөвлөхөд нэлээд дэм болно. Учир нь байгаль орчны хэрэг, зөрчлийг илрүүлэхэд мэдээлэл өгч, хууль хяналтын байгууллагад туслалцаа үзүүлж байгаа иргэд буруу ташаа, хэтрүүлэгтэй, худал мэдээлэл өгч болзошгүйг анхаарахын зэрэгцээ мэдээллийн нууцлалыг хамгаалах шаардлага үүсэж байдаг.

Иргэдэд байгаль орчны хэрэг, зөрчлийн талаар олон чухал мэдээлэл байдаг. Гэвч тэдний өгч байгаа мэдээлэлд бүрэн төгс итгэж болохгүй, заавал нягталж шалгаж байх хэрэгтэй.

Дээр дурдсанчлан мэдээлэл өгч буй иргэний нэр төр, алдар хүнд, ашиг сонирхлыг хамгаалж мэдээллийн нууцлалыг чанд хадгалах шаардлагатай. Учир нь мэдээлэл өгсөн иргэнийг шагнаж урамшуулах үед Засаг дарга тэдгээр бичиг баримтыг бүрдүүлж байгаа бичиг хэрэг, нарийн бичиг, санхүүгийн ажилтан, элдэв тайлан танилцуулга зэргээс нууцлал алдагдах магадлалтай.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4-д зааснаар улсын байцаагч илрүүлсэн зөрчлийг таслан зогсоох, арилгах арга хэмжээ авахдаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, үйлдвэрлэлийн нууцыг хадгалах үүргийг хэрэгжүүлэх ёстой.

Хувь хүний талаарх нууцлал нь 2021 оноос эхлэн хүчин төгөлдөр болсон Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиар хамгаалагдсан бөгөөд тус хуульд (4.1.11) “*хүний хувийн мэдээлэл*” гэж хүний эмзэг мэдээлэл болон хүний эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, төрсөн газар, оршин суугаа газрын хаяг, байршил, иргэний бүртгэлийн дугаар, хөрөнгө, боловсрол, гишүүнчлэл, цахим тодорхойлогч, хүнийг шууд болон шууд бусаар тодорхойлох, эсхүл тодорхойлох боломжтой бусад мэдээллийг, (4.1.12) “*хүний эмзэг мэдээлэл*” гэж хүний үндэс, угсаа, шашин шүтлэг, итгэл үнэмшил, эрүүл мэнд, захидал харилцаа, генетик болон биометрик мэдээлэл, тоон гарын үсгийн хувийн түлхүүр, ял эдэлж байгаа болон ял эдэлсэн эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, бэлгийн харьцааны талаарх мэдээллийг, (4.1.14) “*цахим тодорхойлогч*” гэж хүнийг цахим орчинд тодорхойлох мэдээллийн системийн нэвтрэх нэр, цахим шуудан, нийгмийн сүлжээ, харилцаа холбооны утастай болон утасгүй технологийн хаяг, бусад төрлийн төхөөрөмж, мэдээллийн систем дэх мэдээлэл хэмээн тус тус тодорхойлсон байдаг.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.7 дугаар зүйлийн Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны нууцлалд (1) шүүгч, прокурор, зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах болон эрх бүхий албан тушаалтан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад олж мэдсэн хүний эмзэг мэдээлэл, төрийн болон албаны нууцыг задруулахгүй байх, түүнийг хамгаалах арга хэмжээ авах, мөн (2) шүүгч, прокурор, зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах болон эрх бүхий албан тушаалтан нь хүний эмзэг мэдээлэл, төрийн болон албаны нууцтай холбоотой ажиллагаанд оролцсон, байлцсан хүнд нууцыг задруулахгүй байх үүргийг сануулж, бичгээр баталгаа гаргуулж авахаар тус тус заасан байна.

Энэхүү мэдээлэл олж авах ажиллагаа нь Зөрчлийн тухай хуульд заасан зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр хандаж буй хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас зөрчлийн талаар гомдол гаргасан, эсхүл мэдээлж байгаагаас өөр ялгаатай гэдгийг ойлгох хэрэгтэй.

Мэдээлэл өгч байгаа иргэдийг нутгийн иргэд, аялал жуулчлал, амралт, ажлаар яваа иргэд, эрдэм шинжилгээ судалгаа хийж буй судлаач гэх мэтээр дотор нь ангилж болно. Орон нутагт аялал жуулчлалаар яваа иргэд байгаль орчны талаар сөрөг буруутай аливаа үйлдлийг харсан үзсэн, сонссон байдаг бол судлаачид судалгаа шинжилгээ явуулж байхдаа олж мэдсэн янз бүрийн мэдээллүүд байдаг тул тэдгээрээс энэ талаарх мэдээллийг сонсох, харилцан ярилцах зэргээр олж авах хэрэгтэй. Энэ нь тухайн байгаль хамгаалагчийн өөрийн арга эв, ур чадвар, туршлага, идэвх санаачлагаас ихээхэн шалтгаална. Ер нь иргэдийг өөрсдөө хүрч ирээд мэдээлэл өгнө хэмээн хүлээн сууж үл болно.

Харин аж ахуйн нэгж, байгууллагад аливаа аж ахуйн үйл ажиллагаа явуулж буй компани, нөхөрлөл, хоршоо зэрэг хуульд заасан янзын бүрийн байгууллагуудаас гадна, судалгаа шинжилгээ явуулдаг төрийн болон хувийн хэвшлийн сургууль, судалгааны байгууллагууд ч хамаарна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлд (4) байгалийн баялгийг энэ хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу бий болгосон эсэх талаар мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагын дүгнэлт, орон нутгийн засаг захиргааны болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тодорхойлолтыг үндэслэн тэдгээрт өмчлүүлэх асуудлыг хуулийн дагуу шийдвэрлэнэ, мөн 11 дүгээр зүйлд (2) төрийн захиргааны төв байгууллага, зохих шатны Засаг дарга нь эрдэм шинжилгээний болон холбогдох мэргэжлийн байгууллагад байгаль орчны судалгаа, шинжилгээний ажил хийх, төсөл боловсруулах захиалга өгч зохих төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээс гадна, сонирхогч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад өөрийн хөрөнгөөр судалгаа,шинжилгээ хийхэд нь дэмжлэг үзүүлнэ, түүнчлэн 37 дугаар зүйлд (4) энэ хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, 6-д заасан мэдээллийг эрдэм шинжилгээний болон тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор улсын мэдээллийн санд төвлөрүүлнэ хэмээн тус тус заасан байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн байгаль орчныг хамгаалах талаарх иргэний эрх, үүрэгт (6) сайн дурын үндсэн дээр зохион байгуулалтад орж, энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8 дахь заалтад заасан нөхөрлөл байгуулах замаар оршин суугаа нутгийнхаа байгалийн тодорхой төрлийн баялгийг хамгаалах, холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээгээр ашиглах, эзэмших, энэ хуулийн 19 дүгээр зүйлийн байгаль орчныг хамгаалах нийтлэг арга хэлбэрт (7) нөхөрлөлд гэрээний дагуу байгалийн тодорхой төрлийн баялгийн хамгаалалт, ашиглалт, эзэмшилтийг хариуцуулах, мөн 28 дугаар зүйлийн байгаль хамгаалагчийн эрх, үүрэгт (7) хариуцсан нутаг дэвсгэртээ ажиллах нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах, тус хуулийн 32 дугаар зүйлийн байгаль орчныг хамгаалахад төрийн бус байгууллага оролцох хэсэгт (1) байгаль орчин, түүний баялгийг хамгаалах дүрмийн зорилго бүхий олон нийтийн байгууллага болон байгалийн нөөцийн хамтын менежмент эрхлэн явуулах нөхөрлөл байгаль орчныг хамгаалах талаар (1) ... хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, үзлэг хийх, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, гэм буруутай этгээдээс байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах, мөн (2) байгаль орчныг хамгаалах талаарх саналаа төрийн захиргааны төв байгууллага болон зохих шатны Хурал, Засаг даргад уламжлах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлж болно хэмээн тус тус заасан байдаг.

2.1.2. Төрийн байгууллагын мэдээлэл

Төрийн байгууллагууд болох яам, агентлаг, нутгийн удирдлагын байгууллагууд төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхдээ янз бүрийн мэдээлэлтэй болсон байдаг. Ялангуяа цагдаа, хил, гааль, гадаадын харьяат, татвар, замын хөдөлгөөний хяналтын байгууллага, онцгой байдал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх болон тагнуул, төрийн тусгай хамгаалалтын алба зэрэг байгууллагуудаас байгаль орчны хэрэг, зөрчлийн талаарх мэдээлэл олох боломжтой.

Мөн түүнчлэн аймаг нийслэл, сум дүүрэг, баг, хорооны Засаг дарга, тэдгээрийн ажилтнууд, шат шатны иргэдийн хурал, төлөөлөгчид зэрэг байгууллагууд өөр өөрсдийн чиглэлээр хуулийн хэрэгжилтэд хяналт тавихдаа байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт болон хэрэг, зөрчилтэй таарах, тулгарах, тэдгээрийн талаарх мэдээллийг олох магадлал тун өндөр юм. Иймд дээрх байгууллагуудын заримаас нь товчхон оруулав.

Цагдаагийн байгууллага. Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тухайлан ажилладаг учир гэмт хэргийг мөрдөн шалгах, эрэн сурвалжлах, урьдчилан сэргийлэх ажиллагааг явуулж байхдаа байгаль орчны зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох ажлуудыг хийж байдаг. Гэмт хэргийн харьяалалын дагуу илрүүлсэн зөрчлийг зөрчил шалгах эрх бүхий байгууллага албан тушаалтанд шилжүүлдэг. Энэ талаар олон жишээ баримт дурдаж болно.

Үүнээс гадна, цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан Зөрчил шалган шийдвэр тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн Амьтны тухай хууль зөрчих (7.6 дугаар зүйлийн 9 дэх хэсэг), мөн энэ хуулийн 7.15 дугаар зүйлийн Усны тухай хууль зөрчих (7.15 дугаар зүйлийн 8 дахь хэсэг) үйлдлийн холбогдох хэсгийг шалгах эрхтэй байдаг.

Цэргийн анги байгууллага. Цэргийн анги, салбар үүрэгт ажлынхаа онцлогоос шалтгаалан янз бүрийн газар нутагт шилжин байршиж ажилладаг. Харуул манаа болон бусад ажил үүрэг гүйцэтгэх явцдаа байгаль орчны хууль бус үйлдлүүдийг харж үзэж болно. Ялангуяа хил хамгаалах байгууллага улсын хил, хил орчмын бүс нутгийг хамгаалах явцдаа байгаль орчныг хамгаалах үүргийг давхар хариуцдаг бөгөөд энэ чиглэлийн хууль бус үйлдлийг илрүүлэх боломжтой.

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд (2) хил, гааль, мал эмнэлэг, эрүүл ахуй, халдвар судлал, уул уурхайн зэрэг хяналтын байцаагч буюу хуульд зааснаар энэхүү хяналтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий ажилтанд байгаль орчны улсын байцаагчийн эрх олгож, хяналтын үүрэг гүйцэтгүүлж болох бөгөөд үүнээс гадна, Зөрчлийн тухай хуулийн 7.3 дугаар зүйлийн Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль зөрчих үйлдлийн холбогдох хэсгийг хилийн төлөөлөгч, орлогч, туслагч нар шалгах эрхтэй байдаг.

Онцгой байдлын байгууллага. Онцгой байдлын байгууллага нь ой хээрийн түймэр унтраах, түүний шалтгаан нөхцлийг тогтоох болон гамшиг ослын үед ажиллах, мөн тэдгээрээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулж байхдаа энэ талаарх мэдээллийг олох боломжтойгоос гадна, Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн Ойн тухай хууль зөрчих (7.9 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг) үйлдлийн холбогдох хэсгийг гал түймрийн улсын хяналтын байцаагч шалгах эрхтэй.

Гадаадын харьяатын байгууллага. Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаад улсын иргэд янз бүрийн зорилгоор тухайлбал, аялал зугаалга, ан агнах, байгалийн ургамал түүх, судалгаа

шинжилгээ хийх, аж ахуйн үйл ажиллагаа явуулахдаа хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулах, зөрчил үйлдэж болзошгүй бөгөөд өөрт олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээн хяналт шалгалт, бичиг баримт бүрдүүлэх, зөвшөөрөл олгох зэрэг ажил үүргээ гүйцэтгэх үедээ энэ чиглэлийн мэдээлэл олох боломжтой.

Татварын байгууллага. Өөрсдийн эрх хэмжээний хүрээнд үйл ажиллагаагаа явуулах үедээ байгаль орчны хэрэг, зөрчлийн талаарх мэдээлэл олох боломжтой. Үүнээс гадна, Зөрчил шалган шийдвэр тухай хуулиар татварын улсын байцаагч нь Зөрчлийн тухай хуулийн 7.5 дугаар зүйлийн Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль зөрчих, 7.10 дугаар зүйлийн Газрын хэвлийн тухай хууль зөрчих, 7.11 дүгээр зүйлийн Ашигт малтмалын тухай хууль зөрчих, 7.12 дугаар зүйлийн Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль зөрчих, 7.13 дугаар зүйлийн газрын Тосны тухай хууль зөрчих, 7.16 дугаар зүйлийн Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль зөрчих зэрэг үйлдлүүдийн холбогдох хэсгийг шалгах эрхтэй байдаг.

Гаалийн байгууллага. Гаалийн хяналт шалгалтаар хууль тогтоомж зөрчсөн үйлдлүүдийг илрүүлж, зохих арга хэмжээг авч байдаг. Гэхдээ тэдгээр үйлдлийг хэн, хаана, хэзээ үйлдсэн зэрэг дээр хяналт шалгалт явуулдаггүй тул эх үндэс, зөрчил гаргасан этгээд нь орон нутагт үлдэх тохиолдол бий. Мөн Зөрчил шалган шийдвэр тухай хуулиар гаалийн улсын байцаагч нь Зөрчлийн тухай хуулийн 7.3 дугаар зүйлийн Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль зөрчих, 7.4 дүгээр зүйлийн Агаарын тухай хууль зөрчих, 7.7 дугаар зүйлийн Байгалийн ургамлын тухай хууль зөрчих, 7.13 дугаар зүйлийн Газрын тосны тухай хууль зөрчих, 7.14 дүгээр зүйлийн Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль зөрчих зэрэг үйлдлүүдийн холбогдох хэсгийг шалгах эрхтэй байдаг.

Замын хөдөлгөөний хяналтын байгууллага. Байгаль орчны хэрэг, зөрчлийг үйлдэгдсэд хууль бусаар олсон зүйлсээ тээвэрлэх явцдаа замын хяналт шалгалтаар илрэх тохиолдол нэлээд их байгаа бөгөөд сүүлийн үед хувийн тээврийн хэрэгсэл, ялангуяа орон нутгийн автобус, ачаа хүргэх шуудангаар амьтан, ургамлын гаралтай түүхий эд, өнгөт чулуу зэргийг явуулах зөрчлүүд ихээр үйлдэгдэх болсон байна.

Аймаг нийслэл, сум дүүрэг, баг, хорооны Засаг дарга, тэдгээрийн ажилтнууд, шат шатны иргэдийн хурал, төлөөлөгчид. Орон нутгийн өөрөө удирдах болон Засаг захиргааны нэгж байгууллага, шат шатны Засаг дарга нарт хуулиар олгосон эрх хэмжээ, үүрэгтэй.

Тэдгээр эрхээ эдлэх, үүргээ гүйцэтгэхдээ энэ чиглэлийн мэдээлэл олох боломжтой. Тухайлбал, Ойн тухай хуульд (17.2.1) ойн тухай хууль тогтоомж, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах, (17.2.2) ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ой, хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах, биелэлтийг хангах, (17.2.5) ой, хээрийн түймрээс учирсан хохирлын хэмжээг тогтоолгож, байгаль орчныг нөхөн сэргээх талаар улсын захиалга өгч, судалгаа-шинжилгээний ажил гүйцэтгүүлэх, үр дүнг тооцож, хэрэгжүүлэх арга хэмжээ авах, (17.2.6) ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх талаар ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагаас явуулж байгаа үйл ажиллагааны явцад хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах, шаардлагатай бол ойн санд сөргөөр нөлөөлж байгаа үйл ажиллагааг нь түдгэлзүүлэх, зогсоох, (18.2.5) ой, хээрийн түймэр, хөнөөлт шавж, өвчин, хууль бус үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, учирсан хор хөнөөлийг арилгах, (18.2.7) ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, ойн мэргэжлийн байгууллагын ойн менежментийн төлөвлөгөөг үндэслэн сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон хязгаарт багтаан мод бэлтгэх шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, хяналт тавих, (19.1.3) ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад ойн

сангийн тодорхой хэсгийг эзэмшүүлэх, гэрээг цуцлах санал, дүгнэлтийг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад уламжлах, (19.2.4) ой, хээрийн түймэртэй тэмцэх ажлыг шуурхай зохион байгуулах, хүн хүч, техник хэрэгслийг дайчлах, ой, хээрийн түймэр гарсан тухай болон түймрийг унтраах ажлын явцыг дээд шатны Засаг дарга болон холбогдох бусад байгууллагад шуурхай мэдээлэх зэргээр тодорхой заасан байдаг.

2.1.3. Сошиал буюу нийтийн мэдээлэл

Мэдээллийн эх сурвалжийн нэг нь нийгмийн сошиал сүлжээ, түүнд тавигдаж байгаа мэдээлэл юм. Тэдгээр нь мэдээллийн бүхий л суваг болох зар, сонин хэвлэл, телевиз, радио, интернэт болон мэдээллийн бусад хэрэгслээр цацагдсаар л байна. Өнөө үед мэдээллийн хэрэгслээр явагдаж байгаа зар сурталчилгаа нь хүмүүсийн харилцааны чухал нэгэн хэрэглүүр болжээ.

Зар сурталчилгааны тухай хуулиар нэн ховор, ховор амьтны эд эрхтнийг худалдаалах, нэн ховор, ховор ургамал болон түгээмэл тархацтай ашигт малтмал болох өнгөт чулуу гэх мэт байгалийн баялгийг худалдаалахтай холбоотой зар явуулахыг хориглосон хэдий ч энэ төрлийн мэдээлэл гарсаар байна. Зар сурталчилгаа, нийгмийн сошиал мэдээлэл нь хууль бусаар амьтны эд эрхтэн, ургамал, өнгөт чулуу худалдаалдаг цэг, байршил, гэмт этгээдүүдийг илрүүлэхэд тодорхой нэмэр болох тохиолдол бий.

Зар сурталчилгааны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн Байгаль орчны салбар дахь зар сурталчилгаа хэсэгт (14.1) нэн ховор, ховор ургамал, амьтны жагсаалтад орсон болон тэдгээрийн үндэс, иш, мөчир, навч, бугын цусан эвэр, чив, засаа, согооны сүүл, сав, хүдрийн заар, баавгайн доньд зэрэг эрхтнийг бэлтгэх, худалдах, худалдан авах, мөн (14.2) хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд Засгийн газраас гаргасан шийдвэрийн дагуу тодорхой хугацаанд агнах, бэлтгэхийг хориглосон амьтан, ургамлын эд эрхтэн, түүхий эдийг худалдах, худалдан авах тухай зар сурталчилгаа явуулахыг тус тус хориглосон байна.

2.2 МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ АРГА, АЖИЛЛАГАА

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.2 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт зөрчлийн талаарх мэдээллийг төлбөртэй авч болно. Мэдээллийг төлбөртэй авах журмыг санхүү, төсвийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батлахаар тусгажээ.

Зөрчлийн шинжтэй мэдээлэл олж авахын тулд байгаль орчныг хамгаалах эрх бүхий байгууллага, алба хаагчид буюу байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нарын өөрсдийнхөн идэвхтэй үйлдэл, үйл ажиллагаа чухал ач холбогдолтой. Уг үйл ажиллагааг байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нь өөрсдөө биечлэн болон гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх үүрэг бүхий бусад алба хаагчид, нутаг дэвсгэр хариуцсан төрийн байгууллагын албадтай хамтран тодорхой зорилго, зорилт бүхий хяналт шалгалт, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион явуулж болно.

Хяналт шалгалтыг Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу явуулна. Хяналт шалгалт нь тус хуульд зааснаар хуульд заасан эрх бүхий байгууллагын хяналт шалгалт болон бусад төрийн байгууллагаас хийх хяналт шалгалтаас бүрдэнэ.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 3 дугаар зүйлд (3.1) төрийн хяналт шалгалт нь Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Төрийн аудитын байгууллага болон хуульд заасан эрх бүхий байгууллагын хяналт шалгалт, Үндсэн хуулийн Цэц, шүүх, прокурорын хяналт, нутгийн өөрөө удирдах байгууллагаас энэ хуулийн дагуу хэрэгжүүлэх хяналт шалгалтаас бүрдэнэ, мөн энэ хуулийн 3^1 дүгээр зүйлд (3^1.1.1) "*хяналт шалгалт*" гэж иргэн, хуулийн этгээдийн явуулж байгаа үйл ажиллагаа (үйлдэл, эс үйлдэхүй), түүнчлэн үйлдвэрлэж байгаа болон борлуулж байгаа бараа, бүтээгдэхүүн, үзүүлж байгаа ажил, үйлчилгээ хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг дүгнэхэд чиглэсэн хянан шалгах арга хэмжээний цогцолборыг, (3^1.1.2) "*хяналт шалгалтын арга, хэлбэр*" гэж тухайн хяналт шалгалтад хамаарах баримт бичгийг хянан үзэх, шалгуулагч этгээдийн үйл ажиллагаагаа явуулдаг нутаг дэвсгэр, байр, барилга байгууламж, өрөө тасалгаа, тоног төхөөрөмж, бусад объект, тээврийн хэрэгсэл, ачаа бараанд үзлэг хийх, бүтээгдэхүүн болон тухайн үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны орчноос дээж авч шинжлэх, турших, учирсан хор хохирол болон гаргасан зөрчлийн хоорондох уялдаа холбоог тогтоох зорилгоор шинжилгээ явуулах зэрэг хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллагын албан тушаалтан, түүнчлэн хууль тогтоомжид заасан журмын дагуу хяналт шалгалтад татагдан оролцож байгаа шинжээч, шинжилгээний байгууллагын үйл ажиллагааг ойлгоно хэмээн тус тус заажээ.

Төрийн хяналт шалгалтын тухай хуульд зааснаар хяналт шалгалтыг төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх болон гүйцэтгэлийн гэж ангилна. Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу хийнэ. Харин Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 53 дугаар зүйлийн урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хэсэгт (53.1) урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хүний амь нас, эрүүл мэнд, нийтийн болон орчны аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдэл, хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох зорилгоор хийнэ, мөн (53.2) урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг тухайн асуудлыг хариуцсан хяналт шалгалтын байгууллагууд хамтран гүйцэтгэж болно хэмээн тодорхой тусгажээ.

Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан хяналт шалгалтын үйл ажиллагааны горим, үндсэн шаардлага, хяналт шалгалтын төлөвлөгөө, эрсдэлийн шалгуур үзүүлэлт харилцааг Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтоолоор батлагдсан "Хяналт шалгалт хийх нийтлэг

журам”-ын дагуу явуулна. Хяналт шалгалт явуулах улсын байцаагч нь зөвхөн төрийн хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Мэдээллийг олж авахдаа дээр дурдсан хуулиудын хүрээнд явуулахаас гадна, байгаль хамгаалагчийн Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар олгогдсон үндсэн үүрэг болох хариуцсан нутаг дэвсгэртээ байгаль орчинд учирч болзошгүй аюулаас сэргийлэх, байгалийн баялгийг хамгаалах арга хэмжээ авах, хариуцсан нутаг дэвсгэртээ орших гол, мөрөн, нуур, усан замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавих, улсын байцаагч бол иргэн, аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад харьяалал харгалзахгүйгээр хянан шалгах зорилгоор мэдээлэл цуглуулна.

Байгаль хамгаалагчид хариуцсан нутаг дэвсгэр дээрээ бусад байгууллага, ард иргэдийн оролцоотойгоор эсвэл дангаараа нэгдсэн, бүсчилсэн, хэсэгчилсэн эргүүл хяналт шалгалтын ажиллагааг идэвхтэй зохион явуулах нь хэрэг, зөрчлийг ирүүлэх, мэдээллийг олж авах эх сурвалжийн нэг болдог.

Хяналт шалгалт, эргүүл хийхэд хамгийн энгийн арга нь ажиглалт бөгөөд энэ нь хэрэг, зөрчил үйлдэгдэж болзошгүй газар орон, нөхцөл байдал, хөдөлгөөн, сэжигтэй хүнийг харах, сонсох, харьцуулах зэрэг үйл ажиллагаа юм. Ажиглалт нь хүн, эд зүйл, түүний байрлал, объектод орох, гарах хөдөлгөөнийг илрүүлэх, ажлын зураг авах, зөрчил гаргагчийг үйлдэлд нь барих зэрэгт тусалдаг, цаг хугацаа нэлээд зарцуулдаг үйл ажиллагаа боловч маш олон мэдээллийг танд өгнө.

Ажиглалтыг явуулж байгаа хэлбэрээр нь хяналтын цэгийн, явган явж ажиглах, агаарын, автомашинтай, завьтай болон бусад техник хэрэгсэлтэй, мэдээллийн гэх мэтээр ангилж болно.

а) Хяналтын цэгийн ажиглалт. Байгаль хамгаалагч энэ ажиглалтын аргыг нийтийг хамарсан газарт эсвэл өндөрлөг газраас тухайн нутаг дэвсгэрийг биечлэн болон техник хэрэгсэл ашиглан ажиглахад хэрэглэж болно. Хяналтын пост, цэг нь ажиглалтын энэ аргын нэг хэлбэр бөгөөд дүрс бичлэг, гэрэл зургийн хэрэгсэл ашиглаж болно. Жишээлбэл, орон нутгаас нийслэл рүү орох төв зам, худалдааны зах зэрэгт хяналтын камер байрлуулах юм уу бусад байгууллагуудын техник хэрэгсэл ашиглаж болно.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд (3.5) гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбай, олон нийтийн газарт, эсхүл замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор дүрсний бичлэгийн төхөөрөмж байршуулахтай холбогдсон Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд зааснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна хэмээн тодорхой тусгасан байдаг.

б) Явган явж ажиглах. Энэ арга нь байрандаа ажиглахтай адил олон хүн цуглардаг болон зах худалдааны газарт ашиглахад тун тохиромжтой. Тэнд болж буй үйл ажиллагааг илээр ажиглахаас гадна, тухайн зах дээр хууль бус худалдаа наймаа хийдэг эсэх талаар өөр төрлийн наймаа хийдэг танил худалдаачин, бусад хүмүүсээс тодруулах, үйлчлүүлэгч болж үзэх зэргээр ашиглаж болно. Энэ нь хэрэг, зөрчил мөрдөхөд туслах олон чухал мэдээллийг өгнө. Гэхдээ албаны дүрэмт хувцастай хийх нь тийм ч үр дүнтэй бус.

в) Завиар явж ажиглах. Завиар явж ажиглах аргыг гол мөрөнд ашиглана. Амьтан агнах хориотой улирлын үед гол мөрөнд завиар эргүүл, хяналт хийх нь эргийн ойролцоо болж буй аливаа үйл явцыг харах, загасчилж байгаа хүмүүс рүү чимээ багатайгаар ойртоход дөхөмтэй.

Эргүүл, хяналт шалгалтаар яваа алба хаагчдын тээврийн хэрэгсэл (машин, мотоцикл г.м)-ийн дуу чимээнээр голын эрэг орчимд хууль бус үйлдэл хийж байгаа этгээдүүд зугтах, эд мөрийн баримтыг нуух бололцоог олгодог учраас түүнээс сэргийлдэг. Мөн голын эрэг дагуу уул урхайн олборлолт хууль бусаар явуулах, гол усыг бохирдуулах, голын ус руу зөвшөөрөлгүй бохирдуулах зүйл асгах, цутгах зэрэг үйлдлийг илрүүлж болзошгүй.

г) Агаарын ажиглалт. Хүний хүч хөдөлмөр хөнгөвчилсөн, өртөг зардал бага, цаг хугацаа хэмнэсэн үр дүнтэй, ажиглалтын нэг төрөл юм. Эргүүл, хяналт шалгалт явуулах бололцоо боломж муутай газарт хууль бусаар мод бэлтгэх, агнуурын отог, түүний байршил, зам харгуй зэргийг тогтоох, гэмт этгээдүүд, зөрчил гаргагчдын үйлдлийг баримтжуулах, таслан зогсоох, отолт хийх газрыг сонгох, богино хугацаанд хяналтыг үр дүнтэй зохион явуулах, газар орны нөхцөл байдлыг судлах зэрэг олон талын ач холбогдолтой. Агаарын ажиглалт явуулахад бага оврын нисэх онгоц (1-2 хүний суудалтай), нисгэгчгүй нисдэг төхөөрөмж (дрон) зэрэг хэрэгслийг ашиглах өргөн боломж бий.

д) Авто машинт ажиглалт. Эргүүл хяналт, шалгалт явуулахад ашиглаж буй гол тээврийн хэрэгсэл бол автомашин юм. Автомашинаар “хөдөлгөөнт эргүүл” хийх нь иргэдийн хөдөлгөөнийг ажиглаж, урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулж буй нэг хэлбэр юм.

е) Мэдээллийн ажиглалт. Мэдээлэл хүний амьдралын салшгүй нэг хэсэг болжээ. Ялангуяа цахим мэдээлэл (фэйсбүүк, твитер, мэйл, мэссэнжэр г.м) бөгөөд түүнд хяналт тавих нь чухал болж буй өнөө үед технологийн дэвшилтэт үр дүнтэй техник хэрэгслүүдийг ашиглах нь зүйтэй.

Аливаа эргүүл, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулахдаа урьдчилан суурь судалгаа хийж, нарийвчилсан ажлын төлөвлөгөө гаргаж байх нь цаг хэмнэх, эрсдэлийг багасгахад тусална. Ингэж ажлын төлөвлөгөө (уян хатан байж болно) гаргаснаар тухайн ажиллагааг үр дүнтэй, эрсдэлгүй болгох эхний алхам болно. Төлөвлөгөөнд объектын судалгааг ашиглах, хяналт шалгалт явуулах газар нутгийн масштаб зургийг гаргах, зам харгуй, орчны байдал, айл өрхийн байршил болон тухайн цаг үеийн нөхцөл байдал, цаг агаар, улирлын байдлыг тодорхойлох, түүнд тохируулан хамтран ажиллах байгууллага, хүн хүч, ашиглах техник хэрэгсэл зэргийг урьдчилан гаргаж тусгах нь зүйтэй.

Эргүүл, хяналт шалгалтыг хөдөө орон нутагт зохион байгуулахаас гадна, төв суурин газар, худалдаа үйлчилгээний зах, төвүүдэд явуулж, хяналт тогтоох нь зөрчлийн талаарх мэдээлэл олж авах эх сурвалжийн нэг болно. Худалдааны төв, захуудад хууль бусаар агнасан амьтны эд эрхтний худалдаа ихэвчлэн нууц далд явагддаг тул худалдаа, наймаа эрхлэгч нартай уулзаж хэлхээ холбоо тогтоож, мэдээлэл олж авахдаа албаны хүн гэдгээ мэдэгдэх эсвэл мэдэгдэхгүйгээр харилцах нь тухайн үеийн нөхцөл байдлаа зөв үнэлж гаргах таны шийдвэр юм. Амьтны эд эрхтнийг худалдан авах, зарах, хадгалах нь өөрөө гэмт хэрэг тул наймаачидтай тун болгоомжтой хандах нь чухал.

2.3 ХАМТЫН АЖИЛЛАГАА

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа бол дан ганц байгууллагын хуулиар хүлээсэн үүрэг биш бөгөөд ганц нэгээрээ тэмцээд ч үр ашиг багатай болохыг дэлхий нийтийн туршлага нэгэнт баталсаар байна. Ер нь хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажил нь олон байгууллагуудыг тогтмол хамтран ажиллах шаардлагыг практикт үүсгэж байдаг. Төрийн байгууллагуудад хуулиар хүлээлгэсэн олон чиг үүрэг байдаг бөгөөд ялангуяа гэмт явдалтай тэмцэх нийтлэг үүргийг хууль, хяналт, шалгалтын байгууллагууд иргэдийн оролцоотой хамтран ажиллахыг эрх зүйгээр зохицуулсан.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь хууль сахиулах, хэрэгжүүлэх, хамгаалах байгууллагуудын хамтын ажиллагаа, хэрэг, зөрчил гарахад нөлөөлж байгаа шалтгаан нөхцөлийг арилгахад чиглэгдсэн урт хугацааны системтэй, нөр их ажил бөгөөд бүх нийтийн идэвхийг өрнүүлсний үндсэн дээр хэрэгжих цогц арга хэмжээ юм. Харин хамтын ажиллагааг хэрэг, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, дэг журмыг сахиулж, хуулийн хэрэгжилтийг хангах зорилгод чиглэсэн, байгууллагууд хоорондоо харилцан зөвшилцсөний үндсэн дээр эрх тэгш, өөрсдийн хэм хэмжээний хүрээнд, тухайн салбарынхаа онцлогт тохируулж, үйл ажиллагаагаа уялдуулан зохион байгуулах ажиллагаа гэж ойлгож болно.

Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын чанар, үр нөлөөг дээшлүүлэх зайлшгүй нэг хүчин зүйл нь хамтын ажиллагаа бөгөөд байгууллагууд хоорондын үйл ажиллагааг зохицуулах явдал хамгаас чухал юм. Зохицуулалт нь аливаа ажил үйлдлийн хооронд зүй зохист харьцаа, хамаарал тогтоох, уялдуулах, нийцүүлэх гэсэн гол утгыг илэрхийлнэ[5]. Тодруулж хэлбэл, олон төрлийн чиг үүрэгтэй байгууллага, ажилтны үйл ажиллагааг уялдуулан холбож, харилцан бие биеийн ажиллагаанд зохист харьцаа тогтооход зохицуулалтын зорилго оршино.

Олон төрлийн байгууллага өөрсдийн өмнөх нийтлэг зорилтыг хүч хамсан шийдвэрлэхийн тулд тус тусын гүйцэтгэх үүрэг, гаргах хүч хөрөнгө, уг ажлыг эхлэх дуусах хугацаа, хэрэгжүүлэх, дүгнэх арга, хэлбэр зэрэг олон тал асуудлыг урьдчилан тохиролцох буюу товлон тогтоож, түүний дагуу практик үйлдлүүдийг хооронд нь хэлхэж, холбож өгөх, ингэснээрээ тухайн ажил үүргийг хийдүүлэх, давхардуулж зэрэгцүүлэх явдлаас сэргийлж, объект (жишээ нь, орон нутгийн байгууллагууд)-ыг хүндрүүлэхгүй байх, улмаар цаг, хүч, хөрөнгийн хэмнэлт гаргахад зохицуулалтын ач холбогдол илэрдэг[6].

Хамтын ажиллагааг аль нэгэн байгууллагын санаачлагчаас гадна, эрх зүйн зохицуулалтаар хэрэгжүүлнэ. Тухайлбал, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгад төрийн байгууллагууд **хуульд заасан эрх хэмжээний хүрээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар бусад байгууллагад дэмжлэг үзүүлэх, харилцан мэдээлэл солилцох, хамтран ажиллах** талаар заасан нь хамтын ажиллагааны гол эрх зүйн зохицуулалт юм.

Сүүлийн үед хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа сайжирч, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар зохиож байгаа ажлын чанар дээшилж, тэдний хамтын хүчин чармайлтаар хүрээлэн буй орчны эсрэг зарим төрлийн гэмт хэрэг, зөрчлийн

5 Козлов, Ю. М. (1976). *Координация в управлении в народном хозяйстве в СССР*. Изд Московского университета. 5 дахь тал.

6 Чимэд, Б. (1979). *Хууль хамгаалах байгууллагуудын хамтын ажиллагааны зохицуулалт, түүний үндсэн хэлбэр*. Социалист хууль ёс. №3. Улаанбаатар. 28 дахь тал.

гаралт буурч, иргэдийн эрх зүйн боловсрол, хүмүүжил болон урьдчилан сэргийлэх ажлын систем тогтож, нэгдмэл үйл ажиллагаа явуулах туршлага зохих хэмжээгээр хуримтлагджээ.

Хамтран ажиллахдаа төрийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хууль тогтоомжийн биелэлтийг шалгах, гэмт хэрэг, зөрчлийн байдал, бүтэц, хөдөлгөөн хандлагыг улсын хэмжээгээр болон засаг захиргааны нэгж, улс ардын аж ахуйн салбар, үйлдвэр, аж ахуйн газар, байгууллага, иргэдийн дунд судлах, тэдний хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, төр засгаас дэвшүүлсэн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх нийтлэг арга хэмжээний зорилттой уялдуулан зохион байгуулж байх нь зохистой.

Хамтын ажиллагааны уялдаа холбоог сайжруулж, үр нөлөөг дээшлүүлэхэд анхаарах хэдэн нөхцөл бий. Юуны өмнө хамтран ажиллах төлөвлөгөөг зохиох, түүнийг хэрэгжүүлэх арга, шаардагдах хөрөнгө, зардал, цаг хугацааны талаар харилцан тохиролцох нь зүйтэй. Хэрэгжүүлэх арга хэмжээ нь тухайн байгууллагын эрхлэх чиг үүрэг, эрх хэмжээний дотор байхын зэрэгцээ нэг байгууллагын онцлог, эрх хэмжээ үүрэгт холбогдох асуудлыг нөгөө байгууллага шийдвэрлэхгүй байх ёстой. Байгууллагууд урьдчилан сэргийлэх ажиллагааг олон нийтийн хүчинд тулгуурлан тэдний туслалцааг авч хэрэгжүүлнэ. Хууль сахиулах ба хяналт шалгалтын байгууллагуудаас зохиох хэрэг зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэлийн чухал хэсэг бол гэмт хэрэг, зөрчлийн байдал, түүнийг үйлдсэн этгээдийн тухай болон шалтгаан нөхцөлийн талаар бие биедээ харилцан мэдээлж байх явдал юм.

Хамтын ажиллагаа нь нэгдсэн төлөвлөгөө боловсруулахаас эхлэх бөгөөд хэтийн, дунд хугацааны болон ойрын (цаг үеийн) төлөвлөгөө боловсруулах нь гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажлыг системтэй явуулахад ач холбогдолтой. Төлөвлөгөө нь зохион байгуулалтын асуудал, хамтран хийх хяналт шалгалтын ажил, судалгаа шинжилгээний ажил, ухуулга сурталчилгааны ажил, төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх хэсгүүдээс бүрдэж болох бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй юм.

Хамтын ажиллагааны зохион байгуулалтын асуудалд гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх талаар хууль сахиулах байгууллагуудын удирдах албан тушаалтнууд, хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар зохион байгуулах хурал зөвлөгөөн, хэлэлцүүлэг, тодорхой асуудлаар санал боловсруулах зэрэг зүйлс багтана. Харин хамтран хийх хяналт шалгалтад тодорхой газар орон, бүс нутаг, үйлдвэр, аж ахуйн нэгжид шалгалт явуулах, түүний дүнг авч хэлэлцэх, арга хэмжээг хамтран боловсруулна. Хамтын ажиллагаагаар ажлын хэсэг байгуулан гэмт явдлын бүтэц, хөдөлгөөн, гаралт, хандлага, шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх ажлыг зохион явуулж байгаа ажлын практикийг судалж болно.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулж байгаа ажлыг дотоод ба гадаад хамтын ажиллагаа гэж ангилна. *Дотоод хамтын ажиллагаанд* хууль сахиулах байгууллагууд, төрийн болон төрийн бус байгууллагууд, шинжлэх ухааны ба хууль сахиулах байгууллагууд хоорондын болон тухайн байгууллагын дотоод бүтэц, нэгжийн гэх мэтээр хуваан үзэж болно. Харин *гадаад хамтын ажиллагаанд* хөрш зэргэлдээ улсууд болон бусад улсын орон, гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын байгууллагууд (интерпол г.м) хоорондбайж болох бөгөөд гадаад хамтын ажиллагаа нь ижил төрлийн байгууллагуудтай хамтран ажиллах, санамж бичиг, гэрээ, хэлэлцээр байгуулах, харилцан туршлага солилцох, мэдээлэл дамжуулах зэрэг хэлбэрээр илэрч байдаг.

Хууль сахиулах болон гааль, хяналт, шалгалтын байгууллагуудаас гэмт хэрэг, зөрчлийн тухай мэдээллээр хангах, шаардлагатай үед хэрэг мөрдөх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд мэргэжлийн дэмжлэг туслалцаа үзүүлэх, гэмт хэрэг, зөрчил гарч буй шалтгаан

нөхцөлийг тогтоож, түүнийг арилгах талаар урьдчилан сэргийлэх ажлуудыг зохион байгуулж, хариу мэдэгдэх, байгаль хамгаалах чиглэлээр гадаад орны туршлага судлах, хамтран сургалт зохиох, нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ явуулах, хэрэг шалгах ажиллагааны үр дүнд дүрэм журам, стандартыг зөрчсөн тухай мэдээллийг илрүүлсэн тохиолдолд харьяалах байгууллагад нь шилжүүлэх, зарим төрлийн лабораторийн шинжилгээг хийлгүүлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, мэдээллээ саадгүй солилцож байх зэрэг олон ажлыг хамтран зохион байгуулж болно.

Төрийн захиргааны бусад байгууллагатай хамтран ажиллахаас гадна, байгаль орчны салбарын байгууллага дотроо албадын хамтын ажиллагааг зохион байгуулах нь нэгдмэл байдлыг хангах, хүн хүч, нөөц боломжоо зөв хуваарилах, мэдээллийг шуурхай дамжуулах, хэрэг, зөрчлийг таслан зогсоох зэрэг олон талын ач холбогдолтой. Иймд зохион байгуулалтын нэгжүүд гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хамтын ажиллагааны хэлбэрүүдийг (а) зохион байгуулалтын нэгжүүдийн хоорондох, (б) зохион байгуулалттай нэгжнутаг дэвсгэрийн байгууллага хоорондын, (в) нутаг дэвсгэрийн байгууллага хоорондын гэж байгууллага, салбар нэгжээр зохион байгуулж болно.

Хамтын ажиллагаанд тус тусын байгууллага, албан тушаалтан, ажилтанд хүндэтгэлтэй хандах, хууль ёс дээдлэх, шударга, шуурхай байх зэрэг **зарчмыг баримтална.**

Иргэдийн оролцоо хамтын ажиллагааны хэлбэр болох нь. Байгаль орчны хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагаанаас гадна, иргэдийн оролцоог хангах, түүнийг нэмэгдүүлэх нь өнөө үеийн чухал шаардлага бөгөөд дэлхийн нийтийн хандлага ч иргэдийн оролцоог хангаж, нутгийн иргэдэд түшиглэх болсон. Иргэдийг байгаль хамгаалах ажилд татан оролцуулах нь хамтын ажиллагааны хамгийн идэвхтэй хэлбэр юм.

Нутгийн иргэдэд түшиглэсэн байгаль орчны менежментийг нэвтрүүлж, иргэд, төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлж, байгаль орчны стратегийн үнэлгээ болон аудитын тогтолцоог шинээр нэвтрүүлж, ногоон эдийн засгийн хөгжлийн үндсийг тавьснаар байгаль хамгааллын цоо шинэ эрх зүйн орчин бүрдсэн. Байгаль хамгаалалд иргэний оролцооны анхдагч элемент нь тэднийг мэдээллээр хангах явдал юм. Иргэд аливаа асуудлаар мэдээлэлтэй болсон тохиолдолд оролцох боломж нээгдэж, оролцооны үндэс суурь тавигдана.

Өнөөдрийн эрх зүйн зохицуулалтаар ч тэр иргэдийн хамтын ажиллагаа, оролцооны хэлбэр нь мэдээллээр хангах, мэдээлэл авах гэсэн хэлбэр илүү түлхүү байна. Мөн байгаль орчны зөрчлийн талаар үнэн зөв мэдээллийг холбогдох байгууллагад мэдээлсэн, иргэд, байгууллагыг урамшуулах тухай заалтууд Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Амьтны тухай хууль болон Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль зэрэгт тусгагдсан[7] байдаг. Ер нь иргэдийн оролцоотойгоор

7 Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 54 дүгаар зүйл. Байгаль орчныг хамгаалах эдийн засгийн хөшүүрэг

4. Байгаль орчны хууль тогтоомж зөрчсөн тухай үнэн бодит мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд өгсөн, түүнчлэн зөрчлийг илрүүлсэн, илрүүлэхэд бодитой туслалцаа үзүүлсэн иргэнд зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн орлогын дүнгийн 15 хувьтай тэнцэх мөнгөн урамшууллыг сум, дүүргийн Засаг дарга байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос олгоно.

6. Энэ зүйлийн 4, 5, 8, 9 дахь хэсэгт заасан урамшуулал олгох журмыг Сангийн болон Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд батална.

7. Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан мэдээлэгчийг холбогдох хууль тогтоомжийн дагуу нууцлана.

8. Байгаль орчны хууль тогтоомж зөрчсөн тухай үнэн бодит мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд өгсөн иргэн, нөхөрлөл, төрийн бус байгууллагад 150000 төгрөгийн мөнгөн урамшууллыг сум, дүүргийн Засаг дарга ажлын 10 өдөрт багтаан байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос олгоно */Энэ хэсгийг 2015 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн хуулиар нэмсэн/.*

байгаль хамгааллын ач холбогдлыг бусад иргэдэд хүргэх нь урьдчилан сэргийлэх ажлын хамгийн үр дүнтэй, оновчтой хэлбэр мөн гэдгийг онцгой анхаарах хэрэгтэй.

Бодит жишээ

Улаанбаатар (МОНЦАМЭ). Нийслэлийн Байгаль орчны газраас гаргасан “Зуслан” аппликейшнийг иргэн та гар утсандаа суулгаж хотын ногоон бүс, зусланд гарч буй байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийг илгээх боломжтой болжээ. Уг аппликейшнийг Андройд, iOS үйлдлийн системтэй ухаалаг төхөөрөмжид “Зуслан” эсвэл “zuslan” гэсэн түлхүүр үгээр хайлт хийж суулгана. “Санал гомдол” цэсэд 3 хүртэл гэрэл зургийг хавсарган хүрээлэн буй орчны эсрэг хууль, журам зөрчсөн үйлдлийн талаарх мэдээлэл, санал, гомдлыг илгээж болох юм. Таны мэдээллийг Нийслэлийн Байгаль орчны газрын эрхлэх асуудлын хүрээнд хамаарч байвал шалгаж нягтлан, авсан арга хэмжээний талаар хариу мэдэгдэх аж.

Мэдээлэл илгээхдээ холбоо барих утас, и-мэйл хаягаа оруулахыг тус газраас зөвлөж байгаа бөгөөд видео бичлэг болон илүү олон зураг илгээх бол аппликейшний зүүн дээд буланд байх нийгмийн сүлжээний хаягуудаар холбогдох боломжтой. Мөн “Зуслан” аппликейшний “Мэдээ, мэдээлэл” цэсээс байгалийн нөөц ашиглалттай холбоотой сүүлийн үеийн мэдээлэл, дэд цэсүүдээс байгаль орчны талаарх зөвлөмж өгөх юм байна. Эх сурвалж https://montsame.mn/mn/read/227410

Дээрх мэдээлэл нь байгаль орчны хэрэг, зөрчлийн талаарх мэдээлэл цуглуулах нэгэн арга болж байна. Энэ талаар хууль зүйн дүгнэлт хийж, мэдээллийн эх сурвалж болгоход анхаарч, цаашид мэдээлэл цуглуулах ажиллагааг идэвхжүүлэх шаардлагатай.

“Амьтны тухай хуулийн 8 дугаар зүйл. Зөрчил илрүүлсэн, мэдээлэл өгсөн иргэнийг урамшуулах

38.1. Амьтны тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийг илрүүлсэн, илрүүлэхэд туслалцаа үзүүлсэн буюу түүний тухай мэдээлэл өгсөн иргэнд уг мэдээлэл нь батлагдсан тохиолдолд зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн хэмжээний 15 хувиар тооцож мөнгөн шагналыг сум, дүүргийн Засаг дарга олгоно.

“Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуулийн 14 дүгээр зүйл. Зөрчил илрүүлсэн, мэдээлэл өгсөн иргэнийг урамшуулах

14.1. Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийг илрүүлсэн буюу түүний тухай мэдээлэл өгсөн иргэнд уг мэдээлэл нь батлагдсан тохиолдолд зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн хэмжээний 20 хүртэл хувиар тооцож мөнгөн шагналыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.

2.4 ХЭРГИЙН ГАЗРЫН ҮЗЛЭГ, АРГА ТЕХНИК БА АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан нарт зөрчил шалгах ажиллагааны нэг болох зөрчлийн үзлэг хийх арга техникийн талаар мэдлэг, чадвар эзэмшүүлэхэд чиглэх бөгөөд үзлэг нь зөрчлийн нотлох баримтыг цуглуулах эх сурвалж тул түүнийг хийхэд анхаарах асуудлуудыг авч үзнэ. Зөрчлийн талаар өмнө үзсэнээ эргэн саная.

Хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, Зөрчлийн тухай хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхүйг **зөрчил** гэнэ. Зөрчлийн эс үйлдэхүй гэдэг нь хүн, хуулийн этгээд нь хууль, захиргааны хэм хэмжээний актыг биелүүлэх боломжтой байсан боловч түүнийг биелүүлэх зохих арга хэмжээг хэрэгжүүлээгүйг ойлгоно.

Зөрчлийн тодорхой ажиллагааны нэг нь зөрчил үйлдэгдсэн газар, хүн, хуулийн этгээдийн эзэмшил газар, барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, хүний бие, эд зүйлд үзлэг хийх ажиллагаа байдаг.

Үзлэг нь нотлох баримт цуглуулах үндсэн арга болдог. Түүний зорилго нь хэрэг, зөрчлийн ул мөр, эд мөрийн бусад баримтыг илрүүлэх, бэхжүүлэх, хэрэг зөрчилтэй холбоотой бусад байдлыг шалгах, үнэлэх, тодруулах зорилгоор судлан үзэж буй бие даасан тодорхой ажиллагаа юм. Өөрөөр хэлбэл, болж өнгөрсөн үйл явдлыг ойлгож мэдэх, түүнтэй холбоотой материаллаг зүйлийг илрүүлж, бэхжүүлэх зорилгоор хийж буй танин мэдэхүйн шинж чанартай хэрэг, зөрчил шалгах ажиллагааны нэг хэлбэр юм.

Зөрчлийн тухай хуульд хэргийн газрын үзлэгийн тухай ойлголт байхгүй боловч Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт *Зөрчил шалгах ажиллагаа нь зөрчил үйлдэгдсэн газар, хүн, хуулийн этгээдийн эзэмшил газар, барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, хүний бие, эд зүйлд үзлэг хийх, баримт бичиг, мэдээлэл гаргуулан авах, эд зүйл, баримт бичгийг хураан авах, эд хөрөнгийг битүүмжлэх, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, мэдүүлэг авах, шинжилгээнд зориулж хэв загвар, дээж авах, шинжилгээ хийлгэх ажиллагаанаас бүрдэнэ* хэмээн зөрчил шалгах ажиллагааг тодорхой тусгасан байна.

Харин Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 23.3 дугаар зүйлд гэмт хэрэг үйлдэгдсэн, үйлдэгдсэн байж болзошгүй гэх бодит үндэслэл байгаа бол хэргийн нотлох баримтыг олж тогтоох, хэрэгт ач холбогдол бүхий байдлыг тодруулах зорилгоор орон байр, бусад газар, нийтийн эзэмшил газрын тодорхой хэсгийг **хэргийн газраар тогтоон үзлэг хийх**ээр тусгажээ. Мөн Зөрчлийн тухай хуулийн 4.1 дүгээр зүйлд заасны дагуу “зөрчил үйлдэгдсэн газар, хүн, хуулийн этгээдийн эзэмшил газар, барилга байгууламж”-д үзлэг хийж болох бөгөөд харин зөвхөн прокурорын зөвшөөрлөөр хуулийн этгээдийн эзэмшил газар, барилга байгууламж, орон байранд үзлэгийг хийнэ.

Зөрчлийн холбогдогчийн биед зөвхөн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.2, 6.3, 6.8, 6.11, 6.13, 6.24, 6.25, 6.62 дахь заалтад дурдагдсан буюу (6.2) хилийн төлөөлөгч, орлогч, туслагч, (6.3) төрийн тусгай хамгаалалтын эрх бүхий ажилтан, (6.8) цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч, (6.11) гаалийн улсын байцаагч, (6.13) гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, (6.24) иргэний нисэхийн хяналтын байцаагч, (6.25) төмөр замын тээврийн улсын байцаагч, (6.62) дотоодын цэргийн эрх бүхий алба хаагч нар тус тус үзлэг хийх эрхтэй байна.

Энэ сэдэвт Зөрчлийн тухай хуулийн долдугаар бүлгийн Байгаль орчин, амьтан, ургамлыг хамгаалах журмын эсрэг зөрчилтэй холбоотой газарт үзлэгийг хэрхэн хийж болохыг Зөрчлийн

тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн Амьтны тухай хууль зөрчих зөрчлийн жишээ дээр тайлбарлах болно. Тухайлбал, Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн Амьтны тухай хууль зөрчих зөрчлийн (1) хугацаа дууссан гэрээ, зөвшөөрлөөр, эсхүл гэрээ, зөвшөөрөлгүйгээр амьтныг (1.1) ашигласан, (1.2) барьсан, (1.3) агнасан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулна гэж заасан байдаг.

Ан агнах ихэнх зөрчил нэлээд хугацаа өнгөрсний дараа илэрдэг учир агнасан гэдгийг нотлох зорилгоор тухайн газарт үзлэг хийж болох бөгөөд ингэж зөрчил үйлдэгдсэн газарт үзлэг явуулснаар тухайн зөрчилд хэчнээн хүн оролцсон, ямар чиглэлд явсан зэрэг хэрэгт ач холбогдолтой зүйлүүдийг тодорхойлж, нотлох баримтыг цуглуулна.

Үзлэгийг явуулахдаа а) бэлтгэл, б) үзлэг явуулах, в) төгсгөлийн гэсэн үе шаттайгаар зохион байгуулах нь илүү үр дүнтэй бөгөөд чухал ач холбогдолтой.

а) Бэлтгэл үе шат. Зөрчлийн тухай мэдээллийг хүлээн авсны дараа хэзээ, хаана, ямар асуудал болсон болон хэргийн газар ямар замаар очих гэх мэт асуудлуудыг мэдээлэл өгөгчөөс асууж тодруулна.

Мөн үзлэг хийх газар очихоос өмнө үзлэг хийхэд шаардлагатай дүрс бичлэг, дуу хураагч, гэрэл зургийн хэрэгсэл, тэдгээрийн ажиллагаа, зай, цэнэгийг шалгаж ажилд бэлтгэнэ. Үзлэгийн үр дүнд эд мөрийн баримтаар гол төлөв биологийн гаралтай эд зүйлс хураагддаг тул тэдгээрийг муутгахгүй, чанар байдлыг алдагдуулахгүй хадгалах зориулалтын цаасан уут, сав баглаа боодлыг урьдчилан бэлтгэнэ. Түүнчлэн энэ төрлийн зөрчил ихэвчлэн хээр тал, ой хөвчид үйлдэгддэг учраас бартаа саад туулах чадвартай машин техникийг урьдчилан бэлтгэнэ.

б) Үзлэг явуулах үе шат. Үзлэг нь нарийн төвөгтэй боловч хамгийн их үр дүн өгдөг шалгах ажиллагааны чухал төрөл тодийгүй зөрчлийн анхны бөгөөд хойшлуулшгүй ажиллагаа юм. Иймд үзлэгийн энэ үе шатанд үйл явдал болсон шинж тэмдгийн бодит мөр, бусад мэдээллийг шууд эрж хайх, шинжлэх, хураан авах асуудлууд багтана.

Мэдээлэл өгсөн хүмүүсээс хэргийн нөхцөл байдлын талаар товч мэдээлэл авч хэргийн газрыг баримжаална. Үзлэг явуулах орчны хил, үзлэг эхлэх цэгийг байршил тодорхойлогч багаж (GPS)-аар хөдөлбөргүй тогтоож, үзлэг явуулах дарааллыг тогтооно. Байршлыг нарийн тогтоох нь хэрэг болсон газар улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагддаг эсэх, аль аймаг, сумын нутаг дэвсгэрт хамаарах зэргийг тодорхойлох ач холбогдолтой бөгөөд энэ нь иргэний нэхэмжлэгчийг тогтоох, зөрчил юм уу гэмт хэргийн алин болохыг тогтоосноор хэргийн зүйчлэлд шууд нөлөөлнө.

Үзлэгийг объектив[8] хийж байгаа тохиолдолд их төлөв төвөөс эхлэн зах руу (эксцентрик) явуулах арга илүү үр дүнтэй. Учир нь мөрдөн байцаалтад ач холбогдол бүхий мөр, эд зүйлсийг ихээр илрүүлэн тогтоодог бөгөөд тухайн хэрэгтэй холбоотой эсэхийг нягтлах боломж илүү байдаг.

8 Өнөө үеийн криминалистууд субьектив ба обьектив гэсэн хоёр тодорхой аргаар хэргийн газрын үзлэгийг явуулж болно хэмээн үздэг. Үүнд:
Субъектив буюу эд мөрийн баримтыг сонгон авч үзлэгийг явуулах арга нь мөрдөгч зөвхөн гэмт хэрэгтний явах замд учрах объектуудыг шинжлэх, хамгийн их мөр үлдсэн байж болох эсвэл байгаа талбайг шинжилнэ. Тодруулбал, мөр байгаа гэсэн тэр хэсэг газарт үзлэг хийж, бусад газарт үзлэг хийхгүй юм. Энэ аргын дутагдалтай тал нь хэрэгт ач холбогдол бүхий ул мөр өөр газарт байгааг анзаарахгүй орхиж болох талтай.
Объектив буюу үзлэгийг нийтэд нь хийх арга нь хэргийн газрын үзлэг хийвэл зохих газрыг нийтэд нь хамарч байдгаараа субъектив аргаас ялгаатай бөгөөд үзлэгийг их хэмжээний хүч хэрэгсэл, талбайг хамруулж хийдэг тул нэлээд их цаг хугацааг үр ашигүй зарцуулах явдал олонтоо гарна. Ер нь хэргийн газрыг бүхэлд нь дэс дараалалтай судлах нь ямагт илүү оновчтой байдаг нь практикаас харагддаг.



Мөр: ямар амьтны мөр болох, хэдэн амьтан байсан, мөн өөр амьтан байсан эсэх, тээврийн хэрэгсэл болон хэдэн хүн байсан, түүнчлэн орчны байр байдал, явсан чиглэл зэрэг олон мэдээллүүдийг авч болно.

Захаас төв рүү (концентрик) арга нь хэрэг яг хаана болсныг тогтоох боломжгүй байгаа, зах орчмоос илрүүлж болох мөрийг баллах устгах магадлалтай байгаа бол, захаас зах хязгаар хүртэлх (фронт) арга нь төв рүү хүрэхийн тулд зах орчмын мөрийг туучиж талхлахаар бол энэ аргыг хэрэглэнэ. Ер нь эдгээр аргуудын аль нэгийг заавал ашиглана гэсэн зүйлгүй юм.

Энэ төрлийн зөрчил ихэвчлэн хээр тал, ой тайга зэрэг алс бөглүү нутагт үйлдэгдэг тул байршил тогтоогч багаж (GPS) ашиглан хэргийн газрын координатуудыг авч, зөрчил болсон газрыг баримжаалсны дараа үзлэг явуулах орчны хил хязгаарыг тогтооно.

Амьтан агнасан зөрчлийн газар оронд хийх үзлэгийг дахин давтагдашгүй гэж үздэг тул анхны үзлэгийг маш чанартай явуулах шаардлагатай. Учир нь үзлэгийг хангалтгүй явуулбал тодорхой хугацааны дараа давтан үзэхэд, амьтны сэг зэмийг нохой шувуу идэх, цас бороо орж ул мөрийг арилгах, шинж байдлыг алдагдуулах, мөн тухайн хэргийн газрын координатыг байршил тогтоогч багаж (GPS)-аар тогтоогоогүй бол эргэж газраа олохгүй байх юм уу олоход бэрхшээл учрах, алс хол газарт дахин очиход цаг хугацаа, хөрөнгө хүч ихээхэн үргүй зарах асуудал гарна.


Захаас төв рүү (концентрик) арга


Төвөөс эхлэн зах руу (эксцентрик) арга

Үзлэгээр зөрчил үйлдсэн этгээд тухайн газарт ирсэн буцсан чиглэл, замыг тогтоох, илрүүлсэн эд зүйлээс гэмт этгээд хэдүүлээ байсан, ямар ан агнасан, ямар эд эрхтнийг нь авсан, үйлдлийн арга нь галт зэвсэг эсвэл хавх, занга, сааль хэрэглэсэн эсэх, хэргийг үйлдэхдээ морь, мотоцикл, автомашин зэрэг тээврийн хэрэгсэл ашигласан эсэх зэрэг олон асуултад хариулт авах болно. Үзлэгийг нягт нямбай явуулснаар тухайн амьтныг үргээх, хөөх, отох зэрэг ямар аргаар агнасан болон тухайн үеийн нөхцөл байдлыг тодорхойлж болно. Тухайлбал, үргээлэгт үргээгч, хашигч, тосон буудагч зэрэг хүмүүс оролцдог тул оролцогчийн тоог харьцуулан гаргаж болохоос гадна, үргээгчид ихэвчлэн тухайн орон нутгийн хүмүүс байдаг тул гэрч, холбогдогчийг тодорхойлох боломжтой.

Үзлэгээр илэрч байгаа зүйлсийг дараах байдлаар хуваан үзнэ. Үүнд:

а) Амьтны холбогдол бүхий эд мөрийн баримт - амьтны сэг зэм, арьс мах, үс ноос, толгой шийр, эвэр, цус зэрэг биологийн гаралтай эд зүйлс болон амьтны биед үүссэн гэмтэл г.м.

б) Зөрчил үйлдэхдээ ашигласан багаж хэрэгсэлтэй холбогдол бүхий эд мөрийн баримт - амьтныг агнаж төхөөрөхөд хэрэглэсэн багаж зэвсэг, хутга мэс, олс дээсний тасархай, сумны хошуу, хонгио зэрэг орхигдож, гээгдсэн эд зүйлс, мөн түүнчлэн хууль бус үйлдлээ нуун далдлах болон ашигласан тээврийн хэрэгсэл, морь мал, гутлын мөр г.м.


в) Бусад эд зүйлс – сэжигтний хэргийн газарт үлдээсэн тамхины иш болон гутлын мөр, хувийн эд зүйлс, ашигласан авто машины шатах тослох материал дуссан асгарсан мөр, гал түүдэг асаасан ором г.м байж болно.

в) Төгсгөлийн үе шат (үзлэгийн дүнг бэхжүүлэн авах). Энэ үе шатанд үзлэгийн явцад олж авсан үр дүнг баримтжуулах, бэхжүүлэх асуудлууд хамаарна. Зөрчлийн хэргийн газарт хийсэн үзлэгийн явц үр дүнг бэхжүүлж, цугларсан эд мөрийн баримтуудыг хураан авахдаа бусад үзлэг явуулах нийтлэг журмыг баримтална. Хураан авахад анхаарах асуудлын талаар хураан авах ажиллагаа хэсгээс үзнэ үү.

Илрүүлсэн эд мөрийн баримтыг зөрчил шалгах ажиллагаанд нотлох ач холбогдлыг алдагдуулахгүйн тулд түүний нотолгооны болон адилтгалын онцлог шинжийг хэвээр хадгалан үлдээхээр хамгаалах, бататгах арга технологийн дагуу бэхжүүлнэ. Бэхжүүлэхийн тулд тодорхойлон бичих, схем, план масштаблан үйлдэх, гэрэл зураг, гар зураг үйлдэх, дуу, дүрс бичлэг хийх, хэв цутган авах зэрэг аргыг хэрэглэж болно. Бие биеэс салангид орших эд мөрийн баримтыг тус тусад нь бэхжүүлнэ.

Үзлэгийг гэрэл зургийн аргаар бэхжүүлэх. Хэргийн газрын гэрэл зураг нь хэрэг үйлдэгдсэн орчин, илэрсэн ул мөр, эд зүйлс, зөрчил үйлдэхэд ашигласан зэвсэг хэрэгсэл, агнагдсан амьтны эд эрхтэн, түүний үлдэгдэл, үс яс болон бусад баримтуудын ерөнхий байршил, объект нэг бүрийн онцлогийг харуулсан гэрэл зураг юм.


Зөрчлийн хэргийн газарт баримжаалах, тоймлох, зангилаа, нэг бүрчилсэн, нарийвчилсан хэлбэрээр гэрэл зураг авна.



Баримжаалах гэрэл зураг

Баримжаалах гэрэл зурагт хэрэг үйлдэгдсэн газар орон болон байгалийн тогтоц зэрэг онцлох зүйлсийг харуулсан байна. Баримжаалах зургаас зөрчил үйлдэгдсэн орчин, нөхцөлийн талаар мэдээлэл олж авах, хожим ямар нэгэн шалтгаанаар зөрчил үйлдэгдсэн газрыг эрж олох шаардлага гарвал чиг баримжаа болгоно. Иймд зөрчил үйлдэгдсэн хэргийн газрын орчныг зургийг хэд хэдэн цэгээс авна.


Тойм зураг нь хэрэг үйлдсэн газрыг тоймлон харуулж буй ерөнхий зураг юм. Тойм гэрэл зурагт объектууд харьцангуй ойрын зайнаас дүрслэгдэх тул ач холбогдолтой өндөр цэгүүдэд үсэг болон тоон бичиглэл бүхий таних тэмдэг тавьж авч болно[9].



Тойм зураг

9 Очирбат, Т., Соронзонболд, Ч. (2012). *Хэргийн газрын үзлэг (биет нотлох баримт цуглуулах арга хэрэгсэл)*. Улаанбаатар

Зангилаа гэрэл зургаар хэргийн газрын тодорхой хэсэг, объектуудын харилцан байрлалыг харуулна. Хэргийн газрын хамгийн ач холбогдолтой мэдээлэл агуулсан хэсгийн зураг байна.



Зангилаа зураг

Нэгбүрчилсэн зургаар ул мөр, эд мөрийн баримтын хэлбэр хэмжээ, шинж тэмдгийг харуулдаг тул хэмжих хэрэгсэл ашиглаж харьцуулж авна.




Нэг бүрчилсэн зураг

Нарийвчилсан гэрэл зураг нь эд мөрийн баримт, ул мөр, тэдгээрийн онцлог, тодорхой хэсгийн шинж байдлыг онцлон харуулах зорилгоор томруулан татаж авсан зураг байна.



Нарийвчилсан зураг

Зөрчлийн газрын үзлэгээс гадна, гэмт хэрэг үйлдсэн газрын орон зайг зөв тогтоох өөрөөр хэлбэл, “орон зайн шинж байдлын судалгаа”-г техник хэрэгсэл ашиглан хийх нь чухал ач холбогдолтой юм. Зөрчил үйлдэгдсэн газрын орон зайн шинж байдлыг тодорхойлох нь зөрчил гарсан хэргийн газарт хийх үзлэгтэй нягт холбоотой боловч адилтган үзэж болохгүй. Орон зайн шинж нь тухайн нутгийн байгалийн төлөв, уул хад, гуу жалга, намаг, гол мөрөн, ой шугуй цастай зэрэг физик газар зүйн шинж байдлыг агуулсан ойлголт юм[10]. Хэрэг гарсан газрын орон зайн шинжийг тодорхойлох нь үзлэг явуулах, мөр сурвалжлахад тус дөхөм үзүүлэх, чиг баримжааг тогтоох, таамаг сэжиг дэвшүүлэх, эд мөрийн баримтыг олж илрүүлэх, хэргийн нөхцөл байдлыг тогтооход чухал ач холбогдолтой арга зүйн нэг хэлбэр мөн. Ихэнх алба хаагч нар орон зайн шинжийг хэргийн газарт хийх үзлэгтэй хольж хутгах, нэг зүйл мэт үздэг явдал олонтоо тэдийгүй зөрчил шалгах ажиллагаанд огт ашиглахгүй байгаа нь харамсалтай. Орон зайн шинжийг тодорхойлох нь практик ач холбогдлоор өндөр ч хялбар ажиллагаатай судалгаа юм.



Схем зураг

Эрх бүхий албан тушаалтан өөрийн ажиглалтаар орчны байдлыг тодорхойлж тэмдэглэлд тусгаж, зохих объектууд зөрчил гарсан газарт алслагдсан байдал зэргийг схемээр харуулж, зургийг материалд хавсаргана. Зарим эрх бүхий албан тушаалтан нотлох баримт цуглуулан судлах, эрэн сурвалжлах ажлаас төвөгшөөн бэрхшээх юм уу зөрчлийг зөв таньж мэдээгүйн улмаас “орон зайн шинж байдлын судалгаа”-г хийхгүй орхигдуулж байгаа нь түүний ач холбогдлыг үнэлж чадахгүй, илүүц зүйл гэж боддогтой шууд холбоотой юм.

10 Тодорхой төрлийн зарим гэмт хэргийг мөрдөх аргачлал (Редактор: Т.Дэндэв). (1977). Улаанбаатар. 47 дахь тал.

Бодлого 1

Зөрчил болсон газарт үзлэг хийж, шаардлагатай гэрэл зураг, дүрс бичлэг хийсэн байна. Зөрчил болсон газрын план схем зургийг нэмэлтээр хийх шаардлагатай юу? Хэрэв байгаа бол ямар зорилгоор хэрхэн хийх вэ? Ямар ач холбогдолтой вэ?

Бодлого 2

Хэнтий аймгийн Дархан суманд нутгийн иргэд зохих зөвшөөрөлтэйгөөр цагаан зээр агнах эрхийн бичгийг сумын байгаль хамгаалагчаас авсан боловч эрхийн бичигт заасан хэмжээнээс хэтрүүлэн цагаан зээр агнасан зөрчил үйлдсэн байна. Эрх бүхий албан тушаалтан зөрчил болсон газарт ирж үзлэг хийж, гэрэл зургаар үйл баримтыг баримтжуулжээ. Ингэхдээ нийт хэчнээн кадр зураг, ямар байрлалаас авч хэрэгт хавсаргах шаардлагатай вэ?

Бодит жишээ

Хяналтын байгууллагаас Амьтны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутагт 2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдрөөс 5 дугаар сарын 3-ны өдөр хүртэлх хугацаанд хяналт шалгалтыг явуулжээ.

Хяналт шалгалтаар Мөнгөнморьт сумын Цагаан чулуут нэртэй Хэрлэн голын эрэг дагуух газарт 2019 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр “Ниссан патроль” маркийн хар өнгийн 12-34 УАА улсын дугаартай, тээврийн хэрэгсэлтэй, гурван хүн отоглон буудаллаж байх үед хяналтын шалгалтын багийнхан таарчээ.

Байгаль орчны хяналтын улсын байцаагч Б нь тэдгээр хүмүүстэй уулзаж ямар зорилгоор, хаанаас хаа хүртэл аялж байгаа талаар асууж ярилцахад, Улаанбаатар хотоос гараад найзындаа очиж хэд хоног амрахаар явж байна. Голын дэргэд түр саатаж алжаалаа тайлж байна гэж хариулсан бөгөөд тэд бүгд усны гутал өмссөн, хоёр хүний усны гутал нойтон, тээврийн хэрэгслийн арын тэвшний нөөц дугуйны дээд хэсэгт хүрэн улаан өнгийн толбо үүссэн, мөн машины дэргэд байгаа бор ногоон өнгийн цүнхний цахилгааны хагас татагдсан хэсгээр загасны уургын бариул цухуйж байв.

Байгаль орчны хяналтын улсын байцаагч Б нь та бүхэн загас барьж байгаа юм биш үү гэхэд нэг нь бид загас бариагүй ээ гэж хариулав. Байгаль орчны хяналтын улсын байцаагч Б нь тэдгээр хүмүүс сэжигтэй байна гэж үзээд шалгалтын ажиллагааг явуулжээ.

Тайлбар. Байгаль орчны хяналтын улсын байцаагч Б нь дээрх үйлдэлд Амьтны тухай хууль зөрчих зөрчил үйлдсэн байж болзошгүй сэжиг байгааг таамаглаж, шалгах ажиллагаа хийх шийдвэр гаргажээ.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн Хяналт шалгалт хийх нийтлэг үндэслэл, журмын 5.6 дахь хэсэгт заасны дагуу хяналт шалгалт эхлэхээс өмнө эрх бүхий албан тушаалтан шалгуулах этгээдэд шалгалтын зорилго, бүрэлдэхүүнийг танилцуулж, удирдамж, хяналтын хуудасны нэг хувийг өгөх бөгөөд улсын байцаагч албаны үнэмлэхээ үзүүлнэ. Мөн хуулийн 3[1].1.2-д тодорхойлсон “хяналт шалгалтын арга, хэлбэр”-ийн нэг болох тухайн хяналт шалгалтад хамаарах баримт бичгийг хянан үзэх заалтын дагуу тэдгээр иргэдийг бичиг баримтаа үзүүлэхийг хүсэж, уг хүмүүсийн хэн болохыг тодорхойлох иргэний үнэмлэх болон бусад бичиг баримтыг үзэж шалгана.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.4 дүгээр зүйлийн (1) Эрх бүхий албан тушаалтан (1.1) хуулиар харьяалуулсан зөрчлийг өөрөө илрүүлсэн, (1.5) зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааг хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулах эрх хэмжээний хүрээнд зөрчил шалгах ажиллагааг эхлүүлэн явуулна.

Байгаль орчны хяналтын улсын байцаагч Б тээврийн хэрэгслийн арын тэвшний нөөц дугуйны дээд хэсэгт үүссэн хүрэн улаан өнгийн цус мэт толбо, загасны уургын үзүүр цүнхнээс цухуйж байгаа, тэдгээр хүмүүсийн зорчиж байгаа цаг хугацаа, усны гутал норсон байсан зэрэгт дүгнэлт хийж, Амьтны тухай хууль зөрчих зөрчил үйлдсэн байж болзошгүй гэж үзэж, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар зөрчил үйлдэгдсэн газар, тээврийн хэрэгсэл, эд зүйлд үзлэг хийх, эд зүйл, баримт бичгийг хураан авах, мэдүүлэг авах, шинжилгээнд зориулж хэв загвар, дээж авах зэрэг ажиллагааг хийнэ.

Үзлэг хийх. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.1 дүгээр зүйлд заасан эрх бүхий албан тушаалтан энэ хуульд заасны дагуу зөрчил шалгах ажиллагаа явуулж, нотлох баримт цуглуулж, бэхжүүлнэ, мөн зөрчил үйлдэгдсэн газар, тээврийн хэрэгсэл, эд зүйлд үзлэг хийх гэж заасны дагуу үзлэг хийнэ Үзлэг хийхдээ дараах зүйлсийг анхаарах шаардлагатай. Үүнд:

- Хөндлөнгийн гэрчийг байлцуулах
- Гэрэл зураг, дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлэх техник хэрэгслийг бэлтгэх
- Үзлэг хийх явцад шаардлагатай бол шинжилгээнд зориулж хэв загвар, дээж авах
- Шаардлагатай бол эд хөрөнгө битүүмжлэх, эд зүйл, баримт бичиг хураан авах ажиллагааг хамтад нь явуулах
- Эрх бүхий албан тушаалтны шаардлагаар үзлэг хийлгэхээс татгалзсан, эсэргүүцэл үзүүлсэн бол үзлэгийг албадан гүйцэтгэх
- Шинжилгээнд зориулан авсан хэв загвар, дээж авсан бол түүнийг хадгалах, шилжүүлэх, устгах, тээвэрлэх талаар Засгийн газрын гаргасан журмыг баримтлах
- Шинжилгээнд зориулж хэв загвар, дээж авах ажиллагаанд мэргэжилтнийг оролцуулах зэрэг болно.

Зөрчил үйлдэгдсэн газарт үзлэг хийхэд нотолгооны ач холбогдолтой амьтны сэг зэм, яс, үс, толгой, шийр, арьс, эвэр туурай зэрэг амьтны эд эрхтэн түүнээс гадна, сэжигтэй этгээдийн үлдээсэн ул мөр, сумны хонгио, хутга, тамхины иш зэрэг эд зүйл, хэрэг, зөрчил үйлдэхэд ашигласан зэвсэг хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, морь, тэмээ, тэдгээрийн ул мөр байгаа эсэхийг сайтар нягтлан илрүүлж, бэхжүүлэн авахад онцгой анхаарна. Үзлэгийг хөдөө хээр, хойшлуулшгүй тохиолдолд хийж, дараа нь прокурорт мэдэгдэж, хөндлөнгийн гэрч оролцуулах боломжгүй тохиолдолд дүрс бичлэг, гэрэл зургаар бэхжүүлнэ.

Зөрчил үйлдэгдсэн газарт хийх үзлэгийн тэмдэглэл жишээ загвар

Үзлэгээр илэрсэн зүйл:
Үзлэгийг 2019 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 15 цаг 00 минутад эхлүүлж, тэнгэр цэлмэг, нартай, агаарын дулаан 10 хэм байх үед байгалийн гэрэлд явуулав.

Үзлэг явуулж буй газар нь хөдөө хээр, төв суурин газраас алслагдсан хөндлөнгийн гэрч оролцуулах боломжгүй байсан тул Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн үзлэг хийх 4.3 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт заасны дагуу гэрэл зураг, дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлсэн бөгөөд фото зургийн аппарат, Garmin 64s маркийн GPS байршил тогтоогч багаж, Phantom-4 маркийн нисдэг камер (дрон) ашиглан фото зураг авч, бичлэг хийж, зөрчил шалгах ажиллагааны явцыг бэхжүүлэв.

1. ҮЗЛЭГЭЭР ИЛЭРСЭН НӨХЦӨЛ БАЙДАЛ:
Зөрчлийн үзлэг хийж буй газар нь Төв аймгийн Мөнгөнморьт сумаас ертөнцийн зүгээр зүүн урд зүгт 45 километрт, Хэрлэн гол дагуу бөгөөд зүүн талаараа ой мод бүхий уултай, баруун талаараа задгай талархаг Цагаан чулуут хэмээх нэртэй газар байлаа.

Үзлэг явуулж буй газрын орчин нь Хэрлэн голын ус тохойрсон эрэгтэй, эргэн тойрон бургас, торлог бут, хад чулуутай хэвгийдүү газар бөгөөд нэлэнхийдээ борог өвстэй, хуурай, голын урсац тогтуун байв.

Зөрчил илрүүлсэн газрын голын зүүн эрэгт орших хадархаг уулыг үл хөдлөх цэг болгон авч, орон зайн байршил тогтоогч Garmin 64s маркийн GPS багажаар координатыг тогтооход E46 57 36.51, N101 41 39.45 цэгт байв. Уг хадархаг уулаас үзлэг явуулж буй газар 30 метр зайтай байлаа. Уг газарт ертөнцийн зүгээр хойшоо чиглэлд зогссон “Ниссан патроль” маркийн хар өнгийн 12-34 УАА улсын дугаартай, зүүн гар талын жолооны хүрдтэй, тээврийн хэрэгсэл байна. Уг тээврийн хэрэгслийн баруун хойд дугуйны дэргэд 35х65 см хэмжээтэй бор ногоон өнгийн цүнх байна. Цүнхний амны цахилгаан хагас татагдсан, цүнхний амнаас загасны хар өнгийн уургын хойд хэсэг нь цухуйсан байв.

Тээврийн хэрэгслээс 7 метр зайд гурван чулуу зэрэгцүүлэн тавьж, дунд нь хуурай мөчир жижиглэн гал түлэхээр бэлтгэсэн байв. Уг чулуунаас хойшоо чиглэлд 10 м зайтай газар бургасан дунд бор шаргал өнгийн, 4 м урттай загасны уурга 2 ширхэг түүний дэргэд 5 ширхэг загас байв.

Барьсан загасыг хэмжиж үзэхэд, их бие үзүүрээсээ сүүл хүртэл 50 см урттай өргөн нь 14 см хэмжээтэй 2 загас, 35 см урттай, өргөн нь 10 см хэмжээтэй 3 загас байна. Загасны өнгө дүрс нь ..... өнгө дүрс, амьтны морфологи шинжээр шинэхэн барьсан зэвэг загас байна.

Үзлэгийг тээврийн хэрэгсэлд үргэлжлүүлэн машины үйлдвэрийн тэмдэглэгээг шалгахад, (машины урд копут дотор) NISSAN MOTORS CORPORATION MODEL LA-V73W LRHVQ SHASSIS V73W 0P0185 дугаартай байв. Машины гадна кузов хар өнгөтэй, төмөр цайвар өнгийн ачаатай, машины арын хаалганд нөөц дугуйтай, 12-34 УАА тээврийн хэрэгслийн улсын дугаартай, суудлын жип машин байна. Машины гадна хэсэг нэлэнхийдээ шавар, шороо болсон, гадна талын кузов ямар нэгэн механик эвдрэл, хонхойлт үүсээгүй, баруун урд дугуйны шаврын хаалт хугарч унжсан. Машины дөрвөн дугуйн хээ тод, гэрэлтүүлэх болон дохионы хэрэгсэл, шил арчигч бүрэн ажиллагаатай техникийн хувьд бүрэн бүтэн байна.

Машины арын хаалганы нөөц дугуйн дээр 5х7 см хэмжээтэй хүрэн улаан өнгийн цус мэт зүйлээр бохирлогдсон байв. Уг бохирлогдсон зүйлийг шинжлүүлэх зорилгоор бага зэрэг спирт шингээсэн хөвөнгөөр арчин дээж авч, цаасан дугтуйд хийж амсрын тэмдэг дарж битүүмжлэв.

Машины дотор талд үзлэгийг явуулж жолооч талын хаалгыг нээхэд машины түлхүүр асаалтын үүрэндээ байх бөгөөд түлхүүрийг түлхэн асаахад хэвийн ажиллагаатай асаж байв. Машины арын хаалгыг онгойлгож үзэхэд, багажид бор ногоон өнгийн 3 ширхэг аяны хөнжил, түүний доор ангийн зориулалттай Дробовинк буу 1 ш, бага калибрын Тоз-8 буу 1 ш, Чех калибрь ZKM-452 (дурантай 9 мм) 1 ш тус тус байв. Бууны дэргэд 17 мм дайзтай сум 10 ш, дробовинк бууны цаасан бортоготой сум 3 ш, 5.6х15 мм хэмжээтэй калибрын сум 1 хайрцаг буюу 24 ширхэг байна. Эдгээр галт зэвсгийг эзэмших гэрчилгээг байгаа

эсэхийг тээврийн хэрэгслийн жолооч Д-ээс тодруулахад, бүгд байгаа гээд машины урд талын хайрцгаас 3 ш галт зэвсэг эзэмшигчийн гэрчилгээг гаргаж үзүүлэхэд, Иргэн С овогтой Д гэрчилгээний дугаар 435, ОХУ-д үйлдвэрлэсэн Дробовинк буу № 34556, иргэн С овогтой Д гэрчилгээний дугаар 743 ОХУ-д үйлдвэрлэсэн Тоз-8 калибр № 44456, Иргэн Г овогтой Ш, гэрчилгээний дугаар 956, Чех калибрь ZKM-452 № 67778 дугаартай галт зэвсэг эзэмших гэрчилгээтэй. Гэрчилгээ дээрх дугаар үзлэгээр илэрсэн галт зэвсэг дээрх дугаартай тохирч байна. Галт зэвсгийн эзэмшигч нараар бууны сумны хүхээгт сум байгаа эсэх, аюулгүй байдлыг шалгуулахаар Чех калибрь ZKM-452 № 67778 дугаартай галт зэвсгийн замгийг татахад сумны хүхээгт 1 ширхэг сум байсныг авч аюулгүй болгосны дараа уг буугаар буудлага үйлдэгдсэн эсэхийг шалгах зорилгоор бууны гол төмрийн хошууны амсрыг үнэртэж үзэхэд, дарь үнэртэж байв. Нөгөө хоёр бууны гол төмрийн амсраас дарь үнэртэхгүй байв. Бууг буудлага үйлдэгдсэн эсэхийг тогтоох зорилгоор гол төмрийн амсрыг хөвөнгөөр бөглөж, хураан авлаа.

Мөн багажид 2 цаасан хайрцагтай зүйл байв. Нэг цаасан хайрцгийг нээж үзэхэд, хоол хүнсний зүйлс болох талх, лаазалсан мах, зөөврийн хийн тулга, 5 ширхэг баллонтой хийн газ байна.

Нөгөө хайрцгийн тагийг нээж үзэхэд, хүрэн улаан өнгөтэй, цээж, бөгсөн бие болгон шинэхэн бэлтгэсэн амьтны мах (гадна шинж тэмдгээр ямар амьтны мах гэдэг нь танигдахгүй) байв. Махыг бэлтгэсэн байдал, цээж хэсэгтээ хүрэн улаан өнгийн цус хурж, нөжирсөн, уг хэсэгтээ хавирга хугарсан зэргээс үзэхэд буудаж агнасан байж болзошгүй шинж тэмдэг байна. Уг махны жинг үзэх зорилгоор гар жингээр жигнэж үзэхэд 25 кг болж байв.

Уг хайрцагт 0.5 граммын цэнхэр өнгөтэй “Вояж” гэсэн шошготой усны хуванцар саванд хар хүрэн өнгийн шингэн зүйл дүүртэл нь хийсэн байв. Уг махыг ямар амьтны мах болох, савтай шингэнийг юуны шингэн болох талаар тээврийн хэрэгслийн жолооч Д-ээс асуухад, ямааны мах байгаа юм, савтай шингэн нь яргуй идсэн ямааны цус байгаа гэж хариулав.

Машины баруун хойд дугуйны дэргэд байх 35х65 см хэмжээтэй бор ногоон өнгийн цүнхийг онгойлгож үзэхэд, хар өнгөтэй, 55 см урттай эвхсэн загасны уурга 1 ш, дамартай цагаан өнгийн сатурк 2 ш, жижиг төмөр хайрцагт загасны дэгээнүүд, 28 см урттай төмөр хутга, бор ногоон өнгийн гар чийдэн, 2 ш хуруу зай, 15 см радиустай дугуй хар өнгийн гэрэлтүүлэх хэрэгсэл, 2 м урт цахилгааны залгуур утастай байв.

Үзлэгийн явцыг “Canon EOS600D” маркийн дижитал тоон технологид суурилагдсан, өнгөт фото зургийн аппаратаар баримжаалсан 3, тоймчилсон 5, зангилаа болон нарийвчилсан 17, нийт 25 кадр гэрэл зураг авч, зөрчлийн газрын схем зураг үйлдэж, нисдэг камер (дрон) ашиглаж 5 минутын бичлэг хийж, бэхжүүлсэн болно.

Үзлэгийн явцад илрүүлсэн зүйлс:

- Ангийн зориулалттай Дробовинк буу 1 ширхэг
- Бага калибрын буу Тоз-8 буу 1 ширхэг
- Чех калибр ZKM-452 (дурантай 9 мм) 1 ширхэг
- 17 мм дайзтай сум 10 ширхэг
- Дробовинк бууны цаасан бортоготой сум 3 ширхэг
- 5.6х15 мм хэмжээтэй калибрийн сум 1 хайрцаг буюу 24 ширхэг
- Загасны уурга (хар өнгийн) 5 м урттай 1 ширхэг

- Загасны уурга (бор шаргал өнгийн) 4 м урттай 2 ширхэг нийт 3 ширхэг
- Цагаан өнгийн сатурк 2 ширхэг
- Жижиг төмөр хайрцагт загасны дэгээнүүд
- Төмөр хутга 28 см урттай
- Гэрэлтүүлэх хэрэгсэл 15 см радиустай дугуй (хар өнгийн), (2 м урт цахилгааны залгуур утастай)
- Их бие үзүүрээсээ сүүл хүртэл 50 см урттай өргөн нь 14 см хэмжээтэй 2 загас
- 35 см урттай, өргөн нь 10 см хэмжээтэй 3 загас. Нийт 5 загас.
- Цаасан хайрцагтай 25 кг амьтны мах
- “Вояж” гэсэн бичигтэй цэнхэр өнгийн 0.5 граммын хуванцар савтай хар хүрэн өнгийн шингэн зүйл
- Машины нөөц дугуй дээрх цус мэт хүрэн улаан өнгийн толбоноос хөвөнд шингээн авч цаасан дугтуйд хийж битүүмжлэн шинжилгээнд зориулж авсан дээж 1 ширхэг зэргийг эд мөрийн баримтаар хураан авлаа.

Үзлэгийн тэмдэглэлийг “Toshiba” маркийн зөөврийн компьютер, “Samsung ML1670” маркийн принтер, автомашинаас цахилгаан өсгөгч багаж (инвертер) зэргийг ашиглан хэвлэв.

Үзлэгийн тэмдэглэлийг оролцогчдод уншуулж танилцуулахад, үзлэгийн явцтай холбогдуулж ямар нэгэн санал хүсэлт гаргаагүй тул үзлэгийг 18 цаг 30 минутад дуусгаж, оролцогчдоор гарын үсэг зуруулав.

Тэмдэглэл үйлдсэн: Улсын байцаагч ..... (Ц)

2.5 ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛД ХИЙХ ҮЗЛЭГ, АРГА ТЕХНИК БА АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

2.5.1. Тээврийн хэрэгслийн тухай ойлголт, түүний төрөл

Тээврийн хэрэгсэл нь гэмт хэргийн халдлагын зүйл болохоос гадна, гэмт хэрэг, зөрчил тэр дундаа байгаль орчны эсрэг зөрчил үйлдэхэд ашиглах хэрэгсэл болдог тул зөрчил үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэлд үзлэг хийх нь энэ төрлийн зөрчлийг шалган шийдвэрлэх, нотлох ажиллагаа явуулахад нэн чухал.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлд зааснаар (3.1.1) *“тээврийн хэрэгсэл”* гэж хүн, ачаа, суурилагдсан тоног төхөөрөмжийг замаар тээвэрлэхэд зориулсан хэрэгслийг, (3.1.2) “*механикжсан тээврийн хэрэгсэл”* гэж мопедоос бусад, хөдөлгүүрээр тоноглогдсон тээврийн хэрэгслийг, (3.1.3) *“жолооч”* гэж тээврийн хэрэгсэл жолоодож яваа хүн, жолоодлогын дадлага хийлгэж яваа багш, замаар ердийн хөсөг унаж, хөтөлж яваа хүнийг тус тус ойлгоно.

Харин “ачаа” гэж тээврийн хэрэгслээр зөөж буй овор хэмжээ ихтэй бараа, “тээш” гэж зорчигч биедээ авч явах ойр зуурын хэрэглээний зүйл агуулах сав юм.

Тээврийн хэрэгслийг янз бүрээр ангилсан байдаг. Тухайлбал, *зориулалтаар* нь суудлын (нийтийн болон нэг бүрийн), ачааны, спортын, хөдөө аж ахуйн, уул уурхайн, үйлдвэрийн, барилгын, цэргийн, хамгаалалт, тусгай албаны (банк, эмнэлэг, цагдаа, галын г.м), ердийн хөсөг, унадаг дугуй, мопед, мотоцикль, ахуйн (усны тэрэг, чарга, тэргэнцэр г.м), мөн *явагч хэсгээр* нь өнхөрдөг (дугуйт бүх төрлийн тээврийн хэрэгслүүд), гулсдаг (чарга), гинжит (трактор, экскаватор, танк), холимог (цасны мотоцикл нь гулгагч, гинжит 2 явагч хэсэгтэй байдаг) зэргээр ангилна. Явагч хэсэг гэдэг нь тээврийн хэрэгслийг хөдөлгөөнд оруулахын тулд эргэх, гулсах үйлдэл хийж газартай харьцах эд анги юм.

2.5.2. Тээврийн хэрэгсэлд үзлэг хийх эрх зүйн үндэслэл

Шинэчлэн найруулсан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.3 дугаар зүйлд зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнуудын үзлэг хийх эрх зүйн үндэслэлийг хуульчилсан байна.

Эрх бүхий албан тушаалтан зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг тогтоох зорилгоор үзлэг хийж болох бөгөөд харин орон байранд зөвхөн прокурорын зөвшөөрлөөр үзлэг хийнэ.

Хүний биед хийх үзлэгийг зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.2, 6.3, 6.8, 6.11, 6.13, 6.24, 6.25, 6.62 дахь заалтад заасан эрх бүхий албан тушаалтнууд хийнэ. Харин *байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37) болон улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч (6.27) нарт энэ үндэслэл хамаарахгүй* тул хүний биед үзлэг хийх эрхгүй юм.

Эд зүйл, баримт бичиг, ачаа тээш, мал, амьтан, тээврийн хэрэгсэлд үзлэг хийхэд эзэмшигчийг байлцуулна. Эзэмшигчийг оролцуулах боломжгүй бол хөндлөнгийн гэрчийг байлцуулах, эсхүл гэрэл зураг, дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлж болно. Үзлэг хийх үед хуулиар хориглосон зүйл илэрвэл хураан авч, тэмдэглэлд тусгана.

Мөн үзлэг хийх явцад хүний амь нас, эрүүл мэндэд аюул, орчинд хөнөөл учруулж болзошгүй тэсэрч дэлбэрэх болон химийн хортой бодис, бусад эд зүйл байна гэж үзвэл холбогдох мэргэжилтнийг оролцуулж болно. Түүнчлэн шаардлагатай бол шинжилгээнд зориулж хэв загвар, дээж авах, эд хөрөнгө битүүмжлэх, эд зүйл, баримт бичиг хураан авах ажиллагааг явуулж болно.

Тээврийн хэрэгсэлд үзлэг хийхдээ эзэмшигчээр нь тээврийн хэрэгсэлд ачсан эд зүйлийг нь гаргуулах эсхүл гадна талаас нь харах, гараар тэмтрэх, тусгай багаж ашиглах аргаар хийж болно. Үзлэг хийхэд хугацаа шаардагдах эсхүл бусад үндэслэл байвал эрх бүхий байгууллага дээр хийж болно.

Эрх бүхий албан тушаалтны шаардлагаар үзлэг хийлгэхээс татгалзсан, эсэргүүцэл үзүүлсэн бол үзлэгийг албадан гүйцэтгэнэ.

Тээврийн хэрэгсэлд үзлэг хийх ажиллагаа нь байгаль орчны эсрэг аливаа зөрчлийг нотлох, зөрчлийн нотлох баримт илрүүлэх, цуглуулах аргын нэг юм. Тээврийн хэрэгсэлд үзлэгийг хэрхэн явуулснаас шалтгаалан зөрчлийг хурдан шуурхай шалгах, зөрчил гарсан эсэхийг нотлох чухал баримтуудыг олж, тогтоох боломжтой. Ийм учраас үзлэгийг түргэн шуурхай, чанартай явуулах шаардлагатай.

Байгаль орчны эсрэг зөрчлийг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан зөрчил үйлдэгдсэн байдал, зөрчлийн ул мөр, эд мөрийн баримтыг олох, зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдол бүхий байдлыг тодруулах зорилгоор тээврийн хэрэгсэлд үзлэгийг явуулдаг.

2.5.3. Тээврийн хэрэгсэлд үзлэг хийсэн тэмдэглэл хөтлөх

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.13 дугаар зүйлд заасан журмын дагуу тэмдэглэлд зөрчил шалган шийдвэрлэх тодорхой ажиллагааны явц, дэс дараалал, илэрсэн нөхцөл байдал, авсан арга хэмжээ, үр дүн зэргийг тусгана. Түүнчлэн тээврийн хэрэгсэлд үзлэг хийсэн эрх бүхий албан тушаалтан үзлэг хийсэн тохиолдол бүрт тэмдэглэл хөтлөх шаардлагатай бөгөөд түүнд дараах нийтлэг зүйлсийг тусгана. Үүнд:

- Ажиллагааг явуулсан эрх бүхий албан тушаалтны нэр, албан тушаал
- Ажиллагааг явуулсан газар, эхэлсэн, дууссан он, сар, өдөр, цаг, минут, хэрэгжүүлэх явцад хугацаа тасалдсан бол түүний шалтгаан, хугацаа
- Ажиллагааг прокурорын зөвшөөрлөөр явуулж байгаа бол зөвшөөрлийн дугаар, хүчинтэй хугацаа
- Ажиллагааг хойшлуулшгүй тохиолдолд явуулж байгаа бол үндэслэл бүхий нөхцөл байдлын талаар
- Зөрчил шалгах ажиллагаанд оролцсон хүний эцэг (эх)-ийн болон өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, байршил
- Ажиллагаанд байлцсан бусад хүний хувийн баримт бичиг дэх мэдээлэл
- Ажиллагаанд оролцсон хүнд эрх, үүргийг тайлбарласан тухай
- Оролцогч, гэрчээс санал, хүсэлт гаргасан эсэх, түүнийг хэрхэн шийдвэрлэсэн талаар тусгана.

Тэмдэглэлд эрх бүхий албан тушаалтан, ажиллагаанд оролцсон хүн гарын үсэг зурна. Тэмдэглэл хэд хэдэн хуудастай бол ажиллагаанд оролцсон хүн хуудасны нүүр тус бүрд гарын үсэг зурна. Тэмдэглэлд нэмэлт оруулсан, засвар хийсэн бол ямар засвар, өөрчлөлт хийсэн талаар тусгаж, баталгаажуулна.

Ажиллагаанд оролцсон хүн гарын үсэг зурахаас татгалзсан, эсхүл баталгаажуулах боломжгүй бол шалтгааныг тэмдэглэлд тусгана. Үзлэгийн явцад хийсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, гэрэл зураг, гар зураглал, хэв загварыг тэмдэглэлд хавсаргана.

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцыг дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлж болно.

Тэмдэглэлд зөрчил шалгах ажиллагаанд ашиглаж байгаа техник хэрэгслийн нэр төрөл, үзүүлэлтийг тэмдэглэж, бичлэг хийсэн цаг, минут, авсан гэрэл зургийн тоог тусгана. Дуу-дүрсний бичлэгт тухайн ажиллагааны зорилго, он, сар, өдөр, байршил, эхэлсэн, дууссан цаг, минутыг тодорхой тусгана.

Зөрчил шалгах ажиллагаанд оролцсон хүн хүндэтгэн үзэх шалтгааны улмаас тэмдэглэлд гарын үсэг зурах боломжгүй бол энэ тухай эрх бүхий албан тушаалтан тайлбар бичиж тэмдэглэлд хавсаргана.

2.5.4. Тээврийн хэрэгслийг зогсоож шалгах

Байгаль орчны эсрэг зөрчлийг шалгаж шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан дараах тохиолдолд тээврийн хэрэгслийг зогсоон шалгаж болно. Үүнд:

- Төрийн албаны болон Байгаль орчны тухай хууль тогтоомжийн дагуу төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн хяналт шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлж буй тохиолдолд
- Жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодож яваа байдал нь бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд аюул учруулж болзошгүй тохиолдолд
- Тээврийн хэрэгслийг байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд ашигласан гэх үндэслэлтэй
- Хууль бус, хуулиар хязгаарласан эд зүйл тээвэрлэж байгаа эсхүл хүний амь нас, эрүүл мэндэд шууд хохирол учруулах эд зүйлийг хууль бусаар тээвэрлэн авч яваа гэх үндэслэлтэй
- Эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр тодорхой газар нутаг, бүсэд тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарласан тохиолдол зэрэг болно.

Ингээд эрх бүхий албан тушаатан тээврийн хэрэгслийг зогсоосны дараа доорх бичиг баримтуудыг шалгана. Үүнд:

- Тээврийн хэрэгслийн гэрчилгээ, эзэмшигчийн овог нэр
- Тээврийн хэрэгслийн улсын дугаар, марк, өнгө, бүх жин, даац
- Тээврийн хэрэгслийг үйлдвэрлэсэн, импортлосон он сар өдөр
- Тээврийн хэрэгслийн зориулалт, үзлэг тооллогод орсон байдал зэргийг шалгаж болно.

2.5.5. Тээврийн хэрэгсэл, ачаа тээшинд үзлэг хийх арга тактик ба аюулгүй байдлыг хангах ажиллагаа

Тээврийн хэрэгсэл, ачаа тээшинд үзлэг хийхийн өмнө шалгуулагчаас эрх бүхий албан тушаалтны амь насанд аюултай үйлдэл хийхдээ ашиглаж болзошгүй буу зэвсэг, бусад зүйлийг илрүүлэх зорилгоор халаас, өвөр, өмд, гутлын түрий, ханцуй зэргийг нь ажиглаж сэжигтэй тохиолдолд гарын алга, хуруугаар тэмтэрч шалгана. Энэ нь хүний биед үзлэг хийх ажиллагаа биш аюулгүй ажиллагааны үед хийх ажил гэдгийг ойлгуулна.

Тээврийн хэрэгсэл, эд зүйл, ачаа тээшинд үзлэг хийхэд удаан хугацаа шаардагдах буюу бусад үндэслэл байвал үзлэгийг аль ойрхон цагдаагийн байгууллага (газар, хэлтэс, тасаг, хэсэг, кобаны байр г.м) боломжгүй тохиолдолд ойр байгаа аж ахуйн нэгж, байгууллагын албан тасалгаа, өрөөнд явуулж болно.

Байгаль орчны эсрэг зөрчлийг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан тээврийн хэрэгсэлд үзлэг хийхдээ аюулгүй байдлыг хангаж ажиллах шаардлагатай. Үүнд:

- Тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийг унтрааж бүрэн зогсолт хийсэн байх
- Жолооч, зорчигчийг буулгасан байх
- Үзлэгийг үзэгдэх орчин хязгаарлагдмал юм уу харанхуй нөхцөл байдалд явуулахгүй байх
- Эрх бүхий албан тушаалтан нь иргэд, олон нийтийн дургүйцлийг илт төрүүлхүйц байдлаар үзлэг хийхээс зайлсхийх (хувийн сэдэлт зорилго, хувь хүний үзэл бодлоор албан бус хандлага илэрхийлэхгүй байх г.м)
- Эрх бүхий албан тушаалтан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар тээврийн хэрэгслээр тээвэрлэж буй ачаа тээш нь хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд шууд, эсхүл шууд бусаар хор хохирол учруулж байгаа, эсхүл учруулж болох нөхцөл байдал үүссэн үед холбогдогчийн ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн, эсхүл барилга байгууламж, машин, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалтыг прокурорын зөвшөөрлөөр түр зогсоож болно.
- Эрх бүхий албан тушаалтан хойшлуулшгүй тохиолдолд дээрх арга хэмжээг авч, энэ тухай прокурорт даруй мэдэгдэх бөгөөд прокурор эрх бүхий албан тушаалтны авсан эрх хязгаарлах арга хэмжээг хүчинтэйд тооцох эсэхийг хуулийн дагуу шийдвэрлэнэ.

Тээврийн хэрэгслийн гадна талд үзлэг хийхдээ эвдрэл гэмтэл, гадны ул мөр, шавар шавхай, тоос шороо тогтсон байдал зэргийг сайтар ажиглах хэрэгтэй. Мөн тээврийн хэрэгслийн доод хэсгийг шалгана.

Тээврийн хэрэгслийн дотор хийх үзлэгийг (а) жолооч, зорчигчийн хэсэгт, (б) хөдөлгүүр, явах, дамжуулах анги, бүхээг, тээшний хэсэгт, (в) тухайн тээврийн хэрэгслийн ачаа, тээш, чиргүүлийн хэсэг зэрэг байдлаар 3 хуваан явуулж болно.
Хоёр ба түүнээс дээш эрх бүхий албан тушаалтан нар хяналт шалгалтын үүрэг гүйцэтгэж байгаа үед нэг нь үзлэгийг явуулж, бусад нь аюулгүй байдлыг хангах үүрэгтэй ажиллана.

Үзлэгийг хийхдээ шалгуулагчийн үйлдэл хөдөлгөөнийг болон орчныг анхааралтай ажиглаж хяналтандаа байлгана.

Үзлэг хийсэн тохиолдолд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.13 дугаар зүйлд заасан журмын дагуу үзлэг хийсэн тухай тэмдэглэл үйлдэнэ. Тэмдэглэлд явуулсан ажиллагаа, үзлэгийн явц, илэрсэн болон хурааж авсан, битүүмжилсэн эд зүйл, цаг агаарын нөхцөл, хэрэглэсэн техник хэрэгсэл, лац, эд мөрийн баримт, зөрчлийн хэрэгт ач холбогдол бүхий бусад зүйлийг хэрхэн хадгалсан, шийдвэрлэсэн, эхэлсэн, дууссан цаг хугацаа зэргийг дэс дарааллаар нь нэг бүрчлэн тодорхой бичнэ.

Үзлэг хийхийн өмнө шалгуулагчтай мэндчилж, албаны үг хэллэг хэрэглэн харьцаж үзлэг хийх зорилгоо тайлбарлаж өгнө. Эрх бүхий албан тушаалтны шаардлагыг биелүүлэхгүй эсэргүүцсэн тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлд заасан Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд нь саад учруулсан үндэслэлээр хариуцлага хүлээлгэхийг санууулна.

Эрх бүхий албан тушаалтан тээврийн хэрэгсэлд үзлэг хийж Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.5 дугаар зүйлд зааснаар зөрчлийг шалган тогтоох зорилгоор зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлого, эд зүйл, зөрчил үйлдэхэд ашигласан зэвсэг, хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, уналга, эсхүл зөрчил шалгах ажиллагаанд ач холбогдолтой эд зүйл, баримт бичгийг хураан авна.

Хураан авах ажиллагааг эхлэхийн өмнө хураан авах эд зүйл, баримт бичгийг сайн дураар гаргаж өгөх, зааж өгөх боломжийг тухайн хүн, хуулийн этгээдийн төлөөлөгчид олгоно. Хураан авсан эд зүйлийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.12 дугаар зүйлд заасны дагуу арга хэмжээ авч, шийдвэрлүүлнэ.

Тээврийн хэрэгсэлд үзлэг хийсэн тэмдэглэл жишээ загвар

2024 оны 3 дугаар сарын 06-ны өдөр Дугаар ..... Улаанбаатар хот

Архангай аймгийн Засаг даргын Тамгын газрын геологи, уул уурхайн хяналт, газрын улсын байцаагч Ангар би Архангай аймгийн Хашаат сумын иргэн Батын ..... /гомдол гаргасан хүн, хуулийн этгээд, албан тушаалтны нэр, хаяг, утасны дугаар 88111111 дугаартай, регистр 99999999 дугаартай улсын бүртгэлийн дугаар/-ээс 2024 оны 3 дугаар сарын 06-ны өдөр гаргасан /гомдол, мэдээллийн утга/ гэх зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл, хэрэгтэй танилцаад зөрчил үйлдэгдсэн /эсхүл үйлдэгдсэн байж болзошгүй/

..... Архангай аймгийн Хашаат сум 2-р багийн нутаг дэвсгэрт Засаг даргын Тамгын газрын геологи, уул уурхайн хяналт, газрын улсын байцаагч Ангар би Архангай аймгийн Хашаат сумын нутаг дэвсгэрт хууль бусаар түгээмэл тархацтай ашигт малтмал олборлосон байж болзошгүй үндэслэл байх тул хэргийн нотлох баримтыг олж тогтоох, Зөрчлийн хэрэг, материалд ач холбогдол бүхий байдлыг тодруулах зорилгоор иргэн Доржийн АРХ 99-11 улсын дугаартай KIA маркийн ачааны авто машинд үзлэг хийхээр тогтов ....

АРХ 99-11 улсын дугаартай KIA маркийн ачааны авто машинд үзлэг хийх ажиллагаанд уг тээврийн хэрэгслийн эзэмшигч Архангай аймгийн Хашаат сумын 2-р багт оршин суух 6666666666 регистрийн дугаартай бичиг баримттай, хувираа хөдөлмөр эрхэлдэг Пагам овогтой Доржийг оролцуулж, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 3.1 дүгээр зүйл, хэсэгт заасан оролцогчийн эрх, үүргийг тайлбарлан өгч гарын үсэг зуруулав.

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хөндлөнгийн гэрчээр
1. Цэцэг овогтой Дулмаа Архангай аймгийн Хашаат сумын 2-р багт хаягт оршин суугч, 66666666 регистрийн дугаартай бичиг баримттай,
2. Сайнаа овогтой Дугар Архангай аймгийн Хашаат сумын 2-р багт хаягт оршин суугч, 66666666 регистрийн дугаартай бичиг баримттай нарын оролцуулж Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 3.7 дугаар зүйлд заасан хөндлөнгийн гэрчийн эрх үүргийг тайлбарлаж өгөв.

Үзлэгийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.3 дугаар зүйлийг удирдлага болгон хийв.

Үзлэгийг 2024 оны ..3.... сарын ..6..-ны өдрийн ..14. цаг ..10.. минутад эхлүүлж, тэнгэр цэлмэг, нартай, салхи тогтуун, агаарын дулаан 16 хэм байх үед байгалийн гэрэлд явуулав.

Үзлэгээр илэрсэн тогтоогдсон нөхцөл байдал /дэлгэрэнгүй бичнэ/

1. АРХ 99-11 улсын дугаартай KIA маркийн ачааны авто машины тээшинд үзлэг хийхэд Цагаан өнгийн тааран шуудайтай, шуудайны амыг мяндсан утсаар боосон байсныг онгойлгож үзэхэд, хүрмэн чулуу их хэмжээгээр хийсэн байна.

   Хүрмэн чулууг дэлгэн тарааж үзэхэд, шинэвтэр олборлож түүгээд удаагүй бололтой, нойтон бор шороо наалдсан, шороо нь нойтон байв. Үзлэгээр хүрмэн чулууг бутлуулаагүй байгалийн хэвээр 90 см урттай цагаан өнгийн ямар нэгэн бичиггүй мяндсан уутанд 60 ширхэг савлаж хийсэн байв.

2. Үзлэгээр илсэн 60 шуудай хүрмэн чулууг хураан авч Архангай аймгийн Засаг даргын Тамгын газрын геологи, уул уурхайн хяналт, газрын хашаанд битүүмжилж хадгалахаар тогтов.

   Үзлэг хийх ажиллагааны явцад SONY маркийн гэрэл зургийн аппаратаар 35 кадр зураг авч, баталгаажуулан тэмдэглэлд хавсаргав.

   Ажиллагааны явцад оролцогч Цэцэг овогтой Дулмаа Архангай аймгийн Хашаат сумын 2-р багт хаягт оршин суугч, 66666666 регистрийн дугаартай бичиг баримттай, Сайнаа овогтой Дугар Архангай аймгийн Хашаат сумын 2-р багт хаягт оршин суугч, 66666666 регистрийн дугаартай бичиг баримттай нарт үзлэгийн тэмдэглэлийг танилцуулж, санал хүсэлт байгаа эсэхийг асуухад ямар нэгэн санал, хүсэлт засвар өөрчлөлт байхгүй гэснээр дуусгав.

   Үзлэгийн тэмдэглэлийг оролцогчдод танилцуулахад ....үнэн зөв..... бичигдсэн байна гэв.

ТЭМДЭГЛЭЛ ҮЙЛДСЭН:
ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН:

...../ (гарын үсэг) Ангар...../ (нэр)

ТАНИЛЦСАН:
ХӨНДЛӨНГИЙН ГЭРЧ

...../ (гарын үсэг) Ц.Дулмаа...../ (нэр)

...../ (гарын үсэг) С.Дугар...../ (нэр)

ХОЛБОГДОГЧ:

...../ (гарын үсэг) Д. Дорж...../ (нэр)

2.6 ГАЛТ ЗЭВСЭГТ ХИЙХ ҮЗЛЭГ, АРГА ТЕХНИК БА АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

2.6.1. Галт зэвсгийн тухай ойлголт, түүний зориулалт ба төрөл

Тээврийн хэрэгсэл нь гэмт хэргийн халдлагын зүйл болохоос гадна, гэмт хэрэг, зөрчил тэр

Галт зэвсэг судлал нь криминалистикийн шинжлэх ухааны судлагдахуун бөгөөд галт зэвсгийн бүтэц, буудлага явагдах зүй тогтлыг судалж, галт зэвсгийн мөртэй ажиллах арга зүйг боловсруулдаг мэдлэгийн салбар юм.

Галт зэвсэг гэдэг нь дарины шаталтаас үүссэн өндөр даралтын хүчээр сумны хошуу болон үрэл гол төмрөөс шидэгдэж амьд болон бусад биетийг гэмтээх, хөнөөх, устгах зориулалт бүхий буудлагын хэрэгслийг ойлгоно.

Галт зэвсэгтэй холбоотой зарим нэр томёог Галт зэвсгийн тухай хуульд тайлбарласан байх бөгөөд тэдгээрийг дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

“сум” гэж галт зэвсэгт зориулагдсан хонгио, бялт, дарин цэнэг, хошуу бүгд нэг биет болж угсрагдсан, эсхүл гол төмөрт хийж буудлага үйлдэх зориулалттай бүрдэл хэсгийг,

“байлдааны зориулалттай галт зэвсэг” гэж байлдааны болон тусгай ажиллагаанд ашиглах зэвсэг, галт хэрэгсэл, түүний эд ангийг,

“галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл” гэж галт зэвсгээс бусад хийн буу, хавчаахай болон ан агнах, спорт-сургалт, үзмэр, цуглуулгын зориулалттай хэрэгслийг;

“буудлага үйлдэх байгууламж /тир/” гэж галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслээр спорт-сургалтын дадлага хийх болон энэ хуульд зааснаар ашиглах зориулалтаар тоноглож зассан орчныг,

“хууль сахиулах албаны зориулалттай галт зэвсэг” гэж цагдаа, дотоодын цэрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, авлигатай тэмцэх байгууллага, эсхүл тагнуулын байгууллагын мөрдөн шалгах, төрийн тусгай хамгаалалтын албаны алба хаагчийн эзэмшиж байгаа галт зэвсгийг,

“үйлдвэрийн хийцийг өөрчлөх” гэж галт зэвсгийн гол төмөр, замаг, их бие буюу хайрцаг ангийг өөрчилснийг,

“сумны зүрхэвч” гэж хуяг нэвтлэх чанарыг сайжруулахын тулд тусгай хайлшаар хийж сумны дотор байрлуулсан хэсгийг тус тус ойлгоно.

Галт зэвсгийг зориулалтаар нь дараах байдлаар ангилж болно. Үүнд:

- *Иргэний зориулалттай галт зэвсэг* - ан агнах, буудлагын спорт-сургалтаар хичээллэх, үзмэр, цуглуулгын зорилгоор Монгол Улсын иргэний өмчилж, эзэмшиж байгаа галт зэвсгийг ойлгоно. Ан агнах зорилгоор ашиглах галт зэвсэг нь автоматаар, эсвэл өөрөө цэнэглэгдэх боломжгүй, хүхээгт нь арав, түүнээс цөөн сум орох багтаамжтай, үйлдвэрийн хийцийг нь өөрчлөөгүй галт зэвсэг байх бөгөөд сумны хошуу нь зүрхэвчгүй, нэг эсвэл хэд хэдэн урт гол төмөртэй, сум, үрэл, хорголжоор буудлага үйлддэг байна. Спорт-сургалтын галт зэвсэг нь бага калибрын, богино ба дунд зэргийн гол төмөртэй, цагирган очлууртай сумаар буудлага үйлддэг. Мөн иргэний

галт зэвсэг нь нэг бүрийн хамгаалалтын зориулалттай, бага калибрын, байлдааны ба пластик сум, мэдрэл саатуулагч хийгээр бууддаг эсвэл дуу чимээ гаргагч богино гол төмөртэй байдаг.

- *Харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг* - харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд, байгаль хамгаалагч хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор өмчилж, эзэмшиж байгаа галт зэвсэг юм. Харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг нь автоматаар буудах боломжгүй, сумны хошуу нь зүрхэвчгүй байна.
- *Хууль сахиулах албаны зориулалттай галт зэвсэг* - хууль сахиулах албаны зориулалттай галт зэвсэг, сумны төрлийн жагсаалтыг тусгайлан баталж, улсын хилээр оруулна.
- *Байлдааны галт зэвсэг* - үйлдвэрийн аргаар хийгдсэн, олон цэнэглэгддэг, бянт бүхий нэг гол төмөртэй, гулсдаг замагтай, сумаар буудлага үйлддэг.
- *Тусгай галт зэвсэг* - хадаас хадагч, дохио өгөгч, гэрэлт сумаар буудагч зэргээр тусгай зориулалтаар ашигладаг.
- *Гэмт хэргийн (зориуд бэлтгэсэн) галт зэвсэг* - гэмт хэрэг үйлдэхэд тохиромжтой болгон загвар, хийцийг өөрчилсөн галт зэвсэг. Төрлөөр нь винтовка, карабин, пистолет, ружьё, штуцер, автомат, пистолет, пульмёт, револьвер гэж хуваана. Гол төмрийн уртаар нь богино (20 см), дунд зэрэг (20-50 см), урт (50 см дээш) гол төмөртэй гэж ангилна.

Хүснэгт 2.1. *Галтын зэвсгийн төрөл*

Тоз-8	Винтов	Ругер	Автомат калибрь	Марлен
Тоз-78	Дробовик	Сауэр	Блайзер	Томпсон
Тоз-99	Винчестер	Аншютц	Мазалат	Маузер
Savage	Armalite	Армед	Shristensen SHR	Маузер винтов
Лось	Оп-СКС	Бекас	Герман калибрь KKV 1001	Макаров ТТ
Тигр	Карабин	Браунинг	Файнберкбай	Револьюр наган
CZ-550	Вепрь	МЦ 21	Арсенал	Венелли
CZ-527	Моссвер	Застава	Ремингтон	Вальтер
Урал	Марго	Маурик	Севюргин	Марголин
Сайга	Зобровка	Медведь	Чех калибрь ZKM-452	НК-2000
Иж	Emerald	Тикка	Hatsan Escort	Барс
Ege	Tgf	Lazer Zoni		

Галт зэвсгийн сумны хэмжээ				
17 mm	5.56	5.6	7.62x25	7.62x39
5.6x10	5.6x15	5.6x39	7.62x51	7.62x54
7.62x63	7.62	7.64	8.2	9
12x70	12x76	16 mm	зэрэг хэмжээтэй сумыг хэрэглэж байна.	

2.6.2. Галт зэвсэгт үзлэг хийх эрх зүйн үндэслэл

Үзлэг хийх ажиллагаа нь аливаа зөрчлийг нотлох, зөрчлийн нотлох баримт илрүүлэх, цуглуулах аргын нэг юм. Үзлэгийг хэрхэн явуулснаас шалтгаалан зөрчлийг хурдан шуурхай шалгах, зөрчил гарсан эсэхийг нотлох чухал баримтууд олдох боломжтой. Тиймээс үзлэгийг түргэн шуурхай, чанартай явуулах шаардлагатай.

Эрх бүхий албан тушаалтан зөрчил үйлдэгдсэн байдал, зөрчлийн ул мөр, эд мөрийн баримтыг олох, зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдол бүхий байдлыг тодруулах зорилгоор зөрчил үйлдэгдсэн газар буюу бусад газар, эд зүйл, баримт бичигт үзлэгийг явуулдаг.

Шинэчлэн найруулсан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.3 дугаар зүйлд зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнуудын үзлэг хийх эрх зүйн үндэслэлийг хуульчилсан байна.

Эрх бүхий албан тушаалтан зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг тогтоох зорилгоор үзлэг хийж болох бөгөөд харин орон байранд зөвхөн прокурорын зөвшөөрлөөр үзлэг хийнэ.

Хүний биед хийх үзлэгийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.2, 6.3, 6.8, 6.11, 6.13, 6.24, 6.25, 6.62 дахь заалтад заасан эрх бүхий албан тушаалтнууд хийнэ. Харин *байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37) болон улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч (6.27) нарт энэ үндэслэл хамаарахгүй* тул хүний биед үзлэг хийх эрхгүй юм.

Эд зүйл (галт зэвсэг), баримт бичиг, ачаа тээш, мал, амьтан, тээврийн хэрэгсэлд үзлэг хийхэд эзэмшигчийг байлцуулна. Эзэмшигчийг оролцуулах боломжгүй бол хөндлөнгийн гэрчийг байлцуулах, эсхүл гэрэл зураг, дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлж болно. Үзлэг хийх үед хуулиар хориглосон зүйл илэрвэл хураан авч, тэмдэглэлд тусгана.

Мөн үзлэг хийх явцад хүний амь нас, эрүүл мэндэд аюул, орчинд хөнөөл учруулж болзошгүй тэсэрч дэлбэрэх болон химийн хортой бодис, бусад эд зүйл байна гэж үзвэл холбогдох мэргэжилтнийг оролцуулж болно. Түүнчлэн шаардлагатай бол шинжилгээнд зориулж хэв загвар, дээж авах, эд хөрөнгө битүүмжлэх, эд зүйл, баримт бичиг хураан авах ажиллагааг явуулж болно.

Эрх бүхий албан тушаалтны шаардлагаар үзлэг хийлгэхээс татгалзсан, эсэргүүцэл үзүүлсэн бол үзлэгийг албадан гүйцэтгэнэ.

2.6.3. Галт зэвсэг илрүүлвэл анхаарах зүйлс

Байгаль орчин, амьтныг хамгаалах журмын эсрэг зөрчлийн хэргийн газарт галт зэвсэг илрүүлвэл дараах зүйлд анхаарал хандуулна. Үүнд:

- Галт зэвсгийн байрлал (отог, майхан, буудлага хийсэн газар орчны зүйлээс баримжаална)
- Галт зэвсгийн төрөл, марк, хийц, систем, төлөв (галт зэвсэг урт, богино, ангийн, байлдааны ямар зориулалттай, хаанахын ямар фирмийн, ямар загвар, хийцийн буу болох, хаана ямар байдалтай байгаа, бууны ам хаашаа чиглэсэн байгаа, гох, замаг, хоолойд сумтай эсэхийг мэдээлэх хэрэгсэл зэргийн байрлалыг түүнд хүрэлгүйгээр, байгаа байдлаар нь бэхжүүлнэ)

- Галт зэвсэг дээр үнэрийн, гарын болон бичил мөр, гадны биетийн үлдэц, бохирдол бий эсэх. Энэ хүртлэх үзлэгийг галт зэвсэгт хүрэлгүйгээр хийх бөгөөд хүрэхээс өмнө зориулалтын бээлий өмсөж, хямсааны тусламжтайгаар үнэрийн мөрийг соруулах болон нэвчүүлэх аргаар тусгаарлан авна.
- Шалгасны дараа галт зэвсгийн эд ангиудад байгаа тэмдэг, дугаар, бүрэн, бүтэн эсэх, харилцан ажиллагаа зэргийг шалгана.
- Уг галт зэвсгийн давтагдашгүйг заасан бусад шинж бий эсэхийг тогтоож, цэнэгтэй бол түүнийг авч, гал хамгаалагч дээр тавин гол төмрийн сувгийн хоёр талыг хурц үнэргүй цэвэрхэн зүйлээр бөглөж, битүүмжлэн Шүүхийн шинжилгээний хэлтэст шинжилгээнд явуулахад бэлтгэнэ.

Мөн түүнчлэн энэ төрлийн зөрчлийг шалгах ажиллагааны үед эрх бүхий албан тушаалтан галт зэвсэг илрүүлсэн бол дараах ул мөр үүссэн эсэхийг сайтар шалгана. Үүнд:

- *Сумны хонгион дээр* - дайзны мөр, хүхээгний мөр, шөвөг төмрийн мөр, хонгио хаягч хумсны мөр, тортог, хөө, дутуу шатсан дарь бий эсэх
- *Сумны хушуун дээр* - хонгионы амсрын бичил зураасан мөр, бянтны анхдагч мөр, бянтны хоёрдогч мөр, тортог, хөө, дутуу шатсан дарь үлдсэн эсэх
- *Галт зэвсэгт өртсөн байн дээр* - гэмтэл, шарх, тулгаж буудсан үед штанцмарк, тортог, хөө, дутуу шатсан тортог бий эсэх
- *Буудагчийн гар, мөр, хүзүү, цээжин дээр* - тортог, хөө, дутуу шатсан дарь ул мөр бий эсэх

Буудлагын улмаас үүссэн дээрх мөрүүдэд оношлол, адилтгал хийснээр галт зэвсэг ашиглан үйлдсэн байгаль орчны эсрэг зөрчил, гэмт хэргийг илрүүлж, нотолдог.

2.6.4. Галт зэвсэгт үзлэг хийсэн тэмдэглэл хөтлөх

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.13 дугаар зүйлд заасан журмын дагуу эрх бүхий албан тушаалтан үзлэг хийсэн тохиолдол бүрт тэмдэглэл хөтлөх шаардлагатай бөгөөд түүнд дараах нийтлэг зүйлсийг тусгана. Үүнд:

- Ажиллагааг явуулсан эрх бүхий албан тушаалтны нэр, албан тушаал
- Ажиллагааг явуулсан газар, эхэлсэн, дууссан он, сар, өдөр, цаг, минут, хэрэгжүүлэх явцад хугацаа тасалдсан бол түүний шалтгаан, хугацаа
- Ажиллагааг прокурорын зөвшөөрлөөр явуулж байгаа бол зөвшөөрлийн дугаар, хүчинтэй хугацаа
- Ажиллагааг хойшлуулшгүй тохиолдолд явуулж байгаа бол үндэслэл бүхий нөхцөл байдлын талаар
- Зөрчил шалгах ажиллагаанд оролцсон хүний эцэг (эх)-ийн болон өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, байршил
- Ажиллагаанд байлцсан бусад хүний хувийн баримт бичиг дэх мэдээлэл
- Ажиллагаанд оролцсон хүнд эрх, үүргийг тайлбарласан тухай
- Оролцогч, гэрчээс санал, хүсэлт гаргасан эсэх, түүнийг хэрхэн шийдвэрлэсэн талаар тусгана.

Тэмдэглэлд эрх бүхий албан тушаалтан, ажиллагаанд оролцсон хүн гарын үсэг зурна. Тэмдэглэл хэд хэдэн хуудастай бол ажиллагаанд оролцсон хүн хуудасны нүүр тус бүрд гарын үсэг зурна. Тэмдэглэлд нэмэлт оруулсан, засвар хийсэн бол ямар засвар, өөрчлөлт хийсэн талаар тусгаж, баталгаажуулна.

Ажиллагаанд оролцсон хүн гарын үсэг зурахаас татгалзсан, эсхүл баталгаажуулах боломжгүй бол шалтгааныг тэмдэглэлд тусгана. Үзлэгийн явцад хийсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, гэрэл зураг, гар зураглал, хэв загварыг тэмдэглэлд хавсаргана.

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцыг дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлж болно.

Тэмдэглэлд зөрчил шалгах ажиллагаанд ашиглаж байгаа техник хэрэгслийн нэр төрөл, үзүүлэлтийг тэмдэглэж, бичлэг хийсэн цаг, минут, авсан гэрэл зургийн тоог тусгана. Дуу-дүрсний бичлэгт тухайн ажиллагааны зорилго, он, сар, өдөр, байршил, эхэлсэн, дууссан цаг, минутыг тодорхой тусгана.

Зөрчил шалгах ажиллагаанд оролцсон хүн хүндэтгэн үзэх шалтгааны улмаас тэмдэглэлд гарын үсэг зурах боломжгүй бол энэ тухай эрх бүхий албан тушаалтан тайлбар бичиж тэмдэглэлд хавсаргана.

2.6.5. Галт зэвсэг бүхий сэжигтэй этгээдийг шалгах ажиллагаа

Байгаль орчин, амьтныг хамгаалах журмын эсрэг зөрчлийг шалгах эрх бүхий албан тушаалтан галт зэвсэг бүхий сэжигтэй этгээдийг галт зэвсэгтэй холбоотой дараах шалгах ажиллагааг явуулна. Үүнд:

а. Галт зэвсгийн гэрчилгээнд дараах зүйлс тусгасан эсэхийг шалгана. Үүнд:

- Өмчлөгч иргэний овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, иргэний бүртгэлийн дугаар, оршин суугаа газрын хаяг, хуулийн этгээдийн тухайд оноосон нэр, улсын бүртгэлийн дугаар, үйл ажиллагааны чиглэл, оршин байгаа газрын хаяг
- Галт зэвсгийн нэр, төрөл, үйлдвэрлэсэн он, дугаар
- Галт зэвсэг өмчлөх зориулалт
- Галт зэвсгийн гол төмрийн голчийн хэмжээ
- Галт зэвсгийн сумны төрөл, зориулалт
- Галт зэвсгийн гэрчилгээн дээрх түүний цээж зураг мөн эсэх, зэрэг дээр тэмдэг дарж, хамтран эзэмших этгээдийн эцэг /эх/-ийн нэрийг баталгаажуулсан эсэхийг шалгана.

б. Галт зэвсгийг хамтран эзэмших этгээд нь Галт зэвгийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах. Үүнд:

- Монгол Улсын иргэн байх
- 21 нас хүрсэн байх
- Иргэний эрх зүйн бүрэн чадамжтай сэтгэцийн өвчингүй хэрэг хариуцах чадвартай байх
- Галт зэвсэг ашиглаж гэмт хэрэг санаатай үйлдэж байгаагүй
- Галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан эсэх
- Иргэн иргэний зориулалттай галт зэвсэг мөн эсэх.

в. Галт зэвсгийг тээвэрлэх. Галт зэвсэг өмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа иргэн галт зэвсгийн гох, эсхүл замгийг цоожилж, сумыг тусад нь түгжээтэй шүүгээ (сав)-нд хадгалах ба галт зэвсгээс замгийг салгах боломжтой бол замгийг салгаж хадгалсан эсэх, мөн галт зэвсэг өмчлөгч хуулийн этгээд галт зэвсгийг зориулалтын төхөөрөмжилсөн өрөөнд, сумыг тусад нь түгжээтэй шүүгээ (сав)-нд хадгалж буй эсхийг шалгана.

2.6.6. Галт зэвсгийн аюулгүй ажиллагаа ба шалгах арга, техник


Зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтан галт зэвсгийн аюулгүй ажиллагааг дараах дэс дараалаар шалгана. Үүнд:

- Галт зэвсгийн хоолойд болон хүхээгт сум байгаа эсэх, хэрэв реольвер бол аль үүрэндээ сумтай болох
- Галт зэвсэг дээр элдэв мөр буй эсэхийг эд ангиудад хүрэлгүйгээр хийх бөгөөд үзлэг хийхээр хүрэхдээ хамгийн түрүүнд хоолойд сумтай эсэхийг шалгана.
- Хүхээгийг салгаж, дараа нь замгийг хойш болгоомжтойгоор тултал татна.
- Хэрэв хоолойд сумтай байгаа бол энэ үед сугаран доош унаж, буудсан хонгио байгаа бол хаягчийн цонхоор хойш шидэгдэнэ.
- Үүний дараа гол төмрийн сувгийн байгаа төлөв (цэвэр, бохир, ямар нэгэн үнэр байгаа эсэх г.м)-ийг тогтоож ам болон хүхээг орчимд дарины үнэр бий эсэхийг магадлан тэмдэглэлд тусгана.
- Бууны ам болон хүхээг орчимд дарины үнэр байвал бууны амыг хурц үнэргүй даавуун эдлэлээр бөглөж хамгаалан галт зэвсгийн шилжилгээ хийлгэхэд бэлтгэнэ.

Бууг шалгахдаа аюулгүй байдлыг хангаж, бууг гадна байдлаас нь харахдаа цоожлогч нь цоожилсон эсэхийг эхэлж үзнэ. Хэрвээ цоожлогч (гал хамгаалагч) цоожлогдоогүй байвал бууны цоожлогчийг буулгаад буу магазинтай бол буунаас магазиныг салгана. Дараа нь бууны хүхээгт сум байгаа эсэхийг шалгахын тулд цоожлогчийг нээж, замгийг татаж үзнэ. Ингэж татаж үзэх үедээ бууны гол төмрийн амыг ямагт дээш нь хүн амьтан байхгүй чигт чиглүүлэн барина.

Бууны чавх, цохигч сойгдсон байвал санамсаргүй байдлаар буулгахгүй байхыг анхаарна. Бууг унагах, юманд цохиж доргиохгүй байхад анхаарна. Бууг аюулгүй болгосны дараа үзлэгийг явуулна.

Төрөл бүрийн галт зэвсгийн буудлага үйлдэх зарчим, сум магазин, цоожлогчийн талаар зохих мэдлэгтэй байх шаардлагатай. Хэрвээ огт үзэж хараагүй буу байвал бууны эзэмшигчээр бууг аюулгүй болгох арга хэмжээг авах хэрэгтэй.



Галт зэвсэгт үзлэг хийхдээ бууны калибрь марк, төрлийг тогтооно. Улмаар бууны гол төмөр, замаг, замгийн рам дээр байгаа дугаар тэмдэглэгээ, үйлдвэрийн газрын тэмдэг, бусад нэмж бичсэн зүйлсийг нарийн үзэж, тэмдэглэлд тусгана. Бууны хэлбэр дүрсийг хэсэгчилсэн буюу нарийвчилсан гэрэл зургаар бэхжүүлж, эд ангийг хэмжинэ. Дээр дурдсанчлан галт зэвсгийн зөвшөөрөл гэрчилгээг юуны өмнө шалгах нь зүйтэй.

Буунд гадна үзлэг хийсний дараа нарийвчилсан лабораторийн шинжилгээнд хүргүүлэхээр зөөвөрлөхдөө бууны гол төмрийн амнаас дарины угаар үнэртэж байвал цэвэр даавуу, цаасаар бөглөх таглах, гарын мөр илэрч болзошгүй хэсгийг хамгаалж тусгай хайрцагт хийх, хайрцаг байхгүй тохиолдолд зөөлөн даавуугаар ороож битүүмжлэн зөөвөрлөнө. Уут, хайрцаг саван дээр хэзээ хаана ямар хэргийн холбогдолтой зэрэг мэдээллийг бичнэ.

Галт зэвсгийн шинжилгээ хийлгэх шинжээчид тавих асуулт. Галт зэвсгээр үйлдэгдсэн байгаль орчны эсрэг зөрчлийг шалгах, нотлох ажиллагаа явуулахдаа тухайн галт зэвсгийг хураан авч, Шүүхийн шинжилгээний хэлтэст галт зэвсгийн шинжилгээ хийлгэж болно.

Галт зэвсгийн шинжээчид дараах асуултыг тавьж, дүгнэлт гаргуулна. Үүнд:

- Төхөөрөмж нь галт зэвсэг мөн эсэх?
- Ямар марк, моделийн галт зэвсэг болох?
- Ямар зориулалтын, ямар калибрын сум хэрэглэдэг болох?
- Галт зэвсэгт бүтээцийн өөрчлөлт хийсэн эсэх?
- Галт зэвсгээр буудлага үйлдэж болох эсэх?
- Галт зэвсэг бүрэн ажиллагаатай эсэх?
- Галт зэвсгээр буудлага үйлдсэн эсэх?
- Гох дээр дараагүй үед доргилтоос буудлага үйлдэх эсэх?
- Сүүлчийн цэвэрлэгээ хийснээс хойш хэдэн удаа буудсан байна вэ? гэх мэтчилэн байж болно.

Ингэснээр буудлага үйлдсэн эсэх, мөн байгаль орчны эсрэг зөрчил үйлдэхдээ ашигласан эсэхийг тогтоох зэрэг ач холбогдолтой юм.

Эрх бүхий албан тушаалтан галт зэвсэгт үзлэг хийж Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.5 дугаар зүйлд зааснаар зөрчлийг шалган тогтоох зорилгоор зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлого, эд зүйл, зөрчил үйлдэхэд ашигласан зэвсэг, хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, уналга, эсхүл зөрчил шалгах ажиллагаанд ач холбогдолтой эд зүйл, баримт бичгийг хураан авна.

Хураан авах ажиллагааг эхлэхийн өмнө хураан авах эд зүйл, баримт бичгийг сайн дураар гаргаж өгөх, зааж өгөх боломжийг тухайн хүн, хуулийн этгээдийн төлөөлөгчид олгоно. Хураан авсан эд зүйлийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.12 дугаар зүйлд заасны дагуу арга хэмжээ авч, шийдвэрлүүлнэ.

ШИНЖЭЭЧ ТОМИЛЖ, ШИНЖИЛГЭЭ ХИЙЛГЭХ ТУХАЙ ТОГТООЛ

Дугаар 12

2024 оны 7 дугаар сарын 24-ний өдөр Түнэл сум

Хөвсгөл аймгийн Түнэл сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч Бат би, 2024 оны 7 дугаар сарын 21-ний өдөр Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийн .7.6... дугаар зүйлийн 3.. дахь хэсэгт зааснаар зөрчлийн хэрэг нээсэн “М” ХХК-ийн захирал Доржид холбогдох 20808123 дугаартай хэрэгт шалган шийдвэрлэх ажиллагаа явуулаад

ОЛСОН нь:
“М” ХХК нь Хөвсгөл аймгийн Түнэл сумын нутгаас зэрлэг гахайн 2 бодгалийг агнах зөвшөөрөл авч холбогдох төлбөрийг төлж, гэрээг байгуулсан боловч 2024 оны 7 дугаар сарын 18-ны өдөр Хайрхан гэх газарт агнуур хийхдээ гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн 4 ойн зэрлэг гахайг агнасан хэрэгт хураагдсан буугаар ан агнагдсан эсэх (ямар нөхцөл байдлыг тогтоолгох шаардлагатай байгаа талаар тодорхой бичих)-ийг мэргэжлийн шинжээчийн тусламжтайгаар тогтоох шаардлагатай байх тул Монгол Улсын Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.11 дүгээр зүйлийг удирдлага болгон

ТОГТООХ нь:
1. Энэ хэрэгт шинжилгээ хийлгэхээр Шүүхийн шинжилгээний ерөнхий газрын галт зэвсгийн шинжилгээний хэсэгт (шинжилгээ хийх байгууллага, шинжээчийн нэр) шинжээчээр томилсугай.

2. Шинжээчид үнэлгээ хийлгэхээр дараах асуултыг тавихаар тогтсугай.

1… Шинжилгээнд хүргүүлсэн ТОЗ 8 маркийн 123456 дугаарын гол төмөртэй ангийн зориулалттай буугаар буудлага үйлдэж болох уу? Хэрэв болох бол шинээр буудлага үйлдэгдсэн эсэх?

2... Гэрээнд зааснаас илүү агнагдсан 5 ширхэг ойн зэрлэг гахайн биеэс олдсон 3 ширхэг сумны хошуунд бууны гол төмрийн мөр үүссэн эсэх?

3. ТОЗ 8 маркийн 123456 дугаарын гол төмөртэй ангийн зориулалттай буугаар дээрх 6 ширхэг сумны хошуу буудагдсан эсэхийг харьцуулан шинжлэх?

3. Шинжилгээг 2024 оны 8 дугаар сарын 04-ний өдрийн дотор гаргахыг шинжээч .....-д даалгасугай.

4. Шинжээч.....-ний мэдэлд ТОЗ-8 маркийн 123456 дугаарын гол төмөртэй ангийн зориулалттай буу 1 ширхэг (хэргийн хавтас, хуудасны тоо болон шилжүүлж байгаа эд зүйл, хэв, хэлбэр, дээж)-ийг шилжүүлсүгэй.

5. Шинжээчид Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.2 дугаар зүйлд заасан эрх, үүргийг тайлбарлан өгч, зориуд худал дүгнэлт гаргах, дүгнэлт гаргахаас хууль бусаар татгалзсан, зайлсхийсэн, дүгнэлт гаргах хугацааг шинжээч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хэтрүүлсэн бол Эрүүгийн хуулийн 21.4 дүгээр зүйл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг сануулсугай.

6. Энэ тогтоолыг хохирогч, холбогдогч нарт танилцуулж Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 3.1, 3.2, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 8.2 дугаар зүйлд заасан эрхийг тайлбарласугай.

ТОГТООЛ ҮЙЛДСЭН: БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ УЛСЫН БАЙЦААГЧ
АЛБАН ТУШААЛТАН:

/.....БАТ...../
/гарын үсэг/ /нэр/

ТАНИЛЦСАН:

/...../ /...../
/гарын үсэг/ /нэр/

ТОГТООЛД ЗААСАН ЭРХ, ҮҮРЭГТЭЙ
ТАНИЛЦСАН ШИНЖЭЭЧ:

/...../ /...../
/гарын үсэг/ /нэр/

2.7 ЭД МӨРИЙН БАРИМТАД ХИЙХ ҮЗЛЭГ, АРГА ТЕХНИК

Өмнөх хичээлээрээ үзлэгийн талаар ойлголттой болсон, ялангуяа зөрчил үйлдэгдсэн газар оронд үзлэг хэрхэн хийх талаар үзсэн бол энэ удаагийн хичээлээр эд зүйлсэд үзлэг хэрхэн хийх талаар үзнэ.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.1 дүгээр зүйлд заасан зөрчил шалгах ажиллагаа нь “Зөрчил үйлдэгдсэн газар, хүн, хуулийн этгээдийн эзэмшил газар, барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, хүний бие, эд зүйлд үзлэг хийх, баримт бичиг, мэдээлэл гаргуулан авах, эд зүйл, баримт бичгийг хураан авах, эд хөрөнгийг битүүмжлэх, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, мэдүүлэг авах, шинжилгээнд зориулж хэв загвар, дээж авах, шинжилгээ хийлгэх ажиллагаанаас бүрдэнэ” гэдгийг сэргээн саная.

Байгаль орчны холбоотой зөрчлийг үйлдэхэд тээврийн хэрэгсэлийг ашиглаж үйлдэх тохиолдол нэлээд элбэг байдаг. Тухайлбал, Амьтны тухай хууль зөрчих зөрчил, Ойн тухай хууль, Усны тухай хууль, Байгалийн ургамлын тухай хууль гэх мэт зөрчлийг үйлдэхэд тээврийн хэрэгслийг өргөнөөр ашигладаг. Тийм учраас тээврийн хэрэгсэлд хийх үзлэгийг сайн хийх хэрэгтэй.

Үзлэг хийх ажиллагааны талаар Амьтны тухай хууль зөрчих зөрчлийн жишээ дээр тайлбарлан ярья. Жишээлбэл, Амьтны тухай хууль зөрчих зөрчлийг үйлдэхдээ ихэвчлэн тээврийн хэрэгсэл ашигладаг бөгөөд эргүүл, шалгалтыг хулгайн гэх тодотголтой замуудад явуулж, авто машины хөдөлгөөнд хяналт тогтоож, сэжигтэй тээврийн хэрэгслийг шалгах шаардлагатай.

Хяналт шалгалтыг явуулж байгаа байгаль хамгаалагчид тактикийн шинжтэй зарим зүйлийг анхаарах хэрэгтэй. Тухайлбал, хөдөлгөөнд оролцож байгаа бүх автомашиныг шалгахаасаа илүү хот суурин газрын зүгт чиглэсэн, гадна байдлаараа тоос шороо, шавар шавхай болсон, бартаа саад туулах чадвартай, бидний хэлдгээр “жип” машин ан хийсэн байж болох сэжиглэл өндөртэй.

Тээврийн хэрэгсэлд үзлэг хийхдээ жолооч болон зорчигчдоос аль зүгт, ямар зорилгоор явж байгааг тодруулах, зорчигч, жолооч нарыг өөр хооронд нь цохилдуулан асуух зэргээр ярилцах хэрэгтэй. Тээврийн хэрэгсэлд үзлэг хийхэд цусны толбо, амьтны үс, үнэр зэрэг бичил ул мөрийг нягт нямбай сайтар үзэх, машины гадна талын байдлыг нягтлан харах, хэрвээ галт зэвсэг авч яваа бол түүний гэрчилгээ, бичиг баримтыг үзэх шаардлагатай.






Авто машины тээшний хэсэг, зорчигчдын авч яваа эд юмсыг үзэж шалгахдаа зорчигчдын бие, хувцас, авч яваа эд зүйл, автомашины гадна болон дотор хэсэгт амьтны цусны толбо, үс, хялгас наалдсан эсэхийг сайтар ажиглах. Хэрвээ ан амьтан агнасан бол гарал үүслийн тодорхойлолтыг үзэх. Хууль бусаар ан агнах гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд эд мөрийн баримт нь онцгой чухал үүрэгтэй байдаг.

Зөрчлийн хэргийн эд мөрийн баримтад гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг, хэрэгсэл, ан амьтны эд, эрхтэн, бусад зүйлс, түүнчлэн гэмт үйлдлийн замаар олсон мөнгө, үнэ бүхий зүйл, баримт бичиг болон зөрчлийн хэргийг илрүүлэх, хэргийн бодит байдлыг тогтооход ач холбогдол бүхий бусад эд зүйлсийг тооцно.

Амьтны эд эрхтнийг янзалж, төхөөрсөн болон бэлтгэсэн газарт үзлэг хийхэд ангийн арьс үсийг цэвэрлэх вандан, өлгүүр мод, мохоо хутга, арьс цэвэрлэсэн газарт өөх тос махны тасархай хэсэг, шар мах, үс ноосны хэсэг байж болно. Вандан дээр цовдлон хатаасан хадаасны нүх гардгийг анхаарах хэрэгтэй.



Галт зэвсэгт үзлэг хийхдээ аюулгүй байдлыг хангаж, бууг гадна байдлаас нь харахдаа цоожлогч нь цоожилсон эсэхийг эхэлж үзнэ. Хэрвээ цоожлогч (гал хамгаалагч) цоожлогдоогүй байвал бууны цоожлогчийг буулгаад буу магазинтай бол буунаас магазиныг салгана. Дараа нь бууны хүхээгт сум байгаа эсэхийг шалгахын тулд цоожлогчийг нээж, замгийг татаж үзнэ. Ингэж татаж үзэх үедээ бууны гол төмрийн амыг ямагт дээш нь хүн амьтан байхгүй чигт чиглүүлэн барина. Бууны чавх, цохигч сойгдсон байвал санамсаргүй байдлаар буулгахгүй байхыг анхаарна. Бууг аюулгүй болгосны дараа үзлэгийг явуулна. Төрөл бүрийн галт зэвсгийн буудлага үйлдэх зарчим, сум магазин, цоожлогчийн талаар зохих мэдлэгтэй байх шаардлагатай. Хэрвээ огт үзэж хараагүй буу байвал бууны эзэмшигчээр бууг аюулгүй болгох арга хэмжээг авах хэрэгтэй.

Галт зэвсэгт үзлэг хийхдээ бууны калибр марк, төрлийг тогтооно. Улмаар бууны гол төмөр, замаг, замгийн рам дээр байгаа дугаар тэмдэглэгээ, үйлдвэрийн газрын тэмдэг, бусад нэмж бичсэн зүйлийг нарийн үзэж тэмдэглэлд тусгана. Бууны хэлбэр дүрсийг хэсэгчилсэн буюу нарийвчилсан гэрэл зургаар бэхжүүлж, эд ангийг хэмжинэ. Галт зэвсгийн зөвшөөрөл гэрчилгээг юуны өмнө шалгах нь зүйтэй.

Буунд гадна үзлэг хийсний дараа нарийвчилсан лабораторийн шинжилгээнд хүргүүлэхээр зөөвөрлөхдөө бууны гол төмрийн амнаас дарийн угаар үнэртэж байвал цэвэр даавуу, цаасаар бөглөж таглах, гарын мөр илэрч болзошгүй хэсгийг хамгаалж тусгай хайрцагт хийх, хайрцаг байхгүй тохиолдолд зөөлөн даавуугаар ороож битүүмжлэн зөөвөрлөнө. Уут, хайрцаг саван дээр хэзээ хаана ямар хэргийн холбогдолтой зэрэг мэдээллийг бичнэ.

2.7.1. Нотлох баримтыг бэхжүүлэх

Зөрчлийн хэргийг нотлох ажиллагааны чухал үе шатны нэг нь эд мөрийн баримт (амьтны эд эрхтэн, арьс г.м)-ыг бэхжүүлэх ажиллагаа юм. Бэхжүүлэх ажиллагаанд эд мөрийн баримтын онцлог шинжийг тэмдэглэлд зөв, тодорхой, бүрэн тусгана.

Эд мөрийн баримтын шинж, онцлогийг тэмдэглэлд бүрэн тусгах шаардлагатай. Үзлэгийн тэмдэглэлд аливаа баримтыг зөв, тодорхой дүрслэхийн тулд амьтны морфологи шинжийн талаар мэдлэгтэй байх ёстой. Жишээлбэл, амьтны арьсанд үзлэг хийх бол амьтны арьсыг үсэн бүрхүүлийн тархац, хөрсний зузаан, нимгэн зэрэг шинж чанар байдлын онцлогоос хамааруулж нуруу, хэвлий хэсэг гэсэн 2 үндсэн хэсэгт хувааж, түүнчлэн хоншоор, дух, хүзүү, сэрвээ, хоолой, хажуу дал, өгзөг, хонго, цавь зэрэг нэлээд хэдэн хэсэгт ангилна.

Амьтны эд эрхтэн байвал түүний гадна морфологи шинж болох эвэр, туурай, амьтны хөл, гуяа, яс, мах зэргийн шинж байдлыг харж тодорхойлж бичнэ. Ингэхдээ амьтны эд эрхтнийг таних гарын авлага ашиглаж болно.

Хууль бусаар ан агнах гэмт хэрэгт эд мөрийн баримтаар хураасан болон хураан авах амьтны эд эрхтнийг ерөнхий шинжээр нь буюу нүдэн баримжаагаар таньж мэддэг байх хэрэгтэй.

Махыг харж танихдаа аливаа амьтны махыг нямбай үзэж, өнгө, үнэр, ясны анатомийн онцлогт анхаарал хандуулна. Махны өнгө, булчингийн ширхэг, үнэр зэргээр ямар амьтны мах болохыг энгийн ажиглалтын аргаар мэдэж болно. Тухайлбал, хандгайн мах хөхөвтөр туяатай, улаан хүрэн өнгөтэй, хатуу холбогч эдийн судлууд сайн хөгжсөн, булчингийн эдүүдийн хооронд өөх бараг байхгүй байдаг бол үхрийн мах цайвар улаанаас хүрэн улаан өнгөтэй, адууны мах улаан хүрэн өнгөтэй, агаарт улам барайж, хөхөвтөр туяатай хар хүрэн өнгөтэй болох ба буцалгахад хөөс буй болно. Бугын мах хар бараан өнгөтэй бүдүүн ширхэгтэй, харин цаа бугын мах түүний наснаас хамаарч цайвар ягаанаас хүрэн улаан хүртэл өнгөтэй, нарийн ширхэгтэй байдаг. Туулайн мах цайвар ягаан өнгөтэй, зөөлөн нарийн ширхэгтэй. Нохойн мах хар хүрэн өнгөтэй, нохойн ноосны өвөрмөц үнэртэй.

Амьтны ясны анатомийн бүтцээр махыг таньж болох ба бүтэн гулууз болон тал буюу өрөөл махаар мал, амьтны зүйлийг тодорхойлж болно. Хонь ямааны гулуузыг чоно нохойноос ялгахын тулд нохойны эхний хос хавирга зууван маягтай холбогдож, хавирга нь ерөнхийдөө нарийхан дугараг, харцага нь 7 нугаламтай, хажуугийн сэртэнгүүд нь нарийн бөгөөд доош, урагш чиглэлтэй. Өвчүүний яс нь нарийн, шаант нь хоёр хэсэг яснаас тогтоно. Харин хонины хавирга хурц өнцгөөр холбогдох ба хавирга нь нэлээд хавтгай, харцаганы нугалам нь 6 бөгөөд хажуугийн сэртэнгүүд нохойноос өргөн. Хажуу тийш чиглэлтэй. Өвчүүний яс нь өргөн. Шаант ганц яснаас тогтно. Хандгай 13 хос хавиргатай. Хавирга нь бөөрөнхий хавчиг, бие биедээ ойрхон байрлаж, хавирганы толгой урт, бараг 3 тал хэлбэртэй. Өвчүүний үзүүр нь бараг 2 дахин өргөн. Чөмөг яснуудын хөндийд ялтас ба утаслагаас тогтсон ясны тор үгүй.

Мөн амьтны эрхтний анатомийн бүтцээр ямар мал, амьтны мах болохыг тодорхойлж болно. Тухайлбал, хандгайн хэл урт, нарийхан үзүүр нь дугараг, дээд талдаа гүвгэр хэсгүүдтэй. Гахайн хэл урт, нарийхан гүвгэр байхгүй. Нохой, чонын хэл өргөн, хавтгай хурц, улаан өнгөтэй, гадаргуу нь хилэн шиг зөөлөн нөсөөгүй байдаг. Хандгайн бөөр хэлтэнцэргүй, шош маягийн зууван хэлбэртэй, дэлүү нь хавтгай зузаан.

Янз бүрийн мал, амьтны махыг өөхөөр нь ялгаж болох ба мал, амьтны өөх нь хайлах температур, өнгө, үнэрээрээ өөр өөр байна. Өөхний хайлах температур химийн бүтцээс

хамаарна. Өөхөнд хүчил хэдий чинээ их байвал хайлах температур төдий чинээ их байна. Бага температурт хайлдаг өөхөнд олейны хүчил, стеорины хүчил бага байна. Амьтны өөхний өнгө нь тэжээлийн найрлага, өөхөн доторх липохром гэдэг нөсөөнөөс ихээхэн хамаарна. Адууны өөх ихэвчлэн шаравтар өнгөтэй, 15-16^{0}С-т зөөлөрч, хайлах температур 18-39^{0}С-т хэлбэлзэнэ. Хонины өөх хатуу цагаан өнгөтэй, хайлах температур 42-52^{0}С. Нохойн өөх тасалгааны температурт зөөлөрч адууны өөхтэй ойролцоо хайлна. Гахайн өөх цагаан 28-48^{0}С-т хайлна. Цаа бугын өөх цагаан хатуу нягт 51-52^{0}С-т хайлна.

2.7.2. Биологийн гаралтай эд зүйлийг хураан авах ажиллагаа

Эд мөрийн баримт (биологийн гаралтай)-ыг хураан авах тэмдэглэл үйлдэхдээ тухайн эд зүйлд хийсэн үзлэгийн тэмдэглэлийг үндэслэн эд мөрийн баримтын шинж байдлыг мөн нарийн тодорхойлон бичнэ.

Хураан авах ажиллагааны дараа нотлох баримтыг зохих журмаар хадгалах асуудал маш чухлаар тавигддаг. Эрх бүхий албан тушаалтан нотлох баримтыг үрэгдэх, гэмтэх, солигдох, устгагдах нөхцөл үүсгэхгүй байх шаардлагыг хангах ёстой.

Энэ төрлийн хэрэг зөрчилд амьд амьтан хэргийн баримт болох тохиолдол цөөнгүй тохиолдоно. Амьд амьтан тухайн хэргийг нотлох хөдөлшгүй баримт мөн. Хууль бусаар ан агнах, барих гэмт хэрэгт зохих зөвшөөрөлгүйгээр нэн ховор, ховор амьтан, тэдгээрийн үр төлийг амьдаар нь барьж тэжээх, гаршуулах худалдан борлуулж буй хэргүүд олон бий. Тэдгээр амьтныг эд мөрийн баримтаар хураан авах, хадгалах, буцаан тавих ажиллагаа нь бусад гэмт хэргийн эд мөрийн баримт түүнийг хураан авах, хадгалах арга зүйгээс ялгагдах онцлогуудтай.

Амьд амьтан хураан авсан хэргийн баримтуудаас дурдвал, 2007 онд нийслэлийн Чингэлтэй дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “Амирита” нэртэй бар цэнгээний газарт зохих зөвшөөрөлгүйгээр хүрэн баавгайн бамбарууш тэжээсэн, Нарантуул худалдааны захад мөн хүрэн баавгайн бамбарууш худалдсан, Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны нутагт айлын хашаанд шонхор шувууг олноор нь барьж гадаадын иргэдэд худалдахаар агуулж, түүнд өгөөш болгох зорилгоор их хэмжээгээр тагтаа барьж тэжээж байсан, тусгай хамгаалалттай газар нутгаас тарвага барьж өөр газарт нутагшуулах нэрээр зохих зөвшөөрөлгүй барьж торон саванд хадгалсан зэрэг хэргүүд шалгагдан шийдвэрлэгджээ.

Хууль бусаар барьсан амьтан нь амьд байгаа тохиолдолд амьтныг хэрхэх тухай шийдвэрийг яаралтай гаргана. Тухайн хэргийг илрүүлсэн даруйд амьтныг байгальд нь буцаан тавих боломжтой, орчин нөхцөл нь тохирсон бол шууд тавих шаардлагатай. Энэ үед эд мөрийн баримт болох амьтныг гэрэл зураг, дүрс бичлэг, тэмдэглэлээр бэхжүүлнэ. Амьтныг байгальд нь буцаан тавиҳдаа тухайн газар нь амьтны амьдрах чадварт нөлөөлөх эсэхийг тооцоолж, хот суурин газраас хол, хүн малын хөлөөс зайдуу газрыг сонгон авна[11]. Байгальд нь зэрлэг амьтныг эргүүлэн тавьж байгаа тохиолдолд албан хаагчийн аюулгүй байдлыг хангахад анхаарна.

11 Амьтныг байгальд эргүүлэн тавиҳдаа амьтанд тохирох идэш тэжээлгүй, хоргодох хэвтэх бартаа саадгүй газарт болон бие даах чадваргүй нялх төлийг байгальд шууд тавьснаар үхэх аюултай, мөн олон тооны амьтныг нэг дор зэрэг тавихад өөр хоорондоо сөргөлдөөн үүсэх зэрэг байдлыг харгалзах хэрэгтэй. Жишээ дурдвал, “Амирита” бааранд хууль бусаар баавгай тэжээж байсныг хураан авч циркэд түр хугацаагаар хадгалуулсан. Энэ үед Нарантуул захад 2 сар ч хүрээгүй баавгайн бамбарууш худалдаж байсан хууль бус үйлдлийг илрүүлж, мөн хураан авсан. Тэдгээр хураасан амьтдыг байгальд нь эргүүлэн тавих комиссын шийдвэрийн дагуу ойд буцаан тавиҳдаа баавгайг бамбаруушаас нь тусад нь өөр газарт тавьсан. Учир нь том нь багаа барьж идэх аюултайг харгалзан үзсэн болно.

Амьтан бүр өөр өөрийн өвөрмөц зан авиртай бөгөөд дайрах, хазах, мөргөх, түлхэх, өшиглөх зэрэг үйлдлүүд гаргаж болзошгүйг санаж байх шаардлагатай. Аливаа амьтныг байгальд буцаан тавих ажиллагаанд боломжтой бол мэргэжилтнийг оролцуулж, тэдний зөвлөгөөг авч хаана хэрхэн яаж тавих, оролцох хүн, тээврийн хэрэгсэл, бусад багаж хэрэгсэл зэргийг урьдчилан сайтар төлөвлөж, уг ажиллагааг мэргэжлийн хүмүүсээр гүйцэтгүүлж, харин албан хаагчид тэдгээрийн үйл ажиллагааг баримтжуулбал зохимжтой. Хэрвээ буцаан тавих боломжгүй бол тухайн амьтныг хадгалах тохиромжтой байр сав, зөөж тээвэрлэх тээврийн хэрэгслийг бэлтгэнэ.

Энэ үед амьтныг хангалттай хооллох хэрэгтэй. Амьтныг зөөж тээвэрлэхдээ түүний айдсыг намжаахын тулд аль болох юмаар бүтээх, нарнаас хол байлгаж ус өгч, дуу чимээнээс хол байлгана. Дуу чимээ болон хүмүүс түүнийг стресст оруулах, шархдах үхэх эрсдэлийг нэмэгдүүлнэ. Амьтад наршсанаас үхэх аюултай. Амьтанд ус хоолноос ч илүү чухал байдаг.



Хураасан амьтныг зориулалтын торонд оруулсан байгаа нь

Амьтныг зөөж тээвэрлэх үедээ хаана байрлуулах талаар ямар нэгэн шийдвэр гаргасан байх ёстой. Учир нь хууль хяналтын байгууллагад амьд амьтан хадгалах зориулалтын байр байхгүй тул амьтны хүрээлэн, цирк, хувираа амьтан тэжээдэг хүмүүс зэргийг сонгон авч урьдчилан тохирох, зохих зөвшөөрлийг авсан байх шаардлагатай. Амьтдыг зөөж тээвэрлэх үеийн үйл ажиллагааг гэрэл зураг, видео бичлэгээр баримтжуулна.

2.7.3. Биологийн гаралтай эд эрхтэн, зүйлсийг хадгалах

Хууль бусаар ан агнах гэмт хэрэгт биологийн гаралтай эд мөрийн баримт нь хураан авах, хадгалах тусгай горим, арга ажиллагааг шаарддаг. Баримтыг хураан авч бэхжүүлэх, чанар байдлыг алдагдуулахгүй хадгалах нь нотлох ажиллагааны нэг элемент төдийгүй нотлох ажиллагааны зорилтыг хангах чухал хэрэглүүр юм. Хэргийн газраас болон мөрдөн байцаалтын үзлэгээр илрүүлсэн эд мөрийн баримт болох амьтны эд эрхтнийг хураан авахдаа эд эрхтэн тус бүрийг уут саванд хийж, битүүмжлэн дугаарлаж хаягжуулна.

Биологийн гаралтай эд эрхтнийг зөвхөн цаасан уутанд хийж, аль болох нар тусахгүй, халаах хэрэгсэл, хорхой шавжаас хол тавьж сэрүүн газарт хадгална. Эд мөрийн баримтыг гялгар уутанд хийж хэрхэвч болохгүй, муудах аюултай. Амархан муудах цус, бусад эд эрхтнийг хөргөгч, хөлдөөгчид яаралтай хадгална. Ийм учраас хууль хяналтын байгууллага нь эд мөрийн баримт хадгалдаг газартаа хөргөгч, хөлдөөгч заавал байх шаардлагатай.

Аливаа үслэг эдийг хадгалахад агуулах хэрэгтэй. Эд мөрийн баримтаар хурааж ирсэн ангийн үс, арьсыг хүлээн авахдаа тэдгээрийг төрөлжүүлэн ялгах, баглах, хүлээн авсан үеийн анхны чанар байдлыг алдагдуулахгүйн тулд норж гэмтэх, хортон шавжаас хамгаалах, ариутгал цэвэрлэгээ хийх, чанарын хамгаалалт, хаягжуулалт хийнэ.

Агуулах байрны температур, агаарын харьцангуй чийг ялгаатай байх шаардлагатай. Тухайлбал, хатааж чанар байдлыг хамгаалсан арьсанд агаарын чийг 50-60%, давсалж хатаасан арьсанд 60-65%, нойтон давсалсан арьсанд 75-80% тус тус байх нь зохимжтой. Агаарын температур хатаасан арьсанд +15-20°С, нойтон давсалсан арьсанд 8-12°С тус тус байна. Арьс хадгалах агуулахыг тавиур, вандан, өлгүүр, тасалгаатай шүүгээ, хэц зэргээр тоноглосон байна. Үнэг, хярс, мануул, шилүүс зэрэг амьтдын арьсыг нүд хамрын нүхээр нь холбон агуулахын хана туурганаас хөндий хэц, тусгай өлгүүрт өлгөнө. Усны булга, булга, суусар, солонгын арьсыг хайрцаг тавиурт, хэрмийн арьсыг нүдний нүхээр нь холбон баглаж, багцлан хадгална. Жирх, зурмын арьсыг 50-100 ширхгээр нь багцалж тавиур дээр хураах буюу хайрцагт хадгална. Гэмт хэргийн статистик баримтаас үзэхэд, улсын хилээр хууль бусаар гаргах гэж байгаад баригдсан 8,000 ш хэрмийн арьс, 2,500 ш үнэгний арьс зэрэг эд мөрийн баримтыг хадгалах хамгаалах шаардлага зүй ёсоор гарч байсан.

Үзлэгт анхаарах өөр нэг асуудал бол үзлэгийн явц үр дүнг бэхжүүлэх явдал юм. Үзлэгийг хийхдээ иргэний амь нас, эрүүл мэндэд аюултай эсвэл тэдний нэр төрийг гутаах, хүнлэг бус аргаар хандах, хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх, тулган шаардах, хуурч мэхлэх зэрэг хууль бус аргыг хэрэглэж хэрхэвч болохгүй.

Хураан авах ажиллагаа нь ямар нэгэн таамаглалд тулгуурлан явуулах учиргүй заавал бодит болон хууль зүйн үндэслэлтэй хэрэгжүүлдэг тодорхой ажиллагаа юм.

Хураан авах нь хуульд заасан журмаар авагдсан нотлох баримтын аль нэг эх сурвалжид хэрэг, зөрчилд ач холбогдол бүхий эд зүйл, бичиг баримт, тодорхой газар, тодорхой этгээд байна гэх хангалттай мэдээлэл мөн. Хэрэгт ач холбогдолтой эд зүйл, бичиг баримт байна гэж дотоод итгэлээрээ үнэлж, түүнийг эзэмшигчээс хуульд заасан үндэслэл журмын дагуу шаардан албадан гаргуулж буй явдлаар илэрч буй ажиллагаа юм.

2.8 ШИНЖИЛГЭЭ ХИЙЛГЭХ АЖИЛЛАГАА

Зөрчил шалгах тодорхой ажиллагааны нэг хэсэг нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.11 дүгээр зүйлд заасан шинжилгээ хийлгэх явдал юм.

Эрх бүхий албан тушаалтан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу зөрчил шалгах ажиллагаа явуулж, нотлох баримт цуглуулж, бэхжүүлнэ. Үүний дагуу шинжилгээнд зориулж хэв загвар, дээж авах, шинжилгээ хийлгэх ажиллагаа нь зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны тодорхой нэг хэсэг болно.

Эрх бүхий албан тушаалтанд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд прокурорын зөвшөөрлөөр явуулахаар заасснаас бусад ажиллагааг явуулах шийдвэрийг бие даан гаргахаар эрх хэмжээ нь хуульчлагдсан байдаг.

Эрх бүхий албан тушаалтан нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу хүн, эд зүйл, баримт бичиг, ургамал, мал амьтанд шинжилгээ хийлгэнэ. Мөн гэрч, хохирогч, холбогдогч зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдол бүхий байдлыг бодитой тусгаж, зөв мэдүүлэг өгөх чадвартай эсэхэд эргэлзээ төрвөл сэтгэцийн байдлыг тодорхойлох, холбогдогчийг донтох сэтгэцийн эмгэгтэй эсэхийг тогтоох шаардлагатай бол, эсвэл холбогдогчийн насыг гэрчлэх баримт бичиг байхгүй бөгөөд түүний насыг тогтоох нь зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдолтой бол, хүний биед гэмтэл учирсан эсэхийг тогтоох шаардлагатай бол хүнд холбогдуулан шинжилгээ хийж болно. Ингэхдээ эрх бүхий албан тушаалтан дээрх ажиллагаа явуулах саналыг уг ажиллагааг явуулахаас өмнө прокурорт хүргүүлнэ.

Хичээлийн энэ сэдвээр зөвхөн зөрчлийн хэрэгт хамаарах эд зүйл, баримт бичиг, ургамал, мал амьтанд шинжилгээ хийлгэх талаар үзнэ.

Шинжилгээ хийлгэхээс өмнө бид Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.10 дугаар зүйлд заасан шинжилгээнд зориулж хэв загвар, дээж авах талаар товч авч үзье. Шинжилгээнд зориулж хэв загвар, дээж авах явц нь шинжилгээний нэг өвөрмөц хэлбэр боловч процессын журмын онцлог талаасаа зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны нэг бие даасан төрөл болдог.

Зөрчил үйлдэгдсэн газар, орчинд хэргийн ул мөр ямар нэг хэмжээнд хадгалагдаж үлдсэн байдаг. Энэхүү ул мөрийг бэхжүүлэх, улмаар хэрэгт холбогдох нотолгооны эд зүйлс, баримт сэлтийг олж илрүүлэхэд уг ажиллагаа маш чухал.

Харьцуулан шинжлэхээр хэв, хэлбэр авах гэдэг нь зөрчилд холбогдогч, гэрч, хохирогчоос шаардлагатай ул мөрийг техник хэрэгсэл ашиглан бэхжүүлэн авсныг зэрэгцүүлэн-жиших замаар шинжлэн тогтооход чиглэгдсэн ажиллагаа юм.

Шаардлагатай ул мөр гэдэгт тухайн холбогдох этгээдийн хуруувны хээ, үсний үлдэц, хөл, гутлын мөрний дардас, гарын үсэг, шүлс, хумс, шүдний хэв, үнэр, алганы дардас, мөрний хэв болон бусад мал, амьтан, эд зүйлийг харьцуулах зэрэг шинжилгээний объект, түүнд тусгагдсан бүхий л зүйлс хамаарна.

Харьцуулан шинжлэхээр хэв, хэлбэр авах ажиллагаа нь шинжилгээтэй нэгэн адил тусгай мэдлэг, нарийн мэргэжил шаарддаг утгаараа мэргэжилтний оролцоотой хийгддэг.

Харьцуулан шинжлэхээр хэв, хэлбэр авах ажиллагаа нь хүний халдашгүй эрхийг хөндөж буй нэг хэлбэр төдийгүй зарим тохиолдолд энэ нь албадлагын шинжтэй байдаг тул түүнийг явуулахад хөндлөнгийн гэрч заавал байлцуулах шаардлагатай. Харьцуулан шинжлэхээр хэв, хэлбэр авах талаар Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд дараах байдлаар тусгагдсан байна. Тус хуулийн 4.10 дугаар зүйлийн 1-д шинжилгээ хийх зорилгоор хүн, эд зүйл, баримт бичиг, ургамал, мал амьтнаас хэв загвар, дээж авч болно, мөн 2-т шинжилгээнд зориулж хэв загвар, дээж авах ажиллагаанд мэргэжилтнийг оролцуулж болно хэмээн заасан байдаг.

Шинжилгээнд зориулж хүн, эд зүйл, баримт бичиг, ургамал, мал амьтнаас хэв загвар, дээж авах авахдаа хүний эрхийг дээдлэх, аюулгүй байдлыг хангах, шинжилгээний обьектын шаардлагыг хангахуйц байдлаар бэхжүүлж авах шаардлагатай юм.

Зөрчил шалган шийдвэрлэх явцад шинжилгээ хийх зорилгоор хүн, эд зүйл, баримт бичиг, ургамал, мал амьтнаас харьцуулахаар авсан хэв загвар, дээжийг зөв зохистой хадгалах, тээвэрлэх асуудалд онцгойлон анхаарах шаардлагатай. Учир нь энэ харьцуулагдах хэв загвар, дээж нь гэмтэх, хадгалах стандарт шаардлага хангахгүйгээс харьцуулах боломжгүй болох эсвэл шинж чанар нь алдагдах зэрэг асуудал үүсэж болзошгүй ба үүнээс шалтгаалан үнэн зөв дүгнэлт гаргах нь эргэлзээтэй болно.

Тийм ч учраас Засгийн газрын 2019 оны 267 дугаар тогтоолоор “Шинжилгээнд зориулан авсан хэв загвар, дээжийн хадгалалт, тээвэрлэлтийн горим”[12]-ыг баталсан байдаг бөгөөд түүнийг баримтлан ажиллана.

Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан зөрчил шалган шийдвэрлэх явцад шинжилгээнд зориулан хүн, эд зүйл, баримт бичиг, ургамал, мал амьтнаас авсан хэв загвар, дээжийн хадгалалт, хамгаалалтыг бүрэн хариуцна.

Хэв загвар, дээжийг хадгалах байр, өрөө нь биоаюулгүй байдал, биохамгааллын шаардлагыг хангасан орчинтой байх бөгөөд тусгай бэхэлгээ бүхий хамгаалалттай хаалга, цонхтой, ус, чийг, шороо, тоос нэвтрэхгүй, агааржуулалт, гэрэлтүүлэг сайтай, зориулалтын тоног төхөөрөмжтэй, халаалт, хөргөлтийн системтэй, байнгын дохиолол, камерын хяналт, харуул хамгаалалттай байна. Уг байр, өрөөнд галын аюулгүй байдлыг хангаж, тогтоосон стандарт, дүрэм журмыг мөрдөж ажиллана.

Хэв загвар, дээжийн хаягжуулалт (дагалдах хуудас)-д байгууллагын нэр, огноо, зөрчлийн хэргийн дугаар, холбогдогчийн нэр, зөрчлийн хэрэг бүртгэлт явуулсан эрх бүхий албан тушаалтны нэр, албан тушаалыг тодорхой тусгаж, гарын үсэг, баталгааны тэмдэг хэрэглэж, зөрчлийн хэрэг нээсэн хуулийн заалт, хэзээ, хаанаас бэхжүүлэн хураан авсан зэргийг тодорхой бичнэ. Хэв загвар, дээжийг хадгалах сав, баглаа боодол нь стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан “Цаасан уут”, “Сав баглаа боодол”, “Нийлэг хальсан уут”-ны стандартыг хангасан байна.

Түргэн муудах, эмзэг бараа бүтээгдэхүүн, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, биологийн гаралтай дээж, тэсэрч дэлбэрэх, ууршиж дэгдэх бодис, цацраг идэвхт материал, цацрагийн үүсгүүр, хүний амь нас, эрүүл мэнд, орчин тойронд аюул учруулж болзошгүй галт хэрэгсэл, амархан дөл авалцдаг болон шатамхай шингэн зэргийг стандарт горимын дагуу хадгална. Тиймээс энэ бүх стандарт гормийг мэддэг байх шаардлагатай болно.

- Биологийн гаралтай хэв загвар, дээж болох хатаасан цусыг тасалгааны температурт, цус цусан бүтээгдэхүүн, үрийн шингэн, шүлс, шээс, өтгөн, ходоодны агууламж

12 Засгийн газрын 2019 оны 267 дугаар тогтоолоор баталсан “Шинжилгээнд зориулан авсан хэв загвар, дээжийн хадгалалт, тээвэрлэлтийн горим https://legalinfo.mn/mn/detail?lawId=14573

(амьтны), яс (амьтны) зориулалтын хөргөгчид, үс хумс, эд, эс зэрэг бусад зүйлийг зориулалтын цаасан хайрцаг эсхүл шилэн саванд,
- Түргэн гэмтэх, хадгалалтын онцгой нөхцөл шаардагдах бараа бүтээгдэхүүн, сорьц, үржүүлгийн бүтээгдэхүүний онцлогт тохирсон хэмийг хангаж зориулалтын сав, төхөөрөмж, хөргөгч, хөлдөөгчинд, галт зэвсгийг хадгалахдаа замаг, хүхээ болон галт зэвсгийг хамтад нь нийлэг уутанд хийн битүүмжилж, зориулалтын шүүгээ, саванд,
- Цацрагийн үүсгүүрийн 1-5 дугаар ангилалд хамаарах цацраг идэвхт материал, цацрагийн үүсгүүрийг мэргэжлийн байгууллагад хадгалуулах, хяналтаас чөлөөлөгдөх түвшний цацраг идэвхт материал, цацрагийн үүсгүүрийг тусгай саванд хийж, бусад хэв загвар, дээжээс тусад нь байрлуулах,
- Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, химийн хорт болон аюултай бодис, түүний хаягдлаас авсан хэв загвар, дээжийг мэргэжлийн байгууллагад,
- Амархан дөл авалцдаг болон шатамхай шингэний дээжийг шатдаггүй материалаар хийсэн, галын аюулгүй ажиллагааны шаардлага хангасан хайрцаг, шүүгээнд,
- Цахим төхөөрөмж, тоон ул мөрийг хадгалахад зориулалтын сүлжээ унагагч, радио долгионоос хамгаалсан уут, саванд,
- Зам тээврийн осол зөрчилтэй холбоотой тээврийн хэрэгслийг эвдрэл гэмтлийн анхны байдал, хэв загвар, дээжийн шинж байдлыг алдагдуулахгүйгээр гадна орчны нөлөөлөл (цас, бороо, нар, салхи, шороо, тоос, чийг г.м)-өөс хамгаалж бүрэн хучиж хадгалах зэргээр горим стандартыг баримтлана.

Харин хэв загвар, дээжийг шинжилгээ хийлгэх, хадгалах, хамгаалах зорилгоор тээвэрлэх шаардлага гардаг. Ингэж тээвэрлэхдээ мөн зохих горим дэглэм журмыг баримтална. Үүнд:

- Хэв загвар, дээжийг тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь гадна орчны нөлөөлөл (цас, бороо, нар, салхи, шороо, тоос, чийг г.м)-өөс хамгаалагдсан, холбогдох стандарт, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан байна.
- Түргэн муудах, эмзэг бүтээгдэхүүн, хадгалалтын онцгой нөхцөл шаардагдах биологийн дээж, сорьц, үржүүлгийн бүтээгдэхүүний дээжийг хөргөх, хөлдөөх болон халуун, хүйтний хэм, чийгийн тохируулга бүхий тусгай тоног төхөөрөмжөөр тоноглогдсон зориулалтын тээврийн хэрэгслээр зөөвөрлөнө.
- Зориулалтын тээврийн хэрэгсэлгүй тохиолдолд термометр бүхий мөстэй сав эсхүл зөөврийн зориулалтын сав, төхөөрөмж, хөргөгчийг ашиглан шинжилгээ хийх эрх бүхий байгууллагад хүргэнэ.
- Эрх бүхий албан тушаалтан нь хэв загвар, дээжийн бүрэн бүтэн байдал, нууцлалыг бүрэн ханган битүүмжилж, шинжилгээ хийх эрх бүхий байгууллагад өөрийн биеэр хүргэнэ. Хэрэв өөрийн биеэр хүргэх боломжгүй бол эрх бүхий албан тушаалтнаар эсхүл тусгай шуудангаар хүргүүлнэ.
- Хэв загвар, дээжийг тээвэрлэх боломжгүй тохиолдолд эрх бүхий албан тушаалтан нь шинжээчийг хэв загвар, дээж хадгалагдаж байгаа газарт чөлөөтэй нэвтрүүлэх, шинжилгээ хийх нөхцөлөөр хангах үүргийг хүлээнэ.
- Халдварт өвчин, хоол хүнсээр дамжих өвчинд нөлөөлсөн байж болох хэв загвар, дээж, химийн хорт болон аюултай бодис, химийн үйлдвэрийн бараа бүтээгдэхүүний дээжийг хадгалах, тээвэрлэхдээ хагарч гэмтэхээр бол “Анхаар хагарна”, “Асгарч болзошгүй”, тэсэрч дэлбэрэх эрсдэлтэй бол “Тэсэрч болзошгүй”, халдварын сэжиг бүхий бол “Халдвартай”, “Биоаюултай”, химийн хорт болон аюултай бодис бол “Аюултай”, “Хортой” гэсэн таних тэмдгийг сав, баглаа боодол дээр ил, тод харагдахаар хэсэгт бат бөх байрлуулж, шинжилгээ хийх эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.
- Аюулын зэрэг өндөр химийн хорт болон аюултай бодис бүхий хэв загвар, дээжийг зөвхөн өдрийн цагаар ачиж буулгах бөгөөд ачааны тэмдэгт заасан урьдчилан сэргийлэх арга хэмжээг сахин биелүүлнэ.

- Дээжийг тээвэрлэх ажилтанд аюулгүй ажиллагааны талаар зааварчилгааг холбогдох мэргэжилтэн өгсний дараа тээвэрлэх үйл ажиллагааг гүйцэтгүүлнэ.
- Хэв загвар, дээжийг тээвэрлэх явцад болзошгүй аюул учирсан тохиолдолд хэрэглэх, хор уршгийг арилгах зориулалтын тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл, хор саармагжуулах бодис, уусмал, арьс болон амьсгал хамгаалах зориулалт бүхий стандартын шаардлага хангасан хүн нэг бүрийн хэрэгслээр тээврийн хэрэгслийг хангасан байна.
- Химийн хорт болон аюултай бодис бүхий хэв загвар, дээжийг тээвэрлэх үед холбогдох мэргэжилтнийг байлцуулна.
- Хүчил, шүлт зэрэг идэмхий шингэнийг үйлдвэрлэгчээс савласан зориулалтын тусгай шилэн сав, шилэн савны гадуур зориулалтын материалаар хийсэн давхар хамгаалалтын савтайгаар тээвэрлэнэ.
- Тэсрэх, хөлдөөх эрсдэлтэй шингэрүүлсэн хийн шингэнд хадгалсан биологийн дээж, генетик материалыг үйлдвэрлэгчээс савласан давхар ханатай зориулалтын саванд тээвэрлэнэ.
- Соёлын биет өв, аюултай хог хаягдал, цацраг идэвхт материал, цацрагийн үүсгүүрийг шинжилгээ хийх зорилгоор тээвэрлэхдээ Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 51.2, Хог хаягдлын тухай хуулийн 7.1.2, 7.1.3, Цөмийн энергийн тухай хуулийн 11.1.4-д заасны дагуу холбогдох байгууллагаас баталсан дүрэм, журмыг дагаж мөрдөнө.
- Химийн хорт болон аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл дээжийг тээвэрлэхдээ Автотээврийн тухай хуулийн 9.2, Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 6.1.2, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 14.1, 14.7-д заасны дагуу холбогдох байгууллагаас баталсан дүрэм, журмыг дагаж мөрдөнө.
- Мал, амьтны гоц халдварт, халдварт, шимэгчтэх, бодис солилцооны өвчин, хордлогын сэжигтэйгээр өвчлөх, үхэж хорогдох үед түүний шалтгааныг тогтоох, оношлох зорилгоор амьд байгаа малаас болон үхсэний дараах эмгэг материалаас авсан дээжийг тээвэрлэхдээ Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 29.4-д заасны дагуу холбогдох байгууллагаас баталсан журмыг дагаж мөрдөнө.
- Шинжилгээ хийх зорилгоор үр, хөрс, бордооноос дээж авах, тээвэрлэхдээ стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан “Буурцагт ургамлын бактерийн бордоо”, “Ризобактерийн бордоо”, “Сортын болон үрийн чанар” стандартыг тус тус дагаж мөрдөнө.
- Түргэн муудах, эмзэг бараа бүтээгдэхүүнээс авсан хэв загвар, дээжийг хадгалах, тээвэрлэхдээ Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 55.3-д заасныг үндэслэн холбогдох байгууллагаас баталсан журмыг дагаж мөрдөнө.
- Зам тээврийн осол, зөрчилтэй холбоотой тээврийн хэрэгслийн эвдрэл гэмтлийн анхны байдал, хэв загвар, дээжийн шинж байдлыг алдагдуулахгүйгээр гадна орчны нөлөөлөл (цас, бороо, нар, салхи, шороо, тоос, чийг г.м)-өөс хамгаалж бүрэн хучиж тээвэрлэнэ.
- Хадгалалт, тээвэрлэлтийн горим зөрчсөнөөс хэв загвар, дээжийн шинж чанар алдагдсан тохиолдолд шинжилгээ хийх эрх бүхий байгууллага хүлээн авахаас татгалзах эрхтэй бөгөөд нэн даруй шинжилгээний дээж илгээсэн эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэнэ.
- Шаардлагатай тохиолдолд хэв загвар, дээжийг тусгай хамгаалалттай тээвэрлэж болно.

Орчин тойрондоо аюул учруулж болзошгүй мал, амьтан, тэсэрч дэлбэрэх, хорт бодис, бусад байдлаар аюул учруулж болзошгүй эд зүйлээс хэв загвар, дээж авахдаа аюулгүй байдлыг хангах арга хэмжээг урьдчилан авна. Ер нь шинжилгээнд зориулж хэв загвар, дээж авахдаа нарийн мэргэжлийн мэргэжилтнийг оролцуулж авах нь чухал ач холбогдолтой байдаг.

Зөрчлийн тухай хуулийн 4.11 дүгээр зүйлд зааснаар шинжилгээг хэрхэн хийх талаар хуульчилсан байна. Шинжилгээгээр тухайн эд юмс, мал амьтны эд эрхтний талаар тусгай мэдлэгтэй мэргэжилтний дүгнэлтийг гаргаж, зөрчлийн нотлох баримтыг бүрдүүлдэг. Мөн эрх бүхий албан тушаалтан эд зүйл, хөрөнгөд үнэлгээ тогтоох, тусгай мэдлэг шаардагдах асуудлыг тодруулах зорилгоор хүсэлт гаргаж шинжилгээ хийлгэж болно.

Байгаль орчны хяналт шалгалтыг явуулж буй ихэнх эрх бүхий албан тушаалтан нар нь тухайн мэргэжлийнхээ талаар мэдлэг эзэмшсэн хүн байдаг тул Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.11 дүгээр зүйлийн 4-д заасны дагуу тусгай мэдлэг, мэргэжил эзэмшсэн эрх бүхий албан тушаалтан өөрөө бие даан шинжилгээ хийж, магадалгаа гаргаж болно гэж заасны дагуу шинжилгээ хийж дүгнэлт магадлагаа гаргаж, нотлох баримт бүрдүүлж болохыг хуульчлан заасан байна.

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны аль нэг талын оролцогч шинжээчийн дүгнэлттэй санал нийлэхгүй бол эрх бүхий албан тушаалтан, прокурорт Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу гомдол гаргаж болох бөгөөд оролцогчийн хүсэлтээр дахин шинжилгээг нэг удаа хийж болохоор хуульчилжээ.

Шинжээч шинжилгээний дүгнэлт гаргахдаа Шүүх шинжилгээний тухай хуульд заасан журмыг баримтална ажиллана.

Тодорхой төрлийн зөрчилд хийх шинжилгээ. Тодорхой төрлийн зөрчилд хийх шинжилгээ зөрчлийн шинж байдлаас шалтгаалан янз бүр байна. Тухайлбал, Амьтны тухай хууль зөрчих зөрчилд амьтан ба тэдгээрийн эд эрхтний талаар шинжилгээ хийгдэх бол Байгалийн ургамлын тухай хууль зөрчих зөрчлийн хэрэгт зөрчлийн эд мөрийн баримтаар хураагдсан ургамлын төрөл зүйл, жин зэргийг тодорхойлдог бол Ойн тухай хууль зөрчих зөрчилд модны төрөл, хэмжээ, хаанаас бэлтгэсэн зэрэг асуудлуудыг тодорхойлоход чиглэгдэнэ. Усны тухай хуульд усны бохирдол, усны хэрэглээ зэргийг тодорхойлохоос гадна, хохирол, нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох зэрэгт шинжилгээ явуулна.

Шинжилгээ явуулахад анхаарах зүйлсийн талаар бусад гарын авлага зэргээс дэлгэрүүлж үзэх шаардлагатай бөгөөд зөрчил бүрийн онцлог хэсэгт дэлгэрүүлж бичсэн байгааг анхаарч үзэх хэрэгтэй.

Зөрчил тус бүрийн шинжилгээ явуулах онцлог болгоныг дурдах боломжгүй бөгөөд зөвхөн Амьтны тухай хууль зөрчих зөрчлийн жишээн дээр шинжээч томилох, асуулт, шинжилгээ хийхэд анхаарах зүйлсийн талаар товч танилцуулья.

Ан агнах зөрчлийн хэргийн эд мөрийн баримт болох амьтны эд, эрхтэнд шинжлэн магадлахуйн-амьтан судлалын шинжилгээ явуулахад дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй. Энэ төрлийн гэмт хэрэгт амьтны эд эрхтэнд хийх болон бусад шинжилгээ гэж хоёр хуваж үзэж болно.

а) Амьтны эд эрхтэнд хийх шинжилгээгээр:

- Амьтны үхлийн шалтгаан тодорхойлох – Паталоги
- Амьтны эд эрхтнийг тодорхойлох – Биологи

- Эд эрхтнийг таних, төрөл зүйлийг тодорхойлох – Генетик
- Морфологи[13], ДНХ[14]-ийн шинжилгээг явуулж болно.

Дээрх магадлах шинжилгээг явуулснаар ямар зүйлийн амьтан болох, эр, эм, үр төлийн алин болохыг тогтооно. Амьтны нас, хүйс, үр төлийг тодорхойлсноор хохирлын хэмжээг тогтоох зэрэг хэргийн зүйчлэлд чухал нөлөө үзүүлнэ.

б) Энэ төрлийн гэмт хэрэгт томилох бусад шинжилгээнд:

- Мөр судлал, түүн дотроо тээврийн хэрэгслийн, гутлын, мал, амьтны мөр г.м
- Галт зэвсэг
- Хүйтэн зэвсэг
- Биологи
- Үнэр судлал
- Амьтан агнах, барих бусад зэвсэг хэрэгсэл (амьтан агнах, барихад хуулиар хориглосон зэвсэг, хэрэгсэл болох сааль, занга, урхи, хаж, загас барих тор, цахилгаан гүйдэл, хаалт, хашлага, гувчуур г.м)
- Хөрс, ургамал, шавжийн зэрэг шинжилгээ хамаарна.

Амьтны үхлийн шалтгаан тогтоох (паталоги) шинжилгээгээр үхсэн амьтан нь хордсон, түлэгдсэн, угаартсан гэх мэт шалтгааныг тогтооно. Жишээбэл, загас олноороо хорогдох, амьтад хордож үхэх зэрэг тохиолдол гардаг.

Амьтны эд эрхтнийг тодорхойлох (биологи) шинжилгээгээр мах, арьс, үс, эвэр, туурай, цус, ялгадас зэрэг физик, хими, биологи зэрэг суурь шинжлэх ухааны ололт, арга зүйг өргөн ашиглаж, тухайн амьтны төрөл зүйлийг тогтоох, тодорхойлох шинжилгээ юм.

Эд эрхтнийг таних, төрөл зүйлийг тодорхойлох (генетик) шинжилгээгээр ген, ДНХ-ийн түвшинд амьтны төрөл, зүйл, тоо ширхэг зэргийг тодорхойлно. Амьтны махыг жижиглэсэн, яснаас салгасан, хэлбэр дүрсийг өөрчлөн боловсруулж өнгө үнэрийг танигдахгүй болгосон үед түүнийг ялган таних найдвартай мэдрэг аргыг гений түвшинд өөрөөр хэлбэл, ДНХ-ийн аргаар махны төрөл, амьтны хүйсийг тогтоох найдвартай шинжилгээ хийж байна. Амьтны мах, цус, бусад эдээс ДНХ ялган авч, гений санд буй амьтны ДНХ-ийн тодорхойлолттой харьцуулж, махны төрөл, зүйлийг тогтооно. Түүнчлэн эмэгчин амьтны дээжид хос Х хромсомоос үүдэлтэй 1 толбо, эрэгчин амьтны дээжид Х ба У интроноос үүдэлтэй 2 толбо илрэх зарчимд тулгуурлан амьтны хүйсийг тодорхойлж байна.

Шинжилгээгээр тогтоох асуулт. Амьтны үхлийн шалтгааныг тогтоолгохоор шинжилгээнд хүргүүлж буй амьтан бүхлээрээ байгаа тохиолдолд үхлийн шалтгааныг тогтоох боломжтой бөгөөд шинжээч бололцооны хирээр дараах асуултад хариулна.

13 Морфология - хэлбэр бүтцийн зүй. Дамдинсүрэн, Ц., Лувсандэндэв, А. (1982). *Русско-Монгольский словарь* (около 55 000 слов). Улаанбаатар. 279 дэх тал.

14 Англиар dezxyribonucleic acid гэхийг DNA гэж, оросоор дизоксирибонуклеиновая кислота гэхийг ДНК гэж товчилдог бөгөөд манайд аль алийг нь авсан тохиолддог ба Монголоор дизоксирибонукленны хүчил буюу ДНХ гэнэ. Жаргалсайхан, Б. (2015). *Монгол Улсад криминалистикийн үнэр судлалын хөгжлийн онол, арга зүйн асуудал*. Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл. Улаанбаатар. 14 дэх тал.
Бие махбодод нийлэгждэг уургийн молекул байгууламжийн тухай мэдээлэл нуклейны хүчлийн молекулд хадгалагдаж байдаг. Түүнээс гадна дезоксирибонуклеины хүчил өөрөө өөрийгөө нийлэгжүүлэх “увдистай” цорын ганц молекул юм. Жамъянсүрэн, Д. (1986). *Биофизик*. МЭДН. Улсын хэвлэлийн газар. Улаанбаатар. 6 дахь тал.

Эд мөрийн баримтаар амьд амьтан хураагдаж ирсэн бол:

- Шинжилгээнд хүргүүлж буй амьтан (амьд бол) ямар зүйлийн амьтан болох, түүний шинжлэх ухааны нэршил?
- Энэ амьтан Монгол орны аль хэсэгт тархсан бэ?

Хэрвээ эд мөрийн баримтаар хураасан амьтан амьд байгаа бөгөөд гадна үзлэгээр бэртсэн гэмтсэн цус гарсан, шархтай байгаа бол:

- Тухайн амьтны биеийн аль хэсэгт ямар шарх үүссэн байна вэ?
- Уг шарх хатуу мохоо эсвэл хурц үзүүртэй зүйлээр (хутга, шөвөг г.м) хатгагдсан, огтлогдсон, зүсэгдсэн эсвэл буудагдсан аль нь болох?

Хэрвээ агнасан амьтны үхлийн шалтгааныг тогтоож болохоор бүхлээрээ байгаа эсхүл хангалттай эд хэсгүүд байгаа тохиолдолд:

- Тухайн амьтны үхлийн шалтгаан юу болох?
- Уг амьтны биеийн гадна арьсанд ил харагдах ямар ямар гэмтэл үүссэн байна вэ?
- Задлан шинжилгээгээр амьтны дотор эд эрхтэнд ямар ямар гэмтэл (буудсанаас, хавх, урхины г. м) үүссэн байна вэ?
- Үхэлд хүргэхэд гаднын ямар нөхцөлүүд нөлөөлсөн байна вэ?
- Амьтан үхсэнээс хойш хэдий хугацаа өнгөрсөн болох, хугацааг ойролцоогоор тогтоох. Дурдсан хугацаанд (...төдийд) үхсэн байж болох уу?

Амьтны эд эрхтэнд хийх шинжилгээгээр:

- Шинжилгээнд хүргүүлсэн зүйл (арьсны хэсэг, булчин, мах, яс, дотор эрхтний хэсэг г.м) амьтны эд эрхтэн мөн үү? Хэрвээ мөн бол хүн, мал, амьтны аль нь болох?
- Шинжилгээнд хүргүүлсэн эд эрхтэн амьтных мөн бол ямар зүйлийн амьтны (арьс, мах, эвэр, туурай, дотор эрхтэн г.м) болох вэ? Шинжлэх ухааны нэршил.
- Тухайн амьтан манай орны аль хэсэгт тархсан бэ?
- Уг эд, эрхтнээр тухай амьтны нас, хүйсийг тогтоох боломжтой эсэх?
- Амьтны эд эрхтэн нь холилдсон олон тоотой байвал ямар ямар амьтны аль хэсгийн, хэдэн тоо бүхий эд эрхтэн байгааг тодорхойлох
- Шинжилгээнд хүргүүлсэн амьтны эд эрхтэн болох эвэр, арьс, үсээр тухайн амьтан хэдийд агнагдсан хугацааг тогтоох боломжтой эсэх?
- Шинжилгээнд хүргүүлсэн эд зүйл (нэрийг нь бичих) дээр цус байгаа эсэх?
- Хэрэв цус мөн бол хүнийх үү амьтных уу? Амьтных бол ямар зүйлийн амьтных вэ?
- Тухайн объект үс мөн эсэх? хэрэв мөн бол хүн ба амьтны үсний аль нь болох?
- Хэрэв амьтны үс бол ямар амьтны үс вэ? ..... тухайн амьтны үс мөн эсэх?
- Үс нь ямар зүйлээр бохирлогдсон? ямар шалтгаанаар үс гэмтэлд орсон болох?
- Үс зулгаагдсан, тасалсан, хайчилсан алин болох?
- Амьтны аль хэсгийн үс болох?
- Хэрэг, учрал болсон газарт илэрсэн хөлийн мөр (энэ нь тухай амьтны мөрний талаарх харьцуулах хэв загвартай үед хийх боломжтой) ямар амьтных болох?
- Тухайн мөрийн хувийн онцлог шинж тэмдэг юу вэ?
- Тухайн амьтан аль чиглэлд явж байсан?
- Амьтны мөрөөр нас, хүйсийг тогтоох боломжтой эсэх?
- Хэрэг учрал болсон газарт хэчнээн тооны амьтан байсныг тогтоох боломжтой эсэх?
- Тухайн амьтны явдлын мөрөнд өөр амьтан (ялангуяа, морь, тэмээ, үхэр) зэрэг амьтны мөр холилдон орсон эсэх зэрэг асуудлаар хариулт авах боломжтой.

Үүнээс гадна, шинжилгээний явцад олж мэдсэн бусад асуудлын талаар асуулт асуугаагүй байсан ч шинжээч мэргэжилтний хувьд тодорхой тайлбарлан бичиж ирүүлэх учиртай.

Анхаарвал зохих асуулт, хариулт

Асуулт. Амьтны эд эрхтэн гэж юуг ойлгох бэ?

Хариулт. Амьтны тухай хуулиар “ангийн гаралтай түүхий эд” гэдэгт амьтны арьс, шир, үс, өд, эвэр, толгой, цус, өөх, тос зэрэг эд эрхтнийг” ойлгоно хэмээн тодорхойлсон бөгөөд дээрхээр хязгаарлагдахгүй юм. Тодруулбал, ан амьтдын мах, арьс, үс, ясан болон цусан эвэр, булчирхай, цус, тос, дотор эрхтэн, өд, туурай зэрэг байна. Хууль бус худалдаанд ихэвчлэн баавгайн донид, хүдрийн заар, бугын чив засаа, цусан эвэр, согооны сүүл, тарваганы арьс, бөхөнгийн эвэр, ирвэсийн арьс зэрэг амьтдын эд, эрхтэн өртөж байна.

Асуулт. Амьтны эд эрхтнээр хийсэн бүтээгдэхүүн, тэдгээрийг хэрхэн ялгаж таних бэ?

Хариулт. Амьтны эд эрхтнийг ямар нэгэн бүтээгдэхүүн болгосон эсхүл үйлдвэрийн түүхий эд болгон бэлтгэсэн зүйлийг ойлгоно. Тухайлбал, хотон шувууны хошуугаар хурдан морины хусуур хийх, хулангийн унаганы туурайгаар гоёл чимэглэл, сангийн бойпор, тарвага болон үслэг ангийн арьсаар дээл, хувцас, чонын соёо, шагай, баавгайн хумс, бүргэд зэрэг махчин шувуудын өд, сарвуу, тул загасны толгой зэргээр элдэв бэлэг дурсгал, чимэглэлийн зүйлс хийсэн байдаг. Тэдгээр зүйлсийг эд эрхтний хэлбэр хэмжээ, өнгө зүс, үнэр, ясны жишил анатоми зэрэг онцлог шинжээр нь ямар зүйл амьтны эд эрхтэн болохыг ялган таньж болно.

Асуулт. Амьтны үсийг ашиглан гэмт хэрэг илрүүлж болох уу?

Хариулт. Үс бол гэмт хэрэг илрүүлэх нэг чухал эх үүсвэр бөгөөд тухайн гэмт хэргийн талаар өөртөө үнэтэй мэдээлэл агуулж байдаг.

Асуулт. Амьтны эд эрхтнийг энгийн нүдээр таньж мэдэж болох уу?

Хариулт. Амьтны эд эрхтнийг анатоми бүтэц, хэлбэр дүрс, өнгө, үнэрээр нь ялган таньж мэдэж болно. Таньж мэдэх шинж тэмдгүүдийг амьдралын туршлагаас суралцан мэднэ. Тухайлбал, хандгайн хэл урт, нарийхан үзүүр нь дугараг, дээд талдаа гүвгэр хэсгүүдтэй. Гахайн хэл урт, нарийхан гүвгэр байхгүй. Нохой, чонын хэл өргөн, хавтгай хурц, улаан өнгөтэй, гадаргуу нь хилэн шиг зөөлөн нөсөөгүй байдаг. Хандгайн бөөр хэлтэнцэргүй, шош маягийн зууван хэлбэртэй, дэлүү нь хавтгай зузаан гэх мэт.

Асуулт. Амьтны үсэн бүрхүүлийг хэд ангилдаг бэ?

Хариулт. Ан амьтны арьсны үсэн бүрхүүлийн байдал, агналтын хугацааг харгалзан өвөл, хаврын гэж 2 төрөлд хуваана. Өвлийн төрөлд ангийн арьсанд үс хөрс нь ургаж гүйцсэн үед нь агнасан буюу өвөл агнасан амьтдын арьс багтана. Хаврын төрлийн ангийн арьсанд өвлийн улиралд ичээнд ордог тухайлбал, тарвага, баавгай зэрэг амьтдын арьс хамаарах бөгөөд эдгээрийг хавар эсвэл намар агнана.

Асуулт. Үслэг ангийн арьсны эдийн бүтэц, шинж чанарыг ярина уу?

Хариулт. Ан амьтны арьсыг үсэн бүрхүүлийн тархац, хөрсний зузаан, нимгэн зэрэг шинж чанар байдлын онцлогоос хамааруулж нуруу, хэвл хэсэг гэсэн 2 үндсэн хэсэгт хуваана. Түүнчлэн хоншоор, дух, хүзүү, сэрвээ, хоолой, хажуу дал, өгзөг, хонго, цавь зэрэг нэлээд хэдэн хэсэгт ангилна. Ан амьтны үсэн бүрхүүл нь биеийн дулаан хүйтнийг зохицуулах, эд эсийн чийглэгийг хадгалах, бие организмыг хамгаалах зэрэг биологийн чухал үүрэг гүйцэтгэх олон тооны үсний нийлбэр цогц юм.

Ан амьтны үсэн бүрхүүлийн олон тооны үсний ширхгүүд нь морфологи болон гистологи бүтэц, хэмжээ хэлбэр хөндлөн огтлол, атираа, өнгө, байрлал зэргээрээ ялгаатай. Үсийг гадаад хэлбэрээр нь конус, цилиндр, тууз, ээрүүл, сэлэм хэлбэрийн гэж ангилна.

Ээрүүл хэлбэрийн үсний уг нь нарийн, үсний уртын 3/1-ээс дээших хэсэгт бүдүүрсэн байна. Цилиндр хэлбэрийн үс уртынхаа дагуу бараг бүхэлдээ ижил диаметртэй байх боловч төгсгөл болон үндсэн хэсэгт үл мэдэг нарийссан байна. Конус хэлбэрийн үс үзүүрээсээ уг руугаа жигд өргөссөн байна. Сэлэм хэлбэрийн үс нь дээд үзүүр хэсгээрээ сэлэм мэт хавтгайрч доод сууриараа цилиндр хэлбэртэй байна. Туузан хэлбэрийн үс нь бүх хэсгээрээ жигд хавтгайрсан байна.

Асуулт. Үсний төрөл, түүний ангилал?

Хариулт. Үсэн бүрхүүл дэх үсний ширхгүүдийг мэдрэмж үс буюу сахал, чиглүүлэгч үс, сор, ноолуур, завсрын үс гэж хэд хэдэн категорид хувааж үздэг.

Мэдрэгч үс буюу сахал нь урт бүдүүн бага зэрэг тахирдуу байх бөгөөд амьтны толгой, уруул нүдний ойролцоо, заримдаа хүзүү, цээж, хөлийн тавхайд байдаг мэдрэгч үс нь ихэвчлэн 3-11-ээр бүлэглэж уруулын дээд, доод талд нүд, хүзүү, цээж өвчүү, хөлийн тавхайн хэсэгт байрлана.

Чиглүүлэгч үс амьтдын үсэн бүрхүүл дэх бусдаас урт, өндөр бүдүүн үсийг чиглүүлэгч үс гэнэ. Чиглүүлэгч үсний уг арьсанд хамгийн гүн суусан байдаг. Чиглүүлэгч үсний тоо цөөн, арьсны 1 см^2 талбайд дунджаар 5-20 ш байна.

Сор үс нь чиглүүлэгч үснээс богино, нарийн долгиотсон нь тод илрэх ирмэгтэй, ирмэг хэсгээрээ бага зэрэг тахийсан байна. 1 см^2 дунджаар 50-200 ш байна. Завсрын үс ихэнх шинж тэмдэг, чанарааараа сор үс болон ноолууртай төстэй бөгөөд сор үснээс богино, нарийн ноолуураас бүдүүн урт байна.

Ноолуур бол хамгийн богино, нарийн, зөөлөн атираатсан байхаас гадна, уртын дагуу жигд нарийссан байна.

Асуулт. Амьтны үсийг шинжилж, түүгээр ямар зүйлийн амьтан болохыг тогтоож болох уу?

Хариулт. Болно. Үсийг шинжлэхдээ физик, хими, биологи зэрэг суурь шинжлэх ухааны зэрэгцээ биофизик, биохими, удамшил зүй зэрэг салбар шинжлэх ухааны ололт, арга зүйг өргөн ашиглаж, амьтны үсний шинж чанарыг иж бүрэн судалж, үсний гадна шинж өнгө, урт, өргөн бүтцээр[1] нь тухайн амьтны төрөл зүйлийг тогтоож байна.

Асуулт. Биологийн гаралтай эд эрхтнийг хураан авах, хадгалах онцлог?

Хариулт. Биологийн гаралтай эд мөрийн баримт нь хураан авах, хадгалах тусгай горим, арга ажиллагааг шаарддаг юм. Баримтыг хураан авч бэхжүүлэх, чанар байдлыг алдагдуулахгүй хадгалах нь нотлох ажиллагааны нэг элемент төдийгүй эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зорилтыг хангах чухал хэрэглүүр юм. Хэргийн газраас болон мөрдөн байцаалтын үзлэгээр илрүүлсэн эд мөрийн баримт болох амьтны эд эрхтнийг хураан авахдаа эд эрхтэн тус бүрийг уут савand хийж, битүүмжлэн дугаарлан хаягжуулна.

Биологийн гаралтай эд эрхтнийг зөвхөн цаасан уутанд хийж, аль болох нар тусахгүй, халаах хэрэгсэл, хорхой шавжаас хол тавьж, сэрүүн газарт хадгална. Эд мөрийн баримтыг гялгар уутанд хийж хэрхэвч болохгүй муудах аюултай. Амархан муудах цус, бусад эд эрхтнийг яаралтай хөргөгч, хөлдөөгчид хадгална. Ийм учраас хууль хяналтын байгууллага нь эд мөрийн баримт хадгалдаг газартаа заавал хөргөгч, хөлдөөгчтэй байх ёстой.

Асуулт. Эд мөрийн баримтыг хадгалах онцлог бий юу?

Хариулт. Хууль бусаар ан агнах гэмт хэрэгт хураагдсан биологийн гаралтай нотлох баримтыг хадгалах, хураан авах нь ихээхэн өвөрмөц онцлогтой. Тухайлбал, аливаа үслэг эдийг хадгалахад агуулах хэрэгтэй. Эд мөрийн баримтаар хураагдаж ирсэн ангийн үс, арьсыг хүлээн авахдаа тэдгээрийг төрөлжүүлэн ялгах, баглах, хүлээн авсан үеийн анхны чанар байдлыг алдагдуулахгүйн тулд норж гэмтэх, хортон шавжаас хамгаалах, ариутгал цэвэрлэгээ хийх, чанарын хамгаалалт, хаягжуулалт хийнэ. Агуулах байрны температур, агаарын харьцангуй чийг ялгаатай байна. Тухайлбал, хатааж чанар байдлыг хамгаалсан арьсанд агаарын чийг 50-60%, давсалж хатаасан арьсанд 60-65%, нойтон давсалсан арьсанд 75-80% тус тус байх нь зохимжтой. Агаарын температур хатаасан арьсанд +15-20^{0}C, нойтон давсалсан арьсанд 8-12^{0}C тус тус байна. Арьс хадгалах агуулах нь тавиур, вандан, өлгүүр, тасалгаатай шүүгээ, хэц зэргээр тоноглогдсон байна.

Асуулт. Амьд амьтан нотлох баримт болох уу?

Хариулт. Амьд амьтан нь тухайн хэргийг нотлох хөдөлшгүй баримт мөн. Хууль бусаар ан агнах, барих гэмт хэрэгт зохих зөвшөөрөлгүйгээр нэн ховор, ховор амьтан, тэдгээрийн үр төлийг амьдаар нь барьж тэжээх, гаршуулах худалдан борлуулж буй хэргүүд олон бий. Тэдгээр амьтныг эд мөрийн баримтаар хураан авах, хадгалах, буцаан тавих ажиллагаа нь бусад гэмт хэргийн эд мөрийн баримт, түүнийг хураан авах, хадгалах арга зүйгээс ялгагдах онцлогуудтай.

Асуулт. Эд мөрийн баримтаар амьд амьтан хураагдсан тохиолдол хэрхэх вэ?

Хариулт. Хууль бусаар барьсан амьтан нь амьд байгаа тохиолдолд амьтныг хэрхэх тухай шийдвэрийг яаралтай гаргана. Тухайн хэргийг илрүүлсэн даруйд амьтныг байгальд нь буцаан тавих боломжтой, орчин нөхцөл нь тохирсон бол шууд тавих шаардлагатай. Энэ үед эд мөрийн баримт болох амьтныг гэрэл зураг, дүрс бичлэг, тэмдэглэлээр бэхжүүлнэ. Амьтныг байгальд нь буцаан тавихдаа тухайн газар нь амьтны амьдрах чадварт нөлөөлөх эсэхийг тооцоолж, хот суурин газраас хол, хүн малын хөлөөс зайдуу газрыг сонгоно. Байгальд нь зэрлэг амьтныг эргүүлэн тавьж байгаа тохиолдолд албан хаагчийн аюулгүй байдлыг хангахад анхаарна. Амьтад өөр өөрийн өвөрмөц зан авиртай тул дайрах, хазах, мөргөх, түлхэх, өшиглөх зэрэг үйлдлүүд гаргаж болзошгүйг санаж байх шаардлагатай. Аливаа амьтныг байгальд буцаан тавих ажиллагаанд боломжтой бол мэргэжилтнийг оролцуулж, тэдний зөвлөгөөг авч хаана хэрхэн яаж тавих, оролцох хүн, тээврийн хэрэгсэл, бусад багаж хэрэгсэл зэргийг урьдчилан сайтар төлөвлөж, уг ажиллагааг мэргэжлийн хүмүүсээр гүйцэтгүүлж, харин эрх бүхий албан тушаалтан нь тэдгээрийн үйл ажиллагааг баримтжуулбал зохимжтой.

15 Үсний бүтцээр нь тухай амьтны төрөл зүйлийг тодорхойлж болно. Тухайлбал, газар зүйн ялгаатай нутагт оршдог тарваганы арьсны үсэн бүрхүүлийн өтгөн, урт богино, нарийн бүдүүн өнгө нь харилцан адилгүй. Үсний өтгөн сийргийн 1 см^2 талбайд байх үсний тоогоор өрнөдийн тарваганы сор үс хажуу бөөрөндөө 1258 ш, чиглүүлэгч үс 193 ш, үсний урт хажуу бөөрний орчимд 19,7 микрон, нарийн бүдүүн нь хажуу бөөрний орчимд 29.79 микрон байна. Дорнодын тарваганы сор үс 2257 ш, чиглүүлэгч үс 271 ш, үсний урт хажуу бөөрний орчим 15.0 микрон, нарийн бүдүүн нь 27.52 микрон зэргээр ялгаатай байна. Банзрагч, Г. (1962). *Ангийн үсний судлал* (эмхэтгэл). Улаанбаатар. 55 дахь тал.

Хэрвээ буцаан тавих боломжгүй бол тухайн амьтныг хадгалах тохиромжтой байр сав, зөөж тээвэрлэх тээврийн хэрэгслийг бэлтгэнэ. Энэ үед амьтныг хангалттай хооллох хэрэгтэй. Амьтныг зөөж тээвэрлэхдээ түүний айдсыг намжаахын тулд аль болох юмаар бүтээх, нарнаас хол байлгаж ус өгч, дуу чимээнээс хол байлгана. Дуу чимээ болон хүмүүс нь түүнийг стресст оруулах, шархдах үхэх эрсдэлийг нэмэгдүүлнэ. Амьтад наршсанаас үхэх аюултай. Амьтанд ус нь хоолноос ч илүү чухал байдаг.

Амьтныг зөөж тээвэрлэх үедээ хаана байрлуулах талаар ямар нэгэн шийдвэр гаргасан байх ёстой. Учир нь хууль хяналтын байгууллагад амьд амьтан хадгалах зориулалтын байр байхгүй тул амьтны хүрээлэн, цирк, хувираа амьтан тэжээдэг хүмүүс зэргийг сонгон авч урьдчилан тохирох, холбогдох зөвшөөрлийг авсан байх шаардлагатай. Амьтдыг зөөж тээвэрлэх үеийн үйл ажиллагааг мөн баримтжуулна.

Асуулт. Амьтан бүрийн мөр адилхан уу? Хэрвээ өөр бол яагаад?

Хариулт. Амьтан бүр өөр өөрийн гэсэн морфологи шинжтэй учраас тэдгээрийн мөр нь ч гэсэн өөрийн гэсэн онцлогтой байдаг. Мөр нь өөрөө байгаль, цаг агаараас шалтгаалан салхи бороонд балархайших, чийгтэй, зөөлөн шороотой газар тод, хатуу газарт бүдэг, цасны шинэ хуучнаас шалтгаалан өөр өөр гардаг.

Асуулт. Амьтны мөрд хийх оноош зүйн шинжилгээ дараах асуултуудад хариу өгөх үү?

Хариулт. Амьтны мөрөөр дараах асуултад хариу өгнө. Үүнд:

Хэрэг, учрал болсон газарт илэрсэн хөлийн мөр (энэ нь тухай амьтны мөрний талаарх харьцуулах хэв загвартай үед хийх боломжтой) ямар амьтных болох? тухайн мөрний хувийн онцлог шинж тэмдэг? тухайн амьтан аль чиглэлд явж болох? амьтны мөрөөр нас, хүйсийг тогтоох боломжтой эсэх? хэрэг учрал болсон газарт хэчнээн тооны амьтан байсныг тогтоох боломжтой эсэх? тухайн амьтны явалтын мөрөнд өөр амьтан (ялангуяа, морь, тэмээ, үхэр) зэрэг амьтны мөр холилдон орсон эсэх зэрэг асуудлуудыг шийдвэрлэж болно.

Асуулт. Амьтан агнахад ашигласан зэвсэг хэрэгсэл нь нотлох баримт болох уу?

Хариулт. Амьтныг агнах, барихад ашигласан зэвсэг хэрэгсэл нь тухайн гэмт хэргийг нотлох эд мөрийн баримт болно.

Асуулт. Агнуурын амьтан агнах, барихад хориглох ямар арга, зэвсэг хэрэгсэл байдаг вэ?

Хариулт. Агнуурын амьтан агнах, барихдаа дараах арга, зэвсэг хэрэгсэл хэрэглэхийг хориглосон байдаг. Үүнд:

Химийн болон тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглах, агнуурын амьтны жим дээр нүх ухах, буу сойх, занга, сааль тавих, туурайтан амьтныг агнахад цасанд умбуулах, мөсөнд халтиргах, хясаа, эрэг, ганга руу нисгэх, хавх тавих, тарвагыг нүхэнд нь утах, ус цутгах, хавх, урхи тавих, нохойгоор зориудаар бариулах, агнуурын амьтныг агаарын болон авто тээврийн хэрэгслээр хөөх, гэрэлтүүлэх, загас барихад буу, бамбар, цахилгаан гүйдэл, хаалт, хашилга, гувчуур хэрэглэх, ахуйн хэрэгцээнд загас барихад тор хэрэглэх, ан агнах зориулалтын бус буу, сум ашиглах, гол, мөрөнд бүх төрлийн завиар загасчлах зэрэг болно.

2.9 МЭДҮҮЛЭГ АВАХ, ЯРИЛЦЛАГА ХИЙХ АРГА ТЕХНИК

Зөрчил шалгах ажиллагаа нь зөрчил үйлдэгдсэн газар, хүн, хуулийн этгээдийн эзэмшил газар, барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, хүний бие, эд зүйлд үзлэг хийх, баримт бичиг, мэдээлэл гаргуулан авах, эд зүйл, баримт бичгийг хураан авах, эд хөрөнгийг битүүмжлэх, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, **мэдүүлэг авах**, шинжилгээнд зориулж хэв загвар, дээж авах, шинжилгээ хийлгэх ажиллагаанаас бүрдэнэ.

Зөрчлийн хэрэгт байнга хийгддэг ажиллагааны нэг нь мэдүүлэг авах ажиллагаа юм. Мэдүүлгийг эрх бүхий албан тушаалтан зөрчил гарсан байдлыг тодруулах, зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдол бүхий баримт, мэдээллийг олох зорилгоор авна.

Мэдүүлэг нь хүний ухамсарт тусгагдсан обьектив талын тусгал бөгөөд түүнийг сэргээн санаж илэрхийлэх үйл явц юм. Мэдүүлэг бол мэдээллийг дамжуулах, хүлээн авахад чиглэгдэх ба мэдүүлэг авч байгаа болон мэдүүлэг өгч байгаа этгээдийн хоорондын харилцан хамаарал бүхий харилцаа юм. Энэ нь хэдийгээр харьцангуй императив шинжтэй албан ёсны харилцаа боловч мэдүүлэг авч байгаа албан тушаалтан нь хэргийг тулган хүлээлгэх замаар мэдүүлгийг хөтлөн удирдана гэсэн үг биш юм.

Мэдүүлэг нэг талаас зөрчлийн нөхцөл байдалд холбогдох үйл явдлын талаар тодорхой этгээд эрх бүхий албан тушаалтанд мэдүүлэг өгөх замаар дамжуулах, нөгөө талаас эрх бүхий албан тушаалтан нь уг мэдээллийг хуульд заасан журмын дагуу хүлээн авч бэхжүүлэхэд чиглэгдсэн хоёр талт үйл ажиллагааны нийлбэр цогц мөн.

Зөрчил шалгах ажиллагаанд мэдүүлэг шийдвэрлэх үүрэгтэй бөгөөд зөрчлийн хавтаст хэргийн материалын зонхилох хэсгийг оролцогч нарын мэдүүлэг эзэлдэг нь үүний нэг илрэл юм. Эрх бүхий албан тушаалтан мэдүүлэг авахын өмнө зохих бэлтгэлийг хангах нь зүйтэй. Үүнд:

а) Мэдүүлэг авбал зохих хүмүүсийг тогтоох
б) Мэдүүлгээр зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдол бүхий ямар нөхцөл байдлуудыг тодруулж болохыг урьдчилан бэлтгэх
в) Мэдүүлэг авах явцад мэдүүлэг өгч буй этгээдэд гаргаж үзүүлж болох ямар нотлох баримт байгааг тодорхойлж, ямар үед үзүүлж болох арга тактикийг боловсруулах
г) Холбогдогч, хохирогч, гэрчид тавьж болох асуулт, тэдгээрийн дэс дарааллыг тогтоох
д) Мэдүүлэг өгөх этгээдийн хувийн байдлыг урьдчилан судлах
е) Мэдүүлэг авах үед мэдүүлэг өгч буй этгээдээс ялангуяа, холбогдогчийн зүгээс гаргаж болох зүй бус үйлдлийг урьдчилан тогтоож, таслан зогсоох талаар арга хэмжээ авах
ё) Мэдүүлгийг хэрхэн авах талаар төлөвлөгөө зохиох зэрэг ажиллагааг хийж гүйцэтгэвэл зохино.

Мэдүүлгээр дараах асуудлыг заавал тодруулах ёстой байдаг. Үүнд:

1. Зөрчил үйлдэгдсэн байдал (газар, үйлдэл, хугацаа, орчин)
2. Хохирол, үр дагавар болон хохирогчийн байдал (хохирогчийн гаргасан гомдол, түүний агуулга)
3. Гэрчийн болон хөндлөнгийн хүчин зүйл
4. Зөрчил үйлдэгчийн хувийн байдал, зөрчлийн шууд шалтгаан (хэргээ хүлээсэн байдал, зөрчлийн сэдэл, шалтаг, хүчин зүйл) зэрэг болно.

Мэдүүлгийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.8 дугаар зүйлд заасан нөхцөл, журмын дагуу явуулна. Үүнд:

1. Эрх бүхий албан тушаалтан зөрчил гарсан байдлыг тодруулах, зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдол бүхий баримт, мэдээллийг олох зорилгоор мэдүүлэг авна.
2. Мэдүүлгийг тухайн хүнийг эрх бүхий байгууллагад ирүүлэн, эсхүл тухайн хүний байгаа газарт авч болно.
3. Холбогдогчоос мэдүүлэг авахын өмнө түүнд үнэн зөв мэдүүлэг өгөхийн ач холбогдлыг тайлбарлаж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаатай холбоотой нууцыг хадгалах талаар мэдэгдэнэ.
4. Эрх бүхий албан тушаалтан хүнийг албадан ирүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг (эх), үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах эрхгүй.
5. Тухайн хүн хүсвэл мэдүүлгийг бичгээр авч болно.
6. Эрх бүхий албан тушаалтан мэдүүлгийг асуулт асууж, хариулт авах хэлбэрээр явуулна.
7. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар, эсхүл хүний нэр төрийг гутаан доромжлон харьцаж мэдүүлэг авахыг хориглоно.
8. Мэдүүлэг өгч байгаа хүн тоо болон санахад төвөгтэй бусад зүйлийн талаар мэдүүлэг өгөх бол эрх бүхий албан тушаалтны зөвшөөрснөөр баримт бичиг, бичлэг ашиглаж болно. Ашигласан баримт бичиг, бичлэгийн тухай тэмдэглэлд тусгаж, боломжтой бол мэдүүлгийн тэмдэглэлд хавсаргана.
9. Мэдүүлэг өгч байгаа хүнд эд мөрийн баримтыг үзүүлэх, тухайн зөрчлийн талаар бусад хүнээс өгсөн мэдүүлгийг танилцуулж, энэ талаар мэдүүлэг авч болно.
10. Мэдүүлэг авах ажиллагааг 3 цагаас илүү хугацаагаар явуулах бол 30 минутын завсарлага авна. Нэг удаагийн мэдүүлэг авах ажиллагаа нийт 6 цагаас хэтэрч болохгүй.
11. Мэдүүлэг авч дуусмагц тэмдэглэлийг мэдүүлэг өгч байгаа хүнд танилцуулж, нэмэлт оруулах, засвар хийх боломж олгоно.
12. Мэдүүлэг өгөхөөс татгалзсан бол энэ тухай тэмдэглэлд тусгана.
13. Доор дурдсанаас бусад тохиолдолд мэдүүлгийг шөнийн цагаар авахыг хориглоно:
    - Шөнийн цагаар явагдаж байгаа үйлдвэрлэл, ажил, үйлчилгээний газарт гарсан зөрчлийг газар дээр нь шийдвэрлэх бол
    - Олон нийтийн аюулгүй байдал, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд аюул учирч болох нөхцөл байдал үүссэн, эсхүл үүсэж болзошгүй бол
    - Зөрчлийн ул мөр устах, холбогдогч оргон зайлж болзошгүй
    - Гудамж, талбай, олон нийтийн газарт шөнийн цагаар үйлдэгдсэн зөрчлийг хялбаршуулсан журмаар газар дээр нь шалган шийдвэрлэх бол.
14. Эрх бүхий албан тушаалтан мэдүүлгийг тэмдэглэлээр бэхжүүлж, мэдүүлэг өгсөн хүн гарын үсэг зурж баталгаажуулна.
15. Мэдүүлэг өгч байгаа хүнд мэдэгдэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийж болно.

Мэдүүлэг өгч байгаа этгээдэд хариултыг нь хэлж өгсөн агуулгатай асуултыг хөтөлсөн асуулт гэнэ. Хөтөлсөн асуулт асуусан тохиолдолд мэдүүлэг өгч байгаа оролцогч тэрхүү бэлэн хариултыг нь ашиглан ам дагуулж мэдүүлэх боломжтой.

Тулгасан гэдэгт мэдүүлэг өгч байгаа этгээдээс өөрийнхөө хүссэн агуулгатай хариултыг заавал хэлүүлэх гэж зүй бусаар шахан шаардсан асуулт тавихыг ойлгоно. Мэдүүлгэн нотлох баримт нь асуулт, хариултаас бүрддэг тул асуулт, хариулт нь зөрчилд ач холбогдолгүй л бол тэр мэдүүлэг тухайн зөрчлийн нотлох баримт болж чадахгүй. Зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдолгүй гэдэг нь тухайн зөрчлийн нотолбол зохих зүйлд хамааралгүй зүйлийн талаар асуулт тавихыг хэлнэ.

Зөрчлийн хэргийн холбогдогч, хохирогч нь эх хэлээрээ, эсхүл сайн мэдэх хэлээрээ мэдүүлэг өгөх, орчуулагч, хэлмэрч авах эрхтэй байна. Харин өмгөөлөгч холбогдогчоос мэдүүлэг авахад байлцах, асуулт тавих, тэмдэглэлд тусгуулах, хохирогч, гэрч, шинжээчээс мэдүүлэг авхуулахаар хүсэлт гаргах эрхтэй.

Зөрчлийн хэрэгт гэрчээр оролцож буй хүн нь зөрчлийн хэргийн талаар өөрийн мэдэх зүйлийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэйгээс гадна, өөрийн болон гэр бүлийн гишүүн, эцэг, эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй.

Шинжилгээнд явуулж дүгнэлт гаргасан шинжээч нь гаргасан дүгнэлттэй холбоотой асуудлаар мэдүүлэг өгөх үүрэгтэй.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.9 дүгээр зүйлд насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авах журам, нөхцөлийг заасан байдаг. Үүнд: арван найман насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авахдаа түүний хууль ёсны төлөөлөгч, эсхүл өмгөөлөгч, шаардлагатай тохиолдолд сурган хүмүүжүүлэгч, сэтгэл зүйч, нийгмийн ажилтны аль нэгийг байлцуулна. Эрх бүхий албан тушаалтны зөвшөөрснөөр хууль ёсны төлөөлөгч, сэтгэл зүйч, сурган хүмүүжүүлэгч, нийгмийн ажилтан арван найман насанд хүрээгүй хүнээс асуултыг зөв ойлгосон, хариултаа зөв илэрхийлсэн эсэхийг тодруулан асууж, тайлбарлаж болно. Арван найман насанд хүрээгүй хүнээс авах мэдүүлгийг 1 цагийн хугацаагаар тасралтгүй явуулж болно. Мэдүүлгийг 1 цагаас илүү хугацаагаар явуулах бол 30 минутын завсарлага авна. Нэг удаагийн мэдүүлэг авах нийт хугацаа 2 цагаас илүүгүй байна. Арван найман насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авахдаа дээр заасан журмыг баримтална.

Мэдүүлгийг авч буй ажиллагааг заавал бэхжүүлэх (тэмдэглэл үйлдэх, дүрс болон дуу бичлэг хийх г.м) ёстой. Эрх бүхий албан тушаалтан мэдүүлгийг тэмдэглэлээр бэхжүүлж, мэдүүлэг өгсөн хүн гарын үсэг зурж баталгаажуулна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.13 дугаар зүйлд тэмдэглэл үйлдэх журмыг заасан байна. Үүнд:

- Ажиллагааг явуулсан эрх бүхий албан тушаалтны нэр, албан тушаал
- Ажиллагааг явуулсан газар, эхэлсэн, дууссан он, сар, өдөр, цаг, минут, хэрэгжүүлэх явцад хугацаа тасалдсан бол түүний шалтгаан, хугацаа
- Ажиллагааг прокурорын зөвшөөрлөөр явуулж байгаа бол зөвшөөрлийн дугаар, хүчинтэй хугацаа
- Ажиллагааг хойшлуулшгүй тохиолдолд явуулж байгаа бол үндэслэл бүхий нөхцөл байдлын талаар
- Зөрчил шалгах ажиллагаанд оролцсон хүний эцэг (эх)-ийн болон өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, байршил
- Ажиллагаанд байлцсан бусад хүний хувийн баримт бичиг дэх мэдээлэл
- Ажиллагаанд оролцсон хүнд эрх, үүргийг тайлбарласан тухай
- Оролцогч, гэрчээс санал, хүсэлт гаргасан эсэх, түүнийг хэрхэн шийдвэрлэсэн
- Тэмдэглэлд эрх бүхий албан тушаалтан, ажиллагаанд оролцсон хүн гарын үсэг зурна.
- Тэмдэглэл хэд хэдэн хуудастай бол ажиллагаанд оролцсон хүн хуудасны нүүр тус бүрд гарын үсэг зурна.
- Тэмдэглэлд нэмэлт оруулсан, засвар хийсэн бол ямар засвар, өөрчлөлт хийсэн талаар тусгаж, баталгаажуулна.
- Ажиллагаанд оролцсон хүн гарын үсэг зурахаас татгалзсан, эсхүл баталгаажуулах боломжгүй бол шалтгааныг тэмдэглэлд тусгана.
- Ажиллагааны явцад хийсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, гэрэл зураг, гар зураглал, хэв загварыг тэмдэглэлд хавсаргана.

Ярилцлага. Зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтан нь холбогдогч, гэрч, хохирогч нараас мэдүүлэг авна гэдэг нь өөр хоорондоо харилцаа үүсгэж ярилцлага хийнэ гэсэн ойлголт юм. тийм учраас ярилцлага хэрхэн хийх талаар багахан тактикийн шинжтэй мэдээллийг бэлтгэн хүргэж байна.

Та гэмт хэрэг, зөрчлийн тухай, гэр бүлийн болон түүний хамсаатны талаар мэдээлэл хүлээн авч болно (мэдээллийн эх сурвалж хэсгийг дахин үзээрэй). Тэднээс асуухыг хүссэн асуултаа урьдчилан жагсаан гаргах хэрэгтэй. Ярилцлага нь ерөнхий асуултаар эхэлж, дараа нь өвөрмөц онцгой асуулт руу шилжинэ.

Ярилцлагын эхэнд ярилцагчийн эгц өөдөөс нь харж суугаад биеэ суллан чөлөөтэй сууна. Та хөлөө ачих юм уу гараа элгэндээ тэвэрч болохгүй. Биеэ чөлөөтэй байлгах нь түүний хэлж ярихыг сонсох хүсэлтэй байгааг илтгэнэ.

Ярилцлага ярилцагчтай мэндэлж, өөрийгөө танилцуулснаар эхэлнэ. Ярилцлагын үед ярилцагч руугаа харах хэрэгтэй боловч түүн рүү ширтэж болохгүй. Та нөхөрсөг, эелдэг байж, хэрвээ дүрэмт хувцасгүй байгаа бол албаны үнэмлэхээ үзүүлнэ.

Ярилцагчаа тайвшруулж байж ярилцлагаа эхлэх нь зохистой. Албаны хэргээр бусадтай ярилцахад зарим хүмүүс айх сандрах байдалд ордог. Ийм үед та ярилцагчдаа амархан асуулт тавьж, түүнийг тавгүйтүүлэх асуулт асуухгүйгээр эхэлнэ. Хэрвээ ярилцагч зөрчил шалгах ажилд туслахааргүй байвал ярилцагч хүндээ зөрчил шалгах ажлын тухай мэдээлэл өгөхгүй байх нь зүйтэй. Шаардлагатай биш бол та мэдээж шалгах ажиллагааныхаа нарийн ширийн зүйлсийг бусдад зарлах хэрэггүй.

Ярилцлагын үед. Та тухайн хүнтэй ярилцах цорын ганц боломжтой хүн байж болох юм. Та ярилцаж буй хүнээсээ аль болох бололцоотой мэдээллүүдээ авахыг хичээгээрэй. Та тун няхуур байж, хариултуудад маш хурдан дүн шинжилгээ хийж бататгах асуулт асуух хэрэгтэй. Жишээлбэл, та андуураагүй биз, түүнтэй адилхан хүн явж байсан юм биш биз, таны хараа сайн уу гэх мэт хариултыг өөр талаас нь сөргүүлэн тавьж хариултыг бататгахыг хичээх хэрэгтэй. Энэ үедээ ярилцагч эгдүүцэж байвал түүнээс эвтэйхэн зайлсхийж гарах хэрэгтэй. Түүнтэй харин муудалцах, өөрийнхөөрөө зүтгэх, тулгаж бас болохгүй. Мөн хууран мэхлэх, төөрөгдөлд оруулах зэрэг зүйлс хийхийг хориглоно.

Ярилцлагын асуултыг эхлэх хэлбэр нь тун энгийн байх хэрэгтэй. Мэндэлснийхээ дараагаар асуух асуулт нь хэт энгийн тийм үгүй гэж хариулагдахаар байх ёсгүй. Жишээ нь “та саяхан энэ хавьд нэн ховор амьтан болох бөхөн алагдсан талаар мэдэж байгаагаа надад хэлээч” гэж асууж болох юм. Тийм үгүй гэж хариулахаар асуулт нь ярилцагчтай цаашид хийх асуултуудын эхлэл болж чадахгүй хязгаарлагдах боломжтой. Аль бол ярилцагчаа тухайн сэдвээр чөлөөтэй ярилцлага явагдах эхлэл байх ёстой. Өөрөөр хэлбэл, ам халж цаашид ярих сэдэл өдөөхөөр байх хэрэгтэй.

Ярилцагчаа тухайн сэдвээр яриулахын тулд түүний хариултыг битгий тастаарай. Та зарим чөлөөтэй асуулт асуусныхаа дараа өвөрмөц асуултыг тавих хэрэгтэй. Жишээ нь, хэн бөхөн агнасан бэ? эсвэл энэ үед та хаана байсан бэ? г.м.

Та түүнээс бүх хариултаа авах хүртлээ онцгой асуултууд асууж үргэлжлүүлсээр байх хэрэгтэй. Хэрвээ худлаа ярьж байгаа бол та түүнийг худлаа ярьж байна гэж шууд хэлэх хэрэггүй. Худлаа ярьж байгааг сайн тэмдэглэж авсны дараагаар ижил асуулт асууж, ижил хариулж байгаа эсэхээр нь түүнийг шалгаж болно. Дараа нь харин ярилцагчдаа худлаа хэлж байгааг, яагаад гэдгийг хэлж болох юм. Та түүнд зөвхөн үнэнийг л хүсэж байгааг хэлэх хэрэгтэй.

Хүлээн авсан мэдээллээ баримтжуул. Хэрэвээ боломжтой бол ярилцагчийнхаа яриаг энгийн дуу хураагчид авч байх хэрэгтэй. Гэхдээ зарим хүмүүс дуу хураагч тавьсан үед чөлөөтэй ярьж чаддаггүй. Ярилцлагын дундуур гарч болохгүй, энэ нь тухайн ярилцагчаа үл хүндлэх, бодож төлөвлөж хариулах хугацаа олгох, анхаарал сарних, яг хэлье гэж бодож аман дээр тулж ирсэн үгээ “буцаан залгих” гэх мэт олон сөрөг талуудтай.

Ярилцахдаа хөтөлж асуухгүй байх. Харин чиглүүлэх зорилгоор зарим зүйлийг сануулан хэлж өгч болно. Ярилцахдаа “хэн, хэзээ, юуг, хаана, яагаад, яаж” гэсэн асуулт хариулт авахаар асуултаа төлөвлөн хариултаа авах хэрэгтэй.

Ярилцаж буй хүнийхээ худал хэлж буй эсэхийг мэдэхийн тулд дахин яриулах хэрэгтэй. Худлаа юм уу хэтрүүлэн ярьж буй хүмүүс ярьсан зүйлээ дахин яг тэр чигээр нь ярьж чаддаггүй. Худлаа ярьж байгаа хүмүүс нарийн ширийн зүйлсийг хэзээ ч хэлж чаддаггүй. Та ярилцлагын үед нарийн ширийн зүйлсийг мэдэхийг хичээх хэрэгтэй. Ярилцагчийнхаа санаа бодлыг сорих юм уу эсэргүүцэж болохгүй.

Асуулт хоорондын хугацааг урт байлгаж болохгүй. Хэрвээ асуултын хооронд хэт их зайтайгаар асуувал ярилцагч цаг хожиж өөрийнхөө хариултаа төлөвлөж эхэлдэг. Товч тодорхой сүрдүүлээгүй асуулт асуух. Та үг, үйлдлээрээ ярилцагчийнхаа нөхцөл байдал, санаа бодол, сонирхлыг нь ойлгож байгаагаа түүнд итгүүлэх хэрэгтэй. Биеэ барьж, уурлахгүй байх. Та биеэ барихгүйгээр уурлаж хэзээ ч болохгүй. Учир нь энэ байдал нь түүнд таныг аргандаа оруулах боломжтой юм байна гэсэн ойлголтыг өгнө.

Ярилцлагаа дуусгахгүйгээр ямар нэгэн зүйл бүү амла. Ямар нэгэн шийтгэл оногдуулахыг зөвхөн шүүх л шийднэ гэдгийг та санаж байх ёстой.

Ярилцлагын төгсгөл. Ярилцагчаас гарын үсэг зуруулж үнэн зөв бичсэн эсэхийг өөрөөр нь бичүүлж авах хэрэгтэй. Учир нь холбогдогч нар мэдүүлэгээ өөрчилдөг.

Холбогдогчтой ярилцах арга техник. Та холбогдогчид өөрт тань олон мэдээлэл байгаа түүнээс үнэнийг хэлэхийг хүлээж байгаагаа хэлж болно. Та бас түүнд хамтын ажиллагаа нь ялыг хөнгөрүүлэх боломжтойг хэлж болно. Гэсэн хэдий ч ямар нэгэн зүйл бүү амла.

Холбогдогчдын үйлдэл, түүний хамсаатнууд дээр анхаарлаа төвлөрүүлэх хэрэгтэй. Та хэн юуг хэзээ яаж яагаад гэсэн асуултуудад хариулт авахыг хичээх хэрэгтэй. Ялангуяа, холбогдогч худлаа ярьж байна гэж бодсон бол та түүнийг яриулаад байх хэрэгтэй, дараа нь та түүнд худлаа ярьсан гэдгийг нь ойлгомжтойгоор хэлэх хэрэгтэй. Холбогдогч дараа нь таныг бүхнийг мэдэж байгаа гэдэгт итгэснээр танд бүх үнэнийг хэлэхээр шийдэж болох юм.

Холбогдогчид зөвшөөрөхүйц санал тавих. Хэрвээ тэр зөвшөөрч байгаа, хууль зөрчсөн өөрийнхөн буруу гэдгийг хүлээж авахуйцаар тайлбарлаж өгсөн тохиолдолд холбогдогч буруугаа хүлээхэд бэлэн байдаг. Жишээ нь, холбогдогч улсын тусгай хамгаалалттай газар нутагт амьтан агнасан бол та энэ үйлдлийг өөрийнхөө гэр бүлийг тэжээхийн тулд хийсэн байх гэж хэлж болно. Хэдийгээр энэ нь худлаа байсан ч холбогдогч энэ шалтгааныг дэмжиж, үнэнээ хэлж магадгүй юм.

Буруугаа хүлээх. Хэрвээ холбогдогч буруугаа хүлээвэл түүнтэй санал нийлж, хэн нэгэн нь түүнийг хууль зөрчихийг хүчилсэн, тулгасан эсэхийг асуух хэрэгтэй.

Гэрэл зургийг үзүүлэх. Хэрвээ холбогдогч гэрэл зургийг хараад гэмт хэргийн дүр төрх харагдаж, тэрээр уг зөрчилд гүйцэтгэсэн үүргийн талаар үнэнээ хэлж магадгүй.

Хоёр үзүүртэй асуултыг ашиглах. Эдгээр асуулт нь хоёр боломжийн хариултуудыг агуулсан төдийгүй холбогдогчийн хамсаатнууд руу хүрэх замыг заадаг. Жишээлбэл, та буга агнахдаа буудаж алсан уу эсвэл занга тавьсан уу, эсвэл буга агнасныхаа дараа мах, эд эрхтэн (эвэр, сүүл, сав чив)-ийг нь зарсан уу? г.м.

Холбогдогчийн байр байдлыг шалгах. Ярилцлагын явцад та холбогдогчоос асуугдаж байхдаа юу мэдэрч байгааг асуух. Үүний дараа буруугүй хүн уурлах юм уу сандарч байснаа, тантай хамтран ажиллаж эхэлдэг. Харин буруутай хүн өөрийнхөн цагийг үрж байгаа, түүнийг доромжилж, эрхийг нь зөрчиж байна гэх мэт зүйл ярьсаар байдаг.

Та зарим мэддэггүй зүйлээ мэддэг юм шиг царайл. Та холбогдогчид тухайн хэргийг мэдэхгүй байгаа бодит байдлыг мэдэж байна гэж хэлж болно, үнэнд аль болох ойрхон байх хэрэгтэй.

Холбогдогчиийн ярьж буй байдал болон үйл хөдлөлөөр нь таних. Ихэнх хүмүүс төрийн байгууллагын ажилтантай ярилцаж байхдаа буруугүй байсан ч эхэндээ сандрах юм уу уурлах, уцаарлах байдал гаргадаг. Гэсэн хэдий ч буруугүй хүмүүс аажимдаа тайвширдаг бол гэмтнүүд улам л сандарна. Та хэн нэгнийг худлаа ярьж байна гэж буруутгалгүй хамтран ажиллах хэрэгтэй байгаагаа хэлээрэй.

Холбогдогчийн дараах байдлууд үнэнийг хэлж байгааг илтгэнэ. Үүнд:

- Ойлгогдохоор үндэслэлтэй хариулт өгч байх
- Цухалдаагүй, бардам ихэрхүү биш байж дөлгөөн намуухан байх
- Гэмт хэрэгт их санаа зовсон байх
- Чин сэтгэлээсээ хандаж байх
- Мэдээллээр хангахыг хүсч байх.

Дараах үйл хөдлөлүүд үнэнийг илтгэнэ. Үүнд:

- Цэх суусан
- Чөлөөтэй байдлаар суугаад амарч байх
- Санаандгүй бөхийсэн
- Ярилцагчийнхаа өөдөөс эгц харж суусан
- Байрлалаа чөлөөтэй өөрчилсөн.

Дараах байдлууд худлаа хэлж буйг харуулна. Үүнд:

- Ээрэх юм уу дуу хоолой чичирч байх
- Асуудлыг өөрчлөхийг оролдох
- Гэм буруугаа хэн нэгэн рүү түлхэх
- Халуун байна, ам цангаж байна эсвэл өвчтэй, бие нь муу байна гэж гомдоллох
- Эелдэг бус байх
- Хэт их инээх буюу инээмсэглэх
- Уурлах, өөрийгөө гүтгүүлсэн гэж хэлэх
- Сэтгэлийн дарамтад орж, гутарсан байх
- Бүгдийг ярихгүй байх
- Асуултад хуурмаг байдлаар хариулах
- Асуултад хариулж чаддаггүй
- Асуултад хариулахаас зайлсхийж, асуудлыг өөрчилж байх
- Ярилцагч хүнийхээ яриаг дуусгахаас өмнө асуултад хариулах
- Асуултыг дахин лавлах замаар хариултаа удаашируулах

- Юуг ч санахгүй байна гэж мэдүүлэх эсхүл хэт нарийн ширийн зүйлсийг санах (тэр гэмт хэрэг гарсан долоо хоногийн туршид юу хийж байснаа сайн санаж байдаг) юм уу үзүүлэх
- “Миний санаж байгаагаар” эсвэл “би ер нь яачихсан юм вэ” гэх мэтээр хариулах

Дараах үйл хөдлөлүүд нь холбогдогчийг худлаа ярьж байгааг илтгэнэ. Үүнд:

- Таны урдаас эгц харж чадахгүй байх
- Хөлрөх
- Гараа ихээр савчих
- Юм тонших юм уу гар хуруу, хөлөө байнга савчих
- Нүдээ дэндүү ихээр цавчих, эсвэл эвшээх
- Уруулаа долоох юм уу хазлах
- Үзэг харандаа мэтийн зүйлээр тоглох
- Дэндүү ихээр тамхи татах
- Хөлөө ачих юм уу гараа элгэндээ эвхэх
- Бөгтийх
- Хажуу тийшээ буюу жишүү харж суух
- Юу ч сонирхохгүй байгаа царай гаргах
- Байн байн байрлалаа солих
- Ярилцагчаасаа холдох
- Холхих.

Холбогдогч дараах байдал үзүүлбэл буруугаа хүлээх гэж байж магадгүй юм. Үүнд:

- Таныг хэр их зүйл мэдэж байгааг асуух
- Зөрчил гаргасан хүмүүст юу тохиолдсоныг асуух
- Хэрвээ тэр мэдүүлэг өгвөл түүнд юу тохиолдохыг асуух
- Энэ үйлдэл ямар нэгэн зөрчил биш гэж хэлэх
- Толгойгоо гудайлгаж, лаг хийтэл суух.

Төрийн алба хаагчийн ёс зүй. Ярилцлагын явцад таны гол зорилго бол үр ашигтай мэдээлэл бүрдүүлэх явдал юм. Биеийн болон оюун санааны хүчирхийллийг ямар ч тохиолдолд гаргахгүй байх. Тухайн хүнээр заналхийлгэсэн, айсан байх юм бол тэр байцаагчийн сонсмоор буй зүйлийг бодож хэлдэг бөгөөд яг үнэнийг хэлэхгүй.

Бодлого 1

Зөрчил гаргасан этгээд өөрийн үйлдсэн зөрчлийнхөө талаар үнэн зөвөөр хэлэхгүй байгаа тохиолдолд зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнаас ямар арга тактик хэрэглэх бэ? Арга тактикуудыг нэрлэнэ үү?

Бодлого 2

Зөрчлийн холбогдогчоос мэдүүлэг авахын өмнө ямар бэлтгэл ажлыг зохион байгуулсан байх ёстой бэ? холбогдогчоос мэдүүлэг авахын өмнө бэлтгэл ажлыг хангах нь хэр ач холбогдолтой бэ? энэ талаар өөрийн бодлоо танилцуулж хариулна уу?

Дадлага, дасгал

Амьтны тухай хууль зөрчих зөрчлийг шалгах ажиллагааны жишээ дээр дасгал ажлыг боловсруулав.

Хэсэг 1. Зөрчил шалгах ажиллагааны үе шат

Суралцагч та зөрчлийн хэрэг бүртгэх ажлыг амжилттай явуулах үе шатуудын талаар ойлголттой болж, лекцээр олж авсан мэдлэгээ бататгана. Ерөнхий танилцуулгаас дасгал ажлын зорилгыг ойлгож мэднэ.

Хэсэг 1.1. Ерөнхий танилцуулга. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа нь ихэвчлэн түүнийг амжилттай дуусгахад зориулагдсан мэдээлэл **цуглуулах, төлөвлөх, шалгах** гэсэн үе шаттай байна. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд зааснаар зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтан нь зөрчлийг илрүүлэх, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоох зорилгоор зөрчлийн хэргийн талаарх гомдол, мэдээлэл хүлээн авснаас хойш, зөрчлийн хэргийг шийдвэрлэх хүртэл энэ хуульд заасан ажиллагааг зөрчлийн хэрэг бүртгэлт гэнэ.

Үе шат бүр нь олон тооны төлөвлөлт зохицуулалтыг шаардана.

Багшийн зааварчилга: Суралцагч та өөрсдийн сонгож авсан жишээн дээр лекцийн хичээлээр олж авсан мэдлэгээ ашиглан хэрэг бүртгэх үе шатууд тус бүр дээр харьцуулан үзэж дасгалыг явуулна.

Хэсэг 1.2. Мэдээлэл цуглуулах үе шат (та хууль бус үйлдлийн талаар мэдээлэл хүлээн авах юм уу цуглуулна).

Алхам 1. Эхний мэдээллийг дүгнэх. Та мэдээллийг бусад мэдээллийн эх сурвалжуудтай **харьцуулан шалгах** ёстой. Заримдаа мэдээллийн эх сурвалжууд дэгсдүүлсэн юм уу худал мэдээлэл байж болзошгүй (мэдээллийн эх сурвалж сэдвээс уншаарай).

Алхам 2. Хууль бус үйлдлийн талаарх мэдээллийг бусад мэдээллийн эх сурвалжуудтай **хамтад нь шалгах.** Эхний олж авсан мэдээлэл төдийлөн хангалттай бус, тодорхой биш байж магадгүй.

Багшийн зааварчилга: Суралцагчдаас мэдээллийн эх сурвалжийн талаар асууж ямар мэдээллийг яаж шалгах талаар суралцагчаас асууна.

Алхам 3. Мэдээллийн эх сурвалжуудыг шалгаж хангалттай мэдээлэл олсон тохиолдолд төлөвлөлтийн ажлыг эхлүүлнэ (олон шалгах ажиллагаа мэдээлэл цуглуулах үе шат дээрээ төгсдөг. Учир нь хангалттай мэдээлэл байхгүй эсвэл тухайн үйлдлийг хууль бус гэж үзэж шийдвэр гаргадаг. Үүнийг анхаарах).

Хэсэг 1.3. Төлөвлөлтийн үе шат. Зөрчил илрүүлэхэд чиглэсэн төлөвлөгөөг боловсруулна.

Алхам 1. Мэдээллийг шалгах төлөвлөлтийг;

- Хойшлуулшгүй ажиллагааны хүрээнд хийх ажил
- Таамаглалыг шалгах ажлын хүрээнд явуулах ажил гэсэн байдлаар төлөвлөнө.

Алхам 2. Төлөвлөлтөд ажиллах хүч, шаардлагатай техник хэрэгсэл, дараагаар нь хэрхэн яаж явуулахыг шийднэ.

Алхам 3. Хүлээн авсан мэдээлэл дээр үндэслэн зөрчил шалгах ажлын явцад анхаарах нэн тэргүүнд хийх ажлыг жагсаана.

Алхам 4. Эрх бүхий албан тушаалтан нар ажил үүргээ хуваарилж авна.

Багшийн зааварчилга: Төлөвлөлт нь уян хатан байх ёстой. Учир нь зөрчлийн хэрэг шалгах ажилд өөрчлөлт орох, гэнэтийн зүйл тохиолдох явдал гардгийг сануулах.

Алхам 5. Төлөвлөлтөд учирч болох эрсдэлийг тодорхойлно.

Хэсэг 1.4. Шалгах үе шат. Мэдээллийн эх сурвалжийг шалгах зорилгоор үзлэг хийх, шинжилгээнд зориулж дээж, хуруулы хээ, ул мөрийн хэв авах, гэрчээс мэдүүлэг авах, хэрэгт ач холбогдол бүхий тээврийн хэрэгсэл, мөнгө, эд зүйлийг хураж авах, эд хөрөнгийг битүүмжлэх зэрэг ажиллагааг явуулна.

Алхам 1. Хойшлуулшгүй ажиллагааны хүрээнд дээрх ажиллагаануудаас сонгох эсвэл хослуулах, дараалан хийх зэргээр дасгалыг үргэлжлүүлэн явуулна.

Хэсэг 1.5. Асуулт, хариулт, үнэлгээ

Асуулт:

1. Зөрчил шалгах ажиллагааны үе шат гэж юу бэ?
2. Бүх ажлууд үе шатны дагуу явагддаг уу?
3. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны төлөвлөлт, бүх үе шатуудыг хэн удирдаж явуулах бэ?
4. Яагаад Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны үед гэнэтийн зүйл тохиолддог вэ?
5. Төлөвлөлтийг ямар хүрээнд явуулах бэ? нэрлэнэ үү.
6. Шалгах үе шатанд ямар ямар ажлуудыг хийх бэ?

Хариулт:

1. Мэдээлэл цуглуулах, төлөвлөх, шалгах гэсэн үе шатууд байна.
2. Үгүй. Олон хэрэг бүртгэх ажлууд нь мэдээлэл цуглуулах үе шатан дээр дуусгавар болдог. Учир нь эрх бүхий албан тушаалтан нар хангалттай мэдээлэл цуглуулаагүй эсвэл тэд үүнийг зөрчил биш гэж үзсэн байдаг.
3. Зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтан.
4. Зөрчил бүр өөр байдаг. Нөхцөл байдлын улмаас гэнэтийн зүйлс их тохиолддог.
5. Хойшлуулшгүй ажиллагаа, таамаглалыг шалгах ажлын хүрээнд гэж ангилан хийж болно.
6. Үзлэг хийх, шинжилгээнд зориулж дээж, ул мөрний хэв авах, гэрчээс мэдүүлэг авах, хэрэгт ач холбогдол бүхий тээврийн хэрэгсэл, мөнгө, эд зүйлийг хураж авах, эд хөрөнгийг битүүмжлэх.

Үнэлгээ: Энэ хэсэг нь үндсэн танилцах материал бөгөөд дээр дурдсан асуултуудад хариулахаас өөрөөр ямар нэгэн үнэлгээг шаардахгүй.

Хэсэг 2. Мэдээллийн эх сурвалж

Энэ хэсэгт мэдээллийн эх сурвалжууд, тэдгээрийг зөрчлийн хэрэг бүртгэх ажилд ашиглах. Суралцагчид мэдээллийн боломжтой эх үүсвэрүүдийн тухай, эх сурвалжуудыг хэрхэн бий болгох, ашиглах талаар мэддэг болно.

Хэсэг 2.1. Ерөнхий зүйл. Хууль бус үйлдлийн талаар мэдээлэл авах, дүн шинжилгээ хийх, түүнийг ашиглах нь зөрчлийг илрүүлэх, таслан зогсооход чухал ач холбогдолтой.

Алхам 1. Аливаа зөрчлийг илрүүлэхийг зорьж байгаа бол энэ талын мэдээлэл өөрөө аяндаа ирнэ гэж хүлээж болохгүй. Иймд мэдээллийн шинэ эх сурвалжуудыг олохын тулд дор дурдсан хүмүүстэй хэлхээ холбоо тогтоох хэрэгтэй. Мэдээллийн энгийн эх сурвалж:

- Тухайн газар нутгийн иргэд
- Мэдээлэгчид
- Цэргийн албан хаагчид
- Хууль хэрэгжүүлэгч бусад байгууллага, тэдгээрийн ажилтнууд (байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нар)
- Зар сурталчилгаа ба мэдээлэл
- Мэдээлэл олж авах ажиллагаа.

Багшийн зааварчилга: Мэдээллийн дээрх эх сурвалжуудыг ашиглан мэдээлэл бэлтгэх. Суралцагч нарт мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд нь туслах. Суралцагчид дээрх мэдээллийн эх сурвалжуудаас ямар нэгэн мэдээлэл ирж олон, тэдгээрт дүн шинжилгээ хийнэ.

Алхам 1.1. Нутгийн иргэдийн мэдээлэл. Нутгийн иргэд хууль бус үйлдэлд оролцоогүй бол тэдний амьдардаг газар оронд хууль бус ан агнуур, амьтны эд эрхтний худалдааны талаар мэдэж болох юм. Тэд хууль бус үйлдлийг хараагүй үед нарийн тодорхой мэдээлэлгүй амнаас ам дамжсан мэдээлэл байдаг.

Багшийн зааварчилга: Суралцагчдаас нутгийн иргэдтэй хэрхэн харилцаж, тэдний өөр хоорондоо ярьж буй мэдээллийг авч болох талаар санаа гаргаж өгнө.

Алхам 1.2. Мэдээлэгчид. Мэдээлэгчид гэдэг нь нууц ажилтнууд биш, зөвхөн хууль тогтоомжид заасны дагуу байгаль орчны хэрэг зөрчлийг илрүүлэхэд мэдээлэл өгч, хууль хяналтын байгууллагад туслалцаа үзүүлж байгаа иргэн юм. Байгаль орчны эсрэг хууль бус үйлдлийг мэдээлсэн иргэнд хэрэг зөрчилд оногдуулах торгууль, нөхөн төлбөрийн тодорхой хувийг олгохоор хуульчлагдсан.

Багшийн зааварчилга: Мэдээлэгчид яагаад ийм мэдээлэл өгч байгаад дүгнэлт хийх тал дээр суралцагч нарт анхааруулга өгнө.

Алхам 1.3. Цэргийн албан хаагчид. Цэргийн анги салбар нь үүрэгт ажлынхаа онцлогоос шалтгаалан янз бүрийн газар нутагт шилжин байршиж ажилладаг. Ялангуяа, хилийн цэргийн байгууллага. Хууль бусаар ан агнах, тэдгээрийн эд, эрхтнийг худалдаалах гэмт үйлдлүүд нь хил дамжин үйлдэгддэг болж, арга ажиллагаа нь улам нарийсаж байна.

Багшийн зааварчилга: Цэргийн алба хаагчид нь өөрсдөө энэ төрлийн хэрэгт хамтран оролцогч байж болзошгүйг суралцагч нарт мэдээлнэ.

Алхам 1.4. Хууль хэрэгжүүлэгч байгууллагын ажилтан. Хууль хяналтын байгууллагын ажилтнууд нь хариуцсан нутаг дэвсгэртээ байнгын хяналт шалгалт явуулахдаа хэрэг, зөрчлийн талаар сэжиг, таамаглал болон бусад нарийн мэдээлэлтэй болсон байдаг.

Багшийн зааварчилга: Төрийн хяналт шалгалт болон бусад байгууллагын ажил, үүргийн талаар суралцагчид мэдээлэл өгч тэдэнд санаа авах боломжийг нээнэ.

Алхам 1.5. Зар сурталчилгаа ба хэвлэл мэдээлэл. Сонин, сэтгүүл дээр гардаг зар сурталчилгаа нь зэрлэг амьтан, ургамлын хууль бус худалдааны цэг, иргэдийг илрүүлэхэд тусалж магадгүй юм.

Багшийн зааварчилга: Хэрэв зар сурталчилгааг уншсаныхаа дараа энэ нь хууль бус үйл ажиллагаа гэж бодвол яах ёстойг зөвлөнө. Үүнд баривчлахыг урьтал болговол томоохон сүлжээг илрүүлж чадахгүй орхигдуулах талтай учир худалдан авагч юм уу худалдаачин болж уулзаж ярилцах зэрэг арга уудыг санал болгоно.

Алхам 1.6. Мэдээлэл олж авах ажиллагаа. Мэдээлэл олж авахын тулд хууль сахиулах байгууллагын ажилтны явуулж байгаа идэвхтэй үйлдэл, үйл ажиллагаа (ажиглалт, эргүүл хяналт шалгалт г.м) байна.

Багшийн зааварчилга: Суралцагч нарт мэдээлэл бүрийн дагуу мөрдөн шалгах ажиллагааг хийж болохгүй. Заримдаа та баттай бус эх үүсвэрээс эсвэл цаашид шалгахад хангалттай бус мэдээлэл авч болох талаар сануулна. Суралцагч нарын боловсруулсан жишээн дээр үйл явцынхан талаар юу гэж бодож байгааг асуух. Алхам бүр дээр шийдвэрлэж байх ёстой ямар бэрхшээлүүд гарч болохыг асуух, хамтран ярилцах.

Асуулт:

1. Нутгийн иргэдэд хууль бус үйлдлийн талаар нарийн мэдээлэл байдаг уу? Яагаад иргэд мэдээлдэг бэ? Нутгийн иргэдээс амжилттай мэдээлэл авахын тулд та юу хийх хэрэгтэй бэ?
2. Яагаад цэргийнхнээс мэдээлэл авахдаа болгоомжлох хэрэгтэй бэ?
3. Хэрвээ та сониноос зэрлэг амьтны хууль бус зар үзвэл юу хийх бэ? Хэрвээ зах дээр хууль бус худалдаа явагдах тухай сонсвол юу хийх бэ?
4. Мэдээлэл хүлээн авсны дараа ямар асуултуудад та хариулах хэрэгтэй байдаг бэ?

Хариулт:

1. Үгүй. Тэдэнд хууль бус үйлдлийг үзэж хараагүй бол бодит мэдээлэл байхгүй гэсэн үг. Харин тухайн ам дамжсан яриаг өөр эх үүсвэрээр шалгаж баталгаажуулах хэрэгтэй. Нутгийн иргэдээс амжилттай мэдээлэл авахыг хүсвэл та тэдний итгэлийг олж харилцаа тогтоох хэрэгтэй. Итгэлтэй харилцаа тогтоохын тулд тэдэнд туслах, итгэл үнэмшлээ харуулах, ярилцах замаар харилцан нөлөөлнө. Хамтдаа сэтгэл зовж явдгаа илэрхийлнэ. Иргэд байгаль орчноо хайрлан хамгаалах сэтгэл зүрхтэй байдаг.
2. Тэдний зарим нь хууль бус ажиллагаанд оролцсон байж болзошгүй.
3. Худалдаачин болж, дүрээ хувирган бүх мэдээллийг олохын төлөө ажиллана. Баривчилгаа явуулахаар яарч болохгүй.
4. Хэн юуг хэзээ хаана яагаад яаж гэсэн асуултуудад хариулах хэрэгтэй болно.

Үнэлгээ: Багш суралцагч нарыг багуудад хуваарилна. Баг бүр ярилцлагыг удирдан явуулах ахлагчаа томилно. Багууд нь тухай газарт гарсан хууль бус агнуурын талаар мэдээлэлтэй хүмүүсийн дүрд тоглоно. Мэдээллээ ашиглан багууд мэдээллээ баримтжуулж, багшид танилцуулна. Багш баг тус бүрд үнэлгээ өгнө.

Хэсэг 3. Ярилцлагын арга техникүүд

Хэсэг 3.1. Ерөнхий зүйл. Зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтан нар ярилцаж байхдаа бусдыг итгүүлэх чадвараа хөгжүүлэх хэрэгтэй. Нэг ярилцлагаар шийдэгдсэн болон шийдэгдээгүй хэргүүдийн хоорондын ялгааг гаргаж ирж болдог.

Эрх бүхий албан тушаалтан та ярилцахдаа ямар асуулт тавих, яаж асуухаа мэддэг байх хэрэгтэй. Та түүнд болон мэдээлэлд нь итгэх эсэхээ мэддэг байх хэрэгтэй.

Холбогдогч нартай ярилцах арга техникүүд. Зөв ярилцлагын техникүүдээр та амжилттай ярилцлага явуулахад шаардагдах ур чадвар болон өөртөө итгэлтэй байх чанараа хөгжүүлдэг.

Хэсэг 3.2 Ярилцлага

Алхам 1. Зөрчлийн тухай мэдээллийг та хүлээн авч болно. Тиймээс мэдээлэгчээс асуухыг хүсэж байгаа асуултаа жагсаан бичнэ.

Ярилцлага нь ерөнхий асуултуудаар эхэлж, дараа нь өвөрмөц онцгой асуултууд руу шилжинэ. Яагаад ярилцагч мэдээлэл өгсөндөө урам зоригтой байх вэ гэдгийг эргэцүүлэн бодох. Хэрвээ худлаа яриад байгааг та мэдвэл түүнийг бодлыг өөрчлөх хэрэгтэй.

Алхам 2. Ярилцлага эхлэх. Ярилцагчийн эгц өөдөөс нь харж суугаад биеэ суллан чөлөөтэй, нээлттэй сууна. Та хөлөө ачих юм уу гараа элгэндээ тэвэрч болохгүй. Чөлөөтэй нээлттэй байх нь түүний хэлж ярихыг сонсох хүсэлтэй байгааг илтгэнэ. Ярилцлага ярилцагчтайгаа мэндэлж, өөрийгөө танилцуулснаар эхэлнэ. Ярилцагч руугаа харах хэрэгтэй боловч ширтэж болохгүй гэх мэт техникүүдийг эзэмших.

Алхам 3. Ярилцлагын үед. Ярилцагчаас бололцоотой мэдээллүүдээ авахыг хичээх. Та няхуур байх, ярилцлагын дундуур гарч явж болохгүй. Хүмүүс дуу хураагч тавьсан үед чөлөөтэй ярьж чаддаггүй. Энэ тохиолдолд та тэмдэглэл хийх хэрэгтэй. Тэмдэглэл хийж байхдаа “хэн хэзээ юуг, хаана, яагаад” гэсэн асуултуудад хариулт авч байх хэрэгтэй.

Алхам 4. Холбогдогчтой ярилцах. Ихэнх хүмүүс худлаа ярьж байгааг нь тийм амархан илрүүлдэггүй. Худлаа ярих юм уу хэтрүүлж байгаа хүмүүс ярьсан зүйлээ яг тэр чигээр нь дахин ярьж чаддаггүй. Ярилцагчийн санаа бодлыг сорих юм уу эсэргүүцэж болохгүй. Асуулт хоорондын хугацааг урт байлгаж болохгүй. Хэрвээ та асуултуудаа хооронд нь хэт их зайтайгаар асуувал ярилцагч цаг хожиж өөрийнхөө хариултуудаа төлөвлөж эхэлдэг.

Холбогдогчийг ярьж буй байдал, үйл хөдлөлөөр нь таних. Тэд ярилцаж байхдаа гэм буруугүй ч гэсэн эхэндээ сандрах, уурлаж уцаарлах байдал гаргадаг.

Багшийн зааварчилга: Суралцагч нарт хүнтэй харилцах, ярилцлагын техникүүдийн янз бүрийн хувилбарыг өмнө үзэж байсан хичээлтэй нь холбогдуулан сануулах, сэргээх, санаа өгнө.

Хэсэг 3.3. Асуулт, хариулт, үнэлгээ.

Асуулт:

1. Ярилцлагын явцад та гол асуух гол асуултуудаа мэдэж байна уу?
2. Таныг мэдээллээр хангаж байгаа хүнийхээ мэдээлэл өгч байгаа шалтгааныг мэдэх нь яагаад чухал байдаг вэ?
3. Таны ярилцлагыг эхлэх үед холбогдогч маш ихээр сандарч, биеийн байрлалаа хэд хэдэн удаа сольж байна. Энэ нь түүний буруутайг илтгэх үү?
4. Ярилцлагын үед холбогдогч таны асуусан асуултуудыг олон удаа давтан асууж байна. Яагаад?

5. Холбогдогч таны өмнө гараа элгэндээ тэвэрч суугаад маш товчхон хариулт өгч байна. Энэ юу гэсэн үг бэ?

Хариулт:

1. Хэн юуг хаана, яагаад, яаж. Мэдээллийг авахдаа их анхааралтай, нямбай байж тэвчээртэй хандана.
2. Асуудлыг шийдвэрлэхэд чухал.
3. Заавал тийм байх албагүй. Гэмгүй хүмүүс ч ярилцлагын эхэнд маш их сандарч бухимддаг. Гэхдээ ярилцлагын явцад тэд хурдан тайвширдаг.
4. Цаг хожих буюу хариултаа бодох хугацаа гаргаж байна.

Үнэлгээ: Суралцагч нарыг 2 багт хуваана. Баг бүр ярилцлагыг удирдан явуулах багийн ахлагчаа томилно. Өөрсдийн зохиосон кейс дээр мэдээлэгч, холбогдогч, гэрч нарын ярилцлагыг 30 минут явуулах, үр дүнгээ багшид тайлагнана. Багш баг тус бүрд үнэлгээ өгнө.

Хэсэг 4. Нотлох баримтууд ба тэдгээрийг бүрдүүлэх

Хэсэг 4.1. Ерөнхий зүйл. Зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааны зорилго нь зөрчлийн шинжийг илрүүлж, нотлох баримтыг цуглуулан бэхжүүлэх ажиллагаа болон холбогдогчийг олж тогтооход оршино.

Хэсэг 4.2. Нотлох баримтыг илрүүлэх, цуглуулах, бэхжүүлэх ажиллагаа.

Алхам 1. Энэ төрлийн зөрчил ихэвчлэн хөдөө алс зэлүүд газарт үйлдэгддэг, үйлдэгдсэн даруйдаа тэр бүр хууль хяналтын байгууллагад мэдээлэл ирдэггүй, ирсэн ч хугацаа алдаж ирдэг. Зөрчлийн талаар мэдээ хожуу хүлээн авч байгаагаас холбогдогчийг тэр дор нь шалгах боломж багасдаг.

Алхам 2. Нотлох баримтыг илрүүлэх цуглуулах гол ажил нь үзлэг явуулах. Үзлэг явуулснаар хэрэгт ач холбогдолтой зүйлүүдийг тодорхойлж, нотлох баримтыг цуглуулна.

Алхам 3. Холбогдогчийн тодорхойлохыг оролдох. Хэрэв зөрчил гаргагч холбогдогч нь хэн болох нь мэдэгдэхгүй байгаа үед буруутай этгээдийг олж тогтоох шаардлага үүснэ. Ихэнх зөрчил зөрчил гаргасан хүн, хуулийн этгээд тэр дороо ил байдаг учраас холбогдогчийг хайх ажил тэр бүр хийгдэхгүй. Гэсэн ч зарим зөрчилд зөрчлийг хэн үйлдсэн нь тодорхой байх тохиолдол байдаг.

Алхам 4. Үзлэг нь тодорхой үе шаттайгаар явагдана. Үүнд:

а) Бэлтгэл үе шат буюу зөрчил болсон газарт хүрч очих үе
б) Үзлэг явуулах үе шат
в) Төгсгөлийн үе шат –үзлэгийн дүнг бэхжүүлэн авах.

Алхам 5. Үзлэгээр илрүүлсэн зүйл. Үзлэгээр илэрч байгаа зүйлийг дараах байдлаар хуваан үзнэ. Амьтны тухай хууль зөрчих зөрчлийн жишээ дээр:

а) Амьтны холбогдол бүхий эд мөрийн баримт. Түүнд амьтны сэг зэм болох арьс, мах, үс ноос, толгой шийр, эвэр, цус зэрэг биологийн гаралтай эд зүйл, амьтны биед үүсэн гэмтэл
б) Зөрчил үйлдэхдээ ашигласан багаж хэрэгсэлтэй холбогдол бүхий эд мөрийн баримт. Амьтныг алах, төхөөрөхөд хэрэглэсэн багаж зэвсэг, хутга мэс, олс дээсний тасархай, сумны хошуу, хонгио зэрэг орхигдож, гээгдсэн эд зүйлс. Зөрчлөө нуун далдлах болон ашигласан тээврийн хэрэгсэл, морь малын хөлийн мөр.

в) Бусад эд зүйл. Холбогдогчийн үлдээсэн тамхины иш болон гутлын мөр, хувийн эд зүйлс. Ашигласан автомашины шатах тослох материалын дуссан асгарсан мөр, гал түүдэг асаасан ором зэрэг болно.

Багшийн зааварчилга: Суралцагч нарт тодорхой кейс өгч нотлох бариmтыг бүрдүүлэх талаар даалгавар өгч ажиллуулна. Өмнө үзсэн хичээлийг сэргээн санаж даалгаврыг гүйцэтгэхийг сануулна.

Хэсэг 4.3. Асуулт, хариулт, үнэлгээ.

Асуулт.

1. Зөрчил үйлдэгдсэн даруйдаа яагаад хууль хяналтын байгууллагад ирдэггүй вэ?
2. Үзлэг нь нотолгооны гол эд мөрийн баримтыг илрүүлэх хэрэгсэл мөн үү?
3. Үзлэгийн ач холбогдол юу вэ?
4. Үзлэгээр илрүүлсэн зүйлийг нотолгоо болгохоос гадна, өөр ямар байдлаар ашиглах боломжтой бэ?

Хариулт:

1. Хөдөө хээр эзгүй газарт хууль бус үйлдлүүд ихэвчлэн явагддаг.
2. Зөрчлийн газрын үзлэг нь эд мөрийн баримтыг илрүүлэх үндсэн хэрэгсэл мөн болно. Үзлэгээр зөрчил үйлдэгдсэн арга, хэн үйлдсэн, зорилго, аль чиглэлд явсан зэрэг чухал мэдээллүүдийг өгнө.
3. Зөрчлийг ихэвчлэн халуун сэргэг дээр нь буюу үйлдэж байхад нь илрүүлэх боломжоор тааруу учраас үзлэгээр өнгөрснийг сэргээн бодит байдлыг тогтоож болдгоор чухал ач холбогдолтой.
4. Тэдгээр нотлох баримтыг яллагдагчийг байцаах тактик боловсруулахад ашиглах нь үр дүнтэй.

Үнэлгээ: Багш суралцагч нарыг багуудад хувааж, баг бүрд зөрчил шалгах ажлын үед олдсон нотлох баримтуудын нэрсийн жагсаалтыг өгнө. Багууд өөрсдийн хэрэг шалгах ажиллагааныхаа эхнээс төгсгөл хүртэл хийх ажлуудыг 30 минутад багтаан хийх болно. Баг бүр үр дүнгээ ангийнхандаа тайлагнана

Хэсэг 5. Зөрчил шалгах ажиллагаа

Хэсэг 5.1. Ерөнхий зүйл. Зөрчил шалгах ажиллагаагаар зөрчил гарсан байдал, үйлдсэн этгээд хэн болохыг тогтоох, зөрчлийн сэдэлт, гэм буруугийн хэлбэр, учирсан хохирол, хэмжээ, холбогдогчийн хувийн байдал, түүнд хүлээлгэх хариуцлагын хэр хэмжээ шинж чанарт нөлөөлөх нөхцөлүүдийг тогтоох ёстой.

Алхам 1. Зөрчил гарсан байдал. Хэзээ, хаана, яаж үйлдсэн бэ гэсэн асуултуудад хариулт өгнө. Зөрчил гарсан эсэхийг нарийвчлан тогтоохын тулд тодорхой ажиллагааг хийнэ. Үүнд, зөрчил гарсан газрыг тогтоох ёстой. Зөрчил үйлдэгдсэн даруйдаа илэрсэн асуудлыг хамааруулаагүй болно.

Алхам 2. Зөрчлийн хэрэгт тогтоох зайлшгүй өөр нэг шаардлагатай зүйл бол цаг хугацаа юм. зөрчил хэдийд гарсныг тогтоох нь чухал.

Алхам 3. Зөрчлийг хэн үйлдсэн. Буруутай этгээдийг олж тогтоох нь зөрчил шалгах ажиллагааны чухал хэсэг болно.

Алхам 4. Сэдэлт, зорилго, гэм буруу. Бурууг тогтооход холбогдогч этгээдийн зорилго, сэдэлтийг тогтоох ёстой.

Алхам 5. Зөрчил үйлдсэн аргыг тогтоох нь нотолбол зохих асуудлуудын нэг юм. Зөрчлийг холбогдогч этгээд үйлдэхдээ хориглосон арга, зэвсэг хэрэгслээр үйлдсэн эсэхийг тогтоох ёстой.

Алхам 6. Хохирлын хэмжээ, шинж чанар. Зөрчлийн хэрэг бүртгэлтийн дараагийн шатанд хийгдэх ёстой асуудлын нэг нь зөрчлийн улмаас учирсан хохирол, түүний хэмжээг тогтоох тухай юм.

Алхам 7. Шийтгэл нь гарцаагүй байх ёстой.

Багшийн зааварчилгаа: Суралцагч нарт тодорхой хэргийн жишээ өгч өөрсдөөр нь дээрх ажиллагааг нэг бүрчлэн хийлгэж, хооронд хамтран ярилцана.

Хэсэг 5.2. Асуулт, хариулт, үнэлгээ

Асуулт:

1. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны гол зорилго юу бэ?
2. Зөрчлийн хэргийн цаг хугацааг тогтоох нь ямар ач холбогдолтой бэ?
3. Зөрчил үйлдсэн бурууталй этгээдийг олж тогтоох нь нэн тэргүүний ажил мөн үү?
4. Хохирлын хэмжээг заавал тогтоох үү?
5. Шийтгэлийг хэрхэн оногдуулах бэ?

Хариулт:

1. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны гол зорилго нь зөрчил үнэхээр гарсан эсэхийг илрүүлж, зөрчлийг хэн үйлдсэнийг тогтоох зорилготой.
2. Хэргийн цаг хугацааг тогтоох нь зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд чухал нөлөөтэй. Ажлаа хуваарилах, зөрчлийн хэргийн хөөн хэлэлцэх хугацаа байгаа эсэх гэх мэт.
3. Нэн тэргүүний ажил нь зөрчил мөн эсэхийг тогтоох юм.
4. Хохирлын хэмжээг тогтоох нь хохирол нөхөн төлүүлэхэд чухал шаардлагатай.
5. Зөрчил үйлдсэн бол шийтгэл нь гарцаагүй. Зөрчлийг зөв зүйчлэх шаардлагатай.

Үнэлгээ: Суралцагч нэг бүрийн хийсэн даалгаварт багш үнэлгээ өгнө.

Мэдлэг сорих тест

1. Зөрчил шалгах ажиллагааны бүрдэл аль нь болохыг дугуйл.
   а. Газар, хүн, хуулийн этгээдийн эзэмшил газар, барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, хүний бие, эд зүйлд үзлэг хийх
   б. Баримт бичиг, мэдээлэл гаргуулан авах, эд зүйл, баримт бичгийг хураан авах
   в. Эд хөрөнгийг битүүмжлэх, мэдүүлэг авах, шинжилгээнд зориулж хэв загвар, дээж авах, шинжилгээ хийлгэх ажиллагаа
   г. Дээрх бүгд

2. Үзлэг хийх зорилтыг тодорхойлно уу.
   а. Зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг тогтоох зорилгоор үзлэг хийнэ
   б. Зөрчлийг шүүхэд шилжүүлэх зорилгоор үзлэг хийнэ
   в. Зөрчлийн шийтгэл оногдуулах зорилгоор үзлэг хийнэ
   г. Зөрчлийн шийтгэл оногдуулахад эд зүйлийг хураах зорилгоор үзлэг хийнэ.

3. Хүний биед үзлэг хийх эрхгүй албан тушаалтан аль нь вэ?
   а. Хилийн төлөөлөгч, орлогч, туслагч
   б. Цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч
   в. Гаалийн улсын байцаагч
   г. Улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч

4. Мал, амьтанд үзлэг хийхэд хэнийг байлцуулах вэ?
   а. Эзэмшигчийг байлцуулна
   б. Эзэмшигч заавал байлцах шаардлагагүй
   в. Төрийн алба хаагчийг байлцуулна
   г. Шинжээчийг заавал байлцуулна

5. Үзлэг хийлгэхээс татгалзсан, эсэргүүцэл үзүүлсэн бол үзлэгийг … .
   а. Албадан гүйцэтгэнэ
   б. Үзлэгийг хойшлуулна
   в. Прокурорт мэдэгдэнэ
   г. Шүүхэд хандана

6. Үзлэг хийх явцад шаардлагатай бол …….. явуулж болно.
   а. Шинжилгээнд зориулж хэв загвар, дээж авах
   б. Эд хөрөнгө битүүмжлэх
   в. Эд зүйл, баримт бичиг хураан авах ажиллагаа
   г. Дээрх бүгд

7. Үзлэг хийх явцад хүний амь нас, эрүүл мэндэд аюул, орчинд хөнөөл учруулж болзошгүй тэсэрч дэлбэрэх болон химийн хортой бодис, бусад эд зүйл байна гэж үзвэл?
   а. Холбогдох мэргэжилтнийг оролцуулж болно
   б. Үзлэг хийхгүй орхино
   в. Энэ талаар эрх бүхий байгууллагад мэдэгдэж үзлэгийг зогсооно
   г. Шүүхэд нэн даруй мэдэгдэнэ

8. Орон байранд үзлэг хийхэд хэнээс зөвшөөрөл авах бэ?
   а. Прокуророос зөвшөөрөл авна
   б. Харьяалах даргаасаа зөвшөөрөл авна

в. Шүүхээс зөвшөөрөл авна
г. Аль ч биш

9. Эд зүйл, баримт бичиг, ачаа тээш, мал, амьтан, тээврийн хэрэгсэлд үзлэг хийхэд эзэмшигчийг оролцуулах боломжгүй бол?
а. Хөндлөнгийн гэрчийг байлцуулах
б. Гэрэл зураг, дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлэх
в. “а”, “б” хоёр
г. Зөвхөн “а” мөн

10. Мэдээллийн эх сурвалж гэдэгт юуг хамааруулах бэ?
а. Иргэдийн мэдээлэл
б. Төрийн байгууллагуудын мэдээлэл
в. Олон нийтийн мэдээлэл, зар сурталчилгаа
г. Дээрх бүгд

11. Иргэдийг байгаль орчноо хамгаалахад эдийн засгийн ямар урамшуулал эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдсан бэ?
а. Үнэн бодит мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд өгсөн иргэнд зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн орлогын дүнгийн 15 хувьтай тэнцэх мөнгөн урамшууллыг сум, дүүргийн Засаг дарга байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос олгоно.
б. Үнэн бодит мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд өгсөн иргэнд зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн орлогын дүнгийн 20 хувьтай тэнцэх мөнгөн урамшууллыг сум, дүүргийн Засаг дарга байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос олгоно.
в. Үнэн бодит мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд өгсөн иргэнд зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн орлогын дүнгийн 5 хувьтай тэнцэх мөнгөн урамшууллыг сум, дүүргийн Засаг дарга байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос олгоно.
г. Үнэн бодит мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд өгсөн иргэнд татвараас хөнгөлж, чөлөөлөх шийдвэрийг сум, дүүргийн Засаг дарга гаргаж, татварын байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос олгоно.

12. Цагдаагийн байгууллагын ажилтан зөрчлийн тухай хуульд заасан байгаль орчны зөрчлийг шалгах эрх бүхий албан тушаалтан мөн эсэх?
а. Зөрчил шалган шийдвэр тухай хуулиар цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч байгаль орчны талаарх зарим зөрчлийн холбогдох хэсгийг шалгах эрхтэй байдаг.
б. Байгаль орчны талаарх зөрчилд цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах эрхгүй.
в. Байгаль орчны талаарх зөрчил шалгуулахаар Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тушаал гаргаж томилсон бол болно.
г. Байгаль орчны талаарх зөрчил шалгуулахаар тухайн орон нутгийн Засаг дарга хүсэлт гаргасан бол болно.

13. Байгалийн баялгийг хууль бусаар ашигласан, гэмтээсэн, хөнөөж сүйтгэсэн үйлдлийг олж мэдсэн иргэн ……. нэн даруй мэдэгдэх үүрэг хүлээнэ.
а. Тухайн орон нутгийн Засаг дарга, улсын байцаагч, байгаль хамгаалагч нарт
б. Тухайн орон нутгийн Засаг дарга, улсын байцаагч, байгаль хамгаалагч, цагдаагийн ажилтан нарт

в. Тухайн орон нутгийн улсын байцаагч, байгаль хамгаалагч нарт
г. Тухайн орон нутгийн Засаг дарга, цагдаагийн ажилтан нарт

14. Байгаль хамгаалагч дараах үүрэгтэй. Үүнд:
а. Хариуцсан нутаг дэвсгэртээ байгаль орчинд учирч болзошгүй аюулаас сэргийлэх, байгалийн баялгийг хамгаалах арга хэмжээ авах
б. Хууль тогтоомжид заасан тохиолдолд байгалийн баялгийн нөөц ашиглах эрхийн бичиг олгох
в. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад гэрээ, зөвшөөрлийн дагуу тухайн баялгийг ашиглах газрыг зааж өгөх, хяналт тавих
г. Дээрх бүгд

15. Байгаль орчны зөрчил гаргасан иргэн зөрчлөө илчлэн мэдээлж болох уу?
а. Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд үйлдсэн зөрчлөө сайн дураараа илчилсэн мэдээллийг бичгээр болон амаар гаргаж болно.
б. Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд үйлдсэн зөрчлөө сайн дураараа илчилнэ гэсэн ойлголт байхгүй.
в. Зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзана.
г. Зөрчлийг шууд хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэнэ.

16. Хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх үндэслэл аль нь вэ?
а. Зөрчил үйлдэгдсэн нь ил тодорхой, зөрчил, учирсан хохирлыг нотлох талаар зөрчлийн хэрэг бүртгэлт явуулах шаардлагагүй бол
б. Зөрчил үйлдэгдсэн, учруулсан хохирол нь нотлох баримтаар тогтоогдож холбогдогч зөрчил үйлдсэнээ сайн дураараа хүлээн зөвшөөрсөн бол
в. Зөрчил үйлдсэн болох нь стандартаар баталгаажсан хэмжилт-хяналтын төхөөрөмжөөр нотлогдсон бол
г. Дээрх бүгд зөв

17. Эрх бүхий албан тушаалтан ямар зорилгоор мэдүүлэг авдаг бэ?
а. Зөрчил гарсан байдлыг тодруулах
б. Зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдол бүхий баримт, мэдээллийг олох
в. Зөрчлийн холбогдогчийг тогтоох
г. Эхний хоёр асуулт нь зөв

18. Холбогдогчоос мэдүүлэг авахын өмнө ямар ажиллагаа хийх бэ?
а. Түүнд үнэн зөв мэдүүлэг өгөхийн ач холбогдлыг тайлбарлаж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаатай холбоотой нууцыг хадгалах талаар мэдэгдэнэ.
б. Түүнд зөвхөн үнэн зөв мэдүүлэг өгөхийн ач холбогдлыг тайлбарлаж өгнө.
в. Түүнд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаатай холбоотой нууцыг хадгалах талаар мэдэгдэнэ.
г. Түүнээс гарын үсэг зуруулж авна.

19. Холбогдогчийн зөрчлийг шалгахаар хэрхэн ирүүлж болох вэ?
а. Холбогдогчийг дуудах хуудсаар эсхүл харилцаа холбооны хэрэгсэл ашиглан дуудна.
б. Харьяалах сум дүүргийн Засаг даргын тамгын газарт мэдэгдэж, тэднээр дамжуулан дуудна.
в. Цагдаагийн байгууллагад мэдэгдэж, авчруулна.
г. Холбогдогчийн хамаарал бүхий хүмүүст хэлж мэдэгдэн, тэднээр дамжуулан дуудна.

20. Зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдол бүхий хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан аливаа баримт мэдээлэл зөрчлийн нотлох баримтыг нэрлэнэ үү.

а. Гэрч, хохирогч, холбогдогчийн мэдүүлэг
б. Бичмэл болон эд мөрийн баримт
в. Баримт бичиг, шинжээчийн дүгнэлт, мэдүүлэг
г. Дээрх бүгд

21. Эрх бүхий албан тушаалтан мэдүүлгийг ямар хэлбэрээр явуулж болох вэ?

а. Асуулт асууж, хариулт авах
б. Харилцан ярилцах
в. Аль нь ч биш
г. Хоёрдох асуулт нь мөн

22. Мэдүүлэг өгч байгаа хүн санахад төвөгтэй зүйлийн талаар мэдүүлэг өгөх бол баримт бичиг, бичлэг ашиглаж болох уу?

а. Эрх бүхий албан тушаалтны зөвшөөрснөөр баримт бичиг, бичлэг ашиглаж болно.
б. Болохгүй, хөтөлсөн асуулт болно.
в. Эрх бүхий албан тушаалтан баримт бичиг, бичлэг ашиглах талаар зөвшөөрөхгүй.
г. Хуульд тийм заалт байхгүй.

23. Мэдүүлэг авах ажиллагаа хэдэн цаг үргэлжилж болох вэ?

а. Нэг удаагийн мэдүүлэг авах ажиллагаа нийт 6 цагаас хэтэрч болохгүй
б. Нэг удаагийн мэдүүлэг авах ажиллагаа нийт 4 цагаас хэтэрч болохгүй
в. Нэг удаагийн мэдүүлэг авах ажиллагаа нийт 3 цагаас хэтэрч болохгүй
г. Нэг удаагийн мэдүүлэг авах ажиллагаа нийт 8 цагаас хэтэрч болохгүй

24. Мэдүүлгийг шөнийн цагаар авч болох уу?

а. Мэдүүлгийг шөнийн цагаар авахыг хориглоно.
б. Зөрчлийн ул мөр устах, холбогдогч оргон зайлж болзошгүй үед болно
в. Дээрх хоёр хариултын аль ч биш
г. Зөвхөн хоёр дахь хариулт нь зөв

25. Арван найман насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авахдаа хэнийг байлцуулах бэ?

а. Арван найман насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авахдаа түүний хууль ёсны төлөөлөгчийг байлцуулна.
б. Арван найман насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авахдаа түүний хууль ёсны төлөөлөгч, эсхүл өмгөөлөгч, шаардлагатай тохиолдолд сурган хүмүүжүүлэгч, сэтгэл зүйч, нийгмийн ажилтны аль нэгийг байлцуулна.
в. Арван найман насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авахдаа түүний өмгөөлөгчийг байлцуулна.
г. Арван найман насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авахдаа түүний сурган хүмүүжүүлэгч, сэтгэл зүйч, нийгмийн ажилтны аль нэгийг байлцуулна.

26. Зөрчлийн хэрэг бүртгэлтийг дуусгахад гаргах шийдвэр аль нь вэ?

а. Хариуцлага ноогдуулах
б. Сануулга өгөх
в. Шийтгэл оногдуулах
г. Арга хэмжээ авах

27. Эрх бүхий албан тушаалтан зөрчлийг шалган тогтоох зорилгоор зөрчил үйлдэхэд ашигласан зэвсэг, хэрэгслийг хураан авах эрхтэй юу?

а. Эрх бүхий албан тушаалтан зөрчлийг шалган тогтоох зорилгоор зөрчил үйлдэхэд ашигласан зэвсэг, хэрэгслийг зөвхөн прокурорын зөвшөөрлөөр хураан авах эрхтэй

б. Эрх бүхий албан тушаалтан зөрчлийг шалган тогтоох зорилгоор зөрчил үйлдэхэд ашигласан зэвсэг, хэрэгслийг шүүхийн зөвшөөрлөөр хураан авах эрхтэй

в. Эрх бүхий албан тушаалтан зөрчлийг шалган тогтоох зорилгоор зөрчил үйлдэхэд ашигласан зэвсэг, хэрэгслийг хураан авах эрхтэй

г. Эрх бүхий албан тушаалтан зөрчлийг шалган тогтоох зорилгоор зөрчил үйлдэхэд ашигласан зэвсэг, хэрэгслийг хураан авах эрхгүй.

28. Хураан авсан эд зүйлийн тэмдэглэлийг хэнд гардуулан өгөх бэ?

а. Хураан авсан эд зүйлийн тэмдэглэлийг эд зүйлийн эзэмшигч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид даруй гардуулна.

б. Хураан авсан эд зүйлийн тэмдэглэлийн хувийг эд зүйлийн эзэмшигч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид даруй гардуулна.

в. Хураан авсан эд зүйлийн тэмдэглэлийн хувийг эд зүйлийн эзэмшигчид даруй гардуулна.

г. Хураан авсан эд зүйлийн тэмдэглэлийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид даруй гардуулна.

29. Хураан авах эд хөрөнгө нь овор хэмжээ, эсхүл бусад шалтгаанаар зөрчлийн хэрэгт хадгалах боломжгүй бол байгаа газарт нь битүүмжилж болох уу?

а. Хураан авах эд хөрөнгө нь овор хэмжээ, эсхүл бусад шалтгаанаар зөрчлийн хэрэгт хадгалах боломжгүй бол байгаа газарт нь битүүмжилж болохгүй алдагдах аюултай.

б. Зөрчлийн тухай хуульд тийм заалт байхгүй

в. Хураан авах эд хөрөнгө нь овор хэмжээ, эсхүл бусад шалтгаанаар зөрчлийн хэрэгт хадгалах боломжгүй бол байгаа газарт нь битүүмжилнэ.

г. Хураан авч байгаа эд хөрөнгийг битүүмжлэх шаардлагагүй.

30. Шинжилгээнд зориулж авсан хэв загвар, дээжийг хадгалах сав баглаа боодол ямар байх бэ?

а. Хадгалах сав, баглаа боодол нь стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан “Цаасан уут”, “Сав баглаа боодол”, “Нийлэг хальсан уут”-ны стандартыг хангасан байна.

б. Хадгалах сав, баглаа боодол нь стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан зөвхөн “Цаасан уут” байна.

в. Хадгалах сав, баглаа боодол нь стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан зөвхөн “Цаасан уут”, “Сав баглаа боодол” байна.

г. Гуравдах хариулт нь зөв

31. Түргэн муудах, эмзэг бүтээгдэхүүний болон гэмтэж, устаж, ялзарч болзошгүй эд мөрийн баримтыг хэрхэн хадгалах бэ?

а. Түргэн муудах, эмзэг бүтээгдэхүүний болон гэмтэж, устаж, ялзарч болзошгүй хэв загвар, дээжийг бэхжүүлсний дараа хатаах, үнэрийг нь арилгах арга хэмжээг авч зориулалтын сав баглаа боодолд

б. Биологийн гаралтай хэв загвар, дээж болох хатаасан цусыг тасалгааны температурт, цус цусан бүтээгдэхүүн, үрийн шингэн, шүлс, шээс, өтгөн, ходоодны агууламж (амьтны), яс (амьтны) зориулалтын хөргөгчид, үс хумс, эд, эс, зэрэг

бусад зүйлийг зориулалтын цаасан хайрцагт, эсхүл шилэн саванд

в. Түргэн гэмтэх, хадгалалтын онцгой нөхцөл шаардагдах бараа бүтээгдэхүүн, сорьц, үржүүлгийн бүтээгдэхүүний онцлогт тохирсон хэмийг хангаж зориулалтын сав, төхөөрөмж, хөргөгч, хөлдөөгчид

г. Дээрх бүгд

32. Хэв загвар, дээжийг тээвэрлэх тээврийн хэрэгсэл аль шаардлагыг хангасан байх ёстой вэ?

а. Хэв загвар, дээжийг тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь стандарт, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан байна.

б. Хэв загвар, дээжийг тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь гадна орчны нөлөөлөл (цас, бороо, нар, салхи, шороо, тоос, чийг г.м)-өөс хамгаалагдсан, холбогдох стандарт, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан байна.

в. Хэв загвар, дээжийг тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь гадна орчны нөлөөлөл (цас, бороо, нар, салхи, шороо, тоос, чийг г.м)-өөс хамгаалагдсан шаардлага хангасан байна.

г. Дээрх бүгд

33. Эд хөрөнгө битүүмжлэх ажиллагааг хураан авах, үзлэг хийх ажиллагаатай хамтатган явуулж болох уу?

а. Болно

б. Болохгүй

в. Прокурор зөвшөөрвөл болно

г. Аль ч биш

34. Эрх бүхий албан тушаалтан дараах шинжилгээг хийлгэнэ. Үүнд?

а. Эд зүйл, баримт бичиг

б. Ургамал

в. Мал, амьтанд шинжилгээ

г. Дээрх бүгд

35. Шинжилгээ хийх зорилгоор дараах зүйлсийн алинаас нь хэв загвар, дээж авч болох вэ?

а. Хүн

б. Эд зүйл, баримт бичиг

в. Ургамал, мал амьтан

г. Дээрх бүгд

36. Шинжилгээнд зориулж хэв загвар, дээж авах ажиллагаанд …… оролцуулж болно.

а. Мэргэжилтэн

б. Засаг дарга

в. Иргэдийн хурлын төлөөлөгч

г. Цагдаагийн ажилтан

37. Эрх бүхий албан тушаалтан өөрөө бие даан шинжилгээ хийж, магадалгаа гаргаж болох уу?

а. Зөрчлийг өөрөө шалгаж байгаа тул болохгүй

б. Тусгай мэдлэг, мэргэжил эзэмшсэн бол болно

в. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд харшилна

г. Заавал хөндлөнгийн шинжээч хийх ёстой

38. Оролцогч шинжээчийн дүгнэлттэй санал нийлэхгүй бол хэнд гомдол гаргах бэ?
    а. Эрх бүхий албан тушаалтанд
    б. Прокурорт
    в. Шүүхэд
    г. “а” ба “б”-д заасан албан тушаалтанд

39. Оролцогчийн хүсэлтээр шинжилгээг хэдэн удаа хийж болох бэ?
    а. Дахин нэг удаа
    б. Дахин хоёр удаа
    в. Дахин хийж болохгүй
    г. Аль ч биш

40. Шинжээч шинжилгээний дүгнэлт гаргахдаа ямар хуульд заасан журмыг баримтлах бэ?
    а. Шүүх шинжилгээний тухай хууль
    б. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль
    в. Зөрчлийн тухай хууль
    г. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

ГУРАВДУГААР БҮЛЭГ

БАЙГАЛЬ ОРЧИН, АМЬТАН, УРГАМЛЫГ ХАМГААЛАХ ЖУРМЫН ЭСРЭГ ЗӨРЧЛИЙН ШИНЖ, ОНЦЛОГ, АНХААРАХ АСУУДАЛ



3.1 БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬ ЗӨРЧИХ, ЗӨРЧЛИЙН ШИНЖ, ОНЦЛОГ, АНХААРАХ АСУУДАЛ

3.1.1. Шийтгэл, эрх бүхий албан тушаалтан ба харьяалал, нэр томъёоны тайлбар

Шийтгэл. Зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль зөрчих тохиолдолд зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд дараах шийтгэл оногдуулна. Үүнд:

1. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэхгүйгээр эсхүл зохих байгууллагын шийдвэр гаргуулахгүйгээр үйл ажиллагаа явуулсан бол хууль бус үйл ажиллагааг зогсоож, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хураож хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй ажилласан эсхүл уг төлөвлөгөөг хэрэгжүүлээгүй, биелэлтийг тогтоосон хугацаанд гаргаж, холбогдох газарт тайлагнаагүй бол хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тавигдсан шаардлагыг биелүүлээгүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
4. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний шинжилгээ, хянан магадлагаагаар байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг буруу хийсэн нь тогтоогдсон бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Зөрчлийг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан ба харьяалал. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлд зааснаар Зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль зөрчих зөрчлийг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан болон харъяаллыг доорх хүснэгтээр харуулав. Үүнд:

Эрх бүхий албан тушаалтан	Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харьяалал
Зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль зөрчих	
Байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37) Газар, геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагч (6.40)	Зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг
	Зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг
	Зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг
	Зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг

Хуулийн нэр томъёоны тайлбар. Зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлд заасан зөрчилтэй холбогдох нэр томьёог Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд тайлбарласан байдаг бөгөөд тэдгээрийг дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

“Байгаль орчны стратегийн үнэлгээ” гэж улсын болон бүс нутаг, салбарын хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах явцад түүний хэрэгжилтээс байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэл, сөрөг

нөлөөлөл, үр дагаврыг уур амьсгалын өөрчлөлтийн чиг хандлага, гамшиг, аюулт үзэгдэл, осол, аюултай уялдуулан тодорхойлохыг,

“Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ” гэж аливаа төслийн техник, эдийн засгийн төлөвлөлтийн баримт бичиг, зураг төсөл, улсын болон бүс нутаг, салбарын хэмжээнд хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах явцад тэдгээрийг хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлыг судлан тогтоож цаашид төсөл, хөтөлбөр, төлөвлөгөө, бодлого боловсруулахад анхаарах байгалийн нөхцөл, орчны онцлогийг тодорхойлохыг,

“Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ” гэж тодорхой бүс нутаг, сав газарт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас хэрэгжүүлж байгаа төслүүдээс хүн амын эрүүл мэндэд үзүүлж байгаа хам болон давхардмал сөрөг нөлөөллийг тодорхойлж, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ тогтоохыг,

“Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ” гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас тодорхой төслийг хэрэгжүүлэх явцад байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл, үр дагаврыг урьдчилан тодорхойлж, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ тогтоохыг,

“Үнэлгээний шинжээч” гэж байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, үнэлгээний тайланд шинжилгээ хийж, дүгнэлт гаргах эрх бүхий этгээдийг,

“Үнэлгээний шинжилгээ” гэж байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний ажлыг холбогдох хууль журмын дагуу гүйцэтгэсэн эсэх, тайлан, дүгнэлт үндэслэлтэй, зөв эсэхэд мэргэжлийн дүгнэлт гаргах үйл ажиллагааг,

“Хянан магадлагаа” гэж батлагдсан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайлан, дүгнэлт үнэн зөв эсэхэд мэргэжлийн дүгнэлт гаргах үйл ажиллагааг,


“Эрсдэлийн үнэлгээ” гэж хүн, амьтан, ургамал болон байгаль орчинд хими, биологи, физикийн хүчин зүйлээс үзүүлж болзошгүй нөлөөлөл, мөн гамшиг болон аюулын нөлөөллийг урьдчилан тодорхойлох үйл ажиллагааг,

“Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах” гэж төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээг тус тус ойлгоно.

3.1.2. Зөрчлийн ойлголт, шинж ба төсөөтэй гэмт хэргээс ялгагдах шинж

Зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль зөрчих зөрчлийн ойлголт. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэхгүйгээр эсхүл зохих байгууллагын шийдвэр гаргуулахгүйгээр үйл ажиллагаа явуулсан, байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй ажилласан эсхүл уг төлөвлөгөөг хэрэгжүүлээгүй, биелэлтийг тогтоосон хугацаанд гаргаж, холбогдох газарт тайлагнаагүй, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний шинжилгээ, хянан магадлагаагаар байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг буруу хийсэн үйлдэл, эс үйлдэхүйг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль зөрчих зөрчил гэнэ.

Зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль зөрчих зөрчлийн шинжийг дор харуулав.



Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийлгэхгүйгээр гэж байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийх эрх бүхий байгууллагаар тухайн төслийн техник, эдийн засгийн төлөвлөлтийн баримт бичиг, зураг төсөл, улсын болон бүс нутаг, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулаагүй, тэдгээрийг хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлыг судлан тогтоогоогүй, үйл ажиллагааг явуулахыг ойлгоно.

Шийдвэр гаргуулаагүй гэж байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох байгууллагаас үйл ажиллагаа явуулах тухай шийдвэр гараагүй байхад үйл ажиллагаа явуулсан байхыг ойлгоно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй ажилласан гэж төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх, байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх зэрэг үйл ажиллагааг тусгасан эрх бүхий байгууллагаас гаргасан төлөвлөлтийн баримт бичгийг гаргуулаагүй үйл ажиллагаа явуулахыг хэлнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг биелүүлээгүй гэж төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх, байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх зэрэг үйл ажиллагааг тусгасан эрх бүхий байгууллагаар гаргуулахаар ямар нэгэн үйлдэл хийгээгүй, ийм төлөвлөлтийн баримт бичгийг огт гаргуулаагүй байхыг ойлгоно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу ажиллаагүй гэж төсөл хэрэгжих орчинд агаарын чанар, гадаргын ба газрын доорх усны нөөц, хөрсөн бүрхэвч, газрын хэвлий, ургамлан нөмрөг, амьтны аймгийг хамгаалах, хуримтлагдах нөлөөллийн үнэлгээгээр тогтоогдсон арга хэмжээ болон тухайн орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээг тусгаж, нөхөн сэргээх арга хэмжээ (техникийн болон биологийн нөхөн сэргээлт), биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ, түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ, химийн хортой болон аюултай бодисын эрсдэлийг бууруулах арга хэмжээ, хог, хаягдлын менежментийн арга хэмжээ, орон нутгийн захиргаа, аймаг, нийслэлийн байгаль орчны газар, ажлын хэсгийн дүгнэлт, шаардлагаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах үйл ажиллагаа, орчны хяналт шинжилгээний талаар төлөвлөсөн арга хэмжээг зөрүүтэй хэрэгжүүлсэн, төлөвлөгдсөн үйл ажиллагааг зөрчсөн байхыг ойлгоно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг тогтоосон хугацаанд тайлагнаагүй гэж дээр дурдсан төлөвлөгөөний биелэлт тайланг Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8-д зааснаар нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийсэн тайланг жил бүрийн 12 дугаар сард багтаан тайлагнаагүйг ойлгоно.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний шинжилгээг буруу хийсэн нь тогтоогдсон гэж байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх ажлыг холбогдох хууль журмын дагуу гүйцэтгэсэн тайлан, дүгнэлт үндэслэлтэй, зөв эсэхэд мэргэжлийн дүгнэлт гаргаж нөлөөлөх байдлын үнэлгээний шинжилгээ хийх үйл ажиллагааг буруу хийсэн байхыг ойлгоно.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг буруу хийсэн нь тогтоогдсон гэж ашигт малтмалын хайгуул, ашиглалт, боловсруулах, баяжуулах үйлдвэр, парк, бүтээгдэхүүн хуваах, эрэл хийх төсөл хэрэгжүүлэгч, тэдгээрийг дагалдах болон бусад дэд бүтэц, дулааны цахилгаан станц, цэвэрлэх байгууламж, усан хангамж, химийн хортой болон аюултай бодис, цацраг идэвхт бодис, аюултай хог хаягдлыг хадгалах, тээвэрлэх, устгах, булах, боловсруулах зэрэг төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд тухайн төслийн нөлөөллийн бүсийг тогтоож, байгаль орчин, нийгэмд үзүүлэх шууд ба шууд бус эерэг болон сөрөг нөлөөллийг үнэлж, зайлсхийх, бууруулах, арилгах, нэмэгдүүлэх арга хэмжээг тодорхойлсон судалгааны үр дүнг буруу гаргасан, мөн Засгийн газрын 2023 оны 58 дугаар тогтоолоор батлагдсан Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам (2 дугаар хавсралт)-ын 2.3-д заасан шаардлагыг зөрчсөн байхыг ойлгоно.

Зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль зөрчих зөрчил нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.1 дүгээр зүйлийн Байгаль орчныг бохирдуулах гэмт хэрэгт заасантай төсөөтэй тул доорх хүснэгтээр харьцуулан харуулав.

Хүснэгт 3.1. *Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль зөрчих зөрчлийн төсөөтэй гэмт хэргээс ялгагдах шинж*

Ялгагдах шинж	Байгаль орчныг бохирдуулах (Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.1 дүгээр зүйл)	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль зөрчих (Зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйл)
Объект	Байгаль орчны цэвэр ариун байдал, унаган төрх байх бөгөөд хүн амын эрүүл мэнд давхар объект болно.	Байгаль орчны тэнцвэрт байдал
Объектив тал	Химийн хорт, аюултай бодис, аюултай, хортой хог хаягдлыг агаар, газар, газрын хэвлий, усны сан бүхий газар, гол мөрний урсац бүрэлдэх эх, эх үүсвэрийн тэжээгдлийн муж, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хамгаалалтын бүс дотор хаяж хүний эрүүл мэнд, мал, амьтан, ургамал, тэдгээрийн үр удамд сөрөг нөлөөлөл үзүүлэх, өвчин эмгэг үүсгэх, үхэл, мөхөлд хүргэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэхгүйгээр, эсхүл зохих байгууллагын шийдвэр гаргуулахгүйгээр үйл ажиллагаа явуулсан идэвхтэй үйлдэл байна.

Субьект	Эрүүгийн хуульд заасан 16 насанд хүрсэн хэрэг хариуцах чадвартай Монгол Улсын харьяат болон гадаадын харьяат, аль ч улсын харьяат бус хүн, хуулийн этгээд байна. Ихэвчлэн химийн хорт, аюултай бодис үйлдвэрлэдэг, импортоор оруулж ирдэг, худалдан авч аж ахуйн үйл ажиллагаанд (олборлолт, боловсруулалт, бүтээгдэхүүн үйлдвэрлэл г.м) ашигладаг, тэдгээр үйл ажиллагааныхаа улмаас аюултай, хортой хог хаягдлыг бий болгодог үйлдвэр, аж ахуйн нэгжийн эрх бүхий албан тушаалтан эсвэл үйлдвэрийн эзэн, холбогдол бүхий иргэн байна.	Зөрчлийн тухай хуулийн 3.2-т заасан хэрэг хариуцах чадвартай хувь хүн, хуулийн этгээд байна.
Субьектив тал	Байгаль орчин бориргуулах гэмт хэргийг гэм буруугийн санаатай хэлбэр байна.	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэхгүйгээр, эсхүл зохих байгууллагын шийдвэр гаргуулахгүйгээр үйл ажиллагаа явуулсан гэм буруугийн санаатай хэлбэр байна.

3.1.3. Зөрчлийн зүйлчлэл

Байгаль орчныг бохирдуулах гэмт хэргийн үндсэн шинж нь халдлагад өртөгчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан байхыг шаардахгүй, химийн хорт, аюултай бодис, аюултай, хортой хог хаягдлыг агаар, газар, газрын хэвлий, усны сан бүхий газар, гол мөрний урсац бүрэлдэх эх, эх үүсвэрийн тэжээгдлийн муж, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсэд хаяж, хүний эрүүл мэнд, мал, амьтан, ургамал, тэдгээрийн үр удамд сөрөг нөлөөлөл үзүүлэх, өвчин эмгэг үүсгэх, үхэл, мөхөлд хүргэх нөхцөлийг бүрдүүлсэн бол энэ төрлийн зөрчлөөр зүйлчлэхгүй, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24 дүгээр зүйлд заасан гэмт хэрэг болно.

Харин зөрчил үйлдэгч байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэхгүйгээр, эсхүл зохих байгууллагын шийдвэр гаргуулахгүйгээр үйл ажиллагаа явуулсан, байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй ажилласан, эсхүл уг төлөвлөгөөг хэрэгжүүлээгүй, биелэлтийг тогтоосон хугацаанд гаргаж, холбогдох газарт тайлагнаагүй, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тавигдсан шаардлагыг биелүүлээгүй, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний шинжилгээ, хянан магадлагаагаар байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг буруу хийсэн нь тогтоогдсон тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль зөрчих зөрчлийн аль тохирох хэсэг, заалтаар зүйлчилнэ.

Зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль зөрчих зөрчил нь дээр дурдсан үйлдэл, эс үйлдэхүйг хийснээр төгс үйлдэгдсэнд тооцогдоно.

Зөрчлийн тухай хуулийн Байгаль орчин, амьтан, ургамлыг хамгаалах журмын эсрэг зөрчлийн бүлэгт “хуулийн зарим гол шаардлага хангасан боловч бусад нарийвчилсан шаардлага хангаагүй” үйлдлүүдийг зөрчилд тооцохоор зохицуулсан байна. Тухайлбал, “тусгай зөвшөөрөлгүй” этгээд ашигт малтмалыг хайх, ашиглах, олборлох чиглэлээр үйл ажиллагаа явуулсан бол “гэмт хэрэгт” тооцсон бол “тусгай зөвшөөрөлтэй” этгээд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй ашигт малтмалыг хайх, ашиглах, олборлох чиглэлээр үйл ажиллагаа явуулсан бол “зөрчилд” тооцон шалгахаар зохицуулсан байна.

3.1.4. Зөрчлийг шалгах тодорхой ажиллагаа

Шинэчлэн найруулсан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 9.1 дүгээр зүйлд Зөрчил шалган шийдвэрлэх тусгай журамд зааснаар Эрх бүхий албан хаагч Зөрчлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 5.2 дугаар зүйл, 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 5.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 5.13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 6.20 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 6.26 дугаар зүйл 8.6, 8.7 дугаар зүйл, 14.7 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 15.33 дугаар зүйл, 17.1 дүгээр зүйлийн 7, 16 дахь хэсэг, 18.1, 18.2, 18.4 дэх заалт, 23 дахь хэсэгт заасан зөрчлийг шалгахад энэ хуульд заасан ердийн журмаас гадна, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр бүлэгт заасан тусгай журмыг баримталж хэргийн газрын үзлэг хийх, таньж олуулах, туршилт хийх, нүүрэлдүүлж мэдүүлэг авах, ердийн ажиглалт явуулах, мэдүүлгийг газар дээр нь шалгах зэрэг ажиллагааг явуулна.

Харин байгаль орчны хяналтын улсын байцаагч, улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч нар Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр бүлэгт заасан зөрчил шалган шийдвэрлэх зорилгоор дараах тодорхой ажиллагааг явуулж болно. Үүнд:

Үзлэг хийх. Эд зүйл, баримт бичиг, ачаа тээш, мал, амьтан, тээврийн хэрэгсэл болон бусад эд зүйлд үзлэг хийнэ.

Хураан авах. Зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлого, эд зүйл, зөрчил үйлдэхэд ашигласан зэвсэг, хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, уналга, эсхүл зөрчил шалгах ажиллагаанд ач холбогдолтой эд зүйл, баримт бичгийг хураан авна. Зөрчил үйлдсэн этгээдийн баримт бичиг тодорхойгүй, хуулбарлагдсан, эргэлзээтэй баримт материал гаргаж өгвөл тухайн бичиг баримтад үзлэгийн ажиллагаа явуулж, материалын шинж, онцлогийг нарийн дурдаж тэмдэглэл хөтлөн гарын үсэг зуруулж хураан авна.

Эд хөрөнгө битүүмжлэх. Хураан авах эд хөрөнгө нь овор хэмжээ, эсхүл бусад шалтгаанаар зөрчлийн хэрэгт хадгалах боломжгүй бол байгаа газарт нь битүүмжилнэ.

Мэдүүлэг авах. Эрх бүхий албан тушаалтан зөрчил гарсан байдлыг тодруулах, зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдол бүхий баримт, мэдээллийг олох зорилгоор мэдүүлэг авна. Тухайн зөрчилд хамаарах асуудлаар зөрчил үйлдсэн байж болзошгүй холбогдогч, зөрчлийн талаар мэдэх болсон хүнийг гэрчээр, зөрчлийн улмаас хор хохирол хүлээсэн байгууллага, иргэнийг хохирогчоор тус тус хуульд заасан үндэслэл журмын дагуу мэдүүлэг авч энэ тухай тэмдэглэл үйлдэнэ.

Мэдүүлгийн эхэнд тухайн зөрчлийн талаарх мэдүүлж буй бүх зүйлсийг үгчлэн, дэлгэрэнгүй бичих бөгөөд үүний дараа холбогдох асуудлаар тодруулан мэдүүлэг авна. Зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтан мэдүүлгийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.8, 4.9-д заасан журмаар явуулж, тэмдэглэл үйлдэнэ.

Шинжилгээнд зориулж хэв загвар, дээж авах. Шинжилгээ хийх зорилгоор хүн, эд зүйл, баримт бичиг, ургамал, мал амьтнаас хэв загвар, дээж авч болно.

Шинжилгээ хийлгэх. Эрх бүхий албан тушаалтан хүн, эд зүйл, баримт бичиг, ургамал, мал амьтанд шинжилгээ хийлгэнэ. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, шинжилгээг хянаж эдгээр нь маргаантай тохиолдолд хэрэг бүртгэлт хийж лавлагаа, мэдүүлгийн үндсэн дээр нотолно.

Мөн тухайн хуулийн этгээдийн дотоод дүрэм, албан тушаалтны ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүрэг, ажил үүргийн хуваарь зэрэг холбогдох баримт бичиг, эрх зүйн актыг олж судлан, хэрэгт хавсаргана.

3.1.5. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд анхаарах асуудал

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль зөрчих зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааг явуулахдаа дараах зүйлсийг анхаарах нь зүйтэй. Үүнд:

- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэхгүйгээр, эсхүл зохих байгууллагын шийдвэр гаргуулахгүйгээр үйл ажиллагаа явуулсан, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй ажилласан, эсхүл уг төлөвлөгөөг хэрэгжүүлээгүй, биелэлтийг тогтоосон хугацаанд гаргаж, холбогдох газарт тайлагнаагүй, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тавигдсан шаардлагыг биелүүлээгүй болохыг тогтоох
- Практикт алслагдмал газар нутагт улсын байцаагч уул уурхайн чиглэлээр шалгалт хийх явцад аж ахуйн нэгжийн албан тушаалтнаас “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ”, “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө” зэрэг цаашид ашиглалтын үйл ажиллагааг үргэлжлүүлэх эрх олгодог бичиг баримтуудыг хуурамчаар үйлдэн (бусдын батлагдсан төлөвлөгөөний тамга тэмдэг, гарын үсэг зэргийг сканердаж өнгөтөөр хэвлэх, засварлах г.м) гаргаж үзүүлэх явдал байдаг. Энэ тохиолдолд Эрүүгийн хуулийн 23.2 дугаар зүйлд заасан “Хуурамч баримт бичиг үйлдэх, ашиглах” гэмт хэрэг гэж үзэх үндэслэлтэй. Үүнд: “Тусгай зөвшөөрөл, эрх олгосон, үүргээс чөлөөлсөн баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягт .... эдийн, эдийн бус баялгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийг тодорхойлсон баримт бичгийг хуурамчаар үйлдсэн, хуурамч болохыг мэдсээр байж ашигласан, худалдсан бол” эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан. Мөн зөрчлийн хэрэг нээж шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах явцад “Хэрэг шалган шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг зориуд устгасан, нуусан, засварласан, өөрчилсөн, хуурамчаар үйлдсэн, эсхүл нотлох баримтыг хуурамч болохыг мэдсээр байж хууль сахиулагчид ...гаргаж өгсөн бол” Эрүүгийн хуулийн 21.1 дүгээр зүйлд зааснаар “Нотлох баримтыг хуурамчаар үйлдэх, устгах” гэмт хэрэг үйлдсэнд тооцон шалгах ажиллагаа явуулж материалыг харъяалалын дагуу цагдаагийн байгууллагад шилжүүлнэ.
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ шинжилгээг хянан байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг буруу хийсэн үйлдэл байгаа эсэхийг шалгаж тогтоох
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй ажилласан, эсхүл уг төлөвлөгөөг хэрэгжүүлээгүй, биелэлтийг тогтоосон хугацаанд гаргаж, холбогдох газарт тайлагнаагүй үйлдлээ урьдаас мэдэж, түүнийг хэрэгжүүлэх талаар хууль тогтоомж зөрчсөн зөрчил үйлдээд, өөрсдийн гэмт үйлдлээ нуун дарагдуулсан шинжтэй, төлөвлөгөөг нөхөж хийх, төлөвлөгөөний дагуу ажилласан мэт хуурамч баримт бүлдүүлэх, төвлөгөөний биелэлтийн хугацааг хоцроох зэргээр шийтгэл хүлээхээс зайлсхийх болон өөрсдийн аж ахуйн үйл ажиллагааны ашгийг нуун дарагдуулах зэрэг эдийн засгийн ашиг сонирхлын үүднээс үйлдэгдсэн байж болзошгүй тохиолдол

бий эсэхийг шалгана. Үүнтэй холбоотойгоор байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, төлөвлөгөөний тайлан, биелэлт зэргийн талаарх баримт мэдээлэл, бусад лавлагаа, мэдүүлгийн үндсэн дээр нотлох

- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тавигдсан шаардлагыг биелүүлээгүй буюу Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг байгалийн нөөцийг ашиглах, газрын тос болон ашигт малтмал хайх, ашиглах, аж ахуйн зориулалтаар газар эзэмших, ашиглах эрх авах болон төсөл хэрэгжүүлэхээс өмнө байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл байгаль орчны албаар хийлгэх шаардлагыг зөрчсөн эсэхийг шалгахад анхаарал хандуулах шаардлагатай.
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээг 14 хоногт багтаан хийх зохицуулалт практикт хэрэгждэггүй, ерөнхий үнэлгээний дүгнэлт, нарийвчилсан үнэлгээ, тусгай зөвшөөрөл зэрэг хуулиар тусгайлан хугацаа заасан ажлууд тухайн цаг хугацаандаа хийгдэггүй, улмаар эрх бүхий аж ахуйн нэгжүүд тендерт оролцох боломжгүй болох, захиалгат ажлуудаа цуцлуулах гэх мэтээр хэвийн үйл ажиллагаа нь доголдох, үнэлгээний компани, төсөл хэрэгжүүлэгчийн хооронд үл ойлголцол үүссэн эсхүл үнэлгээг тогтоосон хугацаа шаардлагын хүрээнд хийхийг эрмэлзсэн байдал зэргийг шалгаж тогтоох нь чухал.
- Байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2023 оны 58 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний журам” болон “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам” зэргийг баримталж, боловсруулсан эсхийг шалгах
- Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний салшгүй хэсэг болох байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага болон байгаль орчны төрийн бус байгууллага хяналт тавих тухай Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар батлагдсан журмыг хэрэгжүүлсэн эсэхийг энэ төрлийн зөрчлийг шалгах эрх бүхий улсын байцаагч нягтлан шалгаж болно.
- Мөн энэ төрлийн зөрчлийг шалгах улсын байцаагч Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 11 дүгээр зүйлд Байгаль орны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэсний үндсэн дээр төсөл хэрэгжүүлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учруулж байгаа болон учруулсан бол үнэлгээ буруу хийгдсэн эсэхэд анхаарч зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг явуулна.
- Түүнчлэн энэхүү үнэлгээг хууль тогтоомжид зааснаар хийлгээгүйн улмаас ямар хохирол, хор уршиг учруулсан зэргийг тогтоож шалгах нь зүйтэй.
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэгт байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгах асуудлыг заасан бөгөөд 8.4.8-д “төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн нийтийн хурлын санал, тэмдэглэл”-ийг үнэлгээний тайланд тусгахыг хуульчилсан. Мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.4-д “төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийж байгаа хуулийн этгээд тайлан боловсруулах явцдаа төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, оршин суугчдаас албан ёсоор санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулна” гэж заасан учир дээр дурдсан иргэдийн нийтийн хурлын санал, тэмдэглэл болон нутгийн иргэд, оршин суугчдаас албан ёсоор санал авсан эсэхийг баримт бичиг үзэх, мэдүүлэг авах болон бусад аргаар шалгана.

Бодлого 1

Улсын байцаагч Э нь тусгай зөвшөөрөл авсан “Б” ХХК-ийн ..... аймгийн ..... сумын ..... нэртэй газар орших ашигт малтмалын олборлолт, баяжуулалт явуулж байгаа уурхайн үйл ажиллагааг шалгахад, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсэн үнэлгээний тайланг дүгнэлт гаргуулахаар хүргүүлсэн ажлын 18 хоногт багтаж гарна, бид тусгай зөвшөөрөлтэй тул ажиллаж байна гэсэн тайлбар хэлжээ.

Асуулт

1. Дээрх үйлдэл нь ямар хууль тогтоомж зөрчсөн вэ?
2. Энэ зөрчлийг шалгах ажиллагааны үед ямар ажиллагаа явуулах вэ?
3. Дээрх хууль бус үйлдэл нь Зөрчлийн тухай хуульд заасан ямар зөрчил болох вэ? Зөрчлийг зүйлчилнэ үү?
4. Зөрчил үйлдэгчид ямар шийтгэл оногдуулах вэ?

Хариулт

1. Дээрх үйлдэл нь ямар хууль тогтоомж зөрчсөн вэ?
Тусгай зөвшөөрөл авсан “Б” ХХК-ийн ..... аймгийн ..... сумын ..... нэртэй газар орших ашигт малтмалын олборлолт, баяжуулалт явуулж байгаа хуулийн этгээд нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан нөлөөллийн үнэлгээ нь тус хуулийн 7.1.1. байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ заавал хийлгэхээр заасан, мөн хуульд Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг байгалийн нөөцийг ашиглах, газрын тос болон ашигт малтмал хайх, ашиглах, аж ахуйн зориулалтаар газар эзэмших, ашиглах эрх авах болон төсөл хэрэгжүүлэхээс өмнө хийнэ, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг хүлээн авсан шинжээч ажлын 18 өдөрт багтаан үнэлгээний шинжилгээ хийж дүгнэлт гаргах бөгөөд шаардлагатай тохиолдолд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ерөнхий шинжээч уг тайланд үнэлгээний шинжилгээ хийх шинжээчдийн баг томилно хэмээн заасан бөгөөд өмнөх дүгнэлт хүчингүй болохоос өмнө уг хуулийн этгээд тайлангаа хүргүүлж, хугацаа дуусахаас өмнө дүгнэлтээ гаргуулан авах үүрэгтэй гэсэн заалт зөрчсөн байна. Мөн Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31.3-д үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх явцад байгаль орчинд гаргаж байгаа хорт бодис, физикийн хортой нөлөөлөл, хог хаягдлын хэмжээг бүртгэж, тэдгээрийг багасгах, цэвэрлэх талаар авсан арга хэмжээ, хянах төхөөрөмжийн ажиллагааны тухай тайлан мэдээг хугацаанд нь гаргаж холбогдох байгууллагад өгөх гэсэн хуулийн заалтыг тус тус зөрчсөн байна.

2. Энэ зөрчлийг шалгах ажиллагааны үед ямар ажиллагаа явуулах вэ?
Энэ тохиолдолд зөвхөн тухайн илэрсэн зөрчилтэй холбогдуулан зөрчлийн хэрэг нээж энэ тухай удирдах албан тушаалтан болон прокурорт мэдэгдэж бүртгэлд оруулах ба тухайн газарт үзлэг хийх, шинжилгээнд зориулан дээж авах, шинжилгээ томилон, шинжээчийн ажилд дөхөм болох эд мөрийн баримтаар хураан авсан хаяг, шошго, сав, баглаа боодол гэх мэтийг хүргүүлэх, холбогдогч, гэрч, хохирогчоос мэдүүлэг авах, шаардлагатай бичиг баримтыг шаардан гаргуулах зэрэг бие даан шийдвэрлэх ажиллагаа явуулахын зэрэгцээ эд зүйл хураан авах, битүүмжлэх зэрэг хойшлуулшгүй тохиолдолд прокурорын зөвшөөрөлгүй явуулах ажиллагаануудыг тухайн газар дээр нь хийж хэрэгжүүлэх зэргээр Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан ажиллагааг явуулна.

3. Дээрх хууль бус үйлдэл нь Зөрчлийн тухай хуульд заасан ямар зөрчил болох вэ? Зөрчлийг зүйлчилнэ үү?

Зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэхгүйгээр, эсхүл зохих байгууллагын шийдвэр гаргуулахгүйгээр үйл ажиллагаа явуулсан гэж үзэж Зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгээр зүйлчилж шийтгэл оногдуулна.

4. Зөрчил үйлдэгчид ямар шийтгэл оногдуулах вэ?
Үйлдэгдсэн зөрчилд хүлээлгэх хариуцлага: Зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар “Б” ХХК-д Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэхгүйгээр, эсхүл зохих байгууллагын шийдвэр гаргуулахгүйгээр үйл ажиллагаа явуулсан үйлдэлд нь хууль бус үйл ажиллагааг зогсоож, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хураж, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож шийдвэрлэнэ.

Бодлого 2

Улсын байцаагч Б нь төлөвлөгөөт хяналт шалгалтын ажлын хүрээнд “Өгөөмж” ХХК-ийн ..... аймгийн ..... сумын ..... нэртэй газар орших ашигт малтмалын олборлолт, баяжуулалт явуулж байгаа уурхайн үйл ажиллагааг шалгахад, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайланг нутгийн иргэд, олон нийтэд танилцуулаагүй, мөн санал, хүсэлтийг нь авахгүйгээр тайланг гаргаж зохих байгууллагад хүргүүлсэн зөрчийг илрүүлжээ.

Асуулт

1. Дээрх үйлдэл нь ямар хууль тогтоомж зөрчсөн вэ?
2. Энэ зөрчлийг шалгах ажиллагааны үед ямар ажиллагаа явуулах вэ?
3. Дээрх хууль бус үйлдэл нь Зөрчлийн тухай хуульд заасан ямар зөрчил болох вэ? Зөрчлийг зүйлчилнэ үү?
4. Зөрчил үйлдэгчид ямар шийтгэл оногдуулах вэ?

Хариулт

1. Дээрх үйлдэл нь ямар хууль тогтоомж зөрчсөн вэ?
Энэ тохиолдолд төсөл хэрэгжүүлэгч “Өгөөмж” ХХК нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.8-д зааснаар төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн нийтийн хурлын санал, тэмдэглэл, мөн зүйлийн 8.5-д зааснаар байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд төсөл хэрэгжүүлэгчээс албан ёсоор санал авна, мөн хуулийн 10.4-д байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, түүнд үнэлгээний шинжилгээ хийсэн шинжээчийн болон мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт, энэ хуулийн 18.4-д заасан саналыг үндэслэн төслийг хэрэгжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ, 14.1.3-д газрын тос болон уул уурхайн төслүүд нь нөхөн сэргээлт, хаалтын менежментийн төлөвлөгөөг тухайн үйл ажиллагаа эхэлж, хаалт хийхээс гурван жилээс доошгүй хугацааны өмнө боловсруулж, тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг авч, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлэх гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

2. Энэ зөрчлийг шалгах ажиллагааны үед ямар ажиллагаа явуулах вэ?
Энэ тохиолдолд зөвхөн тухайн илэрсэн зөрчилтэй холбогдуулан зөрчлийн хэрэг нээж энэ тухай удирдах албан тушаалтан болон прокурорт мэдэгдэж бүртгэлд оруулах ба тухайн

газарт үзлэг хийх, шинжилгээнд зориулан дээж авах, шинжилгээ томилон, шинжээчийн ажилд дөхөм болох эд мөрийн баримтаар хураан авсан хаяг, шошго, сав, баглаа боодол гэх мэтийг хүргүүлэх, холбогдогч, гэрч, хохирогчоос мэдүүлэг авах, шаардлагатай бичиг баримтыг шаардан гаргуулах зэрэг бие даан шийдвэрлэх ажиллагаа явуулна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тавигдсан шаардлагыг биелүүлээгүй болохыг тогтоох зорилгоор байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, шинжилгээг хянан байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг буруу хийсэн үйлдэл байгаа эсэхийг шалгаж тогтооно.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн олон нийтийн оролцоог хангах талын зохицуулалтууд болон хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд гарсан “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам”-ын дагуу хийсэн ажлын тайлан, бусад баримт бичгийг үзэж шалгах, шаардлагатай зүйлийг хураан авч зөрчлийн хэрэгт хавсаргана.

Түүнчлэн энэ төрлийн зөрчлийг шалгах улсын байцаагч Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн Байгаль орны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэсний үндсэн дээр төсөл хэрэгжүүлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учруулж байгаа болон учруулсан бол үнэлгээ буруу хийгдсэн эсэхэд анхаарч зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг явуулна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагааг зохион байгуулахад төсөл хэрэгжүүлэгч болон орон нутгийн удирдлагууд, мэргэжлийн байгууллагууд хамтран ажиллах, тухайн орон нутгийн удирдлагууд нь иргэдээ төлөөлөх үүргээ биелүүлж, санал, хүсэлт авах үйл ажиллагааг зохион байгуулсан, хурал хийсэн байдал, олон нийтийн оролцоог хангахад дэмжлэг үзүүлж ажилласан тайлан мэдээ, зурагт хуудас гэх мэт ач холбогдолтой зүйлийг шалгах болон тухайн зөрчлийн нөхцөл байдалд тохируулан дээр дурдсан ажиллагааг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу явуулна.

3. Дээрх хууль бус үйлдэл нь Зөрчлийн тухай хуульд заасан ямар зөрчил болох вэ? Зөрчлийг зүйлчилнэ үү?
Зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тавигдсан шаардлагыг биелүүлээгүй гэж үзэж Зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгээр зүйлчилж шийтгэл оногдуулна.

4. Зөрчил үйлдэгчид ямар шийтгэл оногдуулах вэ?
Үйлдэгдсэн зөрчилд хүлээлгэх хариуцлага: Зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар “Өгөөмж” ХХК-д Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тавигдсан шаардлагыг биелүүлээгүй гэсэн үндэслэлээр хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулна.

Бодит жишээ 1 **Улсын дээд шүүхийн тогтоол**

Нэхэмжлэлийн шаардлага: “Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн А/425 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн 2019/14 дүгээр дүгнэлтийг хүчингүй болгуулах”

Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн 128/ШШ2020/0449 дүгээр шийдвэр,

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн 515 дугаар магадлалтай,

Шүүх хуралдаанд оролцогч: нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Ж.О, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч О.Б нарыг оролцуулан,

Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гаргасан гомдлыг үндэслэн хэргийг хянан хэлэлцэв.

ТОДОРХОЙЛОХ нь:

Өмнөх шатны шүүхийн шийдвэр:

1. Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 7 дугаар сарын 01-ны өдрийн 128/ШШ2020/0449 дүгээр шийдвэрээр: Захиргааны ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 46 дугаар зүйлийн 46.1, 48 дугаар зүйлийн 48.1, Ашигт малтмалын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 56 дугаар зүйлийн 56.1, 56.1.5, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 11, 14, 15 дугаар зүйлийн 15.1.1, 26 дугаар зүйлийн 26.1, 27 дугаар зүйлийн 27.1.10, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт заасныг тус тус баримтлан нэхэмжлэгч “М” ХХК-ийн нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн А/425 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн 2019/14 дүгээр дүгнэлт”-ийг хүчингүй болгож шийдвэрлэжээ.
2. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гомдлоор хэргийг 2020 оны 9 дүгээр сарын 02-ны өдөр хянан хэлэлцээд 515 дугаар магадлалаар: Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 7 дугаар сарын 01-ны өдрийн 449 дүгээр шийдвэрийн Тогтоох хэсгийн 1 дэх заалтыг “Ашигт малтмалын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 56 дугаар зүйлийн 56.1, 56.1.5, Байгаль орныг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 6, 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4, 17 дугаар зүйлийн 2 хэсгийн 4-д заасныг тус тус баримтлан нэхэмжлэгч “М” ХХК-ийн нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж, 2019/14 дүгээр дүгнэлтийг хүчингүй болгосугай гэж өөрчлөн, тогтоох хэсгийн бусад заалтыг хэвээр үлдээж” шийдвэрлэсэн байна.

Хяналтын журмаар гаргасан гомдол:

3. Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч О.Б хяналтын журмаар гаргасан гомдолдоо: 1.“Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын “ажлын хэсэг байгуулах тухай” 2019 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн А/425 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг нь “М” ХХК-ийн ашиглалтын тусгай зөвшөөрлийг Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.6 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.1.1, Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.5 дахь заалт болон Өмнөговь аймгийн Засаг дарга, Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Засаг даргын саналыг үндэслэн “тусгай зөвшөөрлийг цуцлах тухай дүгнэлт”-ийг гаргасан.

4. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15.1.1-д “байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчны тэнцлийг хангах, байгаль орчинд учирч болох хохирлоос урьдчилан сэргийлэх, учирсан хохирлыг арилгуулах төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах”, Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д “Төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрлийг дараах үндэслэлээр цуцална” гэж заасан ба 56.1.5-д “тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчинд хортой нөлөөлж байгаа, эсхүл нөхөн сэргээх, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заасан үүргээ биелүүлээгүй талаар нутгийн захиргааны байгууллагын саналыг харгалзан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дүгнэлт гаргасан” бол ашигт малтмалын газрын тосны газар тусгай зөвшөөрлийг цуцлах зохицуулалттай.
5. Тухайн орон нутагтаа Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомж, Ашигт малтмалын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, биелэлтийг хангуулах, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг мөрдүүлэх эрх бүхий байгууллага буюу нутгийн захиргааны байгууллагаас дээрх хуулийн дагуу саналаа ирүүлсэн.
6. Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь хяналт шалгалтын байгууллага биш бөгөөд Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 1-д “Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээхэд тавих хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага хэрэгжүүлнэ” гэж заасан.
7. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2-д “Аймаг, нийслэлийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 16.2.4-д “нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх үйл ажиллагаанд харьяалал харгалзахгүйгээр хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай бол тухайн аж ахуйн нэгж байгууллагын байгаль орчинд хортой нөлөөлж буй үйл ажиллагааг өөрөө түдгэлзүүлэн зогсоох буюу уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх”, 16.2.10-д “байгалийн нөөцийг төрийн нэрийн өмнөөс хамгаалан, халдашгүй байдлыг нь хангах үүргийг тухайн нутаг дэвсгэртээ хариуцах”,
8. Мөн Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2-т “сум, дүүргийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаарх дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 17.2.4-д “нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд харьяалал харгалзахгүйгээр хяналт тавьж, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчинд хортой нөлөөлж буй үйл ажиллагааг өөрөө түдгэлзүүлэн зогсоох буюу уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх”, 17.2.8-д “байгалийн нөөцийг төрийн нэрийн өмнөөс хамгаалан, халдашгүй байдлыг нь хангах үүргийг тухайн нутаг дэвсгэртээ хариуцах” гэж тус тус заасан. Эдгээр зохицуулалтыг шүүгч судалж хараагүй, орон нутгийн удирдлага байгаль орчны талаар ямар эрх, үүрэгтэй нь тодорхой байгаа төдийгүй шүүхэд эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах эрхийг нь эдлүүлээгүй. ... ашигт малтмалын харилцаанд өдөр тутам хяналт тавьж ажилдаг этгээдээс төлөөлөл оролцуулахгүй байгаа нь хууль бус байна.
9. Иймд уг гомдлыг хүлээн авч хэргийг хянан шийдвэрлэж дээрх магадлалыг хүчингүй болгож өгнө үү” гэжээ.

ХЯНАВАЛ:

1. Шүүхүүд маргааны үйл баримтуудыг үндэслэл бүхий дүгнэж, нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн нь зөв, анхан шатны шүүхийн шийдвэрийн “тогтоох” хэсэгт баримталсан хуулийн зүйл заалтад хууль хэрэглээний өөрчлөлт оруулсан давж заалдах шатны шүүхийн магадлал Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.3-т заасанд нийцжээ.
2. Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Засаг даргын 2019 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 1/302 дугаартай албан бичгээр Монгол Улсын шадар сайд (Ө.Э)-д, Өмнөговь аймгийн Засаг даргын 2019 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 1-2103 дугаартай албан бичгээр Байгаль орчин, аялал жуулчлалын сайд (Н.Ц)-д тус тус хүргүүлсэн санал, хүсэлтэд “ ... (нэр бүхий) зэрэг компаниуд нь ашиглалтын үйл ажиллагаа явуулахад бэлэн болж холбогдох хүсэлтээ ирүүлснийг шийдвэрлэх боломжгүй, орон нутгийн зүгээс нэмж уурхай ажиллуулахгүй гэдэг байр суурьтай байгаа, шинээр уурхай нээхтэй холбоотой аж ахуйн нэгж, иргэдийн дунд үл ойлголцол үүсэж, зөрчил гарч байгаа, нэг сумын нутаг дэвсгэрт 20-25 тусгай зөвшөөрөл дээр нэгэн зэрэг уул уурхайн олборлолт явуулснаар иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөл, байгаль орчны тэнцвэрт байдал алдагдаж, бэлчээрийн хомсдол бий болж, нутгийн иргэдийг ихээр бухимдуулж байгаа...” гэх зэргээр дурдаж, үүнийг харгалзан үйл ажиллагаа эхлээгүй байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тусгай зөвшөөрлийг цуцлуулах шийдвэр гаргуулах”-ыг хүссэн, тэдгээр компаниудад “М” ХХК хамаарсан, нэхэмжлэгч “М” ХХК нь Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг “Зангат уул” нэртэй газрын 1110.49 гектар уурхайн талбайд ашигт малтмал ашиглах MV-019137 дугаар тусгай зөвшөөрлийг 2015 оны 9 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн эзэмшсэн ба маргаан бүхий акт гарах хүртэл хугацаанд тус тусгай зөвшөөрлөөр олгогдсон уурхайн талбайд ашиглалтын үйл ажиллагаа явуулаагүй (ажлаа эхлээгүй) зэрэг үйл баримтууд тогтоогдсон, уг үйл баримттай хэргийн оролцогчид маргаагүй байна.
3. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах талаар Ашигт малтмалын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д заасны дагуу байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон уг хуулийн 38,39 дүгээр зүйлд заасан үүргийг хүлээнэ, ашигт малтмалын асуудлаар нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагын бүрэн эрхийг мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт, үүний 12.1.1-д “ашигт малтмалын тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газраас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах”, 12.1.3-т “байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн талаар хүлээсэн үүргээ тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих” гэж тус тус заасан ба уг чиг үүргээ хэрэгжүүлж, байгаль орчныг хамгаалах талаарх хуульд заасан үүргээ биелүүлээгүй тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрлийг цуцлуулах асуудлаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргасан санал нь мөн хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.5-д заасан “тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчинд хортой нөлөөлж байгаа, эсхүл нөхөн сэргээх, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заасан үүргээ биелүүлээгүй талаар нутгийн захиргааны байгууллагын саналыг харгалзан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дүгнэлт гаргасан” гэсний дагуу тус дүгнэлтийн үндэслэлд хамаарч байна.
4. Хуулийн дээрх зохицуулалтуудаас үзэхэд, тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй зөрчил гаргасан нь бодитой бөгөөд зохих журмын дагуу шалгаж тогтоогдсон байхыг шаардсаны зэрэгцээ Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.6-д “саналыг харгалзан” гэсний

дагуу дүгнэлт гаргах эрх хэмжээ өөрт нь хадгалагдаж буй субъектийн хувьд, хариуцагч нь шийдвэр гаргахад хамаарах бодит нөхцөл байдлыг тогтоох талаар Захиргааны ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д заасан үүргээс чөлөөлөгдөхгүй юм.

5. Энэ маргааны хувьд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн А/425 дугаар тушаалаар байгуулагдсан бөгөөд Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.5-д заасан дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсэг нь 2019 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 2019/14 дүгээр дүгнэлтийг гаргахдаа үндэслэсэн Өмнөговь аймгийн Засаг даргын болон Гурвантэс сумын Засаг даргын дээрх 2 албан бичгээр, нэхэмжлэгч нь тусгай зөвшөөрлөөр олгогдсон уурхайн талбайд ашиглалтын үйл ажиллагаа явуулж эхлээгүй болохыг мэдсэн атлаа тусгай зөвшөөрөл эзэмшигч нь бодит зөрчил гаргасан, тэр нь зохих журмын дагуу тогтоогдсон байх хуулийн нөхцөлийг буруу хэрэгжүүлж “ашиглалт хийхдээ байгаль орчинд хортой нөлөө учруулж болзошгүй” гэх үндэслэлээр “дүгнэлт” гаргасан нь хууль бус, үүний улмаас нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн талаар шүүхүүд зөв дүгнэсэн байна.
6. Иймээс, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хяналтын журмаар гаргасан “... эрх бүхий байгууллага буюу нутгийн захиргааны байгууллагаас хуулийн дагуу саналаа ирүүлсэн (байхад) яам дүгнэлт гаргахгүй байх хуулийн зохицуулалт байхгүй, ...яам нь хяналт шалгалтын байгууллага биш, ...хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага хэрэгжүүлнэ, ...хуулийн зохицуулалтыг шүүгч судалж хараагүй” гэх гомдлын үндэслэлийг хүлээж авах боломжгүй.
7. Түүнчлэн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д “үндсэн нэхэмжлэлийн шаардлагаар үүссэн маргааны үйл баримтын талаар бие даасан шаардлага гаргасан, эсхүл эдгээрийн улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа гэж үзсэн гуравдагч этгээдийг тухайн этгээдийн хүсэлтээр, эсхүл шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах”-аар зааснаас үзэхэд, энэ маргаанд Өмнөговь аймгийн Засаг дарга болон Гурвантэс сумын Засаг даргыг гуравдагч этгээдээр татан оролцуулах эрх зүйн үндэслэлгүй, анхан шатны шүүх хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчөөгүй талаар давж заалдах шатны шүүх үндэслэлтэй, зөв дүгнэсэн байна.
8. Иймд, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн “...орон нутгийн удирдлагын шүүхэд эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах эрхийг нь эдлүүлээгүй, төлөөлөл оролцуулахгүй байгаа нь хууль бус” гэх гомдлыг хангах үндэслэлгүй.
9. Дээрх үндэслэлүүдээр давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээж, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч О.Б хяналтын журмаар гаргасан гомдлыг хангахгүй орхих нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн дүгнэлээ.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.2.1-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн 515 дугаар магадлалыг хэвээр үлдээж, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гомдлыг хангахгүй орхисугай.
2. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.3-т зааснаар хариуцагч хяналтын журмаар гаргахдаа тэмдэгтийн хураамж төлөөгүй болохыг дурдсугай.

Шүүхийн шийдвэрийн дүгнэлт

Шүүх шийдвэрлэхдээ хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хяналтын журмаар гаргасан “... эрх бүхий байгууллага буюу нутгийн захиргааны байгууллагаас хуулийн

дагуу саналаа ирүүлсэн (байхад) яам дүгнэлт гаргахгүй байх хуулийн зохицуулалт байхгүй, ...яам нь хяналт шалгалтын байгууллага биш, ...хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага хэрэгжүүлнэ, ...хуулийн зохицуулалтыг шүүгч судалж хараагүй" гэх гомдлын үндэслэлийг хүлээж авах боломжгүй. Гэсэн тул нөлөөлөх байдлын үнэлгээ хийх эрх бүхий байгууллагуудын дүгнэлт гаргуулан авах шаардлагатай байсан.

Мөн Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах талаар Ашигт малтмалын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д заасны дагуу байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон уг хуулийн 38,39 дүгээр зүйлд заасан үүргийг хүлээнэ, ашигт малтмалын асуудлаар нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагын бүрэн эрхийг мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт, үүний 12.1.1-д "ашигт малтмалын тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газраас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах", 12.1.3-д "байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн талаар хүлээсэн үүргээ тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих", мөн хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.5-д заасан тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчинд хортой нөлөөлж байгаа, эсхүл нөхөн сэргээх, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заасан үүргээ хуулийн дагуу биелүүлсэн эсэхийг сайтар шалгаж тогтоох нь зүйтэй байсан.

Бодит жишээ 2 **Улсын дээд шүүхийн тогтоол**

Нэхэмжлэлийн шаардлага: "Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн даргын 2019 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн 417 дугаар Тусгай зөвшөөрөл цуцлах тухай шийдвэрийг хүчингүй болгох, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2019 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 2019/03 дугаартай Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг цуцлуулах тухай дүгнэлтийг хүчингүй болгуулах"

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 128/ШШ2020/0413 дугаар шийдвэр,

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн 507 дугаар магадлалтай,

Шүүх хуралдаанд оролцогч: Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Б, нэхэмжлэгчийн өмгөөлөгч П.Ц, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч А.Ц нарыг оролцуулж,

Нэхэмжлэгчийн өмгөөлөгчийн хяналтын журмаар гаргасан гомдлыг үндэслэн хэргийг хянан хэлэлцэв.

ТОДОРХОЙЛОХ нь:

Өмнөх шүүхийн шийдвэр:

1. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 128/ШШ2020/0413 дугаар шийдвэрээр: Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.5, 56.2, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, Захиргааны ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 24.2-т заасныг тус тус баримтлан нэхэмжлэгч "Б" ХХК-ийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж, Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн даргын

2019 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн 417 дугаар шийдвэр, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2019 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 2019/03 дугаартай Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг цуцлуулах тухай дүгнэлтийг тус тус хүчингүй болгож шийдвэрлэсэн.

2. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн 507 дугаар магадлалаар: Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 128/ШШ2020/0413 дугаар шийдвэрийг хүчингүй болгож, хариуцагч нарын давж заалдах гомдлыг хангаж, Ашигт малтмалын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1, 39.7, 56 дугаар зүйлийн 56.1.5, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 7, 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4, 26 дугаар зүйлийн 1-д заасныг тус тус баримтлан “Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2019 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 2019/03 дугаар дүгнэлт, Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн даргын 2019 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн 417 дугаар шийдвэрийг тус тус хүчингүй болгуулах” шаардлагатай “Б” ХХК-ийн нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

Хяналтын журмаар гаргасан гомдол:

3. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлд заасны дагуу Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн 507 дугаар магадлалыг эс зөвшөөрч дараах үндэслэлээр хяналтын журмаар гомдол гаргав. Давж заалдах шатны шүүх “...хэрэгт авагдсан нотлох баримтыг буруу үнэлсэн...’’ гэж анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэгч “Б” ХХК-ийн нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэснийг хуульд нийцээгүй гэж үзэж байна.
4. Нэхэмжлэгч “Б” ХХК нь Кадастрын хэлтсийн даргын 2019 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн 332 дугаар шийдвэрийн дагуу Архангай аймгийн Цэнхэр сумын нутаг Харгуйтын ам нэртэй 284 гектар талбай бүхий ашигт малтмалын ашиглалтын MV-005529 тоот тусгай зөвшөөрлийг шилжүүлж авахдаа өмнөх эзэмшигч “М” ХХК-тай холбоотой Архангай аймгийн Мэргэжлийн хяналтын газрын хийсэн хяналт шалгалтын 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 01/53 дугаар актын талаар мэдээгүй бөгөөд уг тусгай зөвшөөрлийг шилжүүлж авснаас хойш хуульд заасан шаардлагуудыг хангахаар ажиллаж байх үед нь уг тусгай зөвшөөрөл гэнэт цуцлагдсан. Уг лиценз бүхий талбай нь бүрэн олборлолт хийгдсэн талбай бөгөөд шороог дахин ашиглахаар арга буюу шилжүүлж авсан байжээ.
5. Давж заалдах шатны шүүх, байгаль орчныг хамгаалах талаарх Байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасан үүргүүд тусгай зөвшөөрөл шилжүүлж авсан нэхэмжлэгч компанид шилжсэн, нэхэмжлэгч хариуцлага хүлээх ёстой гэж үзэж нэхэмжлэгчийг буруутгаж байгаа нь үндэслэлгүй байна. Учир нь хариуцагч захиргааны байгууллагуудаас тусгай зөвшөөрлийг шилжүүлж авсан “Б” ХХК-д дээрх актад дурдсан гэх зөрчил дутагдлыг засуулах талаар ямар ч арга хэмжээ авааагүй, зохицуулах, үйлчилгээ үзүүлэх хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй байхад давж заалдах шатны шүүх хэрэгт авагдсан нотлох баримтад хэт нэг талыг баримталсан дүгнэлт хийсэн нь хууль зүйн үндэслэлгүй бөгөөд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2-т заасныг буруу хэрэглэсэн.
6. Маргаан бүхий захиргааны актыг гаргах үедээ хариуцагч Байгаль орчин, аялал жуулчлалын яам хяналт шалгалтын гэх актуудын талаар мэдэхгүй байсан байхад давж заалдах шатны шүүх Байгаль орчин, аялал жуулчлалын яамыг бодит нөхцөл

байдлыг тогтоогоогүй гэж үзэхээргүй байна гэж буруу дүгнэсэн. Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2 “Төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрлийг цуцлах үндэслэл тогтоогдсоноос хойш ажлын 10 өдөрт багтаан тусгай зөвшөөрөл эзэмшигчид энэ тухай мэдэгдэл өгөх бөгөөд түүнд тусгай зөвшөөрлийг цуцлах болсон үндэслэлийг тодорхой заана” гэж тусгайлан заасан байхад хариуцагч Кадастрын хэлтсийн дарга нь хуульд заасан энэ үүргээ хэрэгжүүлэхгүйгээр маргаан бүхий тусгай зөвшөөрлийг цуцлах шийдвэрийг гэнэт гаргаж нэхэмжлэгчид эрхээ хамгаалах боломж олгоогүй буруутай байгааг давж заалдах шатны шүүх анхаарч үзсэнгүй.

7. Иймд Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн 507 дугаар магадлалыг хүчингүй болгож, Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 128/ШШ2020/0413 дугаар шийдвэрийг хэвээр үлдээж өгнө үү.

ХЯНАВАЛ:

1. Хяналтын шатны шүүхээс шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцааж шийдвэрлэв.
2. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1, 3 дугаар зүйлийн 3.1.3-д хүн, хуулийн этгээдээс захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргахыг, 106 дугаар зүйлийн 106.3.1-д захиргааны акт хууль бус бөгөөд түүний улмаас нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн бол түүнийг хүчингүй болгохоор тус тус заасан.
3. Нэхэмжлэгч “Б” ХХК нь Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтэс, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, тус яамны Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг цуцлах дүгнэлт гаргасан ажлын хэсэгт холбогдуулан, Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн даргын 2019 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн 417 дугаар шийдвэр, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2019 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 2019/03 дугаартай “Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг цуцлуулах тухай” дүгнэлтийг хүчингүй болгуулахыг хүссэн нэхэмжлэлийн шаардлага гаргаж, үндэслэлийг “... Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн даргын 2019 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн 332 дугаар шийдвэрээр “М” ХХК-ийн эзэмшиж байсан MV-005529 дугаартай тусгай зөвшөөрлийг манай компанид шилжүүлж эзэмшүүлсэн, мөн тус компани ашиглалтын үйл ажиллагаа явуулаагүй байтал 2019 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн 417 дугаар шийдвэрээр ...тусгай зөвшөөрөл бүхий талбайд ашиглалт хийхдээ байгаль орчинд хортой нөлөө учруулж буй гэсэн баримт нотолгоогүй үндэслэлээр тусгай зөвшөөрлийг цуцалсан. ...захиргааны актыг гаргахдаа манай компанийг оролцуулах, тайлбар гаргах боломжоор хангаагүй, Захиргааны ерөнхий хуулийн 26, 27 дугаар зүйлд заасан журмыг зөрчсөн” гэж маргажээ.
4. Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн даргын 2019 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн 417 дугаар шийдвэрээр, ... “Б” ХХК нь ашигт малтмал ашиглалтын MV-005529 дугаартай тусгай зөвшөөрлийг эзэмшиж байхдаа Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.5-д заасан зөрчил гаргасан болох нь Байгаль орчин, аялал жуулчлалын яамны ... ажлын хэсгийн 2019/03 дугаар дүгнэлтээр тогтоогдсон гэсэн үндэслэлээр нэхэмжлэгч компанийн тусгай зөвшөөрлийг цуцалсан байна.
5. Мөн нэхэмжлэгчийн маргаж буй Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2019 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 2019/03 дугаар дүгнэлтээр, “...Архангай аймгийн Засаг

даргын 2019 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 02/975 тоот албан бичгийг үндэслэн ... “Б” ХХК ... тусгай зөвшөөрөл бүхий талбайдаа ашиглалт хийхдээ байгаль орчинд хортой нөлөө учруулж буй тул тусгай зөвшөөрлийг цуцлах нь зүйтэй” гэж үзсэн бол, Архангай аймгийн Засаг даргын 2019 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 02/975 тоот “Санал хүргүүлэх тухай” албан бичигт “... ашиглалтын MV-005529 дугаартай тусгай зөвшөөрөл эзэмшигч “Б” ХХК, ... (-ийн) ... үйл ажиллагаа нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.6 дахь хэсэгт заасны дагуу байгаль орчинд хортой нөлөөллийг үзүүлж байгаа тул Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.5-д заасны дагуу холбогдох дүгнэлт гаргаж тусгай зөвшөөрлийг цуцалж өгнө үү” гэжээ.

6. Ашигт малтмалын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 32, 33 дугаар зүйлд заасан нөхцөл, шаардлагыг хангаж ажиллах үүрэгтэй бөгөөд зөрчвөл мөн хуулийн 56 дугаар зүйлд заасны дагуу тусгай зөвшөөрлийг цуцална”, 56 дугаар зүйлийн 56.1-д “Төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрлийг дараах үндэслэлээр цуцална: ... 56.1.5.тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчинд хортой нөлөөлж байгаа, эсхүл нөхөн сэргээх, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заасан үүргээ биелүүлээгүй талаар нутгийн захиргааны байгууллагын саналыг харгалзан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дүгнэлт гаргасан” гэж хуульчилсан. Түүнчлэн Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2.6-д “байгаль орчинд хортой нөлөөлөх” гэдэгт байгаль орчин, түүний баялгийг бохирдуулах, муутгах, гэмтээх, сүйтгэх, сөнөөж мөхөөх үйлдэл /эс үйлдэхүй/ хамаарна” гэж заасан.
7. Анхан шатны шүүх Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 107 дугаар зүйлийн 107.4-д заасан хэргийн нөхцөл байдал, маргаж буй захиргааны актуудын үндэслэл, тэдгээртэй холбоотой нотлох баримтыг цуглуулж, дүгнэлт өгөх үүргээ хэрэгжүүлээгүй, давж заалдах шатны шүүхээс энэ алдааг залруулаагүй нь буруу байна. Өөрөөр хэлбэл, маргаан бүхий Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн даргын 417 дугаар шийдвэрээр, “Б” ХХК-ийг Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.5-д заасан зөрчил гаргасан гэж үзсэн бол, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2019/03 дугаар дүгнэлтээр, тус компанийг тусгай зөвшөөрөл бүхий талбайдаа ашиглалт хийхдээ байгаль орчинд хортой нөлөө учруулж байгаа гэж дүгнэсэн, түүнчлэн хэрэгт нотлох баримтаар Архангай аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 01/53 тоот хяналт шалгалтын танилцуулга, “Нөхөн сэргээлт хийсэн газрыг хүлээн авсан акт” №6, Орхон-Чулуут голын сав газрын захиргааны 2019 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 150 тоот албан бичиг, Архангай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2019 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 333 тоот албан бичиг гэх баримтууд авагджээ.
8. Гэтэл давж заалдах шатны шүүхээс “... хариуцагч Яам байгаль орчныг нөхөн сэргээсэн эсэхийг шалгаж тогтоосны үндсэн дээр дүгнэлт гаргах үүрэгтэй бөгөөд харин энэ тохиолдолд өөрийн харьяа орон нутгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, байгаль орчны байцаагч, Орхон-Чулуут голын сав дахь хэсгийн 4, 26 дугаар зүйлийн 1-д заасан үүрэг хүлээсэн газар болон Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2 байгууллагаас хамтарч хийсэн хяналт шалгалтын дүн, аймгийн Засаг даргын саналыг үндэслэж дүгнэлтээ гаргасныг хууль зөрчсөн гэж үзэхгүй” гэж дүгнэсэн боловч ямар баримтад үндэслэж ийнхүү дүгнэсэн, мөн хэрэгт авагдсан бусад баримтуудыг хэрхэн үнэлж дүгнэсэн нь ойлгомжгүй болсон, иймд анхан шатны шүүх маргаан бүхий дээрх захиргааны актуудын үндэслэлийг шалгаж буюу нэхэмжлэгч

“Б” ХХК нь тусгай зөвшөөрөл бүхий талбайд ашиглалт хийхдээ Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2.6-д заасан байгаль орчинд хортой нөлөөлөл учруулах ямар үйлдэл /эс үйлдэхүй/ гаргасан, энэ нь хяналт шалгалтын ямар акт, баримтаар тогтоогдсон, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны ...ажлын хэсэг ямар баримтад үндэслэн дүгнэлт гаргасан, тус компанийн тусгай зөвшөөрлийг цуцлах Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.5-д заасан үндэслэл бүрдсэн эсэх, маргаан бүхий захиргааны актуудын улмаас нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөх эсэхэд дүгнэлт өгч хэргийг шийдвэрлэх шаардлагатай байна.

9. Иймд шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаах үндэслэлтэй тул нэхэмжлэгчийн өмгөөлөгчийн “... магадлалыг хүчингүй болгож, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээх”-ээр гаргасан хяналтын гомдлыг хангах үндэслэлгүй гэж шүүх бүрэлдэхүүн дүгнэв.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.1, 127.2.5-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 128/ШШ2020/0413 дугаар шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн 507 дугаар магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаасугай.
2. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь хэсэгт заасныг баримтлан нэхэмжлэгчээс хяналтын гомдол гаргахдаа улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 70,200 төгрөгийг төрийн сангийн орлогод хэвээр үлдээсүгэй.

Шүүхийн шийдвэрийн дүгнэлт

Энэ төрлийн зөрчлийг шалгах эрх бүхий албан тушаалтан Архангай аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 01/53 тоот хяналт шалгалтын танилцуулга, “Нөхөн сэргээлт хийсэн газрыг хүлээн авсан акт” №6, Орхон-Чулуут голын сав газрын захиргааны 2019 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 150 тоот албан бичиг, Архангай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2019 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 333 тоот албан бичиг гэх баримтуудыг хэрэгт хавсаргасан нь тухайн хэргийг бүрэн нотолж чадахгүй байна.

Харин Байгаль орчныг нөхөн сэргээсэн эсэхийг шалгаж тогтоох, Орхон-Чулуут голын сав газар болон Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4, 26 дугаар зүйлийн 1-д заасан үүрэг хүлээсэн байгууллагаас хамтарч хийсэн хяналт шалгалтыг үр дүнгүй хийсэн, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2.6-д заасан байгаль орчинд хортой нөлөөлөл учруулах ямар үйлдэл /эс үйлдэхүй/ гаргасан болохыг хяналт шалгалтын ямар нэгэн акт, баримтаар тогтоогоогүй зэрэг нь хэргийг шүүхээр шийдвэрлэхэд эргэлзээ төрүүлж, буцаах шалтгаан болсон байна.

3.2 ХӨРС ХАМГААЛАХ, ЦӨЛЖИЛТӨӨС СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ ЗӨРЧИХ, ЗӨРЧЛИЙН ШИНЖ, ОНЦЛОГ, АНХААРАХ АСУУДАЛ

3.2.1. Шийтгэл, эрх бүхий албан тушаалтан ба харьяалал, нэр томъёоны тайлбар

Шийтгэл. Зөрчлийн тухай хуулийн 7.2 дугаар зүйлийн Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль зөрчих тохиолдолд зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд дараах шийтгэл оногдуулна. Үүнд: (1) хуульд заасан (1.1) хөрс хамгаалах, (1.2) цөлжилтөөс сэргийлэх, (1.3) цөлжилттэй тэмцэх арга хэмжээний тухай журам зөрчсөн бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Зөрчлийг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан ба харьяалал. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлд зааснаар Зөрчлийн тухай хуулийн 7.2 дугаар зүйлийн Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль зөрчих зөрчлийг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан болон харъяаллыг доорх хүснэгтээр харуулав. Үүнд:

Эрх бүхий албан тушаалтан	Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харьяалал
Зөрчлийн тухай хуулийн 7.2 дугаар зүйл. Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль зөрчих	
Байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37)	Зөрчлийн тухай хуулийн 7.2 дугаар зүйлийн 1.1 дэх заалт
Байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37) Газар, геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагч (6.40)	Зөрчлийн тухай хуулийн 7.2 дугаар зүйлийн 1.2 дахь заалт
Байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37) Газар, геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагч (6.40)	Зөрчлийн тухай хуулийн 7.2 дугаар зүйлийн 1.3 дахь заалт

Хуулийн нэр томъёоны тайлбар. Зөрчлийн тухай хуулийн 7.2 дугаар зүйлд заасан зөрчилтэй холбогдох нэр томьёог Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуульд тайлбарласан байдаг бөгөөд тэдгээрийг дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

“Хөрс” гэж газрын гадаргын өнгөн хэсгийн үржил шимт давхарга бүхий сэвсгэр хэсгийг,

“Хөрсний доройтол” гэж хөрсний үржил шим муудах, элэгдэл, эвдрэлд орох, бохирдох, бэлчээр талхлагдаж анхны шинж чанараа алдахыг,

“Цөлжилт” гэж уур амьсгалын өөрчлөлт, хүний үйл ажиллагаа зэрэг бусад хүчин зүйлийн нөлөөгөөр хөрс доройтох үйл явцыг,
“Хөрс хамгаалах” гэж хөрсийг хүний болон байгалийн хүчин зүйлийн нөлөөгөөр доройтохоос хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг,

“Хөрсийг нөхөн сэргээх” гэж доройтсон хөрсийг анхны төрх байдалд нь оруулах, үржил шимийг нь нэмэгдүүлэн сайжруулах үйл явцыг,

“Цөлжилтөөс сэргийлэх арга хэмжээ” гэж цөлжих нөхцөл байдлыг илрүүлэх, мэдээлэх, хөрсийг сайжруулахад чиглэсэн цөлжилтөөс зайлсхийх үйл ажиллагааг,

“Цөлжилтийг сааруулах арга хэмжээ” гэж цөлжилтийн эсрэг техникийн болон биологийн үйл ажиллагаа явуулж, түүний тархалт, идэвхжилт, үйл явцыг удаашруулах, тогтоох арга хэмжээг,

“Цөлжилттэй тэмцэх арга хэмжээ” гэж хөрсний доройтол, цөлжилтийн тархалт, идэвхжилтийг бууруулах, зогсоох, сөрөг нөлөөллийг арилгах үйл ажиллагааг,

“Хуурайшлын индекс” гэж тухайн газар нутгийн жилийн тундасны хэмжээ болон ургамал, хөрсний нийлбэр ууршилт хоорондын харьцааг тус тус ойлгоно.

Мөн Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 5 дугаар зүйлд хөрсний доройтол, цөлжилтийн төлөв байдлыг сул, дунд, хүчтэй гэсэн зэрэглэлээр ангилсан байна. Үүнд:

“Хөрсний доройтлын сул зэрэглэлд” тухайн газар нутгийн хөрсний талбайн таван хувиас бага бохирдсон, эсхүл хөрсний өнгөн хэсэг бага зэрэг элэгдсэн, ялзмагийн нөөцийн багасалт 25 хувиас бага газар, *“Хөрсний доройтлын дунд зэрэглэлд”* тухайн газар нутгийн хөрсний талбайн 5-20 хувь бохирдсон, эсхүл хөрсний өнгөн хэсэг эвдрэлд орсон, ялзмагийн нөөцийн багасалт 25-50 хувьд хүрсэн газар, *“Хөрсний доройтлын хүчтэй зэрэглэлд”* тухайн газар нутгийн хөрсний талбайн 20-50 хувь бохирдсон, эсхүл хөрс гүн эвдрэлд орсон, үржил шимт чанараа алдаж ялзмагийн нөөцийн багасалт 50-аас дээш хувьд хүрсэн газар тус тус хамаарна.

“Цөлжилтийн сул зэрэглэлд” хөрсний доройтлын сул зэрэглэлд багтах тухайн газрын хуурайшлын индекс сүүлийн 30 жилд 0.1 нэгжээр буурсан газар, *“Цөлжилтийн дунд зэрэглэлд”* хөрсний доройтлын дунд зэрэглэлд багтах тухайн газрын хуурайшлын индекс сүүлийн 30 жилд 0.2 нэгжээр буурсан газар, *“Цөлжилтийн хүчтэй зэрэглэлд”* хөрсний доройтлын хүчтэй зэрэглэлд багтах газрын хуурайшлын индекс сүүлийн 30 жилд 0.3 нэгжээр ихээр буурсан газар тус тус хамаарна.

3.2.2. Зөрчлийн ойлголт, шинж ба төсөөтэй гэмт хэргээс ялгагдах шинж

Зөрчлийн тухай хуулийн 7.2 дугаар зүйлийн Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хууль зөрчих зөрчлийн ойлголт. Хөрс хамгаалах, хөрсний сул, дунд, хүчтэй зэрэглэлийн доройтол илэрсэн хөрстэй тэмцэх, хөрсийг нөхөн сэргээх, хөрс хамгаалах чадавхийг бэхжүүлэх, бүс нутгийн онцлогт тохируулан газрын тогтвортой менежментийг бий болгох, ойн зурвас бүхий тариалан эрхлэлтийг дэмжих, усны нөөцийг зөв зохистой ашиглах, хамгаалах, нэмэгдүүлэх, ой болон ургамлыг хамгаалах, ойжуулах, тариалангийн талбайн хөрс хамгаалах, хөдөө аж ахуй, хот суурин, тусгай болон ойн хэрэгцээний газрын хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй үйлдэл эс үйлдэхүйг хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль зөрчил гэнэ.

Зөрчлийн тухай хуулийн 7.2 дугаар зүйлийн Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль зөрчих зөрчлийн шинжийг дор харуулав.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль зөрчих зөрчил 7.2 дугаар зүйл

- Сул зэргийн хөрсний доройтол илэрсэн тохиолдолд сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлээгүй
- Дунд зэргийн хөрсний доройтол илэрсэн тохиолдолд сааруулах арга хэмжээг хэрэгжүүлээгүй
- Хүчтэй зэргийн хөрсний доройтол илэрсэн тохиолдолд сааруулах арга хэмжээг хэрэгжүүлээгүй
- **Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлээгүй үйлдэл эс үйлдэхүй. Үүнд:**
- Бэлчээрийг тухайн орон нутгийн малын тоо толгойд тохируулан улирлын хувааръгай ашиглахгүй байх
- 100 га-аас дээш талбайд үр тарианы тариалалтын үйл ажиллагаа явуулахдаа зурваслан тариалалт хийх
- Тариалангийн газрын хөрсний үржил шимийг дээшлүүлэх, хөрс хамгаалах техник, технологийг нэвтрүүлэхгүй байх
- Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тогтоосон цэгээс бусад газарт хөрсийг хог хаягдлаар бохирдуулахгүй байх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага эрүүл ахуйн шаардлага хангасан бохир ус зайлуулах байгууламжтай байх
- Барилга байгууламж барьж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь барилгын ажлын явцад болон дууссаны дараа эвдэрсэн газрын хөрсийг нөхөн сэргээхгүй орхих
- Иргэн, хуулийн этгээд өмчлөлийн газрын 10 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу мод тарьж, зүлэгжүүлэхгүй орхих
- Тогтоосон авто зогсоол болон авто замын зорчих хэсгээс бусад газарт тээврийн хэрэгсэл зогсоох
- Бичил уурхайн зориулалтаар олгосон газар болон газрын тосны гэрээт талбай, ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээд нь үйл ажиллагааныхаа явцад доройтсон хөрсийг биологийн нөхөн сэргээлтийн стандартын шаардлагад нийцүүлэн нөхөн сэргээхгүй орхих
- Аймаг дундын отрын бэлчээрийн болон улсын тэжээлийн сангийн хадлангийн талбайн газрыг хувааръгай сэлгэн ашиглахгүй байх
- Мод бэлтгэсэн талбайг хэршихээс өмнө ойжуулахгүй орхих, мод бэлтгэлийг технологийн дагуу явуулах байх
- Хөрсний ялзмаг, үржил шимийг тогтоох, дороитлоос хамгаалах зорилгоор гуу, жалга үүсэж болох газарт хаалт хамгаалалт хийхгүй, ойжуулаагүй байх зэрэг хуульд заасан шинжтэй байна.

Сул зэргийн хөрсний доройтол илэрсэн тохиолдолд сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлээгүй гэж тухайн газар нутгийн хөрсний талбайн таван хувиас бага бохирдсон, эсхүл хөрсний өнгөн хэсэг бага зэрэг элэгдсэн, ялзмагийн нөөцийн багасалт 25 хувиас бага газар нутагт Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлээгүй байхыг ойлгоно.

Дунд зэргийн хөрсний доройтол илэрсэн тохиолдолд сааруулах арга хэмжээг хэрэгжүүлээгүй гэж хөрсний доройтлын дунд зэрэглэлд тухайн газар нутгийн хөрсний талбайн 5-20 хувь бохирдсон, эсхүл хөрсний өнгөн хэсэг эвдрэлд орсон, ялзмагийн нөөцийн багасалт 25-50 хувьд хүрсэн газар нутагт цөлжилтийн эсрэг техникийн болон биологийн үйл ажиллагаа явуулж, түүний тархалт, идэвхжилт, үйл явцыг удаашруулах, тогтоох арга хэмжээг хэрэгжүүлээгүйг ойлгоно.

Хүчтэй зэргийн хөрсний доройтол илэрсэн тохиолдолд сааруулах арга хэмжээг хэрэгжүүлээгүй гэж хөрсний доройтлын хүчтэй зэрэглэлд тухайн газар нутгийн хөрсний талбайн 20-50 хувь бохирдсон, эсхүл хөрс гүн эвдрэлд орсон, үржил шимт чанараа алдаж ялзмагийн нөөцийн багасалт 50-аас дээш хувьд хүрсэн газар нутагт хөрсний доройтол, цөлжилтийн тархалт, идэвхжилтийг бууруулах, зогсоох, сөрөг нөлөөллийг арилгах үйл ажиллагааг хэрэгжүүлээгүйг ойлгоно.

Зөрчлийн төсөөтэй гэмт хэргээс ялгагдах шинж. Эрүүгийн хуульд энэ төрлийн зөрчилтэй шууд адилтган үзэх зүйл, заалт байхгүй тул Зөрчлийн тухай хуулийн 7.2 дугаар зүйлийн Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль зөрчих зөрчлийн шинжээр нь нэг мөр ойлгож, хэрэглэнэ. Гэхдээ Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.1 дүгээр зүйлийн Байгаль орчныг бохирдуулах гэмт хэрэгт заасан зүйлтэй төсөөтэй тул харьцуулж авч үзье.

Хүснэгт 3.2. *Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль зөрчих зөрчлийн төсөөтэй гэмт хэргээс ялгагдах шинж*

Ялгагдах шинж	Байгаль орчныг бохирдуулах (Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.1 дүгээр зүйл)	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль зөрчих (Зөрчлийн тухай хуулийн 7.2 дугаар зүйл)
Объект	Байгаль орчны цэвэр ариун байдал, унаган төрх байх бөгөөд хүн амын эрүүл мэнд давхар объект болно.	Байгаль орчныг хамгаалах журам
Объектив тал	Химийн хорт, аюултай бодис, аюултай, хортой хог хаягдлыг агаар, газар, газрын хэвлий, усны сан бүхий газар, гол мөрний урсац бүрэлдэх эх, эх үүсвэрийн тэжээгдлийн муж, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хамгаалалтын бүс дотор хаяж хүний эрүүл мэнд, мал, амьтан, ургамал, тэдгээрийн үр удамд сөрөг нөлөөлөл үзүүлэх, өвчин эмгэг үүсгэх, үхэл, мөхөлд хүргэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх, цөлжилттэй тэмцэх арга хэмжээний тухай журам зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй байна.

Субьект	Эрүүгийн хуульд заасан 16 насанд хүрсэн хэрэг хариуцах чадвартай Монгол Улсын харьяат болон гадаадын харьяат, аль ч улсын харьяат бус хүн, хуулийн этгээд байна. Ихэвчлэн химийн хорт, аюултай бодис үйлдвэрлэдэг, импортоор оруулж ирдэг, худалдан авч аж ахуйн үйл ажиллагаанд ашигладаг (олборлолт, боловсруулалт, бүтээгдэхүүн үйлдвэрлэл г.м), тэдгээр үйл ажиллагааны улмаас аюултай, хортой хог хаягдлыг бий болгодог үйлдвэр, аж ахуйн нэгжийн эрх бүхий албан тушаалтан эсвэл үйлдвэрийн эзэн, холбогдол бүхий иргэн байна.	Зөрчлийн тухай хуулийн 3.2-т заасан 16 настай хэрэг хариуцах чадвартай хувь хүн, хуулийн этгээд байна.
Субьектив тал	Байгаль орчин борирдуулах гэмт хэрэг гэм буруугийн санаатай хэлбэр байна.	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх, цөлжилттэй тэмцэх арга хэмжээний журам зөрчсөн гэм буруугийн санаатай хэлбэр байна.

3.2.3. Зөрчлийн зүйлчлэл

Энэ төрлийн зөрчлийг шалгах эрх бүхий албан тушаалтан нар нь дээр дурдсан энэ төрлийн зөрчлийн шинжийн аль нэгийг зөрчсөн этгээдийн үйлдэл эс үйлдэхүйд Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль зөрчих зөрчлөөр зүйлчилж Зөрчлийн тухай хуульд заасан шийтгэл оногдуулна.

Зөрчлийн тухай хуулийн 7.2 дугаар зүйлийн Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль зөрчих зөрчил нь хөрсний сул, дунд, хүчтэй зэрэглэлийн доройтол илэрсэн хөрсийг нөхөн сэргээх, хөрс хамгаалах чадавхийг бэхжүүлэх, бүс нутгийн онцлогт тохируулан газрын тогтвортой менежментийг бий болгох, ойн зурвас бүхий тариалан эрхлэлтийг дэмжих, усны нөөцийг зөв зохистой ашиглах, хамгаалах, нэмэгдүүлэх, ой болон ургамлыг хамгаалах, ойжуулах, тариалангийн талбайн хөрс хамгаалах, хөдөө аж ахуй, хот суурин, тусгай болон ойн хэрэгцээний газрын хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх журам зөрчснөөр төгс үйлдэгдсэнд тооцогдоно.

3.2.4. Зөрчлийг шалгах тодорхой ажиллагаа

Шинэчлэн найруулсан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 9.1 дүгээр зүйлийн Зөрчил шалган шийдвэрлэх тусгай журамд зааснаар Эрх бүхий албан хаагч Зөрчлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 5.2 дугаар зүйл, 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 5.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 5.13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 6.20 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 6.26 дугаар зүйл 8.6, 8.7 дугаар зүйл, 14.7 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 15.33 дугаар зүйл, 17.1 дүгээр зүйлийн 7, 16 дахь хэсэг, 18.1, 18.2, 18.4 дэх заалт, 23 дахь хэсэгт заасан зөрчлийг шалгахад энэ хуульд заасан ердийн журмаас гадна, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр бүлэгт заасан тусгай журмыг баримтлан хэргийн газрын үзлэг хийх, таньж олуулах, туршилт хийх, нүүрэлдүүлж мэдүүлэг авах, ердийн ажиглалт явуулах, мэдүүлгийг газар дээр нь шалгах зэрэг ажиллагааг явуулна хэмээн заасан.

Харин байгаль орчны хяналтын улсын байцаагч, улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч нар нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр бүлэгт заасан зөрчил шалган шийдвэрлэх зорилгоор дараах тодорхой ажиллагааг явуулна. Үүнд:

Үзлэг хийх. Эд зүйл, баримт бичиг, ачаа тээш, мал, амьтан, тээврийн хэрэгсэл болон бусад эд зүйлд үзлэг хийнэ.

Түүнчлэн Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан хөрс хамгаалах, хөрсний сул, дунд, хүчтэй зэрэглэлийн доройтол илэрсэн хөрстэй тэмцэх, хөрсийг нөхөн сэргээх, хөрс хамгаалах чадавхийг бэхжүүлэх, бүс нутгийн онцлогт тохируулан газрын тогтвортой менежментийг бий болгох, ойн зурвас бүхий тариалан эрхлэлтийг дэмжих, усны нөөцийг зөв зохистой ашиглах, хамгаалах, нэмэгдүүлэх, ой болон ургамлыг хамгаалах, ойжуулах, тариалангийн талбайн хөрс хамгаалах, хөдөө аж ахуй, хот суурин, тусгай болон ойн хэрэгцээний газрын хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй үйлдэл эс үйлдэхүйг олж тогтоох зорилгоор газар дээр нь үзлэг шалгалт хийнэ.

Хураан авах. Зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлого, эд зүйл, зөрчил үйлдэхэд ашигласан зэвсэг, хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, уналга эсхүл зөрчил шалгах ажиллагаанд ач холбогдолтой эд зүйл, баримт бичгийг хураан авна.

Мөн түүнчлэн хөрс хамгаалах, цөлжилттэй тэмцэх арга хэмжээ, хөдөө аж ахуйн газрын хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх арга хэмжээ, хот тосгон, суурин газрын хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх арга хэмжээ, тусгай хэрэгцээний газрын хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх арга хэмжээ, ойн сангийн газрын хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх эрх бүхий албан тушаалтны тушаал, захирамж, төлөвлөгөө, тайлан, биелэлт, үр дүн, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой үүрэг хүлээсэн албан тушаалтнуудын холбогдох баримт бичиг зэргийг хураан авч шалгаж тогтооно.

Эд хөрөнгө битүүмжлэх. Хураан авах эд хөрөнгө нь овор хэмжээ эсхүл бусад шалтгаанаар зөрчлийн хэрэгт хадгалах боломжгүй бол байгаа газарт нь битүүмжилнэ.

Мэдүүлэг авах. Эрх бүхий албан тушаалтан зөрчил гарсан байдлыг тодруулах, зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдол бүхий баримт, мэдээллийг олох зорилгоор мэдүүлэг авна. Тухайн зөрчилд хамаарах асуудлаар зөрчил үйлдсэн байж болзошгүй холбогдогч, зөрчлийн талаар мэдэх болсон хүнийг гэрчээр, зөрчлийн улмаас хор хохирол хүлээсэн байгууллага, иргэнийг хохирогчоор тус тус хуульд заасан үндэслэл журмын дагуу мэдүүлэг авч, энэ тухай тэмдэглэл үйлдэнэ.

Мэдүүлгийн эхэнд тухайн зөрчлийн талаарх мэдүүлж буй бүх зүйлсийг үгчлэн, дэлгэрэнгүй бичих бөгөөд үүний дараа холбогдох асуудлаар тодруулан мэдүүлэг авна. Зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтан мэдүүлгийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.8, 4.9-д заасан журмаар явуулж, тэмдэглэл үйлдэнэ.

Шинжилгээнд зориулж хэв загвар, дээж авах. Шинжилгээ хийх зорилгоор ойн зурвас, газар тариалан, усны нөөц бүхий газар орон, хөдөө аж ахуй, хот суурин, тусгай хэрэгцээний газрын хөрс, ургамал зэргээс дээж авна.

Шинжилгээ хийлгэх. Эрх бүхий албан тушаалтан хөрсний доройтол, цөлжилтийн төлөв байдлын судалгаа, дүгнэлтийг мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлнэ.

Цөлжилтийн зэрэглэлийг тогтоохдоо “хуурайшлын индекс” ашиглаж болно. Энэ хуульд НҮБ-ийн Хүрээлэн буй орчны хөгжлийн хөтөлбөр (United Nations Environmental Program (UNEP))-өөс боловсруулсан хувилбарыг үндэслэл болгон авчээ. Үүнд: хуурайшлын индекс 0-ээс 1 хүртэл утгатай, хур тундасаас шууд, агаарын температураас урвуу хамааралтай байна. Индексийн утга 0.65-аас их бол чийглэг, 0.5-0.65 бол хагас чийглэг, 0.5-0.2 байхад хуурайвтар, 0.2-0.05 байхад хуурай гандуу, 0.05-аас бага бол хэт хуурай нутагт тооцогдоно.

AIu = P/PET, AIu-Хуурайшлын индекс (Aridity Index, UNEP), P-Жилийн дундаж нийлбэр хур тундас (average annual precipitation), PET-Ургамал, хөрсний нийлбэр ууршилт (potential evapotranspiration)-ын харьцаагаар хуурайшлын индексийг тогтоолгож болно.

3.2.5. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд анхаарах асуудал

Хөрс хамгаалах үйл ажиллагаа нь цогцолбор шинжтэй байдаг бөгөөд тухайн газар нутгийн хөрсийг элэгдэл эвдрэлд орох, бохирдох, давсжих, элсжих үйл явцаас сэргийлэх зорилготой. Иймд зөрчил шалгах ажиллагааг зөрчил үйлдэгдсэн газрын газар зохион байгуулалт, газар ашиглалт, бэлчээрийн менежмент, тариалангийн хөрс хамгаалах цогцолбор арга хэмжээ, авто зам, дэд бүтцийн хөгжил, хот суурин газрын төлөвлөлт, хөрсний эвдрэлээс сэргийлэх механик хаалт, ойжуулах, зүлэгжүүлэх гэх мэт арга хэмжээтэй холбогдуулан шалгах нь зүйтэй.

Цөлжилтийн зэрэглэлийг тогтоох, үнэлэх олон янзын аргууд бий. Эдгээрээс хамгийн энгийн арга нь дээр дурдсан хөрс болон цаг агаарын зарим үзүүлэлтийг ашигласан хуурайшлын идексийн арга бөгөөд үүнийг энэ төрлийн зөрчлийг шалгахад ашиглаж болно. Хөрс нь ургамлан бүрхэвчийг бодвол харьцангуй тогтвортой шинж чанартай учир олон улсын практикт хөрсний энэ шинж чанарыг илүү ашиглаж байна.

Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль зөрчих зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааг явуулахдаа дараах зүйлсийг анхаарах нь зүйтэй. Үүнд:

- Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан хөрсний сул зэрэглэлийн доройтол илэрсэн хөрсөнд сэргийлэх, дунд зэрэглэлийн доройтол илэрсэн хөрсөнд сааруулах, хүчтэй зэрэглэлийн доройтол илэрсэн хөрсөнд тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлсэн эсэхийг шалгаж тогтооно.
- Байгаль орчны хяналтын улсын байцаагч, улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч нар Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.4 дүгээр зүйл дэх “зөрчлийн үр дагаврыг арилгах зорилгоор ариутгах, хоргүйжүүлэх, цэвэршүүлэх, засвар үйлчилгээ хийх, холбогдох бүтээгдэхүүнийг борлуулахыг хориглох, иргэний гүйлгээнээс буцаан татах, хохирлыг нөхөн төлүүлэх, зөрчлийг арилгах хүртэлх хугацаанд үйл ажиллагаа, ашиглалтыг зогсоох, энэ талаар олон нийтэд зарлан мэдээлэх зэрэг арга хэмжээ авч болно” гэсэн заалтыг үндэслэн зөрчил үйлдэгдсний улмаас эвдэрсэн хөрсийг нөхөн сэргээх, эвдрэлд орсон газрын нүхийг булж, налууг багасгах зэргээр гадаргыг хэлбэршүүлж нягтруулах, хөрсгүй болсон газрын дээд хэсэгт 10-20 см зузаан шимт хөрсөөр хучих замаар нөхөн сэлгээлт хийлгэж зөрчлийн үр дагаварыг арилгах арга хэмжээг авна.
- Хөрсний шинж чанарт гарч байгаа өөрчлөлтийг итгэмжлэгдсэн хөрсний лаборатори тогтооно. Хөрсөнд доройтол учруулсан тохиолдолд мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн байгаль орчны хяналтын улсын байцаагч, холбогдох сум, дүүргийн Засаг дарга учирсан хохирлыг арилгуулж, Зөрчлийн тухай хуулийн 7.2 дугаар зүйлийн Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль зөрчих зөрчилд зааснаар шийтгэл оногдуулна. Эрх бүхий албан тушаалтан зөрчийн үр дагаварыг арилгуулах арга хэмжээг хэрэгжүүлсэн нь зөрчил үйлдсэн этгээдийг шийтгэлээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

- Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан хөрс хамгаалах, хөрсний сул, дунд, хүчтэй зэрэглэлийн доройтол илэрсэн хөрстэй тэмцэх, хөрсийг нөхөн сэргээх, хөрс хамгаалах чадавхийг бэхжүүлэх, бүс нутгийн онцлогт тохируулан газрын тогтвортой менежментийг бий болгох, ойн зурвас бүхий тариалан эрхлэлтийг дэмжих, усны нөөцийг зөв зохистой ашиглах, хамгаалах, нэмэгдүүлэх, ой болон ургамлыг хамгаалах, ойжуулах, тариалангийн талбайн хөрс хамгаалах, хөдөө аж ахуй, хот суурин, тусгай болон ойн хэрэгцээний газрын хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй үйлдэл эс үйлдэхүйг олж тогтоох
- Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх талаар Засгийн газар болон бусад эрх бүхий байгууллагаас батлан гаргасан бодлого, хөтөлбөрийн дагуу хүлээсэн (хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх үйл ажиллагаатай холбогдсон дүрэм, журам, нөхөн сэргээх технологи г.м) үүргээ биелүүлсэн эсэхийг шалгах
- Хөрсний доройтол, цөлжилтийн төлөв байдлын судалгааг хийлгэх (үүнд хөрсний доройтол, цөлжилт үүсгэж байгаа шалтгаан, эх үүсвэр, төлөв байдлын зэрэглэл, тархалтын хүрээ, хөрсний шинж чанар, шууд болон шууд бус хохирол болон доройтолд орсон хөрсний экологи-эдийн засгийн үнэлгээг тогтоолгох г.м) зэрэг шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Бодит жишээ	Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр

******* аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүх хуралдааныг шүүгч Б.Баярцогт даргалж, тус шүүхийн шүүх хуралдааны “Б” танхимд нээлттэй хийж Гомдол гаргагч: “********” ХХК-ийн гомдолтой, Хариуцагч: ******* аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч*******,

Гомдлын шаардлага: “******** аймгийн Байгал орчин, аялал жуулчлалын газрын улсын байцаагч*******ын “********” ХХК-д оногдуулсан 0048006 дугаартай шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах”-ыг хүссэн гомдлын шаардлагатай захиргааны хэргийг хянан хэлэлцэв.

Шүүх хуралдаанд: Гомдол гаргагч “********” ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Ч.Мөнхсүх, хариуцагч ******* аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч*******, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга Э.Энхсаруул нар оролцов.

ТОДОРХОЙЛОХ нь:

1. Хэргийн нөхцөл байдлын талаарх хураангуй:

1.1. Гомдлын шаардлага: Гомдол гаргагч “********” ХХК нь ******* аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч*******-д холбогдуулан ******* аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч*******ын “********” ХХК-д 2023 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 0048006 дугаартай шийтгэлийн хуудсаар Зөрчлийн тухай хуулийн 7.2 дугаар зүйлийн 1.3 дахь хэсэгт зааснаар 500 нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 500.000 төгрөгийн торгууль оногдуулж, байгаль орчинд учирсан хохирлын нөхөн төлбөрт 26.428.343.12 төгрөг, хохирлыг тогтооход гарсан зардалд 3.000.000 төгрөгийг төлөх тухай шийдвэрийг хүчингүй болгуулахаар гомдол гаргасан.

1.2. Эрх бүхий албан тушаалтан болох ******* аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Байгаль орчны хяналтын улсын байцаагч ******* нь ******* аймаг дахь Цагдаагийн

газраас харьяаллын дагуу шилжүүлсэн ******* аймгийн******* сумын 2 дугаар багт үйл ажиллагаа явуулдаг "*******" ХХК нь орон нутгийн зөвшөөрөлгүйгээр ус зөөвөрлөж, маршрут зөрчиж хөрс эвдсэн гэх гомдол мэдээлэлд зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулаад Зөрчлийн тухай хуулийн 7.2 дугаар зүйлийн 1.3 дахь хэсэгт заасан зөрчил гаргасан гэж үзээд "*******" ХХК-д 500 нэгжтэй тэнцэх буюу 500.000 төгрөгөөр торгож, байгаль орчинд учирсан хохирлын нөхөн төлбөрт 26.428.343.12 төгрөг, хохирол тогтоох зардалд 3.000.000 төгрөгийг тус тус гаргуулахаар шийтгэл ногдуулжээ.

2. Процессын түүх:

2.1. Дээрх шийтгэлийн хуудсыг "*******" ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Х.Эрдэнэцогтод 2023 оны 4 дүгээр сарын 03-ны өдөр танилцуулсан байх бөгөөд тэрээр гаргасан шийдвэртэй танилцаж гарын үсэг зурсан байна.

2.2. "*******" ХХК нь маргаан бүхий шийтгэлийн хуудсыг эс зөвшөөрч шүүхэд гомдол гаргасан бөгөөд уг гомдлоо 2023 оны 4 дүгээр сарын 06-ны өдөр шууданд хийсэн байх бөгөөд оролцогчийн гомдлыг тус шүүх 2023 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр хүлээн авч танилцаад, 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр захиргааны хэрэг үүсгэн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулсан.

*3. Гомдол гаргагч "*******" ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Ч.Мөнхсүх шүүхэд гаргасан гомдолдоо:* "*******" ХХК нь Байгаль орчин, аялал жуулчлалын газрын улсын байцаагч ******* ын 2023 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 0048006 дугаартай шийтгэлийн хуудас үйлдэж Зөрчлийн тухай хуулийн 7.2 дугаар зүйлийн 1.3 дэх хэсгийг зөрчсөн гэх үндэслэлээр зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа бөгөөд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан эрхийн дагуу мөн "Зөрчлийн хэргийн бодит байдлыг тогтоох" зарчмуудыг зөрчиж үндэслэлгүй шийтгэх хуудас гаргасан гэж үзэж энэхүү гомдлыг гаргаж байна.

Улсын байцаагчаас зөрчлийн хэргийг шийдвэрлэхдээ хэт нэг талыг баримтлан урьдчилсан дүгнэлт гаргаж, оролцоог хангалгүйгээр зөрчил шалган шийдвэрлэсэн тухайд.

3.1. Шийтгэлийн хуудсаар хохирлын нөхөн төлбөр болох 26.428.343 төгрөг төлүүлэх үндэслэл болсон Байгаль орчны үнэлгээ хийх эрх бүхий "*******" ХХК-ийн шинжээчийн 2023 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн дүгнэлт нь буруу аргачлал ашиглаж гаргасан хохирлын үнэлгээ, шинжээчийн дүгнэлтийг хүчин төгөлдөр бусад тооцуулах тухай шинжээч "*******" ХХК нь тус дүгнэлтийн 1.6-д Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2010 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн А-156 тоот тушаалаар батлагдсан Байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн төлбөр тооцох аргачлалыг үндэслэл болгож хийсэн бөгөөд уг аргачлалаар байгалийн нөөц баялгийг ашиглах аливаа үйл ажиллагааны улмаас байгаль орчинд учирсан хохирлын үнэлгээг тооцоход ашигладаг бөгөөд манай компани нь ямарваа нэг байдлаар байгалийн нөөц баялгийг ашиглах үйл ажиллагаа явуулаагүй буруу аргачлал ашиглаж гаргасан хохирлын үнэлгээ, шинжээчийн дүгнэлтийг хүчин төгөлдөр бус болсон байна.

3.2. Тус эвдэрсэн замыг манай компани ашигладаггүй зөрчилд холбогдож буй тээврийн хэрэгсэл нь 4246 УНУ улсын дугаартай авто машин, 8169 УНР улсын дугаартай машинууд нь манай бүртгэлтэй машин биш бөгөөд ******* аймгийн******* сумаас "*******" ХХК-нд олгосон замын маршрут олгож тус замыг тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг

“********” ХХК, “Эф Жи Пи Эм” ХХК-уудын олон жилийн эвдрэл гэмтлийг зөвхөн манай компани үүсгэсэн мэтээр хариуцуулан торгох мөн хохирол, нөхөн сэргээх зардлыг шаардаж байгаа нь илт хууль бус шийтгэх хуудас болсон байна.

3.3. Захиргааны ерөнхий хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д заасан захиргааны шийдвэр гаргах ажиллагааны талаар хуульд заасан журмын дагуу мэдээлэл авах, холбогдох баримт бичгийг хуулбарлан авах, 15.1.4-т заасан захиргааны шийдвэр гаргахаас өмнө оролцогч нотлох баримт гаргах, шаардлагатай баримт бичгийг бүрдүүлэн өгөх, 92 дугаар 92.1-д Хуульд өөрөөр заагаагүй бол иргэн, хуулийн этгээдээс түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзвэл холбогдох захиргааны актыг хууль болон зорилгодоо нийцэж байгаа эсэх талаар хянуулахаар гомдол гаргах эрхтэй гэж заасан нэхэмжлэгчийн хуульд заасан эрхийг зөрчсөн, түүнчлэн мөн хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д Захиргааны акт, захиргааны гэрээг батлан гаргахын өмнө эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдэд захиргааны шийдвэр гаргахад ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаар тайлбар, санал гаргах боломж олгоно, 32 дугаар зүйлийн 32.1-д Захиргааны байгууллага өөрийн шийдвэрийн хүчин төгөлдөр байдлыг урьдчилан мэдэгдэх, тухайн шийдвэртэй холбоотой оролцогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад шаардлагатай баримт бичигтэй оролцогч, түүний төлөөлөгчид танилцах боломж олгоно гэж заасныг тус тус хэрэгжүүлэн ажиллах хуулиар тогтоосон журмыг зөрчин мөн хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-т заасан сонсох ажиллагаа-г явуулах үүргээ эрх бүхий албан тушаалтан хэрэгжүүлээгүй, мөн шинжээчийн дүгнэлт гаргасан “********” ХХК-ийн гүйцэтгэх захирал байгаль орчны шинжээч Г.Мөнгөнбаатар гэх хүн нь дүгнэлт гаргах эрхгүй, тус компанийн гүйцэтгэх захирал биш хүн байна.

3.4. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн “…5.1.Хяналт шалгалтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага /цаашид “хяналт шалгалтын байгууллага” гэх/ хуульд заасан үндэслэл, журмын дагуу хяналт шалгалтыг хийх бөгөөд хяналт шалгалтыг төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн гэж ангилна…”, мөн 5.2.Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу хийх бөгөөд түүнд дараах зүйлийг тусгана, мөн хуулийн 5.6-д Хяналт шалгалт эхлэхээс өмнө эрх бүхий албан тушаалтан шалгуулах этгээдэд шалгалтын зорилго, бүрэлдэхүүнийг танилцуулж удирдамж, хяналтын хуудасны нэг хувийг өгөх бөгөөд улсын байцаагч албаны үнэмлэхээ үзүүлнэ…” гэж заасан ч улсын байцаагч******* нь ямар нэгэн удирдамж, хөндлөнгийн шинжээч томилсон талаар танилцуулахгүйгээр мөн тус газрын байцаагч нар мөн хуулийн 5.4.Хяналт шалгалтыг холбогдох асуудлын талаар урьдчилсан дүгнэлт гаргаж, түүнийгээ батлах замаар хийхийг хориглоно гэж заасныг ноцтойгоор зөрчиж, Зөрчлийн тухай хуулийн 7.2 дугаар зүйлийн 1.3 дэх хэсгийг зөрчсөн буюу цөлжилттэй тэмцэх арга хэмжээний тухай журам зөрчсөн гэх үндэслэлгүй урьдчилсан дүгнэлт гарган шийдвэр гаргасан хууль бус болсон байна. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1 дэх заалтад зааснаар “…тухайн хүн … зөрчил үйлдсэнийг нотлох баримт бүрдсэн эсэх”-ийг эрх бүхий албан тушаалтан тогтоосон байх ёстой…” мөн хуулийн 4.1 дүгээр зүйлийн 1-д эрх бүхий албан тушаалтан энэ хуульд заасны дагуу зөрчил шалгах ажиллагаа явуулж, нотлох баримт цуглуулж, бэхжүүлнэ…” гэж заасныг зөрчсөн, зөрчил шалгах тодорхой ажиллагааг зөрчсөн юм.

3.5. 2023 оны 4 сарын 03-ны өдөр ирж шийтгэлийн хуудастай танилц гэсэн дагуу танилцаж гомдол гаргах, хэргийн материалтай танилцах, хуулбарлах, утас дээрээ зураг дарах эрхээр хангаагүй бөгөөд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.12 дугаар зүйлийн

4-д заасан оролцогч энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан прокурорын шийдвэрийг эс зөвшөөрвөл шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор тухайн нэгжийн дээд шатны прокурорт гомдол гаргаж болно гэсэн эрхийг зөрчиж 2023 оны 4 дүгээр сарын 03-ны өдөр улсын байцаагч******* нь дуудан зөрчлийн хэргийг хааж байгааг мэдэгдэн 0048006 дугаартай шийтгэлийн хуудсыг танилцуулсан явдал нь Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн урьдчилсан дүгнэлт гарган шийдвэр гаргасан хууль бус шийдвэр болсон бөгөөд дээрх хуульд заасан оролцоог хангаагүй нэг талын шийдвэр үйл баримтын хүрээнд маргаан бүхий захиргааны актыг гаргахдаа захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд нэхэмжлэгчийн оролцоог хангахгүйгээр гаргасан нь Захиргааны ерөнхий хуулийн 4.2.6-д заасан “бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах тохиолдолд тэдгээр урьдчилан мэдэгдэх, оролцоог нь хангах” зарчмыг бүрэн хангаагүйгээр хариуцагч нь шийдвэр гаргасан байна.

Иймд дээрх үндэслэлүүдээр Байгаль орчин, аялал жуулчлалын газрын улсын байцаагч *******-ын 2023 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 0048006 дугаартай шийтгэлийн хуудсыг бүхэлд нь хүчингүй болгон шийдвэрлэж өгнө үү гэжээ.

Гомдол гаргагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Ч.Мөнхсүх шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа:
3.6. “********” ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч би тус шүүхэд хянан шийдвэрлэгдэж буй ******* аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын улсын байцаагч*******ын 2023 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 0048006 дугаартай шийтгэлийн хуудас хүчингүй болгуулах захиргааны хэргийн хэргийн шүүх хуралдаанд зохигчдын гаргасан тайлбар, шинжлэн судалсан нотлох баримтуудыг үндэслэн дараах тайлбар, саналыг гаргаж байна.

Юуны өмнө Байгаль орчин, аялал жуулчлалын газрын улсын байцаагч *******-ын 2023 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 0048006 дугаартай шийтгэлийн хуудас үйлдэж Зөрчлийн тухай хуулийн 7.2 дугаар зүйлийн 1.3 дэх хэсгийг зөрчсөн гэх үндэслэлээр зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа бөгөөд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан эрхийн дагуу мөн “Зөрчлийн хэргийн бодит байдлыг тогтоох” зарчмуудыг зөрчиж үндэслэлгүй шийтгэх хуудас гаргасан болохыг онцлон хэлэхийг хүсэж байна.

3.7. Манай зүгээс зөрчил байсан гэдэгт эргэлзэж байна. Зөрчлийн тухай хуулийн 1.1, 2.1 дэх хэсэгт зааснаар хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, энэ хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхүйг зөрчил гэж заасан. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.1, 1.4.2 дахь хэсгүүдэд зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоох, хуульд заасан ажиллагааг зөрчлийн хэрэг бүртгэлтийн хэрэг гэнэ. Хуульд заасан ажиллагаа гэдэг бол Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.1.2 дахь хэсэгт Зөрчил шалгах ажиллагаа нь зөрчил үйлдэгдсэн газар, хүн, хуулийн этгээдийн эзэмшил газар, барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, хүний бие, эд зүйлд үзлэг хийх, баримт бичиг, мэдээлэл гаргуулан авах, эд зүйл, баримт бичгийг хураан авах, эд хөрөнгийг битүүмжлэх, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, мэдүүлэг авах, шинжилгээнд зориулж хэв загвар, дээж авах, шинжилгээ хийлгэх ажиллагаанаас бүрдэнэ гэж заасан. Гэтэл зөрчлийн шийтгэх хуудас бичсэн ******* байцаагч ямар ажиллагаа хийсэн бэ гэвэл 2 бичиг л явуулсан. Захиргааны ажиллагаанд зааснаар бий болсон газарт үзлэг хийгээд талуудаас тайлбар аваад шинжилгээ хийх ажиллагааг огт хийгээгүй. Өмнө нь бий болсон баримтыг үндэслээд ажиллагаа хийсэн гэж үзээд байна.

Гэтэл өмнө нь бүрдсэн баримтууд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.2.2 дахь хэсэгт зааснаар прокуророос заавал зөвшөөрөл авч зөрчлийн хэрэгт хавсаргах ёстой байсныг зөрчсөн.

3.8. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ гээд мөн зүйлийн 1.6 дахь заалтад зөрчлийн хэрэг бүртгэлтийн хэргийг харьяаллын дагуу шилжүүлэхээр прокурорт танилцуулж, шийдвэрлүүлэх гэж заажээ.

Хавтаст хэрэгт 39, 40, 41, 42-р талд цугларсан нотлох баримтууд болон шүүх хуралдааны хэлэлцүүлэгт хэлсэн талуудын тайлбар мэдүүлэг зэргээс үзэхэд, ******* аймгийн******* сумын нутаг дэвсгэр дээр гаргасан гэх зөрчлийг ******* сумын ИТХ-ын дарга Э.Мөнхтулга нь 2023 оны 3 дугаар сарын 05-ны өдөр утсаар цагдаагийн байгууллагад гомдол гаргаж 2023 оны 3 дугаар сарын 08-ны өдөр хүлээн аваад зөрчлийн хэрэг бүртгэгч дэслэгч С.Отгонбаатар нь ******* аймгийн прокурорын газраас 1100044230000610 дугаартай зөрчлийн хэрэг бүртгэлийн дугаарыг авч зөрчлийн хэрэг шалгаж байгаад 2023 оны 3 дугаар сарын 21-ний өдөр зөрчлийн хэрэг бүртгэх тасгийн дарга, цагдаагийн хошууч зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан болох Ж.Итгэлт нь ******* аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт шилжүүлэхдээ прокурорын зөвшөөрөлгүй буюу танилцуулж бүртгүүлэхгүйгээр шилжүүлсэн нь хууль бус болжээ.

Учир нь хууль зүйн утгааraa дээрх тохиолдол нь зөрчил шалган шийдвэрлэх байгууллагын харьяалал өөрчлөгдөж байгаа явдал бөгөөд энэ тохиолдолд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.3 дугаар зүйлийн 1.4 дэх заалт бус, харин мөн зүйлийн 1.6 дахь заалтыг баримталж, прокурорт танилцуулж шийдвэрлүүлэх шаардлагатай байсан.

3.9. Мөн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт эрх бүхий албан тушаалтан 14 хүртэл хоногийн дотор зөрчлийн хэрэг бүртгэлт явуулна, 2 дахь хэсэгт зөрчил шалгах нэмэлт ажиллагаа явуулж нотлох баримт цуглуулах шаардлагатай бол зөрчлийн хэрэг бүртгэлтийн хугацааг зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан 14 хүртэл, прокурор 30 хүртэл хоногоор сунгаж болно гэж заасан.

Хуулийн дээр дурдсан хэм хэмжээнээс үзвэл, аливаа зөрчлийн тухайд түүнийг шалган шийдвэрлэх үндсэн хугацаа нь 14 хоног, сунгах тохиолдолд зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан 14 хүртэл, прокурор 30 хүртэл хоног, нийт 58 хоногийн хугацаанд зөрчлийг шалган шийдвэрлэх журам үйлчилнэ.

Мөн уг хуулийн 6.8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зөрчлийн хэргийг харьяаллын дагуу шилжүүлсэн тохиолдолд хэрэг бүртгэлтийн хугацааг үргэлжлүүлэн тоолно, мөн зүйлийн 4 дэх хэсэгт хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон үйлдэл, эс үйлдэлд зөрчлийн хэрэг нээх тухай прокурорын шийдвэрийг эрх бүхий байгууллага хүлээн авсан өдрөөс эхлэн зөрчлийн хэрэг бүртгэлтийн хугацааг тоолно гэж заажээ.

Хуулийн дээр дурдсан хэм хэмжээнээс үзэхэд, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон үйлдэл, эс үйлдэлд зөрчлийн хэрэг нээх тухай прокурорын шийдвэрийг эрх бүхий байгууллага хүлээн авсан өдрөөс эхлэн зөрчлийн хэрэг бүртгэлтийн хугацааг тоолохоор байх бөгөөд энэ үндэслэлээр зөрчлийн хэргийг харьяаллын дагуу шилжүүлсэн

тохиолдолд хэрэг бүртгэлтийн хугацааг үргэлжлүүлэн тоолохоор өөрөөр хэлбэл, зөрчил шалган шийдвэрлэх хугацаа шинээр эхлэхгүй буюу тасалдахгүйгээр үргэлжлэн тоологдох журамтай байна.

3.10. Хавтаст хэрэгт цугларсан нотлох баримтуудаас үзэхэд, анх ******* аймгийн Прокурорын 610 дугаартай зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг 2023 оны 3 дугаар сарын 08-ны өдөр хүлээн аваад 2023 оны 3 дугаар сарын 21-ний өдөр ******* аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт шилжүүлсэн байх бөгөөд энэ хугацаанаас зөрчлийн хэрэг бүртгэлтийн хугацааг тоолоход үндсэн 14 хоногийн хугацаа нь 2023 оны 3 дугаар сарын 27-ны өдөр дуусгавар болжээ.

Тодруулбал, хариуцагч улсын байцаагч нь гомдол гаргагчид холбогдох зөрчлийн хэргийг 2023 оны 3 дугаар сарын 27-ны өдөрт багтаан шийдвэрлэж, зохих шийдвэрийг гаргах учиртай байсан. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт эрх бүхий албан тушаалтан дараах үндэслэл тогтоогдвол зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгох шийдвэр гаргана гээд мөн зүйлийн 1.4 дэх заалтад зөрчлийн хэрэг бүртгэлтийн хугацаа дууссан гэж заасан.

Өөрөөр хэлбэл, хариуцагч улсын байцаагч нь хуулийн дээр дурдсан заалтын дагуу зөрчлийн хэрэг бүртгэлтийн хугацаа дууссан гэх үндэслэлээр зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгох тухай шийдвэр гаргахаар хуульчилсан байна.

Мөн хавтаст хэргийн 60 хуудаст авагдсан далд уурхайн шүүрлийн усыг ашиглах гэрээний дагуу манай компани зөвхөн худалдан авагч тал хэрэглэгч бөгөөд ус тээвэрлэх нийлүүлэх үүргийг “Говь мастер” ХХК нь өөрийн жолооч, автомашин техник хэрэгслээр нийлүүлснийг манай компани хариуцлага хүлээх ёсгүй.

Иймд шийтгэлийн хуудсыг хүчингүй болгож, нэхэмжлэгчийн эрхийг хангаж өгнө үү гэжээ.

4. Хариуцагч шүүхэд ирүүлсэн хариу тайлбар, шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа:
“*******” ХХК-ийн нэхэмжлэлтэй танилцаад дараах хариу тайлбарыг гаргаж байна.

4.1. “*******” ХХК нь “*******” ХХК-ийн уурхайгаас байгалийн нөөц баялаг болох гүний усыг гэрээ дүгнэлтгүйгээр авч ашиглах явцдаа газрын хөрсийг гэмтээж газарт хохирол учруулсан. Иймэрчлийг 2021, 2022 онуудад бас үйлдэж байсан сумын байгаль орчны хяналтын улсын байцаагчид арга хэмжээ авч ажиллаагүй. Зөрчлийг “*******” ХХК нь давтан гаргаж байгаа, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2010 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн А-156 тоот тушаалаар батлагдсан Байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн төлбөр тооцох аргачлалаар хохирлын үнэлгээг тооцдог үүнээс өөр ашиглах тушаал шийдвэр байхгүй “*******” ХХК-ийн шинжээчийн ашигласан А-156 тоот тушаалаар гаргасан дүгнэлт нь үнэн зөв болно.

4.2. Зөрчилд холбогдож буй 4246 УНУ, 8169 УНР улсын дугаартай авто машинууд нь хувь хүний эзэмшилд байдаг. 2022 онд “*******” ХХК-аас “*******” ХХК-ийн баяжуулах үйлдвэрт гэрээний дагуу ус зөөж байсан. “*******” ХХК-ийн уурхай дээр парклан байршуулсан бөгөөд жолооч нарыг дуудаж “*******” ХХК-ийн хятад захирал LUO YUJING 5 машин ус зөөсөн усны машины жолооч нь шинээр ирсэн маршрут зөрчсөн явдал байна. Би бас явж үзсэн хэсэг хэсэг газар машины дугуй шигдэж орсон байна. Нээх их эвдэрчихсэн зүйл байхгүй байна байгалиараа сэргэчих боломжтой. Мэргэжлийн байгууллагууд их өндөр үнэ хэлдэг манайх компаниа сонгож хийлгэж төлбөрөө төлөх саналтай байна. Гаргасан зөрчилдөө хариуцлага хүлээнэ гэх “*******” ХХК-ийн холбогдогч Х.Эрдэнэцогтын мэдүүлэг.

4.3. "*******" ХХК-ийн холбогдогч О.Шинэдарам мэдүүлэхдээ манай компани нь 2022 онд уурхайн шүүрлийн усаа холбогдох гэрээний дагуу 12864 м^3 ус нийлүүлсэн 2023 онд ус нийлүүлэх гэрээ байгуулаагүй байгаа. 3 дугаар сарын 06-ны өдөр уурхай дээр очиж шалгахад тоолуурын заалт 13118 болсон байна. Ус зөөдөг машин манай компанид байхгүй манай компаниас ус авах зөвшөөрөл аваагүй манай маршрутын замаар яваагүй өөрсдийн дураар зам гарган явсан тул манайх хариуцахгүй "*******" ХХК-тай холбоотой асуудал, хэн хулгай хийнэ гэж бодох вэ дээ буухдаа хариуцлага алдаж гүний насосны утсыг ил орхисон байна. Бид хэлмэгдчихээд байна. "*******" ХХК нь кемпийн харуулаас гуйж байгаад авсан байсан. Хуулийн дагуу хариуцлагаа хүлээнэ гэх мэдүүлэг.

4.4. Гэрчийн мэдүүлснээр: "*******" ХХК-ийн орчуулагч С.Отгонбаяр ус зөөх хугацаанд Бор-Өндөр хотод ажлаар явж байсан ирээд мэдсэн. 2022 онд ус авах гэрээг "*******" ХХК-тай байгуулсан тэгээд гэрээнд заасан усыг бүрэн аваагүй байсан тул хятад захирал үлдэгдэл усаа авч болно гэж ойлгосон 5 машин ус зөөсөн. Жолооч нарт маршрут зөрчихгүй яв гэдгийг бол сануулж хэлдэг хэсэг хэсэг газар бол эвдэрсэн байна би сая явж үзсэн. Сумын ИТХ-ын дарга Э.Мөнхтулга ярьж хэлсэн цагдаад мэдэгдэж шалгуулна гэж хэлсэн гэх мэдүүлэг.

4.5. Гэрч Б.Батбаяр "*******" ХХК нь "*******" ХХК-ийн уурхайгаас зөвшөөрөлгүйгээр ус зөөсөн 2 дугаар сарын сүүлчээр******* суманд их хэмжээний цас орсны дараа "*******" ХХК нь ус зөөсөн тээвэрлэлт хийх замаараа яваагүй замын хажуугаар ковшоор цасыг нь хусуулаад том усны машинаар ус зөөсөн газар эвдэж явсан. 3 дугаар сарын 5-8-ны хооронд 3 өдөр ус зөөсөн газар гэсэж хөлдөж байгаа үед таарсан газрыг бол гамшиг болгосон байгаа та нар хараа байлгүй дээ малчид бид энэ газраар шөнө орой малын араас явна явах боломжгүй хүний амь нас эрүүл мэндэд халтай байна. Тодоос тод харлаад хөрсийг нь эргүүлчихсэн байгаа өөрсдийнх нь зам хажууд нь байгаа гэх мэдүүлэг.

4.6. Гэрч Х.Цогтбаатар "*******" ХХК 3 дугаар сарын 5-8-ны өдрийн хооронд "*******" ХХК-ийн уурхайгаас 30 тн усны том машинаар ус зөөсөн, зөөхдөө батлагдсан замаараа яваагүй ковшоор цас хусаж усны машин явсан нь хөрс их эвдсэн одоо эвдэрсэн газар нь хөлдөөд машин мотоцикль явах боломжгүй хүндрэлтэй байна. "*******" ХХК-ийг ажиллаж байгаа юм байх гээд очиход ямар ч хүн байгаагүй. Сумын ИТХ-ын даргад утсаар хэлсэн "*******" ХХК нь хариуцаж байгаа хүнгүй замын хажуугаар өөр зам гаргаж ковш усны машинтай явж байна гэж хэлсэн гэх мэдүүлэг.

4.7. Хохирогч Э.Мөнхтулга ******* аймгийн******* суманд үйл ажиллагаа явуулдаг "*******" ХХК нь "*******" ХХК-ийн уурхайгаас сум орон нутагт мэдэгдэлгүй батлагдсан замын маршрутаа зөрчин тоосжилт үүсгэж зам эвдэж тээвэрлэлт хийсэн. Мөн ковш машинаар замын цас хусаж газар эвдсэн. Иргэн Б.Батбаяр, Х.Цогтбаатар нар утсаар гомдол мэдээлэл өгсний дагуу миний бие цагдаад гомдол гаргасан. "*******" ХХК-ийн удирдлагуудтай өөрийн биеэр очиж уулзах гэсэн боловч удирдлагууд нь байгаагүй, орчуулагч Отгонбаяр гэх залуу байсан. Отгонбаярт хэлсэн замын маршрут зөрчиж зам эвдлээ гэхэд батлагдсан замаараа явж байгаа 2022 оны усны гэрээнийхээ үлдэгдэл усыг зөөсөн гэж хэлсэн. Сум орон нутаг удирдаж байгаа хүний хувьд багийн иргэдээ сонсож ажиллах ёстой гэх мэдүүлэг, 2021, 2022 онуудад "Эф жи пи эм" ХХК-аас "*******" ХХК нь ус зөөж зам эвдсэн гэх зөрчлийг ******* сумын ЗДТГ-ын Байгаль орчны хяналтын улсын байцаагчийг шалгаж шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн.

4.8. “********” ХХК нь байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийх эрхийг 2010 оны 11 дүгээр сард Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас тусгай зөвшөөрлөө авсан 13 жилийн туршлагатай компани юм. 2022 оны 5 дугаар сард 3 жилээр үнэлгээ хийх эрхээ сунгуулсан. Гүйцэтгэх захирал Г.Мөнгөнбаатар нь 2023 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 23/001 дугаартай шийдвэрээр гүйцэтгэх захирлаар томилогдсон эрх бүхий албан тушаалтан мөн. Г.Мөнгөнбаатар нь 15 цагийн чадавхжуулах сургалтад сууж сертификат авсан.

4.9. Өргөдөл гомдол ирсэн тохиолдолд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5.2-т заасны дагуу төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх удирдамжийг батлуулж холбогдох компаниудад мэдэгддэг. Тус газарт иргэнээс гомдол мэдээлэл ирүүлээгүй.

4.10. ******* аймгийн цагдаагийн газрын 2023 оны 43-8/899 тоот албан бичгээр 610 дугаартай зөрчлийн шинжтэй гомдол нь Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Байгаль орчны хяналтын улсын байцаагч шалган шийдвэрлүүлэхээр харьяалуулсан зөрчил байх тул Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.4 дүгээр зүйл ийн 1 дэх хэсэгт заасныг удирдлага болгон тус газарт шилжүүлсэн тул зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэн явуулсан.

4.11. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны холбогдогч Х.Эрдэнэцогтын мэдүүлэгт “********” ХХК нь газрын хөрс эвдсэн зөрчилд хохирол тооцох шинжээч томилох асуудлыг дурдаж өгсөн. Х.Эрдэнэцогт нь өөрсдөө үнэлгээ хийлгэдэг компаниараа хохирлоо тооцуулна гэх саналыг өгсөн, энэ үйлдэл өөрсийн гаргасан үйлдлээ нуун дарагдуулах оролдлого байж болох тул үнэлгээ хийх эрх бүхий байгууллагуудад миний бие санал тавьж хохирлын үнэлгээг гаргаж өгөх санал хэлсэн компанийг сонгож хийлгүүлсэн. Шинжээч нь оролцогчоос өөрт шаардлагатай мэдээлэл хэрэгтэй болбол оролцогчоос татаж авна. Үнэн зөв дүгнэлт гаргах үүрэгтэй гэж эрх үүрэгт зааж өгсөн. Шинжээч болон үнэлгээний компанийг нэрийг “********” ХХК-д мэдэгдэх шаардлагагүй. “********” ХХК-ийн холбогдогч, тус компани гэрч нар нь өөрсдийн мэдүүлэгтээ маршрут зөрчиж хэсэг хэсэг газрыг эвдсэн байна сая явж үзлээ гэж мэдүүлсэн нь “********” ХХК-ийн гаргасан зөрчил Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.5 дахь тогтоосон авто зогсоол болон авто замын зорчих хэсгээс бусад газарт тээврийн хэрэгсэл зогсоох, зорчихыг хориглох, 7.3.1 дэх бичил уурхайн зориулалтаар олгосон газар болон газрын тосны гэрээт талбай, ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээд нь үйл ажиллагааныхаа явцад доройтсон хөрсийг биологийн нөхөн сэргээлтийн стандартын шаардлагад нийцүүлэн нөхөн сэргээх гэх заалтуудыг зөрчсөн нь Зөрчлийн тухай хуулийн 7.2 дугаар зүйлийн 1.3 дахь хэсгээр арга хэмжээ авах нь үндэслэлтэй.

4.12. Зөрчлийн материалтай танилцуулахдаа тухайн компанид хамааралтай хэсгүүдийг танилцуулдаг бөгөөд хэргийн материалтай танилцахдаа бүх хүний мэдүүлэг хэн юу гэж хэлснийг нэг бүрчлэн зургийг нь авах зорилго агуулж танилцах ажиллагааг явуулсан. Миний бие шаардлагаа тавьж та өөрт холбогдолтой материалтай танилцах ёстой гэдгийг хэлсэн эсэргүүцэх хандлага гаргаж байсан тул хэргийн материалтай танилцах үед прокурорт мэдэгдэж хэлсэн. Компанитай холбоотой материалтай танилцуулах ёстой гэсэн хариуг авч ажилласан. Х.Эрдэнэцогт нь бухимдлаа илэрхийлж өс санасан маягтай үг хэллэг хэлж ******* сумын ИТХ-ын даргын санал хүсэлтийг одооноос эхлээд хүлээж авахгүй, компанийхаа үйл ажиллагааг зогсоолгоно. Иргэд нь ажилгүй байг, Цогтбаатар, Батбаяр зэрэг малчин нь хурлын даргын хамаарал бүхий нөхөд шороо цасыг нь цэвэрлэж өгөхгүй. “********” ХХК-д ямар нэгэн ажил үнэлгээ хийлгэхгүй байх хэрэгтэй юм байна гэх мэт үг

хэллэгийг хэлж байсан. Зөрчлийн материалыг бүхэлд нь эргүүлж тэмдэглэл үйлдэж авч явсан.

4.13. "*******" ХХК-тай холбоотой зөрчлийг 2023 оны 3 дугаар сарын 21-ний өдөр харьяаллын дагуу шилжүүлж ирүүлсэн зөрчлийн хэрэг нээж хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж байгаа талаарх мэдэгдлийг хүргэхээр захирал Чуданжийгийн 99118893 дугаар руу залгахад зарагдсан байсан холбогдож чадаагүй. Уурхайн дарга Баяраагийн 89919489 дугаарт өөрийн 95207524 дугаараар залгаж хэлсэн. Чуданжий захирал дугаараа сольсон хуучин дугаар нь зарагдсан гэдгийг бол баталж хэлж өгсөн. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд инженер, байгаль орчны мэргэжилтэн Х.Эрдэнэцогтыг томилон оролцуулах талаар мэдэгдэж хэлсэн. Зөрчлийн хэрэг нээх тухай тогтоолыг зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд оролцохоор ирэхэд нь уншиж танилцуулдаг. Тогтоолд бол гомдол гаргагчид мэдэгдэхийг тусгасан байдаг.

4.14. 2023 оны 3 дугаар сарын 27-ны өдөр "*******" ХХК-ийн холбогдогч Х.Эрдэнэцогт, гэрч С.Отгонбаяр нарт 4 дүгээр сарын 03-нд хэргийн материалтай танилцаж шийтгэврийн хуудас авах талаар биечлэн мэдэгдсэн мөн 4 дүгээр сарын 02-ны өдөр утсаар холбогдож сануулсан, 4 дүгээр сарын 03-ны өдөр ирж хэргийн материалтай танилцаж, гарын үсэг зурж зөвшөөрсөн. 2023 оны 3 дугаар сарын 27-ны өдөр ирж зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо Х.Эрдэнэцогт, гэрч орчуулагч С.Отгонбаяртай ирсэн. Явсан мөр бол байна хэсэг хэсэг газар эвдэрсэн байна байгалиараа нөхөн сэргэчихнэ ш дээ гэх зүйлийг ярьж хэлсэн нь "*******" ХХК нь зөрчил үйлдсэн болох нь тогтоогдож байна. "*******" ХХК нь удаа дараа ийм зөрчил гаргаж байгаа бөгөөд арга хэмжээ авсан шийдвэрлэгдсэн асуудал байхгүй байна.

Иймд дээрх гомдлыг хэрэгсэхгүй болгож шийтгэлийн хуудсыг хэвээр үлдээж өгнө үү гэжээ.

ҮНДЭСЛЭХ нь:

1. "*******" ХХК-ийн гомдлын шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэлээ.

2. ******* аймгийн Байгал орчин, аялал жуулчлалын газрын Байгаль орчны хяналтын улсын байцаагчийн 2023 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн Зөрчилд шийтгэл оногдуулах тухай 0048006 дугаартай шийтгэлийн хуудсаар "*******" ХХК-ийг орон нутгийн зөвшөөрөлгүйгээр ус зөөвөрлөж, маршрут зөрчиж хөрс эвдсэн зөрчил гаргасан гэж үзэж Зөрчлийн тухай хуулийн 7.2 дугаар зүйлийн 1.3 дахь хэсэгт зааснаар 500 нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 500,000 төгрөгийн торгууль оногдуулж, байгаль орчинд учирсан хохирлын нөхөн төлбөрт 26,428,343.12 төгрөг, хохирлыг тогтооход гарсан зардалд 3.000.000 төгрөгийг тус тус төлүүлэхээр шийтгэл оногдуулжээ.

3. Зөрчлийн тухай хуулийн Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль тогтоомжийг зөрчих гэсэн 7.2 дугаар зүйлийн 3-д цөлжилттэй тэмцэх арга хэмжээний журам зөрчсөн бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэж хуульчилсан.

4. ******* аймгийн ******* суманд үйл ажиллагаа явуулдаг "*******" ХХК нь жонш баяжуулах үйлдвэрт ашиглах усаа "*******" ХХК-ийн уурхайгаас ус зөөж, батлагдсан замын маршрутыг зөрчиж зорчин, хөрс эвдэж хохирол учруулсан нь зөрчлийн хэрэгт авагдсан нотлох баримтуудаар тогтоогдож байна гэж үзлээ.

5. Хэрэгт авагдсан /хх-82/ “*******” ХХК-ийн 2023 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 28/001 дугаар Хувьцаа эзэмшигчийн шийдвэрээр Ганбаатар овогтой Мөнгөнбаатарыг тус компанийн гүйцэтгэх захирлаар томилсон, /хх-83/ Г.Мөнгөнбаатарын сургалтын сертификат, /хх-84/ Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийх эрхийн 20 дугаар гэрчилгээ, уг гэрчилгээг сунгасан нэмэлт өөрчлөлтийн бүртгэлээр “*******” ХХК нь байгаль орчны нарийвчилсан шинжилгээ хийх эрх бүхий хуулийн этгээд байна.

6. Хариуцагч улсын байцаагч *******-ын 2023 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн Шинжээч томилж, шинжилгээ хийлгэх тогтоолоор ******* сумын “*******” ХХК-ийн уурхайгаас “*******” ХХК-ийн жоншны баяжуулах үйлдвэрт ашиглах ус зөөж, замын маршрут зөрчиж, хөрс эвдсэн хохирлыг тогтоолгохоор томилогдсон шинжээч нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2010 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн А-156 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны хохирлын, нөхөн төлбөр тооцох аргачлал”-ын дагуу тухайн газарт учирсан хохирлыг тооцсоныг буруутгах боломжгүй.

7. Тус эвдэрсэн замаар “*******” ХХК-ийн жоншны баяжуулах үйлдвэрт ашиглах ус зөөсөн болох нь хохирогч Э.Мөнхтулгын “******* аймгийн******* сумын 2 дугаар багт үйл ажиллагаа явуулдаг “*******” ХХК-ийн уурхай нь 2023 оны 3 дугаар сарын 5-8-ны өдрийн хооронд тус сумын 2 дугаар баг Баянцагаан гэх газарт байрлах “*******” ХХК-ийн уурхайгаас сум орон нутагт мэдэгдэлгүй, батлагдсан замаар явахгүй, тоосжилт үүсгэн зам харгуй эвдэж байна” /хх-42/, “*******” ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Х.Эрдэнэцогтын “би сая явж үзсэн хэсэг газар машинуудын дугуй шигдэж орсон байна. Нээх их эвдчихсэн зүйл байхгүй байна. Байгалиараа сэргэх боломжтой байна” /хх-48/ гэх мэдүүлгээр тогтоогдож байна.

8. Захиргааны ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-д “хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, түүнд тавих прокурорын хяналт, нийгмийн хэв журмыг сахиулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа”-нд энэ хууль үйлчлэхгүй гэж зааснаар гомдол гаргагчийн Захиргааны ерөнхий хуульд заасан захиргааны шийдвэр гаргах үйл ажиллагааг хариуцагч улсын байцаагч зөрчсөн гэх гомдлын шаардлагыг шүүх хүлээн авах боломжгүй.

9. Мөн Зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа уг харилцааг нарийвчлан зохицуулсан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар явагдах тул гомдол гаргагчийн Төрийн хяналт шалгалтын тухай хуулийг хариуцагч улсын байцаагч зөрчсөн гэх гомдлын шаардлагыг шүүх хүлээн авах боломжгүй.

10. Зөрчлийн хэрэг бүртгэх тасгийн дарга, цагдаагийн хошууч Ж.Итгэлтийн 2023 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн “Зөрчлийн талаарх гомдол мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлэх тухай” тогтоолоор /хх-38/ ******* аймгийн******* сумын иргэдийн төлөөлөгчдийн Хурлын дарга Э.Мөнхтулгаас гаргасан тус аймгийн ******* сумын 2 дугаар багт үйл ажиллагаа явуулдаг “Монголжүюанли” ХХК-ийн уурхай нь тус сумын 2 дугаар багт үйл ажиллагаа явуулдаг “*******” ХХК-ийн уурхайгаас сум орон нутгийн зөвшөөрөлгүй ус зөөвөрлөж байна гэх зөрчлийн талаарх гомдол мэдээлэлтэй танилцахад хохирогч Э.Мөнхтулгын мэдүүлэг бусад баримтуудаар дээрх үйлдэл нь Байгаль орчин, аялал жуулчлалын газрын улсын байцаагчид шалган шийдвэрлэхээр харьяалуулсан зөрчил байх тул Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар гомдол мэдээллийг Байгаль орчин, аялал жуулчлалын газарт харьяаллын дагуу шилжүүлсэн. Уг тогтоолоос үзэхэд, цагдаагийн байгууллага хэрэг бүртгэлтийн хэрэг нээлгүйгээр гомдол, мэдээллийг шилжүүлсэн байна.

11. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.3 дугаар зүйлийн 1.2-т “Зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлж, прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх” гэж заасан, харин 1.6-д “Зөрчлийн хэрэг бүртгэлтийн хэргийг харьяаллын дагуу шилжүүлэхээр прокурорт танилцуулж, шийдвэрлүүлэх” гэж ялгаатай зохицуулсан бөгөөд гомдол мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлэхдээ прокурорт танилцуулж, шийдвэрлүүлэхээр зохицуулаагүй байхад цагдаагаас харьяаллын дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын газарт гомдол мэдээллийг шилжүүлэхдээ прокурорт танилцуулж, шийдвэрлүүлээгүй гэж хариуцагчийг буруутгах боломжгүй.

12. Хариуцагч улсын байцаагч ******* нь 2023 оны 3 дугаар сарын 22-ны өдөр Зөрчлийн хэрэг нээх тухай тогтоол үйлдэн прокурорт танилцуулан Зөрчлийн 2330000132 дугаар аван хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулан холбогдогчид шийтгэх хуудсаар торгууль ногдуулан 2023 оны 4 дүгээр сарын 04-ны өдрийн Зөрчлийн хэргийг прокурорт хүргүүлэх тогтоолоор зөрчлийн хэрэг бүртгэлтийг дуусгасан нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.8 дугаар зүйлийн 1-д “Эрх бүхий албан тушаалтан 14 хүртэл хоногийн дотор зөрчлийн хэрэг бүртгэлт явуулна” гэсэн хугацаанд зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа прокурорын хяналтад хуульд заасан журмын дагуу явагдаж дууссан байна.

13. Хөрсийг доройтлоос хамгаалах, нөхөн сэргээх, цөлжилтөөс сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан Хөрс хамгаалах, цөлжилттэй тэмцэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-д “Өөрийн хууль бус үйл ажиллагаанаас хөрсийг доройтуулсан бол хохирлыг арилгаж, хөрсийг нөхөн сэргээх” гэж хуулийн этгээдийн хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх үүргийг хуульчлан тогтоосон.

Мөн Хөрс хамгаалах, цөлжилттэй тэмцэх тухай хуулийн 4.1.1-д “хөрс гэж газрын гадаргын өнгөн хэсгийн үржил шимт давхарга бүхий сэвсгэр хэсгийг”, 4.1.2-т “хөрсний доройтол” гэж хөрсний үржил шим муудах, элэгдэл, эвдрэлд орох, бохирдох, бэлчээр талхлагдаж анхны шинж чанараа алдахыг” ойлгохоор хуульчилсан бөгөөд “*******” ХХК нь өөрийн жонш баяжуулах үйлдвэрт ашиглах усаа “*******” ХХК-ийн уурхайгаас зөөхдөө батлагдсан замын маршрут зөрчиж хөрс эвдэж хохирол учруулсан нь Хөрс хамгаалах, цөлжилттэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.5-д “тогтоосон авто зогсоол болон авто замын зорчих хэсгээс бусад газарт тээврийн хэрэгсэл зогсоох, зорчихыг хориглох” гэж заасныг зөрчсөн байна.

Түүнчлэн Хөрс хамгаалах, цөлжилттэй тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Хөрсөнд доройтол учруулсан тохиолдолд мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн байгаль орчны хяналтын улсын байцаагч, холбогдох сум, дүүргийн Засаг дарга учирсан хохирлыг арилгуулж, ... торгууль ногдуулан, төлөлтөд нь хяналт тавина” гэж зохицуулснаар эрх бүхий албан тушаалтан нь “батлагдсан замын маршрут зөрчиж хөрс эвдэж хохирол учруулсан” гомдол гаргагчид Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх хууль тогтоомж зөрчсөн гэж хариуцлага ногдуулсныг буруутгах үндэслэлгүй.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.1, 106.3, 106.3.14-т заасныг тус тус удирдлага болгон

ТОГТООХ нь:

1. Зөрчлийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1, 7.2 дугаар зүйлийн 1.3 дахь хэсэгт заасныг баримтлан “*******” ХХК-ийн ******* аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч *******-д холбогдуулан гаргасан ******* аймгийн Байгал орчин, аялал жуулчлалын газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч *******-ын Зөрчилд шийтгэл оногдуулах тухай 2023 оны 4 дүгээр сарын

03-ны өдрийн 0048006 дугаартай шийтгэлийн хуудсаар Зөрчлийн тухай хуулийн 7.2 дугаар зүйлийн 1.3 дахь хэсэгт зааснаар "********" ХХК-д 500 нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 500,000 төгрөгийн торгууль оногдуулж, байгаль орчинд учирсан хохирлын нөхөн төлбөрт 26,428,343.12 төгрөг, хохирлыг тогтооход гарсан зардалд 3.000.000 төгрөгийг тус тус төлөх тухай шийдвэрийг хүчингүй болгуулах тухай гомдлын шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосугай.

2. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэгт заасныг баримтлан гомдол гаргагчаас улсын тэмдэгтийн хураамжид урьдчилан төлсөн 70,200 төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээсүгэй.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 113 дугаар зүйлийн 113.2-т зааснаар хэргийн оролцогчид, тэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгч нь шийдвэрийг эс зөвшөөрвөл шийдвэрийг гардан авсан өдрөөс хойш 5 хоногийн дотор давж заалдах журмаар гомдол гаргах эрхтэй.

Шүүхийн шийдвэрийн үндэслэл, дүгнэлт

Дээрх зөрчлийн хэрэгт Хөрс хамгаалах, цөлжилттэй тэмцэх тухай хуулийн 4.1.1-д "хөрс" гэж газрын гадаргын өнгөн хэсгийн үржил шимт давхарга бүхий сэвсгэр хэсгийг", 4.1.2-д "хөрсний доройтол" гэж хөрсний үржил шим муудах, элэгдэл, эвдрэлд орох, бохирдох, бэлчээр талхлагдаж анхны шинж чанараа алдахыг" ойлгохоор хуульчилсан бөгөөд "********" ХХК нь өөрийн жонш баяжуулах үйлдвэрт ашиглах усаа "********" ХХК-ийн уурхайгаас зөөхдөө батлагдсан замын маршрут зөрчиж хөрс эвдэж хохирол учруулсан нь Хөрс хамгаалах, цөлжилттэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.5 дахь "тогтоосон авто зогсоол болон авто замын зорчих хэсгээс бусад газарт тээврийн хэрэгсэл зогсоох, зорчихыг хориглох" гэж заасныг зөрчсөн үйлдлийг тогтоосон.

Зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа уг харилцааг нарийвчлан зохицуулсан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар явагдах бөгөөд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийг улсын байцаагч зөрчөөгүй боловч уг хуулийн дагуу шалгалтын ажиллагаа явуулсан бол хүчинтэй тооцуулах санал прокурорт танилцуулж шийдвэрлүүлээгүй алдаа гаргасан үйлдлийг цаашид анхаарах хэрэгтэй.

Түүнчлэн Хөрс хамгаалах, цөлжилттэй тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Хөрсөнд доройтол учруулсан тохиолдолд мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн байгаль орчны хяналтын улсын байцаагч, холбогдох сум, дүүргийн Засаг дарга учирсан хохирлыг арилгуулж, ... торгууль ногдуулан, төлөлтөд нь хяналт тавина" гэж зохицуулснаар эрх бүхий албан тушаалтан нь "батлагдсан замын маршрут зөрчиж хөрс эвдэж хохирол учруулсан" Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх хууль тогтоомж зөрчсөн үйлдлийг үндэслэлтэй тогтоосон буюу зөрчлийн нотлох ажиллагааг хуулийн дагуу зөв зүйтэй явуулжээ.

Зөрчлийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1, 7.2 дугаар зүйлийн 1.3 дахь хэсэгт заасныг баримтлан "********" ХХК-ийн ******* аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч *******-д холбогдуулан гаргасан ******* аймгийн Байгал орчин, аялал жуулчлалын газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч *******-ын Зөрчилд шийтгэл оногдуулах тухай 2023 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 0048006 дугаартай шийтгэлийн хуудсаар Зөрчлийн тухай хуулийн 7.2 дугаар зүйлийн 1.3 дахь хэсэгт зааснаар "********" ХХК-д 500 нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 500,000 төгрөгийн торгууль оногдуулж, байгаль орчинд учирсан хохирлын нөхөн төлбөрт 26,428,343.12 төгрөг, хохирлыг тогтооход гарсан зардалд 3.000.000 төгрөгийг тус тус төлөх тухай шийдвэрийг гаргах үндэслэл болжээ.

3.3 АГААРЫН ТУХАЙ ХУУЛЬ ЗӨРЧИХ, ЗӨРЧЛИЙН ШИНЖ, ОНЦЛОГ, АНХААРАХ АСУУДАЛ

3.3.1. Шийтгэл, эрх бүхий албан тушаалтан ба харьяалал, нэр томъёоны тайлбар

Шийтгэл. Зөрчлийн тухай хуулийн 7.4 дүгээр зүйлийн Агаарын тухай хууль зөрчих тохиолдолд зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд дараах шийтгэл оногдуулна. Үүнд:

1. Агаарын чанарт сөргөөр нөлөөлж байгаа өөрийн үйл ажиллагааны тухай мэдээлэл, озон задалдаг бодис, түүнийг орлуулах бусад бодис, тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмжийн импорт, үйлдвэрлэлийн тухай мэдээлэл, агаарын бохирдлын эх үүсвэрийн тухай мэдээлэл, агаарт гаргасан бохирдуулах бодисын агууламж, хаягдлын хэмжээ, дотоод хяналтын мэдээг (1.1) тогтоосон хугацаанд мэдээлээгүй, (1.2) зориуд буруу мэдээлсэн, (1.3) нуун дарагдуулсан, эсхүл хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2. Агаар бохирдуулах бодисын хаягдлын стандартаас хэтэрсэн бохирдуулах бодис гаргадаг, физикийн сөрөг нөлөөлөл үзүүлдэг тээврийн хэрэгсэл, эсхүл хөдөлгөөнт бусад эх үүсвэр ашиглан агаар бохирдуулсан бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
3. Агаар хамгаалах талаар тавигдах шаардлага хангаагүй (3.1) барилга байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглалтад оруулсан, (3.2) техник, технологи нэвтрүүлсэн бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
4. Агаарт бохирдуулах бодис гаргах, физикийн сөрөг нөлөөлөл үзүүлэх талаар зөвшөөрөлд заасан хэмжээ, нөхцөл, шаардлагыг зөрчсөн бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
5. Агаарт гаргах бохирдуулах бодис, физикийн сөрөг нөлөөллийг багасгах, цэвэрлэх, хянах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг ашиглах журам зөрчсөн бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
6. Хүн амын оршин суугаа орчны агаарыг бохирдуулан хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх нөхцөлийг бүрдүүлсэн бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
7. Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр бохирдуулах бодис гаргадаг, физикийн сөрөг нөлөөлөл үзүүлдэг эх үүсвэр ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж агаар бохирдуулсан бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Агаарын тухай ерөнхий ойлголт. Манай дэлхийн хийн мандлын агаарын хэвийн найрлагын 78%-ийг азот (N), 21%-ийг хүчилтөрөгч (O_2), 0.9%-ийг аргон (Ar) эзлэх бөгөөд нүүрсхүчлийн хий (CO_2), устөрөгч (H_2), неон (Ne), гели (He), озон (O_3) зэрэг хий маш бага хэмжээтэй байхаас гадна, агаарт усны уур, тоосонцор (PM2.5, PM10), мананцар ч тодорхой хэмжээгээр байна.

Хил дамжсан агаарын бохирдол гэдэг нь гадаад улсын нутаг дэвсгэр дэх агаар бохирдуулах эх үүсвэрээс улс орны хил хязгаар дамжин агаарт дэгдсэн бохирдуулах бодис юм.

Байгалийн болон хүний үйл ажиллагааны улмаас хүхрийн болон азотын ислүүд, угаарын хий, нүүрсхүчлийн хий, тоос тортог зэрэг хорт хий, тоосонцорууд агаарт цацагдан хуримтлагдсаар агаарын бохирдлыг үүсгэнэ. Агаарын бохирдлыг үүсгэж, агаарын чанарыг бууруулж байгаа эдгээр хорт хий, тоосонцорыг агаар бохирдуулагч гэнэ. Агаар бохирдуулагчдыг анхдагч болон хоёрдогч бохирдуулагчид гэж ангилдаг. Анхдагч бохирдуулагчид агаар бохирдуулах эх үүсвэрээс шууд агаар мандалд ялгарч байгаа бохирдуулагчид болох жигнэгдэгч бодисууд, азотын ислүүд, хүхрийн давхар исэл, нүүрстөрөгчийн дутуу исэл гэх мэт орно. Хоёрдогч бохирдуулагчид агаар мандалд явагдах фотохимийн урвалын дүнд үүсэх бохирдуулагчид болох азотын ислүүд, озон, пероксиацетил нитрат, периоксибензолнитрат, кетон, альдегид зэрэг орно.

Агаар бохирдуулагчийг төлөв байдлаар нь хий (нүүрс хүчлийн хий, хүхрийн давхар исэл, хүхэрт устөрөгч, азотын дан исэл, азотын давхар исэл г.м), шингэн (хүхрийн давсны хүчил, азотын давсны хүчил, давсны хүчил, давирхайлаг бодисууд), хатуу (тоос, тоосонцор, хөө, нүүрсний дутуу шаталтын бодисууд) гэж ангилна. Үүнээс тоосонцор нь агаар дахь жижиг тоос, шингэний жижиг дуслуудаас бүрдэнэ. Байгалийн болон хүний үйл ажиллагааны явцад тоосонцор агаарт шууд хаягдахаас гадна, өөр бусад хийн бохирдуулагчид агаарт хоорондоо нэгдэн хувирч тоосонцорыг үүсгэнэ. 10 мкм-ээс бага даиметр бүхий тоосонцор амьсгалын замаар орж, амьсгалын системд хуримтлагддаг тул хүний эрүүл мэндэд хортой. 2.5 мкм-ээс бага ширхэгтэй тоосонцор нүүрс мод, газрын тос зэрэг түлшийг шатаах явцад болон зарим үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад үүснэ. 2.5-10 мкм ширхэгтэй тоосонцор нь буталж нунтаглах ажиллагаа, замын тоос шорооноос үүдэлтэй.

Харин агаар бохирдуулах бодисыг хүний бие эрхтэнд үзүүлэх нөлөөллөөр нь физикийн ба химийн гэж 2 ангилж болно. Физикийн нөлөөлөлд агаарын даралт, чийгшил, температур, хурц бүдэг гэрэл, хэт ягаан туяа, салхи шуурга, хур танадас, агаарын цахилгаан цэнэгжилт, цацраг идэвхт ионжсон туяа, цахилгаан соронзон орон, дулааны бохирдол, шуугиан ба нам давтамжийн чичиргээ зэрэг физик хүчин зүйлс багтана. Химийн нөлөөлөлд хийн төлөв байдалтай нүүрстөрөгчийн нэгдлүүд, шингэн нүүрстөрөгч, угаагч бодис, пластмасс, пестицид ба бусад нийлэг бодис, хүхэр, фтор, азотын нэгдлүүд, хүнд металл, хатуу хольц, органик нэгдлүүдийн нөлөөлөл хамаарна.

Зөрчлийг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан ба харьяалал. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлд зааснаар Зөрчлийн тухай хуулийн 7.4 дүгээр зүйлийн Агаарын тухай хууль зөрчих зөрчлийг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан болон харъяаллыг доорх хүснэгтээр харуулав. Үүнд:

Эрх бүхий албан тушаалтан	Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харьяалал
Зөрчлийн тухай хуулийн 7.4 дүгээр зүйл. Агаарын тухай хууль зөрчих	
Байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37) Гаалийн улсын байцаагч (6.11)	Зөрчлийн тухай хуулийн 7.4 дүгээр зүйлийн 1.1, 1.2, 1.3 дахь заалт
Байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37)	Зөрчлийн тухай хуулийн 7.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг
Байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37)	Зөрчлийн тухай хуулийн 7.4 дүгээр зүйлийн 3.1, 3.2 дахь заалт
Байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37)	Зөрчлийн тухай хуулийн 7.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг
Байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37)	Зөрчлийн тухай хуулийн 7.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг
Байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37)	Зөрчлийн тухай хуулийн 7.4 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг
Байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37)	Зөрчлийн тухай хуулийн 7.4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг

Хуулийн нэр томъёоны тайлбар. Зөрчлийн тухай хуулийн 7.4 дүгээр зүйлд заасан зөрчилтэй холбогдох нэр томьёог Агаарын тухай хуульд тайлбарласан байдаг бөгөөд тэдгээрийг дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

“Хүрээлэн байгаа агаар” гэж байгаль орчны бүрэлдэхүүн хэсгийн нэг болох хийн мандлын байгалийн төлвөөрөө байгаа хийн хольцыг,

“Агаарын бохирдол” гэж хүрээлэн байгаа агаарт шууд хаягдсан, эсхүл физик, химийн урвалын дүнд шинээр үүсэж бий болсон бохирдуулах бодисын агууламж нь агаарын чанарын стандартаас хэтрэхийг,

“Агаарын чанар” гэж агаарын чанарын стандартад нийцэж байгаа эсэхийг илэрхийлэх агаарын физик, хими, биологийн цогц шинж чанарыг,

“Агаарын чанарын хяналт-шинжилгээ” гэж агаарын чанарын төлөв байдал, түүний өөрчлөлтөд бай нгын ажиглалт, хэмжилт, судалгаа, шинжилгээ хийж үнэлэх үйл ажиллагааг,

“Агаарын чанарыг сайжруулах бүс” гэж агаарын бохирдлыг бууруулах зорилгоор тусгай дэглэм тогтоож, тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа хилийн зааг бүхий нутаг дэвсгэрийг,

“Агаар бохирдуулах бодис” гэж бохирдлын аливаа эх үүсвэр, эсхүл түүнээс хаягдаж хүрээлэн байгаа агаар бохирдуулж байгаа физик, хими, биологийн болон цацраг идэвхт бодис, тэдгээрийн хольцыг,

“Аюултай бохирдуулах бодис” гэж байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан жагсаалтад орсон бохирдуулах бодисыг,

“Агаарын бохирдлын эх үүсвэр” гэж хатуу түлш болон хүрээлэн байгаа агаарт бохирдуулах бодис гаргадаг, эсхүл физикийн сөрөг нөлөө үзүүлдэг аливаа объектыг,

“Агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр” гэж хүрээлэн байгаа агаарт жилд 100 тонноос их аливаа бохирдуулах бодис, эсхүл таван тонноос их аюултай бохирдуулах бодис гаргадаг үйлдвэрлэл, үйлчилгээний болон бусад зориулалтын барилга байгууламжийг,

“Хөдөлгөөнт эх үүсвэр” гэж дизель түлш, шатахуунаар ажилладаг бүх төрлийн автотээврийн хэрэгсэл, өөрөө явагч болон зөөврийн хөдөлгөөнт хэрэгслийг,

“Агаар хамгаалах” гэж хүрээлэн байгаа агаар бохирдохоос урьдчилан сэргийлэх, бохирдлыг бууруулах, агаарын чанарын төлөв байдлыг зохих түвшинд байлгах, тэдгээрт хяналт тавих ажиллагаа,

“Агаарын чанарын стандарт” гэж хүрээлэн байгаа агаар дахь бохирдуулах бодисын хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх хүлцэх хэм хэмжээг стандартын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталгаажуулсныг,

“Бохирдуулах бодисын хаягдлын стандарт” гэж агаарын бохирдлын эх үүсвэрээс үргэлжилсэн хугацааны турш хүрээлэн байгаа агаарт гаргаж болох бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээг стандартын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталгаажуулсныг,

“Агаарын бохирдлын төлбөр” гэж түүхий нүүрс олборлогч, органик уусгагч үйлдвэрлэгч, импортлогч, автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэл эзэмшигч, агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр ашиглах зөвшөөрөл эзэмшигч, агаарын бохирдлын эх үүсвэр хэрэглэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэний агаарт бохирдуулах бодисыг бохирдуулах бодисын хаягдлын стандартад заасан хэмжээнд гаргасан тохиолдолд төлөх төлбөрийг,

“Агаарын бохирдлын нөхөн төлбөр” гэж хүрээлэн байгаа агаарт бохирдуулах бодисыг бохирдуулах бодисын хаягдлын стандартад заасан хэмжээнээс хэтрүүлэн гаргасан тохиолдолд төлөх төлбөрийг,

“Зөвшөөрөгдөх хаягдал” гэж агаарын чанарын стандартаас хэтрэхгүй байхаар агаарын бохирдлын эх үүсвэрийн хувьд тогтоосон бохирдуулах бодисын хүрээлэн байгаа агаарт гаргаж болох дээд хэмжээг,

“Агаарт үзүүлэх физикийн сөрөг нөлөөлөл” гэж хүрээлэн байгаа агаарын дулаан, энерги, долгион, цацраг зэрэг физик шинж чанарыг өөрчилж улмаар хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа дуу чимээ, чичиргээ доргио, ионжуулагч цацраг, цахилгаан соронзон долгион зэрэг физикийн бусад хүчин зүйлийн үйлчлэлийг,

“Физикийн сөрөг нөлөөллийн стандарт” гэж физикийн нөлөөллийн хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх хүлцэх хэм хэмжээг стандартын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталгаажуулсныг,

“Физикийн сөрөг нөлөөллийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” гэж физикийн сөрөг нөлөөллийн стандартаас хэтрэхгүй байхаар тооцож агаарын бохирдлын эх үүсвэрийн хувьд тогтоосон хүрээлэн байгаа агаарт үзүүлж болох физикийн сөрөг нөлөөллийн хэм хэмжээг,

“Озоны үе давхарга” гэж дэлхийн гадаргаас дээш орших хийн мандлын озоны давхаргыг,

“Хүлэмжийн хий” гэж хэт улаан туяаг шингээн авч буцаан туяаруулах шинж чанартай байгалийн буюу хүний үйл ажиллагааны гаралтай хийн мандлын бүрэлдэхүүн хэсгийг,

“Дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй бодис” гэж Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай Монреалийн Протоколын хавсралтад тусгагдсан гидрофторт нүүрстөрөгчийн төрлийн бодисыг тус тус ойлгоно.

3.3.2. Зөрчлийн ойлголт, шинж ба төсөөтэй гэмт хэргээс ялгагдах шинж

Зөрчлийн тухай хуулийн 7.4 дүгээр зүйлийн Агаарын тухай хууль зөрчих зөрчлийн ойлголт. Агаарын чанарт сөргөөр нөлөөлж байгаа хуулиар мэдээлэх мэдээг тогтоосон хугацаанд мэдээлээгүй, зориуд буруу мэдээлсэн, нуун дарагдуулсан, эсхүл хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, стандартаас хэтэрсэн бохирдуулах бодис гаргадаг, физикийн сөрөг нөлөөлөл үзүүлдэг тээврийн хэрэгсэл, эсхүл хөдөлгөөнт бусад эх үүсвэр ашиглан агаар бохирдуулсан, агаар бохирдуулах бодис, физикийн сөрөг нөлөөллийг багасгах, цэвэрлэх, хянах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг ашиглах журам зөрчсөн, хүн амын оршин суугаа орчны агаарыг бохирдуулан хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх нөхцөлийг бүрдүүлсэн, зөвшөөрөлгүйгээр бохирдуулах бодис гаргадаг, физикийн сөрөг нөлөөлөл үзүүлдэг эх үүсвэр ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж агаар бохирдуулсан үйлдэл, эс үйлдэхүйг Агаарын тухай хууль зөрчих зөрчил гэнэ.

Зөрчлийн тухай хуулийн 7.4 дүгээр зүйлийн Агаарын тухай хууль зөрчих зөрчлийн шинжийг дор харуулав.

Буруу мэдээлсэн *гэж* агаарын чанарт сөргөөр нөлөөлөх, озон задалдаг бодис, түүнийг орлуулах бусад бодис, тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмжийн импорт, үйлдвэрлэлийн тухай мэдээлэл, агаарын бохирдлын эх үүсвэрийн тухай мэдээлэл, агаарт гаргасан бохирдуулах бодисын агууламж, хаягдлын хэмжээ, дотоод хяналтын мэдээг илт зөрүүтэй, бодит байдлыг гуйвуулж мэдээлснийг ойлгоно.

Нуун дарагдуулсан гэж агаарын чанарт сөргөөр нөлөөлөх, озон задалдаг бодис, түүнийг орлуулах бусад бодис, тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмжийн импорт, үйлдвэрлэлийн тухай мэдээлэл, агаарын бохирдлын талаарх мэдээллийг олон нийт болон зохих байгууллагад мэдээлээгүй зориуд нуун дарагдуулсан үйлдлийг ойлгоно.

Зөрчлийн тухай хуулийн 7.4 дүгээр зүйл.Агаарын тухай хууль зөрчих зөрчил

- Агаарын чанарт сөргөөр нөлөөлж байгаа өөрийн үйл ажиллагааны тухай мэдээлэл, озон задалдаг бодис, түүнийг орлуулах бусад бодис, тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмжийн импорт, үйлдвэрлэлийн тухай мэдээлэл, агаарын бохирдлын эх үүсвэрийн тухай мэдээлэл, агаарт гаргасан бохирдуулах бодисын агууламж, хаягдлын хэмжээ, дотоод хяналтын мэдээг
- Зориуд буруу мэдээлсэн, тогтоосон хугацаанд мэдээлээгүй
- Нуун дарагдуулсан, эсхүл хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан
- Агаар бохирдуулах бодисын хаягдлын стандартаас хэтэрсэн бохирдуулах бодис гаргадаг, физикийн сөрөг нөлөөлөл үзүүлдэг тээврийн хэрэгсэл, эсхүл хөдөлгөөнт бусад эх үүсвэр ашиглан агаар бохирдуулсан
- Агаар хамгаалах талаар тавигдах шаардлага хангаагүй
- Барилга байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглалтад оруулсан, техник, технологи нэвтрүүлсэн
- Агаарт бохирдуулах бодис гаргах, физикийн сөрөг нөлөөлөл үзүүлэх талаар зөвшөөрөлд заасан хэмжээ, нөхцөл, шаардлагыг зөрчсөн
- Агаарт гаргах бохирдуулах бодис, физикийн сөрөг нөлөөллийг багасгах, цэвэрлэх, хянах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг ашиглах журам зөрчсөн
- Хүн амын оршин суугаа орчны агаарыг бохирдуулан хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх нөхцөлийг бүрдүүлсэн
- Агаарын чанарыг сайжруулах бүсэд Монгол Улсын стандартаар тогтоосон экологийн хамгийн өндөр ангиллаас доош ангиллын, эсхүл уг ангиллын стандартын шаардлага хангаагүй автобензин, дизель түлшийг жижиглэнгээр худалдан борлуулсан
- Бохирдуулах бодис гаргадаг, физикийн сөрөг нөлөөлөл үзүүлдэг эх үүсвэр ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж агаар бохирдуулсан

Хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан гэж агаарын чанарт сөргөөр нөлөөлөх, озон задалдаг бодис, түүнийг орлуулах бусад бодис зориулалтын бус газарт хог хаягдал хаях, ил задгай шатаах, агаар бохирдуулах бодис ялгаруулдаг үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, урамшуулал бүхий цахилгаан эрчим хүчийг ахуйн зориулалтаас бусад хэлбэрээр ашиглах, стандартын шаардлага хангаагүй цахилгаан халаах хэрэгсэл ашиглах, түүхийн нүүрс болон агаар бохирдуулах бусад хаягдал зүйлс шатаах, Монгол Улсын стандартаар тогтоосон экологийн хамгийн өндөр ангиллаас доош ангиллын, эсхүл уг ангиллын стандартын шаардлага хангаагүй автобензин, дизель түлшийг жижиглэнгээр худалдан борлуулах, зориулалтын бус газарт хог хаягдал хаях, ил задгай шатаах болон хог хаягдал устгах стандартын шаардлага хангаагүй үйл ажиллагаа явуулахыг ойлгоно.

Стандартаас хэтэрсэн бохирдуулах бодис гаргадаг, физикийн сөрөг нөлөөлөл үзүүлдэг тээврийн хэрэгсэл, эсхүл хөдөлгөөнт бусад эх үүсвэр ашиглан агаар бохирдуулсан гэж агаар бохирдуулах хөдөлгөөнт эх үүсвэр дизель түлш, шатахуунаар ажилладаг бүх төрлийн автотээврийн хэрэгсэл, өөрөө явагч болон зөөврийн хөдөлгөөнт хэрэгслийг стандарт шаардлага хангаагүй эх үүсвэр ашиглаж агаар бохирдуулсан байна.

Агаар хамгаалах талаар тавигдах шаардлага хангаагүй гэж үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга байгууламжид ариун цэврийн хамгаалалтын бүс тогтоож хүн амын суурьшлын бүсээс зааглах, хот, тосгон, бусад суурин газрын байршил, хөгжлийн ерөнхий төлөвлөгөө зэрэг баримт бичгүүдэд агаарын төлөв байдалд гарч болох өөрчлөлт, болзошгүй сөрөг нөлөөллийг тусгасан Агаарын тухай хуулийн 21, 22 дугаар зүйлийг зөрчсөн байхыг ойлгоно.

Барилга байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглалтад оруулсан гэж агаарт онцгой хортойгоор нөлөөлөх стандартын шаардлага ханаагаагүй барилга байгууламж, аливаа тоног төхөөрөмжийг ашиглалтад оруулсныг ойлгоно.

Агаарт бохирдуулах бодис гаргах, физикийн сөрөг нөлөөлөл үзүүлэх талаар зөвшөөрөлд заасан хэмжээ, нөхцөл, шаардлагыг зөрчсөн *гэж а*гаарт бохирдуулах бодис гаргах, физикийн сөрөг нөлөөлөл үзүүлэх талаар эрх бүхий байгууллагаас тогтоосон хэмжээ, нөхцөл, шаардлагыг зөрчсныг ойлгоно.

Хүн амын оршин суугаа орчны агаарыг бохирдуулан хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх нөхцөлийг бүрдүүлсэн гэж хүн, хуулийн этгээд хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул учруулах нөхцөл байдал бий болгосон үйлдэл байна.

Агаарын чанарыг сайжруулах бүсэд Монгол Улсын стандартаар тогтоосон экологийн хамгийн өндөр ангиллаас доош ангиллын, эсхүл уг ангиллын стандартын шаардлага хангаагүй автобензин, дизель түлшийг жижиглэнгээр худалдан борлуулсан *гэж* эрх бүхий байгууллагаас тогтоосон бүсэд Монгол Улсын MNS 0216: 2017. Дизелийн түлш Евро.Техникийн шаардлага, MNS 0217:2017. Хөдөлгүүрийн түлш. Этилжүүлээгүй бензин стандартын шаардлага хангаагүй автобензин, дизель түлшийг жижиглэнгээр худалдсан үйлдэл байна.

*Бохирдуулах бодис гаргадаг, физикийн сөрөг нөлөөлөл үзүүлдэг эх үүсвэр ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж агаар бохирдуулсан гэж З*өвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.10-д заасан агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр ашиглах зөвшөөрөлгүйгээр болон бусад эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хатуу түлш болон хүрээлэн байгаа агаарт бохирдуулах бодис гаргадаг, эсхүл физикийн сөрөг нөлөө үзүүлдэг аливаа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлсэн үйлдэл байна.

Зөрчлийн төсөөтэй гэмт хэргээс ялгагдах шинж. Эрүүгийн хуульд энэ төрлийн зөрчилтэй шууд адилтган үзэх зүйл, заалт байхгүй боловч Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.9 дүгээр зүйлд хуульчлан тодорхойлсон Байгалийн тэнцэл алдагдуулах гэмт хэргийг Зөрчлийн тухай хуулийн 7.4 дүгээр зүйлд заасан Агаарын тухай хууль зөрчих зөрчилтэй харьцуулан ялгагдах шинжийг доорх хүснэгтээр харуулав.

Хүснэгт 3.3. *Агаарын тухай хууль зөрчих зөрчлийн төсөөтэй гэмт хэргээс ялгагдах шинж*

Ялгагдах шинж	Байгалийн тэнцэл алдагдуулах (Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.9 дүгээр зүйл)	Агаарын тухай хууль зөрчих (Зөрчлийн тухай хуулийн 7.4 дүгээр зүйл)
Объект	Байгаль орчин, байгаль хамгаалах журам, экологийн тогтолцоо байна. Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна” гэж заасан.	Хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх, агаарт гаргах бохирдуулах бодис физикийн сөрөг нөлөөллийг багасгах, цэвэрлэх, хянах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг ашиглах журам байна.
Объектив тал	...Агаар мандал, усны нөөцийг хордуулсан, бусад хэлбэрээр экологийн тогтолцоог алдагдуулсан...идэвхтэй үйлдэл байна.	Агаарын чанарт сөргөөр нөлөөлж байгаа хуулиар мэдээлэх мэдээг тогтоосон хугацаанд мэдээлээгүй, зориуд буруу мэдээлсэн, нуун дарагдуулсан, эсхүл хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, стандартаас хэтэрсэн бохирдуулах бодис гаргадаг, физикийн сөрөг нөлөөлөл үзүүлдэг тээврийн хэрэгсэл, эсхүл хөдөлгөөнт бусад эх үүсвэр ашиглан агаар бохирдуулсан, агаар бохирдуулах бодис, физикийн сөрөг нөлөөллийг багасгах, цэвэрлэх, хянах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг ашиглах журам зөрчсөн, хүн амын оршин суугаа орчны агаарыг бохирдуулан хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх нөхцөлийг бүрдүүлсэн, зөвшөөрөлгүйгээр бохирдуулах бодис гаргадаг, физикийн сөрөг нөлөөлөл үзүүлдэг эх үүсвэр ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж агаар бохирдуулсан идэвхтэй үйлдэл байна.
Субьект	Эрүүгийн хуульд заасан 16 насанд хүрсэн хэрэг хариуцах чадвартай Монгол Улсын харьяат болон гадаадын харьяат, аль ч улсын харьяат бус хүн, хуулийн этгээд байна.	Зөрчлийн тухай хуулийн 3.2-т заасан 16 настай хэрэг хариуцах чадвартай хүн, хуулийн этгээд байна.
Субьектив тал	Гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгдэнэ. Өөрөөр хэлбэл, гэмт этгээд өөрийн амьтан, ургамлын зүйлийг зөвшөөрөлгүйгээр гэмтээх, устгах, газар, газрын хэвлий, агаар мандал, усны нөөцийг хордуулах, бусад хэлбэрээр экологийн тогтолцоог алдагдуулах үйлдлийг хууль бус шинжтэй болохыг ухамсарлаж, түүнийг хүсэж үйлдсэн байна.	Зөрчлийн тухай хуулийн 7.4 дүгээр зүйлийн 1, 2, 3, 4, 5, 7 дахь хэсэгт заасан зөрчил гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгдэнэ. Харин энэ хуулийн 7.4 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт заасан зөрчил гэм буруугийн болгоомжгүй хэлбэрээр үйлдэгдэж болно.

3.3.3. Зөрчлийн зүйлчлэл

Энэ төрлийн зөрчлийг шалгах эрх бүхий албан тушаалтан нар дээрх схемээр харуулсан зөрчлийн шинжийн аль нэгийг зөрчсөн этгээдийн үйлдэл эс үйлдэхүйд Агаарын тухай хууль зөрчих зөрчлөөр зүйлчилж, Зөрчлийн тухай хуульд заасан шийтгэл оногдуулна. Дээр дурдсан шинж үгүй бол Зөрчлийн тухай хуульд заасан аль тохирох зөрчлөөр зүйлчилж шийтгэл оногдуулна.

Зөрчлийн тухай хуулийн 7.4 дүгээр зүйлийн Агаарын тухай хууль зөрчих зөрчил нь агаарын чанарт сөргөөр нөлөөлж байгаа хуулиар мэдээлэх мэдээг тогтоосон хугацаанд мэдээлээгүй, зориуд буруу мэдээлсэн, нуун дарагдуулсан, эсхүл хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, стандартаас хэтэрсэн бохирдуулах бодис гаргадаг, физикийн сөрөг нөлөөлөл үзүүлдэг тээврийн хэрэгсэл, эсхүл хөдөлгөөнт бусад эх үүсвэр ашиглан агаар бохирдуулсан, агаар бохирдуулах бодис, физикийн сөрөг нөлөөллийг багасгах, цэвэрлэх, хянах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг ашиглах журам зөрчсөн, хүн амын оршин суугаа орчны агаарыг бохирдуулан хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх нөхцөлийг бүрдүүлсэн, зөвшөөрөлгүйгээр бохирдуулах бодис гаргадаг, физикийн сөрөг нөлөөлөл үзүүлдэг эх үүсвэр ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж агаар бохирдуулсан, агаарын чанарыг сайжруулах бүсэд Монгол Улсын стандартаар тогтоосон экологийн хамгийн өндөр ангиллаас доош ангиллын, эсхүл уг ангиллын стандартын шаардлага хангаагүй автобензин, дизель түлшийг жижиглэнгээр худалдан борлуулсан, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр бохирдуулах бодис гаргадаг, физикийн сөрөг нөлөөлөл үзүүлдэг эх үүсвэр ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж агаар бохирдуулснаар төгс үйлдэгдсэнд тооцогдоно.

Харин зөрчил үйлдэгч Агаарын тухай хууль зөрчих зөрчил үйлдэх үедээ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль зөрчих зөрчил үйлдсэн тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 7.4 дүгээр зүйлийн Агаарын тухай хууль зөрчих болон 7.1 дүгээр зүйлийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль тогтоомж зөрчих зөрчлөөр давхар зүйлчилж шийтгэл оногдуулна.

3.3.4. Зөрчлийг шалгах тодорхой ажиллагаа

Шинэчлэн найруулсан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 9.1 дүгээр зүйлд Зөрчил шалган шийдвэрлэх тусгай журамд зааснаар Эрх бүхий албан хаагч Зөрчлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 5.2 дугаар зүйл, 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 5.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 5.13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 6.20 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 6.26 дугаар зүйл 8.6, 8.7 дугаар зүйл, 14.7 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 15.33 дугаар зүйл, 17.1 дүгээр зүйлийн 7, 16 дахь хэсэг, 18.1, 18.2, 18.4 дэх заалт, 23 дахь хэсэгт заасан зөрчлийг шалгахад энэ хуульд заасан ердийн журмаас гадна, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр бүлэгт заасан тусгай журмыг баримтлан хэргийн газрын үзлэг хийх, таньж олуулах, туршилт хийх, нүүрэлдүүлж мэдүүлэг авах, ердийн ажиглалт явуулах, мэдүүлгийг газар дээр нь шалгах зэрэг ажиллагааг явуулна.

Харин байгаль орчны хяналтын улсын байцаагч Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр бүлэгт заасан зөрчил шалган шийдвэрлэх зорилгоор дараах тодорхой ажиллагааг явуулж болно. Үүнд:

Үзлэг хийх. Эрх бүхий албан тушаалтан Агаарын тухай хууль зөрчсөн эсэхийг тогтоох, дээж авах, шинжилгээ хийлгэх зорилгоор хүн, хуулийн этгээдийн үйлдвэрлэл, үйлчилгээний агуулах байр сав, зуух, тоног төхөөрөмж, автотээврийн хэрэгсэл болон бусад эд зүйлс, баримт бичиг, ачаа тээш, тээврийн хэрэгсэлд үзлэг хийнэ.

Мөн Агаарын тухай хуулийн 9.1.8-д агаарын чанарыг сайжруулах бүсэд түүхий нүүрс болон агаар бохирдуулах бусад зүйл шатаахгүй байх, 15.5-д агаарын чанарыг сайжруулах бүсэд хамаарах газар нутгийн хэмжээнд аливаа бохирдуулах бодисын хамгийн их агууламж нь агаарын чанарын стандартаас хэтрэхгүй байвал зохино, 16 дугаар зүйлд зориулалтын бус газарт хог хаягдал хаях, ил задгай шатаах, агаар бохирдуулах бодис ялгаруулдаг үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, стандартын шаардлага хангаагүй цахилгаан халаах хэрэгсэл ашиглах, түүхийн нүүрс болон агаар бохирдуулах бусад хаягдал зүйлс шатаах, Монгол Улсын стандартаар тогтоосон экологийн хамгийн өндөр ангиллаас доош ангиллын, эсхүл уг ангиллын стандартын шаардлага хангаагүй автобензин, дизель түлшийг жижиглэнгээр худалдан борлуулах үйл ажиллагаа явуулсан эсэхийг үзэж шалгална.

Хураан авах. Агаарын тухай хууль зөрчиж олсон хөрөнгө, орлого, эд зүйл, зөрчил үйлдэхэд ашигласан зэвсэг, хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, уналга, эсхүл зөрчил шалгах ажиллагаанд ач холбогдолтой эд зүйл, баримт бичгийг хураан авна.

Түүнчлэн Агаарын тухай хуулийн 28.1-д “Агаарын төлөв байдал, цаг уурын үзэгдэлд зориуд нөлөөлөх шаардлага гарсан тохиолдолд уг ажиллагааг гүйцэтгэх байгууллагад төрийн захиргааны төв байгууллага мэргэжлийн албаны дүгнэлтийг үндэслэн зөвшөөрөл олгоно”, мөн хуулийн 18.1-д “Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.10-д заасан агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр ашиглах зөвшөөрлийг тухайн сум, дүүргийн Засаг дарга олгоно”, 18.2-т “зөвшөөрөлд тухайн эх үүсвэрээс агаарт гаргах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх хаягдал, үзүүлэх физикийн сөрөг нөлөөллийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг зааж, агаар хамгаалах талаар авах арга хэмжээ, хууль тогтоомжид заасан бусад шаардлагыг тусгана” хэмээн заасан тул тусгай зөвшөөрөлтэй холбоотой дээрх зөрчлийг шалгаж буй тохиолдолд тусгай зөвшөөрлийг шаардан авах, лавлагаа, тодорхойлолт авах, бичиг баримт үзэж шалгах, хураан авах ажиллагааг хийнэ.

Эд хөрөнгө битүүмжлэх. Эрх бүхий албан тушаалтан Агаарын тухай хууль зөрчсөн эсэхийг тогтоох, дээж авах, шинжилгээ хийлгэх зорилгоор хүн, хуулийн этгээдийн үйлдвэрлэл, үйлчилгээний агуулах байр сав, зуух, тоног төхөөрөмж, автотээврийн хэрэгсэл болон бусад эд зүйлийг битүүмжилнэ.

Мэдүүлэг авах. Эрх бүхий албан тушаалтан зөрчил гарсан байдлыг тодруулах, зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдол бүхий баримт, мэдээллийг олох зорилгоор мэдүүлэг авна. Тухайн зөрчилд хамаарах асуудлаар зөрчил үйлдсэн байж болзошгүй холбогдогч, зөрчлийн талаар мэдэх болсон хүнийг гэрчээр, зөрчлийн улмаас хор хохирол хүлээсэн байгууллага, иргэнийг хохирогчоор тус тус хуульд заасан үндэслэл журмын дагуу мэдүүлэг авч энэ тухай тэмдэглэл үйлдэнэ.

Мэдүүлгийн эхэнд тухайн зөрчлийн талаарх мэдүүлж буй бүх зүйлсийг үгчлэн, дэлгэрэнгүй бичих бөгөөд үүний дараа холбогдох асуудлаар тодруулан мэдүүлэг авна. Зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтан мэдүүлгийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.8, 4.9-д заасан журмаар явуулж, тэмдэглэл үйлдэнэ.

Шинжилгээнд зориулж хэв загвар, дээж авах. Эрх бүхий албан тушаалтан Агаарын тухай хууль зөрчсөн эсэхийг тогтоох зорилгоор хүн, хуулийн этгээдийн үйлдвэрлэл, үйлчилгээний агуулах байр сав, зуух, тоног төхөөрөмж, автотээврийн хэрэгсэл, тодорхой газар орноос тогтоосон аргачлалын дагуу дээж, сорьц авч, шинжилгээ хийлгэхэд бэлтгэнэ.

Шинжилгээ хийлгэх. Эрх бүхий албан тушаалтан агаарын бохирдол нь анхдагч, хоёрдогч, агаар бохирдуулах бодис нь азотын ислүүд, хүхрийн давхар исэл, нүүрстөрөгчийн дутуу исэл,

озон, пероксиацетил нитрат, периоксибензолнитрат, кетон, альдегид зэргийн аль нь болохыг тогтоох, энэ зорилгоор шинжилгээ хийлгэнэ.

3.3.5. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд анхаарах асуудал

Зөрчлийн тухай хуулийн 7.4 дүгээр зүйлийн Агаарын тухай хууль зөрчих зөрчлийг шалган шийдвэрлэхдээ дараах ажиллагаанд анхаарч, гүйцэтгэнэ. Үүнд:

- Агаарын тухай хууль зөрчин агаарын чанарт сөргөөр нөлөөлж байгаа хуулиар мэдээлэх мэдээг тогтоосон хугацаанд мэдээлээгүй, зориуд буруу мэдээлсэн, нуун дарагдуулсан, эсхүл хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, стандартаас хэтэрсэн бохирдуулах бодис гаргадаг, физикийн сөрөг нөлөөлөл үзүүлдэг тээврийн хэрэгсэл, эсхүл хөдөлгөөнт бусад эх үүсвэр ашиглан агаар бохирдуулсан, агаар бохирдуулах бодис, физикийн сөрөг нөлөөллийг багасгах, цэвэрлэх, хянах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг ашиглах журам зөрчсөн, хүн амын оршин суугаа орчны агаарыг бохирдуулан хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх нөхцөлийг бүрдүүлсэн, зөвшөөрөлгүйгээр бохирдуулах бодис гаргадаг, физикийн сөрөг нөлөөлөл үзүүлдэг эх үүсвэр ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж агаар бохирдуулсан үйлдэл, эс үйлдэхүйг олж тогтоох
- Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн хамтарсан 2022 оны А/424, А1353 дугаар тушаал, захирамжаар Агаарын чанарыг сайжруулах бүс, бүсэд мөрдөх журмыг шинэчлэн батлсан байдаг бөгөөд Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүс болон уг бүсэд амьдарч буй иргэн, үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээд бүр дагаж мөрдөх ёстой учир түүнийг зөрчсөн эсэхийг шалгаж, тогтоох
- Агаарын чанарын албатай хамтран тодорхой газар орны агаараас дээж авч, агаар мандалд ялгарч байгаа бохирдуулагч, жигнэгдэгч бодисууд, азотын ислүүд, хүхрийн давхар исэл, нүүрстөрөгчийн дутуу исэл буюу анхдагч бохирдуулагч, агаар мандалд явагдах фотохимийн урвалын дүнд үүсэх бохирдуулагч азотын ислүүд, озон, пероксиацетил нитрат, периоксибензолнитрат, кетон, альдегид зэрэг хоёрдогч бохирдуулагч бодисийн хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнээс илүү байгаа эсэхийг шинжлэн, магадлах, дүгнэлт гаргуулах
- Хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааны улмаас хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд шууд, эсхүл шууд бусаар хор хохирол учруулж байгаа, учруулж болох нөхцөл байдал үүссэн бол хойшлуулашгүй тохиолдолд прокурорын зөвшөөрөлгүйгээр тухайн хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зөрчлийн холбогдогчийн ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг бүхэлд нь эсхүл хэсэгчилэн түр зогсоох, эсхүл барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалт, үйл ажиллагааг түр зогсоох эрх хязгаарлах арга хэмжээ авах
- Эрх бүхий албан тушаалтан дээр дурдсанчлан үйл ажиллагааг зогсоосон бол үйлдвэрлэл, үйлчилгээний агуулах байр сав, зуух, тоног төхөөрөмж, автотээврийн хэрэгсэл болон эд зүйлд үзлэг хийж, тогтоосон аргачлалын дагуу дээж, сорьц авч, шинжилгээ хийлгэхэд бэлтгэх
- Агаар бохирдуулагч бодисыг тогтоохын тулд холбогдох аргачлалын дагуу дээж авч, шинжилгээ хийлгэх тогтоол үйлдэж Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.11 дүгээр зүйлд зааснаар шинжилгээ хийлгэнэ. Хэрэв зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалан өөрөө тусгай мэдлэг, мэргэжил эзэмшсэн бол уг хуулийн 4.11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар эрх бүхий албан тушаалтан өөрөө бие даан шинжилгээ хийж болно.
- Агаарын тухай хуулийн 9.1.3-д заасан агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхдээ тухайн эх үүсвэрийн хаягдал, нөлөөллийг

хянах дотоод хяналтын багаж хэрэгслээр тоноглосон эсхийг шалгах, мөн хяналтын төхөөрөмжийн ажилсан байдал, үзүүлэлт зэргийг нарийн үзэж, эд зүйлд үзлэг хийж, гэрэл зургаар бэхжүүлж, тэмдэглэл үйлдэн зөрчлийн хэрэгт хавсаргах

- Ер нь энэ төрлийн зөрчлийг шалгаж тогтоох, шинжилгээ хийх зэрэгт аль болох орчин үеийн техник, технологи, багаж, тоног төхөөрөмжийг ашиглаж байх нь зүйтэй.

Бодлого

Сүхбаатар дүүргийн 7 дугаар хороо Эрхүүгийн гудамж 41 дүгээр байр 2-р орц *** тоотод байрлах “Шар будаа” ХХК нь 2012 оноос 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр оффисын болон хэвлэлийн үйл ажиллагаа явуулаад 1 жилийн хугацаа өнгөрч байгаа бөгөөд тус “Шар будаа” ХХК-ийн дэргэд байх 47А байрны оршин суугчид гомдол гарган хэвлэлийн үйлдвэр өдөр шөнөгүй ажиллаж байгаагаас үүдэлтэй хүүхдүүдэд харшил өгч байна гэх гомдол гаргажээ. Иймд “Шар будаа” ХХК-ийг ажиллаж байх үеийн агаарын сорьцын хэмжээг хэмжүүлэхээр “Ногоон титэм” ХХК-д хандсан. “Ногоон титэм” ХХК-ийн лабораторийн тайлангийн дүнгийн талаар тайланг хянасан химичээс нь асуухад хүний эрүүл мэндэд хор хөнөөл бүхий формальдегид 2.30 мкг/мл, озон 1.43 мкл, бензол 0.5 мкг/мл, толуол 0.7 мкг/мл, этилбензол 0.5 мкг/мл, ксилол 0.8 мкг/мл тус тус илэрсэн нь тогтоогдсон байна. Эдгээр химийн бодисууд нь хор аюулын зэрэглэлээр онцгой болон их аюултай химийн бодисууд бөгөөд шатамхай, идэмхий, хортой, харшил өдөөгч, маш шатамхай, цочроомтгой бодист хамаардаг байна.

Асуулт

1. Дээрх үйлдэл нь ямар хууль тогтоомж зөрчсөн вэ?
2. Энэ зөрчлийг шалгах ажиллагааны үед ямар ажиллагаа явуулах вэ?
3. Дээрх хууль бус үйлдэл нь Зөрчлийн тухай хуульд заасан ямар зөрчил болох вэ? Зөрчлийг зүйлчилнэ үү?
4. Зөрчил үйлдэгчид ямар шийтгэл оногдуулах вэ?

Хариулт

1. Дээрх үйлдэл нь ямар хууль тогтоомж зөрчсөн вэ?
Сүхбаатар дүүргийн 7 дугаар хороо Эрхүүгийн гудамж 41 дүгээр байр 2-р орц *** тоотод байрлах “Шар будаа” ХХК нь Химийн хорт бодис болон аюултай бодисын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т заасан химийн хорт болон аюултай бодис ашиглах явцад тухайн ажлын байр болон байгаль орчинд эрх бүхий байгууллагаас тогтоосон химийн хорт болон аюултай бодисын хүлцэх хэмжээг хэтрүүлэхийг хориглоно, мөн Агаарын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2-т агаар хамгаалахтай холбогдсон дүрэм, журам, бохирдуулах бодисын хаягдлын стандарт, хэм хэмжээний шаардлагыг хангах, Зөрчлийн тухай хуулийн 7.4 дүгээр зүйлийн 7.4.4, 7.4.6 дахь заалтуудыг зөрчиж байна.

2. Энэ зөрчлийг шалгах ажиллагааны үед ямар ажиллагаа явуулах вэ?
Уг зөрчлийг шалгах ажиллагаа Сүхбаатар дүүргийн 7 дугаар хороо Эрхүүгийн гудамж 41 дүгээр байр 2-р орц *** тоотод байрлах “Шар будаа” ХХК-ийн химийн хорт болон аюултай бодис ашиглахтай холбоотой үйл ажиллагаа, нөхцөл шаардлага болон зориулалтын байр, тайлбайн зөвшөөрөл, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм боловсруулж, мөрдөж байгаа эсэх, мөн “Шар будаа” ХХК-ийн үйл ажиллагааны улмаас харшилтай болсон гэх хүүхдүүд хэн болохыг тогтоож, харшил хэзээнээс үүссэн, харшил нь юунаас болсныг тогтоосон холбогдох материалыг, харшлаа үзүүлж эмчлүүлсэн эмнэлгийн карт зэрэг бичиг баримтуудыг үзэж шалган, шаардлагатайг нь хуулбарлана авна.

Мөн зөрчлийн газарт бусад зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд дурдсан аргачлалын дагуу үзлэг хийнэ. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд оролцох хохирогчийг тогтоолгон мэдүүлэг авах ажиллагааг явуулна.

3. Дээрх хууль бус үйлдэл нь Зөрчлийн тухай хуульд заасан ямар зөрчил болох вэ? Зөрчлийг зүйлчилнэ үү?
Зөрчлийн тухай хуулийн 7.4 дүгээр зүйлийн 7.4.4, 7.4.6-д заасан агаарт бохирдуулах бодис гаргах, физикийн сөрөг нөлөөлөл үзүүлэх талаар зөвшөөрөлд заасан хэмжээ, нөхцөл, шаардлагыг зөрчсөн, Хүн амын оршин суугаа орчны агаарыг бохирдуулан хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх нөхцөлийг бүрдүүлсэн гэж үзэж Зөрчлийн тухай хуулийн 7.4 дүгээр зүйлийн 7.4.4 болон 7.4.6-д зааснаар зүйлчилж шийтгэл оногдуулна.

4. Зөрчил үйлдэгчид ямар шийтгэл оногдуулах вэ?
Үйлдэгдсэн зөрчилд хүлээлгэх хариуцлага: Зөрчлийн тухай хуулийн 7.4 дүгээр зүйлийн 4, 5-д зааснаар Агаарт бохирдуулах бодис гаргах, физикийн сөрөг нөлөөлөл үзүүлэх талаар зөвшөөрөлд заасан хэмжээ, нөхцөл, шаардлагыг зөрчсөн хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. Мөн хүн амын оршин суугаа орчны агаарыг бохирдуулан хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх нөхцөлийг бүрдүүлсэн гэж үзэж хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Бодит жишээ **Нийлэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр**

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүх хуралдааныг шүүгч Б.Адъяасүрэн даргалж, тус шүүхийн шүүх хуралдааны 1 дүгээр танхимд нээлттэй хянан хэлэлцэв.

Гомдол гаргагч: "********" ХХК

Хариуцагч: Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Баянзүрх дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын Байгаль орчны хяналтын улсын байцаагч О

Гуравдагч этгээд: Э

Нэхэмжлэлийн шаардлага: "Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Баянзүрх дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын Байгаль орчны хяналтын улсын байцаагчийн 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 0066279 дугаартай шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах" гомдол бүхий зөрчлийн хэргийг хянан хэлэлцэв.

Шүүх хуралдаанд: Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга Э, гомдол гаргагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч С, өмгөөлөгч Н, хариуцагч О нарыг оролцуулав.

ТОДОРХОЙЛОХ нь:
"********" ХХК нь шүүхэд иргүүлсэн гомдолдоо: "Нийслэлийн Баянзүрх дүүргийн 3 дугаар хороонд байрлах "********"-95 хүнсний мухлагыг түрээсийн гэрээгээр иргэн Э-д 2014 оны 2 дугаар сарын 17-ны өдөр шилжүүлэн эзэмшүүлж байгаа билээ. Хамтран ажиллах түрээсийн гэрээгээр иргэн Э нь одоо хүртэл тус дэлгүүрийг ашиглаж байгаа бөгөөд гэрээний үүргийн дагуу бүрэн бүтэн байдал ба хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээний актын биелэлтийн дагуу хариуцан ажиллаж байгаа билээ.

2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Баянзүрх дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын улсын байцаагч О түрээслэгч Э-ийн түрээсэлж буй хүнсний мухлагт сайжруулсан зууханд түүхий нүүрс түлсэн нь агаарын чанарын 4 дүгээр бүсэд хамаарч байгаа нь хяналт шалгалтын явцад тогтоогдсон гэж үзэн Зөрчлийн тухай хуулийн 7.4 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэгт заасны дагуу 3000 нэгжээр торгох шийтгэлийг оногдуулж шийтгэлийн хуудсыг гардуулсан.

Зөрчлийн тухай хуулийн 1.2 дугаар зүйлд хууль ёсны зарчимд зааснаар зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл ногдуулна. Зөрчлийн хуулийг төсөөтэй хэрэглэхийг хориглоно. Зөрчлийг зөвхөн үйлдсэн гэм буруутай этгээд хариуцлага хүлээх зэрэг хуулийн зохицуулалт байсаар байхад зөрчил үйлдээгүй боловч түрээслүүлсэн аж ахуйн нэгжид түрээслэгчийн буруутай үйлдлийн үр дагаврыг хариуцуулахаар шийтгэлийн хуудсыг бичиж, хэвийн үйл ажиллагаа явуулж байсан аж ахуйн нэгж байгууллагыг хохироож байна.

Зөрчлийг түрээслэгч Э үйлдсэн нь зөрчлийн хэрэгт авагдсан нотлох баримтуудаар тогтоогдсон буюу өөрөөр хэлбэл, зөрчил иргэнээс өдүүлсэн байхад түрээслэгч Э-ийн зөрчлийг “*******” ХХК-аас төлүүлэх шийдвэр гаргасан нь хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх хууль ёсны шаардлагыг зөрчсөн гэж үзэж байгаа тул 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 0066279 дугаартай шийтгэлийн хуудсыг хүчингүйд тооцож өгнө үү” гэжээ.

Хариуцагч Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Баянзүрх дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын Байгаль орчны хяналтын улсын байцаагч О шүүхэд гаргасан хариу тайлбартаа:

1. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын 2019 оны 02-01/21 дугаартай Агаар бохирдуулагч эх үүсвэр ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай, Баянзүрх дүүргийн Прокурорын “Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх” удирдамжийн дагуу Баянзүрх дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх 5 дугаар байрны урд талд байрлах “*******” ХХК-ийн хүнсний дэлгүүрт 2019 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн 11 цаг 30 минутад Баянзүрх дүүргийн прокурорын газрын ахлах прокурор, хууль цаазын итгэмжит зөвлөх А, тус дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн дарга Ц нарын бүрэлдэхүүнтэй Агаарын тухай хууль, Агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журмын хэрэгжилтэд хяналт шалгалт хийсэн.

2. Шалгалтаар “*******” ХХК-ийн хүнсний дэлгүүрийн халаалтад түүхий нүүрс түлж байсан үйлдэл нь Агаарын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.8 дахь Агаарын чанарыг сайжруулах бүсэд түүхий нүүрс болон агаар бохирдуулах бусад зүйл шатаахгүй байх заалтыг зөрчсөн нь хяналт шалгалтын явцад илрүүлсэн бөгөөд фото зураг, “*******” ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч С-ийн мэдүүлэг зэрэг нотлох баримтаар нотлогдон тогтоогдож байгаа болно.

3. Дээрх гаргасан зөрчилд нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг удирдлага болгон Зөрчлийн тухай хуулийн 7.4 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэгт зааснаар 1906000399 дугаартай зөрчлийн хэрэг нээн, холбогдогчийн тайлбар мэдүүлэг авч, гаргасан зөрчилд нь холбогдуулан 0066279 дугаартай шийтгэлийн хуудас үйлдэн, гарын үсэг зурж баталгаажуулан Баянзүрх дүүргийн Прокурорын газарт хүргүүлж холбогдох хяналтын прокуророор нь хуулийн дагуу хянуулсан.

Иймд Баянзүрх дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн Байгаль орчны хяналтын улсын байцаагчийн үйлдсэн 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 0066279 дугаартай шийтгэлийн хуудсыг хэвээр үлдээж, нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож өгнө үү” гэжээ.

Гуравдагч этгээд Э шүүхэд гаргасан хүсэлтдээ: “Миний бие хувиараа “********” ХХК-ийн байрыг түрээслэж, зургаан нэрийн барааны дэлгүүр ажиллуулж байсан. Энэ хугацаанд тень тавихаар тог их гардаг тул утаагүй зуухыг тавьж, нэг жил ажилласан чинь Мэргэжлийн хяналтын гурван байцаагч ирж гал түлж болохгүй, утаа гаргаж байна гэв. Би нүүрс түлээгүй зуухны хажууд хоёр шуудай мод тавьсан байсан. Модоо түлж байсан болно. Тэгээд Мэргэжлийн хяналтын байцаагч мод түлж болохгүй гэж хэлсэн мөртлөө тэр хоёр жижиг шуудайтай модыг нүүрс гэж хараад цааш нь “********” ХХК-ийг торгох шийдвэр гаргасан байна. Иргэн хүний хувьд мөн “********” ХХК-95 дэлгүүрийг өөрөө түрээслэж, хариуцаж ажиллуулж байгаагийн хувьд мод түлсэн хариуцлагаа өөрөө хүлээнэ. Зөрчлийн хуулийн дагуу иргэний журмаар 200,000 төгрөгөөр торгуулах хүсэлтэй байна” гэжээ.

ҮНДЭСЛЭХ нь:

Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Баянзүрх дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын Байгаль орчны хяналтын улсын байцаагч О-ийн 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 0066279 дугаартай шийтгэлийн хуудсыг хүчингүй болгох нь зүйтэй гэж үзлээ.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.1 дүгээр зүйлийн 1-д “Энэ хуулийн зорилт нь ... зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах, энэхүү ажиллагааны явцад хүн, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад оршино”, Зөрчлийн тухай хуулийн 1.1 дүгээр зүйлийн 1-д “энэ хуулийн зорилго нь ... түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах замаар шударга ёсны тогтолцоог бэхжүүлэхэд оршино” гэж тус тус заажээ.

Эдгээр хуулийн заалтаас үзэхэд, Зөрчил үйлдсэн этгээдэд шийтгэл ногдуулахаар зохицуулсан атал Баянзүрх дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн Байгаль орчны хяналтын улсын байцаагч 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 0066279 дугаартай шийтгэлийн хуудсаар тухайн зөрчлийг гаргасан этгээд болох Э-д шийтгэл ногдуулалгүй, түрээслүүлэгч “********” ХХК-д шийтгэл ногдуулсан нь дээр дурдсан хуулийн зорилгод нийцээгүй, “********” ХХК-ийн эрх хууль ёсны ашиг сонирхлыг зөрчжээ.

Учир нь: “********” ХХК нь “********”-95 хүнсний дэлгүүрийг иргэн Э-д 2007 оноос эхлэн хамтран ажиллах гэрээ байгуулан түрээслүүлж байсан нь хэрэгт авагдсан гэрээ, түүний сунгалт, өөрчлөлт оруулсан тухай гэрээгээр тус тус нотлогдож байна.

“********” ХХК-ийн түрээслэгч Э-тэй байгуулсан гэрээний 2.2.9-д “халуун, дулааны асуудлыг түрээслэгч тал хариуцан шийдэх бөгөөд төлбөрийг бүрэн хариуцна”, 2.2.10-д “түрээслэгч үйл ажиллагаа явуулахдаа хууль тогтоомж зөрчсөний улмаас үүссэн асуудлыг өөрөө хариуцах ...”-аар заасан байна.

Тодруулбал, Хариуцагч 2019 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр 1906000399 дугаартай зөрчлийн хэрэг нээж, 2019 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр Баянзүрх дүүргийн 3 дугаар хороо 5 дугаар байрны урд байрлах “********” ХХК-ийн эзэмшлийн хүнсний дэлгүүр нь агаарын чанарыг сайжруулах 4 дүгээр бүсэд түүхий нүүрс болон бусад зүйл шатааж ойр орчныг бохирдуулсан гэж үзэн Зөрчлийн тухай хуулийн 7.4 дүгээр зүйлийн 1.3-д зааснаар 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 0066279 дүгээр шийтгэлийн хуудсаар шийтгэл ногдуулсан нь зөв боловч, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 3.1 дүгээр зүйлийн 1-д “Зөрчил үйлдсэн гэж буруутгагдаж байгаа хүн, хуулийн этгээдийг холбогдогч гэнэ” гэж зааснаар Агаарын тухай хууль тогтоомж зөрчсөн зөрчил гаргасан холбогдогчийг зөв тодорхойлохгүйгээр түрээслүүлэгч “********” ХХК-д шийтгэл ногдуулж хууль буруу хэрэглэжээ.

Иймд Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Баянзүрх дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын Байгаль орчны хяналтын улсын байцаагчийн 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 0066279 дугаартай шийтгэлийн хуудсыг хүчингүй болгож шийдвэрлэв.

Харин зөрчил үйлдсэн этгээд болох “*******” ХХК-ийн “*******”-95 хүнсний дэлгүүрийг түрээслэгч Э-ийн гаргасан зөрчилд шийтгэл ногдуулахад энэхүү шийдвэр саад болохгүйг дурдах нь зүйтэй.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.1, 106.3.11 дэх хэсэгт заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийн 7.4 дүгээр зүйлийн 1.3, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 3.1 дүгээр зүйлийн 1-д заасныг тус тус баримтлан Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Баянзүрх дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын Байгаль орчны хяналтын улсын байцаагчийн 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 0066279 дугаартай шийтгэлийн хуудсыг хүчингүй болгосугай.

2. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.14 дэх хэсэгт тус тус заасны дагуу нэхэмжлэгчийн улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 70,200 төгрөгийг хариуцагчаас гаргуулж, нэхэмжлэгчид олгосугай.

3. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 113 дугаар 113.2-т зааснаар хэргийн оролцогчид, тэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгч нь шийдвэрийг эс зөвшөөрвөл шийдвэрийг гардан авсан өдрөөс хойш 5 хоногийн дотор давж заалдах журмаар гомдол гаргах эрхтэй.

Шүүхийн шийдвэрийн үндэслэл, дүгнэлт

Байгаль орчны хяалтын улсын байцаагч Баянзүрх дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх 5 дугаар байрны урд талд байрлах “*******” ХХК-ийн хүнсний дэлгүүрт 2019 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн 11 цаг 30 минутад Баянзүрх дүүргийн прокурорын газрын ахлах прокурор, хууль цаазын итгэмжит зөвлөх А, тус дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн дарга Ц нарын бүрэлдэхүүнтэй Агаарын тухай хууль, Агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журмын хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, шалгалтаар “*******” ХХК-ийн хүнсний дэлгүүрийн халаалтад түүхий нүүрс түлж байсан үйлдэл нь Агаарын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.8 дахь Агаарын чанарыг сайжруулах бүсэд түүхий нүүрс болон агаар бохирдуулах бусад зүйл шатаахгүй байх заалтыг зөрчсөн нь хяналт шалгалтын явцад илрүүлсэн бөгөөд фото зураг, “*******” ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч С-ийн мэдүүлэг зэрэг нотлох баримтуудаар нотолж тогтоосон нь сайшаалтай байна.

Гэвч улсын байцаагч 1906000399 дугаартай зөрчлийн хэрэг нээж, 2019 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр Баянзүрх дүүргийн 3 дугаар хороо 5 дугаар байрны урд байрлах “*******” ХХК-ийн эзэмшлийн хүнсний дэлгүүр нь агаарын чанарыг сайжруулах 4 дүгээр бүсэд түүхий нүүрс болон бусад зүйл шатааж ойр орчныг бохирдуулсан гэж үзэн Зөрчлийн тухай хуулийн 7.4 дүгээр зүйлийн 1.3-д зааснаар 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 0066279 дүгээр шийтгэлийн хуудсаар шийтгэл ногдуулж хуулийг буруу хэрэглэсэн алдаа гаргажээ.

Тайлбар: Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 3.1 дүгээр зүйлийн 1-д “Зөрчил үйлдсэн гэж буруутгагдаж байгаа хүн, хуулийн этгээдийг холбогдогч гэнэ” гэж зааснаар Агаарын тухай хууль тогтоомж зөрчсөн зөрчил гаргасан холбогдогчийг зөв тодорхойлохгүйгээр түрээслүүлэгч “*******” ХХК-д шийтгэл ногдуулж Зөрчлийн хуулийг буруу хэрэглэжээ.

“*******” ХХК нь “*******”-95 хүнсний дэлгүүрийг иргэн Э-д 2007 оноос эхлэн хамтран ажиллах гэрээ байгуулан түрээслүүлж байсан нь хэрэгт авагдсан гэрээ, түүний сунгалт, өөрчлөлт оруулсан тухай гэрээгээр тус тус нотлогдож байна.

Харин “*******” ХХК-ийн түрээслэгч Э-тэй байгуулсан гэрээний 2.2.9-д “халуун, дулааны асуудлыг түрээслэгч тал хариуцан шийдэх бөгөөд төлбөрийг бүрэн хариуцна”, 2.2.10-д “түрээслэгч үйл ажиллагаа явуулахдаа хууль тогтоомж зөрчсөний улмаас үүссэн асуудлыг өөрөө хариуцах ...”-аар заасан тул түрээслэгчид шийтгэл оногдуулсан буруу шийдвэр байна.

3.4 АМЬТНЫ ТУХАЙ ХУУЛЬ ЗӨРЧИХ, ЗӨРЧЛИЙН ШИНЖ, ОНЦЛОГ, АНХААРАХ АСУУДАЛ

3.4.1. Шийтгэл, эрх бүхий албан тушаалтан ба харьяалал, нэр томъёоны тайлбар

Шийтгэл. Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн Амьтны тухай хууль зөрчих тохиолдолд зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд дараах шийтгэл оногдуулна. Үүнд:

1. Хугацаа дууссан гэрээ, зөвшөөрлөөр, эсхүл гэрээ, зөвшөөрөлгүйгээр амьтныг (1.1) ашигласан, (1.2) барьсан, (1.3) агнасан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2. Амьтныг ашиглах, барих, агнах зөвшөөрлийг бусдад шилжүүлсэн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
3. Ан агнах, загас барих гэрээ, тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийг бусдад шилжүүлсэн, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ан агнасан, барьсан, зохих гэрээ байгуулахгүйгээр үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнасан, барьсан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
4. Агнуурын бүс нутгаас бусад газарт, эсхүл амьтныг агнах хориотой үед, эсхүл хориглосон хугацаанд, эсхүл хориглосон арга хэрэгслээр амьтныг барьсан, агнасан, тээвэрлэсэн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
5. Агнуурын амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийн зүйлийг тусгай зөвшөөрөл, гарал үүслийн бичиг, дагалдах тодорхойлолтгүйгээр худалдсан, худалдан авсан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
6. Амьтныг зөвшөөрөлгүйгээр нутагшуулсан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
7. Харь амьтныг зөвшөөрөлгүйгээр нутагшуулсан, өсгөж үржүүлсэн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
8. Энэ зүйлийн 5 дахь хэсэгт зааснаас бусад амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг гарал үүслийн тодорхойлолтгүйгээр худалдсан, худалдан авсан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

9. Амьтны хүрээлэн ажиллуулахад тавигдах шаардлагыг зөрчсөн бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Зөрчлийг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан ба харьяалал. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлд зааснаар Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн Амьтны тухай хууль зөрчих зөрчлийг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан болон харъяаллыг доорх хүснэгтээр харуулав. Үүнд:

Эрх бүхий албан тушаалтан	Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харьяалал
Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн Амьтны тухай хууль зөрчих	
Байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37)	Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйл (9 хэсэгтэй бөгөөд бүгд хамаарна)
Цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч (6.8) Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч (6.44) Эрүүл ахуй, халдвар хамгаалллын хяналтын улсын байцаагч (6.59)	Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн 9 дэх хэсэг

Хуулийн нэр томъёоны тайлбар. Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлд заасан зөрчилтэй холбогдох нэр томьёог Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон ихэвчлэн Амьтны тухай хуульд тус тус тайлбарласан байдаг бөгөөд тэдгээрийг дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

“Амьтан” гэдэгт Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4-д заасан Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга буюу түр нутагшсан хөхтөн, шувуу, мөлхөгч, хоёр нутагтан, загас, хавч хэлбэртэн, шавж, зөөлөн биетэн, эгэл биетэн хамаарна.

“Тархац нутаг” гэж тухайн амьтны нутагладаг, нүүдэллэдэг, тэдгээрийн амьдрах тохиромжтой нөхцөл бүрдсэн газар нутгийг,

“Биотехникийн арга хэмжээ” гэж амьтны амьдрах болон идэш тэжээлийн нөхцөлийг сайжруулахад чиглэгдсэн үйл ажиллагааг,

“Сэргээн нутагшуулах” гэж хамгаалах, өсгөх үржүүлэх зорилгоор устах аюулд орсон, ховордсон амьтны зүйлийг урьд амьдарч байсан нутагт нь зориудаар зөөвөрлөн нутагшуулах үйл ажиллагааг,

“Агнуурын амьтан” гэж арьс, үс, мах болон бусад түүхий эдийг нь ашиглахаар агнаж ирсэн уламжлалтай, агнуурын нөөцтэй амьтныг,

“Агнуурын нөөц” гэж хэвийн өсөлт, үржилтийг нь алдагдуулахгүй агнах, барих боломжтой агнуурын амьтны тоо, хэмжээг,

“Агнуурын бүс нутаг” гэж агнуурын нөөцийг тогтвортой ашиглах, хамгаалах зориулалт бүхий амьтны байршил, тархац нутгийг,

“Агнуурын амьтны сүргийн бүтэц” гэж сүрэг дэх амьтдын нас, хүйсийн харьцааг,

“Ан агнуурын менежментийн төлөвлөгөө” гэж тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх агнуурын бүс нутагт ан амьтныг хамгаалах, тогтвортой ашиглах, өсгөн үржүүлэхэд чиглэгдсэн ан агнуурын арга хэмжээний хүрээнд гүйцэтгэх ажлыг тодорхой үе шаттайгаар цогц байдлаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн баримт бичгийг,

“Амьтны нөөцийг хамгаалах” гэж амьтны сүргийн бүтцийн төлөв байдлыг доройтохоос урьдчилан сэргийлэх, тэдгээрийн жам ёсоороо нөхөн сэргэх боломжийг нь алдагдуулахгүйгээр амьтны нөөцийг зүй зохистой ашиглах, гамшиг, аюулт үзэгдэл, халдварт өвчин, хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс хамгаалах, амьтны идэш тэжээлийн төлөө тэмцэл, хорогдлын шалтгааныг олж тодорхойлох, биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх, сэргээн нутагшуулах, өсгөн үржүүлэх, тэдгээрт хяналт тавих цогц үйл ажиллагааг,

“Амьтныг өсгөн үржүүлэх” гэж амьтныг зохих журмын дагуу эзэмшилдээ авч, батлагдсан технологи, норм, нормативын дагуу тэжээврээр үржүүлэх замаар үр төлийг бойжуулан өсгөхийг,

“Ангийн буу” гэж хийц, үзэмж, загвараараа байлдааны зэвсгээс ялгаатай, замагтай бууны хүхээнд нэг, дайзанд дөрвөөс илүүгүй, өөрөө цэнэглэгдэгч (хагас автомат) бууны хүхээнд нэг, дайзанд таваас илүүгүй сумны багтаамжтай галт зэвсгийг,

“Спорт агнуур” гэж анчин ан агнах, барих хэрэгцээгээ хангах зорилгоор ан амьтны эд, эрхтнийг үзүүлэлтийн хувьд сонголт болголгүй агнах, барихыг,

“Олзворын ан” гэж амьтны илүү үзүүлэлт бүхий эд, эрхтнийг авах зорилгоор тусгай төлбөр төлж агнах, барихыг,

“Агнах, барихыг түр хориглосон ан амьтан” гэж хуулиар агнах, барихыг хориглоогүй ч тархац, нөөц, хэвийн өсөж үржих, амьдрах орчин нөхцөл нь хомсдсон, муудсан, доройтсоны улмаас Амьтны тухай хуулийн 5.2, 5.3-д заасан эрх бүхий байгууллагаас агнах, барихыг нь тодорхой хугацаагаар хориглосон амьтныг,

“Харь амьтан” гэж улсын хилийн гаднаас зориудаар болон санамсаргүй байдлаар зөөвөрлөгдөн ирж, нутагшиж байгаа амьтны зүйлийг,

“Анчин” гэж аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон анчны үнэмлэхтэй иргэнийг,

“Ангийн гаралтай түүхий эд” гэж амьтны арьс, шир, үс, өд, эвэр, толгой, цус, өөх, тос зэрэг эд эрхтнийг,

“Ан агнуур” гэж ангийн гаралтай түүхий эдийг ашиглах зорилгоор хуулиар заасан хугацаа, арга, хэрэгсэл, зөвшөөрлийн дагуу агнуурын амьтныг агнах, барих үйл ажиллагааг,

“Агнуурын зохион байгуулалт” гэж агнуурын амьтны тархац, байршил, нөөц, төрөл, зүйл, тоо толгой, сүргийн бүтэц, өөрчлөлтийг судлан тогтоож, агнуурын нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, өсгөн үржүүлэх арга хэмжээг цогц байдлаар тодорхойлох үйл ажиллагааг,

“Ангийн аж ахуй” гэж Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 30.3-т заасны дагуу агнуурын амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, зохистой ашиглах үйл ажиллагааг ан агнуурын менежментийн төлөвлөгөөний дагуу эрхэлдэг мэргэжлийн байгууллагыг,

“Амьтны жам ёсны эрх” гэж амьтад идэш тэжээлээ олох, амьдрах идээшил, тархац нутгаа сонгох, үржил хөөцөнд орж, үр төлөө үлдээх, бүл сүрэгтэй дасан ижилсэх, айдас цочрол, хомроглон устгагдахаас ангид байхыг,

“Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ” гэж тухайн зүйл амьтны амьдрах орчин болон экологийн, эдийн засгийн, эрх зүйн, нийгмийн ач холбогдлоор нь үнэлсэн тусгай аргачлалын дагуу тооцсон амьтны мөнгөн үнэлгээг тус тус ойлгоно.

3.4.2. Зөрчлийн ойлголт, шинж ба төсөөтэй гэмт хэргээс ялгагдах шинж

Амьтны тухай хууль зөрчих зөрчлийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.37-д заасан байгаль орчны хяналтын улсын байцаагч дангаараа зөрчлийг шалган шийдвэрлэнэ. Харин тус зүйлийн 9 дэх хэсгийн зөрчлийг байгаль орчны хяналтын улсын байцаагчаас гадна, цагдаагийн байгууллагын эрх бүхий албан хаагч, мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч, эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч нар шалгаж шийдвэрлэх эрхтэй.

Зөрчлийн холбогдогч. Уг зөрчлийн холбогдогч нь хугацаа дууссан гэрээ, зөвшөөрлөөр эсхүл гэрээ, зөвшөөрөлгүйгээр амьтныг ашигласан, барьсан, агнасан зөрчил үйлдсэн, зөрчил үйлдэх үедээ арван зургаан насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай Монгол Улсын иргэн, гадаадын улсын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд байна.


Зөрчлийн хөвн хэлэлцэх хугацаа. Зөрчил үйлдсэнээс хойш зургаан сар өнгөрсөн бол зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахгүй болно.

Зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлого. Зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлого гэж зөрчил үйлдэн олж авсан мөнгө, эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, тэдгээрийг арилжаалж бий болгосон бусад эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, тэдгээрийг түрээслэх, ашиглах замаар олсон бүх төрлийн орлогыг ойлгоно.

Зөрчил үйлдэхдээ ашигласан зэвсэг, хэрэгсэл, эд зүйл, тээврийн хэрэгсэл, уналга, зөрчилтэй бараа, бүтээгдэхүүн, эд зүйлийг хураана. Зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл нь зөрчил үйлдсэн хүний амьжиргааны эх үүсвэр болсон эд зүйл, хэрэгсэл бол тэдгээрийг хураахгүй.

Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлд зааснаар Амьтны тухай хууль зөрчих зөрчил нь 9 хэсгээс бүрдэх бөгөөд хэсэг тус бүр өөр өөрийн онцлог шинжтэй юм. Иймд хэсэг тус бүрийг тусгайлан авч үзэх болно.

Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчлийн онцлог нь тусгай зөвшөөрөл, гэрээгүйгээр амьтныг агнасан, барьсан, ашигласан үйлдэл хамаарна. Тийм учраас тусгай зөвшөөрлийн тухай ойлголтыг нягтлан үзэх шаардлагатай.



Хугацаа дууссан гэрээ, зөвшөөрөл гэж зөвшөөрөл гэрээгээр тогтоосон хүчинтэй байх хугацаа нь дууссан байхыг ойлгоно.


Амьтныг агнах, барих хугацааг эрхийн бичиг, тусгай зөвшөөрөл гэрээнд тодорхой тусгасан байдаг. Тухайлбал, Амьтны тухай хуульд зааснаар Монгол Улсын иргэнд ахуйн зориулалтаар шувуу, тарвага агнаж, загас барихад гурав хүртэл хоног, бусад агнуурын амьтан агнах, барихад тав хүртэл хоногийн хугацаагаар нэг удаагийн эрхийн бичгийг олгоно.

Гэрээ, зөвшөөрөлгүй гэж Амьтны тухай хуульд зааснаар иргэн ахуйн зориулалтаар агнуурын амьтан агнах, барихад эрхийн бичиг, иргэн, хуулийн этгээд тусгай зориулалтаар агнуурын амьтан агнах, барихад тусгай зөвшөөрөл аваагүй, үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнах, барихад гэрээ байгуулаагүй байхыг ойлгоно.


Ашигласан гэж зохих зөвшөөрлийн хугацаа дууссан, гэрээ зөвшөөрөлгүйгээр аливаа зорилгоор ашиглаж буй үйлдлийг ойлгоно. Хуульд зааснаар иргэн, хуулийн этгээд нэн ховроос бусад амьтныг эрдэм шинжилгээний ажил, соёл урлаг, гоо зүйн зориулалт, хөрс бүрдүүлэх, байгалийг ариутгах, ургамалд тоос хүртээх зэрэг амьдралын үйл ажиллагааны хэрэгтэй чанарыг ашиглах, амьдралын үйл ажиллагааны бүтээгдэхүүнийг авах зэрэг зорилгоор тодорхой нөхцөл, болзол бүхий гэрээ, зөвшөөрлийн үндсэн дээр ашиглаж болдог.

Амьтныг ашиглах зорилгоор агнаж, барьж болох бөгөөд гагцхүү төрийн захиргааны төв байгууллагаас олгосон зохих зөвшөөрөл авсан байх ёстой.

Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан зөрчлийн онцлог нь тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлсэн үйлдэл байна. Амьтныг ашиглах, барих, агнах зөвшөөрлийг бусдад шилжүүлсэн гэдэг нь хууль, журмаар өөрт олгогдсон эрхийн бичиг, гэрээг бусдад ашиглуулахаар шилжүүлж байгаа үйлдлийг ойлгоно.



Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан зөрчлийн онцлог нь гэрээ, тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийг бусдад шилжүүлсэн, гэрээнд зааснаас хэтрүүлсэн эсвэл зохих гэрээг байгуулахгүйгээр үйлдвэрлэлийн зориулалтаар ан агнасан, барьсан үйлдэл хамраах бөгөөд энэ хуулийн 7.6 дугаар зүйлийн 2 дахь хэсгээс ялгагдах шинж нь зөвхөн ан агнах, загас барих, гэрээ, тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийг бусдад шилжүүлсэн үйлдэл хамаарна.



Амьтны тухай хуулийн 25.1-д иргэн ахуйн зориулалтаар агнуурын амьтан агнах, барихад **эрхийн бичиг**, иргэн, хуулийн этгээд тусгай болон үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнах, барихад **тусгай зөвшөөрөл** авч, **гэрээ** байгуулна хэмээн заасан байдаг. Хуульд зааснаар эрхийн бичиг, тусгай зөвшөөрөл, гэрээ гэсэн тус тусдаа ойлголтууд байна. Тэдгээрийг ялгаж салгаж мэддэг байх шаардлагатай. Агнуурын амьтан агнах, барих гэрээ, эрхийн бичиг, тусгай зөвшөөрлийн загварыг төрийн захиргааны төв байгууллага батална[16].

16 Амьтны тухай хуулийн 25.2-т заасан

Мөн өөр нэг анхаарах зүйл бол “ан амьтан агнах эрхийн бичиг, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэх, түүнчлэн зөвшөөрөлгүй ан амьтан агнасан этгээдэд нөхөн төлбөр ногдуулна”[17] гэдгийг анхаарах нь чухал.

Ан агнах, загас барих гэрээ, тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийг бусдад шилжүүлсэн гэж Амьтны тухай хуулиар ан агнах, барих тусгай зөвшөөрөл, гэрээ, эрхийн бичгийг бусдад эзэмшүүлж, ашиглуулахаар шилжүүлж буй үйлдлийг ойлгоно.

Энэ үйлдэл нь Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан “амьтныг ашиглах, барих, агнах зөвшөөрлийг бусдад шилжүүлсэн” үйлдлээс ялгагдах шинж нь “амьтныг ашиглах” зөвшөөрлөөс бусад тусгай зөвшөөрөл, гэрээ, эрхийн бичгийг шилжүүлж байгаа үйлдэл болон зөрчил гаргасан хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож шийтгэлийн хэмжээг чангаруулж байгаа санкцаараа тус тус ялгагдана. Иймд амьтныг ашиглахад олгох зөвшөөрлийг бусдад шилжүүлэх болон ан агнах, загас барих гэрээ, тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийг бусдад шилжүүлэх ялгааг сайтар ойлгож мэдэх хэрэгтэй.

Гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ан агнасан, барьсан гэдэг нь үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнах, барих гэрээнд заасан агнах, барих агнуурын амьтны нэр, тоо хэмжээг хэтрүүлэн агнаж, барьж байгаа хууль бус үйлдэл юм.


Төрийн захиргааны төв байгууллага жил бүр үйлдвэрлэлийн зориулалтаар агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг тухайн нутаг дэвсгэрийн агнуурын амьтны нөөц, хэрэгцээг харгалзан аймаг, нийслэл тус бүрээр тогтоодог. Ан амьтан агнах гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн агнасан, барьсан этгээдэд нөхөн төлбөр ногдуулна.

Зохих гэрээ байгуулахгүйгээр үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнасан, барьсан гэдэг нь хууль, журамд заасны дагуу гэрээ, хэлцэл хийхгүйгээр үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнаж, барьж байгаа идэвхтэй үйлдэл, үйл ажиллагаа юм.

Орон нутгийн буюу сумын Засаг дарга тухайн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр, агнуурын амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх санхүүгийн чадавх, мэргэжлийн боловсон хүчин, ан хийх анчидтай байх зэрэг шалгуурыг үндэслэн хуулийн этгээдтэй үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнах, барих гэрээ байгуулдаг.

Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан зөрчлийн онцлог нь агнуурын бүс нутгаас бусад газарт, эсхүл амьтныг агнах хориотой үед, эсхүл хориглосон хугацаанд, эсхүл хориглосон арга хэрэгслээр амьтныг барьсан, агнасан, тээвэрлэсэн зөрчил байна.

17 Амьтны тухай хуулийн 37.1-д заасан



Агнуурын бүс нутгаас бусад газарт гэдэг нь агнуурын нөөцийг тогтвортой ашиглах, хамгаалах зориулалт бүхий амьтны байршил, тархац нутгаас өөр газарт амьтан агнах, барих үйлдэл юм. *Агнуурын бүс нутаг* гэдэг нь агнуурын нөөц арвинтай газрыг судалгаа, шинжилгээний үндсэн дээр тогтоож, зөвхөн тухайн газарт ан агнуулах, харин агнуурын амьтны нөөц багатай бусад газарт ан хийлгэхгүй байх зорилго агуулсан амьтныг хамгаалах нэг хэлбэр юм.

Амьтныг агнах хориотой үед гэдэг нь хуулиар агнах, барихыг хориглоогүй ч тухайн амьтны тархац, нөөц, хэвийн өсөлт үржил, амьдрах орчин, нөхцөл хомсдох, муудан доройтох, ган зуд болсны улмаас төрийн захиргааны төв байгууллагаас тодорхой хугацаанд зарим зүйл амьтныг агнах, барихыг хориглосон шийдвэр гаргасан үе юм. Амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, зохистой ашиглах талаар Засгийн газар Амьтны тухай хуульд заасны дагуу сургийн бүтцийн төлөв байдал, тархац, нөөцийг харгалзан тухайн агнуурын бүс нутагт ан хийх, эсхүл зарим зүйл агнуурын амьтныг агнах, барихыг тодорхой хугацаагаар хориглох шийдвэрийг гаргах эрхийг хэрэгжүүлдэг.


Хориглосон хугацаанд гэдэг нь Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан хугацааг ойлгоно. Агнуурын амьтны өсөж үржих, ороо хөөцөлдөөнд орох, үр зулзагаа төрүүлж, өсгөж бойжуулах зэрэг биологийн онцлог хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглодог. Тухайлбал, Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлд (9.1.1) бор гөрөөс, цагаан зээр, зэрлэг гахайг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний өдрөөс дараа оны 8 дугаар сарын 31-ний өдөр хүртэл, (9.1.2) ойн булга, хадны суусар, элбэнх, шилүүс, нохой зээх, шар үнэг, хярс үнэг, бараан хэрэм, ойн солонго, усны булга, өмхий хүрэн, мануул мий, хотны үен, цагаан үен, чандага туулай, бор туулайг жил бүрийн 2 дугаар сарын 11-ний өдрөөс 11 дүгээр сарын 20-ны өдөр хүртэл, (9.1.3) урт сүүлт зурам, тарвагыг жил бүрийн 10 дугаар сарын 16-ны өдрөөс дараа оны 8 дугаар сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар тус тус агнах, барихыг хориглосон байна.

Хориглосон арга, хэрэгслээр амьтныг барьсан, агнасан гэдэг нь Амьтны тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан хориглосон арга, зэвсэг хэрэгслээр агнаж, барьж буй үйлдлийг ойлгоно.

Хориглосон арга, зэвсэг хэрэгсэлд химийн болон тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглах, агнуурын амьтны жим дээр нүх ухах, буу сойх, занга, сааль тавих, туурайтан амьтныг агнахад цасанд умбуулах, мөсөнд халтиргах, хясаа, эрэг, ганга руу нисгэх, хавх тавих, тарвагыг нүхэнд нь утах, ус цутгах, хавх, урхи тавих, нохойгоор зориудаар бариулах, агнуурын амьтныг агаарын болон авто тээврийн хэрэгслээр хөөх, гэрэлтүүлэх, загас барихад буу, бамбар, цахилгаан гүйдэл, хаалт, хашлага, гувчуур хэрэглэх, ахуйн хэрэгцээнд загас барихад тор хэрэглэх, ан агнах зориулалтын бус буу, сум ашиглах, гол, мөрөнд бүх төрлийн завиар загасчлах зэргээр амьтан агнах, барихыг хориглосон байна.

Тээвэрлэсэн гэдэг нь нэг цэгээс нөгөө цэгт тээврийн хэрэгсэл ашиглан зөөж тээвэрлэж буй үйлдлийг ойлгох бөгөөд тээврийн хэрэгсэлд автомашинаас гадна, төмөр зам, нисэх онгоц, ердийн хөсөг ч хамаарна.

Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан зөрчлийн онцлог нь агнуурын амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийн зүйлийг тусгай зөвшөөрөл, гарал үүслийн бичиг, дагалдах тодорхойлолтгүйгээр худалдсан, худалдан авсан үйлдэл байна.



Тусгай зөвшөөрөл гэдэг нь иргэн, хуулийн этгээд тусгай зориулалтаар агнуурын амьтан агнах, барих тохиолдолд олгож буй баримтыг ойлгоно. Тусгай зөвшөөрлийг зөвхөн тусгай зориулалтаар буюу агнуурын амьтныг эрдэм шинжилгээ, соёл урлаг, эмчилгээ, тодорхой нутаг дэвсгэрт агнуурын амьтны сүргийн бүтцийг зохицуулах, халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх зорилгоор болон иргэн спорт агнуур юм уу олзворын ангийн чиглэлээр агнуурын амьтан агнах, барихад олгодог. Тусгай зөвшөөрлийн загварыг төрийн захиргааны төв байгууллага батлан гаргана.

Гарал үүслийн бичиг гэдэг нь ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг нийслэл, өөр аймаг, сум тэдгээрийн хооронд тээвэрлэх, худалдахад зохих журмын дагуу агнасан болохыг гэрчилсэн баримт юм. Амьтны тухай хуульд ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг худалдах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тухайн сум дахь байгаль хамгаалагч гарал үүслийн тодорхойлолт олгож, харин төрийн захиргааны төв байгууллагаас тодорхойлолтын загвар, түүнийг олговол зохих ан амьтан, тэдгээрийн түүхий эдийн жагсаалтыг батлахаар тус тус заасан байна.


Дагалдах тодорхойлолтгүйгээр худалдсан, худалдан авсан гэдэг нь зохих журмын дагуу буюу хууль ёсоор агнасан ан амьтны гаралтай түүхий эдийг хууль бусаар агнасан амьтны

түүхий эдээс ялгах, худалдааг хяналттай байлгах зорилгоор амьтны түүхий эдэд дагалдах тодорхойлолтыг олгох бөгөөд түүнгүйгээр худалдаалж буй үйлдлийг ойлгоно.

Амьтны тухай хуулийн 12 дугаар зүйлд тодорхойлолт аваагүй амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг худалдах, худалдан авахыг хориглоно гэж заасан байдаг. Ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг худалдах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тухайн сум дахь байгаль хамгаалагч гарал үүслийн тодорхойлолт олгоно. Тодорхойлолтыг тухайн жилд Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас баталсан ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар агнах агнуурын амьтны нэр, тоо хэмжээний жагсаалтад орсон амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдэд ан агнах эрхийн бичиг, гэрээг үндэслэн олгоно.

Дээрх зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулна. Тодорхойлолт аваагүй амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг цуглуулсан, худалдсан, худалдан авсан этгээдийг тухайн зүйл амьтныг агнасан, барьсантай адилтган үзэж, нөхөн төлбөр ногдуулна.

Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасан зөрчлийн онцлог нь амьтныг зөвшөөрөлгүйгээр нутагшуулсан үйлдэл байна.




Амьтныг зөвшөөрөлгүйгээр нутагшуулсан гэдэгт зохих зөвшөөрөлгүйгээр амьтныг нутагшуулж буй үйлдэл, үйл ажиллагаа юм.

Аливаа амьтныг мэргэжлийн байгууллагын дүгнэлт, судалгаа шинжилгээний үндсэн дээр тухайн газар нутагт нутагшуулах ажлыг зохион байгуулна. Судалгаа шинжилгээ, зөвшөөрөлгүйгээр амьтныг нутагшуулснаар байгалийн тэнцэл алдагдах, халдварт өвчин гарч мал, гэрийн тэжээвэр амьтанд өвчин халдварлах, улмаар хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлөх, иргэн, хуулийн этгээдэд ямар нэгэн хохирол учирч болзошгүй учраас заавал мэргэжлийн байгууллагын санал, дүгнэлтэд тулгуурлан зохих зөвшөөрлийг олгодог.

Амьтны тухай хуульд сэргээн нутагшуулах гэсэн заалт бий. Энэ нь амьтныг хамгаалах, өсгөх үржүүлэх зорилгоор устах аюулд орсон, ховордсон амьтны зүйлийг урьд амьдарч байсан нутагт нь зориудаар зөөвөрлөн нутагшуулах үйл ажиллагаа хэмээн хуулийн нэр томьёонд тодорхойлж хуульчилсан байдаг.


Амьтныг сэргээн нутагшуулахад ч гэсэн шинжлэх ухааны байгууллагын гаргасан дүгнэлтийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон зөвшөөрөл, баталсан аргачлалын дагуу мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ.

Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасан зөрчлийн онцлог нь харь амьтныг зөвшөөрөлгүйгээр нутагшуулсан, өсгөж үржүүлсэн хууль бус үйлдэл байна.



Харь амьтныг зөвшөөрөлгүйгээр нутагшуулсан, өсгөж үржүүлсэн. Харь амьтан гэж улсын хилийн гаднаас зориудаар болон санамсаргүй байдлаар зөөвөрлөгдөн ирж, нутагшиж байгаа амьтны зүйлийг ойлгоно. Харь амьтныг төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр нутагшуулах, өсгөж үржүүлэхийг хориглодог. Харь амьтныг өөрийн улсад оруулж ирэх бол зохих зөвшөөрлийг авсан байх ёстой. Харь амьтныг ашиглах журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасан зөрчлийн онцлог нь агнуурын амьтнаас бусад амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг гарал үүслийн тодорхойлолтгүйгээр худалдсан, худалдан авсан үйлдэл байна.



Энэ зүйлийн 5 дахь хэсэгт зааснаас бусад амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг гарал үүслийн тодорхойлолтгүйгээр худалдсан, худалдан авсан гэдэгт Зөрчлийн хуулийн 7.6 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан агнуурын амьтнаас бусад амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийн зүйлийг түүхий эдийг гарал үүслийн тодорхойлолтгүйгээр худалдсан, худалдан авсан үйлдлийг тодорхойлсон байна.

Манай улсын нутагт дэвсгэрт байгалийн жамаараа оршин байдаг, унаган, нүүдлийн амьтдыг агнуурын болон агнуурын бус амьтад гэж хуваан үздэг. Агнуурын амьтан гэдэг нь арьс, үс, мах болон бусад түүхий эдийг нь ашиглахаар агнаж ирсэн уламжлалтай, агнуурын нөөцтэй амьтныг ойлгоно. Сүүлийн жилүүдэд агнуурын бус, агнаж барьж ирсэн уламжлалгүй амьтдыг агнах, барих үйлдэл нэмэгдэх болсон. Иймд агнуурын бус амьтдыг хууль бусаар агнах, барих тэдгээрийн түүхий эдийг зөвшөөрөлгүйгээр худалдаалах үйлдлийг эрх зүйгээр хамгаалж байгаагийн илрэл юм.

Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт заасан зөрчлийн онцлог нь амьтны хүрээлэн ажиллуулахад тавигдах шаардлагыг зөрчсөн үйлдэл байна. Тухайлбал, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 17 дугаар тогтоолоор "Амьтны хүрээлэн ажиллуулах журам" батлагдсан байна[18]. Дээр дурдсанчлан энэ зүйлийн 9 дэх хэсгийн зөрчлийг байгаль орчны хяналтын улсын байцаагчаас гадна, цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч, мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч, эрүүл ахуй, халдвар хамгаалллын хяналтын улсын байцаагч нар шалгаж шийдвэрлэх эрхтэй.

Зөрчлийн төсөөтэй гэмт хэргээс ялгагдах шинж. Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлд заасан Амьтны тухай хууль зөрчих зөрчил нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.5 дугаар зүйлийн Хууль бусаар ан агнах гэмт хэрэгтэй төсөөтэй тул тэдгээрийг харьцуулан үзэж, ялгагдах шинжийг доорх хүснэгтээр харуулав.

Хүснэгт 3.4. *Амьтны тухай хууль зөрчих зөрчлийн төсөөтэй гэмт хэргээс ялгагдах шинж*

Ялгагдах шинж	Хууль бусаар ан агнах (Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.5 дугаар зүйл)	Амьтны тухай хууль зөрчих (Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйл)
Объект	Мал, гэрийн тэжээвэр амьтнаас бусад байгальд зэрлэгээр амьдардаг аливаа амьтныг хамгаалах, үржүүлэх, ашиглах болон олон улсын гэрээ, конвенциор хамгаалсан хууль бусаар худалдаалахыг хориглосон харилцаа байна. Энэ хэргийн обьектын өөр нэг онцгой шинжид тусгай хамгаалалтын газар нутгийн тухай ойлголт мөн хамаарна. Тусгай хамгаалалттай газар нутагт орших элбэг тархацтай, ховор болон нэн ховор амьтныг зохих зөвшөөрөлгүйгээр агнаж, барихыг хориглодог.	Амьтныг хамгаалахтай холбоотой харилцаа байна.
Объектив тал	Улсын тусгай хамгаалалттай газар нутагт зөвшөөрөлгүйгээр амьтан агнасан, барьсан, нэн ховор, ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүйгээр агнасан, барьсан, зориудаар тэжээж гаршуулсан, үржүүлсэн, түүхий эдийн зүйлийг хадгалсан, худалдсан, худалдан авсан, тээвэрлэсэн, гадаад улсад гаргасан, амьтны чихмэл, түүхий эдийн цуглуулга, амьдрах орчныг алдагдуулсан, түүхий эдийг бэлтгэсэн үйлдэл байна.	Гэрээ зөвшөөрлийн хугацаа дууссан, гэрээ зөвшөөрөлгүйгээр амьтныг ашигласан, барьсан, агнасан, зөвшөөрлийг бусдад шилжүүлсэн, амьтны хуулиар хориглосон үед хориглосон арга хэрэгслээр амьтныг барьсан, агнасан, тээвэрлэсэн, агнуурын болон бусад амьтны түүхий эдийг тусгай зөвшөөрөл, гарал үүслийн бичиг, дагалдах тодорхойлолтгүйгээр худалдсан, худалдан авсан, амьтныг болон харь амтныг зөвшөөрөлгүйгээр нутагшуулсан, Амьтны хүрээлэн ажиллуулахад тавигдах шаардлагыг зөрчсөн идэвхтэй үйлдэл байна.

18 https://legalinfo.mn/mn/detail?lawId=17089369149571

Ялгагдах шинж	Хууль бусаар ан агнах (Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.5 дугаар зүйл)	Амьтны тухай хууль зөрчих (Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйл)
Субьект	Эрүүгийн хуульд заасан 16 насанд хүрсэн хэрэг хариуцах чадвартай Монгол Улсын харьяат болон гадаадын харьяат, аль ч улсын харьяат бус хүн, хуулийн этгээд байна.	Зөрчлийн тухай хуулийн 3.2-т заасан хэрэг хариуцах чадвартай хувь хүн, хуулийн этгээд байна.
Субьектив тал	Гэм буруугийн санаатай хэлбэр байна.	Гэм буруугийн санаатай хэлбэр байна.

3.4.3. Зөрчлийн зүйлчлэл

Энэ төрлийн зөрчлийг шалгах эрх бүхий албан тушаалтан, байгаль орчны хяналтын улсын байцаагч нар дээр дурдсан зөрчлийн шинжийн аль нэгийг зөрчсөн этгээдийн үйлдэл эс үйлдэхүйг Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлд заасан Амьтны тухай хууль зөрчих зөрчлийн холбогдох заалтаар зүйлчилж, Зөрчлийн тухай хуульд заасан шийтгэл оногдуулна.

Мөн хууль бусаар олсон хөрөнгө, учирсан хохирол, зөрчил үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, галт зэвсэг, загасны уурга хэрэгслийг буцаан өгөх эсвэл хураах эсэх шийдвэрийн аль нэгийг гаргана. Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд хохирол нөхөн төлбөр, торгуулийн орлогыг заасан хугацаанд төлөөгүй бол албадан гүйцэтгүүлэхээр шүүхэд журмын дагуу хандаж нэхэмжлэл гаргана.

3.4.4. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа ба анхаарах асуудал

Амьтантай холбоотой зөрчлийг шуурхай, бодиттой, хууль зүйн дагуу шалгаж, шийдвэрлэх нь эрх бүхий албан тушаалтны үндсэн үүрэг юм. Зөрчлийг шалгах эрх бүхий албан тушаалтан хуульд заасан журмын дагуу зөрчил үйлдэгдсэн газар, хүн, хуулийн этгээдийн тээврийн хэрэгсэл, эд зүйлд үзлэг хийх, баримт бичиг, мэдээлэл гаргуулан авах, эд зүйл, баримт бичгийг хураан авах, эд хөрөнгийг битүүмжлэх, мэдүүлэг авах, шинжилгээнд зориулж хэв загвар, дээж авах, шинжилгээ хийлгэх зэрэг ажиллагааг явуулна.

Байгаль орчны хяналтын эрх бүхий албан тушаалтны зөрчил илрүүлэх, шалгах хууль зүйн үндэслэл, эрх хэмжээ, чиг үүрэг нь Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиас гадна, Төрийн хяналт шалгалтын тухай хуулиар зохицуулагдана. Төрийн хяналт шалгалтын тухай хуульд зааснаар хяналт шалгалтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага хуульд заасан үндэслэл, журмын дагуу хяналт шалгалтыг хийх бөгөөд хяналт шалгалтыг төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн гэж ангилан явуулна.

Хяналт, шалгалт нь иргэн, хуулийн этгээдийн явуулж байгаа аливаа үйл ажиллагаа хуульд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг дүгнэхэд чиглэсэн, хянан шалгалтын арга хэмжээний цогцолбор байна.

Байгаль хамгаалах чиглэлийн хууль тогтоомж, ялангуяа Амьтны тухай хууль хэрхэн хэрэгжиж байгаад хяналт тавих нь өөрийн өвөрмөц онцлогтой байдаг. Учир нь энэ хуулийн хэрэгжилт хэрхэн хангагдаж байгаа байдал, үйлдэгдэж буй зөрчил нь бусдын нүдэн дээр тэр бүр ил үйлдэгдээд байдаггүй, далд байдаг учраас хяналт шалгалтыг төлөвлөгөөтэйгөөр тогтмол эсвэл цаг хугацааны хувьд гэнэтийн буюу төлөвлөгөөт бус гэсэн хэлбэрээр явуулна.

Мөн амьтныг агнах, барихыг хориглосон цаг хугацаа, зөрчил ихээр үйлдэгдэж болзошгүй газар оронд Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан хяналт шалгалтын арга хэлбэрээр, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан зөрчлийг шалгах эрх бүхий албан тушаалтан өөрийн хяналт шалгалтаар зөрчлийг илрүүлж, эсвэл гомдол мэдээллийн дагуу тухайн зөрчлийг шалган шийдвэрлэж болно. Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу явуулна.

Тохиолдол 1

Хяналтын байгууллагаас Амьтны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутагт 2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдрөөс 5 дугаар сарын 03-ны өдрийн хооронд хяналт шалгалтыг явуулжээ.

Тус хяналт шалгалтаар Мөнгөнморьт сумын нутаг дэвсгэрт хамаарах Хэрлэн гол дагуу Цагаан чулуут нэртэй газарт 2019 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр “Ниссан патроль” маркийн хар өнгийн 12-34 УАА улсын дугаартай, тээврийн хэрэгсэлтэй гурван хүн отоглон буудаллаж байх үед хяналтын шалгалтын багийнхан таарчээ.

Байгаль орчны хяналтын улсын байцаагч Б нь тэдгээр хүмүүстэй уулзаж ямар зорилгоор, хаанаас хаа хүртэл аялж байгаа талаар асууж ярилцахад Улаанбаатар хотоос найз дээрээ хэд хоног амрахаар явж байна. Голын дэргэд түр саатаж алжаалаа тайлж байна гэж хариулсан бөгөөд тэд бүгд усны гутал өмссөн, хоёр хүний усны гутал нойтон, тээврийн хэрэгслийн арын тэвшний нөөц дугуйны дээд хэсэгт хүрэн улаан өнгийн толбо үүсэж, мөн машины дэргэд байгаа бор ногоон өнгийн цүнхний цахилгааны хагас татагдсан хэсгээр загасны уургын бариул цухуйж байв.

Байгаль орчны хяналтын улсын байцаагч Б нь та бүхэн загас барьж байгаа юм биш үү гэхэд нэг нь бид загас бариагүй ээ гэж хариулав. Байгаль орчны хяналтын улсын байцаагч Ц нь тэдгээр хүмүүс сэжигтэй байна гэж үзээд шалгалтын ажиллагааг явуулжээ.

Тайлбар. Байгаль орчны хяналтын улсын байцаагч Б нь дээрх үйлдэлд Амьтны тухай хууль зөрчих зөрчил үйлдэгдсэн байж болзошгүй сэжиг байгааг таамаглаж, шалгах ажиллагаа хийх шийдвэр гаргажээ. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн Хяналт шалгалт хийх нийтлэг үндэслэл, журмын 5.6 дахь хэсэгт заасны дагуу хяналт шалгалт эхлэхээс өмнө эрх бүхий албан тушаалтан шалгуулах этгээдэд шалгалтын зорилго, бүрэлдэхүүнийг танилцуулж удирдамж, хяналтын хуудасны нэг хувийг өгөх бөгөөд улсын байцаагч албаны үнэмлэхээ үзүүлнэ. Мөн хуулийн 3[1].1.2-д тодорхойлсон “хяналт шалгалтын арга, хэлбэр”-ийн нэг болох тухайн хяналт шалгалтад хамаарах баримт бичгийг хянан үзэх заалтын дагуу тэдгээр иргэдийн бичиг баримтыг үзүүлэхийг хүсэж, уг хүмүүсийн хэн болохыг тодорхойлох иргэний үнэмлэх болон бусад бичиг баримтыг үзэж шалгана.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.4 дүгээр зүйлийн 1 дэх эрх бүхий албан тушаалтан (1.1) хуулиар харьяалуулсан зөрчлийг өөрөө илрүүлсэн, (1.5) зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааг хуульд заасан үндэслэлээр, журмын дагуу явуулах эрх хэмжээний хүрээнд зөрчил шалгах ажиллагааг эхлүүлж явуулна.

Байгаль орчны хяналтын улсын байцаагч Б тээврийн хэрэгслийн арын тэвшний нөөц дугуйны дээд хэсэгт үүссэн хүрэн улаан өнгийн цус мэт толбо, загасны уургын үзүүр цүнхнээс цухуйж байгаа, тэдгээр хүмүүсийн зорчиж байгаа цаг хугацаа, усны гутал норсон байсан зэрэгт

дүгнэлт хийж, Амьтны тухай хууль зөрчих зөрчил үйлдэгдсэн байж болзошгүй гэж үзэж, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар зөрчил үйлдэгдсэн газар, тээврийн хэрэгсэл, эд зүйлд үзлэг хийх, эд зүйл, баримт бичгийг хураан авах, мэдүүлэг авах, шинжилгээнд зориулж хэв загвар, дээж авах зэрэг ажиллагааг хийнэ.

Үзлэг хийх. Эрх бүхий албан тушаалтан (Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.1 дүгээр зүйл) хуульд заасны дагуу зөрчил шалгах ажиллагаа явуулж, нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх, зөрчил үйлдэгдсэн газар, тээврийн хэрэгсэл болон эд зүйлд үзлэг хийх ажиллагааг явуулна. Үзлэг хийхдээ дараах зүйлсийг анхаарах нь зүйтэй. Үүнд:

- Хөндлөнгийн гэрчийг байлцуулах
- Гэрэл зураг, дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлэх техник хэрэгслийг бэлтгэх
- Үзлэг хийх явцад шаардлагатай бол шинжилгээнд зориулж хэв загвар, дээж авах
- Шаардлагатай бол эд хөрөнгө битүүмжлэх, эд зүйл, баримт бичиг хураан авах ажиллагааг хамтад нь явуулах
- Эрх бүхий албан тушаалтны шаардлагаар үзлэг хийлгэхээс татгалзах юм уу эсэргүүцэл үзүүлсэн тохиолдолд үзлэгийг албадан гүйцэтгэх
- Шинжилгээнд зориулан хэв загвар, дээж авсан бол түүнийг хадгалах, шилжүүлэх, устгах, тээвэрлэх талаар Засгийн газрын гаргасан журмыг баримтлах
- Шинжилгээнд зориулж хэв загвар, дээж авах ажиллагаанд мэргэжилтнийг оролцуулах зэргийг онцгойлон анхаарах шаардлагатай.

Зөрчил үйлдэгдсэн газарт үзлэг хийхэд нотолгооны ач холбогдолтой амьтны сэг зэм, яс, үс, толгой, шийр, арьс, эвэр туурай, мөн амьтны эд эрхтэн түүнээс гадна, сэжигтэн этгээдийн үлдээсэн ул мөр байж болох сумны хонгио, хутга, тамхины иш зэрэг зүйлс, хэрэг, зөрчил үйлдэхэд ашигласан зэвсэг хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, морь, тэмээ, тэдгээрийн ул мөр байгаа эсэхийг сайтар нягтлан илрүүлж, бэхжүүлэн авахад онцгой анхаарна. Үзлэгийг хөдөө хээр, хойшлуулшгүй тохиолдолд хийж байгаа бөгөөд хөндлөнгийн гэрч оролцуулах боломжгүй тул дүрс бичлэг, гэрэл зургаар бэхжүүлж, дараа нь прокурорт мэдэгдэнэ.

Загвар жишээ 1.
Зөрчил үйлдэгдсэн газарт хийсэн үзлэгийн тэмдэглэл

Үзлэгээр илэрсэн зүйл: Үзлэгийг 2019 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 15 цаг 00 минутад эхлүүлж, цэлмэг цаг агаартай, агаарын дулаан 10 хэм байх үед байгалийн гэрэлд явуулав.

Үзлэг явуулж буй газар нь хөдөө хээр, төв суурин газраас алслагдсан хөндлөнгийн гэрч оролцуулах боломжгүй байсан тул Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.3 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасны дагуу фото зургийн аппарат, Garmin 64s маркийн GPS байршил тогтоогч багаж, Phantom-4 маркийн нисдэг камер (дрон) ашиглан фото зураг авч, бичлэг хийн зөрчил шалгах ажиллагааны явцыг бэхжүүлэв.

Үзлэгээр илэрсэн нөхцөл байдал:
Зөрчлийн үзлэг хийж буй газар нь Төв аймгийн Мөнгөнморьт сумаас ертөнцийн зүгээр зүүн урд зүгт 45 км зайд Хэрлэн голын эрэг дагуу бөгөөд голын энэ орчмын зүүн талаар ой модтой уул, харин баруун талаар задгай хээр тал бүхий Цагаан чулуут нэртэй газар байлаа.

Үзлэг явуулж буй газрын орчин нь Хэрлэн голын булан тохой газар тул эргэн тойрон бургас, торлог бут, хад чулуутай хэвгий газар байх бөгөөд нэлэнхийдээ борог өвстэй, цасгүй, хуурай, голын урсац тогтнуун байв.

Зөрчил илрүүлсэн газарт голын зүүн эрэгт орших хадархаг газрыг үл хөдлөх цэг болгон авч орон зайн байршил тогтоогч Garmin 64s маркийн GPS багажаар тогтооход E46 57 36.51, N101 41 39.45 цэг солбицолд байв. Уг хадархаг газраас үзлэг явуулж буй газар 30 м зайтай байлаа. Уг газарт ертөнцийн зүгээр хойш чиглэлд зогссон “Ниссан патроль” маркийн хар өнгийн 12-34 УАА улсын дугаартай, зүүн гар талын жолооны хүрдтэй, тээврийн хэрэгсэл байна. Уг тээврийн хэрэгслийн баруун хойд дугуйны дэргэд 35х65 см хэмжээтэй бор ногоон өнгийн цүнх байна. Цүнхний амны цахилгаан хагас татагдсан, цүнхний амнаас загасны хар өнгийн уургын хойд хэсэг нь цухуйсан байв.

Тээврийн хэрэгслээс 7 м зайд гурван чулуу зэрэгцүүлэн тавьж, дунд нь хуурай мөчир жижиглэн гал түлэхээр бэлтгэсэн байв. Уг чулуунаас хойшоо чиглэлд 10 м зайтай газар бургасан дунд бор шаргал өнгийн, 4 м урттай загасны уурга 2 ш, түүний дэргэд 5 ш загас байв.

Барьсан загасыг хэмжиж үзэхэд, толгойноос сүүл хүртэлх урт 50 см, өргөн нь 14 см хэмжээтэй 2 загас, мөн 35 см урттай, өргөн нь 10 см 3 загас байна. Загасны өнгө дүрс нь ..... өнгө дүрс, амьтны морфологи шинжээр шинэхэн барьсан зэвэг загас байна.

Үзлэгийг тээврийн хэрэгсэлд үргэлжлүүлэн машины үйлдвэрийн тэмдэглэгээг шалгахад (машины урд копут дотор) NISSAN MOTORS CORPORATION MODEL LA-V73W LRHVQ SHASSIS V73W 0P0185 дугаартай байв. Машины гадна кузов хар өнгөтэй, төмөр цайвар өнгийн ачаатай, машины арын хаалганд нөөц дугуйтай, 12-34 УАА тээврийн хэрэгслийн улсын дугаартай, суудлын жип машин байна. Машины гадна хэсэг нэлэнхийдээ шавар, шороо болсон, гадна талын кузов ямар нэгэн механик эвдрэл, хонхойлт үүсээгүй, баруун урд дугуйны шаврын хаалт хугарч унжсан. Машины дөрвөн дугуйн хээ тод, гэрэлтүүлэх болон дохионы хэрэгсэл, шил арчигч бүрэн ажиллагаатай техникийн хувьд бүрэн бүтэн байна.

Машины арын хаалганы нөөц дугуйн дээр 5х7 см хэмжээтэй хүрэн улаан өнгийн цус мэт зүйлээр бохирлогдсон байв. Уг бохирлогдсон зүйлийг шинжлүүлэх зорилгоор бага зэрэг спирт шингээсэн хөвөнгөөр арчин дээж авч, цаасан дугтуйд хийж амсрын тэмдэг дарж битүүмжлэв.

Машины дотор талд үзлэгийг явуулж жолооч талын хаалгыг нээхэд машины түлхүүр асаалтын үүрэндээ байх бөгөөд түлхүүрийг түлхэн асаахад хэвийн ажиллагаатай асаж байв. Машины арын хаалгыг онгойлгож үзэхэд багажид бор ногоон өнгийн 3 ш аяны хөнжил, түүний доор ангийн зориулалттай Дробовинк буу 1 ш, бага калибрын Тоз-8 буу 1 ш, Чех калибрь ZKM-452 (дурантай 9 мм) 1 ш тус тус байв. Бууны дэргэд 17 мм дайзтай сум 10 ш, дробовинк бууны цаасан бортоготой сум 3 ш, 5.6х15 мм хэмжээтэй калибрын сум 1 хайрцаг буюу 24 ш байна. Эдгээр галт зэвсгийг эзэмших гэрчилгээ байгаа эсэхийг тээврийн хэрэгслийн жолооч Д-ээс тодруулахад бүгд байгаа гээд машины урд талын хайрцгаас 3 ш галт зэвсэг эзэмшигчийн гэрчилгээг гаргаж үзүүлэхэд Иргэн С овогтой Д гэрчилгээний дугаар 435, ОХУ-д үйлдвэрлэсэн Дробовинк буу №34556, иргэн С овогтой Д гэрчилгээний дугаар 743, ОХУ-д үйлдвэрлэсэн Тоз-8 калибр №44456, иргэн Г овогтой Ш, гэрчилгээний дугаар 956, Чех калибрь ZKM-452 №67778 дугаартай галт зэвсэг эзэмших гэрчилгээтэй. Гэрчилгээ дээрх дугаар үзлэгээр илэрсэн галт зэвсэг дээрх дугаартай тохирч байна. Галт зэвсгийн эзэмшигч нараар бууны сумны хүхээгт сум байгаа эсэх, аюулгүй байдлыг шалгуулахаар Чех калибрь ZKM-452 №67778 дугаартай галт зэвсгийн замгийг татахад сумны хүхээгт 1 ш сум байсныг авч аюулгүй болгосны дараа уг буугаар

буудлага үйлдэгдсэн эсэхийг шалгах зорилгоор бууны гол төмрийн хошууны амсрыг үнэртэж үзэхэд дарь үнэртэж байв. Нөгөө хоёр бууны гол төмрийн амсраас дарь үнэртэхгүй байв. Бууг буудлага үйлдэгдсэн эсэхийг тогтоох зорилгоор гол төмрийн амсрыг хөвөнгөөр бөглөж, хураан авлаа.

Мөн багажид 2 цаасан хайрцагтай зүйл байв. Нэг цаасан хайрцгийг нээж үзэхэд, хоол хүнсний зүйлс болох талх, лаазалсан мах, зөөврийн хийн тулга, 5 ш баллонтой хийн газ байна.

Нөгөө хайрцгийн тагийг нээж үзэхэд, хүрэн улаан өнгөтэй, цээж, бөгсөн бие болгон шинэхэн бэлтгэсэн амьтны мах (гадна шинж тэмдгээр ямар амьтны мах гэдэг нь танигдахгүй) байв. Махыг бэлтгэсэн байдал, цээж хэсэгтээ хүрэн улаан өнгийн цус хурж, нөжирсөн, уг хэсэгтээ хавирга хугарсан зэргээс үзэхэд буудаж агнасан байж болзошгүй шинж тэмдэг байна. Уг махны жинг үзэх зорилгоор гар жингээр жигнэж үзэхэд 25 кг болж байв.

Уг хайрцагт 0.5 гр цэнхэр өнгөтэй “Вояж” гэсэн шошготой усны хуванцар саванд хар хүрэн өнгийн шингэн зүйл дүүртэл нь хийсэн байв.

Энэ махыг ямар амьтны мах болох, савтай шингэнийг юуны шингэн болох талаар тээврийн хэрэгслийн жолооч Д-ээс асуухад ямааны мах байгаа юм, савтай шингэн нь яргуй идсэн ямааны цус байгаа гэж хариулав.

Машины баруун хойд дугуйны дэргэд байх 35х65 см хэмжээтэй бор ногоон өнгийн цүнхийг онгойлгож үзэхэд, хар өнгөтэй, 55 см урттай эвхсэн загасны уурга 1 ш, дамартай цагаан өнгийн сатурк 2 ш, жижиг төмөр хайрцагт загасны дэгээнүүд, 28 см урттай төмөр хутга, бор ногоон өнгийн гар чийдэн, 2 ш хуруу зай, 15 см радиустай дугуй хар өнгийн гэрэлтүүлэх хэрэгсэл, 2 м урт цахилгааны залгуур утастай байв.

Үзлэгийн явцыг “Canon EOS600D” маркийн дижитал тоон технологид суурилагдсан, өнгөт фото зургийн аппаратаар баримжаалсан 3, тоймчилсон 5, зангилаа болон нарийвчилсан 17, нийт 25 кадр гэрэл зураг авч, зөрчлийн газрын схем зураг үйлдэж, нисдэг камер (дрон) ашиглаж 5 минутын бичлэг хийж, бэхжүүлсэн болно.

Үзлэгийн явцад илрүүлсэн зүйл:

- Ангийн зориулалттай Дробовинк буу 1 ш
- Дага калибрын буу Тоз-8 буу 1 ш
- Чех калибр ZKM-452 (дурантай 9 мм) 1 ш
- 17 мм дайзтай сум 10 ш
- Дробовинк бууны цаасан бортоготой сум 3 ш
- 5.6х15 мм хэмжээтэй калибрын сум 1 хайрцаг буюу 24 ш
- Загасны уурга (хар өнгийн) 5 м урттай 1 ш
- Загасны уурга (бор шаргал өнгийн) 4 м урттай 2 ш, нийт 3 ш
- Цагаан өнгийн сатурк 2 ш
- Жижиг төмөр хайрцагт загасны дэгээнүүд
- Төмөр хутга 28 см урттай
- Гэрэлтүүлэх хэрэгсэл 15 см радиустай дугуй (хар өнгийн, 2 м урт цахилгааны залгуур утастай)
- Толгойноос сүүл хүртэл 50 см урттай, өргөн нь 14 см хэмжээтэй 2 загас

- Толгойноос сүүл хүртэл 35 см урттай, өргөн нь 10 см хэмжээтэй 3 загас, нийт 5 ш загас
- Цаасан хайрцагтай 25 кг амьтны мах
- “Вояж” гэсэн бичигтэй цэнхэр өнгийн 0.5 гр хуванцар савтай хар хүрэн өнгийн шингэнтэй зүйл
- Машины нөөц дугуй дээрх цус мэт хүрэн улаан өнгийн толбоноос хөвөнд шингээн авч цаасан дугтуйд хийж битүүмжлэн шинжилгээнд зориулж авсан дээж 1 ш зэргийг эд мөрийн баримтаар хураан авлаа.

Үзлэгийн тэмдэглэлийг “Toshiba” маркийн зөөврийн компьютер, “Samsung ML1670” маркийн принтер, автомашинаас цахилгаан өсгөгч багаж (инвертер) зэргийг ашиглан хэвлэв.

Үзлэгийн тэмдэглэлийг оролцогчдод уншуулж танилцуулахад, үзлэгийн явцтай холбогдуулж ямар нэгэн санал хүсэлт гаргаагүй тул үзлэгийг 18 цаг 30 минутад дуусгаж, оролцогчдоор гарын үсэг зуруулав.

Тэмдэглэл үйлдсэн: Байгаль орчны хяналтын улсын байцаагч ..... (Ц)

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэх. Байгаль орчны хяналтын улсын байцаагч Ц нь хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх явцад хуулиар шалган шийдвэрлэхээр харьяалуулсан зөрчлийн шинжтэй үйлдлийг илрүүлсэн тул прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулна.

Байгаль орчны хяналтын улсын байцаагч Ц нь ажлын 5 өдрийн дотор шалгаж, дараах шийдвэрийн аль нэгийг гаргах учиртай. Үүнд:

- Гомдол, мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлэх
- Гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзах
- Хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх
- Зөрчлийн хэрэг нээх зэрэг болно.

Харин байгаль орчны хяналтын улсын байцаагч Ц нь энэ тохиолдолд зөрчлийн хэрэг нээх шийдвэр гаргажээ. Дээрх тохиолдолд хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх боломжгүй, учир нь холбогдогч нар загас барьсан ил үйлдэл байгаа ч зөвшөөрлийн бичигтэй гэж загас барих эрхийн бичиг үзүүлсэн, авч яваа мах, эд зүйлээ ямааны мах, цус гэж тайлбарлаж, зөрчил үйлдсэнээ сайн дурааараа хүлээн зөвшөөрөөгүй, учруулсан хохирлыг шууд тогтоох боломжгүй тул зөрчлийн хэрэг нээж, нотлох ажиллагааг хийхээр зөрчлийн хэрэг бүртгэлт явуулна.

Мэдүүлэг авах ажиллагаа. Үзлэгийг явуулж дууссаны дараа эрх бүхий албан тушаалтан буюу байгаль орчны хяналтын улсын байцаагч Ц нь зөрчил үйлдсэн байж болзошгүй тэдгээр гурван иргэнээс Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар зөрчил гарсан байдлыг тодруулах, зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдол бүхий баримт, мэдээллийг олох зорилгоор мэдүүлэг авна. Мэдүүлэг авах ажиллагааг хийхдээ дараах зүйлсийг анхаарах шаардлагатай. Үүнд:

- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 3.1 дүгээр зүйлийн 2.1 дэх хэсэгт заасны дагуу ямар зөрчилд холбогдон шалгагдаж байгааг холбогдогчид мэдэгдэж, энэ зүйлийн 2.2 дахь хэсэгт дурдсан өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах эрхтэйг тайлбарлаж өгөх

- Холбогдогчоос мэдүүлэг авахын өмнө түүнд үнэн зөв мэдүүлэг өгөхийн ач холбогдлыг тайлбарлаж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаатай холбоотой нууцыг хадгалах талаар мэдэгдэх
- Эрх бүхий албан тушаалтан хүнийг албадан ирүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг (эх), үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах эрхгүй
- Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар, эсхүл хүний нэр төрийг гутаан доромжлон харьцаж мэдүүлэг авахыг хориглоно
- Доор дурдсанаас бусад тохиолдолд мэдүүлгийг шөнийн цагаар авахыг хориглоно:
  - Шөнийн цагаар явагдаж байгаа үйлдвэрлэл, ажил, үйлчилгээний газарт гарсан зөрчлийг газар дээр нь шийдвэрлэх бол
  - Олон нийтийн аюулгүй байдал, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд аюул учирч болох нөхцөл байдал үүссэн, эсхүл үүсэж болзошгүй бол
  - Зөрчлийн ул мөр устах, холбогдогч оргон зайлж болзошгүй
  - Гудамж, талбай, олон нийтийн газарт шөнийн цагаар үйлдэгдсэн зөрчлийг хялбаршуулсан журмаар газар дээр нь шалган шийдвэрлэх бол.
- Мэдүүлэг авах ажиллагааг 3 цагаас илүү хугацаагаар явуулах бол 30 минутын завсарлага авна. Нэг удаагийн мэдүүлэг авах ажиллагаа нийт 6 цагаас хэтэрч болохгүйг анхаарна.

Мэдүүлэг авах процесс ажиллагаа:

- Тухайн хүн хүсвэл мэдүүлгийг бичгээр авч болно.
- Эрх бүхий албан тушаалтан мэдүүлгийг асуулт асууж, хариулт авах хэлбэрээр явуулна.
- Мэдүүлэг өгч байгаа хүн тоо болон санахад төвөгтэй бусад зүйлийн талаар мэдүүлэг өгөх бол эрх бүхий албан тушаалтны зөвшөөрснөөр баримт бичиг, бичлэг ашиглаж болно. Ашигласан баримт бичиг, бичлэгийн тухай тэмдэглэлд тусгаж, боломжтой бол мэдүүлгийн тэмдэглэлд хавсаргана.
- Мэдүүлэг өгч байгаа хүнд эд мөрийн баримтыг үзүүлэх, тухайн зөрчлийн талаар бусад хүнээс өгсөн мэдүүлгийг танилцуулж, энэ талаар мэдүүлэг авч болно.
- Мэдүүлэг авч дуусмагц тэмдэглэлийг мэдүүлэг өгч байгаа хүнд танилцуулж, нэмэлт оруулах, засвар хийх боломж олгоно.
- Мэдүүлэг өгөхөөс татгалзсан бол энэ тухай тэмдэглэлд тусгана.
- Эрх бүхий албан тушаалтан мэдүүлгийг тэмдэглэлээр бэхжүүлж, мэдүүлэг өгсөн хүн гарын үсэг зурж баталгаажуулна.
- Мэдүүлэг өгч байгаа хүнд мэдэгдэн дуу, дүрс болон дуу-дүрсний бичлэг хийж болно.
- Мэдүүлгийг тухайн хүнийг эрх бүхий байгууллагад ирүүлэн, эсхүл тухайн хүний байгаа газарт авч болно.
- Мэдүүлэг авахдаа тухай хүний зан байдал, хариулт зэрэгт тохируулан асуух асуултаа боловсруулж, оновчтой тавихад анхаарах нь тун чухал юм.

Загвар жишээ 2.
Мэдүүлэг авах ажиллагаа

Асуулт: Таныг Амьтны тухай хууль зөрчих зөрчил үйлдсэн гэж үзэж шалгах гэж байна. Та өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах эрхтэй тул мэдүүлэг авах ажиллагаанд өмгөөлөгч оролцуулах уу?

Хариулт: За би Зөрчлийн тухай хуульд заасан Амьтны тухай хууль зөрчих зөрчилд намайг холбогдуулан шалгаж байгааг ойлгож мэдлээ. Би өмгөөлөгч авна.

Асуулт: Та болсон асуудлын талаар үнэн зөв мэдүүлэг өгөх нь чухал ач холбогдолтой бөгөөд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаатай холбоотой нууцыг хадгалах талаар танд мэдэгдэж байна.

Хариулт: Ойлгож мэдлээ.

Асуулт: Та 2019 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр 15 цагийн орчим Төв аймгийн Мөнгөн морьт сумын нутаг Цагаан чулуут гэдэг газар Хэрлэн голын хөвөөнд Ниссан патрол маркийн 12-34 УАА улсын дугаартай тээврийн хэрэгсэлтэй явж байгаад хяналтын улсын байцаагч нартай тааралдсан. Та ямар зорилгоор тэнд, хэн хэн гэдэг хүмүүстэй явж байсан бэ?

Хариулт: Би тэр өдөр өөрийн найз Г. Ч нартай хамт Хэрлэн голын эрэг орчимд амрахаар аялж явсан юм. Би өөрийнхөө машиныг унаж явсан.

Асуулт: Таны аялж явсан газар болон тээврийн хэрэгсэлд үзлэг хийж, эдгээр үзлэгээр 5 ш зэвэг загас барьж, бургасан дунд уурга дэгээний хамт нуусан, мөн машин дотор амьтны мах эвдэж жижиглэн хийсэн байсан нь тогтоогдсон. Энэ ямар амьтны мах вэ? Танд болон таны хамт явсан хүмүүст загас барих эрхийн бичиг байгаа юу?

Хариулт: Загас барьсан нь үнэн гэхдээ нуугаагүй ээ, зүгээр тэнд тавьчихсан байсан. Загас барих эрхийн бичиг байсан. Түүнийг танай нэг байцаагч хураан авсан.

Тэр хайрцагт хийсэн мах ямааны мах юм. Айлаас худалдан авсан байсан.

Асуулт: Загасыг хэн барьсан бэ?

Хариулт: Загасыг би бариагүй ээ. Манай найз Г барьсан юм, тэр уурга дэгээ бүгд түүнийх тэр загас барих эрхийн бичигтэй хэдэн загас барьчихъя гэж хэлээд Хэрлэн гол руу бид очсон юм. Зөвшөөрөлтэй л загас барьсан.

Асуулт: Зөрчлийн газрын үзлэгээр цаасан хайрцагт хийсэн байсан мах буудаж бэлтгэсэн шинжтэй цус хурсан мах байсан. Мөн цэвэр усны Вояж гэсэн саванд байсан хүрэн улаан өнгийн шингэн юуны шингэн бэ?

Хариулт: Тэр усны саванд байгаа шингэн зүйл бол яргуй идсэн ямааны цус юм. Айлаас авсан ямаагаа төхөөрөхдөө цусыг нь саванд авсан байсан юм. Ямааг юу гэж буудах бэ дээ. Зүгээр л мал төхөөрдөг шиг л төхөөрсөн.

Асуулт: Та бор гөрөөс агнасан юм биш үү. Та бүхний авч явсан буунуудаас чех калибр буу буудлага үйлдэгдсэн байсан. Дарь үнэртэж байсан. Та буудсан юм биш үү.

Хариулт: Үгүй ээ ан амьтан агнаагүй. Бууны овоо хараа шалгах гээд бай л буудсан юм.
.....

Асуулт: Таны авч явсан цаасан хайрцагтай махыг шинжилгээнд өгч шинжлүүлэхэд бор гөрөөсний мах, ундааны саванд байсан шингэн бор гөрөөсний цус, таны тээврийн хэрэгслийн арын нөөц дугуй дээрх цус мэт толбо бор гөрөөсний цусны толбо гэж гарсан байгааг танд танилцуулъя. Та болсон явдлын талаар үнэн зөвөөр ярина уу?

Хариулт: За би үнэнээ ярья. Тэр өдрийн өмнөх шөнө бид гурав хотоос гарч Мөнгөнморьт руу явсан бөгөөд Хэрлэнгийн Петровисын амралтын орчим явж байгаад гэрэлтүүлж нэг бор гөрөөс буудсан. Манай найз Ч машин барьж, Г гэрэлтүүлж, би буудсан. Тэгээд махыг нь эвдэж янзлаад цаасан хайрцагт хийгээд жаахан цус аваад архи нэмж хийгээд цэвэр усны саванд хийсэн. Тэгээд өглөө үүрээр шахуу жаахан амарч байгаад гол уруудаж Цагаан чулуут гэдэг газарт ирж загас барьж байгаад баригдсан.

Загасыг Г барьсан өөрөө зөвшөөрлийн бичигтэй л гээд байсан. Өөр хүний нэртэй хугацаа дууссан, эрхийн бичиг засварлаад авч явсан гэдгийг нь мэдээгүй байсан...

Шинжилгээ хийх, шинжээч томилох. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт эрх бүхий албан тушаалтан хүн, эд зүйл, баримт бичиг, ургамал, мал амьтанд шинжилгээ хийлгэнэ, мөн (3) эрх бүхий албан тушаалтан эд зүйл, хөрөнгөд үнэлгээ тогтоох, тусгай мэдлэг шаардагдах асуудлыг тодруулах зорилгоор хүсэлт гаргаж шинжилгээ хийлгэж болно, (4) тусгай мэдлэг, мэргэжил эзэмшсэн эрх бүхий албан тушаалтан өөрөө бие даан шинжилгээ хийж, магадалгаа гаргаж болно гэж тус тус зааснаар хураан авсан амьтны мах, цус мэт бохирлогдсон зүйлийн дээжийг шинжлүүлнэ.

Шинжилгээ хийлгэхэд дараах зүйлсийг анхаарч хуульд заасан журмын дагуу явуулах нь хэргийг хууль зүйн дагуу зөв явуулах ач холбогдолтой юм. Үүнд:

- Шинжилгээ хийлгэх тогтоол, шийдвэрт шинжилгээ хийлгэх үндэслэл, шинжилгээний байгууллагын болон шинжээчийн нэр, шинжээчид тавих асуулт, шинжилгээ хийж дүгнэлт гаргах хугацаа, шинжээчийн мэдэлд шилжүүлэн өгсөн шинжилгээний объектын талаарх мэдээллийг тусгана
- Шинжилгээ хийлгэх шийдвэрээ шинжилгээний байгууллага, шинжээчид шинжилгээний объект, эсхүл түүний дээжийн хамт хүргүүлнэ
- Шинжилгээний объектыг хүргэх, тээвэрлэх боломжгүй тохиолдолд шинжээчийг шинжилгээний объект байгаа газарт чөлөөтэй нэвтрүүлэх, шинжилгээ хийх нөхцөлөөр хангана
- Шинжээчид түүний тусгай мэдлэгийн хүрээний асуултыг тавина
- Шинжилгээг шинжилгээний байгууллагаас гадуур хийлгэх бол шинжилгээний зардлыг урьдчилан шийдвэрлэсэн байна
- Тусгай хадгалалт, хамгаалалт шаардлагатай хөрөнгө, орлого, эд зүйл, шинжилгээний объектыг шүүх, прокурор, эрх бүхий албан тушаалтан, шинжилгээний байгууллагын шинжээчийн саналаар тухайн байгууллагаас өөр байгууллагад хадгалуулж болно
- Хураан авсан эд зүйл, шинжилгээний объект нь хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал амьтанд хортой нөлөө үзүүлэх, эсхүл түргэн муудах, гэмтэх, устах, эсхүл зөрчлийг шийдвэрлэгдэх хүртэл чанар нь муудах хөрөнгө, орлого, эд зүйлийг эзэмшигчид нь буцаан өгөх боломжгүй тохиолдолд шүүхэд хүсэлт гаргаж шийдвэрлүүлнэ.

Байгаль орчны хяналтын улсын байцаагч Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар тусгай мэдлэг, мэргэжил эзэмшсэн эрх бүхий албан тушаалтан өөрөө бие даан шинжилгээ хийж, магадалгаа гаргаж болно. Тухайлбал, энэ зөрчилд холбогдогч нарын барьсан загасыг ямар төрөл зүйлийн загас болох талаар магадалгаа гаргаж, тогтоож болно.

Энэ зөрчилд дурдсанчлан амьтны эд эрхтэн, галт зэвсэг, бичиг баримт (засварласан эсэх талаар) болон бусад эд зүйлд шинжилгээ хийлгэхээр шинжээч томилж болно.

Загвар жишээ 3.
Шинжилгээ хийлгэсэн тогтоол

Шинжээч томилох тухай

2020 оны 2 дугаар сарын 02-ны өдөр Дугаар.... Улаанбаатар хот

Байгаль орчны хяналтын улсын байцаагч, Б би Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар зөрчлийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн 184200001 дугаартай хэрэгт ОЛСОН НЬ:

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн харьяат Г, Ч, Б нар нь 2019 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр Төв аймгийн Мөнгөнморьт сумын Цагаан чулуут нэртэй газарт хувийн 12-34 УАА дугаартай Ниссан патроль маркийн тээврийн хэрэгслээр амьтны эд эрхтэн болох өөрсдийнхөн хэлж мэдүүлснээр ямааны мах гэх эвдэж жижиглэсэн 2 ш хаа, 2 ш гуяа, ямааны цус гэж хэлсэн “Вояж” цэвэр усны 0.5 гр хуванцар саванд хийсэн хүрэн улаан өнгийн цус мэт шингэн авч явж байсан зөрчилд амьтны төрөл зүйл болон эд эрхтнийг тогтоолгох шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулах шаардлагатай байх тул Монгол Улсын Зөрчлийн хэрэг шалган шийдвэрлэх тухай хуулийн ..... зүйл, Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 19 дүгээр зүйлийг тус тус удирдлага болгон ТОГТООХ НЬ:

1. Зөрчлийн 184200001 дугаартай хэрэгт шинжилгээ хийхийг шинжээч Шинжлэх ухааны академийн Ерөнхий болон Сорилын биологийн хүрээлэнгийн Хөхтний экологийн лабораторийн эрхлэгч, эрдэм шинжилгээний ажилтан .....-нд даалгасугай.

2. Шинжээчид дүгнэлт гаргуулахаар дараах асуултыг тавьсугай.
   - Шинжилгээнд хүргүүлж байгаа амьтны түүхий эд эрхтэн (эвдэж жижиглэсэн хаа 2 ш, гуяа 2 ш) нь мал, амьтны эд, эрхтэн мөн эсэх?
   - Дээрх эд эрхтэн нь амьтных мөн бол ямар зүйлийн, хэдэн амьтны эд эрхтэн болох, тэдгээрийн Түгээмэл болон Шинжлэх ухааны нэр?
   - Хэрвээ эд эрхтэн нь нэг зүйлийн амьтны эд эрхтэн мөн бол хэдэн бодгаль амьтны ямар ямар эд эрхтэн болох?
   - Шинжилгээнд хүргүүлсэн зүйлс нь зэрлэг амьтны эд эрхтэн мөн бол тухайн амьтад нь манай орны аль хэсэгт тархсан болох?
   - Уг эд эрхтний хэсгээр тухайн амьтны нас, хүйс болон агнасан хугацааг тогтоох боломжтой эсэх?
   - Шинжилгээнд хүргүүлж буй савтай шингэн нь цус мөн эсэх. Хэрвээ мөн бол мал, амьтны алин нь болох?
   - Амьтны цус мөн бол ямар зүйлийн амьтны цус болох?
   - Шинжилгээнд хүргүүлсэн амьтны эд эрхтний цус мөн эсэх?

3. Тогтоолыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор дүгнэлт гаргахыг шинжээч .... -нд даалгасугай.

4. Шинжээчийн мэдэлд шинжилгээ хийлгэх тогтоолын хамт дараах эд зүйлийг түр хүргүүлсүгэй. Үүнд:
   - Амьтны эвдэж жижиглэсэн хаа 2 ш
   - Амьтны эвдэж жижиглэсэн гуяа 2 ш
   - “Вояж” шошготой цэвэр усны саванд хийсэн хүрэн улаан өнгийн шингэн 1 ш зүйлийг хүргүүлсүгэй.

Шинжээч ..... -нд хуульд заасан дараах эрх, үүргийг тайлбарласугай

Шинжилгээнд зориулж дээж авахад анхаарах зүйл. Шинжилгээнд зориулж дээж авахдаа түүнийг муутгахгүй, хэлбэр хэмжээ дүрс байдлыг алдагдуулахгүй байх арга хэмжээ авч зориулалтын хадгалах сав, баглаа боодлыг урьдчилан бэлтгэсэн байх ёстой. Бусад зөрчлийн хэргийн дээж, эд зүйлстэй холилдож андуурагдахгүй байлгахын тулд гадна сав, баглаа боодол дээр нь ямар зөрчлийн газрын, ямар эд зүйл юу болох талаар тодорхой бичин тэмдэглэж, лацдаж тэмдэг дарж баталгаажуулан хадгалж, шинжилгээний байгууллагад хүргүүлнэ.

Хураан авсан, эд зүйлийн талаар авах арга хэмжээ. Байгаль орчны хяналтын улсын байцаагч дээрх холбогдогч нараас хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, эд зүйлийн хадгалалт, хамгаалалтыг бүрэн хариуцна. Зөрчлийн хэргийг харьяаллын дагуу, эсхүл шүүхэд шилжүүлэхдээ хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, эд зүйлийн хамт хүргүүлнэ.

Эрх бүхий албан тушаалтны хураан авсан зүйлийг устгуулахаар зохих байгууллагад шилжүүлж болно. Ингэхдээ устгасан ажиллагааны талаарх эрх бүхий байгууллагын тэмдэглэл, эд зүйлийн жагсаалтыг зөрчлийн хэрэгт хавсаргана.

Эрх бүхий албан тушаалтан нь хураан авсан эд зүйлийн талаар дараах шийдвэрийн аль нэгийг гаргана. Үүнд:

- Эзэмшигчид нь буцаан олгох
- Устгах
- Улсын орлого болгох
- Зөрчлийн хэрэгт хадгалах зэрэг болно.

Нотлох ажиллагаа. Эрх бүхий албан тушаалтан гаргасан шийдвэрийнхээ үндэслэлийг нотлох үүрэг хүлээнэ. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны зөрчлийг нотлох баримт нь гэрч, хохирогч, холбогдогчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт, мэдүүлэг, бичмэл болон эд мөрийн баримт, баримт бичиг, гэрэл зураг, зураглал, дуу, дүрс, дуу-дүрсний бичлэг, хэв загвар, дээж, зөрчил шалгах ажиллагааны болон шүүх хуралдааны тэмдэглэл, хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас ирүүлсэн зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл, стандартаар баталгаажсан хэмжилт-хяналтын төхөөрөмжийн мэдээлэл, бусад баримтаар тодорхойлогдоно.

Мэргэжлийн байгууллагын хяналт шалгалтын явцад хуульд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулж, бэхжүүлсэн баримтат мэдээллийг нотлох баримтаар тооцно. Нотлох баримтыг хууль бус арга, хэрэгслээр цуглуулж, бэхжүүлэхийг хориглоно. Хуульд заасан журам зөрчиж цуглуулсан, бэхжүүлсэн нотлох баримт нотлох чадвараа алдах бөгөөд энэ хуульд заасан шийдвэрийн үндэслэл болохгүйг анхаарах хэрэгтэй.

Эрх хязгаарлах арга хэмжээ. Зөрчил шалган шийдвэрлэж буй эрх бүхий албан тушаалтан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа хэвийн явагдах нөхцөлийг хангах зорилгоор энэ хуульд заасан журмын дагуу эрх хязгаарлах арга хэмжээг авна.
Бидний авсан загвар жишээний хувьд холбогдогчийн баримт бичгүүдийг хураан авч, эрхийг зохих хэмжээгээр хязгаарлаж байна. Тухайлбал, холбогдогчийн жолоодох эрхийн үнэмлэх, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, галт зэвсэг ашиглах гэрчилгээ зэрэг баримт бичгийг хураан авч, хураан авсан тухай баримтыг холбогдогчид өгнө. Холбогдогч хураалгасан баримт бичгийг ашиглах зайлшгүй шаардлагатай бол эрх бүхий албан тушаалтанд хүсэлт гаргаж шийдвэрлүүлнэ.

Зөрчлийн хэргийг танилцуулж, хэрэг бүртгэлтийг дуусгах. Эрх бүхий албан тушаалтан зөрчлийг нотлох ажиллагааг хангалттай хийж, хуульд заасан журмын дагуу явуулж нотлогдсон гэж үзвэл, зөрчлийн хэрэг бүртгэлтийг дуусгахаас өмнө оролцогч, тэдгээрийн өмгөөлөгчийг зөрчлийн хэрэгтэй танилцах боломжоор хангаж, танилцуулна.

Зөрчлийн хэрэг бүртгэлтийг дуусгаж зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгох эсвэл шийтгэл оногдуулах гэсэн шийдвэрийн аль нэгийг гаргана.

Бодлого 1

Иргэн А нь Төв аймгийн Баянжаргалант сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт амьдардаг малчин айл юм. Тэрээр ангийн зөвшөөрлийн буутай ба түүгээрээ зун тарвага буудаж боодог хийж иддэг. А-г хониндоо буу үүрж яваад тарвага буудаж ирснийг нь саахалт айлын Б хараад сумын цагдаад мэдэгдсэн байна. А-н хийсэн үйлдэлд хууль зүйн дүгнэлт хийнэ үү?

Хариулт: Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн 1-д “хугацаа дууссан гэрээ, зөвшөөрлөөр, эсхүл гэрээ, зөвшөөрөлгүйгээр амьтныг ... 1.3.агнасан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно”, мөн хуулийн 7.6 дугаар зүйлийн 4-д “... амьтныг агнах хориотой үед, ... агнасан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж тус тус заасан байна.

Түүнчлэн Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1-д “байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байгаль орчныг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ ... 4.хууль тогтоомжийн дагуу жил бүр ашиглаж болох ой, ургамал, амьтны тоо хэмжээг тодорхойлж, экологийн шаардлага, нөөцийг харгалзан тухайн бүс нутагт байгалийн зарим төрлийн баялгийн ашиглалтыг хязгаарлах буюу тодорхой хугацаагаар хориглох”, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-д “амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, зохистой ашиглах талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ... дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ ... 5.3.4.сүргийн бүтцийн төлөв байдал, тархац, нөөцийг харгалзан тухайн агнуурын бүс нутагт ан хийх, эсхүл зарим зүйл агнуурын амьтныг агнах, барихыг тодорхой хугацаагаар хориглох” гэж тус тус заасан байдаг.

Бодлого 2

Байгаль орчны хяналтын улсын байцаагч У нь 2018 оны 8 дугаар сарын 21-ны өдөр Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын нутагт иргэн Г “тарвага сахисан” гэх зөрчилд зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулан 2018 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр ******* дугаартай шийтгэлийн хуудсаар тус иргэнд Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу 150,000 төгрөгөөр торгож шийдвэрлэсэн байна.

Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн 1.3-д зааснаар иргэн Г нь тарвага агнасан зөрчил үйлдсэн болох нь тогтоогдохгүй, зөрчлийн шинжгүй, эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан 0143166 дугаартай шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах үндэслэлтэй байх тул Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.2 дугаар зүйлийн 8 дахь хэсгийг удирдлага болгон Байгаль орчны хяналтын улсын байцаагч У-ын 2018 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр ******* дугаартай шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулахаар прокурорын дүгнэлт бичив. Прокурорын дүгнэлт хууль зүйн үндэслэлтэй юу?

Хариулт: Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн 1-д “хугацаа дууссан гэрээ, зөвшөөрлөөр, эсхүл гэрээ, зөвшөөрөлгүйгээр амьтныг … 1.3.агнасан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасан. Үндэслэлтэй байна.

Бодлого 3

Г нь 2017 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр Дундговь аймгийн Гурвансайхан сумын ард иргэдийн (Элгэн багийн засаг дарга А бусад малчдын) буюу чоно хонь мал руу дайраад амар байлгахаа байлаа ирж агнаж өгөөч гэсэн хүсэлтээр очиж нутгийн иргэдийн хамтаар 2 чоно агнасан юм. Г-ийн хувьд буу эзэмших болон ан агнах зөвшөөрөлтэй, цагдаагийн байгууллага болон татварын хэлтэст жил бүр бүртгэгдэж явдаг. Гэтэл Их газрын чулууны улсын тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль орчны хяналтын улсын байцаагч А гэдэг хүн дээрх үйлдэлд зөрчлийн хуулиар хариуцлага оногдуулжээ. Г нь тухайн үед ард иргэдийн хүсэлтээр очсон гэдгээ хэлж шалгаж өгөхийг хүссэн боловч энэ талаар нутгийн иргэдтэй уулзаж шалгалгүйгээр хариуцлага тооцсон байна. Хууль зүйн дүгнэлт хийнэ үү?

Хариулт: Улсын тусгай хамгаалалттай газар нутагт чонын тоог зохицуулах, зэрлэгшсэн нохойг устгахад мөрдөх журмын 1-д “чоно авлах ... ажлыг тухайн газрын хамгаалалтын захиргаа зохион байгуулж, хяналт тавина” гэж заасан байх ба нэхэмжлэгч Г-д холбогдох зөрчлийн материал, хариуцагч А-ийн хариу тайлбар, прокурорын дүгнэлт, Р-ийн мэдүүлэг зэргээс үзэхэд, Их газрын чулууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа нь 2017 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр тухайн чоно агнасан нутаг дэвсгэр буюу Их газрын чулууны ууланд чоно авлахтай холбоотой аливаа нэгэн ажлыг зохион байгуулж явуулаагүй байна. Иймээс нэхэмжлэгч Г-ийн тухайн газар нутгийг хариуцсан байгууллагын зөвшөөрөлгүйгээр хамгаалагдсан бүс нутгаас чоно агнасан байна гэж үзэх үндэслэлтэй.

Г-ийн улсын тусгай хамгаалалттай байгалийн цогцолборт газарт чоно агнасан үйлдэл нь Улсын тусгай хамгаалалттай газар нутагт хууль бусаар ан агнасан эрүүгийн гэмт хэрэг болно.

Бодлого 4

Иргэн Д үл таних хүнээс 3 ш болгон хурааж чанаж хөлдөөсөн 1 ш тарваганы махыг зохих зөвшөөрөл, эрхийн бичиггүйгээр худалдан авсан байна. Д худалдаж авсныхаа дараа Өвөрхангай аймгийн 10 дугаар багт байрлах Онгийн голын постоор 3 ш тарваганы ороомгон мах хууль бусаар тээвэрлэсэн байна. Үүнд хууль зүйн дүгнэлт өгнө үү?

Хариулт: Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн 5-д “агнуурын амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийн зүйлийг тусгай зөвшөөрөл, гарал үүслийн бичиг, дагалдах тодорхойлолтгүйгээр худалдсан, худалдан авсан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” хэмээн заажээ.

Бодлого 5

Иргэн Дорж Өвөрхангай аймгаас Улаанбаатар явах замд нэгэн хүн дайвар авахыг гуйж, Дорж зөвшөөрөн шар ууттай зүйлийг авч явсан байна. Өвөрхангай аймгийн цагдаагийн пост дээр Доржийг зогсоож тухайн ууттай зүйлийг юу болохыг асуухад Дорж адууны махан ороомог байх, мэдэхгүй байна гэжээ. Гэтэл Өвөрхангай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч Туяа ийм адуу гэж юу байсан юм. Зөвшөөрлийн бичиггүй тарвага байна, тарвага биз дээ? хэмээн асуугаад хураан авч, 300 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох арга хэмжээ авчээ. Хууль зүйн дүгнэлт өгнө үү?

Хариулт: Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.4 дүгээр зүйлийн 5-д “эрх бүхий албан тушаалтан оногдуулсан шийтгэл, шийтгэлийг албадан гүйцэтгүүлэх үндэслэлийг шүүхэд нотлох үүрэг хүлээнэ”, 4.15 дугаар зүйлийн 1-д “эрх бүхий албан тушаалтан гаргасан шийдвэрийнхээ үндэслэлийг нотлох үүрэг хүлээнэ” гэж заасан бөгөөд Өвөрхангай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч гаргасан шийдвэрийнхээ үндэслэлийг нотлоогүй гэж үзэж байна.

Бодлого 6

Дорноговь аймгийн Сайншанд хотод амьдран суудаг Даш амьтан агнах хоббитой бөгөөд түүнийхээ дагуу цагаан зээр болон бусад нэр бүхий зүйлийн амьтан агнах 5 дугаар сарын зөвшөөрөл авсан байжээ. Тухайн зөвшөөрөл нь 4 дүгээр сард дуусгавар болсон ч 6 дугаар сард гэр бүлээрээ аялж явахдаа цагаан зээр агнан авч явахдаа Дорноговь аймгийн цагдаагийн постод баригдан хураалгасан ба шалгаж үзэхэд, ан агнах зөвшөөрөл нь тухайн оны 4 дүгээр сард дууссан байсныг илрүүлжээ. Хууль зүйн дүгнэлт өгнө үү?

Хариулт: Зөрчлийн тухай хуулийн 7.6.1.хугацаа дууссан гэрээ, зөвшөөрлөөр, эсхүл гэрээ, зөвшөөрөлгүйгээр амьтныг ... 1.1.ашигласан, 1.2.барьсан, 1.3.агнасан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Бодит жишээ **Хөвсгөл аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх**

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Байгаль орчны хяналтын улсын байцаагч зохих зөвшөөрөлгүй, гарал үүслийн тодорхойлолтгүй 38 ш нойтон тарвага тээвэрлэсэн гэх 2338000655 дугаартай зөрчилд зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж, холбогдогч Д-д 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдөр 300 нэгжээр торгох шийтгэл оногдуулсан байна.

Хэрэгт цугларсан нотлох баримтаар Д нь Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан зохих зөвшөөрөлгүй гарал үүслийн тодорхойлолтгүй 38 ш нойтон тарвага тээвэрлэсэн зөрчил үйлдсэн гэж үзсэн байна.

Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан зөрчил үйлдсэн хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэж хуульчилсан.

Прокурорын дүгнэлтэд: Холбогдогч Д-д шийтгэл оногдуулсан шийтгэлийн хуудсанд шийтгэлийн төрлийг хуульд заасан үндэслэл журмын дагуу бичээгүй нь ойлгомжгүй байх бөгөөд Зөрчлийн тухай хуулийн 1.2 дугаар зүйлийн 2-т заасан зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээг энэ хуулиар тогтооно гэсэн хууль ёсны зарчимд нийцээгүй байна. Иймд шийтгэлийн хуудаст өөрчлөлт оруулах үндэслэл тогтоогдож байх тул Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.2 дугаар зүйлийн 8 дахь хэсгийг удирдлага болгон тус аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Байгаль орчны хяналтын улсын байцаагчийн холбогдогч Д-д шийтгэл оногдуулсан 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 0048215 дугаартай шийтгэлийн хуудасны Шийдвэрлэх нь: хэсгийн 1 дэх заалтад бичигдсэн «... (31,460) нэгжээр торгох... гэснийг ...300 нэгжээр торгох... гэж өөрчлүүлэхээр прокурорын дүгнэлт бичив. гэжээ.

Шүүх

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.1 дэх заалтад нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх ... гэж, мөн хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэгт *“Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хүлээн зөвшөөрсөн нь бусад этгээдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөхөөргүй, хуульд харшлаагүй байвал шүүх хариуцагчийн зөвшөөрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгоно”* гэжээ.

Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь ...2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 0048215 дугаартай шийтгэлийн хуудсанд өөрчлөлт оруулах тухай шаардлага бүхий прокурорын дүгнэлтийг бүхэлд нь хүлээн зөвшөөрч байгаагаа шүүхэд бичгээр илэрхийлсэн байх тул хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч прокурорын дүгнэлтийг хүлээн зөвшөөрснийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэх нь үндэслэлтэй байна.

Хариуцагч Хөвсгөл аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Байгаль орчны хяналтын улсын байцаагч нь 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 0048215 дугаартай шийтгэлийн хуудасны Шийдвэрлэх нь: хэсгийн 1 дэх заалтад бичигдсэн “... (31,460) нэгжээр торгох... гэснийг ...300 нэгжээр торгох...” гэж өөрчлөх тухайгаа холбогдогч Д-д мэдэгдсэн тухайгаа баримтжуулах үүрэг хүлээнэ.

ЗАХИРАМЖЛАХ нь: Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэгт заасныг баримтлан Хөвсгөл аймгийн прокурорын газрын зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих ажил хариуцсан ахлах прокурорын гаргасан 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 0048215 дугаартай шийтгэлийн хуудсанд өөрчлөлт оруулах шаардлага бүхий дүгнэлтийг хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч хүлээн зөвшөөрснийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгосугай гэж шийдвэрээ гаргажээ.

Анхаарах зүйл:

- Шийтгэлийн актыг бичихдээ маш анхааралтай, хууль зүйн үг найруулгаар бичих
- Нотлох баримтыг бүрдүүлэхэд анхаарах.

3.5 БАЙГАЛИЙН УРГАМЛЫН ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН УРГАМЛЫН ЭРҮҮЛ МЭНД, УРГАМАЛ ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛЬ ЗӨРЧИХ, ЗӨРЧЛИЙН ШИНЖ, ОНЦЛОГ, АНХААРАХ АСУУДАЛ

3.5.1. Байгалийн ургамлын тухай хууль зөрчих зөрчлийн ойлголт, шинж, харьяалал ба төсөөтэй гэмт хэргээс ялгагдах шинж

Шийтгэл. Зөрчлийн тухай хуулийн 7.7 дугаар зүйлийн Байгалийн ургамлын тухай хууль зөрчих тохиолдолд зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд дараах шийтгэл оногдуулна. Үүнд:

1. Зохих зөвшөөрөлгүйгээр, эсхүл зөвшөөрөлд заасан хугацаа, хэмжээ, ургамал түүж бэлтгэх журам зөрчиж (1.1) байгалийн ховор ургамлыг ахуйн хэрэгцээнд, (1.2) элбэг ургамлыг үйлдвэрлэлийн түүхий эд болгон ашиглах, орлого олох зорилгоор түүсэн, бэлтгэсэн, худалдсан бол хууль бусаар бэлтгэсэн эд зүйлийг хураах хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2. Байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах ач холбогдолтой нутаг дэвсгэр, бэлчээр, хадлангийн газар, мал тэжээх зориулалтаар ашиглахыг хориглосон газар үйлдвэрлэлийн зориулалтаар ургамал түүж бэлтгэсэн, эсхүл мал бэлчээсэн бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
3. Харь ургамлыг зөвшөөрөлгүйгээр байгальд тарималжуулсан, эсхүл гадаад улсаас оруулсан бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
4. Ургамлыг түүж бэлтгэх журам зөрчсөн, эсхүл ахуйн зориулалтаар ашиглахаар түүж бэлтгэсэн ургамлыг үйлдвэрлэлийн түүхий эд болгон ашигласан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хураах, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Зөрчлийг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан ба харьяалал. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлд зааснаар Зөрчлийн тухай хуулийн 7.7 дугаар зүйлийн Байгалийн ургамлын тухай хууль зөрчих зөрчлийг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан болон харъяаллыг доорх хүснэгтээр харуулав. Үүнд:

Эрх бүхий албан тушаалтан	Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харьяалал
Зөрчлийн тухай хуулийн 7.7 дугаар зүйл. Байгалийн ургамлын тухай хууль зөрчих	
Улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч (6.27) Байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37)	Зөрчлийн тухай хуулийн 7.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг
Улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч (6.27) Байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37)	Зөрчлийн тухай хуулийн 7.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг
Байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37) Гаалийн улсын байцаагч (6.11)	Зөрчлийн тухай хуулийн 7.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэг
Байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37)	Зөрчлийн тухай хуулийн 7.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэг

Хуулийн нэр томьёоны тайлбар. Зөрчлийн тухай хуулийн 7.7 дугаар зүйлд заасан зөрчилтэй холбогдох нэр томьёог ихэвчлэн Байгалийн ургамлын тухай хуульд тайлбарласан байдаг бөгөөд тэдгээрийг дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

“Байгалийн ургамал” гэж хүний оролцоогүйгээр байгалийн жамаар ургаж байгаа зүйл ургамлыг,

“Байгалийн ургамлын нөөц” гэж тухайн зүйл ургамлын тархац нутаг дахь нийт хэмжээг,

“Байгалийн ургамлын тархац, нөөцийн судалгаа” гэж тухайн зүйл ургамлын тархац нутаг, нөөцийн хэмжээг тогтоох зорилгоор хийгдэж байгаа судалгааг,

“Байгалийн ургамлыг тариалжуулах” гэж байгалийн ургамлыг хамгаалах, удмын санг хадгалах, түүхий эд болгон ашиглах зорилгоор тарьж ургуулах, үржүүлэх ажиллагааг,

“Ургамлын экологи-эдийн засгийн үнэлгээ” гэж тухайн зүйл ургамлын оршин амьдрах нөхцөл болон экологийн, эдийн засгийн, эрх зүйн, нийгмийн ач холбогдлоор нь үнэлсэн тусгай аргачлалын дагуу тооцсон нэгж жингийн мөнгөн үнэлгээг,

“Харь ургамал” гэж улсын хилийн гаднаас зориудаар болон санамсаргүй байдлаар зөөвөрлөгдөн ирж, нутагшиж байгаа зүйл ургамлыг тус тус ойлгоно.

Зөрчлийн төсөөтэй гэмт хэргээс ялгагдах шинж. Зөрчлийн тухай хуулийн 7.7 дугаар зүйлийн Байгалийн ургамлын тухай хууль зөрчих зөрчлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.8 дугаар зүйлийн Байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх гэмт хэргээс ялгаж тодорхойлох нь энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийг шалгахад нэн тэргүүнд хийх ёстой ажиллагаа юм. Байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.8 дугаар зүйл нь Байгалийн ургамлын тухай хууль зөрчих Зөрчлийн тухай хуулийн 7.7 дугаар зүйлээс хуульчлагдсан байдал, халдлагын зүйл, үйлдлийн арга, зорилго, зориулалтаар ялгагдах хэд хэдэн шинжтэй бөгөөд тэдгээрийг доорх хүснэгтээр харуулав.

Хүснэгт 3.5. *Байгалийн ургамлын тухай хууль зөрчих зөрчлийн төсөөтэй гэмт хэргээс ялгагдах шинж*

Гэмт хэрэг, зөрчлийн ялгагдах шинж	
Эрүүгийн хуулийн 24.8 дугаар зүйл Байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх	**Зөрчлийн тухай хуулийн 7.7 дугаар зүйл Байгалийн ургамлын тухай хууль зөрчих**
Эрүүгийн хуульд хуульчлагдсан	Зөрчлийн тухай хуульд хуульчлагдсан
Халдлагын зүйлийн хувьд	
• Нэн ховор ургамал • Ховор ургамал • Тэдгээрийн үр эрхтэн	• Элбэг ургамал • Харь ургамал
Үйлдлийн арга	
Зохих зөвшөөрөлгүйгээр: • Нэн ховор ургамал • Ховор ургамал	Зохих зөвшөөрөлгүйгээр: • Ховор ургамлыг ахуйн хэрэгцээнд • Харь ургамлыг тариалжуулсан
Түүсэн	Түүсэн
Бэлтгэсэн	Бэлтгэсэн
Худалдсан	Худалдсан

Худалдан авсан	Зөвшөөрөлд заасан хугацаа, хэмжээ
Хадгалсан	Ургамал түүж бэлтгэх журам зөрчсөн
Тээвэрлэсэн	Ашиглахыг хориглосон газар
Боловсруулсан	Үйлдвэрлэлийн зориулалтаар ургамал түүж бэлтгэсэн
	Мал бэлчээсэн
	Харь ургамлыг гадаад улсаас оруулсан
Зорилго, зориулалт	
Хуульд зааснаас өөр зорилгоор нэн ховор, ховор ургамал, тэдгээрийн үр, эрхтнийг түүсэн, бэлтгэсэн, худалдсан, худалдан авсан, хадгалсан, тээвэрлэсэн, боловсруулсан	Элбэг ургамлыг үйлдвэрлэлийн түүхий эд болгон **ашиглах, орлого олох зорилгоор** түүсэн, бэлтгэсэн, худалдсан
	Ахуйн зориулалтаар ашиглахаар түүж бэлтгэсэн ургамлыг **үйлдвэрлэлийн түүхий эд болгон ашигласан**


ГУРАВДУГААР БҮЛЭГ

Зөрчлийн тухай хуулийн 7.7 дугаар зүйлийн Байгалийн ургамлын тухай хууль зөрчих ***зөрчил*** нь дээр дурдсанчлан 4 хэсэг, 2 заалтаас бүрдэх бөгөөд хэсэг тус бүр өөр өөрийн онцлог шинжтэй юм. Иймд хэсэг тус бүрийг тусгайлан авч үзье.

Зөрчлийн тухай хуулийн 7.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчилд зохих зөвшөөрөлгүй эсвэл зөвшөөрөлтэй боловч түүнд заасан хугацаа, хэмжээ, ургамал түүж бэлтгэх журам зөрчсөн үйлдлүүд хамраана. Энэ зөрчил нь 2 заалтаас бүрдэх бөгөөд тэдгээр хориглосон үйлдлийг хийхдээ (1) зөвшөөрөлгүйгээр, мөн (2) зөвшөөрөлтэй ч заасан хугацаа, хэмжээ болон түүж бэлтгэх журам зөрчсөн үйлдлүүд хамаарна.

Түүнчлэн (3) байгалийн ховор ургамлыг ахуйн хэрэгцээнд, (4) элбэг ургамлыг (а) үйлдвэрлэлийн түүхий эд болгон ашиглах, (б) орлого олох зорилгоор түүсэн, бэлтгэсэн, худалдсан бол гэсэн хуулийн зүйл, хэсэг, заалт доторх биеэ даасан эхлэл, төгсгөлтэй үйлдлүүдийг ялган ойлгож, хуулийг хэрэглэх нь зүйтэй.

Эдгээр үйлдлүүд нь үргэлжилсэн нэг үйлдэл ч байж болно. Дангаараа үйлдэл ч байж болно. Жишээ дурдвал: элбэг ургамлыг ашиг олох зорилгоор түүгээд, бэлтгээд, худалдсан бол нэг үйлдэлд хамааруулна. Харин зөвхөн ашиг олох зорилгоор худалдсан нэг үйлдэл байж болно.



Зөрчлийн тухай хуулийн 7.7 дугаар зүйлийн *зохих зөвшөөрөлгүйгээр* гэж байгалийн ургамлыг түүж бэлтгэх, ашиглахад эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас олгосон зөвшөөрөлгүй байхыг ойлгоно.

Байгалийн тухай хуульд иргэн ховор ургамлыг өөрийн ам бүлийн хүнсний болон ахуйн бусад хэрэгцээг хангах зорилгоор сум, дүүргийн Засаг даргын зөвшөөрлөөр, элбэг ургамлыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах зөвшөөрлийг аймаг, нийслэлийн байгаль орчны албаны дүгнэлтийг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга, харин ховор ургамлыг эм үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллага олгохоор тус тус заасан бөгөөд дээрх зөвшөөрлийг аваагүй нь зөрчлийн объектив үйлдэл болно.

Зөвшөөрөлд заасан хугацаа, хэмжээ, ургамал түүж бэлтгэх журам зөрчих гэж ургамал ашиглах зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ургамлыг түүж бэлтгэх журам, ашиглахыг зөвшөөрсөн хэмжээ, хугацааг баримтлан түүж бэлтгэх ёстой бөгөөд тэдгээрийг баримтлахгүй байхыг ойлгоно.

Байгалийн ховор ургамлыг ахуйн хэрэгцээнд гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллага зохих зөвшөөрөлд заасан хугацаа, хэмжээ, ургамал түүж бэлтгэх журам зөрчиж ховор ургамлыг ахуйн хэрэгцээндээ түүж, бэлтгэсэн үйлдлийг ойлгоно.

Иргэн ховор ургамлыг өөрийн ам бүлийн хүнсний болон ахуйн бусад хэрэгцээг хангах зорилгоор Зөвшөөрлийн тухай хууль (2022)[19]-ийн 8.2 дугаар зүйлийн 1.13-д заасны дагуу сум, дүүргийн Засаг даргын зөвшөөрлөөр ашиглаж болно[20].

Ургамлыг ашиглах зөвшөөрлийг эрхийн бичгээр олгох бөгөөд эрхийн бичгийг бусдад шилжүүлэн ашиглуулахыг хориглоно. Эрхийн бичигт тухайн ургамлыг түүж бэлтгэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг, ургамлын зүйлийн нэр, эрхтэн, түүж бэлтгэх хэмжээ, хугацаа, газрыг заана.

Тухайн нутаг дэвсгэрийн байгаль хамгаалагч ургамал ашиглах эрхийн бичгийг үндэслэн ургамлыг түүж бэлтгэх газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад зааж өгөх бөгөөд холбогдох эрхийн бичгийн мэдээллийг Генетик нөөцийн тухай хуульд заасны дагуу генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн бүртгэл, мэдээллийн санд мэдээлэх үүрэгтэй.

Ургамал ашиглах зөвшөөрлийг 30 хоногийн хугацаатай олгож, нэг удаа анх олгосон хугацаагаар сунгана. Ургамал ашиглах зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ургамлыг түүж бэлтгэх журам, ашиглахыг зөвшөөрсөн хэмжээ, хугацааг баримтлан түүж бэлтгэнэ. Ургамлыг түүж бэлтгэх, улсын хилээр нэвтрүүлэх журам, хэмжээ, хугацааг мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн төрийн захиргааны төв байгууллага тогтоодог.

Ургамлыг нь ашиглахаас өөр зориулалтаар газрыг гэрээний дагуу эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн эзэмшил, ашиглалтын газар дахь ургамлыг зохих

19 1.1.“Зөвшөөрөл” гэж зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдээс хуульд заасан хугацаа, нөхцөл, шаардлагын дагуу тодорхой үйл ажиллагааг эрхлүүлэх, эсхүл байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглуулахаар олгосон эрхийг,
1.2.“Зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд” гэж хуулиар зөвшөөрөл олгох бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасан төрийн байгууллага, албан тушаалтан, эсхүл төрийн зарим чиг үүргийг хуульд, эсхүл гэрээнд заасны дагуу шилжүүлэн авсан этгээдийг,
1.3.“Зөвшөөрөл эзэмшигч” гэж тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэх, эсхүл байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглахаар эрх бүхий этгээдээс зөвшөөрөл авсан этгээдийг

20 8.2 дугаар зүйл.Энгийн зөвшөөрлийн жагсаалт, 1.13.ховор ургамлыг өөрийн ам бүлийн хүнсний болон ахуйн бусад хэрэгцээг хангах зорилгоор ашиглах.Тухайн сум, дүүргийн Засаг дарга.

журмын дагуу зөвшөөрөл авч үйлдвэрлэлийн зориулалтаар бол төлбөртэйгөөр, ахуйн зориулалтаар бол төлбөргүйгээр ашиглана.

Байгалийн ургамлын тухай хуульд зааснаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага байгалийн ховор ургамлыг ахуйн болон судалгаа, шинжилгээний зориулалтаар ашиглаж болох бөгөөд түүний ашиглах зориулалт нь зөвхөн иргэний ам бүлийн хүнсний болон ахуйн бусад хэрэгцээг хангах зорилготой байна.

Элбэг ургамлыг үйлдвэрлэлийн түүхий эд болгон ашиглах, орлого олох зорилгоор гэж элбэг тархацтай ургамлыг аливаа үйлдвэрлэлийн түүхий эд болгох, орлого олох зорилгоор түүсэн бэлтгэсэн, худалдсан үйлдлийг ойлгоно.


Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага элбэг ургамлыг хүнсний, техникийн болон ургамлын гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулах зориулалтаар ашиглаж болно. Харин түүж бэлтгэсэн ургамлыг үйлдвэрлэлийн түүхий эд болгон ашиглах, орлого олох зорилгоор бусдад борлуулахыг хориглодог.

Түүсэн, бэлтгэсэн, худалдсан гэж ашиг олох, борлуулах, худалдах зорилгоор байгалийн ургамлыг түүж бэлтгэсэн, худалдсан идэвхтэй үйлдэл байна.

Зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлого. Зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлого гэж зөрчил үйлдэн олж авсан мөнгө, эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, тэдгээрийг арилжаалж бий болгосон бусад эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, тэдгээрийг түрээслэх, ашиглах замаар олсон бүх төрлийн орлогыг ойлгоно.

Зөрчил үйлдэхдээ ашигласан зэвсэг, хэрэгсэл, эд зүйл, тээврийн хэрэгсэл, уналга, зөрчилтэй бараа, бүтээгдэхүүн, эд зүйлийг хураана. Харин зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл нь зөрчил үйлдсэн хүний амьжиргааны эх үүсвэр болсон эд зүйл, хэрэгсэл бол тэдгээрийг хураахгүй.

Зөрчлийн тухай хуулийн 7.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан зөрчилд байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах ач холбогдолтой нутаг дэвсгэр, бэлчээр, хадлангийн газар, мал тэжээх зориулалтаар ашиглахыг хориглосон газар үйлдвэрлэлийн зориулалтаар ургамал түүж бэлтгэсэн, эсхүл мал бэлчээсэн үйлдлүүд хамаарна.



Байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах ач холбогдолтой нутаг дэвсгэр, бэлчээр, хадлангийн газар, мал тэжээх зориулалтаар ашиглахыг хориглосон газар үйлдвэрлэлийн зориулалтаар ургамал түүж бэлтгэсэн, эсхүл мал бэлчээсэн гэж ургамлын нөөц баялагтай, аливаа нөлөөллөөс хамгаалах зайлшгүй шаардлагатай тусгайлан хамгаалалтад авсан газарт үйлдвэрлэлийн зориулалтаар ургамал түүж бэлтгэх, олон тооны мал бэлчээхийг хориглох тухай ойлголт юм.


Зөрчлийн тухай хуулийн 7.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан зөрчил нь монгол орны нутаг дэвсгэрт ургадаггүй харь ургамлыг зөвшөөрөлгүйгээр тариалжуулан ургуулсан эсхүл гадаад улсаас оруулсан хууль бус үйлдэл байна.



Зөвшөөрөлгүйгээр байгальд тарималжуулсан гэж харь ургамлыг төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр байгальд тарималжуулж байгаа үйлдэл, үйл ажиллагааг ойлгоно. Харь ургамлыг зориулалтын хязгаарлаж битүүмжилсэн талбайд тарималжуулж болно.

Гадаад улсаас оруулсан гэж харь ургамлыг зохих зөвшөөрөл авалгүйгээр гаалийн хяналтаас нуух, мэдүүлэхгүй байх зэрэг янз бүрийн арга хэрэглэж улсын хилээр зориудаар оруулж байгаа санаатай үйлдлийг ойлгоно.

Зөрчлийн тухай хуулийн 7.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан зөрчил нь ургамлыг түүж бэлтгэх журам зөрчсөн, ахуйн зориулалтаар ашиглахаар түүж бэлтгэсэн ургамлыг үйлдвэрлэлийн түүхий эд болгон ашигласан үйлдэл байна.



Ургамлыг түүж бэлтгэх журам зөрчсөн гэж ургамал ашиглах зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ургамлыг түүж бэлтгэхэд зориулан гаргасан журмыг зөрчиж байгаа үйлдэл, эс үйлдлийг ойлгоно.

Ахуйн зориулалтаар ашиглахаар түүж бэлтгэсэн ургамлыг үйлдвэрлэлийн түүхий эд болгон ашигласан гэж иргэн ахуйн зориулалтаар ашиглахаар түүж бэлтгэсэн ургамлыг үйлдвэрлэлийн түүхий болгон ашиглаж байгаа санаатай үйлдэл, үйл ажиллагааг ойлгоно.

3.5.2. Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль зөрчих зөрчлийн шинж, онцлог, шийтгэл ба харьяалал

2007 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр батлагдсан Ургамал хамгааллын тухай хууль 2024 оны 6 дугаар сарын 05-ны өдөр хүчингүй болж, мөн өдрөөс эхлэн шинэчлэн найруулсан Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль хүчин төгөлдөр болсон.

Шийтгэл. Зөрчлийн тухай хуулийн 7.8 дугаар зүйлийн Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль зөрчих тохиолдолд зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд дараах шийтгэл оногдуулна. Үүнд:

1. Ургамлын хөнөөлт организмтай тэмцэх технологи зөрчсөн бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2. Ургамлын хорио цээр тогтоосон үед баримтлах журмыг зөрчсөн бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
3. Ургамал хамгаалах бүтээгдэхүүн (3.1) үйлдвэрлэх, (3.2) хадгалах, (3.3) тээвэрлэх, (3.4) худалдаалах, (3.5) хэрэглэх заавар, технологи, стандартыг зөрчсөн, эсхүл зориулалтын бусаар ашигласан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
4. Ашиглаж, эзэмшиж байгаа, өмчилсөн газарт нь ургамлын хөнөөлт организм илэрвэл өөр газарт тархахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг шуурхай авах, холбогдох байгууллагад мэдэгдэх хуульд заасан үүргээ биелүүлээгүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
5. Ургамал, түүнээс гаралтай түүхий эдийг тээвэрлэх, борлуулахдаа тухайн сум, дүүргийн Засаг даргын Тамгын газраас бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ аваагүй бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
6. Албан ёсны сорилт, туршилт, шинжлэх ухаан, сургалтын зорилгоор сорт сонгох, бүтээхэд ашиглахаас бусад тохиолдолд хөнөөлт организмыг Монгол Улсын нутаг дэвсгэрт нэвтрүүлсэн, нүүлгэн шилжүүлсэн, хадгалсан, үржүүлсэн, тараасан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Зөрчлийг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан ба харьяалал. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлд зааснаар Зөрчлийн тухай хуулийн 7.8 дугаар зүйлийн Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль зөрчих зөрчлийг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан болон харъяаллыг доорх хүснэгтээр харуулав. Үүнд:

Эрх бүхий албан тушаалтан	Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харьяалал
Зөрчлийн тухай хуулийн 7.8 дугаар зүйл. Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль зөрчих	
Байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37) Ургамал хамгааллын хяналтын улсын байцаагч (6.48)	Зөрчлийн тухай хуулийн 7.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг
Улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч (6.27) Байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37) Ургамал хамгааллын хяналтын улсын байцаагч (6.48)	Зөрчлийн тухай хуулийн 7.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг
Байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37) Ургамал хамгааллын хяналтын улсын байцаагч (6.48)	Зөрчлийн тухай хуулийн 7.8 дугаар зүйлийн 3, 4, 5, 6 дахь хэсэг

Дээрх хүснэгтээс харахад, Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль зөрчих зөрчлийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.27-д заасан улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч, мөн хуулийн 6.37-д заасан байгаль орчны хяналтын улсын байцаагч болон тус хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.48-д заасан ургамал хамгааллын хяналтын улсын байцаагч нар харьяалагдах хэсгийн зөрчлийг тус тус шалган шийдвэрлэх эрхтэй байна.

Хуулийн нэр томьёоны тайлбар. Зөрчлийн тухай хуулийн 7.8 дугаар зүйлд заасан зөрчилтэй холбогдох нэр томьёог Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуульд тайлбарласан байдаг бөгөөд тэдгээрийг дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

“Ургамал” гэж байгалийн болон таримал бүх төрлийн ургамал, түүний үр, бусад ургал эрхтнийг,

“Ургамлын гаралтай бүтээгдэхүүн” гэж ургамлын боловсруулаагүй түүхий эд болон шинж чанар, боловсруулалтын онцлогоос хамаарч хөнөөлт организм нэвтрэх, тархах эрсдэлийг үүсгэж болзошгүй бүтээгдэхүүнийг,

“Хөнөөлт организм” гэж ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүнд хөнөөл учруулдаг ургамал, амьтны, эсхүл эмгэг төрүүлэгчийн аливаа зүйл, омог, биологийн төрөл, зүйлийг,

“Хорио цээртэй хөнөөлт организм” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт илрээгүй боловч хил дамнан орж ирж аюул учруулж болзошгүй, эсхүл илэрсэн ч өргөн тархаагүй, эрсдэл, нөлөөллийг бууруулах арга нь тодорхой, энэ хуулийн 4.1.12-т заасан эрсдэлийн шинжилгээгээр эдийн засгийн хохирол учруулж болзошгүй нь тогтоогдсон хөнөөлт организмыг,

“Гоц хөнөөлт организм” гэж энэ хуулийн 4.1.12-т заасан эрсдэлийн шинжилгээгээр эдийн засаг, байгаль, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөө ихтэй болох нь тогтоогдсон хорио цээртэй хөнөөлт организмыг,

“Зохицуулалттай хорио цээргүй хөнөөлт организм” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт өргөн тархсан, урьдчилан сэргийлэх, тэмцэх арга нь тодорхой, энэ хуулийн 4.1.12-т заасан эрсдэлийн шинжилгээгээр эдийн засгийн хохирол багатай нь тогтоогдсон хөнөөлт организмыг,

“Ургамлын эрүүл мэнд” гэж ургамлын хөнөөлт организмгүй байдлыг,

“Ургамлын эрүүл мэндийг хамгаалах” гэж ургамлын хөнөөлт организмын гаралт, тархалтаас урьдчилан сэргийлэх, эдийн засгийн хор хөнөөлийг бууруулах, хөнөөлт организмгүй байдлыг тогтоох цогц үйл ажиллагааг,

“Ургамлын эрүүл ахуйн үзлэг” гэж улсын байцаагчаас ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүн, зохицуулалттай эд, материалд хөнөөлт организм байгаа эсэх болон эрүүл ахуйн шаардлагад нийцэж байгаа эсэхийг тогтоох үйл ажиллагааг,

“Зохицуулалттай эд, материал” гэж хөнөөлт организмыг тээх, эсхүл дамжин тархаах эрсдэлтэй ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүн, тэдгээрийг үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, худалдаалахад ашиглах сав, баглаа боодол, ачаа тээш, тээврийн хэрэгсэл, хөрс, өөр бусад организм зэрэг ургамлын эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээ авах шаардлагатай бүх төрлийн эд материалыг,

“Ургамал хамгаалал” гэж ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүнийг хамгаалах зорилгоор хөнөөлт организмыг илрүүлэх, гаралт, тархалтыг хязгаарлах, тэмцэх үйл ажиллагааг,

“Эрсдэлийн шинжилгээ” гэж тухайн илэрсэн организмыг биологийн болон бусад шинжлэх ухааны судалгаа, эдийн засгийн тооцоонд үндэслэн эдийн засаг, байгаль, нийгэмд үзүүлэх нөлөөлөл, хөнөөлийн түвшин, түүний эрсэг хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох үйл ажиллагааг,

“Хорио цээртэй хөнөөлт организмгүй газар нутаг” гэж хөнөөлт организмгүй болохыг тандан судалж тогтоох, хянах, тэмцэх, устгах арга хэмжээ хэрэгжүүлдэг болохыг эрх бүхий байгууллагаас тодорхойлсон газар нутаг, эсхүл зарим хэсэг нутгийг,


“Мэргэжлийн байгууллага” гэж хөнөөлт организм гарсан, тархсан тохиолдолд ариутгал, халдваргүйжүүлэлт, устгал хийх аж ахуйн нэгжийг,

“Ургамал хамгааллын бүтээгдэхүүн” гэж хөнөөлт организмтай тэмцэхэд хэрэглэх химийн болон биологийн гаралтай бүтээгдэхүүнийг тус тус ойлгоно.

Зөрчлийн тухай хуулийн 7.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил нь ургамлын хөнөөлт организмтай тэмцэх технологи зөрчсөн үйлдэл байна.

Ургамлын хөнөөлт организмтай тэмцэх технологи зөрчсөн үйлдэл гэж хөнөөлт организмтай тэмцэх талаар төрийн захиргааны байгууллагаас гаргасан журмыг зөрчсөн үйлдлийг ойлгоно.

Ургамлын хөнөөлт организмыг хорио цээртэй хөнөөлт организм болон зохицуулалттай хорио цээргүй хөнөөлт организм гэж ангилдаг бөгөөд хорио цээртэй хөнөөлт организмыг хөнөөлийн зэрэглэлээс шалтгаалан гоц хөнөөлт организм гэж дотор нь ангилна.




Ургамлын хөнөөлт организмыг тандан судалгаа хийсний үндсэн дээр тогтооно. Албан ёсны сорилт, туршилт, шинжлэх ухаан, сургалтын зорилгоор сорт сонгох, бүтээхэд ашиглахаас бусад тохиолдолд хөнөөлт организмыг Монгол Улсын нутаг дэвсгэрт нэвтрүүлэх, нүүлгэн шилжүүлэх, хадгалах, үржүүлэх, тараахыг хориглодог.

Зөрчлийн тухай хуулийн 7.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан зөрчил нь ургамлын хорио цээр тогтоосон үед баримтлах журам зөрчсөн үйлдэл байна.
Засгийн газрын 2008 оны 190 дүгээр тогтоолоор Ургамлын хорио цээр тогтоосон үед баримтлах журам батлагдсан бөгөөд энэ журмын дагуу үйл ажиллагаа явуулна.

Тус журамд хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт ургамлын гадаад, дотоод хорио цээртэй өвчин, хог ургамал, хөнөөлт шавж, мэрэгч амьтны тархалтыг тогтоох, ургамлын гадаад, дотоод хорио цээртэй өвчнийг оношлох, хог ургамал, хөнөөлт шавж, мэрэгч амьтны төрөл, зүйлийг тодорхойлох, ургамлын гадаад, дотоод хорио цээртэй өвчин, хог ургамал, хөнөөлт шавж, мэрэгч амьтны голомтыг тодорхойлох, ургамлын гадаад, дотоод хорио цээртэй өвчин, хог ургамал, хөнөөлт шавж, мэрэгч амьтныг устгах, хорио цээр тогтоосон нутаг дэвсгэр, ургамлын гадаад, дотоод хорио цээртэй өвчин, хог ургамал, хөнөөлт шавж, мэрэгч амьтан байгаа байгууламжид ариутгал, халдваргүйжүүлэлт хийхийг заасан байна.

Хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт орох, гарах болон дамжин өнгөрүүлэх зурвас байгуулж шалган нэвтрүүлэх, ариутгал халдваргүйжүүлэлтийг тус цэгүүдэд хийж, хүний болон машин техникийн хөдөлгөөнийг хянаж зохицуулна. Хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт орох, гарах, дамжин өнгөрөх зөвшөөрөлтэй иргэн, тээврийн хэрэгслийг зөвхөн тогтоосон орох, гарах цэг, дамжин өнгөрөх зурвасаар нэвтрэхийг зөвшөөрнө.

Зөрчлийн тухай хуулийн 7.8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан зөрчил нь үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, худалдаалах, хэрэглэх заавар, технологи, стандартыг зөрчсөн, зориулалтын бусаар ашигласан үйлдэл байна.



Ургамал хамгаалах бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээг доорх тохиолдол бүрд авна. Үүнд:

- Үйлдвэрлэх
- Хадгалах
- Хураах, савлах
- Тээвэрлэх
- Худалдах зэрэг болно.

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хилээр дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, хадгалах, худалдах, тээвэрлэх, ашиглах, устгах явцад хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, гарсан хор уршгийг арилгах арга хэмжээ болон холбогдох зардлыг өөрийн хөрөнгөөр авч хэрэгжүүлнэ.

Химийн хорт болон аюултай бодис хадгалах агуулахын байршлыг холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн зохих шатны Засаг дарга тогтооно.

Химийн хорт болон аюултай бодисыг түүний онцлог шинж чанарыг нь харгалзан зориулалтын тусгай агуулахад батлагдсан журмын дагуу хадгална. Түүнд хадгалж байгаа химийн хорт болон аюултай бодисын сав, баглаа боодол нь тухайн бодисын нэр, анхааруулах тэмдэг, аюулын шинж чанарыг тод, томоор бичсэн шошготой байна. Хэрэв химийн хорт болон аюултай бодис алдагдсан тохиолдолд түүнийг эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь цагдаа, тагнуулын болон холбогдох бусад байгууллагад 24 цагийн дотор мэдэгдэж, эрэн сурвалжлах арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд бүх талын туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

Химийн хорт болон аюултай бодис үйлдвэрлэх, хадгалах, ашиглах үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тухайн бодисын эрсдэлийн үнэлгээг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дагуу заавал хийлгэнэ. Эрсдэлийн үнэлгээнд тухайн химийн хорт болон аюултай бодисын хор, аюулын шинж чанар, болзошгүй эрсдэлийг судлан тодорхойлох, түүнээс сэргийлэх арга хэмжээ болон хаягдлыг хоргүйжүүлэн устгах асуудлыг тусгана.

Ургамал хамгааллын бүтээгдэхүүнийг **худалдаалах байр**, **хадгалах агуулахад** хийсэн байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлтийг үндэслэн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг заавал хийлгэж, хэрэгжилтийг хангаж ажиллах зайлшгүй шаардлагатай.

Ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүнийг хураах, савлах, **тээвэрлэх,** хадгалах, худалдах тохиолдолд Тариалангийн тухай хуулийн 23.3-д заасан мэдээллийн сангаас бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээг авах бөгөөд пестицидийг турших, бүртгэх, ашиглах, импортлох, **тээвэрлэх,** хадгалах, худалдахтай холбогдсон харилцааг Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулиар зохицуулна.

Ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүнийг хураах, савлах, тээвэрлэх, хадгалах, **худалдах** тохиолдолд Тариалангийн тухай хуулийн 23.3-д заасан мэдээллийн сангаас бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээг авч, мөн пестицидийг турших, бүртгэх, ашиглах, импортлох, тээвэрлэх, хадгалах, **худалдахтай** холбогдсон харилцааг Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулиар зохицуулна.

Ургамал хамгааллын бүтээгдэхүүнийг импортлох, **худалдаалах** тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, хүчингүй болгохтой холбогдсон харилцааг Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.


Хэрэглэх заавар, технологи, стандартыг зөрчсөн гэж пестицидийг ашиглан ургамлын хөнөөлт организмтай тэмцэх тохиолдолд тухайн пестицидийн нэр, төрөл, хэмжээ, хор аюулын лавлах мэдээлэл, ашиглах зориулалтын талаар үйлдвэрлэгч, эсхүл албан ёсны борлуулагчаас дагалдуулсан, эсхүл эрдэм шинжилгээний байгууллагаас баталсан технологийн зааврыг зөрчихийг ойлгоно.

Зориулалтын бусаар ашигласан гэж пестицидийг ашиглах зориулалтаас өөр зориулалтаар ашигласан үйлдэл байна.

Зөрчлийн тухай хуулийн 7.8 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан зөрчил нь урьдчилан сэргийлэх арга хэмжээг шуурхай авах, холбогдох байгууллагад мэдэгдэх хуульд заасан үүргээ биелүүлээгүй зөрчил байна.



Зөрчлийн тухай хуулийн 7.8 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан зөрчил нь ургамал, түүнээс гаралтай түүхий эдийг тээвэрлэх, борлуулахдаа бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ аваагүй зөрчил байна.



Иргэн, хуулийн этгээд нь ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүнийг **тээвэрлэх,** худалдах тохиолдолд Тариалангийн тухай хуулийн 23.3-д[21] заасан мэдээллийн сангаас бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ авна.

Зөрчлийн тухай хуулийн 7.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасан зөрчил нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хөнөөлт организмыг хуульд заасан зориулалт бусаар нэвтрүүлсэн, нүүлгэн шилжүүлсэн, хадгалсан, үржүүлсэн зөрчил байна.

21 Тариалангийн тухай хуулийн 23.3.Тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тариалангийн үйлдвэрлэлийн мэдээллийн сантай байна



3.5.3. Байгалийн ургамлын тухай хууль зөрчих зөрчлийг шалгахад анхаарах зарим асуудал

Байгалийн ургамлын тухай хууль зөрчих зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааг явуулахдаа дараах зүйлсийг анхаарч, ажиллагааг гүйцэтгэх нь зүйтэй. Үүнд:

- Элбэг ургамлын зохих зөвшөөрөл, ховор ургамлыг ашиглах болон гадаад улсад гаргах зөвшөөрөлтэй эсэх талаар лавлагаа авах. Зөвшөөрөл, гэрчилгээ, эрхийн бичиг нь нэгдсэн кодтой тохирч байгаа эсэхийг шалгах
- Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоол, 2004 оны 165 дугаар тогтоол, 2015 оны 410 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад тухайн ургамал байгаа эсэхийг шалгаж, тогтоолын холбогдох хэсгийг хавсаргах
- Байгалийн ховор ургамлыг ахуйн хэрэгцээнд, элбэг ургамлыг үйлдвэрлэлийн түүхий эд болгон ашиглах, орлого олох зорилгоор түүсэн, бэлтгэсэн, худалдсан эсэх
- Байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах ач холбогдолтой нутаг дэвсгэр, бэлчээр, хадлангийн газар, мал тэжээх зориулалтаар ашиглахыг хориглосон газар үйлдвэрлэлийн зориулалтаар ургамал түүж бэлтгэсэн, эсхүл мал бэлчээсэн эсэх
- Ургамлыг түүж бэлтгэх журам зөрчсөн, эсхүл ахуйн зориулалтаар ашиглахаар түүж бэлтгэсэн ургамлыг үйлдвэрлэлийн түүхий эд болгон ашигласан зэрэг үйлдлийн аль нь болохыг тогтоохын тулд холбогдогч, гэрч, хохирогчоос мэдүүлэг авах
- Мэдүүлэг авахдаа ашигласан техник хэрэгслийн марк, төрөл, хүчин чадал, тоо хэмжээ, шатахууны татан авалт, түүсэн, бэлтгэсэн, худалдсан хэмжээ, үнэ, хамрагдсан ажиллагсад, цалин олгосон тооцоо, хөдөлмөрийн гэрээ хийгдсэн эсэх, нийгмийн даатгалын төлөлт, улс орон нутгийн төсөвт төлсөн татвар, хураамжийн хэмжээ зэргийг тодруулж хэвших
- Эрх бүхий албан тушаалтан, байгаль орчны хяналтын улсын байцаагч нар Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны А/603 дугаар тушаалаар батлагдсан “Нэн ховор, ховор, зарим элбэг ургамлын экологи-эдийн засгийн үнэлгээ”-г ашиглан зөрчлийн улмаас ургамлын зүйлд учирсан хохирол, нөхөн төлбөрийг шууд тооцох боломжтой.
- Тухайн зөрчлийн улмаас хор хохирол хүлээсэн байгууллага, иргэнийг хохирогчоор хуульд заасан үндэслэл журмын дагуу мэдүүлэг авч энэ тухай тэмдэглэл үйлдэнэ.

Мэдүүлгийн эхэнд тухайн зөрчлийн талаарх мэдүүлж буй бүх зүйлсийг үгчлэн, дэлгэрэнгүй бичих бөгөөд үүний дараа холбогдох асуудлаар тодруулан мэдүүлэг авна. Мэдүүлгийг авахдаа Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.8, 4.9-д заасан журмыг баримтлан явуулна.

- Зөрчил үйлдэж олсон элбэг болон ховор ургамал, тэдгээрийн үнэ, хэрэглэсэн зэвсэг, тээврийн хэрэгсэл, унаа хөсөг болон бусад хэрэгслийг эд мөрийн баримтаар хураан авах битүүмжлэх ажиллагааг прокурорын хяналттай явуулах, хөдөө хээрийн нөхцөлд эсхүл шөнийн цагаар хойшлуулшгүй тохиолдолд хураан авахдаа эхлээд прокурорт даруй мэдэгдэж ажиллагаа дууссанаас хойш 24 цагийн дотор холбогдох баримтын хамт хүргүүлнэ. Эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт зэргийг нарийвчлан тооцох, эдгээрт гарах зардлыг хадгалагч, хамгаалагч байгууллага, иргэнээр тодорхойлуулан удирдлагад танилцуулж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны зардлаас гаргуулах
- Ховор ургамал нь хадгалалтын нарийн нөхцөл шаарддаг, төрийн байгууллагуудын буруутай үйлдлээс хөгцөрч муудах эрсдэл ихтэй бөгөөд үүний улмаас сөрөг үр дагаврууд гарч болзошгүй учир түргэн муудах эд мөрийн баримтын хувьд зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааг цаг алдалгүй шуурхай явуулах
- Эд мөрийн баримтаар хураагдсан эд зүйл, тээврийн хэрэгслийн эзэмшигч, өмчлөгчийг тогтоож, хөрөнгийн үнэлгээ хийлгэх арга хэмжээ авах
- Зохих зөвшөөрөлгүй болон зөвшөөрөлд заасан хугацаа, хэмжээ, зориулалт, ургамал түүж бэлтгэх журам зөрчсөн бол бэлтгэсэн ургамал нь ямар зүйлийн ургамал болох, ямар ургамлын үр эрхтэн болохыг үзлэг хийж тогтоох. Үзлэгээр тухайн зөрчилд заагдсан ургамал нь зөрчлийн газарт ургаж байгаа эсэх, бэлтгэсэн байдал, газрын хэв шинж, эвдэрсэн байдал, ургамлыг хэрхэн бэлтгэсэн, ямар уут, сав баглаа боодолтой, боловсруулсан эсэх (цайруулсан, иш толгойг тайрсан, багцалсан, үр идээг салгасан, сүүдэрт хатаасан г.м), мөн харагдах байдал, өнгө, үнэр, хэлбэр дүрс, хүндийн жин, муудсан хөгцөрсөн шинж байгаа эсэх зэргийг мэргэжилтэн оролцуулан тогтоох шаардлагатай.
- Ургамлын талаарх зөвшөөрлийн бичиг, гэрээ зэрэг бичиг баримт нь эргэлзээтэй, үнэн эсэх нь тодорхойгүй, хуулбарласан байж болзошгүй баримт материал гаргаж өгвөл тухайн бичиг баримтад үзлэг хийж, материалын шинж онцлогийг нарийн дурдсан тэмдэглэл хөтөлж, гарын үсэг зуруулж хураан авах. Тухайн баримтыг үндэслэн холбогдох гэрчээс мэдүүлэг авах, эрх бүхий байгууллагаас лавлагаа хүсэх, илт хуурамч бичиг баримт үйлдсэн, зөрчлийг хаацайлахын тулд албан тушаалтнаас хуурамч баримт бичиг хийж ирүүлсэн бол прокурорт мэдэгдэж шуурхай шилжүүлнэ.
- Амьдрал дээр түгээмэл үйлдэгддэг хуш модны самартай холбоотой зөрчлийн хувьд самрыг хаанаас ямар эрхийн бичиг, гэрээний дагуу, хэдий хугацаанд бэлтгэсэн талаарх баримт бичгүүдэд нэн даруй үзлэг хийж, холбогдох ажиллагааг хийх
- Самрыг сав, баглаа боодолтой нь нэг бүрчлэн жигнэж, хэдий хэр хэмжээтэй цайруулсан юм уу яснаас нь салгасан үр идээний аль нь болохыг тогтоох
- Шинжилгээнд зориулж дээж авахдаа уут савтай самар, үр идээний олон хэсэг, үе давхаргаас дээж авч, эрүүл ахуйн шаардлага хангах эсэхийг тогтоолгохоор шинжээч томилох
- Самар нь түргэн муудаж, эрүүл ахуйн шаардлага хангахгүй болдог учир “түргэн муудах буюу гэмтэх эд мөрийн баримт”-ыг хэрхэх талаарх хуулийн шаардлага хангаж шүүхээр даруй шийдвэрлүүлнэ.
- Шинжээчээс шинжилгээнд хүргүүлж байгаа самрын түгээмэл болоод шинжлэх ухааны нэр, хуулиар хамгаалагдсан ховор ургамал мөн эсэх, тархац, энэ жилийн самар мөн эсэх (эсвэл хэдэн оны ургац болох), уг самрыг түүж бэлтгэсэн болон хадгалсан хугацааг тогтоох боломжтой эсэх, самрыг хаанаас түүж бэлтгэсэн болохыг

тогтоох боломжтой эсэх, самраас хөнөөлт болон ургамлын ямар нэг өвчин илэрсэн эсэх, энэ самрыг хүнсний зориулалтаар ашиглаж, хэрэглэж болох эсэх, болц гүйцсэн эсэх, самрын экологи-эдийн засгийн хохирлын үнэлгээг тогтоох зэрэг асуултуудыг тодруулж болно.

Байгалийн ургамлыг түүж бэлтгэсний дараа хатааж ашигладаг нийтлэг технологитой учраас хатаах ажиллагаа хийдэг. Тодорхой цаг хугацааны дараа түүж бэлтгэсэн ургамал хатаж хэлбэр, дүрс, жин, өнгө, чийгээ алддаг. Тодруулбал, түүж бэлтгэсний дараа ургамлын үндэс чийгээ 70%-аар алддаг бол иш, навч, цэцэг, үр жимс чийгээ 80-85%-аар алдан хатаж, жин нь эрс багасаж хорогдоно. Тухайлбал, 100 кг ургамлын үндэс бэлтгэхэд 70 кг-аар хорогдож, 30 кг нь үлддэг норматив (бүрэн хатсан ургамлын түүхий эд 10-15%-ийн чийглэгтэй) байна. Мөн буруу хатааж хорчийсон, хэлбэр дүрс нь өөрчлөгдсөн ургамлын түүхий эдийг шууд танихад нэлээд төвөгтэй.

Энэ төрлийн хэрэгт хэргийн газар, хэргийн чухал нотлох баримт болох ургамлын түүхий эдэд үзлэгийг явуулах нь зүйтэй. Үзлэг хийхдээ ургамал судлалын мэргэжилтнийг оролцуулах нь илүү үр дүнтэй.

Үзлэгээр тухайн ургамал нь үзлэг хийж байгаа газарт ургаж байсан эсэхийг нарийвчлан үзэж, тухайн газрын эвдрэл, ул мөрийн үүссэн хязгаарыг нүдээр үзэж, нөхцөл байдлыг үнэлж, үзлэг явуулах талбайн хэмжээ, хязгаарыг тогтооно. Хязгаар тогтоосон талбайг байршил тогтоогчоор хэмжиж, тойм зургийг авч баримтжуулна. Үзлэгээр илэрч болох ул мөрийг гурван хэсэгт ангилан үзнэ. Үүнд:

- Байгалийн ургамлыг түүж бэлтгэх явцад эвдрэлд орсон газрын шинж байдал, ургамлын эрхтний хаягдал, үлдэгдэл
- Ургамлыг түүж бэлтгэхэд ашигласан багаж, техник хэрэглэл, тээврийн хэрэгсэл
- Гутал, хөл, тээврийн хэрэгслийн мөр, тамхины иш, хог хаягдал зэрэг бусад ул мөр зэрэг болно.

Үзлэгийн тэмдэглэлд тухайн газрын онцлог, төрх байдал, эвдрэлд орсон эсэх, ургамлыг түүж бэлтгэсэн ул мөр болох цайруулсан, багцалсан, үр, эрхтнээс нь салгасан, цэвэрлэсэн, ахуйн хог хаягдлыг үлдээсэн ул мөр зэргийг тодорхой нарийн тусгана. Ургамлыг бэлтгэхэд ашигласан багаж хэрэгсэл, боож багласан шуудай, уут сав, зөөж тээвэрлэсэн тээврийн хэрэгсэл, өөр бусад ул мөрийн нарийн үзлэгийг хийнэ.

Эд мөрийн баримтаар хураагдсан ургамалд үзлэг хийхдээ тухайн ургамлын түүхий эдийн гадаад шинж, төрх байдал, ургамлын хэлбэр, хэмжээ, хуурай, хатсан, чийгтэй, норсон, муудсан, хөгцөрсөн, үнэр, өнгө, ургамлын жин зэргийг тодорхой тусгана.

Хэрвээ хууль бусаар ургамлын түүхий эдийг зөөж тээвэрлэж байгаа үйлдлийг илрүүлэн шалгаж байгаа тохиолдолд тээврийн хэрэгсэлд үзлэгийг явуулна. Ингэхдээ тээврийн хэрэгслээр хаанаас хаашаа чиглэлд явж байгааг жолоочоос тодруулан мэдүүлэг авч, улмаар тээврийн хэрэгслийн аль хэсэгт ургамлын түүхий эд хэдий хэмжээтэй байгааг үзлэгийн тэмдэглэлд нарийн тусгаж, гэрэл зураг, дүрс бичлэгээр баталгаажуулна.

Ургамлыг нутгийн иргэд янз бүрээр нэрлэдэг. Тухайлбал, дэрвэгэр жиргэрүү (шинжлэх ухааны нэр (Латин) нь *Saposhnikovia divaricata* (Turcz.) Schischkin)) ургамлыг гоньд, хонин шүүр, шүхэргэнэ, хонин шүхэр, зэгнэ зэргээр нэрлэдэг. Тийм учраас ургамлыг таних мэргэжилтэн, шинжээч томилох шаардлагатай. Шинжээч ургамлын түгээмэл нэр (Монгол)-ээс гадна, шинжлэх ухааны нэрээр нь ямар зүйлийн ургамал болохыг шинжлэн тогтоож, тухайн нэрийн

дагуу эрх бүхий албан тушаалтан “нэн ховор юм уу ховор ургамал”-ын жагсаалтад байгаа эсэхийг тогтооно.

Иймд энэ хэрэгт эд мөрийн баримтаар хураагдсан ургамлын түүхий эдэд заавал шинжилгээ хийж, шинжээч томилох шаардлагатай.

Хууль бусаар байгалийн ургамлыг бэлтгэсэн зөрчлийн хэрэгт эд мөрийн баримтаар хураагдсан ургамлаас шинжилгээнд хүргүүлэхдээ тухайн ургамлын аль болох бүтэн, бүхэл хэсэг (эвдэрч бутраагүй, нунтаг үйрмэг болоогүй)-ээс шилж сонгон дээж болгон авч шинжилгээнд хүргүүлнэ. Шинжээчид тавих асуултаа сайтар боловсруулж, оновчтой зөв тавьснаар шинжээч тэдгээр асуултуудад бүрэн дүүрэн, үнэн зөв, бодит хариултыг өгнө.

Шинжилгээ томилж буй байдлаас үзэхэд, тухайн шинжээч хариулах боломжгүй эсвэл тухайн мэргэжилтний мэдлэгээс давсан, өөр нарийн мэргэжилтэн хариулах, эсвэл нэмэлт шинжилгээ хийлгэж байж дүгнэлт гаргах зэрэг асуудлуудыг шууд нэг шинжилгээ хийлгэх тогтоолоор хандаж байгаа алдаа түгээмэл ажиглагдаж байна.

Иймд түгээмэл үйлдэгдэж байгаа хэрэгт стандарт асуултыг боловсруулах, хэргийн онцлогоос шалтгаалж мэргэжилтнүүдтэй байнга холбоо харилцаатай байж, ямар асуулт асууж хариулт авч болох талаар зөвлөлдөж, ярилцаж байх нь цаг хугацаа хэмнэхээс гадна, тухайн зөрчлийг шалгах ажиллагааг түргэн шуурхай болгож, хэргийн учир шалтгаан, нөхцөл байдлыг үнэн зөв тогтоох зэрэг олон талын ач холбогдолтой юм.

Тухайн төрлийн хэрэг, зөрчлийн улмаас байгаль орчинд учирсан хохирлын хэмжээг тогтоохын тулд байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн төлбөр тооцох аргачлалаар мэргэжлийн байгууллага тогтооно. Хохирол тооцохын өмнө эд мөрийн баримтаар хураагдсан ургамлын зүйл, түүхий эдийн жин, түүсэн хугацаа, хамарсан талбай зэргийг зөрчил шалгах ажиллагаагаар тогтоосон байх шаардлагатай.

Байгалийн ургамлыг хууль бус үйлдлээс хамгаалах нь байгаль орчинд нэн чухал ач холбогдолтой юм. Учир нь хууль бусаар ургамлын түүхий эдийг их хэмжээгээр бэлтгэх нь тухайн зүйл ургамлын тархац, нөөцийг эрс багасгаж, улмаар байгаль дээрээ устах эрсдэлд хүргэж буй гол шалтгааны нэг болсоор байна. Тухайлбал, тал хээрийн бүсэд тархсан дэрвэгэр жиргэрүү ургамлыг түүж бэлтгэхэд 80 см-ээс 1 м хүртэлх эгц доош ургасан голлосон үндсийг нь эмийн түүхий эд болгон бэлтгэснээр энэ зүйл ургамал дахин сэргэн ургах, хөгжих боломжгүй болж, тархац, нөөц нь эрс багасаж байгаагийн зэрэгцээ тухайн нутгийн хөрсний хэв шинж өөрчлөгдөх, хуурайшиж, эвдрэх нөхцөлийг бий болгож, улмаар газрын доройтол, цөлжилт нэмэгдэхэд тодорхой хэмжээгээр нөлөөлж байна. Иймээс учраас байгаль орчинд учруулсан хохирлыг тооцоход тухайн ургамлын түүхий эдийн жин, хаанаас түүсэн зэрэг нь бодит хохирлыг тогтооход чухал ач холбогдолтой.

Ургамлын аймагт учруулсан хохирлыг тогтооход, төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан журмыг баримтлан тухайн орон нутгийн захиргаанд хохирол, нөхөн төлбөрийн акт тогтоолгох албан бичиг хүсэлт хүргүүлэн шийдвэрлүүлнэ. Тус журамд зааснаар тухай орон нутгийн сум, дүүргийн Засаг дарга, гурав түүнээс доошгүй гишүүнтэй ажлын хэсэг томилно. Ажлын хэсэгт хууль хяналт болон байгаль орчны байгууллагуудын холбогдох албан тушаалтнууд оролцож, ургамлын аймагт учруулсан шууд болон шууд бус хохирлын хэмжээг тогтоож, ургамлын нөхөн төлбөрийн акт үйлдэнэ. Ажлын хэсгийн судалгаа хийж гаргасан актыг тухайн аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргаар баталгаажуулна. Ингэж гэмт хэрэг, зөрчлийн хохирлын хэмжээг тогтооно.

Байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэсэн хэрэгт ургамлын аймагт учруулсан хохирлын хэмжээг тооцохдоо, ургамлын экологи-эдийн засгийн үнэлгээгээр тогтоож, нөхөн төлбөрийг Байгаль орчныг хамгаалах тухай хуульд зааснаар 5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр тооцож тогтооно.

Энэ төрлийн хэрэг зөрчлийг шалгах, нотлох баримтыг бүрдүүлэхэд анхаарах зүйл бол аливаа ургамлыг түүж бэлтгэхэд тусгайлан бэлтгэсэн хэрэгсэл ашигладаг. Жишээлбэл, дэрвэгэр жиргэрүүг бэлтгэхэд газар ухах урт төмрөөр хийсэн хэрэгсэл, самрыг бэлтгэхэд муна, шигшүүр, баглаа боодол болгон ашиглахад зориулж шуудай, сав, зөөж тээвэрлэхэд зориулсан тээврийн хэрэгсэл зэргийг бэлтгэдэг.

Байгалийн ургамлын тухай хууль зөрчих зөрчлийг шалгах, нотлох баримт бүрдүүлэхэд анхаарах зарим зүйлсийн талаар онцгойлон дурдвал, үзлэг хийхэд ургамлын зүйл ачсан, тээвэрлэж яваа тээврийн хэрэгсэл, тэдгээрийг буулгасан орчин, эд зүйлс (шуудайтай ургамал г.м), тэдгээрийг бэлтгэсэн газарт үзлэг хийнэ.


Үзлэгээр илэрсэн зүйлийг нотлох баримжаалсан ба тоймчилсон гэрэл зураг авч, ямар цэгээс, ямар аргаар, юуг харуулж, хэчнээн гэрэл зураг авсныг үзлэгийн тэмдэглэлд тусгаж, хавсаргах бөгөөд гэрэл зургийн үзүүлэлтийг хаалтад бичнэ. Гэрэл зургийг авсан техникийн нөхцөлийг энд дэлгэрэнгүй тусгана. Хэрэв хөдөө байгаа бол тухайн газрыг баримжаалахаар “GPS” байршил тогтоогч багаж ашиглан координатыг авч, тухайн газар, орчны зургийг кадастрын албаар гаргуулж авах, ийм боломжгүй бол уг ажиллагааг суурин газарт байгаа, боломжтой алба, ажилтанд даалгах, интернэт сайтаас татуулж авах зэргээр илүү нарийвчилж болно.


Үзлэгийн явцад схем, план зураг үйлдэж газар орны байдлыг схемээр зурж, нүдэн баримжаагаар буулгах аргыг хэрэглэнэ. Энэ зургаар харуулсан объектуудыг баримжаалахдаа ойролцоо хэмжээ хэрэглэж болох ба газар дээр нарийвчлан хэмжинэ. Жишээлбэл, аймгийн төвөөс баруун хойд зүгт 230 орчим км, сумын төвөөс чанх урагш 80 км г.м. Хэргийн газрын байршил, ялангуяа үзлэг хийсэн газрын захын дөрвөн цэгийн координатыг GPS багаж ашиглан (мөн ухаалаг утасны аппликэйшн, GPS Map camera г.м) тогтоох нь зүйтэй.

Схем, план үйлдэхдээ дүрслэх хавтгай (планшет) дээр цаасаа байрлуулж, луужингийн “хойд-урд” зүгийн цэгийг холбосон шугамыг цаасны босоо ирмэгт параллель байрлуулна. Луужингийн зүү хойд зүгийг заах чигт цаасны хэвтээ дээд ирмэгийг, урд зүгийг заах чиглэлд хэвтээ доод ирмэгийг харуулан байрлуулаад схемийн зүүн дээд буланд луужингийн заалтыг зурж үзүүлнэ.

GPS байршил тогтоогч багажгүй үед аливаа объектыг схемд зурж оруулахдаа, албан хаагч өөрийн зогсож буй цэгээс эхлэлийн цэгийг авч баримжаалан оруулна. Гурвалжин шугамын гипотенуз талыг цаасны хэвтээ доод ирмэгт тулгаж, нэг үзүүрийг планшет дээрх эхлэлийн цэгт байрлуулан тавина. Үүний дараа планшетыг өргөж нүдний түвшинд авчраад эхлэлийн цэгт байрлуулсан талыг хөдөлгөлгүйгээр, эсрэг өнцөг талыг эргүүлсээр хэмжиж буй объект руу яг чиглүүлэн тогтоож, түүн дээрээ зурж буй масштабын дагуу, шаардлагатай хэмжээг тэмдэглэж өгнө. Үзлэг хийж буй газарт бусад объектыг мөн үүний адилаар баримжаална. Баримжаалсан схем, планд баримжаалах цэгээр авсан ойролцоох төв суурин газар, төмөр замын өртөө, гол, нуур зэргийг нэрээр нь бичиж, чиглэл, зайг сум, тоогоор зааж үзүүлнэ.

Схем, планд зургийн толгой хэсэгт хаяг (ямар ажиллагааны тэмдэглэл, схем, план зураг болох), он, сар, өдөр, хэрэг зөрчлийн газрын нэр, үйлдсэн албан тушаалтан, масштаб, зүгийн тэмдэг, схем, планд оруулсан объект, зүйлийн жагсаалт (илрүүлж, тэмдэглэлд бичсэн дарааллаар) зэргийг тусгавал зохино.





Шүүх-ургамал судлал (шүүх-ботаник)-ын шинжилгээ. Ургамлын зүйлд хийх шинжилгээний үндсэн зорилго нь үйл явдал болж өнгөрсөн орчны ботаник бүрэлдэхүүн хэсэг тухайн үйл явдалтай холбоотой эсэхийг тогтоох, тэдгээрийг адилтгах, эдгээрт үндэслэн орон зай-цаг хугацааны шинж тэмдгүүдэд орсон өөрчлөлтийг тогтоох явдал болно.

Оношилгоо шинжилгээний зорилгын нэг нь шинжилгээнд ирүүлсэн зүйл дээр ургамлын гаралтай зүйл илрүүлэх байдаг. Шүүх-ургамал судлалын шинжилгээгээр тогтоох асуултыг дараах хоёр чиглэлээр тавьж болох юм. Үүнд:

1) Оношлох чиглэлд:
- Шинжилгээнд хүргүүлсэн зүйл дээр ургамлын гаралтай бичил хэсэг байгаа эсэх? Хэрэв байгаа бол тэдгээрийн шинжийг тодорхойлох?
- Тухайн ургамал ямар төрөл, зүйлд хамаарах, хэдэн настай ургамал болох?
- Шинжилгээнд хүргүүлсэн зүйл ургамлын аль хэсэг (үндэс, иш мөчир, навч г.м) болох? Үр, жимс, булцуу зэрэг нь ямар ургамлын гаралтай зүйл вэ?
- Шинжилгээнд ирүүлсэн ургамлын зүйл ямар нөлөөнд (механик, дулаан, хими, биологийн г.м) өртсөн бэ?
- Шинжилгээнд хүргүүлсэн ургамлын зүйлийн гэмтлийн шалтгаан юу вэ?
- Шинжилгээнд хүргүүлсэн ургамлын зүйл эх биеэсээ (бүхлээсээ) салсан, тасарсан механизм юу вэ?
- Тус холилдсон ургамлууд дотор ямар зүйлийн ургамал, хэдэн хувийг эзэлж байна вэ?

2) Адилтгах чиглэлд:
- Шинжилгээнд хүргүүлсэн навч, иш мөчир, үндэс зэрэг нь тодорхой нэг ургамлынх мөн эсэх?
- Шинжилгээнд хүргүүлсэн зүйл дээр байгаа ургамлын гаралтай бичил хэсэг тодорхой нэг ургамлынх, эдлэлийнх (жишээлбэл, чийрснийх), ургамлын холимгийнх мөн эсэх?
- Тодорхой ургамал буюу түүний хэсэг, ургамлын бичил хэсэг харьцуулах загвараар илгээсэн дээжтэй ерөнхий шинжээрээ адил эсэх?
- Тухайн ургамал тодорхой нэг нутагт ургаж байсан эсэх?

Бодлого 1

Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших Эхэн-Зулганайн баянбүрд нь Монгол орны говийн үзэсгэлэнт баянбүрдүүдийн нэг бөгөөд заг, хулс, сухай, хайлаас, жигд зэрэг ургамал бүхий баянбүрдийг үүсгэдэг. Зулганайн баянбүрдэд говьд ургадаг бүх ургамал ургадаг, ургамлын зүйлээр баялаг боловч эмзэг юм. Гэтэл нутгийн иргэд уг газраас өвс ургамлыг ихээхэн хэмжээгээр түүж авч хатаан эм боловсруулах үйлдвэрт тушаасан байна.

Асуулт:

1. Дээрх үйлдэл нь ямар хууль тогтоомж зөрчсөн вэ? Элбэг ургамал гэж юуг хэлэх вэ?
2. Энэ зөрчлийг шалгах ажиллагааны үед ямар ажиллагаа явуулах вэ?
3. Дээрх хууль бус үйлдэл нь Зөрчлийн тухай хуульд заасан ямар зөрчил болох вэ? Зөрчлийг зүйлчилнэ үү?
4. Зөрчил үйлдэгчид ямар шийтгэл оногдуулах вэ?

Хариулт:

1. Дээрх үйлдэл нь ямар хууль тогтоомж зөрчсөн вэ? Элбэг ургамал гэж юуг хэлэх вэ?
Байгалийн ургамлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2-т зааснаар ургамлыг түүний нөөц, нөхөн сэргэх чадварыг нь харгалзан нэн ховор, ховор болон элбэг гэж ангилдаг. Монгол Улсын нутаг дэвсгэрийн хуурай газар, усны бүх зүйлийн гуурст ургамал, хөвд, замаг, хаг, мөөг болон бичил биетнээс ургамлын сан бүрдэнэ.

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нэн ховор ургамлыг зөвхөн судалгаа, шинжилгээний, ховор ургамлыг ахуйн болон судалгаа, шинжилгээний, элбэг ургамлыг судалгаа, шинжилгээний, ахуйн, үйлдвэрлэлийн зориулалтаар тус тус ашиглаж болно гэж Байгалийн ургамлын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан.

Элбэг ургамал нь тархац, нөөц ихтэй, байгалийнхаа жамаар нөхөн сэргэх чадвартай ургамал юм. Мөн тус хуулийн 13 дугаар зүйлийн 1-д зааснаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага элбэг ургамлыг хүнсний, техникийн болон ургамлын гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулах зориулалтаар ашиглаж болно. Гэвч ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахыг хориглох газруудыг хуулиар тусгайлан заасан байдаг. Тухайлбал, байгаль орчны тэнцлийг хангах ач холбогдол бүхий (1) хот, тосгон, бусад суурины ногоон бүс, (2) гол, горхины эх болон нуур, цөөрмийн эргээс 2 км доторх газар, (3) нэн ховор амьтны байршил газар, (4) баянбүрд, (5) ургамлын бүрхэвч нь талхлагдсан газар, (6) элсний нүүлтээс хамгаалах ач холбогдол бүхий газар, (7) хөрсний элэгдлээс хамгаалах зурвас бүхий газар нутагт ургамлыг нөөцийнх нь хэмжээг үл харгалзан үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахыг хориглодог *(Байгалийн ургамлын тухай хуулийн 8 дугаар зүйл. Ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахыг хориглох газар)*.

Энэ тохиолдолд иргэд говийн баянбүрдэд ургадаг ургамлыг ихээхэн хэмжээгээр түүж, үйлдвэрт тушаах буюу үйлдвэрлэлийн зориулалтаар түүж, бэлтгэсэн байна.

2. Энэ зөрчлийг шалгах ажиллагааны үед ямар ажиллагаа явуулах вэ?
Энэ зөрчлийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.4 дүгээр зүйлд зааснаар эрх бүхий албан тушаалтан тус хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт зааснаар хуулиар харьяалуулсан зөрчлийг өөрөө илрүүлсэн бол зөрчлийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэнэ.

Хэрэв байгаль хамгаалагч илрүүлсэн эсвэл хэн нэгэн этгээд мэдээлэл ирүүлсэн бол эрх бүхий албан тушаалтан гомдол мэдээллийг хүлээн авч ажлын 5 өдрийн дотор шалгаж, хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх эсхүл зөрчлийн хэрэг нээх шийдвэрийн аль нэгийг гаргана.

Ургамал бэлтгэсэн тухайн газар талбайд үзлэг явуулна. Эрх бүхий албан тушаалтан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явц, үр дүнг баталгаажуулахаар тухайн ажиллагаанд хөндлөнгийн гэрчийг оролцуулж болно. Үзлэг хийх явцад шаардлагатай бол шинжилгээнд зориулж хэв загвар, дээж авах, эд хөрөнгө битүүмжлэх, эд зүйл хураан авах ажиллагааг явуулж болно. Эд мөрийн баримт болох ургамлыг хураан авна.

Эрх бүхий албан тушаалтан тухайн ургамлыг ямар зүйлийн ургамал болохыг тогтоох зорилгоор шинжилгээ хийлгэхээр шинжээч томилно. Мөн зөрчлийн нотлох баримтыг бүрдүүлэх зорилгоор гэрч, хохирогч, холбогдогчийн мэдүүлэг авах, Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших Эхэн-Зулганайн баянбүрд гэдгийг тогтоож баримтжуулах зорилгоор стандартаар баталгаажсан хэмжилт-хяналтын төхөөрөмж, GPS байршил тогтоогч багажаар координатыг авч, газар орныг тогтоох.

Байгалийн ургамлыг бэлтгэсэн зөрчлийн хэрэгт эд мөрийн баримтаар хураагдсан ургамлаас шинжилгээнд хүргүүлэхдээ тухайн ургамлын аль болох бүтэн, бүхэл хэсэг (эвдэрч бутраагүй, нунтаг үйрмэг болоогүй)-ээс шилж сонгон дээж болгон авч шинжилгээнд хүргүүлнэ. Шинжээчид тавих асуултаа сайтар боловсруулж, оновчтой зөв тавьснаар шинжээч тэдгээр асуултуудад бүрэн дүүрэн, үнэн зөв, бодит хариултыг өгнө.

Үзлэгийг ургамлын зүйл ачсан, тээвэрлэж яваа тээврийн хэрэгсэл, тэдгээрийг буулгасан орчин, эд зүйлс (шуудайтай ургамал г.м), тэдгээрийг бэлтгэсэн газар зэрэгт хийнэ. Мөн үзлэгээр илэрсэн зүйлийг нотлох баримжаалсан ба тоймчилсон гэрэл зураг авч, ямар цэгээс, ямар аргаар, юуг харуулж, хэчнээн гэрэл зураг авсныг үзлэгийн тэмдэглэлд тусгаж, хавсаргана. Гэрэл зургийг авсан техникийн нөхцөлийг бас дэлгэрэнгүй тусгана. Үзлэгийн явцад газар орны байдал, объектуудыг баримжаагаар харуулсан схем, план зураг үйлдэж хавсаргана.

3. Дээрх хууль бус үйлдэл нь Зөрчлийн тухай хуульд заасан ямар зөрчил болох вэ? Зөрчлийг зүйлчилнэ үү?
Энэ зөрчлийг Зөрчлийн тухай хуулийн 7.7 дугаар зүйлийн Байгалийн ургамлын тухай хууль зөрчих зөрчлийн 2 дахь хэсэгт заасан Байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах ач холбогдолтой нутаг дэвсгэр газар үйлдвэрлэлийн зориулалтаар ургамал түүж бэлтгэсэн гэсэн хэсгээр зүйчилнэ.

4. Зөрчил үйлдэгчид ямар шийтгэл оногдуулах вэ?
Зөрчилд холбогдогч хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож шийтгэл ноогдуулна.

Бодлого 2

Иргэн “А” Тайланд улс руу аялахаар явахдаа нэгэн цай болгон хандалж ургамал олж ихэд таалагдсан тул түүнийг ихээр нь түүж өөрийн эзэмшлийн талбайдаа үрслүүлжээ. Гэвч байгаль орчны хяналтын улсын байцаагч үүнийг олж илрүүлэн харь ургамал тарималжуулсан гэж таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулж шийтгэлийн хуудас үйлджээ.

Асуулт

1. Дээрх үйлдэл нь ямар хууль тогтоомж зөрчсөн вэ? Харь ургамал гэж юуг хэлэх вэ?
2. Энэ зөрчлийг шалгах ажиллагааны үед ямар ажиллагаа явуулах вэ?
3. Дээрх хууль бус үйлдэл нь Зөрчлийн тухай хуульд заасан ямар зөрчил болох вэ? Зөрчлийг зүйлчилнэ үү?
4. Зөрчил үйлдэгчид ямар шийтгэл оногдуулах вэ?

Хариулт

1. Дээрх үйлдэл нь ямар хууль тогтоомж зөрчсөн вэ? Харь ургамал гэж юуг хэлэх вэ?
Байгалийн ургамлын тухай хуулийн 2[1] дүгээр зүйлийн 6-д “харь ургамал” гэж улсын хилийн гаднаас зориудаар болон санамсаргүй байдлаар зөөвөрлөгдөн ирж, нутагшиж байгаа зүйл ургамал хэмээн эрх зүйн хувьд тодорхойлсон байдаг.

Энэ үйлдэл нь Байгалийн ургамлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт зааснаар Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр харь ургамлыг байгальд тарималжуулна гэсэн заалтыг зөрчсөн байна. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлд заасан энгийн зөвшөөрлийн жагсаалтын 1.3-д харь ургамлыг байгальд тарималжуулах зөвшөөрлийг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно. Зөвшөөрлийг түүний зорилго, олгох нөхцөл, үйл ажиллагааны онцлог, эрсдэлийн түвшнээс хамааруулан тусгай болон энгийн зөвшөөрөл гэж ангилна. Тухайн тохиолдолд энгийн зөвшөөрөл олгогдоно.

2. Энэ зөрчлийг шалгах ажиллагааны үед ямар ажиллагаа явуулах вэ?
Энэ зөрчлийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.4 дүгээр зүйлд зааснаар эрх бүхий албан тушаалтан тус хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт зааснаар хуулиар харьяалуулсан зөрчлийг өөрөө илрүүлсэн бол зөрчлийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэнэ.

Хэрэв байгаль хамгаалагч илрүүлсэн эсвэл хэн нэгэн этгээд мэдээлэл ирүүлсэн бол эрх бүхий албан тушаалтан гомдол мэдээллийг хүлээн авч ажлын 5 өдрийн дотор шалгаж, хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх эсхүл зөрчлийн хэрэг нээх шийдвэрийн аль нэгийг гаргана.

Эрх бүхий албан тушаалтан тухайн ургамал ямар зүйл ургамал болохыг тогтоох зорилгоор шинжилгээ хийлгэхээр шинжээч томилно. Шинжилгээ явуулахын тул шинжилгээнд зориулж дээж авч болно. Ургамал тарьсан тухайн газар орчин, талбайд үзлэг хийнэ.

3. Дээрх хууль бус үйлдэл нь Зөрчлийн тухай хуульд заасан ямар зөрчил болох вэ? Зөрчлийг зүйлчилнэ үү?
Уг үйлдэл нь Зөрчлийн тухай хуулийн 7.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар “Харь ургамлыг зөвшөөрөлгүйгээр байгальд тарималжуулсан, эсхүл гадаад улсаас оруулсан” гэсэн зүйл заалтаар хэргийг зүйчилнэ.

4. Зөрчил үйлдэгчид ямар шийтгэл оногдуулах вэ?
Зөрчил үйлдсэн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр эсвэл хуулийн этгээд байвал таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож хариуцлага хүлээлгэнэ.

Зөрчлийн тухай хуулийн 7.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан зөрчлийг гаалийн улсын байцаагч болон байгаль орчны хяналтын улсын байцаагч нар шалган шийдвэрлэнэ.

Бодит жишээ **Хөвсгөл аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх**

Үйл баримт
Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын 3 дугаар баг Чулуут зүрх гэх газарт иргэн А нохой дагуулан ан хийх зорилготой явж байгаад хяналт шалгалтаар явж байсан байгаль орчны хяналтын улсын байцаагч нартай тааралдсан байна. Иргэн А нь энэ үед 200 гр орчим хус модны чаг мөөг түүсэн байсан тул түүнд байгалийн дагалт баялаг зөвшөөрөлгүй түүсэн гэж үзээд Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч Б Зөрчлийн тухай хуулийн 7.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 150 нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 150,000 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулсан байна.

Аймгийн прокурорын газрын зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих ажил хариуцсан ахлах прокурор дээрх зөрчил шалган шийдвэрлэсэн хэргийг хянаад хэрэгт цугларсан зөрчлийн талаарх гомдол мэдээллийг хүлээж авсан эрх бүхий албан тушаалтны тэмдэглэл, холбогдогчийн мэдүүлэг болон бусад бичгийн нотлох баримтуудаар холбогдогч нь зөвшөөрөлгүйгээр хус модны чаг мөөг түүсэн зөрчил үйлдсэн гэж үзсэн байна. Гэвч зөрчлийн хэрэг бүртгэлтийн явцад цугларсан дээрх нотлох баримтууд нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн байна.

Үүнд: хууль бусаар түүсэн гэх чаг мөөгийг хураан авах ажиллагаа хийгээгүй, ямар хэмжээтэй түүж бэлтгэсэн болохыг тодорхойлоогүй, байгаль орчин, экологи-эдийн засагт учирсан хохирлыг тогтоолгоогүй нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.12 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт *Эрх бүхий албан тушаалтны хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, шинжилгээний объект нь хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал амьтанд хортой нөлөө үзүүлэх, нийтийн аюулгүй байдалд сөрөөр нөлөөлөх бодит үндэслэл бий болсон, эсхүл түргэн муудах, гэмтэх, устах, эсхүл зөрчлийг шийдвэрлэгдэх хүртэл чанар нь муудах хөрөнгө, орлого, эд зүйлийг эзэмшигчид нь буцаан өгөх боломжгүй тохиолдолд шүүхэд хүсэлт гаргаж шийдвэрлүүлнэ* гэснийг зөрчсөн байна.

Зөрчлийн тухай хуулийг буруу хэрэглэсэн байна. Холбогдогчийг байгалийн дагалт буюу чаг мөөг түүж бэлтгэсэн зөрчил үйлдсэн гэж Зөрчлийн тухай хуулийн 7.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар шийтгэл оногдуулсан байна.

Ойн дагалт баялаг гэж гэж ойн сангийн газарт ургадаг жимс, жимсгэнэ, мөөг, самар, эмийн болон хүнс, тэжээл, техникийн ургамал, модны холтос, үйс, хусны шүүс, давирхай, ойн хөвд, хөвхөн зэрэг ойгоос авч ашиглаж байгаа аливаа баялгийн нөөцийг ойлгоно гэж Ойн тухай хуульд тодорхойлсон байна.

Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Зөвшөөрөлгүйгээр ойн дагалт баялаг бэлтгэсэн бол шийтгэл оногдуулахаар хуульчилжээ.

Дээрх үйл баримтад дүгнэлт хийхэд, зөрчил үйлдсэн хүн байгалийн ургамлыг түүсэн үү, эсхүл ойн дагалт баялаг түүсэн эсэх үү гэдгийг нотлох баримтаар нотолж шалгаж тогтоогоогүйгээс зөрчлийн шинж ялгагдахгүй, аль зүйл хэсгээр шийтгэл оногдуулах нь эргэлзээтэй байдлыг бий болгосон байна.

Мөн эрх бүхий албан тушаалтны 0614805 дугаартай шийтгэлийн хуудас нь хуульд заасан үндэслэл журмын дагуу бичигдээгүй зөрчил байна. Үүнд:

Шийтгэлийн хуудасны Олсон нь: хэсэгт 7.7 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, Шийдвэрлэх нь: хэсэгт 7.7.1 гэж бичсэн нь Зөрчлийн тухай хуульд байхгүй зөрүүтэй зүйл хэсгээр шийтгэл оногдуулсан нь хуульд заасан үндэслэл журмын дагуу бичигдээгүй гэж үзлээ.

Иймд эрх бүхий албан тушаалтны зөрчлийн хэрэг бүртгэлтийн явцад цуглуулсан дээрх нотлох баримтууд нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн, Зөрчлийн тухай хуулийг буруу хэрэглэж, нотлох ажиллагааг бүрэн хийгээгүй байж хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн хууль бус шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах үндэслэл тогтоогдож байх тул тус аймгийн Цагаан-Үүр сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч Б-ийн холбогдогч А-д шийтгэл оногдуулсан 2024 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 0614805 дугаартай шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулахаар прокурорын дүгнэлт бичжээ.

Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч шүүхэд ирүүлсэн тайлбартаа: чаг мөөг түүсэн үйлдэлд байгалийн дагалт баялаг зөвшөөрөлгүй түүсэн гэж үзээд шийтгэл оногдуулахдаа Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг хэрэглэх байсныг 7.7 дугаар зүйлийн 1 дэх заалтыг хэрэглэсэн нь миний алдаа байсан болно. Иймд прокурорын дүгнэлтийг хүлээн зөвшөөрч байгаа тул хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж өгнө үү гэжээ.

Шүүх

Хөвсгөл аймгийн прокурорын газрын зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих ажил хариуцсан ахлах прокурорын гаргасан 2024 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 0614805 дугаартай шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах шаардлага бүхий дүгнэлтийг хариуцагч Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч бүхэлд нь хүлээн зөвшөөрснийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

Анхаарах зүйл

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг дутуу хийсэн. Тухайлбал, хураан авах ажиллагаа хийгээгүй. Зөрчлийн эд мөрийн баримт болох чага мөөгний хэмжээг тодорхойлоогүй, байгаль орчин, экологи- эдийн засагт учирсан хохирлыг тогтоогоогүй. Зөрчлийн объектыг зөв тодорхойлоогүй. Зөрчлийн зүйчлэл буруу хийсэн. Шийтгэлийн хуудсыг хуульд заасан үндэслэл журмын дагуу бичээгүй. Ойн дагалт баялаг эсвэл байгалийн ургамалд хамаарах эсэх талаарх хууль зүйн тодорхойлолтыг нягтлаагүй зэрэг анхаарах зүйлс байна. Ер нь гэмт хэрэг, зөрчлийн ялгааг маш сайн мэддэг байх хэрэгтэй.

3.6 ОЙН ТУХАЙ ХУУЛЬ ЗӨРЧИХ, ЗӨРЧЛИЙН ШИНЖ, ОНЦЛОГ, АНХААРАХ АСУУДАЛ

3.6.1. Шийтгэл, эрх бүхий албан тушаалтан ба харьяалал, нэр томъёоны тайлбар

Шийтгэл. Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн Ойн тухай хууль зөрчих тохиолдолд зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд дараах шийтгэл оногдуулна. Үүнд:

1. Зөвшөөрөлгүйгээр ойн дагалт баялаг бэлтгэсэн бол зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2. Гэрээний дагуу эзэмшүүлсэн ойг (2.1) түймэр, (2.2) хөнөөлт шавж, (2.3) өвчнөөс хамгаалах арга хэмжээ аваагүй бол учруулсан хохирол нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
3. Зохих зөвшөөрөлтэйгээр мод бэлтгэсэн талбайгаа цэвэрлээгүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
4. Мод бэлтгэх, эсхүл ойн дагалт нөөц ашиглахдаа технологийн горимыг зөрчсөн бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
5. Ойн сан бүхий газарт хориглосон үйл ажиллагаа явуулсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлого, зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгслийг хурааж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
6. Ойн дагалт нөөцийг менежментийн төлөвлөгөөнд туссан хэмжээнээс хэтрүүлэн ашигласан, бэлтгэсэн бол хэмжээнээс хэтрүүлэн бэлтгэсэн эд зүйлийг хурааж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
7. Ойн сан бүхий газарт гал түймэртэй тэмцэх, түүнээс сэргийлэх талаар хуульд заасан шаардлагыг биелүүлээгүй бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
8. Түймрийн аюултай үед (8.1) ой, хээрийн бүс нутагт өсвөр, залуу шилмүүст ой, шатсан ой, хуурай, унанги мод ихтэй ой, мод бэлтгэлийн хаягдал, үлдэгдлийг цэвэрлээгүй талбай, өвслөг ургамлын нөөц ихтэй газар, модны доор ил задгай гал түлсэн, (8.2) мод бэлтгэлийн талбайг цэвэрлэхдээ шатаах аргыг хэрэглэсэн, (8.3) шатах, тослох материал шингээсэн цаас, даавуу, хөвөн, бусад зүйлийг зориулалтын бус газар ил хаясан, (8.4) тээврийн хэрэгсэл, бусад техникийг шатахуунаар цэнэглэх үед тамхи татах, цонх, хаалгаар нь шатах, дэлбэрэх аюул бүхий хог хаягдал, үнс, шүдэнз хаях, оч баригчгүй тээврийн хэрэгсэл ашигласан бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
9. Гэрээний дагуу ашиглалт явуулж байгаа газарт түймэр унтраах багаж, хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжийг тогтоосон норм, нормативын дагуу бүрдүүлээгүй, эсхүл түймэр гарсан үед тэдгээрийг ашиглахад бэлэн байлгаагүй бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

10. Ойн тухай хуулиар тогтоосон шаардлагыг биелүүлээгүй бол учруулсан хохирол нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
11. Гэрээ байгуулахгүйгээр ойгоос мод бэлтгэсэн, эсхүл гэрээний нөхцөл, болзлыг зөрчин үйл ажиллагаа явуулсан бол хууль бусаар бэлтгэсэн зүйл, олсон орлогыг хураах хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Зөрчлийг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан ба харьяалал. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлд зааснаар Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн Ойн тухай хууль зөрчих зөрчлийг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан болон харъяаллыг доорх хүснэгтээр харуулав. Үүнд:

Эрх бүхий албан тушаалтан	Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харьяалал
Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйл. Ойн тухай хууль зөрчих	
Улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч (6.27) Байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37)	Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг
Байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37)	Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг
Байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37) Улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч (6.27)	Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг
Байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37) Улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч (6.27)	Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг
Байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37) Улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч (6.27)	Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг
Байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37)	Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг
Байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37) Улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч (6.27)	Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг
Байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37) Улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч (6.27)	Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг
Байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37) Гал түймрийн улсын хяналтын байцаагч (6.17)	Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг
Байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37) Улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч (6.27)	Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 10 дахь хэсэг
Байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37) Улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч (6.27)	Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 11 дэх хэсэг

Дээрх хүснэгтээс харахад, Ойн тухай хууль зөрчих зөрчлийг Зөрчил шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.27-д заасан улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч, 6.37-д заасан байгаль орчны хяналтын улсын байцаагч болон тус хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.17-д заасан гал түймрийн улсын хяналтын байцаагч нар харьяалах хэсгийн зөрчлийг тус тус шалган шийдвэрлэх эрхтэй юм.

Хуулийн нэр томьёоны тайлбар. Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлд заасан зөрчилтэй холбогдох нэр томьёог Ойн тухай хуульд тайлбарласан байдаг бөгөөд тэдгээрийг дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

“Ой” гэж мод, бут, сөөг болон бусад ургамал, хаг хөвд, амьтан, бичил биетэн шүтэлцэн орших хам бүрдлийн экологи-газарзүйн онцлог нөхцөл бүхий орчныг,

“Ойн сан” гэж энэ хуулийн 3.1.1-д заасан ой, ой дотор байгаа ойгоор бүрхэгдээгүй болон ойн тэлэн ургахад шаардлагатай талбай бүхий орчныг,

“Ойн нөөц” гэж ойг талбай, ургаа модны эзлэхүүнээр нь илэрхийлснийг,

“Эзэмшлийн ой” гэж ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага гэрээний үндсэн дээр тодорхой хугацаанд хариуцан хамгаалж, эзэмшиж, ашиглаж байгаа ойн сангийн тодорхой хэсгийг,

“Ойн менежментийн төлөвлөгөө” гэж тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх, эсхүл эзэмшлийн ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхэд чиглэгдсэн ойн аж ахуйн арга хэмжээний хүрээнд гүйцэтгэх ажлыг цогц байдлаар, тодорхой үе шаттайгаар тусгаж, төлөвлөсөн баримт бичгийг,

“Ойн экологи-эдийн засгийн үнэлгээ” гэж ойн нөөцийн хэмжээ, чанар, хэрэглээний экологи-эдийн засгийн үр өгөөжийг мөнгөн хэлбэрээр илэрхийлснийг,

“Ойн нөхөрлөл” гэж Иргэний хуулийн 481.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3.2.8-д заасны дагуу зохион байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж байгаа иргэдийн сайн дурын байгууллагыг,

“Ойг хамгаалах” гэж ой, хээрийн түймэр болон хөнөөлт шавж, өвчин зэрэг ойн төлөв байдлыг доройтуулах хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх, ойн баялгийг жам ёсоороо нөхөн сэргэх боломжийг алдагдуулахгүйгээр ойн нөөцийн даацад тохируулан зохистой ашиглах, нөхөн сэргээх, тэдгээрт хяналт тавьж гарсан зөрчлийг таслан зогсоох үйл ажиллагааг,

“Ойг ашиглах” гэж ойн сангаас зохих журам, заавар, стандартын дагуу ойн баялгийн даацад тохируулан мод, ойн дагалт баялгийг бэлтгэх үйл ажиллагааг,

“Ойн баялаг” гэж ойн модны нөөц, түүний дагалт баялгийн нөөцийг,

“Ойн дагалт баялаг” гэж ойн сангийн газарт ургадаг жимс, жимсгэнэ, мөөг, самар, эмийн болон хүнс, тэжээл, техникийн ургамал, модны холтос, үйс, хусны шүүс, давирхай, ойн хөвд, хөвхөн зэрэг ойгоос авч ашиглаж байгаа аливаа баялгийн нөөцийг,

“Ойн тооллого, ой зохион байгуулалт” гэж ойн сангийн талбай, нөөц, тархац, бүрэлдэхүүн, чанар, төлөв байдал, өөрчлөлтийг тогтоох, хүлэмжийн хийн шингээлтийг тооцох, биомассын судалгаа хийх, ойн нөөцийг хамгаалах, тогтвортой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээг цогц байдлаар тодорхойлсон үйл ажиллагааг,

“Ой үржүүлэг” гэж урьд өмнө нь ой байгаагүй газарт таримал ой ургуулахыг,

“Ойн цэвэрлэгээ” гэж ойн түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн, хүчтэй салхи, их цасанд өртөн амьдрах чадваргүй болж үхжиж унасан хуурай мод, гишүү, мөчир, мод бэлтгэлийн талбайн үлдэгдлийг цэвэрлэх замаар ойг хамгаалах, ойн төлөв байдлыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг,

“Ойн санд үзүүлэх хортой нөлөөлөл” гэж аж ахуйн болон үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад ойн санг бүрдүүлэгч хүчин зүйлийн даац чадавхид хохирол учруулсан, ойг бохирдуулж, улмаар ойн төлөв байдлыг доройтуулсан бүхий л сөрөг үйлдлийг,

“Түймрийн аюултай үе” гэж тухайн нутаг дэвсгэрт ой, хээрийн түймэр гарах байгалийн нөхцөл бүрдсэн хуурайшилт бүхий цаг хугацаа буюу жил бүрийн 3 дугаар 20-ны өдрөөс 6 дугаар сарын 10-ны өдөр, 9 дүгээр сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 10-ны өдөр хүртэлх хугацааг,

“Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх” гэж төрийн, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс ой, хээрийн түймэр үүсэж тархахаас сэргийлэх зорилгоор хэрэгжүүлж байгаа мэдээлэл, сургалт, сурталчилгааны болон ойн аж ахуйн арга хэмжээг,

“Ой, хээрийн түймрийг илрүүлэх” гэж түймэр гарсан тухайн газрын байр зүй, тархалтын хэмжээг тодорхойлох болон түймрийн голомтыг олж тогтоохыг,

“Хил дамнасан ой, хээрийн түймэр” гэж тухайн улсын хил болон хилийн дагуух бүс нутагт гарсан ой, хээрийн түймэр өргөжин дэлгэрч хоёр улсын хилийн зааг, хил дамнаж гарсныг,

“Ой, хээрийн түймрээс учирсан хохирол” гэж түймрийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, байгаль-экологи, эд материалд учирсан хохирол, ой, хээрийн түймэр унтраахад гарсан зардлыг,

“Ой, хээрийн түймрээс учирсан экологийн хохирол” гэж түймрийн нөлөөгөөр байгаль-экологийн тогтолцооны хэвийн байдал, ой, түүний хөрс, ус хамгаалах экологийн үүрэг ач холбогдол алдагдах, амьтан, ургамал устах болон тэдгээрийн төрөл зүйлийн амьдрах орчин доройтох, байгалийн нөөц, баялаг хомсдохыг,

“Ой, хээрийн түймрээс учирсан эд материалын хохирол” гэж түймрийн нөлөөгөөр барилга байгууламж, мал, амьтан, ургамал, өвс тэжээл, малын хашаа саравч, машин тоног төхөөрөмж, гэр, орон сууц, эд материал зэрэг үндсэн ба эргэлтийн хөрөнгө гэмтэх, устах зэргээр улс орон, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд учирсан шууд хохирлыг,

“Ой, хээрийн түймрийн хор уршиг” гэж Гамшгаас хамгаалах тухай хууль-ийн 4.1.10-т заасныг,

“Ойн үр” гэж мод, бут, сөөг үржүүлэх, ойжуулах, ойг нөхөн сэргээхэд ашиглаж байгаа үржлийн зориулалттай үр хөврөл бүхий эрхтнийг,

“Үржлийн материал” гэж мод, бут, сөөг үржүүлэх, ойжуулах, ойг нөхөн сэргээх зориулалт бүхий үр, ургал эрхтэн, үндэс, мөчрийн тайрдас, тарьц, суулгацыг,

“Ойн үрийн мужлал” гэж экологийн болон өндөршлийн хувьд төстэй бүс нутагт орших удамшил, гадаад илрэлийн хувьд адил шинж тэмдэг бүхий байгалийн ойн газар нутгийг,


“Ойн аж ахуйн арга хэмжээ” гэж ойг үржүүлэх, нөхөн сэргээх, хамгаалах, зохистой ашиглах, ойн тооллого, зохион байгуулалт, арчилгаа, цэвэрлэгээ хийхэд чиглэсэн цогц арга хэмжээг,

“Агро-ойн аж ахуй” гэж тухайн нутаг дэвсгэрийн хөрс, уур амьсгал, ус зүйн нөхцөлийг сайжруулах, таримал болон байгалийн ургамлын ургах орчныг дэмжсэн аж ахуйн арга хэмжээг тус тус ойлгоно.

3.6.2. Зөрчлийн шинж, онцлог ба төсөөтэй гэмт хэргээс ялгагдах шинж

Ойн тухай хууль зөрчих зөрчлийг (а) ойгоос зөвшөөрөлгүйгээр ойн дагалт баялаг бэлтгэсэн, (б) зохих зөвшөөрөлтэйгээр мод бэлтгэх явцдаа журам, дүрэм зөрчсөн, (в) ойн түймрийн аюултай үед баримтлах дүрэм журам зөрчсөн гэж гурван хэсэгт хуваан авч үзнэ.

Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлд заасан Ойн тухай хууль зөрчих зөрчил нь 11 хэсэг, 7 заалтаас бүрдэх бөгөөд хэсэг тус бүр өөр өөрийн онцлог шинжтэй юм. Иймд хэсэг тус бүрийг тусгайлан авч үзэх болно.



Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил нь зөвшөөрөлгүйгээр ойн дагалт баялаг бэлтгэсэн үйлдэл байна.

Зөвшөөрөлгүйгээр ойн дагалт баялаг бэлтгэсэн гэж Ойн тухай хуульд зааснаар түүний дагалт баялгийг иргэн, хуулийн этгээд бэлтгэж ашиглахдаа эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан байх ёстой бөгөөд хэрэв ямар нэгэн зөвшөөрөлгүйгээр ойн дагалт баялгийг бэлтгэсэн бол Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 1-д заасан зөрчил болно.

Ойн дагалт баялгийн нөөц ашиглах эрхийн бичгийг тухайн нутгийн ойн анги олгоно. Хэрэв ойн анги байхгүй тохиолдолд тухайн нутаг дэвсгэрийн байгаль хамгаалагч иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад олгоно.

Ойн дагалт баялгийн нөөц ашиглах эрхийн бичигт иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг, түүж бэлтгэх дагалт баялгийн төрөл, хэмжээ, хугацаа, газрын нэрийг тодорхой заана. Ийм учраас ойн дагалт баялаг түүж бэлтгэж байгаа хүн, хуулийн этгээдийн түүж бэлтгэж байгаа газар, хугацаа, он сар өдөр, төрөл хэмжээ зэргийг эрхийн бичигтэй тулгаж нягтлан үзэх шаардлагатай.

Тухайн зөрчил илэрсэн тохиолдолд зөрчил үйлдэж олсон аливаа хөрөнгө, орлого, эд хөрөнгийн эрх, тэдгээрийг түрээслэх, ашиглах замаар олсон бүх төрлийн орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулах ажиллагааг зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан давхар хийнэ.

Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан зөрчил нь гэрээний дагуу үүргээ гүйцэтгээгүйгээс ойн санд хохирол учирсан үйлдэл байна.

Гэрээний дагуу эзэмшүүлсэн ойг түймэр, хөнөөлт шавж, өвчнөөс хамгаалах арга хэмжээ авааагүй гэж хуульд заасан журмын дагуу ойг гэрээгээр эзэмшиж байгаа нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага ойн сангийн хэсгийг ой, хээрийн түймэр, хөнөөлт шавж, өвчнөөс хамгаалах арга хэмжээг биелүүлээгүй буюу хэрэгжүүлээгүй үйлдэл, эс үйлдлийг ойлгоно. Тухайлбал, хөнөөлт шавж, өвчний судалгаа явуулаагүй, тэдгээрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээ авааагүй, түймэр унтраах багаж, хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжийг тогтоосон норм нормативын дагуу бүрдүүлээгүй зэрэг үйлдлүүд байна. Түүний улмаас учирсан хохирлын хэмжээг тогтоож, нөхөн төлбөрийг гаргуулна.

Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан зөрчил нь мод бэлтгэсэн талбайгаа цэвэрлээгүй үйлдэл байна.

Зохих зөвшөөрөлтэйгөөр мод бэлтгэсэн талбайгаа цэвэрлээгүй гэж эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас авсан зөвшөөрлөөр бэлтгэсэн мод бэлтгэлийн талбайн үлдэгдлийг цэвэрлээгүй орхисон үйлдлийг ойлгоно. Мод бэлтгэлийн талбайн үлдэгдлийг цэвэрлэх нь ойг хамгаалах, түүний төлөв байдлыг сайжруулах чухал ач холбогдолтой.

Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан зөрчил нь мод бэлтгэх, эсхүл ойн дагалт нөөц ашиглахдаа технологийн горимыг зөрчсөн үйлдэл байна.

Мод бэлтгэх, эсхүл ойн дагалт нөөц ашиглахдаа технологийн горимыг зөрчсөн гэж ойд мод бэлтгэх гэрээ байгуулж, зөвшөөрөл авсан мод бэлтгэгч мод бэлтгэх үйл ажиллагааг эхлэхээс өмнө технологийн картыг загварын дагуу боловсруулж батлуулах, ойгоос мод бэлтгэх технологийн үйл ажиллагаанд арчилгаа, цэвэрлэгээ, үйлдвэрлэлийн ашиглалтын огтлолттой

холбоотой стандартыг мөрдөж ажиллах зэрэг ойд мод бэлтгэх, ойн дагалт нөөцийг ашиглах технологийн горимыг зөрчиж байгаа үйлдэл эс үйлдлийг ойлгоно.

Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасан зөрчил нь ойн сан бүхий газарт хориглосон үйл ажиллагаа явуулсан үйлдэл байна.

Ойн сан бүхий газарт хориглосон үйл ажиллагаа явуулсан гэж Ойн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан ойд хориглох үйл ажиллагааг явуулахыг ойлгоно. Үүнд:

- Насны тавдугаар анги хүртэлх ой, бүх төрлийн өсвөр мод, түүнчлэн жодоо, яшил, заг, тоорой, жигд, яргай, сухай, гандигар, тэс болон чацаргана, мойл зэрэг бүх төрлийн жимсний мод, бутыг огтлох, хугалж гэмтээх
- Төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр ойгоос хуш, гацуур, нарсыг бэлтгэх, ашиглах
- Ойг хавтгайруулан огтлох аргаар мод бэлтгэх
- Ойн сан бүхий газарт зөвшөөрөлгүйгээр өвс хадах
- Ойжуулсан, ойн үр бэлтгэх зориулалтаар тусгаарласан болон тарьц, суулгац ургуулсан мод үржүүлгийн талбайд мод бэлтгэх, мал бэлчээх
- Ойн асуудал хариуцсан эрх бүхий албан тушаалтан, ойн ангитай зөвшилцөхгүйгээр эзэмшлийн ойд мод бэлтгэх, ойн дагалт баялаг ашиглах зэрэг үйл ажиллагаа явуулах
- Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага зохих зөвшөөрөлгүйгээр ойгоос мод бэлтгэх, ойн дагалт баялаг ашиглах, ан агнах, түймрийн аюултай үед зохих зөвшөөрөлгүйгээр аялал, зугаалгаар явах
- Байгалийн ойгоос зулзаган модыг ойн ангийн зөвшөөрөлгүйгээр шилжүүлэн суулгах
- Барилга байгууламж барих, шинэчлэх, өргөтгөх, засварлах ажилд барилгын хэв хашмалын тулаасны зориулалтаар бөөрөнхий мод ашиглах
- Ойн сангийн газарт улсын тусгай хэрэгцээний болон ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэхээс бусад зориулалтаар барилга байгууламж барих, аливаа объект байрлуулах
- Мод, сөөг нутагшуулах, тарималжуулахаар хийж байгаа туршилт, судалгааны ажлаас бусад тохиолдолд мод, сөөгийн тарьц, суулгац импортлох зэрэг болно.

Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт заасан зөрчил нь ойн дагалт нөөцийг хэмжээнээс хэтрүүлэн ашигласан, бэлтгэсэн үйлдэл байна.
Ойн дагалт нөөцийг менежментийн төлөвлөгөөнд туссан хэмжээнээс хэтрүүлэн ашигласан, бэлтгэсэн гэж ойн нөхөрлөл, ойн сангийн тодорхой хэсгийг гэрээгээр эзэмшсэн аж ахуйн нэгж, байгууллага нь эзэмшлийнхээ ойгоос ойн менежментийн төлөвлөгөө[22], гэрээ, эрхийн бичигт заасан хэмжээнээс илүү бэлтгэсэн, ашигласан үйлдлийг ойлгоно.

Тухайн байгууллага нь ойн сангийн тодорхой хэсгийг хамгаалах, үржүүлэх, нөхөн сэргээх, зохистой ашиглахдаа ойн менежментийн төлөвлөгөөтэй байх бөгөөд менежментийн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулна. Энэ төлөвлөгөөнд ойн санг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэслэлтэй хийж, тусгасан байх бөгөөд түүнийг эрх бүхий байгууллага баталдаг.

Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт заасан зөрчил нь ойн сан бүхий газарт гал түймэртэй тэмцэх, түүнээс сэргийлэх талаар хуульд заасан шаардлагыг биелүүлээгүй үйлдэл байна.

22 Ойн тухай хуулийн 3.1.6. “ойн менежментийн төлөвлөгөө” гэж тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх, эсхүл эзэмшлийн ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхэд чиглэгдсэн ойн аж ахуйн арга хэмжээний хүрээнд гүйцэтгэх ажлыг цогц байдлаар, тодорхой үе шаттайгаар тусгаж, төлөвлөсөн баримт бичгийг.

Ойн сан бүхий газарт гал түймэртэй тэмцэх, түүнээс сэргийлэх талаар хуульд заасан шаардлагыг биелүүлээгүй гэж Ойн тухай хуульд зааснаар ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага гэрээний дагуу эзэмшиж байгаа ойн сангийн хэсгийг ой, хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээг өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд үүнийг биелүүлээгүй байхыг ойлгоно.

Мөн түймрийн аюултай үед иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ой, хээрийн бүс нутагт дараах үйлдэл хийхийг хориглодог. Үүнд.

- Өсвөр, залуу шилмүүст ой, шатсан ой, хуурай, унанги мод ихтэй ой, мод бэлтгэлийн хаягдал, үлдэгдлийг цэвэрлээгүй талбай, өвслөг ургамлын нөөц ихтэй газар, модны доор ил задгай гал түлэх
- Мод бэлтгэлийн талбайг цэвэрлэхдээ шатаах аргыг хэрэглэх
- Шатах, тослох материал шингээсэн цаас, даавуу, хөвөн болон бусад зүйлийг зориулалтын бус газар ил хаях
- Тээврийн хэрэгсэл, бусад техникийг шатахуунаар цэнэглэх үед тамхи татах, цонх, хаалгаар нь шатах, дэлбэрэх аюул бүхий хог, хаягдал, үнс, чүдэнз хаях, оч баригчгүй тээврийн хэрэгсэл ашиглах
- Ашиглалт явуулж байгаа газарт түймэр унтраах багаж, хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжийг тогтоосон норм нормативын дагуу бүрдүүлэх ба тэдгээрийг түймэр гарсан үед ашиглахад бэлэн байлгах
- Галын аюултай бодис, шатах, тослох материалыг хэрэглэх, тээвэрлэх, хадгалах журам, горимыг чанд мөрдөж ажиллах
- Бүх төрлийн тээврийн болон өөрөө явагч хэрэгслийг галын аюулгүйн төхөөрөмжөөр тоноглох, ажилд гаргахдаа шалгаж байх.

Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт заасан зөрчил нь түймрийн аюултай үед түймрийн аюултай байдлыг бий болгосон үйлдэл байна. Энэ үйлдэл нь шууд хохирол учруулаагүй боловч учрах эрсдэлийг бий болгосон үйлдэл байна.

Түймрийн аюултай үе гэж тухайн нутаг дэвсгэрт ой, хээрийн түймэр гарах байгалийн нөхцөл бүрдсэн хуурайшилт бүхий цаг хугацаа буюу хуульд зааснаар жил бүрийн 3 дугаар 20-ны өдрөөс 6 дугаар сарын 10-ны өдөр, 9 дүгээр сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 10-ны өдөр хүртэлх хугацааг ойлгоно.

Түймрийн аюултай үед гэдэгт дараах үйлдлийг хамруулан ойлгоно. Үүнд:

- Ой, хээрийн бүс нутагт өсвөр, залуу шилмүүст ой, шатсан ой, хуурай, унанги мод ихтэй ой, мод бэлтгэлийн хаягдал, үлдэгдлийг цэвэрлээгүй талбай, өвслөг ургамлын нөөц ихтэй газар, модны доор ил задгай гал түлсэн
- Мод бэлтгэлийн талбайг цэвэрлэхдээ шатаах аргыг хэрэглэсэн
- Шатах, тослох материал шингээсэн цаас, даавуу, хөвөн, бусад зүйлийг зориулалтын бус газар ил хаясан
- Тээврийн хэрэгсэл, бусад техникийг шатахуунаар цэнэглэх үед тамхи татах, цонх, хаалгаар нь шатах, дэлбэрэх аюул бүхий хог хаягдал, үнс, чүдэнз хаях, оч баригчгүй тээврийн хэрэгсэл ашигласан зэрэг болно.

Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 9 дэх хэсэгт заасан зөрчил нь түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг аваагүй үйлдэл байна.
Гэрээний дагуу ашиглалт явуулж байгаа газарт түймэр унтраах багаж, хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжийг тогтоосон норм, нормативын дагуу бүрдүүлээгүй, эсхүл түймэр гарсан үед тэдгээрийг ашиглахад бэлэн байлгаагүй гэж ашиглалт явуулж байгаа газарт

түймэр унтраах багаж, хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжийг тогтоосон норм нормативын дагуу бүрдүүлэх ба тэдгээрийг түймэр гарсан үед ашиглахад бэлэн байлгах шаардлагыг биелүүлээгүй үйлдлийг ойлгоно.

Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 10 дахь хэсэгт заасан зөрчил нь Ойн тухай хуулиар тогтоосон шаардлагыг биелүүлээгүй үйлдэл байна. Түүнээс хохирол учирсан байхыг ойлгоно.

Ойн тухай хуулиар тогтоосон шаардлагыг биелүүлээгүй гэж Ойн тухай хууль тогтоомжоор тусгайлан заасан шаардлагуудыг биелүүлээгүй үйлдэл эс үйлдлийг ойлгоно.

Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 11 дэх хэсэгт заасан зөрчил нь гэрээ байгуулахгүйгээр ойгоос мод бэлтгэсэн, эсхүл гэрээний нөхцөл, болзлыг зөрчин үйл ажиллагаа явуулсан үйлдэл байна.

Гэрээ байгуулахгүйгээр ойгоос мод бэлтгэсэн, эсхүл гэрээний нөхцөл, болзлыг зөрчин үйл ажиллагаа явуулсан гэж Ойн тухай хуульд зааснаар ойгоос мод бэлтгэхдээ ойн анги (байхгүй бол сум, дүүргийн эрх бүхий албан тушаалтан)-тай мод бэлтгэх гэрээ байгуулж, түүнд мод бэлтгэх үндэслэл буюу мод бэлтгэхийг зөвшөөрсөн тухай эрх бүхий этгээдийн шийдвэр, мод бэлтгэх хугацаа, зориулалт, бэлтгэх модны төрөл, хэмжээ, мод бэлтгэлийн талбай тусгаарласан материал, мод бэлтгэх технологийн карт болон ойн нөөцийн тодорхойлолт, ойг нөхөн сэргээх, ой, хээрийн түймэр, хөнөөлт шавж, өвчнөөс хамгаалах төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх зардлын хэмжээ, мод бэлтгэсэн талбайг хүлээлгэн өгөх нөхцөл, мод бэлтгэсэн талбайг хүлээлгэн өгөх, гэрээний биелэлтийг дүгнэх зэрэг нөхцөл шаардлагыг тодорхой тусгасан байх учиртай бөгөөд тэдгээр нөхцөлийг биелүүлэхгүй зөрчих эсхүл огт гэрээ байгуулахгүйгээр мод бэлтгэсэн үйлдлийг ойлгоно.

Төсөөтэй гэмт хэргээс ялгагдах шинж. Ойн тухай хууль зөрчих зөрчил ба хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг хоорондын үндсэн ялгаа нь гэмт хэргийн хувьд зохих зөвшөөрөлгүйгээр мод бэлтгэсэн байх нь үндсэн шинж бол зөрчлийн хувьд зохих зөвшөөрөлтэйгөөр мод бэлтгэхэд шаардагдах журам зөрчсөн байгаагаараа ялагдана.

Хүснэгт 3.6. *Ойн тухай хууль зөрчих зөрчлийн төсөөтэй гэмт хэргээс ялгагдах шинж*

Хууль бусаар мод бэлтгэх (Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.6 дугаар зүйл)	Ойн тухай хууль зөрчих (Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйл)
Зөвшөөрөлгүйгээр ойд мод бэлтгэсэн	Зөвшөөрөлгүйгээр ойн дагалт баялаг бэлтгэсэн
Гарал үүслийн гэрчилгээгүйгээр мод, модон материалыг бэлтгэсэн, тээвэрлэсэн, худалдсан, худалдан авсан	Ойн сан бүхий газарт хориглосон үйл ажиллагаа явуулсан
Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ойд	Гэрээ байгуулахгүйгээр ойгоос мод бэлтгэсэн, эсхүл гэрээний нөхцөл, болзлыг зөрчин үйл ажиллагаа явуулсан
	Ойн сан бүхий газарт гал түймэртэй тэмцэх, түүнээс сэргийлэх талаар журам зөрчсөн

3.6.3. Ойн тухай хууль зөрчих зөрчлийг шалгахад анхаарах зарим асуудал

Ойн тухай хууль зөрчих зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааг явуулахад анхаарах зүйлс байна. Тухайлбал, зохих бичиг баримт буюу зөвшөөрөл, гэрчилгээ, эрхийн бичигтэй эсэх, мөн нэгдсэн кодтой байгаа эсэхийг шалгаж, хэрвээ байхгүй юм уу эргэлзээтэй, зөрчилтэй бол саатуулах, журамлах арга хэмжээ авна.

Зөрчлийн үйлдэлд холбогдогч, гэрч, хохирогчоос мэдүүлэг авахдаа, ашигласан техник хэрэгслийн марк, төрөл, хүчин чадал, тоо хэмжээ, шатахууны татан авалт, бэлтгэсэн, худалдсан хэмжээ, үнэ, хамрагдсан ажиллагсад, цалин олгосон тооцоо, хөдөлмөрийн гэрээ хийсэн эсэх, нийгмийн даатгалын төлөлт, улс орон нутгийн төсөвт төлсөн татвар, хураамжийн хэмжээ зэрэг зүйлсийг асууж, тодруулж хэвших.

Энэ зөрчилд хуулийн этгээдийн асуудлыг шалгахдаа, тухайн аж ахуйн нэгж нь улсын бүртгэлийн гэрчилгээтэй эсэх, үндсэн ашиглалтаар болон ойд арчилгаа, цэвэрлэгээний огтолт хийх, ойн цэвэрлэгээ хийх, үйлдвэрлэлийн зориулалтаар мод бэлтгэх эрх авсан эсэх, мод бэлтгэлийн үйл ажиллагаа явуулах мэргэжлийн байгууллагын эрхтэй эсэх, байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ, ойн сан эзэмшдэг бол ойн менежментийн төлөвлөгөөтэй эсэх талаар төрийн байгууллагуудаас лавлагаа авч, шалгаж тодруулж байх нь зүйтэй.

Зөрчлийн улмаас ойн санд учирсан хохирлыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны А/176 тоот тушаалаар батлагдсан “Ойн экологи-эдийн засгийн үнэлгээ, нөхөн төлбөр тооцох аргачлал”-д зааснаар тогтоолгох.

Тухайн зөрчлийн улмаас хор хохирол хүлээсэн байгууллага, иргэнийг хохирогчоор хуульд заасан үндэслэл журмын дагуу мэдүүлэг авч, энэ тухай тэмдэглэл үйлдэнэ. Мэдүүлэг авахдаа Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.8, 4.9-д заасан журмыг баримтлан явуулна.

Зөрчил үйлдэж олсон мод, модон материал, тэдгээрийн үнэ, хэрэглэсэн зэвсэг, тээврийн хэрэгсэл, унаа хөсөг болон бусад хэрэгсэлд үзлэг хийж улмаар эд мөрийн баримтаар хураан авах, битүүмжлэх ажиллагааг прокурорын хяналттай явуулах, хөдөө хээрийн нөхцөлд эсхүл шөнийн цагаар хойшлуулшгүй тохиолдолд хураан авахдаа эхлээд прокурорт даруй мэдэгдэж ажиллагаа дуусснаас хойш 24 цагийн дотор холбогдох баримтын хамт хүргүүлнэ. Эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт зэргийг нарийвчлан тооцох, эдгээрт гарах зардлыг хадгалагч, хамгаалагч байгууллага иргэнээр тодорхойлуулан удирдлагад танилцуулж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны зардлаас гаргуулах.

Эд мөрийн баримтаар хураагдсан эд зүйл, тээврийн хэрэгслийн эзэмшигч, өмчлөгчийг тогтоож, хөрөнгийн үнэлгээ хийлгэх арга хэмжээ авна.

Ойн ангийн дарга, мэргэжилтэн, байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч зэрэг үүрэг бүхий албан тушаалтнуудын албан үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс хамаарч зөрчил үйлдэгдэхэд нөлөөлсөн бол Төрийн албаны тухай хуульд зааснаар сахилгын шийтгэл хүлээлгэх эсэх талаар хариуцсан дээд шатны байгууллагад бичгээр хандах. Шаардлагатай бол тухайн газар орныг хариуцаж байсан ойн ангийн дарга, мэргэжилтэн, байгаль хамгаалагч нараас гэрчийн мэдүүлэг авч, ажил үүргийн хувьд хэн нь юу хариуцдаг болох, хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолт зэргээс үндэслэн талбай тусгаарлалтыг хэрхэн явуулсан, ойн дагалт нөөц ашиглах эрхийн бичгийн бичилт, хөтлөлт зэргийг үзэх, хуулбарлан авах.

Зөрчил үйлдэгдсэн газарт үзлэг хийж тухайн зөрчил үйлдэгдсэн нөхцөл байдлыг тогтооно. Тухайлбал, зөрчлийн улмаас хураасан, битүүмжилсэн мод нь зөрчлийн газарт ургадаг эсэх, бэлтгэсэн байдал, хожуулын өндөр, голч, холтослог шинж, тайралтаас үүссэн ул мөр, цаг агаарын байдал, газрын хэв шинж, эвдрэл, ойн сангийн ерөнхий харагдах байдал зэргийг өөрөө эсхүл мэргэжилтэн оролцуулан тогтоох шаардлагатай. Зөрчлийн газрын үзлэгийн тэмдэглэлд тухайн талбайн тусгаарлалт хийсэн захын цэгүүдийн солбицлыг GPS байршил тогтоогчийн тусламжтай тогтоох, хэрэв тусгаарласан талбайгаас хэтрүүлэн мод бэлтгэсэн байвал захын цэгүүдийн тогтоон талбайг нь хэмжиж, түүнчлэн тухайн талбай дахь бэлтгэсэн мод, хожуулын тоо хэмжээг тогтоох ажиллагаа хийнэ.

Үзлэгээр тогтоосон цэгүүдийг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны кадастрын хэлтэст хүргүүлэн хязгаарлалт, хориглолтын бүстэй давхцалтай эсэх, тусгаарлалтын талбай, хэтрүүлэн огтолсон талбай зэргийг харьцуулан шалгуулж, зурагтай лавлагаа авах. Лавлагаагаар тусгай хамгаалалттай газар нутгийн ой болох нь тогтоогдвол эрүүгийн хэрэг үүсгэн шалгуулахаар зөрчлийн хэргийг прокурорт даруй шилжүүлнэ.

Мод бэлтгэлийн талбайд улсын байцаагч мэдээллийн дагуу очиж үзлэг явуулахдаа тухайн газрын байршил, орон зайг тодорхойлоход өөрт хялбар болгох үүднээс ой зохион байгуулалтын материал, ойн сангийн план зураг, таксацийн бичлэг, мод бэлтгэлийн талбай тусгаарлах материал зэрэгт үндэслэн урьдчилан гар схем, бичгийн тэмдэглэгээ хийсэн байвал чиг баримжааг зөв тодорхойлох, тухайн ойн бүрэлдэхүүн, нөхцөл нөөц, газрын тогтоц (гуу жалга, хэвгий г.м), мод ихээр бэлтгэх боломжтой газар болон бусад олон талын тодорхой ойлголттой болох чухал ач холбогдолтой байдаг.

Зөрчлийн газрын хамгаалалтыг үзлэгийн өмнөх, үзлэгийн үеийн, үзлэгийн дараа үеийн гэж тооцож, хамгаалалтыг зөв оновчтой байдлаар зохион байгуулахгүй бол тухайн талбайд бэлтгэсэн мод алдагдах магадлал өндөр байдгийг анхаарах хэрэгтэй. Учир нь мод өөрөө уг зөрчлийн зайлшгүй эд мөрийн баримт болдог тул хамгаалалтыг зөв зохион байгуулж, улмаар эд мөрийн баримтаар хураан авах, битүүмжлэх арга хэмжээ авна. Мод бэлтгэсэн талбайд үзлэг явуулахад, ойн сан бүхий газар бөгөөд талбай ихтэй байдаг тул баримжаа алдахгүй байх, мод бэлтгэсэн талбайн нийт хэмжээ, зураглалыг зөв гаргахад GPS байршил тогтоогч багажийг зайлгүй ашиглах шаардлагатай. Үзлэгийн тэмдэглэлийг цэгцтэй, ойлгомжтой болгохын тулд дугаарлах, догол мөр авах, газрын нэрээр хаяглах зэрэг байдлаар бичих хэрэгтэй. Жишээ нь: Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын 1 дүгээр баг, Тарвагатай уулын арын 215 дугаар хэсэглэлийн 2 дугаар ялгаралд мод бэлтгэсэн талбайд хийсэн үзлэг", "А" ХХК-ийн үйлдвэрлэлийн хашааны мод зүсвэрийн "Тайга" хөрөөний хажууд хураалтай байгаа нарсан гуалин модонд хийсэн үзлэг" гэх мэтээр бичиж болох юм.

Мод, модон материалын талаарх зөвшөөрлийн бичиг, гэрээ зэрэг бичиг баримт нь үнэн эсэх нь тодорхойгүй, хуулбарласан, эргэлзээтэй баримт материал гаргаж өгвөл тухайн бичиг баримтад үзлэгийн ажиллагаа явуулж, материалын шинж онцлогийг нарийн дурдсан тэмдэглэл хөтөлж, гарын үсэг зуруулж хураан авах. Тухайн баримтыг үндэслэн холбогдох гэрчээс мэдүүлэг авах, эрх бүхий байгууллагаас лавлагаа хүсэх, илт хуурамч бичиг баримт үйлдсэн, зөрчлийг хаацайлахын тулд албан тушаалтнаас хуурамч баримт бичиг хийж ирүүлсэн бол прокурорт мэдэгдэж даруй шилжүүлнэ. Гарал үүслийн гэрчилгээгүй эсвэл гэрчилгээтэй боловч зөрчилтэй (он, сар, өдөр, цаг, минут тавиагүй, гарын үсгийн тайлал байхгүй, тамга тэмдэг бүдэг, бэлтгэн нийлүүлэгч, тээвэрлэгчийн мэдээлэл дутуу, тээврийн хэрэгслийн дугаар тавиагүй, модны нэр төрөл, хэмжээг тавиагүй эсхүл эдгээрийг зассан, баллаж сохолсон, код зөрүүтэй г.м) зэрэг олон асуудал практикт гарсаар байна.

Шинжээчээс дараах зүйлсийг тодруулж болох юм. Тухайлбал, тухайн зөрчлийн шинж байдлаас хамаарч (шинжээч ихэвчлэн газар дээр нь очин танилцаж, тодорхойлдог) ямар зүйлийн, хэдэн настай мод болох, хуурай, нойтон, хэмжээ, зориулалт, тухайн газрын ойгоос арчилгаа цэвэрлэгээ, үндсэн ашиглалт, үйлдвэрлэлийн зориулалтаар мод бэлтгэх нөөцтэй (тооллого судалгаа хийсэн) эсэх, тухайн мод бэлтгэл хийсэн газар нь ямар мужлал, бүсэд хамаарах, хууль бус мод бэлтгэлд өртсөн талбайг нөхөн сэргээхэд ямар хэмжээний зардал гарах, экологи-эдийн засгийн үнэлгээгээр байгаль орчинд хэдэн төгрөгийн хохирол учирсан болохыг тогтоолгох боломжтой.

Бодлого 1

Завхан аймгийн Байгаль орчны газрын 2019 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн 01/220 дугаар удирдамжаар төлөвлөгөөт хяналт шалгалтыг Завхан аймгийн Тосонцэнгэл сумын ойн мэргэжлийн байгууллагын эрхтэй “Тэнүүн” ХХК-ийн Тарвагатайн нурууны баруун хойд ам гэх газар буюу 2016 оны ой зохион байгуулалтын 55 дугаар хэсэглэлийн 12 дугаар ялгарал болох 10 га ойд цэвэрлэгээний огтлолт хийсэн талбайд явууллаа. Шалгалтыг тус сумын Ойн ангийн инженер, байгаль хамгаалагч, тус компанийн мод бэлтгэлийн бригадын дарга, хөрөөчин, тракторчин нарыг байлцуулан хяналт шалгалтыг гүйцэтгэхэд дараах зөрчил гарсан.

Ойн мэргэжлийн байгууллагын эрхтэй “Тэнүүн” ХХК нь цэвэрлэгээний огтлолт хийхдээ мод бэлтгэх технологийн горимыг зөрчиж хожуулыг өндөр тайрсан нь Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 4 дэх заалтыг зөрчсөн нь тогтоогдов.

Энэ тохиолдолд Байгаль орчны хяналтын улсын ахлах байцаагч тус компанийн мод бэлтгэлийн бригадын дарга, хөрөөчин нар нь гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн тул хялбаршуулсан журмаар шийдвэрлэж торгуулийн арга хэмжээ авч шийдвэрлэжээ.

Бодлого 2

Булган аймгийн Байгаль орчны газрын 2020 оны хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсан төлөвлөгөөт хяналт шалгалтын хүрээнд газрын даргын баталсан 01/25 дугаар удирдамжаар Булган аймгийн Хангал суманд мод бэлтгэлийн үйл ажиллагаа явуулж буй ойн мэргэжлийн байгууллагын эрхтэй “Хандгай” ХХК-ийн үйлдвэрлэлийн зориулалтаар мод бэлтгэж байгаа үйл ажиллагаанд шалгалт хийв.

Шалгалтын явцад тус ойн мэргэжлийн байгууллага нь сум дундын ойн ангийн тусгаарлалт хийсэн талбайгаас хэтрүүлэн 1.5 га талбайд огтлолт хийсэн нь тогтоогдов.

Энэ тохиолдолд тус ойн мэргэжлийн байгууллага нь 1.5 га талбайгаар хэтрүүлэн огтлолт хийсэн бөгөөд тухайн талбайдаа мод бэлтгэх зөвшөөрөл аваагүй тул уг үйлдэлд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахгүй. Харин Эрүүгийн хуулийн 24.6 дугаар зүйлд заасан Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэгт ямар нэг хохирлын хэмжээ заагаагүй тул дээрх үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Улсын байцаагчаас авах арга хэмжээ:

Ойн мэргэжлийн байгууллагын эрхтэй “Хандгай” ХХК нь сум дундын ойн ангийн мод бэлтгэлийн талбай тусгаарлаж шон тэмдэг тавьсан цэгээс гадагш хэтрүүлэн 1.5 га талбайд огтлолт хийсэн үйлдлийг прокурорт мэдэгдэж, холбогдох материалыг хүргүүлнэ. Прокурор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмаар Эрүүгийн хуулийн 24.6 дугаар зүйлд заасан хэргийг шалгуулахаар цагдаагийн байгууллагад шилжүүлнэ.

Цагдаагийн байгууллагад шилжүүлэх материалд:

- Төлөвлөгөөт хяналт шалгалтын батлагдсан удирдамж
- Улсын байцаагчийн шалгалт хийсэн тухай тэмдэглэл, баримтжуулсан зураг, бичлэг г.м
- Тухайн аж ахуйн нэгж, байгууллагад сум дундын ойн ангийн мод бэлтгэлийн талбай тусгаарлаж өгсөн үндсэн материалууд
- Хэргийг шалгуулахаар Цагдаагийн байгууллагад албан бичгээр хандана.

Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг болон ойн тухай хууль зөрчих зөрчил нь ихэвчлэн аглаг зэлүүд ойд хүний нүднээс далд газар оронд үйлдэгддэг онцлогтой тул илрэх магадлал тун бүрхэг. Харин хууль бусаар бэлтгэсэн модыг зөөж тээвэрлэх, худалдан борлуулах үед илрэх магадлал өндөр боловч мөн нууц, далдуур үйлдэгдэг учраас байгаль орчны хяналтын улсын байцаагч, цагдаа, байгаль хамгаалагч нар нь эргүүл, хяналт шалгалтыг тогтмол, оновчтой цаг хугацаанд явуулах нь илүү үр дүнтэй байдаг.

Иймд хулгайгаар мод зөөж тээвэрлэдэг замууд дээр эргүүл шалгалтын ажлыг түлхүү зохиох хэрэгтэй. Хууль бусаар мод бэлтгэгчид нь модыг зөөж тээвэрлэхдээ улсын батлагдсан стандартын замаар бус бидний нэрлэж заншсанаар хулгайн замаар, аливаа хөдөлгөөн бага үеийг ашиглан зөөж тээвэрлэдэг. Тухайлбал, орой үдшийн харанхуй эсвэл өглөө эрт үүрээр, амралтын болон баяр ёслолын үед хяналт шалгалт сул үеэр аль болох бартаатай газраар ихэвчлэн явдаг.

Тийм учраас хяналт шалгалт явуулах объектыг оновчтой сонгох хэрэгтэй. Хууль бусаар бэлтгэсэн мод тээвэрлэж яваа этгээдүүд хяналт шалгалттай таарах үед зугтаах, машинаа асахгүй болгож зориуд эвдэх, унтраах зэрэг янз бүрийн арга хэрэглэдэг. Иймд хяналт шалгалт явуулж байгаа ажилтан маш анхааралтай, ухаалаг шийдвэр гаргаж ажиллах шаардлагатай.

Хүнд ачаатай тээврийн хэрэгслийг зугтаах боломжгүй газарт оруулж байж зогсоох, өөрөөр хэлбэл, ямар ч хөдөлгөөн, ажиллагаа хийх боломжгүй эмзэг цэг, газрыг сонгон хаалт тавих хэрэгтэй. Мөн тээврийн хэрэгсэл нь эвдэрсэн тохиолдолд тээвэрлэн яваа эд зүйлсээ зөөж авах боломжгүй хараа хяналттай газар юм уу суурин газар тавих нь чухал. Туршлагаас харахад, хяналт шалгалт хийж яваа ажилтны зогс гэсэн дохио, шаардлагыг хараагүй мэт ойртон ирж шахах, үл биелүүлэх, тээвэрлэж явсан модтойгоо зугтаах үйлдэл жолооч нар гаргахаас гадна, албан хаагч нар араас нь машинтай хөөх үед албаны машиныг эргэлт тойруу дээр гүйцэж түрүүлэхэд шахах, өөрсдөө сандарч тэвдсэнээс болж онхолдох, осол аваар гаргах, ачиж яваа мод нурах зэрэг янз бүрийн тохиолдол гардаг учир байгаль орчны хяналтын улсын байцаагч, цагдаа, байгаль хамгаалагч нар гэмт этгээдийг хөөх үед маш болгоомжтой ажиллаж, тухайн этгээдийн болон өөрсдийн аюулгүй байдлыг хангах асуудлыг нэгдүгээрт тавих шаардлагатай.

Хууль бусаар мод тээвэрлэж буй этгээдүүд ачиж яваа модыг нуух зорилгоор битүү чингэлэгт хийх, гэр бараа, нүүрс, бусад бараа, бүтээгдэхүүний доор нууж битүү брезент бүтээлгээр дарж ачин замд шалгах бололцоогүй болгох зэргээр авч явдаг. Ийм тохиолдолд ачааны автомашины дугуйн хий, нум зэргийг харж хүнд зүйл ачсан эсэхэд сайтар анхаарах, ачаа чингэлгийн орчимд явахад нойтон мод бол модны анхилуун үнэр үнэртдэг. Хэрэв модны үнэр үнэртвэл ачааг задлан буулгаж үзэх хэрэгтэй.

Хууль бусаар мод тээвэрлэгчид нь урдаа хөнгөн тэрэг оруулан явуулж, замд хяналт шалгалт байгаа эсэхийг урьдчилан шалгаж, утсан харилцаагаар байнга бие биедээ мэдээ дамжуулж байдаг. Баригдсан үедээ хөдөө хээр машинаа цас, шаварт зориуд суулгах, эвдэх зэрэг арга

саам хэрэглэж бултах, зайлах гэж оролдоно. Мөн зөвшөөрлийн бичгийг модны эзэнд яваа, араас ирж байгаа, өөр машинаар яваа гэх мэтээр ярих, мөн баригдах үедээ огт юм бичээгүй шинэ гарал үүслийн гэрчилгээ дээр бичиглэл хийж авчрах зэрэг олон арга хэрэглэдэг учир тэр бүрийг нарийн нягт, хянамгай, сайтар шалгаж хэрэг, зөрчлийг илрүүлэх шаардлагатай.

Хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх ажилд төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, төрийн бус байгууллага, нөхөрлөл, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь үр дүнтэй байдаг. Хяналт шалгалтыг зохион явуулахдаа, хөдөлгөөнт эргүүлийн сүлжээг цагдаа, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нарын оролцоотойгоор хэсэгчилсэн болон тодорхой газар нутагт, мэдээлэл, судалгаанд үндэслэсэн тодорхой цаг хугацаанд гүйцэтгэх нь маш чухал үр дүнтэй байдаг. Мөн нийслэл, аймаг, сумуудаас гарч орох төв замууд дээрх хяналтын постууд болон камержуулалт нь чухал ач холбогдолтой.

Ойд мод бэлтгэх гэрээ байгуулж, зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг шалгахдаа бэлтгэсэн мод нь тусгаарласан талбайгаас бэлтгэсэн эсэхийг тодорхойлох зорилгоор тухайн мод бэлтгэх газрын талбай тусгаарлалтын холбогдох бичиг баримт, технологийн карт, мод бэлтгэх эхлэлийн акттай танилцаж, нөхцөл байдал газар дээрээ ямар байгааг харьцуулан үзнэ. Талбай тусгаарласан газрын өнцөг бүрд тэмдэглээ хийсэн байх ёстой, түүнийг үзэж зөвшөөрсөн талбайтай нь тохирч байгаа эсэхийг GPS багажаар тогтоож, зураг авах, мөн уртын хэмжилтийг метрээр шалгаж талбай тусгаарласан зурагт тэмдэглэсэнтэйгээ тохирч байгааг шалгана. Мод бэлтгэхээр тусгаарласан талбайгаас авах модны тооллого хийсэн эсэхийг тусгаарласан талбай дахь бэлтгэсэн болон бэлтгээгүй (будгаар) тэмдэг тавьсан модтой харьцуулан үзэж, тооллогод орсон мод бэлтгэсэн эсэхийг шалгана. Технологийн картад бичсэн мод бэлтгэх талбайн бүдүүвч зураг, мод бэлтгэх хугацаа болон мод бэлтгэгчийн ажлын явц, бэлтгэсэн модны тоо хэмжээг бичсэн хяналтын хуудас, байгаль хамгаалагч, ойн анги, байгаль орчны улсын байцаагч нарын хяналт тавьсан бүртгэлүүдтэй тулган үзэж, тогтоосон хэмжээнээс илүү болон тусгаарласан талбайгаас өөр газарт мод бэлтгэсэн эсэхийг шалгана. Үүний тулд тээвэрлэсэн машины явсан рейсийг ч тооцоолон багцаа баримжаа гаргаж болно.

Тээврийн хэрэгслийн тэвшний багтаамжаас шалтгаалан харилцан адилгүй хэмжээтэй мод тээвэрлэх бөгөөд түүнийг нүдэн баримжаагаар мэддэг байх хэрэгтэй. Тухайлбал, “Зил 130” машины тэвшинд 8-10 $м^3$ мод, 100-120 орчим палк, дүнз, “Зил 131” маркийн машины тэвшинд 10-15 $м^3$ бөөрөнхий мод багтана.

Ер нь хууль бусаар мод бэлтгэсэн гэж үзвэл, хойшлуулшгүй ажиллагааг тэр дор нь авч хэрэгжүүлэх хэрэгтэй. Ингэж шуурхай арга хэмжээ авалгүй цаг хугацаа алдсаны улмаас шинээр бичиг баримт бүрдүүлэх, хоорондоо холбоо барин үгээ нийлүүлэх, зайлсхийх арга зохиож ажил хүндрүүлэх тохиолдол гардаг. Иймд тээврийн хэрэгсэлд үзлэг хийж, хэдий хэмжээний, ямар мод, нойтон болон хуурай эсэх, машиныг хөдөө хол газраас ирснийг илтгэх тоос шороо, шавар шавхай болсон зэргийг сайтар тусгаж, боломжтой бол зургийг нь авах хэрэгтэй. Мөн хаана ямар газар хяналт шалгалт хийх үед таарсан, ямар байдалтай байсан, зугтаах гэж оролдсон эсэх зэргийг илтгэх хуудсандаа сайн тусган оруулах, хэрвээ хуурамч байж болзошгүй бичиг баримттай бол түүнийг түр хураан авч, тэмдэглэл үйлдэх хэрэгтэй.

Алба хаагчдын үүрэг гүйцэтгэж байгаагаас харахад, бичиг баримтыг хураан авсан ямар нэгэн тэмдэглэл үйлдэлгүй, хаанаас хэн авчирсан нь үл мэдэгдэх бичиг баримтыг цаашид үргэлжлүүлэн шалгах ажилтанд шилжүүлэн өгч байгаа дутагдал цөөнгүй харагдаж байна.

Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэхэд ашиглах объектын судалгаанд доорх мэдээллийг нэмэлтээр бүрдүүлэх шаардлагатай. Үүнд:

- Орон нутгийн байгаль орчны чиглэлээр хийх объектын судалгаандаа хариуцсан нутаг дэвсгэрийн аль хэсэгт нь ойтой, улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газартай бол ямар сумдыг хамардаг талаарх газар зүйн байршлын зурагтай байх шаардлагатай. Уг зургаар эргүүл, хяналт шалгалт, урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах зэрэг олон зүйлд ашиглана.
- Гэмт хэрэг, зөрчлийн гаралтад дүн шинжилгээ хийх зорилгоор “crime map”-ыг ч ашиглах хэрэгтэй
- Хууль бусаар мод бэлтгээд байгаа газар орон, хулгайн гэх тодотголтой замын судалгаа, эргүүл шалгалт хийх үед хаалт боолт хийх цэг, аймаг, нийслэлээс гарч орох гол замууд, хяналтын түр болон байнгын пост, камер
- Төрийн захиргааны төв байгууллага болон орон нутгийн засаг захиргааны байгууллагаас гаргасан жил бүр ойгоос бэлтгэх модны дээд хязгаар, нутаг дэвсгэр, сумдаар хуваарилсан хэрэглээний мод болон түлээ бэлтгэх шийдвэр
- Хариуцсан нутаг дэвсгэрийнхээ ойн нөөц, тооллого, ой зохион байгуулалт, ойн сан бүхий газарт ургадаг самар, жимс, жимсгэнэ, мөөг, эмийн ашигт ургамлыг хамгаалах бүсийн талаарх шаардлагатай мэдээлэл
- Тухайн бүс нутагт мод, ойн дагалт баялгийн ашиглалтыг хязгаарласан юм уу тодорхой хугацаагаар хориглосон шийдвэр байгаа эсэх
- Улсын ойн мэдээллийн сангаас өөрт шаардлагатай мэдээлэл болон орон нутаг дахь ойн мэргэжлийн байгууллагын эрх олгосон, сунгасан, хүчингүй болгосон мэдээлэл
- Нутаг дэвсгэрийн ой, хээрийг түймрээс хамгаалах арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөний холбогдох хэсгийн мэдээлэл
- Ойн анги (хэрвээ байхгүй бол) юм уу эрх бүхий албан тушаалтнаас ойгоос мод бэлтгэх талбай тусгаарласан мэдээлэл, бэлтгэсэн мод, модон материалд гарал үүслийн гэрчилгээ олгох хуваарь, тоо хэмжээний талаарх мэдээлэл
- Хариуцсан нутаг дэвсгэр дээрх ойн баялгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллага, ойн нөхөрлөл, тэдгээрт ажиллаж байгаа хүмүүсийн нэр, хаяг, холбоо барих утасны дугаар зэрэг шаардлагатай мэдээлэл
- Ойн санг гэрээгээр эзэмшигч ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, ойн мэргэжлийн байгууллага, мод бэлтгэх, цэвэрлэгээ арчилгаа хийх зорилгоор болон модны чиглэлийн үйлдвэрлэл, худалдаалах иргэн, аж ахуйн нэгжийн талаарх мэдээлэл
- Ой, модыг хамгаалах, ашиглах талаар гарсан хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон эрхийн акт журам
- Мод бэлтгэх эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээний загвар, нууцлалын талаарх мэдээлэл
- Мод, модон материал зарж борлуулдаг зах, ченж гэх хүмүүсийн судалгаа
- Модон зүсмэл материал бэлтгэхэд зөөврийн болон суурин ажиллагаатай зүсвэрийн туузан хөрөө рамын тоо, эзэмшигч, тэнд ажиллагсад, зөвшөөрөл байршлын судалгаа
- Тухайн орон нутагт мод тээвэрлэдэг ачааны машины судалгаа эзэмшигч, жолоочийн мэдээлэл
- Ойн тухай хууль зөрчсөн хүмүүсийн болон гэмт хэрэгт холбогдсон ба холбогдож болзошгүй хүмүүсийн судалгаа
- Хариуцсан нутаг дэвсгэрт ойн нөөц, төлөв байдал, ашиглалтын эрчимжилтээс хамаарсан аймаг, нийслэлд байгуулагдах сум дундын ойн ангийн хариуцах талбайн норматив, байршил
- Ойн асуудал хариуцсан эрх бүхий албан тушаалтан, идэвхтэн байгаль хамгаалагч нарын холбоо барих утас, хаяг, байршил зэрэг мэдээлэл, судалгааг хийж, баяжуулах, улмаар үйл ажиллагаандаа тогтмол ашиглаж байх нь зүйтэй.

Бодлого 3

Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын иргэн Б нь 2018 оны 4 дүгээр сард “Хүрдэтийн нуруу” гэх газарт түлээний мод бэлтгэх зориулалтаар 0053136 дугаартай эрхийн бичиг авчээ. 2018 оны 10 дугаар сард эрхийн бичигт заасан зориулалтыг зөрчиж ойгоос 4.2 $м^3$ хэрэглээний мод бэлтгэсэн зөрчилд улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэж 2018 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр 300,000 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулсан байна.

Асуулт

1. Дээрх үйлдэл нь ямар хууль тогтоомж зөрчсөн вэ?
2. Энэ зөрчлийг шалгах ажиллагааны үед ямар ажиллагаа явуулах вэ?
3. Дээрх хууль бус үйлдэл нь Зөрчлийн тухай хуульд заасан ямар зөрчил болох вэ? Зөрчлийг зүйлчилнэ үү?
4. Зөрчил үйлдэгчид ямар шийтгэл оногдуулах вэ?

Хариулт

1. Дээрх үйлдэл нь ямар хууль тогтоомж зөрчсөн вэ?
Дээрх үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан “Хууль бусаар мод бэлтгэх” гэмт хэргийн шинжтэй байна.

2. Энэ зөрчлийг шалгах ажиллагааны үед ямар ажиллагаа явуулах вэ?
Дээрх үйлдлийг илрүүлсэн эрх бүхий албан тушаалтан цагдаагийн байгууллагад мэдэгдэх ёстой. Хэрэв зөрчил гэж үзэж анхан шатны ямар нэгэн материал бүрдүүлсэн бол түүнийг цагдаагийн байгууллагад шилжүүлнэ.

Энэ тохиолдолд эрх бүхий албан тушаалтан Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар торгууль оногдуулж шийдвэрлэсэн байгаа нь хууль зүйн үндэслэлгүй тул прокурор тухайн шийтгэлийн актыг хүчингүй болгуулахаар захиргааны хэргийн шүүхэд өргөдөл гаргах ёстой.

Хэрэв дээрх үйлдэл нь Ойн тухай хууль зөрчих зөрчил бол Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.9 дүгээр зүйлийн 1.2-т заасны дагуу Зөрчлийн тухай хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн тул зөрчлийн хэрэг нээхгүй болно.

Бодлого 4

Нэгэн дээд сургуулийн 4 дүгээр курсийн оюутнууд 6 дугаар сард төгсөхөөсөө өмнө ангиараа зугаалгаар явахаар болсон байна. Түүнийг анги удирдсан багш нь зохион байгуулж, санаачилга гаргасан бөгөөд 4 дүгээр сарын дундуур ойн түймрийн идэвхжилтэй үед Богд ууланд гарсан ба сүүдэр бараадаж нэгэн том модны доор түүдэг гал асаан сууж байхдаа байгаль хамгаалагчийг эргүүл хийж явах үетэй нь тааралджээ. Байгаль хамгаалагч ямар арга хэмжээ авсан бэ?

Асуулт

1. Дээрх үйлдэл нь ямар хууль тогтоомж зөрчсөн вэ?
2. Энэ зөрчлийг шалгах ажиллагааны үед ямар ажиллагаа явуулах вэ?
3. Дээрх хууль бус үйлдэл нь Зөрчлийн тухай хуульд заасан ямар зөрчил болох вэ? Зөрчлийг зүйлчилнэ үү?
4. Зөрчил үйлдэгчид ямар шийтгэл оногдуулах вэ?

Хариулт

1. Дээрх үйлдэл нь ямар хууль тогтоомж зөрчсөн вэ?

Ойн тухай хуулийн 3.1.17-д “түймрийн аюултай үе” гэж тухайн нутаг дэвсгэрт ой, хээрийн түймэр гарах байгалийн нөхцөл бүрдсэн хуурайшилт бүхий цаг хугацаа буюу жил бүрийн 3 дугаар сарын 20-ны өдрөөс 6 дугаар сарын 10-ны өдөр, 9 дүгээр сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 10-ны өдөр хүртэлх хугацаа хэмээн заасан байдаг. Дээрх бодлогын өгөгдлөөс үзэхэд, 4 дүгээр сар нь түймрийн аюултай үед хамаарна. Мөн тус хуулийн 20.2 дахь иргэн ойг хамгаалах талаар дараах үүргийн 20.2.4-д гал түймрийн улсын хяналтын дүрмийг чанд биелүүлж, *түймрийн аюултай ил задгай гал түлэхгүй байх*, асаасан чүдэнз, татсан тамхины гал, цог, нурмыг бүрэн унтрааж аюулгүй болгох гэсэн заалттай тул хуулийн эдгээр заалтыг зөрчиж байна.

2. Энэ зөрчлийг шалгах ажиллагааны үед ямар ажиллагаа явуулах вэ?

Эрх бүхий албан тушаалтан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.6 дугаар зүйлийн 1.1-д заасан *“зөрчил үйлдэгдсэн нь ил тодорхой, зөрчил, учирсан хохирлыг нотлох талаар зөрчлийн хэрэг бүртгэлт явуулах шаардлагагүй бол”* хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг явуулж, эрх бүхий албан тушаалтан хуульд заасан шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ авна. Энэ дагуу яг гал түлсэн холбогдогчийг олж тогтоон мэдүүлэг авч, зөрчил гарсан байдлыг тодруулах, зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдол бүхий баримт, мэдээллийг олох зорилгоор гэрч нараас мэдүүлэг авна. Эрх бүхий албан тушаалтан зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг тогтоох зорилгоор зөрчил үйлдэгдсэн газарт үзлэг хийж, гэрэл зураг, дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлж болно.

3. Дээрх хууль бус үйлдэл нь Зөрчлийн тухай хуульд заасан ямар зөрчил болох вэ? Зөрчлийг зүйлчилнэ үү?

Дээрх үйлдэлд эрх бүхий албан тушаалтан Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн Ойн тухай хууль зөрчих зөрчлийн 7 дахь хэсэгт заасан “Ойн сан бүхий газарт гал түймэртэй тэмцэх, түүнээс сэргийлэх талаар хуульд заасан шаардлагыг биелүүлээгүй” заалтаар зөрчлийг зүйчилнэ.

4. Зөрчил үйлдэгчид ямар шийтгэл оногдуулах вэ?

Ойн тухай хууль зөрчих зөрчлийн 7 дахь хэсэгт заасан “Ойн сан бүхий газарт гал түймэртэй тэмцэх, түүнээс сэргийлэх талаар хуульд заасан шаардлагыг биелүүлээгүй” хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, торгож хариуцлага ноогдуулна.

3.7 ГАЗРЫН ХЭВЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ ЗӨРЧИХ, ЗӨРЧЛИЙН ШИНЖ, ОНЦЛОГ, АНХААРАХ АСУУДАЛ

3.7.1. Шийтгэл, эрх бүхий албан тушаалтан ба харьяалал, нэр томъёоны тайлбар

Шийтгэл. Зөрчлийн тухай хуулийн 7.10 дугаар зүйлийн Газрын хэвлийн тухай хууль зөрчих тохиолдолд зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд дараах шийтгэл оногдуулна. Үүнд:

1. Газрын хэвлийг дур мэдэн ашигласан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2. Ашигт малтмал бүхий талбайд барилга байгууламж дур мэдэн барьсан, эсхүл газар доорх усны горимыг ашиглах цооног, геодези, маркшейдерийн тэмдгийг устгасан, эсхүл гэмтээсэн бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
3. Газрын хэвлийд геологийн судалгаа хийх журам, шаардлагыг зөрчсөн нь хайгуул хийсэн ашигт малтмалын нөөцийг буруу үнэлэх, ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барилга байгууламж барих нөхцөлийг буруу тодорхойлоход хүргэсэн бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
4. Газрын хэвлийг (4.1) ашиглах явцад эвдэрсэн газрыг аюул осолгүй болгож цаашид ашиглаж болохуйцаар засаж тохижуулаагүй, (4.2) ашиглах үед илэрсэн үнэт металл, үнэт чулуу, шинжлэх ухаан, түүх, соёлын үнэт зүйлийг зохих байгууллагад мэдэгдээгүй, (4.3) ашиглах үед илэрсэн үнэт металл, үнэт чулуу, шинжлэх ухаан, түүх, соёлын үнэт зүйлийг улсад тушаах хуульд заасан шаардлагыг биелүүлээгүй, (4.4) ашиглах үед түүнийг хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
5. Ашигт малтмал олборлох, эрдэс түүхий эдийг боловсруулах, ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барих барилга байгууламжийн (5.1) зураг төсөл зохиох, (5.2) тэдгээрийг барих, ашиглалтад оруулах талаар хуульд заасан шаардлагыг зөрчсөн хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
6. Газрын хэвлийг ашиглах аюулгүй ажиллагааны дүрэм, хэм хэмжээг зөрчсөн бол хүнийг гучин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
7. Газрын хэвлийг хамгаалах журам, түүнийг ашиглахад үүсч болзошгүй аюул осол, хортой нөлөөнөөс ажиллагчид, хүн ам болон мал, ан амьтан, байгаль орчин, барилга байгууламжийг хамгаалах шаардлагыг биелүүлээгүй бол хүнийг гучин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
8. Ашигт малтмалын ордыг гэмтээж сүйтгэсэн, баялаг хэсгийг нь сорчлон олборлосон, эсхүл ашигт малтмалын балансын нөөцийг зохистой ашиглах шаардлагыг зөрчсөн, олборлох үед ашигт малтмалын хаягдал, бохирдлыг тогтоосон хэм хэмжээнээс хэтрүүлсэн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Зөрчлийг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан ба харьяалал. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлд зааснаар Зөрчлийн тухай хуулийн 7.10 дугаар зүйлийн Газрын хэвлийн тухай хууль зөрчих зөрчлийг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан болон харъяаллыг доорх хүснэгтээр харуулав. Үүнд:

Эрх бүхий албан тушаалтан	Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харьяалал
Зөрчлийн тухай хуулийн 7.10 дугаар зүйл. Газрын хэвлийн тухай хууль зөрчих	
Байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37) Геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч (6.42)	Зөрчлийн тухай хуулийн 7.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг
Байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37) Геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч (6.42)	Зөрчлийн тухай хуулийн 7.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг
Байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37) Геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч (6.42)	Зөрчлийн тухай хуулийн 7.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг
Байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37)	Зөрчлийн тухай хуулийн 7.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэг
Байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37)	Зөрчлийн тухай хуулийн 7.10 дугаар зүйлийн 5 дахь хэсэг
Геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч (6.42)	Зөрчлийн тухай хуулийн 7.10 дугаар зүйлийн 5.1 дэх заалт
Байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37)	Зөрчлийн тухай хуулийн 7.10 дугаар зүйлийн 6 дахь хэсэг
Байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37)	Зөрчлийн тухай хуулийн 7.10 дугаар зүйлийн 7 дахь хэсэг
Геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч (6.42)	Зөрчлийн тухай хуулийн 7.10 дугаар зүйлийн 8 дахь хэсэг

Дээрх хүснэгтээр харуулсан Газрын хэвлийн тухай хууль зөрчих зөрчлийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.37-д заасан байгаль орчны хяналтын улсын байцаагч болон тус хуулийн 6.42-т заасан геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч нар харьяалах хэсэг, заалтыг тус тус шалган шийдвэрлэнэ.

Хуулийн нэр томьёоны тайлбар. Зөрчлийн тухай хуулийн 7.10 дугаар зүйлд заасан зөрчилтэй холбогдох нэр томьёог ихэвчлэн Газрын тухай хуульд, заримыг Газрын хэвийн тухай хуульд тайлбарласан байдаг бөгөөд тэдгээрийг дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

“Газар” гэж газрын гадаргуу, түүний хөрс, ой, ус, ургамал бүхий орон зайн давхаргыг,

“Газар өмчлөх” гэж тухайн газрыг захиран зарцуулах эрхтэйгээр хуулиар зөвшөөрсөн хүрээнд өөрийн мэдэлд байлгахыг,

“Газар эзэмших” гэж газрыг гэрээнд заасан зориулалт, нөхцөл, болзлын дагуу хуулиар зөвшөөрсөн хүрээнд өөрийн мэдэлд байлгахыг,

“Газар ашиглах” гэж хуулиар зөвшөөрсөн хүрээнд газар өмчлөгч, эзэмшигчтэй байгуулсан гэрээнд заасны дагуу газрын аль нэг ашигтай чанарыг нь гаргаж хэрэглэхийг,

“Газрыг чөлөөлөх” гэж тухайн газрыг эзэмших, ашиглах эрх дуусгавар болох, түүнчлэн газрыг зөвшөөрөлгүй ашигласан бол уг газар дээрх барилга байгууламж, бусад эд хөрөнгийг шилжүүлэх, газрыг засаж тохижуулах зэргээр хууль болон гэрээнд зааснаар газрыг өмчлөгчид нь эргүүлэн өгөхөд саадгүй болгохыг,

“Бэлчээр” гэж мал, амьтан бэлчээх зориулалттай байгалийн болон таримал ургамлын нөмрөг бүхий хөдөө аж ахуйн газарт хамааруулсан газрыг,

“Газар эзэмших эрхийн гэрчилгээ” гэж энэ хуулийн дагуу Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших эрхийг баталгаажуулсан баримт бичгийг,

“Газар ашиглах эрхийн гэрчилгээ” гэж энэ хуулийн дагуу гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын хуулийн этгээд, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын иргэн, харъяалалгүй хүний газар ашиглах эрхийг баталгаажуулсан баримт бичгийг,

“Нийтийн эдэлбэрийн газар” гэж зохих журмын дагуу нийтээр ашиглахаар тогтоогдсон төрийн өмчийн газрыг,

“Нэгж талбарын хувийн хэрэг” гэж газар өмчлөх эрх болон түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхтэй холбоотой цаасан болон цахим баримт бичгийн бүрдлийг,

“Бэлчээрийн даац” гэж тухайн бэлчээрийн ургамлын өсөлт, хөгжилт, нөхөн сэргэлтэд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр бэлчээж болох мал, амьтны тоогоор илэрхийлэгдэх бэлчээрийн чадавхыг тус тус ойлгоно хэмээн Газрын тухай хуульд заажээ.

“Газрын хэвлий” гэж хөрснөөс доош газрын гүн рүү үргэлжлэх орон зай, түүнийг эзлэн орших материаллаг бүх зүйлс (бүх төрлийн чулуулаг, ашигт малтмал болон геологийн бусад биет, түүнчлэн барилга байгууламж) хэмээн Газрын хэвлийн тухай хуульд тодорхойлсон бол Монгол Улсын Үндсэн хуульд газрын хэвлий нь төрийн өмч, өөрөөр хэлбэл бүх ард түмний хөрөнгө гэжээ.

“Газрын хэвлийг ашиглах” гэж Газрын хэвлийн тухай хуульд зааснаар геологийн судалгаа хийх (Газрын хэвлийн тухай хуулийн 12 дугаар зүйл), ашигт малтмал олборлох (Газрын хэвлийн тухай хуулийн 13 дугаар зүйл) болон ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барилга байгууламж, түүний дотор нефть, хий, бусад бодис, материал хадгалах, хортой бодис, үйлдвэрлэлийн хаягдлыг хамгаалан булах, бохир ус зайлуулахад зориулан барилга байгууламж барих, ашиглах, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн бусад хэрэгцээг хангах зориулалтаар ашиглахыг ойлгоно. Харин ашигт малтмал хайх, ашиглах, олборлохтой холбогдсон харилцааг Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулахаар хуульчилжээ.

Газрын хэвлийг зөвхөн ашиглуулахаар олгох бөгөөд түүнийг төр өмчлөх эрхийг аливаа хэлбэрээр зөрчихийг хориглоно. Газрын хэвлийг Монгол Улсын аж ахуйн нэгж, байгууллага, иргэд ашиглана. Мөн Монгол Улсын хууль тогтоомжид заасан тохиолдолд газрын хэвлийг гадаад улсын хуулийн этгээд, иргэн, харьяалалгүй хүнд зохих журмын дагуу ашиглуулж болно.

Газрын хэвлийг (1) геологийн судалгаа хийх, (2) ашигт малтмал олборлох, (3) ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барилга байгууламж, түүний дотор нефть, хий, бусад бодис, материал хадгалах, хортой бодис, үйлдвэрлэлийн хаягдлыг хамгаалан булах, бохир ус зайлуулахад зориулан барилга байгууламж барих, ашиглах, (4) Аж ахуйн нэгж,

байгууллага, иргэдийн бусад хэрэгцээг хангах зэрэг зориулалтаар ашиглуулахаар олгодог. Газрын хэвлийг ашиглагчид нь газар эзэмшигч, ашиглагчдаас зохих журмын дагуу зөвшөөрөл авна.

Газрын хэвлийг ашиглах хугацаа. Газрын хэвлийг хугацаагүй буюу хугацаатайгаар ашиглалтад олгож болно. Газрын хэвлийг урьдчилан тодорхой хугацаа тогтоолгүйгээр ашиглалтад олгосон бол хугацаагүй түрээслэн ашиглах гэнэ. Газрын хэвлийг ашиглалтад хугацаатай олгох нийт хугацаа 30 жилээс илүүгүй байна. Шаардлагатай бол тогтоосон хугацааг газрын хэвлийг түрээслэн ашиглуулахаар анх олгосон байгууллагын шийдвэрээр сунгаж болох бөгөөд нэг удаад сунгах хугацаа 20 жилээс дээшгүй байна. Ашигт малтмалын ордыг ашиглах, хугацааг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад уурхайн эдэлбэрийн зөвшөөрлийг бүртгүүлсэн өдрөөс эхлэн тооцно.

Газрын хэвлийг ашиглах эрхийг (1) газрын хэвлийг цаашид ашиглах шаардлагагүй болсон, түүнийг ашиглахаар тогтоосон хугацаа дууссан, төрийн буюу олон нийтийн бусад хэрэгцээнд зориулан газрын хэвлийг буцаан авах зайлшгүй шаардлага гарсан, газрын хэвлийг ашиглаж байсан аж ахуйн нэгж, байгууллагыг татан буулгасан, хүн амын эрүүл мэндэд аюултай байдал бий болсон тохиолдолд бүрэн буюу хэсэгчлэн дуусгавар болгоно, (2) хэрэв газрын хэвлийг ашиглагч нь газрын хэвлийг олгосноос хойш 3 жилийн хугацаанд ашиглаж эхлээгүй, газрын хэвлийг олгосон зориулалтаас өөрөөр ашигласан, түүнийг ашиглах, хамгаалах бусад журмыг өөр хэлбэрээр ноцтой зөрчсөн, хуулиар тогтоосон үүргээ биелүүлээгүй зэрэг зөрчил гаргавал газрын хэвлийг ашиглах эрхийг дуусгавар болгож болно, мөн (3) аж ахуйн нэгж, байгууллага, иргэд газрын хэвлийг аж ахуйн болон ахуйн хэрэгцээндээ зориулан ашиглах талаар тогтоосон журам, нөхцөлийг зөрчвөл газрын хэвлийг ашиглах эрхийг нь дуусгавар болгож болно. Түүнчлэн (4) газрын хэвлийг ашиглах эрхийг дуусгавар болгох өөр үндэслэлийг Монгол Улсын хууль тогтоомжоор тогтоож болох бөгөөд (5) газрын хэвлийг ашиглах эрхийг уурхайн эдэлбэр олгосон тухай акт буюу газрын хэвлийг ашиглуулах тухай зөвшөөрөл олгосон байгууллага нь акт буюу зөвшөөрлөө хүчингүй болгох замаар дуусгавар болгоно.

3.7.2. Зөрчлийн ойлголт, шинж ба төсөөтэй зөрчлөөс ялгагдах шинж

Зөрчлийн тухай хуулийн 7.10 дугаар зүйлийн Газрын хэвлийн тухай хууль зөрчих зөрчих зөрчлийн ойлголт. Газрын хэвлийг дур мэдэн ашигласан, ашигт малтмал бүхий талбайд барилга байгууламж дур мэдэн барьсан, эсхүл газар доорх усны горимыг ашиглах цооног, геодези, маркшейдерийн тэмдгийг устгасан, эсхүл гэмтээсэн, газрын хэвлийд геологийн судалгаа хийх журам, шаардлагыг зөрчсөн нь хайгуул хийсэн ашигт малтмалын нөөцийг буруу үнэлэх, ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барилга байгууламж барих нөхцөлийг буруу тодорхойлоход хүргэсэн, газрын хэвлийг ашиглах явцад эвдэрсэн газрыг аюул осолгүй болгож цаашид ашиглаж болохуйцаар засаж тохижуулаагүй, ашиглах үед илэрсэн үнэт металл, үнэт чулуу, шинжлэх ухаан, түүх, соёлын үнэт зүйлийг зохих байгууллагад мэдэгдээгүй, ашиглах үед илэрсэн үнэт металл, үнэт чулуу, шинжлэх ухаан, түүх, соёлын үнэт зүйлийг улсад тушаах хуульд заасан шаардлагыг биелүүлээгүй, ашиглах үед түүнийг хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, ашигт малтмал олборлох, эрдэс түүхий эдийг боловсруулах, ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барих барилга байгууламжийн зураг төсөл зохиох, тэдгээрийг барих, ашиглалтад оруулах талаар хуульд заасан шаардлагыг зөрчсөн, газрын хэвлийг ашиглах аюулгүй ажиллагааны дүрэм, хэм хэмжээг зөрчсөн, газрын хэвлийг хамгаалах журам, түүнийг ашиглахад үүсч болзошгүй аюул осол, хортой нөлөөнөөс ажиллагчид, хүн ам болон мал, ан амьтан, байгаль орчин, барилга байгууламжийг хамгаалах шаардлагыг биелүүлээгүй газрын хэвлийг хамгаалах журам зөрчсөн үйлдэл эс үйлдэхүйг газрын хэвлийн тухай хууль зөрчих зөрчил гэнэ.

Зөрчлийн төсөөтэй зөрчлөөс ялгагдах шинж. Эрүүгийн хуульд энэ төрлийн зөрчилтэй шууд адилтган үзэх зүйл, заалт байхгүй тул Зөрчлийн тухай хуулийн 7.2 дугаар зүйлд заасан Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль зөрчих зөрчлийн шинжтэй харьцуулан доорх хүснэгтээр харуулав.

Ялгагдах шинж	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль зөрчих (Зөрчлийн тухай хуулийн 7.2 дугаар зүйл)	Газрын хэвлийн тухай хууль зөрчих (Зөрчлийн тухай хуулийн 7.10 дугаар зүйл)
Объект	Байгаль орчныг хамгаалах журам	Газрын хэвлийг хамгаалах журам
Объектив тал	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх, цөлжилттэй тэмцэх арга хэмжээний тухай журам зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй байна.	Газрын хэвлийг дур мэдэн ашигт малтмал, барилга байгууламж, гарын хэвлийд геологийн судалгаа хийх журам хэм хэмжээг зөрчсөн идэвхтэй үйлдлээр үйлдэгдэнэ.
Субьект	Зөрчлийн тухай хуулийн 3.2-т заасан 16 настай хэрэг хариуцах чадвартай хувь хүн, хуулийн этгээд байна.	Зөрчлийн тухай хуулийн 3.2-т заасан 16 наастай хэрэг хариуцах чадвартай хувь хүн хуулийн этгээд байна.
Субьектив тал	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх, цөлжилттэй тэмцэх арга хэмжээний журам зөрчсөн гэм буруугийн санаатай хэлбэр байна.	Газрын хэвлийн тухай хууль зөрчих зөрчил нь гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгдэнэ. Газрын хэвлийг дур мэдэн ашигт малтмал, барилга байгууламж, газрын хэвлийд геологийн судалгаа хийж буй ашиг олох зорилготой шунахайн сэдэлтэй байна.

Зөрчлийн тухай хуулийн 7.10 дугаар зүйлд заасан Газрын хэвлийн тухай хууль зөрчих зөрчил нь дор дурдсан шинжтэй байна. Үүнд:

Газрын хэвлийг дур мэдэн ашигласан, ашигт малтмал бүхий талбайд барилга байгууламж дур мэдэн барьсан байна
Газар доорх усны горимыг ашиглах цооног, геодези, маркшейдерийн тэмдгийг устгасан, эсхүл гэмтээсэн, газрын хэвлийд геологийн судалгаа хийх журам, шаардлагыг зөрчсөн байна
Хайгуул хийсэн ашигт малтмалын нөөцийг буруу үнэлэх, ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барилга байгууламж барих нөхцөлийг буруу тодорхойлоход хүргэсэн байна
Газрын хэвлийг ашиглах явцад эвдэрсэн газрыг аюул осолгүй болгож цаашид ашиглаж болохуйцаар засаж тохижуулаагүй байна
Ашиглах үед илэрсэн үнэт металл, үнэт чулуу, шинжлэх ухаан, түүх, соёлын үнэт зүйлийг зохих байгууллагад мэдэгдээгүй, ашиглах үед илэрсэн үнэт металл, үнэт чулуу, шинжлэх ухаан, түүх, соёлын үнэт зүйлийг улсад тушаах хуульд заасан шаардлагыг биелүүлээгүй байна
Ашиглах үед түүнийг хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй
Ашигт малтмал олборлох, эрдэс түүхий эдийг боловсруулах, ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барих барилга байгууламжийн зураг төсөл зохиох, тэдгээрийг барих, ашиглалтад оруулах талаар хуульд заасан шаардлагыг зөрчсөн байна

Газрын хэвлийг ашиглах аюулгүй ажиллагааны дүрэм, хэм хэмжээг зөрчсөн, газрын хэвлийг хамгаалах журам, түүнийг ашиглахад үүсч болзошгүй аюул осол, хортой нөлөөнөөс ажиллагчид, хүн ам болон мал, ан амьтан, байгаль орчин, барилга байгууламжийг хамгаалах шаардлагыг биелүүлээгүй байна.

Газрын хэвлийг дур мэдэн ашигласан гэж газрын хэвлийг геологийн судалгаа хийх, ашигт малтмал олборлох, ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барилга байгууламж, түүний дотор нефть, хий, бусад бодис, материал хадгалах, хортой бодис, үйлдвэрлэлийн хаягдлыг хамгаалан булах, бохир ус зайлуулахад зориулан барилга байгууламж барих, ашиглах талаар эрх бүхий байгууллагаас зөвшөөрөлгүй газрын хэвлийг дур мэдэн ашигласан үйлдэл байна.

Ашигт малтмал бүхий талбайд барилга байгууламж дур мэдэн барьсан гэж Ашигт малтмалтын тухай хууль зөрчиж зохих зөвшөөрөлгүй ашигт малтмал бүхий талбайд барилга байгууламжийг хууль бусаар дур мэдэн барьсан үйлдэл байна.

Газар доорх усны горимыг ашиглах цооног, геодези, маркшейдерийн тэмдгийг устгасан гэж газар доорх усны горимыг ашиглах координатын системийг бий болгосон дэлхийн гадаргуу дээрх цэгүүдийн байршлыг тодорхойлох, геодезийн сүлжээг бий болгосон тэмдэг, уурхайн хөрс хуулалт, олборлолтын мөргөцөг, уурхайн хажуу догол, давхарга, технологийн зам, хөрсний овоолго, зам талбай, бусад объектуудын зураглалыг тогтоосон тэмдэг тэмдэглэгээг устгасан, арилгасан, зориуд авч хаясан үйлдэл байна.

Газрын хэвлийд геологийн судалгаа хийх журам, шаардлагыг зөрчсөн гэж ашигт малтмал байгаа эсэхийг тогтоох зорилгоор ашигт малтмалын хуримтлалын байршил, тоо хэмжээг нарийвчлан тогтоох зорилгоор газрын гадаргуу, түүний хэвлийд геологи, хайгуулын судалгаа хийж, түүний нөөц, баялгийг ашиглах боломжийг судлан техник, эдийн засгийн үнэлгээ хийх журам, шаардлагыг зөрчсөн үйлдэл байна.

Ашигт малтмалын нөөцийг буруу үнэлэх, ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барилга байгууламж барих нөхцөлийг буруу тодорхойлоход хүргэсэн гэж хайгуулын ажлаар ашигт малтмалын тоо хэмжээ, хэлбэр, агуулга, эрдсийн бүрэлдэхүүн нь нарийвчлан тогтоогдсон, үйлдвэрийн аргаар олборлох боломжтой, эдийн засгийн үр ашигтай, баяжуулах технологи, олборлолтын уул техникийн нөхцлийг буруу тодорхойлсны улмаас газар доор барилга байгууламж барих нөхцөлийг буруу тодорхойлоход хүргэсэн байхыг ойлгоно.

Ашиглах явцад эвдэрсэн газрыг аюул осолгүй болгож цаашид ашиглаж болохуйцаар засаж тохижуулаагүй гэж газрын хэвлийд халдаж үйл ажиллагаа явуулж, эвдрэлд орсон газрын байгаль-экологийн доройтлыг арилгах, унаган төрхөд нь ойртуулж сэргээх, экологийн тогтвортой тогтолцоог бий болгож нөхөн сэргээж, тохижуулаагүйг ойлгоно.

Ашиглах үед илэрсэн үнэт металл, үнэт чулуу, шинжлэх ухаан, түүх, соёлын үнэт зүйлийг зохих байгууллагад мэдэгдээгүй гэж газрын хэвлийг ашиглах явцад үнэт чулуу, шинжлэх ухаан, түүх, соёлын үнэт зүйлийг олж илрүүлсэн ч хуульд заасны дагуу соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлэх, холбогдох байгууллагад мэдээлэх үүргээ биелүүлээгүйг ойлгоно.

Ашиглах үед илэрсэн үнэт металл, үнэт чулуу, шинжлэх ухаан, түүх, соёлын үнэт зүйлийг улсад тушаах хуульд заасан шаардлагыг биелүүлээгүй гэж газрын хэвлийг ашиглах явцад

үнэт чулуу, шинжлэх ухаан, түүх, соёлын үнэт зүйлийг олж илрүүлсэн ч хуульд заасны дагуу соёлын өвийг хамгаалах, холбогдох байгууллагад тушаах үүргээ биелүүлээгүйг ойлгоно.

Ашиглах үед түүнийг хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй гэж тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомж болон энэ хуулийн 42, 46 дугаар зүйлд заасан үүргийг биелүүлээгүйг ойлгоно.

Зураг төсөл зохиох гэж ашигт малтмал олборлох, эрдэс түүхий эдийг боловсруулах, ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барих барилга байгууламжийг төлөвлөх, барилгын ажил гүйцэтгэхэд шаардагдах загвар зураг, эх загвар зураг (эскиз), техник, эдийн засгийн үндэслэл, техникийн болон ажлын зураг, барилгын ажил гүйцэтгэх талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын төсөл, инженер хайгуулын судалгаа, инженер геологи, геодезийн зураглал, инженерийн тооцоо, өртгийн төсөв зэрэг баримт бичгийн иж бүрдлийг бий болгосон үйлдэл байна.

Тэдгээрийг барих, ашиглалтад оруулах талаар хуульд заасан шаардлагыг зөрчсөн гэж Барилгын тухай хуулийн Гуравдугаар бүлгийн 11, 12, 13, 14, 15, 16, 17 дугаар зүйлд заасан шаардлагыг зөрчсөн байхыг ойлгоно.

Газрын хэвлийг ашиглах аюулгүй ажиллагааны дүрэм, хэм хэмжээг зөрчсөн гэж аюулгүй ажиллагааны дүрэм, хэм хэмжээг бүх ажилчин, албан хаагчдаар судлуулж мөрдүүлэх, аюул ослоос урьдчилан сэргийлэх, аюул ослын үр дагаврыг арилгах арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх, ажиллагчдын амь насанд аюултай нөхцөл байдал бий болсон тохиолдолд ажлаа зогсоож, тэднийг аюулгүй газарт гаргаж, уг нөхцөл байдлыг арилгаж хэвийн болгох шаардлагатай арга хэмжээг шуурхай авах, аюулгүй ажиллагааны болон ариун цэврийн дүрэм, хэм хэмжээний шаардлагад тохирсон машин техник, тоног төхөөрөмж, материал, ажлын тусгай хувцас, бие хамгаалах бусад хэрэгслээр хангаж хэрэглүүлж байх, эсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг зохих ёсоор бүртгэн тооцох, хадгалах, зарцуулах, аюул осолгүй хэрэглэх зэрэг хуульд заасан аюулгүй ажиллагааны дүрэм, хэм хэмжээг зөрчсөнийг ойлгоно.

Газрын хэвлийг хамгаалах журам, түүнийг ашиглахад үүсч болзошгүй аюул осол, хортой нөлөөнөөс ажиллагчид, хүн ам болон мал, ан амьтан, байгаль орчин, барилга байгууламжийг хамгаалах шаардлагыг биелүүлээгүй гэж дээр дурдсан аюулгүй ажиллагаанд тавигдах шаардлагыг биелүүлээгүйг ойлгоно.

Ашигт малтмалын ордыг гэмтээж сүйтгэсэн, баялаг хэсгийг нь сорчлон олборлосон гэж тусгай зөвшөөрөл эзэмшигч ашигт малтмалын төрөл зүйлээс ялгаж, баялаг хэсгийг нь сорчлон олборлосон үйлдэл байна.

Ашигт малтмалын балансын нөөцийг зохистой ашиглах шаардлагыг зөрчсөн гэж ашигт малтмалын нөөц, үйлдвэрийн ач холбогдол бүхий орд тус бүрийн байршил, ашигт малтмалын нөөцийн хэмжээ, чанар, судалсан байдал, үйлдвэрлэлийн ашиглалтын түвшин, олборлолт, хаягдлын болон хайгуул хийсэн ашигт малтмалын нөөцийн блансыг ашиглах талаар хууль тогтоомжид заасан шаардлага зөрчсөн үйлдэл байна.

Олборлох үед ашигт малтмалын хаягдал, бохирдлыг тогтоосон хэм хэмжээнээс хэтрүүлсэн гэж тусгай зөвшөөрөл эзэмшигч ашигт малтмалын хаягдал, бохирдлыг тооцож, тогтоосон хэмжээнээс хэтрүүлэхгүй байх талаар хууль тогтоомжид заасныг зөрчсөн үйлдэл байна.

3.7.3. Зөрчлийн зүйлчлэл

Газрын хэвлийн тухай хууль зөрчих зөрчил нь газрын хэвлийг дур мэдэн ашигласан, ашигт малтмал бүхий талбайд барилга байгууламж дур мэдэн барьсан, эсхүл газар доорх усны горимыг ашиглах цооног, геодези, маркшейдерийн тэмдгийг устгасан, эсхүл гэмтээсэн, газрын хэвлийд геологийн судалгаа хийх журам, шаардлагыг зөрчсөн нь хайгуул хийсэн ашигт малтмалын нөөцийг буруу үнэлэх, ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барилга байгууламж барих нөхцөлийг буруу тодорхойлоход хүргэсэн, мөн газрын хэвлийг ашиглах явцад эвдэрсэн газрыг аюул осолгүй болгож цаашид ашиглаж болохуйцаар засаж тохижуулаагүй, ашиглах үед илэрсэн үнэт металл, үнэт чулуу, шинжлэх ухаан, түүх, соёлын үнэт зүйлийг зохих байгууллагад мэдэгдээгүй, ашиглах үед илэрсэн үнэт металл, үнэт чулуу, шинжлэх ухаан, түүх, соёлын үнэт зүйлийг улсад тушаах хуульд заасан шаардлагыг биелүүлээгүй, ашиглах үед түүнийг хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, түүнчлэн ашигт малтмал олборлох, эрдэс түүхий эдийг боловсруулах, ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барих барилга байгууламжийн зураг төсөл зохиох, тэдгээрийг барих, ашиглалтад оруулах талаар хуульд заасан шаардлагыг зөрчсөн, газрын хэвлийг ашиглах аюулгүй ажиллагааны дүрэм, хэм хэмжээг зөрчсөн, газрын хэвлийг хамгаалах журам, түүнийг ашиглахад үүсч болзошгүй аюул осол, хортой нөлөөнөөс ажиллагчид, хүн ам болон мал, ан амьтан, байгаль орчин, барилга байгууламжийг хамгаалах шаардлагыг биелүүлээгүй, ашигт малтмалын ордыг гэмтээж сүйтгэсэн, баялаг хэсгийг нь сорчлон олборлосон, эсхүл ашигт малтмалын балансын нөөцийг зохистой ашиглах шаардлагыг зөрчсөн, олборлох үед ашигт малтмалын хаягдал, бохирдлыг тогтоосон хэм хэмжээнээс хэтрүүлсэн зэрэг шинжтэй байдаг. Энэхүү зүйлд заасан халдлагын зүйл, үйл ажиллагааны явцад хуульд заасан шаардлага зөрчсөн үйлдэл эс үйлдлээрээ гэмт хэргээс ялгагдана.

Эрүүгийн хуулийн 24.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэргийг *тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмалын эрэл хайгуул, олборлолт, боловсруулалт, ашиглалт явуулсан, эсхүл ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доорх барилга байгууламж барьж хууль бусаар газрын хэвлийд халдсан* хэмээн томьёолсон байдаг.

2002 оны Эрүүгийн хуулийн 204 дүгээр зүйлд газрын хэвлийн хууль тогтоомж зөрчих гэмт хэрэг гэж тусгайлан заасан байсныг 2017 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэгт нэгтгэж, нэг зүйлд багтааж хүндрүүлэх шинжүүдийг гэмт хэрэгт тооцох болсон бөгөөд харин Зөрчлийн тухай хуульд заасан дээрх шинжүүдийг “зөрчил” болгосон байна. Мөн Эрүүгийн хуулийн 24.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хүндрүүлж үзэн эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан.

Зөрчлөөс ялгагдах гол шинж нь дээр дурдсан зөрчлийн шинжийг агуулалгүйгээр “... ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доорх барилга байгууламж барьж хууль бусаар газрын хэвлийд халдсан” үйлдэл юм. Уг “халдах” үйлдэлд ямар нэг хохирлын хэмжээ заагаагүй бөгөөд онолын хувьд хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг тул тодорхой үйлдэл хийснээр төгссөнд тооцогдоно.

“Хууль бусаар” гэж газрын хэвлийд халдах тодорхой эрх үүсгэсэн бичигт баримт олгогдоогүй эсхүл газрыг эзэмших, ашиглах эрх үүссэн боловч хуульд заасан тусгай шаардлагаар “газрын хэвлийд халдах” эрх үүсгэсэн баримт бичиг олгогдоогүй, батлагдаагүй, зөвшөөрөгдөөгүй байхад эрүүгийн хуульд заасан дээрх үйлдэл хийсэн нь зөрчлөөс ялгагдах шинж болох бөгөөд гэмт хэрэгт тооцно.

“Газар доорх байгууламж ашиглалтад оруулах, ашиглах талаар хуульд заасан шаардлагыг зөрчсөн” үйлдэл нь Газрын хэвлийн тухай хуулийн 3 дугаар бүлэгт заасан “... ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барих барилга байгууламжийн зураг төсөл зохиох, тэдгээрийг барих ашиглалтад оруулахад тавигдах хуулийн шаардлагуудыг хангаагүй” байхыг ойлгоно.

3.7.4. Зөрчлийг шалгах тодорхой ажиллагаа

Шинэчлэн найруулсан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 9.1 дүгээр зүйлд Зөрчил шалган шийдвэрлэх тусгай журамд зааснаар Эрх бүхий алба хаагч Зөрчлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 5.2 дугаар зүйл, 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 5.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 5.13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 6.20 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 6.26 дугаар зүйл 8.6, 8.7 дугаар зүйл, 14.7 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 15.33 дугаар зүйл, 17.1 дүгээр зүйлийн 7, 16 дахь хэсэг, 18.1, 18.2, 18.4 дэх заалт, 23 дахь хэсэгт заасан зөрчлийг шалгахад энэ хуульд заасан ердийн журмаас гадна, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр бүлэгт заасан тусгай журмыг баримтлан хэргийн газрын үзлэг хийх, таньж олуулах, туршилт хийх, нүүрэлдүүлж мэдүүлэг авах, ердийн ажиглалт явуулах, мэдүүлгийг газар дээр нь шалгах зэрэг ажиллагааг явуулна.

Харин байгаль орчны хяналтын улсын байцаагч нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр бүлэгт заасан зөрчил шалган шийдвэрлэх зорилгоор дараах тодорхой ажиллагааг явуулна. Үүнд:

Үзлэг хийх. Эрх бүхий албан тушаалтан шалгалтын явцад илэрсэн зөвшөөрлийн бичиг, төсөл, хөтөлбөр, техник-эдийн засгийн үндэслэл, гэрээ зэрэг бичиг баримт нь үнэн эсэх нь тодорхойгүй, хуулбарласан, эргэлзээтэй баримт материал гаргаж өгвөл тухайн бичиг баримтад үзлэгийн ажиллагаа явуулж, материалын шинж онцлогийг нарийн дурдаж тэмдэглэл хөтлөн гарын үсэг зуруулж хураан авна.

Тухайн баримтыг үндэслэн холбогдох гэрчээс мэдүүлэг авах, эрх бүхий байгууллагаас лавлагаа хүсэх, илт хуурамч бичиг баримт үйлдсэн, зөрчлийг хаацайлахын тулд албан тушаалтнаас хуурамч баримт бичиг хийж ирүүлсэн бол прокурорт мэдэгдэж даруй шилжүүлнэ.

Газрын хэвлийн ашиглалтын байдлыг энгийн нүдээр харж үнэлэлт дүгнэлт өгөх ба үзлэг хийхдээ гэмт хэрэг үйлдэгдсэн газар орны онцлог, нөхцөл байдал, тухайн үеийн байдлыг тодорхойлж үзлэгийн тэмдэглэлд тусгахаас гадна, эвдрэлд орсон газар, нөхөн сэргээсэн талбай (газрын хэвлийг ухах, ухаш (карьер), овоолгын талбай, засаж тохижуулалгүй орхисон газар г.м) зэргийг байршил тогтоогч GPS багажаар координатыг тогтооно. Энэ төрлийн зөрчлийн газарт үзлэг хийхэд байршил тогтоогч багаж (GPS), эвдэрсэн талбайн хэмжээг тогтоох зай хэмжигч, метр, лац, ломбо, зургийн аппарат, дүрс бичлэгийн камер, дээж авах сав, уут, хүрз, жоотуу, лоом зэрэг багаж хэрэгсэл хэрэг болно.

Үзлэгийн тэмдэглэлийг цэгцтэй, ойлгомжтой болгохын тулд дугаарлах, догол мөр авах, тодорхой объект, газар орны нэрээр хаяглах зэрэг байдлаар бичнэ. Жишээ нь: “Баяжуулах үйлдвэрийн хаягдлын далангийн талбайд хийсэн үзлэг”, “Уурхайн эдэлбэр газрын ахуйн хог хаягдлын цэгт хийсэн үзлэг” гэх мэтээр бичиж болох юм.

Үзлэгээр тогтоосон цэгүүдийг орон нутгийн газрын алба, Ашигт малтмалын газар, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны кадастрын хэлтэст хүргүүлэн хязгаарлалт, хориглолтын бүстэй давхцалтай эсэх, тусгай зөвшөөрлийн талбайн байдал, уурхайн эдэлбэр газрын зөвшөөрөл зэргийн талаар зурагтай лавлагаа авах нь зүйтэй.

Хураан авах. Газрын хэвлийн тухай хууль зөрчих зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлого, эд зүйл, зөрчил үйлдэхэд ашигласан зэвсэг, хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, уналга, эсхүл зөрчил шалгах ажиллагаанд ач холбогдолтой эд зүйл, баримт бичгийг хураан авна.

Эд хөрөнгө битүүмжлэх. Газрын хэвлийн тухай хууль зөрчих зөрчлийн хэрэгт ач холбогдол бүхий техник хэрэгсэл, агуулах байр сав зэрэг бусад зүйлийг битүүмжилнэ.

Мэдүүлэг авах. Газрын хэвлийн тухай хууль зөрчих зөрчил гарсан байдлыг тодруулах, зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдол бүхий баримт, мэдээллийг олох зорилгоор газрын хэвлийн тухай хууль зөрчих зөрчлийн оролцогчдоос мэдүүлэг авна.

Шинжилгээнд зориулж хэв загвар, дээж авах. Шинжилгээ хийлгэх зорилгоор нөлөөлөлд өртсөн газар орон, уулын чулууллаг, эрдэс түүхий эд, материал, үнэт металл, чулуу болон шинжлэх ухаан, түүх, соёлын үнэт зүйлс зэргээс дээж авна.

Шинжилгээ хийлгэх. Эрх бүхий албан тушаалтан тухайн шалгаж буй зөрчлийн онцлогт тохируулан газар, газрын хэвлий, түүний баялаг, уулын чулууллаг, эрдэс түүхий эд, материал, үнэт металл, тэдгээрийг зохистой ашиглах, нөхөн сэргээсэн байдлыг тогтоох зорилгоор шинжилгээ хийлгэж болно. Тухайлбал, газрын хэвлийг ашиглах явцад илэрсэн үнэт чулуу, үнэт металл, шинжлэх ухаан, түүх соёлын үнэт зүйлийг ашигласан эсэхийг тогтоох, нефтийн хог шаарыг мембран, флёнк дэвсэлгүйгээр эсвэл техникийн шаардлагын дагуу дэвсээгүйгээс тэдгээр нь задарч газрын хэвлий, хөрс, усанд шингэж байгаа эсэхийг нарийн мэргэжлийн шинжээчийг урьж шинжилгээ хийлгэж болно.

3.7.5. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд анхаарах асуудал

Зөрчлийн тухай хуулийн 7.10 дугаар зүйлд заасан Газрын хэвлийн тухай хууль зөрчих зөрчлийн хэрэг бүртгэлт, шалган шийдвэрлэх ажиллагааг явуулахдаа дараах зүйлсийг анхаарч, ажиллагааг гүйцэтгэнэ. Үүнд:

- Тухайн зөрчлийн онцлогт тохируулан газар, газрын хэвлий, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, стандарт, хэм хэмжээ, дүрэм, журам, шийдвэрийг судалж, зохих мэдлэгийг хуримтлуулах
- Байгаль орчинд нөлөөлөх үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа байгууллага, аж ахуйн нэгжийн төсөл, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх менежментийн төлөвлөгөөтэй эсэх, тэдгээрийн биелэлтийг шалгах
- Мөн тухайн газар нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн заагт багтаж буй эсэхийг шалган тогтоох. Энэ нь Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд зааснаар газрын хэвлийд халдах нь тусгай журам, шаардлага үйлчилдэг тул гэмт хэрэг эсхүл зөрчлийн алин болохыг ялгах зүйлчлэлийн ач холбогдолтой.
- Үзлэгээр тогтоогдсон цэгүүдийг орон нутгийн газрын алба, Ашигт малтмалын газар, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны кадастрын хэлтэст хүргүүлж хязгаарлалт, хориглолтын бүстэй давхцалтай эсэх, тусгай зөвшөөрлийн талбайн байдал, уурхайн эдэлбэр газрын зөвшөөрөл зэргийн талаар зурагтай лавлагаа авах
- Археологийн болон палентлогийн судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн эсэх, түүх соёлын үнэт зүйлийг уулын ажлын явцад эвдэж сүйтгэх, зохих байгууллагад мэдэгдсэн эсэхийг шалгах
- Газрын хэвлий ашиглах явцад илэрсэн үнэт чулуу, үнэт металл, шинжлэх ухаан, түүх соёлын үнэт зүйлсийг улсад тушаасан эсэхийг шалгах
- Нефтийн компаниуд, нефтийн хог шаарыг мембран, флёнк дэвсэлгүйгээр эсвэл техникийн шаардлагын дагуу дэвсээгүйгээс эдгээр нь задарч хөрс, усанд шингэж

байгаа эсэхийг мэргэжлийн байгууллагын туслалцааг авч тогтоох (шинжилгээний дээжийг сонгон авч энэ тухай тэмдэглэл үйлдэн шинжлүүлж байх)

- Уул уурхайн техник-эдийн засгийн үндэслэлд чиглэсэн шалгалтыг явуулж байх, мөн геологи, уул уурхайн үйлдвэрлэл, техник, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны талаарх хууль тогтоомж, дүрэм, журмын болон үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх талаар авсан арга хэмжээг шалгах
- Ордыг сорчлон олборлочхоод хаягдал болон эфель олборлох гэсэн аж ахуйн нэгжид лицензээ шилжүүлсэн асуудал байгаа эсэхийг анхаарч шалгах, мөн уулын ажлын технологийн горимыг зөрчин байгалийн баялгийг сорчлон олборлож их хэмжээний хаягдал үүсгэх, улмаар хувираа буюу гар аргаар ашигт малтмал олборлох боломж бий болгож байгаль орчинд ихээхэн сөрөг нөлөөлөл үзүүлэх тохиолдлууд ихээхэн гарах болсон тул сайтар нягтлан шалгаж байх
- Газрын хэвлийн хууль тогтоомж зөрчсөн тухайн аж ахуйн нэгжийг урьд өмнө төрийн эрх бүхий байгууллага (Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Ашигт малтмалын газар, Усны сав газрын захиргаа болон орон нутгийн газрууд г.м)-аас шалгаж тавьсан акт, албан шаардлага, мэдэгдэл, дүгнэлт, шинжилгээний хариу, торгуулийн тасалбар, шийтгэвэр, маргаантай асуудлаар гарсан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, албан бичиг зэрэг тухайн асуудалтай холбогдол бүхий баримт бичигт үзлэг хийж, хуулбарлан хавсаргаж байх
- Мөн тухайн аж ахуйн нэгж, байгууллагын дотоод бичиг баримтад үзлэг хийж шалгаж буй хэрэгт хамааралтай тушаал, ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээ, хамтран ажиллах болон туслан гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, ашиг хуваарилсан баримт, уулын ажлын төлөвлөгөө, хайгуулын ажлын тайлан, нөөцийн материал, орд газрын болон уурхайн байгууламжийн зураглал, сүүлийн байдлаар хийсэн хөрсний зураглал (3D технологи), үндсэн, охин, толгой зэрэг компаниудын улсын бүртгэлийн гэрчилгээ, гадаадын хөрөнгө оруулалтын гэрчилгээ, татварын тайлан, үүсгэн байгуулалт болон хөрөнгө оруулагчтай холбоотой баримт зэргийг хураан авах, хуулбарлан авах ажиллагааг явуулж байх
- Газрын хэвлийг ашиглах, хамгаалах журам зөрчсөний улмаас хүрээлэн байгаа орчин, байгалийн нөөц, экосистем, биологийн олон янз байдалд учруулсан хохирлыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан 2025 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн А/37, А/31 дүгээр тушаалаар батлагдсан “Хүрээлэн байгаа орчны хохирол тооцох аргачлал”[23]-аар тооцож тогтоолгох, хохирол нөхөн төлүүлэх явдлыг хангахад чиглэгдсэн ажиллагааг прокурорт танилцуулан шийдвэрлэх
- Ашигт малтмал бүхий талбайд барилга байгууламж дур мэдэн барьсан эсхүл газар доорх усны горимыг ашиглах цооног, геодези, маркшейдерийн тэмдгийг устгасан, эсхүл гэмтээсэн үйлдлийг үзлэг хийж, гэрэл зургаар бэхжүүлэх
- Газрын хэвлийд геологийн судалгаа хийх журам, шаардлагыг зөрчсөн нь хайгуул хийсэн ашигт малтмалын нөөцийг буруу үнэлэх, ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барилга байгууламж барих нөхцөлийг буруу тодорхойлоход хүргэсэн бол гэрч, холбогдогчоос энэ талаар тодорхой мэдүүлэг авах, журамд заасан шаардлага бүрийг тавьж асуух
- Ашигт малтмал олборлох, эрдэс түүхий эдийг боловсруулах, ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барих барилга байгууламжийн зураг төсөл зохиох, тэдгээрийг барих, ашиглалтад оруулах талаар хуульд заасан шаардлагыг зөрчсөн бол зураг төслийг хураан авах, хуульд заасан эрхтэй эсэхийг шалгах, журмын шаардлага нэг бүрээр эрх бүхий албан тушаалтнаас мэдүүлэг авах, зураг төсөлд баталгаажуулалт хийсэн эрх бүхий аж ахуйн нэгж, албан тушаалтны үйлдэл тус

23 https://legalinfo.mn/mn/detail?lawId=17356011967381&showType=1

бүрийг мэдүүлэгт тусгах, барилгын ажил гүйцэтгэхтэй холбоотой тусгай зөвшөөрөл, ажил гүйцэтгэх гэрээ, туслан гүйцэтгэгчийн гэрээ, бараа материалын захиалгын хуудас, үйлдвэрлэгчийн баталгаа, ажлын явцыг шалгасан төрийн байгууллагын комиссын шийдвэр, дүгнэлт зэргийг анхаарах, ашиглалтад хүлээн авсан акт, шийдвэр, тэдгээрийн заалт нэг бүрийг судлах

- Газрын хэвлийг ашиглах аюулгүй ажиллагааны дүрэм, хэм хэмжээг зөрчсөн, газрын хэвлийг хамгаалах журам, түүнийг ашиглахад үүсэж болзошгүй аюул осол, хортой нөлөөнөөс ажиллагчид, хүн ам болон мал, ан амьтан, байгаль орчин, барилга байгууламжийг хамгаалах шаардлагыг биелүүлээгүйн улмаас бохирдол үүссэн бол баримтжуулан прокурорт мэдэгдэх, улмаар цагдаагийн байгууллага эрүүгийн хэрэг үүсгэн шалгах үндэслэл болно.
- Газрын хэвлийг ашиглах, хамгаалах журам зөрчсөний улмаас хүрээлэн байгаа орчинд учруулсан хохиролд төрийн захиргааны байгууллагын эрх бүхий албан тушаалтнаас томилсон этгээд болон иргэнээс хохирогчоор хуульд заасан үндэслэл журмын дагуу мэдүүлэг авч, энэ тухай тэмдэглэл үйлдэнэ. Мэдүүлгийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.8, 4.9-д заасан журмыг баримтлан явуулна.
- Хяналт тавих үүрэг бүхий албан тушаалтнуудын албан үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс хамаарч зөрчил үйлдэгдэхэд нөлөөлсөн бол Төрийн албаны тухай хуульд зааснаар сахилгын шийтгэл хүлээлгэх эсэх талаар хариуцсан дээд шатны байгууллагад бичгээр хандах. Шаардлагатай бол тухайн газар орныг хариуцсан мэргэжилтэн, байгаль хамгаалагч нараас гэрчийн мэдүүлэг авч, ажил үүргийн хувьд хэн нь юу хариуцдаг болох, хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолт зэргийг үзэх, хуулбарлан авах.

Бодлого 1

Байгаль орчны улсын байцаагч “А” нь “Тариа” ХХК-ийн Дархан уул аймгийн Сант нэртэй газарт орших полиметалийн баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааг шалгах төлөвлөгөөт удирдамжийн дагуу шалгалт явуулав. Шалгалтаар баяжуулах үйлдвэрийн хаягдлын далангийн газар нь уурхайн эдэлбэр газарт ордоггүй, газар ашиглах эрхийн гэрчилгээ болон орон нутагтай байгуулсан гэрээ байгаа боловч хугацаа нь дууссан, тэдгээрийг сунгуулаагүй, хаягдлын далангийн зураг төсөл нь “Тариа” ХХК-ийн зураг төсөл гэх боловч хянан баталгаажилт хийгдээгүй, хятад ханз бүхий зургийг орчуулгагүйгээр тэр чигт нь хуулбарлан тавьсан, хаягдлын даланд ашигласан флёнк буюу гоемембран давхарга дэвсэхдээ очлуурт шалгалт хийгээгүйн улмаас шаардлага хангахгүй материалаар хийж нэлэнхийдээ урагдаж салбарсан, цаашид хаягдлын даланд хуримтлагдсан технологийн бохир ус нэмэгдэж байгальд хаягдаж болзошгүй нөхцөл байдал тогтоогдов.

Асуулт

1. Дээрх үйлдэл нь ямар хууль тогтоомж зөрчсөн вэ?
2. Энэ зөрчлийг шалгах ажиллагааны үед ямар ажиллагаа явуулах вэ?
3. Дээрх хууль бус үйлдэл нь Зөрчлийн тухай хуульд заасан ямар зөрчил болох вэ? Зөрчлийг зүйлчилнэ үү?
4. Зөрчил үйлдэгчид ямар шийтгэл оногдуулах вэ?

Хариулт

1. Дээрх үйлдэл нь ямар хууль тогтоомж зөрчсөн бэ?
“Тариа” ХХК-ийн Дархан уул аймгийн Сант нэртэй газарт үйл ажиллагаа явуулсан нь Газрын тухай хуулийн 37.1-д эрхийн гэрчилгээний хүчин төгөлдөр байх хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө эзэмшигч нь хугацаа сунгуулах тухай хүсэлтээ цахим системээр

гаргах бөгөөд дараах баримт бичгүүдийг хавсаргана, мөн 56.5-д газар эзэмших, ашиглах хугацаа дууссан, тэрчлэн зохих зөвшөөрөлгүй барилга байгууламж барьсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар чөлөөлөх тухай мэдэгдлийг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас өгсөн тохиолдолд тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага заасан хугацаанд багтааж газар чөлөөлөх үүрэгтэй. Газрын хэвийн тухай хуулийн 36 дугаар зүйлд заасан Газрын хэвлийг ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар ашиглах журам, (1) ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барилга байгууламж барих, ашиглах болон бусад ийм зорилгоор газрын хэвлийг ашиглахдаа эрх бүхий байгууллагын зөвшөөрч баталсан зураг төслийг баримтална гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

2. Энэ зөрчлийг шалгах ажиллагааны үед ямар ажиллагаа явуулах вэ?
Уг зөрчлийг шалгах ажиллагаа “Тариа” ХХК-ийн Дархан уул аймгийн Сант нэртэй газарт газар доор барих хаягдлын далангийн барилга байгууламжийн зураг төсөл хаанахын ямар компаниар хийлгэсэн болох, хэрхэн баталгаажуулсан, хаягдлын далан барих захиалгын гэрээ, гүйцэтгэл, ашиглалтад өгсөн баримт, хуульд заасан барилгын тусгай эрхтэй гүйцэтгэгч байсан эсэх, барилгын явцад хийгдсэн ажил гүйцэтгэх гэрээ, туслан гүйцэтгэгчийн гэрээ, бараа материалын захиалгыг хуудас, үйлдвэрлэгчийн баталгаа, ажлын яцыг шалгасан төрийн байгууллагын комиссын шийдвэр, дүгнэлт, ашиглалтад хүлээн авсан акт, шийдвэр, тэдгээрийн заалт, ашиглалтад өгөх үед комисс хүлээн авсан бичиг баримтын жагсаалт, архивын нэгж болсон бичиг баримт зэргийг үзэж шалган, шаардлагатайгнь хуулбарлана авна. Мөн зөрчлийн газарт бусад зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд дурдсан аргачлалын дагуу үзлэг хийнэ. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд оролцох хохирогчийг тогтоолгон мэдүүлэг авах ажиллагааг явуулна.

3. Дээрх хууль бус үйлдэл нь Зөрчлийн тухай хуульд заасан ямар зөрчил болох вэ? Зөрчлийг зүйлчилнэ үү?
Энэ үйлдлийг Зөрчлийн тухай хуулийн 7.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан газрын хэвлийг дур мэдэн ашигласан, мөн энэ хуулийн 7.10 дугаар зүйлийн 5.1 дэх заалт зураг төсөл зохиох, 5.2 дахь заалт тэдгээрийг барих, ашиглалтад оруулах талаар хуульд заасан шаардлагыг зөрчсөн гэж үзэж Зөрчлийн тухай хуулийн 7.10 дугаар зүйлийн 1, 7.10 дугаар зүйлийн 5.1, 5.2-т зааснаар зүйлчилж шийтгэл оногдуулна.

4. Зөрчил үйлдэгчид ямар шийтгэл оногдуулах вэ?
Үйлдэгдсэн зөрчилд хүлээлгэх хариуцлага: Зөрчлийн тухай хуулийн 7.10 дугаар зүйлийн 1-д зааснаар “..... аймгийн ..... сумын ..... нэртэй газарт орших полиметалийн баяжуулах үйлдвэрийн баяжуулах үйлдвэрийн хаягдлын далангийн газарт “газар ашиглах эрхийн гэрчилгээ болон орон нутагтай байгуулсан гэрээ” байгаа боловч хугацаа нь дууссан, тэдгээрийг сунгуулаагүй байх тул газрын хэвлийг дур мэдэн ашигласан гэж үзэж хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Мөн Зөрчлийн тухай хуулийн 7.10 дугаар зүйлийн 5.1, 5.2-д зааснаар “Хаягдлын далангийн зураг төсөл нь хянан баталгаажилт хийгдээгүй, хаягдлын далан барих, ашиглалтад оруулахдаа технологийн шаардлага хангаагүй” үйлдэл нь “Ашигт малтмал олборлох, эрдэс түүхий эдийг боловсруулах, ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барих барилга байгууламжийн зураг төсөл зохиох, тэдгээрийг барих, ашиглалтад оруулах талаар хуульд заасан шаардлагыг зөрчсөн” гэж үзээд хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Бодлого 2

Геологи, уул, уурхайн хяналтын улсын байцаагч Т нь Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан сумын 2 дугаар багийн нутаг Андайн шанд гэх газарт төлөвлөгөөний дагуу шалгалт явуулав. Шалгалтаар Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан сумын 2 дугаар багийн нутаг Андайн шанд гэх газарт А.Г болон Б.О нар нь 2021 оны 5 дугаар сарын 10-ны өдөр хууль бусаар их хэмжээний ашигт малтмал олборлож, хаягдлыг ойролцоох газарт орхижээ. Мөн тухайн газраа суурин байх барилга барьсан нь тус тус шалгалтаар тогтоогджээ. А.Г нь уг газрыг эзэмших эрхтэй ба ашигт малтмалын хайгуул хийх зөвшөөрөлтэй учраас ашигт малтмал олборлосон гэв.

Асуулт

1. Дээрх үйлдэл нь ямар хууль тогтоомж зөрчсөн вэ?
2. Энэ зөрчлийг шалгах ажиллагааны үед ямар ажиллагаа явуулах вэ?
3. Дээрх хууль бус үйлдэл нь Зөрчлийн тухай хуульд заасан ямар зөрчил болох вэ? Зөрчлийг зүйлчилнэ үү?
4. Зөрчил үйлдэгчид ямар шийтгэл оногдуулах вэ?

Хариулт

1. Дээрх үйлдэл нь ямар хууль тогтоомж зөрчсөн бэ?
Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан сумын 2 дугаар багийн нутаг Андайн шанд гэх газарт А.Г болон Б.О нар нь хууль бусаар их хэмжээний ашигт малтмал олборлож, хаягдлыг ойролцоох газарт орхисон нь Газрын тухай хуулийн 31.4-д хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгохоос өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, зөвшөөрөл авсан байна, мөн Зөрчлийн тухай хуулийн 7.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан ашигт малтмал бүхий талбайд барилга байгууламж дур мэдэн барьсан, эсхүл газар доорх усны горимыг ашиглах цооног, геодези, маркшейдерийн тэмдгийг устгасан, эсхүл гэмтээсэн болон тус хуулийн 7.10 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасан ашигт малтмалын ордыг гэмтээж сүйтгэсэн, баялаг хэсгийг нь сорчлон олборлосон, эсхүл ашигт малтмалын балансын нөөцийг зохистой ашиглах шаардлагыг зөрчсөн, олборлох үед ашигт малтмалын хаягдал, бохирдлыг тогтоосон хэм хэмжээнээс хэтрүүлсэн гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

2. Энэ зөрчлийг шалгах ажиллагааны үед ямар ажиллагаа явуулах вэ?
Уг зөрчлийг шалгах ажиллагаа Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан сумын 2 дугаар багийн нутаг Андайн шанд гэх газарт А.Г нь газар эзэмших тухай хүсэлт гаргасан эсэх, газар эзэмшиж, ашиглах талаар Газрын төлбөрийн тухай хуулийн дагуу газрын төлбөр төлсөн эсэх, газар эзэмших эрхийн гэрчилгээтэй эсэх, хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгохоос өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, зөвшөөрөл авсан эсэхийг шалгах ажиллагаа явуулна.

3. Дээрх хууль бус үйлдэл нь Зөрчлийн тухай хуульд заасан ямар зөрчил болох вэ? Зөрчлийг зүйлчилнэ үү?
Энэ зөрчил нь Зөрчлийн тухай хуулийн 7.10 дугаар зүйлд заасан Газрын хэвлийн тухай хууль зөрчих зөрчил болох бөгөөд Зөрчлийн тухай хуулийн 7.10 дугаар зүйлийн 2, Зөрчлийн тухай хуулийн 7.10 дугаар зүйлийн 8-д зааснаар зүйлчилж шийтгэл оногдуулна.

4. Зөрчил үйлдэгчид ямар шийтгэл оногдуулах вэ?
Үйлдэгдсэн зөрчилд хүлээлгэх хариуцлага: Зөрчлийн тухай хуулийн 7.10 дугаар зүйлийн 2-д зааснаар “..... аймгийн ..... сумын ..... нэртэй газарт орших ‘’газар эзэмших эрхийн гэрчилгээ” байгаа боловч хүчингүй болж ашигт малтмал бүхий талбайд барилга байгууламж дур мэдэн барьсан гэж үзэж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Мөн Зөрчлийн тухай хуулийн 7.10 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт зааснаар хууль бусаар их хэмжээний ашигт малтмал олборлож, уг малтмалынхаа хаягдлыг ойролцоох газарт орхисон үйлдэл нь ‘’Ашигт малтмалын ордыг гэмтээж сүйтгэсэн, баялаг хэсгийг нь сорчлон олборлосон, эсхүл ашигт малтмалын балансын нөөцийг зохистой ашиглах шаардлагыг зөрчсөн, олборлох үед ашигт малтмалын хаягдал, бохирдлыг тогтоосон хэм хэмжээнээс хэтрүүлсэн’’ гэж үзэж хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Бодит жишээ 1 **Газрын хэвлийн тухай хууль зөрчих зөрчил**

Байгаль орчны улсын байцаагч “А” нь ..... ХХК-ийн ..... аймгийн ..... сумын Тээх нэртэй газарт орших полиметалийн баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааг шалгах төлөвлөгөөт удирдамжийн дагуу шалгалт явуулав. Шалгалтаар баяжуулах үйлдвэрийн хаягдлын далангийн газар нь уурхайн эдэлбэр газарт ордоггүй, газар ашиглах эрхийн гэрчилгээ болон орон нутагтай байгуулсан гэрээ байгаа боловч хугацаа нь дуусаж сунгуулаагүй, хаягдлын далангийн зураг төсөл нь ..... -улсын “.....” компанийн зураг төсөл гэх боловч хянан баталгаажилт хийгдээгүй, хятад ханз бүхий зургийг орчуулгагүйгээр тэр чигт нь хуулбарлан тавьсан, хаягдлын даланд ашигласан флёнк буюу гоемембран давхарга дэвсэхдээ очлуурт шалгалт хийгээгүйн улмаас шаардлага хангахгүй материалаар хийгдэж нэлэнхийдээ урагдаж салбарсан, цаашид хаягдлын даланд хуримтлагдсан технологийн бохир ус нэмэгдэж байгальд хаягдаж болзошгүй нөхцөл байдал бий болсон байна.

Зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаа
Уг зөрчлийг шалгах ажиллагаа ..... ХХК-ийн аймгийн ..... сумын .....нэртэй газарт газар доор барих хаягдлын далангийн барилга байгууламжийн зураг төсөл хаанахын ямар компаниар хийлгэсэн болох, хэрхэн баталгаажуулсан, хаягдлын далан барих захиалгын гэрээ, гүйцэтгэл, ашиглалтад өгсөн баримт, хуульд заасан барилгын тусгай эрхтэй гүйцэтгэгч байсан эсэх, барилгын явцад хийгдсэн ажил гүйцэтгэх гэрээ, туслан гүйцэтгэгчийн гэрээ, бараа материалын захиалгыг хуудас, үйлдвэрлэгчийн баталгаа, ажлын яцыг шалгасан төрийн байгууллагын комиссын шийдвэр, дүгнэлт, ашиглалтад хүлээн авсан акт, шийдвэр, тэдгээрийн заалт, ашиглалтад өгөх үед комисс хүлээн авсан бичиг баримтын жагсаалт, архивын нэгж болсон бичиг баримтууд зэргийг үзэж шалган, шаардлагатайг нь хуулбарлана авна.

Зөрчлийн газарт бусад зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд дурдсан аргачлалын дагуу үзлэг хийх, мөн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд оролцох хохирогчийг тогтоолгон мэдүүлэг авах гэх мэт.

Үйлдэгдсэн зөрчилд хүлээлгэх хариуцлага:

1. Зөрчлийн тухай хуулийн 7.10 дугаар зүйлийн 1-д зааснаар “..... аймгийн ..... сумын ..... нэртэй газарт орших полиметалийн баяжуулах үйлдвэрийн баяжуулах үйлдвэрийн хаягдлын далангийн газарт “газар ашиглах эрхийн гэрчилгээ болон орон нутагтай байгуулсан гэрээ” байгаа боловч хугацаа нь дууссан, түүнийг сунгуулаагүй байх тул газрын хэвлийг дур мэдэн ашигласан гэж үзэж хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2. Зөрчлийн тухай хуулийн 7.10 дугаар зүйлийн 5.1, 5.2-д зааснаар “Хаягдлын далангийн зураг төсөл нь хянан баталгаажилт хийгдээгүй, хаягдлын далан барих, ашиглалтад оруулахдаа технологийн шаардлага хангаагүй” үйлдэл нь “ашигт малтмал олборлох, эрдэс түүхий эдийг боловсруулах, ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барих барилга байгууламжийн зураг төсөл зохиох, тэдгээрийг барих, ашиглалтад оруулах талаар хуульд заасан шаардлагыг зөрчсөн” гэж үзээд хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Бодит жишээ 2 **Улсын дээд шүүхийн тогтоол**

Нийслэлийн …… дүүргийн улсын байцаагчид холбогдуулан гаргасан, “Эрх бүхий албан тушаалтан А 2024 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн № 123456 дугаартай шийтгэлийн хуудаст өөрчлөлт оруулах” нэхэмжлэлийн шаардлагатай (прокурорын дүгнэлт) захиргааны хэрэгт хянан шийдвэрлэх ажиллагаа явуулаад

ТОДОРХОЙЛОХ нь:

Хариуцагч Нийслэлийн …….. дүүргийн улсын байцаагчид холбогдуулан гаргасан, “Эрх бүхий албан тушаалтан А шүүхэд ирүүлсэн тайлбартаа.

“Миний бие “А” нь ..... дүүргийн 2024 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн № 123456 дугаартай шийтгэлийн хуудсаар зөрчил гаргасан “Ө”-д Зөрчлийн тухай хуулийн 7.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу торгох арга хэмжээ авсан. Би шийтгэлийн хуудастаа хуулийн зүйл, заалтыг дутуу бичсэн, мөн хэрэг шалгах хугацааг андуурч бичсэн бөгөөд прокуророос уг шийтгэлийн хуудаст өөрчлөлт оруулахаар тус шүүхэд дүгнэлт гаргасан байна.

Би уг дүгнэлттэй танилцаад, дүгнэлтийг хүлээн зөвшөөрч байна. Иймд, прокурорын дүгнэлтийг хүлээн зөвшөөрч байгаа тул энэ хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж өгнө үү” гэжээ.

ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д заасныг баримтлан Прокурорын газрын хяналтын прокурорын “Эрх бүхий албан тушаалтан А-ийн 2024 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн № 123456 дугаартай шийтгэлийн хуудаст өөрчлөлт оруулах” нэхэмжлэлийн шаардлагыг хариуцагч бүхэлд нь хүлээн зөвшөөрснийг баталж, Прокурорын газрын хяналтын прокурорын нэхэмжлэлтэй (дүгнэлт)-ийг үндэслэн Эрх бүхий албан тушаалтан А-д холбогдох захиргааны хэргийг хэрэгсэхгүй болгосугай.

2. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.3, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1-д тус тус зааснаар нэхэмжлэгч нь төсвийн байгууллага тул улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдсөнийг дурдаж, хариуцагчаас улсын тэмдэгтийн хураамжид 70,200 төгрөг гаргуулан улсын орлого болгосугай.

3. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.2-т зааснаар энэхүү захирамжийг захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн нэгэн адил журмаар биелүүлэхийг дурдсугай.

4. Хэргийн оролцогчид энэ захирамжид гомдол гаргах эрхгүй болохыг тайлбарласугай.

Шүүхийн шийдвэрийн үндэслэл, дүгнэлт

Газрын хэвлийг дур мэдэн ашигласан иргэн “Ө”-д 2024 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн № 123456 дугаартай шийтгэлийн хуудсаар зөрчил гаргасан “Ө”-д нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулсан боловч зөрчил шалгасан эрх бүхий албан тушаалтан “А” нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг буруу хэрэглэсэн тухайлбал, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.8 дугаар зүйлд заасан Зөрчлийн хэрэг бүртгэлтийн хугацааг эрх бүхий албан тушаалтан 14 хүртэл хоногийн дотор зөрчлийн хэрэг бүртгэлт явуулна, Зөрчил шалгах нэмэлт ажиллагаа явуулж нотлох баримт цуглуулах шаардлагатай бол зөрчлийн хэрэг бүртгэлтийн хугацааг зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан 14 хүртэл, прокурор 30 хүртэл хоногоор сунгаж болно.Зөрчлийн хэргийг харьяаллын дагуу шилжүүлсэн тохиолдолд хэрэг бүртгэлтийн хугацааг үргэлжлүүлэн тоолно. Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон үйлдэл, эс үйлдэлд зөрчлийн хэрэг нээх тухай прокурорын шийдвэрийг эрх бүхий байгууллага хүлээн авсан өдрөөс эхлэн зөрчлийн хэрэг бүртгэлтийн хугацааг тоолно” гэсэн заалтыг зөрчсөн нь шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болжээ.

Мөн Зөрчлийн тухай хуулийн 7.10 дугаар зүйлийн Газрын хэвлийн тухай хууль зөрчих зөрчлийн 1 дэх хэсэгт газрын хэвлийг дур мэдэн ашигласан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулахаар заасан боловч эрх бүхий албан тушаалтан шийтгэлийн хуудас дээр 7.1 гэж бичсэн нь зөрчил үйлдсэн этгээдийн үйлдэлд тохирохгүй зэргээр хуулийг буруу хэрэглэсэн нь зөрчил үйлдэгчид шийтгэл оногдуулахгүй өнгөрөх үндэслэл болсон байна.

Иймд зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтнууд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг сайтар судалж, зөрчил шалгах ажиллагааг хуулийн дагуу явуулснаар иймэрхүү алдаа, зөрчил дутагдал гаргахгүй байх үндэс бүрдэх юм.

3.8 УСНЫ ТУХАЙ ХУУЛЬ ЗӨРЧИХ, ЗӨРЧЛИЙН ШИНЖ, ОНЦЛОГ, АНХААРАХ АСУУДАЛ

3.8.1. Шийтгэл, эрх бүхий албан тушаалтан ба харьяалал, нэр томъёоны тайлбар

Шийтгэл. Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлийн Усны тухай хууль зөрчих тохиолдолд зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд дараах шийтгэл оногдуулна. Үүнд:

1. Хуульд заасны дагуу (1.1) усыг зөвшөөрөл авснаас өөр зориулалтаар ашигласан, (1.2) цооног өрөмдөх зөвшөөрөлгүйгээр газрын доорх усыг ашигласан, (1.3) ус ашиглахад тавигдах нөхцөлийг хангуулахаар төрийн албан хаагчийн тавьсан шаардлагыг биелүүлээгүй, (1.4) ус ашиглагчийн үүрэг, тавигдах шаардлагыг биелүүлээгүй, (1.5) усны эх үүсвэрийн онцгой, эсхүл энгийн хамгаалалтын бүс, эсхүл эрүүл ахуйн бүсийн дэглэмийг зөрчсөн, (1.6) ашиглаж дууссан цооногоо битүүмжилж хүлээлгэн өгөөгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2. Ус ашиглах зөвшөөрлийг бусдад худалдсан, эсхүл бусдад шилжүүлсэн, эсхүл усыг үйлдвэрлэлийн зориулалтаар зохих гэрээ, зөвшөөрөлгүйгээр, эсхүл гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашигласан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
3. Усны эх, ундаргын онцгой хамгаалалтын бүсэд хориглосон үйл ажиллагаа явуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
4. Гол, мөрний урсацын байгалийн үндсэн голдирлыг өөрчилсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
5. Хуульд заасан (5.1) усны сан бүхий газарт энгийн хамгаалалтын бүс, эсхүл эрүүл ахуйн бүс тогтоох шаардлага биелүүлэх, (5.2) усны тоо бүртгэл, эрэл, хайгуул, судалгааны тайлан, хяналт- шинжилгээний дүн мэдээ, ус ашиглалтын бүртгэл, хаягдал усны бүртгэлийг хугацаанд нь явуулах, (5.3) тайлан, мэдээг гаргаж өгөх журам зөрчсөн бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
6. Рашааны эх үүсвэрийн хамгаалалтын бүс, хязгаарлалтын бүс, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг зөрчсөн, эсхүл эдгээр бүсэд хориглосон үйл ажиллагаа явуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
7. Рашааныг (7.1) гэрээ, эсхүл зөвшөөрөлгүй ашигласан, (7.2) горимын хэмжээнээс хэтрүүлэн гэрээгүйгээр ашигласан, (7.3) зориулалтыг дур мэдэн өөрчилсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
8. Усны сан бүхий газарт хог хаягдал хаясан, эсхүл машин техник, бохир зүйл угаасан, эсхүл усны нөөцийг бохирдохоос хамгаалах үүргээ биелүүлээгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

9. Ус ашигласны төлбөрийг хугацаанд нь төлөөгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Зөрчлийг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан ба харьяалал. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлд зааснаар Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлийн Усны тухай хууль зөрчих зөрчлийг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан болон харъяаллыг доорх хүснэгтээр харуулав. Үүнд:

Эрх бүхий албан тушаалтан	Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харьяалал
Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйл. Усны тухай хууль зөрчих	
Улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч (6.27) Байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37)	Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг
Эрүүл ахуй, халдвар хамгаалллын хяналтын улсын байцаагч (6.59)	Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлийн 1.5 дахь заалт
Улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч (6.27) Байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37)	Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэг
Улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч (6.27) Байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37)	Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлийн 3 дахь хэсэг
Улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч (6.27) Байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37)	Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлийн 4 дэх хэсэг
Улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч (6.27)	Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлийн 5.1 дэх заалт
Улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч (6.27) Байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37)	Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлийн 5.2 дахь заалт
Улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч (6.27) Байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37)	Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлийн 5.3 дахь заалт
Улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч (6.27) Байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37)	Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлийн 6 дахь хэсэг
Улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч (6.27) Байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37)	Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлийн 7 дахь хэсэг
Улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч (6.27) Байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37) Цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч (6.8)	Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлийн 8 дахь хэсэг
Улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч (6.27) Байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37)	Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлийн 9 дэх хэсэг

Дээрх хүснэгтээр харуулсан Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлийн Усны тухай хууль зөрчих зөрчлийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.27-д заасан улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч бүхэлд нь шалган шийдвэрлэх эрхтэй байгаа бол байгаль орчны хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсэг, 5.2, 5.3 дахь заалт, 6, 7, 8, 9 дэх хэсгийг, эрүүл ахуй, халдвар хамгаалллын хяналтын улсын байцаагч зөвхөн Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлийн 1.5 дахь заалтыг, мөн цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлийн 8 дахь хэсгийг тус тус шалган шийдвэрлэх эрхтэй байна.

Хуулийн нэр томьёоны тайлбар. Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлд заасан зөрчилтэй холбогдох нэр томьёог Усны тухай хууль болон Байгаль орчныг хамгаалах тухай хуульд тус тус тайлбарласан байдаг бөгөөд тэдгээрийг дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

“Ус” гэдэгт Байгаль орчныг хамгаалах тухай хуульд томъёолсноор Монгол Улсын нутаг дэвсгэр дэх мөрөн, гол, горхи, булаг, шанд, рашаан, мөнх цас, мөс, мөсөн гол, байгалийн болон хиймэл нуур, цөөрөм зэрэг газрын гадаргын болон газрын доорх ус хамаарна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд зааснаар Монгол Улсын иргэнд өмчлүүлснээс бусад газар, газрын хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг төрийн өмч мөн бөгөөд төрийн эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлөөр ашиглахаас бусад тохиолдолд халдашгүй байна. Хууль, гэрээнд заасан журмын дагуу иргэн өмчийн болон эзэмшлийн, аж ахуйн нэгж, байгууллага эзэмшлийн газар дээрээ өөрийн хөрөнгөөр тарьж ургуулсан ургамал, ой мод, өсгөж үржүүлсэн амьтан болон хурын усыг хуримтлуулах замаар байгуулсан усан сан, нуур, цөөрмийг өмчилж болно.

Мөн тус хуульд зааснаар хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангах, байгаль орчныг хамгаалах зорилгоор байгаль орчинд гаргах хортой, аюултай бодисын агууламж, үзүүлэх сөрөг нөлөөллийн түвшний хэм хэмжээг *“байгаль орчны чадавхын хэм хэмжээ”* гэх бөгөөд усны биологийн хортой аюултай бодисын хүлцэх хэм хэмжээг стандартчиллын байгууллага тогтоох бол байгаль орчны чадавхын тогтоосон хэм хэмжээг хэтрүүлэн байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчинд учруулсан хохирлыг өөрөө арилгах буюу мэргэжлийн байгууллагаар арилгуулж гарсан зардлыг нөхөн төлнө. Харин усны нөөцөд учирсан хохирлыг тухайн сав газрын усны экологи–эдийн засгийн үнэлгээг гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр тогтооно.

“Усны нөөц” гэж Монгол Улсын нутаг дэвсгэр дэх усны сан бүхий газарт байгаа гадаргын ус болон газрын доорх усыг,

“Ашиглах боломжит нөөц” гэж усны сав газрын экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүйгээр тодорхой хугацаанд ашиглаж болох усны нөөцийн хэмжээг,

“Усны сав газар” гэж гадаргын ус хурах талбай болон газрын доорх усны нөөцийг бүрдүүлэх тэжээгдлийн муж, тархалтын талбайг хамарсан орон зайг,

“Усны сан бүхий газар” гэж нуур, цөөрөм, тойром, гол мөрөн, горхи, булаг, шанд, усан сан, рашаан, намаг, мөстөл, мөсөн голын эзэлж байгаа талбай, тэдгээрийн хамгаалалтын бүсийн газрыг,

“Гол, мөрний урсац бүрэлдэх эх” гэж гадаргын урсацын үндсэн хэсэг бүрэлдэн бий болдог өндөр уулсын бүс, сав газрын эхийг,

“Усны эх үүсвэр” гэж ус хангамжийн эх үүсвэрт ашиглаж байгаа усны нөөц болон гол мөрний урсац бүрэлдэх эхийг,

“Рашаан” гэж физикийн болон химийн өвөрмөц шинж чанар бүхий эмчилгээний ач холбогдолтой байгалийн ус, шаврыг,

“Рашааны орд” гэж газрын гадарга, түүний хэвлийд бүрэлдэн тогтсон рашаан агуулж байгаа газрыг,

“Онцгой болон энгийн хамгаалалтын бүс” гэдэгт усны сан бүхий газар, усны эх үүсвэр, рашааны ордыг хомсдох, бохирдохоос хамгаалах зорилгоор тогтоосон зурвас газрыг,

“Эрүүл ахуйн бүс” гэдэгт ус хангамжийн эх үүсвэр болон рашааны ордыг хамгаалах зорилгоор тогтоосон зурвас газрыг,

“Хилийн ус” гэж Монгол Улсын хилийн шугамын дагуу буюу огтлон оршиж буй гадаргын ба газрын доорх усыг,

“Усан сан” гэж усны нөөцийг хуримтлуулах, ашиглах зориулалтаар бий болгосон хиймэл нуур, хөв, цөөрмийг,

“Усны барилга байгууламж” гэж усны түрэлт, урсацыг тохируулах, ус хуримтлуулах, хадгалах, дамжуулах, хуваарилах, түгээх, ариутгах, цэвэрлэх, түүний чанарыг сайжруулах, газрын доорх ус олборлох, усны үер, гамшгаас хамгаалах энгийн болон инженерийн хийц бүхий барилга байгууламжийг,

“Услалтын систем” гэж бэлчээр, хадлан, тариаланг услах зорилгоор гадаргын болон газрын доорх ус хуримтлуулах, дамжуулах, хуваарилах, түгээх, илүүдэл усыг зайлуулах зориулалт бүхий усны барилга байгууламж, тоног төхөөрөмжийг багтаасан цогцолборыг,

“Ус хангамжийн эх үүсвэр” гэж худаг, татах, цуглуулах, цэвэршүүлэх байгууламж, түгээх зориулалт бүхий усны барилга байгууламжийг,

“Усны нөөцийн менежментийн төлөвлөгөө” гэж сав газрын усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбогдсон үйл ажиллагааг нэгдмэл байдлаар зохицуулах баримт бичгийг,

“Усны экологи-эдийн засгийн үнэлгээ” гэж усны нөөцийн байгалийн үнэ цэнэ, өгөөж, хэмжээ, чанар, хэрэглээний ач холбогдлыг мөнгөн хэлбэрээр илэрхийлснийг,

“Усны нөөцийн хомсдол” гэж усны нөөц багасах, усны чанар, байгалийн үнэ цэнэ, өгөөж доройтохыг,

“Усны бохирдол” гэж хүний шууд ба шууд бус үйл ажиллагааны улмаас байгалийн усны найрлага өөрчлөгдөж, усны чанар доройтохыг,

“Усны чанар” гэж усны чанарын стандартад нийцэх эсэхийг илэрхийлэх физик, хими, биологийн цогц шинж чанарыг,

“Усны чанарын стандарт” гэж усны хими, физик, биологийн шинж чанарын үзүүлэлтүүд нь хүний эрүүл мэнд, усан орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх хэм хэмжээг эрх бүхий байгууллагаар баталгаажуулсныг,

“Бохирдуулах бодис” гэж хаягдал усанд агуулагдаж, хүрээлэн байгаа орчныг бохирдуулж байгаа бодис, тэдгээрийн хольцыг,

“Аюултай бохирдуулах бодис” гэж байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан жагсаалтад орсон бодисыг,

“Хаягдал ус” гэж ахуйн хэрэглээ болон үйлдвэрлэл, үйлчилгээнээс гарч байгаа бохир ус, шингэн хаягдлыг,

“Хаягдал усны стандарт” гэж усны бохирдлын эх үүсвэрээс гарч байгаа хаягдал усанд байж болох бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээг эрх бүхий байгууллагаар баталгаажуулсныг,

“Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал бохир усны стандарт” гэж ариутгах татуургын сүлжээнд нийлүүлж болохыг тогтоосон үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэлтээс гарах хаягдал усан дахь бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээг,

“Ус ашиглагч” гэж ашиг олох зорилгоор үйлдвэрлэл, үйлчилгээндээ ус, усан орчин, рашааныг ашигладаг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг,

“Ус хэрэглэгч” гэж ашиг олох зорилгогүйгээр унд, ахуйн болон гэр бүл, өрхийн хэрэгцээний мал аж ахуй, газар тариаланд ус, усан орчинг ашигладаг хэрэглэгчийг,

“*Ус бохирдуулагч”* гэж ахуйн хэрэглээ болон үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж, хаягдал ус гаргаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг,

“Усны тоо, бүртгэл” гэж усны сан бүхий газар, ус хангамжийн эх үүсвэрийн тоо, хэмжээ, чанар, ашигласан болон хаягдал усны хэмжээ, ус бохирдуулагч эх үүсвэрийн тооллого явуулж бүртгэх үйл ажиллагааг,

“Ус ашигласны төлбөр” гэж ус, рашааны нөөцийг ахуйн болон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласны төлөө төлөх төлбөрийг,


“Ус бохирдуулсны төлбөр” гэж хаягдал усны стандартад нийцсэн агууламж бүхий ус зайлуулсан, хаясан тохиолдолд төлөх төлбөрийг,

“Ус бохирдуулсны нөхөн төлбөр” гэж хаягдал усны стандартаас хэтэрсэн агууламж бүхий ус зайлуулсан, хаясан тохиолдолд төлөх төлбөрийг,

“Гол мөрний татам” гэж голын голдирлын эргээс эхний дэнж хүртэлх нугын зурвас бүсийг тус тус ойлгоно.

3.8.2. Зөрчлийн ойлголт, шинж ба төсөөтэй гэмт хэргээс ялгагдах шинж

Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлд заасан Усны тухай хууль зөрчих зөрчил нь 9 хэсэг, 11 заалтаас бүрдэх бөгөөд тэдгээр нь тус бүрдээ онцлог шинжтэй юм. Иймд хэсэг тус бүрийг тусгайлан авч үзэх болно. Мөн Усны тухай хууль зөрчих зөрчлийг доорх схемээр тоймлон харуулав.



Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчилд:

- Ашиглах зөвшөөрөл авснаас өөр зориулалтаар ашигласан
- Зөвшөөрөлгүйгээр газрын доорх усыг ашигласан
- Ус ашиглахад тавигдах нөхцөлийг хангуулахаар төрийн албан хаагчийн тавьсан шаардлагыг биелүүлээгүй
- Ус ашиглагчийн үүрэг, тавигдах шаардлагыг биелүүлээгүй
- Усны эх үүсвэрийн онцгой, энгийн хамгаалалтын бүс, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг зөрчсөн
- Дууссан цооногоо битүүмжилж хүлээлгэн өгөөгүй үйлдлүүд тус тус хамаарна.

Усыг ашиглаж зөвшөөрөл авснаас өөр зориулалтаар ашигласан гэж ус ашиглах зөвшөөрөл, гэрээнд зааснаас өөр зориулалтаар ашигласан үйлдлийг ойлгоно. Усны тухай хуульд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, гадаад улсын хуулийн этгээд нь тодорхой зориулалт, хугацаа, болзол нөхцөл заасан ус ашиглах зөвшөөрөл, гэрээний үндсэн дээр хууль тогтоомжийн хүрээнд ус ашиглах эрхтэй бөгөөд энэ дагуу л ашиглах ёстой. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг ус ашиглах, хэрэглэх зориулалтаас хамааруулан ус хэрэглэгч, ус ашиглагч гэж ангилна.

“Зөвшөөрөлгүйгээр газрын доорх усыг ашигласан” гэж газрын доорх усыг ямар нэгэн зөвшөөрөлгүйгээр ашиглахыг ойлгоно. Аймаг, нийслэлийн байгаль орчны албан нь ус хэрэглээний тоо хэмжээ, чанарыг үндэслэн ус хэрэглэгчид цооног өрөмдөх, худаг гаргах, голоос суваг шуудуу татах зөвшөөрлийг олгодог. Монгол Улсын нутаг дэвсгэр дэх усны сан бүхий газарт байгаа усны нөөцийг гадаргын ус болон газрын доорх ус гэж ангилна.

Ус ашиглахад тавигдах нөхцөлийг хангуулахаар төрийн албан хаагчийн тавьсан шаардлагыг биелүүлээгүй гэж Усны тухай хуульд заасан ус ашиглагчид тавигдах шаардлагыг биелүүлэхгүй байгаа үйлдлийг ойлгоно.

Ус ашиглагчийн үүрэг, тавигдах шаардлагыг биелүүлээгүй гэж хуульд заасан шаардлагыг биелүүлээгүй үйлдэл, эс үйлдэл байна. Хуульд зааснаар ус ашиглагч нь:

- Ус ашиглах зөвшөөрөл, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашиглахгүй байх
- Хоногт 50 шоометрээс их ус ашиглагч Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31.7-д заасны дагуу дотоод хяналтын цэг, техник хэрэгсэлтэй байх ба усны хэрэглээ хариуцсан ус ашиглалтын менежер ажиллуулах
- Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл авах, ашиглалтын явцад гарах бохир усыг хаягдал усны стандартын шаардлагад нийцүүлэн цэвэрлэж, төвлөрсөн ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх, эсхүл шууд зайлуулах
- Ус авах цэг, газар доорх усны цооног, шугам хоолой бүрийг тоолууржуулах
- Ус, рашааны нөөц ашигласны болон ус бохирдуулсны төлбөр төлөх зэрэг үүрэгтэй.

Түүнчлэн рашаан ашиглагч энэ хуулийн 30.1-д зааснаас гадна, дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- Рашаан, эрдэст нуур, эмчилгээний шаврын найрлага, чанарын үнэлгээний үзүүлэлтэд горимын ажиглалт хийлгэн баталгаажуулж, рашаан ашиглалтын бүртгэл хөтөлж, дүн мэдээг сав газрын захиргаанд хүргүүлэх
- Үйл ажиллагаанаас гарах хаягдал ус, рашааныг цэвэрлэх байгууламж барьж ашиглах, эсхүл зайлуулах цэг тогтоолгох
- Рашааны ордыг бохирдол, хомсдолоос хамгаалах зорилгоор рашааны эрүүл ахуйн болон хориглолтын бүсийн хил, заагийг мэдэгдэхүйцээр тэмдэгжүүлэх, хашиж хамгаалах.

Мөн цацраг идэвхт бодис хэрэглэх үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын хаягдал ус цэвэрлэх байгууламж нь түүнийг бүрэн арилгах тусгай төхөөрөмжөөр тоноглогдсон байна. Хот, суурины унд ахуйн төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээнээс үйлдвэрлэлийн зориулалттай усны эх үүсвэр, шугам сүлжээг тусгаарлана.

Биологийн нөөц хамгаалах байгууламжгүй болон усыг үргүй зарцуулж ууршуулах, газрын хөрсийг намагжих, давсжих, эвдрэхэд хүргэхээр усны барилга байгууламж, усан сан, далан, суваг байгуулахыг хориглоно. Уул уурхайн олборлолтод ус ашиглах аж ахуйн нэгж, байгууллага ашигт малтмал баяжуулах усаа голын эрэг, голдирлыг үл хөндөн шахуурга, яндан хоолойгоор дамжуулан авах үүргийг хүлээнэ.

Усны эх үүсвэрийн онцгой, энгийн хамгаалалтын бүс, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг зөрчсөн гэж усны нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах, үер, усны гамшгаас сэргийлэх зорилгоор усны сан бүхий газар, усны эх үүсвэрийг хамгаалах зорилгоор бүс тогтоож, тухайн бүсэд баримтлах дэглэм журмыг зөрчсөн үйлдлийг ойлгоно.

Хамгаалалтын бүсийг онцгой, энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн гэсэн байдлаар ангилан тогтооно. Усны тухай хуульд зааснаар “онцгой болон энгийн хамгаалалтын бүс” гэдэгт усны сан бүхий газар, усны эх үүсвэр, рашааны ордыг хомсдох, бохирдохоос хамгаалах зорилгоор тогтоосон зурвас газрыг, “эрүүл ахуйн бүс” гэдэгт ус хангамжийн эх үүсвэр болон рашааны ордыг хамгаалах зорилгоор тогтоосон зурвас газрыг ойлгоно.

Усны сан бүхий газрын эргээс 50 метрээс доошгүй зайд болон гол мөрний татамд онцгой хамгаалалтын бүс тогтоож, тухайн бүсэд барилга, байгууламж барих, газар хагалах, тэсэлгээ хийх, газар тариалан эрхлэх, ашигт малтмал хайх, олборлох, зэгс, шагшуурга, мод огтлох, элс, хайрга, чулуу авах, байгалийн ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх, мал угаах болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх цэг байгуулахыг хориглоно.

Усны сан бүхий газрын эргээс 200 метрээс доошгүй зайд энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрээс 100 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн бүс тогтооно. Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журмыг байгаль орчны болон газрын харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах бөгөөд энэ журмаар онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн зааг, бүсэд мөрдөх дэглэмийг тогтооно. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дэглэм зөрчихийг хориглоно.

Нийслэлийн ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс, тэжээгдлийн мужийн заагийг байгаль орчин болон газрын харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран тогтооно.

Энэ хэсэгт зөвхөн усыг хамгаалах талаар гаргасан дэглэмийг зөрчих үйлдлүүд хамраана. Харин рашааны эх үүсвэрийн хамгаалалтын бүс, хязгаарлалтын бүс, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг зөрчсөн үйлдэл нь 6 дахь хэсэгт хамаарна.

Дууссан цооногоо битүүмжилж хүлээлгэн өгөөгүй гэж Усны тухай хуульд зааснаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ашиглаж дууссан цооногоо битүүмжлэн аймаг, нийслэлийн байгаль орчны алба, сум, дүүргийн Засаг даргад хүлээлгэн өгөх үүрэгтэй бөгөөд энэ заалтын дагуу ашиглаж дууссан цооногоо битүүмжилж өгөөгүй эс үйлдэл байна.

Сум, дүүргийн Засаг дарга усыг үйлдвэрлэлийн зориулалтаар зөвшөөрөлгүй ашиглах, дур мэдэн цооног гаргасан үйл ажиллагааг таслан зогсоох бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан зөрчилд:

- Ус ашиглах зөвшөөрлийг бусдад худалдсан
- бусдад шилжүүлсэн
- Усыг үйлдвэрлэлийн зориулалтаар зохих гэрээ, зөвшөөрөлгүйгээр ашигласан
- Гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашигласан үйлдлүүд тус тус хамаарна.



Ус ашиглах зөвшөөрлийг бусдад худалдсан гэж иргэн, хуулийн этгээдэд олгогдсон эзэмших, ашиглах захиран зарцуулах эрхийг баталгаажуулсан зөвшөөрлийг бусдад худалдсан үйлдлийг ойлгоно. Усны тухай хуульд зааснаар:

- Хоногт 100 шоометрээс их ус ашиглах, эрчим хүч, усан тээврийн зориулалтаар ашиглуулах дүгнэлтийг усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гаргаж, тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.28-д заасны дагуу сав газрын захиргаа
- 50-100 шоометр ус болон усан орчин ашиглуулах дүгнэлтийг сав газрын захиргаа гаргаж, тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.27-д заасны дагуу аймаг, нийслэлийн байгаль орчны алба
- 50 шоометр хүртэлх ус ашиглуулах, хурын ус хуримтлуулж, хөв, цөөрөм байгуулах, суваг, шуудуу татах дүгнэлтийг аймаг, нийслэлийн байгаль орчны алба гаргаж, энгийн зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.14-т заасны дагуу сум, дүүргийн Засаг дарга нар тус тус олгоно.

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, гадаад улсын хуулийн этгээд нь тодорхой зориулалт, хугацаа, болзол нөхцөл заасан ус ашиглах зөвшөөрөл, гэрээний үндсэн дээр хууль тогтоомжийн дагуу ус ашиглах эрхтэй.

Зөвшөөрлийг үндэслэн ус ашиглах эрхийн бичиг олгож, гэрээ байгуулснаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ус ашиглах эрх үүснэ. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ус ашиглах зөвшөөрлийг 10 хүртэл жилийн хугацаагаар олгож, гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж

ирсэн ус ашиглагчийн эрхийг тухай бүр 5 хүртэл жилээр сунгана. Мөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага усны нөөцийг гэрээний үндсэн дээр хамтран ашиглаж болно.

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших эрх нь өөрийн эзэмшлийн газар дахь ус ашиглах эрхийг төлөөлөхгүй.

Бусдад шилжүүлсэн гэж ус ашиглах зөвшөөрлийг бусдад шилжүүлж, ашиглуулсан үйлдэл байна.

Усыг үйлдвэрлэлийн зориулалтаар зохих гэрээ, зөвшөөрөлгүйгээр ашигласан гэж ус ашиглах гэрээ байгуулаагүй, зөвшөөрөлгүйгээр ус ашигласан үйлдэл байна. Ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн хүн амын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрээс хангагдаж байгаа ус ашиглагчтай тухайн ус хангагч байгууллага, төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрээс хангагдаж байгаа ус ашиглагчтай сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн байгаль орчны алба, сум, дүүргийн Засаг дарга гэрээ байгуулна.

Гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашигласан гэж Усны тухай хуульд зааснаар ус ашиглагч нь зөвшөөрөл, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашиглахгүй байх үүрэгтэй бөгөөд уг үүргээ биелүүлэхгүй байгаа эс үйлдэл байна.

Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан зөрчил нь усны эх, ундаргын онцгой хамгаалалтын бүсэд хориглосон үйл ажиллагаа явуулсан үйлдэл байна.

Усны эх, ундаргын онцгой хамгаалалтын бүсэд хориглосон үйл ажиллагаа явуулсан гэж тус бүсэд барилга, байгууламж барих, газар хагалах, тэсэлгээ хийх, газар тариалан эрхлэх, ашигт малтмал хайх, олборлох, зэгс, шагшуурга, мод огтлох, элс, хайрга, чулуу авах, байгалийн ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх, мал угаах болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх цэг байгуулах зэрэг хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулахыг ойлгоно.

Усны сан бүхий газар, усны эх үүсвэр, рашааны ордыг хомсдох, бохирдохоос хамгаалах зорилгоор тогтоосон зурвас газрыг онцгой хамгаалалтын бүс гэнэ. Тус бүс нь усны сан бүхий газрын эргээс 50 метрээс доошгүй зайд болон гол мөрний татмаар хязгаарлагдана.

Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан зөрчил нь гол, мөрний урсцын байгалийн үндсэн голдирлыг өөрчилсөн үйлдэл байна.

Гол, мөрний урсцын байгалийн үндсэн голдирлыг өөрчилсөн гэж байгалийн усны үндсэн тогтоц, урсцыг зориудаар, санаатайгаар өөрчилсөн үйлдлийг ойлгоно. Гол, мөрний байгалийн үндсэн голдирлыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэргүйгээр өөрчлөхийг хориглоно.

Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан зөрчилд:

- Усны сан бүхий газарт энгийн хамгаалалтын бүс тогтоох шаардлага биелүүлэх
- Эрүүл ахуйн бүс тогтоох шаардлага биелүүлэх
- Усны тоо бүртгэл, эрэл, хайгуул, судалгааны тайлан, хяналт- шинжилгээний дүн мэдээ, ус ашиглалтын бүртгэл, хаягдал усны бүртгэлийг хугацаанд нь явуулах
- Тайлан, мэдээг гаргаж өгөх журам зөрчсөн үйлдлүүд тус тус хамаарна.

Усны тухай хуульд заасан шаардлага биелүүлээгүй

5.1 Усны сан бүхий газарт энгийн хамгаалалтын бүс

5.2 Эрүүл ахуйн шаардлага биелүүлэх

5.2
- Усны тоо бүртгэл
- Эрэл хайгуул
- Судалгааны тайлан
- Хяналт шинжилгээний дүн, мэдээ
- Ус ашиглалтын бүртгэл
- Хаягдал усны бүртгэлийг хугацаанд нь явуулаагүй

5.3 Тайлан, мэдээг гарган өгөх журам зөрчсөн

Усны сан бүхий газарт энгийн хамгаалалтын бүс тогтоох шаардлага биелүүлэх гэж усны нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах, үер, усны гамшгаас сэргийлэх зорилгоор усны сан бүхий газар, усны эх үүсвэрт энгийн хамгаалалтын бүс тогтоох шаардлагыг биелүүлээгүй үйлдэл байна.

Эрүүл ахуйн бүс тогтоох шаардлага биелүүлэх гэж усны нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах, үер, усны гамшгаас сэргийлэх зорилгоор усны сан бүхий газар, усны эх үүсвэрт эрүүл ахуйн бүс тогтоох хууль зүйн шаардлагыг биелүүлээгүй үйлдэл байна.


Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлийн 5.2 дахь заалт нь усны тоо бүртгэл, эрэл, хайгуул, судалгааны тайлан, хяналт-шинжилгээний дүн мэдээ, ус ашиглалтын бүртгэл, хаягдал усны бүртгэлийг хугацаанд нь явуулах журам зөрчсөн үйлдэл байна.

Усны тоо бүртгэл гэж усны сан бүхий газар, ус хангамжийн эх үүсвэрийн тоо, хэмжээ, чанар, ашигласан болон хаягдал усны хэмжээ, ус бохирдуулагч эх үүсвэрийн тооллого явуулж бүртгэх үйл ажиллагааг ойлгоно.


Ус ашиглалтын бүртгэл гэж усны сан бүхий газар, ус хангамжийн эх үүсвэрийн тоо, хэмжээ, чанар, ашигласан болон хаягдал усны хэмжээ, ус бохирдуулагч эх үүсвэрийн тооллого явуулж бүртгэх үйл ажиллагааг ойлгоно.

Рашаан ашиглагч нь рашаан, эрдэст нуур, эмчилгээний шаврын найрлага, чанарын үнэлгээний үзүүлэлтэд горимын ажиглалт хийлгэн баталгаажуулж, рашаан ашиглалтын бүртгэл хөтөлж, дүн мэдээг сав газрын захиргаанд хүргүүлэх бөгөөд харин сав газрын захиргаа улсын усны тоо бүртгэл, статистикийн мэдээллийг нэгтгэн боловсруулах, усны нөөц, ус ашиглалтын тайланг улсын хэмжээнд нэгтгэн гаргах үүргийг хүлээнэ.

Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасан зөрчилд рашааныг хамгаалахтай холбогдсон дэглэм зөрчсөн үйлдэл хамаарна. Үүнд:
- Эх үүсвэрийн хамгаалалтын бүс
- Хязгаарлалтын бүс
- Эрүүл ахуйн бүсийн дэглэмийг зөрчсөн
- Эдгээр бүсэд хориглосон үйл ажиллагаа явуулсан үйлдлүүд хамаарна.



Рашаан нь өөрийн онцлогтой бөгөөд түүнийг харгалзан үзэж эрүүл ахуйн болон хамгаалалтын бүстэй байхаар хуульчилсан байна. Тухайн бүсийн дэглэмийг байгаль орчин болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран тогтооно.



Рашааны эх үүсвэрийн хамгаалалтын бүс нь хориглолтын болон хязгаарлалтын бүсээс бүрдэх бөгөөд эрүүл ахуйн бүсийн эргэн тойрны 200 метрээс доошгүй зайг хориглолтын бүс гэж ойлгох бол хязгаарлалтын бүсийг усны мэргэжлийн байгууллага тогтооно.

Эдгээр бүсэд хориглосон үйл ажиллагаа явуулсан гэж рашааны эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсэд Усны тухай хуульд заасан хориглосон үйл ажиллагаа явуулахыг ойлгоно.

Рашааны эрүүл ахуйн бүсэд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Үүнд:

- Рашааныг шууд авч ашиглахаас өөр зориулалтаар барилга байгууламж барих, тоног төхөөрөмж суурилуулах
- Хог хаягдал хаях, химийн бодис хадгалах.

Рашааны хориглолтын бүсэд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Үүнд:

- Рашааныг ашиглах зориулалттай барилга байгууламжийг хаягдал ус цэвэрлэх, зайлуулах байгууламжгүй барих
- Газар тариалан эрхлэх, мал бэлчээрлүүлэх, хадлан бэлтгэх
- Хог хаягдал хаях, хадгалах, бохирын цооног байгуулах.

Рашааны хязгаарлалтын бүсэд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Үүнд:

- Ус, рашаан ашиглахтай шууд холбоогүй барилга байгууламж барих
- Хог хаягдлын болон хаягдал ус зайлуулах байгууламж, цэг байрлуулах, нефтийн бүтээгдэхүүн, химийн бодис хадгалах.


Рашааны хязгаарлалтын бүсэд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Үүнд:

- Ус, рашаан ашиглахтай шууд холбоогүй барилга байгууламж барих

- Хог хаягдлын болон хаягдал ус зайлуулах байгууламж, цэг байрлуулах, нефтийн бүтээгдэхүүн, химийн бодис хадгалах зэрэг болно.

Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасан зөрчилд рашааныг ашиглахтай холбогдсон журам зөрчсөн үйлдэл хамаарна. Үүнд:

- Горимын хэмжээнээс хэтрүүлэн гэрээгүйгээр ашигласан
- Зориулалтыг дур мэдэн өөрчилсөн үйлдлүүд хамаарна.



Горимын хэмжээнээс хэтрүүлэн гэрээгүйгээр ашигласан гэж Усны тухай хуульд зааснаар рашааныг ашиглагч нь зөвшөөрөл, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашиглахгүй байх үүрэгтэй бөгөөд уг үүргээ биелүүлэхгүй байгаа үйлдэл болно. Ус ашиглагч нь ус ашиглах зөвшөөрөл, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашиглахгүй байх үүргийг хүлээдэг.


Зориулалтыг дур мэдэн өөрчилсөн гэж рашааныг ашиглагч, хэрэглэгч нь гэрээ, зөвшөөрөлд зааснаас өөр зорилгоор рашааныг ашигласан хэрэглэсэн санаатай үйлдэл болно.

Улсын нөөцөд бүртгэгдсэн рашааныг эмчилгээ-сувилгаа, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашиглах эсэх талаар усны сав газрын захиргаа дүгнэлт гаргана. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, гадаад улсын хуулийн этгээд нь тодорхой зориулалт, хугацаа, болзол нөхцөл заасан ус ашиглах зөвшөөрөл, гэрээний үндсэн дээр хууль тогтоомжийн дагуу ус ашиглах эрхтэй. Харин ус хэрэглэгч ашиглалтын зориулалтыг өөрчлөх, зөвшөөрөлгүйгээр цооног өрөмдөх, худаг гаргах, суваг шуудуу татахыг хориглодог.

Рашаан ашиглах зөвшөөрөл, гэрээнд хоногт ашиглах усны хэмжээ, зориулалтыг заавал тусгасан байна.

Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасан зөрчилд усны нөөцийг хамгаалах холбогдсон журам зөрчсөн үйлдэл хамаарна. Үүнд:

- Усны сан бүхий газарт хог хаягдал хаясан
- Усны сан бүхий газарт машин техник, бохир зүйл угаасан
- Усны сан бүхий газарт усны нөөцийг бохирдохоос хамгаалах үүргээ биелүүлээгүй үйлдлүүд хамаарна.



Усны сан бүхий газарт хог хаягдал хаясан, машин техник, бохир зүйл угаасан гэж Усны тухай хуулийн 24.1-д заасан усны сан бүхий газарт хог хаягдал, машин техник, бохир зүйлс угаахыг хориглосон хэм хэмжээг зөрчсөн үйлдлийг ойлгоно. Усны сан бүхий газарт цацраг идэвхт болон химийн хорт бодис, халдвар үүсгэгч, хог хаягдал, бохир ус хаях, хадгалах, машин техник, бохир зүйлс угаахыг хориглоно.

Усны сан бүхий газарт усны нөөцийг бохирдохоос хамгаалах үүргээ биелүүлээгүй гэж Усны тухай хуульд заасан ус ашиглагчийн үүргээ биелүүлээгүй эс үйлдэл хамаарна.

Ус ашиглагч нь хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл авах, ашиглалтын явцад гарах бохир усыг хаягдал усны стандартын шаардлагад нийцүүлэн цэвэрлэж, төвлөрсөн ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх, эсхүл шууд зайлуулах, үйл ажиллагаанаас гарах хаягдал ус, рашааныг цэвэрлэх байгууламж барьж ашиглах, эсхүл зайлуулах цэг тогтоолгох, рашааны ордыг бохирдол, хомсдолоос хамгаалах зорилгоор рашааны эрүүл ахуйн болон хориглолтын бүсийн хил, заагийг мэдэгдэхүйцээр тэмдэгжүүлэх, хашиж хамгаалах, мөн цацраг идэвхт бодис хэрэглэх үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын хаягдал ус цэвэрлэх байгууламж нь түүнийг бүрэн арилгах тусгай төхөөрөмжөөр тоноглосон байх зэрэг үүргийг хүлээдэг.

Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт заасан зөрчилд ус ашигласны төлбөрийг хугацаанд нь төлөөгүй зөрчил хамаарна.

Усны тухай хуульд зааснаар ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай ус ашиглах гэрээ байгуулахдаа ус ашигласны төлбөрийн хэмжээг заавал тусгасан байхаар хуульчилсан бөгөөд мөн ус, рашааны нөөц ашигласны төлбөр төлнө.

Зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөрийг 50 хүртэл хувиар шатлан өсгөх хэлбэрээр тооцож төлөх бөгөөд шатлан өсгөх хэлбэрээр төлбөр тооцох журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газар батална. Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн хэмжээ, нөхцөлийг хуулиар тогтооно.

Зөрчлийн төсөөтэй гэмт хэргээс ялгагдах шинж. Эрүүгийн хуулийн тусгай ангийн хэд хэдэн заалтад усны талаар тусгасан байдаг тул тэдгээрийг Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлийн Усны тухай хууль зөрчих зөрчлийн шинжтэй харьцуулан доорх хүснэгтээр харуулав.

Хүснэгт 3.7. *Усны тухай хууль зөрчих зөрчлийн төсөөтэй гэмт хэргээс ялгагдах шинж*

Гэмт хэрэг	Зөрчил
Хорин дөрөвдүгээр бүлэг Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	- Зөвшөөрөл авснаас өөр зориулалтаар ашигласан - Зөвшөөрөлгүйгээр газрын доорх усыг ашигласан - Ус ашиглахад тавигдах нөхцөлийг хангуулахаар төрийн албан хаагчийн тавьсан шаардлагыг биелүүлээгүй - Ус ашиглагчийн үүрэг, тавигдах шаардлагыг биелүүлээгүй - Усны эх үүсвэрийн онцгой, энгийн хамгаалалтын бүс, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг зөрчсөн - Ашиглаж дууссан цооногоо битүүмжилж хүлээлгэн өгөөгүй - Ус ашиглах зөвшөөрлийг бусдад худалдсан - бусдад шилжүүлсэн - Усыг үйлдвэрлэлийн зориулалтаар зохих гэрээ, зөвшөөрөлгүйгээр - Гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашигласан - Усны эх, ундаргын онцгой хамгаалалтын бүсэд хориглосон үйл ажиллагаа явуулсан - Гол, мөрний урсцын байгалийн үндсэн голдирлыг өөрчилсөн - Усны сан бүхий газарт энгийн хамгаалалтын бүс, эрүүл ахуйн бүс тогтоох шаардлага биелүүлээгүй - Усны тоо бүртгэл, эрэл, хайгуул, судалгааны тайлан, хяналт- шинжилгээний дүн мэдээ, ус ашиглалтын бүртгэл, хаягдал усны бүртгэлийг хугацаанд нь явуулаагүй - Тайлан, мэдээг гаргаж өгөх журам зөрчсөн - Рашааны эх үүсвэрийн хамгаалалтын бүс, хязгаарлалтын бүс, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг зөрчсөн - Рашааныг хамгаалах бүсэд хориглосон үйл ажиллагаа явуулсан - Рашааныг горимын хэмжээнээс хэтрүүлэн гэрээгүйгээр ашигласан - Рашааны зориулалтыг дур мэдэн өөрчилсөн - Усны сан бүхий газарт хог хаягдал хаясан, эсхүл машин техник, бохир зүйл угаасан - Усны нөөцийг бохирдохоос хамгаалах үүргээ биелүүлээгүй - Ус ашигласны төлбөрийг хугацаанд нь төлөөгүй зэрэг зөрчлүүд байна.
24.1 дүгээр зүйл. Байгаль орчныг бохирдуулах 1. Химийн хорт, аюултай бодис, аюултай, хортой хог хаягдлыг агаар, газар, газрын хэвлий, усны сан бүхий газар, гол мөрний урсац бүрэлдэх эх, эх үүсвэрийн тэжээгдлийн муж, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хамгаалалтын бүс дотор хаяж хүний эрүүл мэнд, мал, амьтан, ургамал, тэдгээрийн үр удамд сөрөг нөлөөлөл үзүүлэх, өвчин эмгэг үүсгэх, үхэл, мөхөлд хүргэх нөхцөлийг бүрдүүлсэн	
24.9 дүгээр зүйл. Байгалийн тэнцэл алдагдуулах 1. Амьтан, ургамлын зүйлийг зөвшөөрөлгүйгээр гэмтээсэн, устгасан, газар, газрын хэвлий, агаар мандал, усны нөөцийг хордуулсан	
Хорьдугаар бүлэг Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	
20.11 дүгээр зүйл. Аюултай хог хаягдал, химийн хорт, аюултай бодисыг хаях 1. Хүний эрүүл мэндэд хортойгоор нөлөөлөх аюултай хог хаягдал, химийн хорт, аюултай бодисыг зориулалтын бус газар хаясан, хог хаягдлын зэрэглэлийг санаатайгаар буруу тогтоож зориулалтын бус газар хаясан	

3.8.3. Зөрчлийн зүйлчлэл

Усны тухай хууль зөрчих зөрчил нь хуульд заасны дагуу усыг зөвшөөрөл авснаас өөр зориулалтаар ашигласан, цооног өрөмдөх зөвшөөрөлгүйгээр газрын доорх усыг ашигласан, ус ашиглахад тавигдах нөхцөлийг хангуулахаар төрийн албан хаагчийн тавьсан шаардлагыг биелүүлээгүй, ус ашиглагчийн үүрэг, тавигдах шаардлагыг биелүүлээгүй, усны эх үүсвэрийн онцгой, эсхүл энгийн хамгаалалтын бүс, эсхүл эрүүл ахуйн бүсийн дэглэмийг зөрчсөн, ашиглаж дууссан цооногоо битүүмжилж хүлээлгэн өгөөгүй, мөн ус ашиглах зөвшөөрлийг бусдад худалдсан, эсхүл бусдад шилжүүлсэн, эсхүл усыг үйлдвэрлэлийн зориулалтаар зохих гэрээ, зөвшөөрөлгүйгээр, эсхүл гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашигласан, түүнчлэн усны эх, ундаргын онцгой хамгаалалтын бүсэд хориглосон үйл ажиллагаа явуулсан, гол, мөрний урсцын байгалийн үндсэн голдирлыг өөрчилсөн зэрэг шинжийг 1-4 дэх хэсэгт тодорхойлсон.

Мөн хуульд заасан усны сан бүхий газарт энгийн хамгаалалтын бүс, эсхүл эрүүл ахуйн бүс тогтоох шаардлага биелүүлэх, усны тоо бүртгэл, эрэл, хайгуул, судалгааны тайлан, хяналт-шинжилгээний дүн мэдээ, ус ашиглалтын бүртгэл, хаягдал усны бүртгэлийг хугацаанд нь явуулах, тайлан, мэдээг гаргаж өгөх журам зөрчсөн шинжийг 5 дахь хэсэгт заасан бол рашааны эх үүсвэрийн хамгаалалтын бүс, хязгаарлалтын бүс, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг зөрчсөн, эсхүл эдгээр бүсэд хориглосон үйл ажиллагаа явуулсан, рашааныг гэрээ, эсхүл зөвшөөрөлгүй ашигласан, горимын хэмжээнээс хэтрүүлэн гэрээгүйгээр ашигласан, зориулалтыг дур мэдэн өөрчилсөн зэрэг рашаан хамгаалахад чиглэсэн заалтууд орсон байна.

Сүүлийн үед элбэг үйлдэгдэх болсон усны сан бүхий газарт хог хаягдал хаясан, эсхүл машин техник, бохир зүйл угаасан, эсхүл усны нөөцийг бохирдохоос хамгаалах үүргээ биелүүлээгүй, ус ашигласны төлбөрийг хугацаанд нь төлөөгүй зэрэг шинжийг зааж зөрчлийн хуулиар хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан байна.

2002 оны Эрүүгийн хуулийн 208 дугаар зүйлд усны тухай хууль тогтоомж зөрчиж их хэмжээний хохирол учруулсан, загас амьтан олноор үхсэн, тусгай хамгаалалттай газар нутагт үйлдсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан байсныг 2017 оны Эрүүгийн хуулиар бүхэлд нь хүчингүй болгосон байна. Иймд дээрх зөрчлийн шинжийг тогтоож зөвхөн Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэх тул энд тусгайлсан зүйлчлэлийн асуудал яригдахгүй.

Харин нэг анхаарах зүйл бол энэ төрлийн асуудлыг шалгах явцад «Химийн хорт, аюултай бодис аюултай, хортой хог хаягдлыг ... усны сан бүхий газар, гол мөрний урсац бүрэлдэх эх, эх үүсвэрийн тэжээгдлийн муж, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хамгаалалтын бүс дотор хаяж хүний эрүүл мэнд, мал, амьтан, ургамал, тэдгээрийн үр удамд сөрөг нөлөөлөл үзүүлэх, өвчин эмгэг үүсгэх, үхэл, мөхөлд хүргэх нөхцөлийг бүрдүүлсэн» бол уг үйлдэлд Эрүүгийн хуулийн 24.1 дүгээр зүйлд зааснаар эрүүгийн хариуцлага хүлээлгэх тул цагдаагийн байгууллагад харьяалал тогтоолгохоор прокурорт хандана.

3.8.4. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд анхаарах асуудал

Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлд заасан Усны тухай хууль тогтоомж зөрчих зөрчлийн хэрэг бүртгэлт, шалган шийдвэрлэх ажиллагааг явуулахдаа дараах зүйлсийг анхаарч, ажиллагааг гүйцэтгэнэ. Үүнд:

- Шалгаж буй зөрчлийн онцлогт тохируулан усны тухай хууль тогтоомж, усны хууль зүйн нэр томьёо болон ойлголтуудыг нарийвчлан судалж мэдэх, холбогдох стандарт, хэм хэмжээ, дүрэм, журам, шийдвэрийг олж судлан зохих мэдлэгийг өөртөө хуримтлуулснаар хуулийг нэг мөр хэрэгжүүлэх, буруу шийдвэр гаргахгүй байх, бусдыг хохироохоос урьдчилан сэргийлэх болно.

- Хуульд заасны дагуу усыг зөвшөөрөл авснаас өөр зориулалтаар ашигласан, цооног өрөмдөх зөвшөөрөлгүйгээр газрын доорх усыг ашигласан, ус ашиглагчийн үүрэг, тавигдах шаардлагыг биелүүлээгүй, усны эх үүсвэрийн онцгой, эсхүл энгийн хамгаалалтын бүс, эсхүл эрүүл ахуйн бүсийн дэглэмийг зөрчсөн, ашиглаж дууссан цооногоо битүүмжилж хүлээлгэн өгөөгүй, мөн усыг үйлдвэрлэлийн зориулалтаар зохих гэрээ, зөвшөөрөлгүйгээр, эсхүл гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашигласан, түүнчлэн усны эх, ундаргын онцгой хамгаалалтын бүсэд хориглосон үйл ажиллагаа явуулсан, гол, мөрний урсцын байгалийн үндсэн голдирлыг өөрчилсөн зэрэг шинжийн хувьд зөрчлийн газрын үзлэг хийж (үзлэг хийх аргачлалыг өмнөх сэдвүүдээс үзнэ үү), хэрэгт ач холбогдол бүхий нөхцөл байдлыг тогтооно.
- Үзлэгээр тогтоосон цэгүүдийг орон нутгийн газрын алба, Ашигт малтмалын газар, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны кадастрын хэлтэст хүргүүлж, орон нутгийн тусгай хэрэгцээний газар, хязгаарлалт, хориглолтын бүстэй давхцалтай эсэх, тусгай зөвшөөрлийн талбайн байдал, уурхайн эдэлбэр газрын зөвшөөрөл зэргийн талаар зурагтай лавлагаа авах
- Тухайн аж ахуйн нэгж, байгууллагыг урьд өмнө төрийн эрх бүхий байгууллага (Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Усны газар, Ашигт малтмалын газар, орон нутгийн алба г.м)-аас шалгаад тавьсан акт, албан шаардлага, мэдэгдэл, дүгнэлт, шинжилгээний хариу, торгуулийн тасалбар, шийтгэвэр, маргаантай асуудлаар гарсан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, албан бичиг зэрэг тухайн асуудалтай холбогдол бүхий баримт бичигт үзлэг хийж, хэрэгт хуулбарлан хавсаргаж байх
- Усны тухай хууль зөрчих зөрчлийн хэргийг шалгахад усны нөөцөд учирсан хохирол, нөхөн төлбөрийг нарийвчлан тогтоох тул тэдгээр хохирол, нөхөн төлбөрийг мэргэжлийн шинжээч томилж, нарийвчлан тогтоолгох. Иймд шинжээчийг томилох, шинжээчид тавих асуултуудыг сайтар боловсруулах, ямар шинжилгээ явуулж болох талаар зохих мэдлэгтэй байх зайлшгүй шаардлагатай.
- Ус хэрэглэгчид цооног өрөмдөх, худаг гаргах, голоо суваг шуудуу татах зөвшөөрлийг ус хэрэглээний тоо хэмжээ, чанарыг үндэслэн аймаг, нийслэлийн байгаль орчны алба олгоно.
- Ус хэрэглэгч зөвшөөрөл авахдаа аймаг, нийслэлийн байгаль орчны албанд өргөдөл гаргах бөгөөд өргөдөлд ус хэрэглэх зориулалт, тоо хэмжээ, газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн бичгийн хуулбар, худгийн мэдээлэл зэргийг тусгана. Харин аймаг, нийслэлийн байгаль орчны алба ус хэрэглэгчийн худаг, цооногийг усны мэдээллийн санд бүртгэж, худгийн паспорт олгоно.
- Ус хэрэглэгч ашиглалтын зориулалтыг өөрчлөх, зөвшөөрөлгүйгээр цооног өрөмдөх, худаг гаргах, суваг шуудуу татахыг хориглоно.
- Усны мэргэжлийн байгууллагын тусгай зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллагаас олгох бөгөөд усны мэргэжлийн байгууллагын эрх олгоход тухайн аж ахуйн нэгж, байгууллагын танилцуулга, улсын бүртгэлийн гэрчилгээ, тухайн чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх мэргэжлийн боловсон хүчний мэдээлэл (диплом, сертификат, ажлын туршлага, ур чадварын мэдээлэл г.м), техник, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн гэрчилгээ, зураг (машин механизм, тээврийн хэрэгсэл г.м), тээврийн хэрэгслийн гэрчилгээ болон бусад техникийн үзүүлэлт, мэдээлэл хангамжийн талаар болон аймаг, нийслэлийн байгаль орчны албаны дүгнэлт, түүнийг үндэслэн олгосон аймаг, нийслэлийн Засаг даргын тодорхойлолт, гэрчилгээний үнэ төлсөн баримт, тэмдэгтийн хураамж зэрэг бичиг баримтуудыг бүрдүүлсэн байх шаардлага тавьсан байдгийг анхаарах. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь материал хүлээн авсан өдрөөс хойш ажлын 21 хоногт шийдвэрлэнэ.

- Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ус ашиглах хүсэлтээ хоногт хэрэглэх усны хэмжээ, хүчин чадлаас шалтгаалан сум, дүүрэг, усны сав газрын захиргаа, төрийн захиргааны төв байгууллагын аль нэгэнд гаргах бөгөөд ус ашиглах хүсэлтэд ашиглах усны эх үүсвэр, эсхүл рашааны эх булаг, түүний байршлыг харуулсан зураг, ус, рашааны нөөц, чанар, найрлагыг тогтоосон хайгуул, судалгааны тайлан, ашиглах боломжит нөөцийн талаарх дүгнэлт, хоногт ашиглах усны хэмжээ зориулалт, барилга байгууламжийн зураг, төсөл, үйлдвэрлэлийн хүчин чадал, техник, эдийн засгийн үзүүлэлт, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайлан, дүгнэлт (нэмэлтээр усны мэргэжлийн байгууллагаар тогтоолгож, усны нөөцийн зөвлөлөөр баталгаажуулсан рашааны хязгаарлалтын бүсийн зураг, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлт, рашааныг хамгаалах, ашиглах төсөл г.м) зэрэг бичиг баримтуудыг хавсаргаж, хүргүүлдэг тул тэдгээрийг анхаарах
- Ус ашиглуулах дүгнэлтийг хоногт 100 шоометрээс их ус ашиглах, эрчим хүч, усан тээврийн зориулалтаар ашиглах бол байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 50-100 шоометр ус болон усан орчин ашиглах бол сав газрын захиргаа, харин 50 шоометр хүртэлх ус ашиглах, хурын ус хуримтлуулж, хөв, цөөрөм байгуулах, суваг, шуудуу татах дүгнэлтийг аймаг, нийслэлийн байгаль орчны алба тус тус гаргадаг тул түүнийг анхаарах ёстой.
- Ус ашиглуулах дүгнэлт болон холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглах, дур мэдэн цооног гаргахыг хориглоно. Мөн байгальд халтай технологи бүхий үйлдвэр, үйлчилгээний газарт ус ашиглуулах дүгнэлт гаргахыг хориглодог.
- Мөн түүнчлэн Усны тухай хуульд нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартуудыг татан авч, үзэж танилцан, хэрэглэж байх нь зүйтэй.

Бодлого 1

Иргэн Б нь Туул голоос эх авч урсдаг нэгэн салааны дэргэд амьдардаг ба олон жил түүнээс ус аван өөрийн хашаан дахь ургацаа усалдаг байжээ. Гэвч нас дээр гарсан тул ус зөөх зам хол санагдаж ач, зээ нараа дуудан усны урсгалыг өөрчлөн хашаа руу урсгадаг болгожээ. Үүнийг мэдсэн хөрш айлын Д гэгч зөрчлийг мэдэгдэж, улмаар байгаль орчны хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлийн 4 дэх заалтыг баримтлан хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэлийн хуудсыг үйлджээ.

Асуулт

1. Дээрх үйлдэл нь ямар хууль тогтоомж зөрчсөн вэ?
2. Энэ зөрчлийг шалгах ажиллагааны үед ямар ажиллагаа явуулах вэ?
3. Дээрх хууль бус үйлдэл нь Зөрчлийн тухай хуульд заасан ямар зөрчил болох вэ? Зөрчлийг зүйлчилнэ үү?
4. Зөрчил үйлдэгчид ямар шийтгэл оногдуулах вэ?

Хариулт

1. Дээрх үйлдэл нь ямар хууль тогтоомж зөрчсөн вэ?

Усны тухай хуулийн 10 дугаар зүйлд зааснаар Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 10.1.8-д заасны дагуу голын голдирлыг өөрчлөх асуудлаар шийдвэр гаргах эрхтэй. Мөн энэ хуулийн 16^1.4-д заасан Усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь 16^1.4.10-д заасны дагуу голын голдирлыг өөрчлөх, урсцад тохируулга хийх, шилжүүлэн ашиглах, төсөлд дүгнэлт гаргах эрхтэй.

Усны тухай хуулийн 22.8-д гол, мөрний байгалийн үндсэн голдирлыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэргүйгээр өөрчлөхийг хориглохоор заасан. Тийм учраас иргэн голын голдирлыг өөрчлөх эрхгүй болно.

2. Энэ зөрчлийг шалгах ажиллагааны үед ямар ажиллагаа явуулах вэ?
Зөрчил шалган шийдвэрлэхэд шаардлагатай бүхий л ажиллагааг явуулна. Голын голдирол өөрчилсөн газарт үзлэг хийнэ. Хөндлөнгийн гэрч оролцуулна. Гэрэл зураг, дүрс бичлэгээр баримтжуулна. Байршлыг тогтооно. Иргэн Д-ээс өндөр настай эмээ зөрчлийн холбогдогч болохгүй. Өндөр настай эмээ нь

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 3.6 дугаар зүйлийн 3-д зааснаар гэрч өөрийн болон гэр бүлийн гишүүн, эцэг, эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй.

Эрх бүхий албан тушаалтан холбогдогчоос мэдүүлэг авахын өмнө түүнд үнэн зөв мэдүүлэг өгөхийн ач холбогдлыг тайлбарлаж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаатай холбоотой нууцыг хадгалах талаар мэдэгдэнэ.

Холбогдогч нь ямар зөрчилд холбогдон шалгагдаж байгааг мэдэх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах эрхтэй. Холбогдогчийн хүсэлтээр зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгч оролцож болно. Холбогдогч, хохирогч зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны аль ч үед өмгөөлөгч авч болно.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу холбогдогчийг зөрчил үйлдсэн болохыг тогтоовол, түүнээс зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны зардлыг холбогдох баримтыг үндэслэн гаргуулна, хэрвээ хэд хэдэн холбогдогч зөрчил үйлдсэн нь тогтоогдвол зардлын хэмжээг холбогдогч нэг бүрийн үйлдсэн зөрчил, хохирлын хэр хэмжээг харгалзан эрх бүхий албан тушаалтан, шүүх хуваарилж тогтооно.

3. Дээрх хууль бус үйлдэл нь Зөрчлийн тухай хуульд заасан ямар зөрчил болох вэ? Зөрчлийг зүйлчилнэ үү?
Дээрх зөрчилд Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан “гол, мөрний урсцын байгалийн үндсэн голдирлыг өөрчилсөн” зүйлээр зүйчилнэ.

4. Зөрчил үйлдэгчид ямар шийтгэл оногдуулах вэ?
Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “гол, мөрний урсцын байгалийн үндсэн голдирлыг өөрчилсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасны дагуу байгаль орчны хяналтын улсын байцаагч торгох үндэслэлтэй.

Байгаль орчны хяналтын улсын байцаагч нь шийтгэлийн хуудас үйлдэхээс өмнө Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйл, 7 дугаар зүйлийг удирдлага болгон шийдвэрийнхээ үндэслэлийг нотлох үүрэгтэй.

Бодлого 2

Баян-Өлгий аймгийн Байгаль орчны газрын улсын байцаагчийн 2020 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн № 0169378 дугаартай “Хялбаршуулсан журмаар шийдвэрлэх зөрчилд шийтгэл оногдуулах тухай” шийтгэлийн хуудсаар иргэн Ж-д “Согоог голын усны сан бүхий газарт хог хаягдал хаясан” зөрчил гаргасан нь тогтоогдсон гэсэн үндэслэлээр Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт зааснаар 100 нэгж буюу 100,000 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулсан.

Гэвч дээрх шийтгэлийн хуудас нь дараах үндэслэлээр хууль зүйн үндэслэлгүй гэж Баян-Өлгий аймгийн прокурор дүгнэлт бичиж шүүхэд ханджээ. Үүнд: “Эрх бүхий албан тушаалтан Е нь иргэн Ж-г зөрчил үйлдсэн эсэх, хэрэв зөрчил үйлдсэн бол хэзээ, хаана, хэрхэн ямар зөрчил үйлдсэн, үйлдсэн зөрчил нь усан сан бүхий газарт хог хаягдал хаясан, эсхүл усны нөөцийг хамгаалах талаарх үүргээ хэрэгжүүлээгүйн аль нь болохыг шалгаж нотлохгүйгээр шууд шийтгэлийн хуудас бичсэн энэ нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.15 дугаар зүйлийн 1 дэх заалт, 6.6 дугаар зүйлийн 1 дэх заалтыг тус тус зөрчсөн үйлдэл юм”.

Хариуцагчаас шүүхэд ирүүлсэн болон шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа:
Хяналт шалгалтаар Ж-ийн Согоог голын эрэгт шар усны үерээс бий болсон өөрийн хашаанд байгаа лаг шаврыг УАЗ-469 машинд бага оврын чиргүүлээр 10 удаа зөөж асгасан зөрчил нь тогтоогдож, нөхцөл байдлыг газар дээр нь баримтжуулсан ба зөрчил гаргасан иргэн Ж-д зөрчлөө арилгуулах шаардлага тавьсан боловч хэл ам гаргаж зөрчлөө арилгахгүй, торгуулиа тавь, би шүүхдэх болно гэж тайлбар өгсөн. Тухайн үед эрх, үүргийг нь амаар мэдэгдэж хэлэхэд хүлээж авахаас татгалзаад яваад өгсөн. Тиймээс ямар нэгэн гарын үсэг зуруулах нөхцөл бололцоо бүрдээгүй. Иргэн Ж голын эрэгт хог хаягдал хаясан зөрчил нь тухайн үед авсан зураг, би асгасан гэж хүлээн зөвшөөрч хэлсэн үг нь оролцогч болон гэрчүүдийн мэдүүлэг зэргээр нотлогдож байгаа тул Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хялбаршуулсан журмаар шалгаж шийдвэрлэсэн гэжээ.

Асуулт:

Прокурор нь байгаль орчны хяналтын улсын байцаагчийн шийдвэрт өөрчлөлт оруулах эрх бүхий субъект мөн үү? Хэрэв мөн бол прокурорын дүгнэлт хууль зүйн үндэслэлтэй юу?

Хариулт:

1. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.2 дугаар зүйлийн 8 дах хэсэгт зааснаар “эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрийг хүчингүй болгох, өөрчлөх үндэслэлтэй гэж үзвэл прокурор дүгнэлт бичиж шүүхэд хүргүүлнэ” гэсний дагуу прокурор нь шүүхэд дүгнэлт бичиж хүргүүлэх эрх бүхий субъект юм.

2. Эрх бүхий албан тушаалтнаас зөрчил шалгах ажиллагааг хууль д заасан үндэслэл, журмын дагуу явуулах өөрөөр хэлбэл, Зөрчлийн тухай хуулийн тусгай ангид хохирол, нөхөн төлбөрийг гаргуулахаар заасан бол уг хохирол, нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох буюу энэ талаар нотлох баримт цуглуулах, шаардлагатай бол холбогдох хууль, журмын дагуу шинжээч томилох зэрэг ажиллагаануудыг хийж хохирол, нөхөн төлбөрийг тогтоосны үндсэн дээр шийтгэл оногдуулахаар хуульчилсан байх тул хариуцагчийн шүүх хуралдаанд гаргасан “...нөхөн төлбөрийг тогтоох боломжгүй байсан,... нөхөн төлбөрийг тогтоохын тулд мэргэжлийн хүмүүс, эсвэл гаргасан журам стандарт нь байх ёстой” гэх тайлбар нь үндэслэлгүй байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1-д “Энэ хуулийн зорилт нь зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны үндэслэл, журмыг тогтоож, зөрчлийг шалгах, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах, энэхүү ажиллагааны явцад хүн, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад оршино”, 2.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.5-д “зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааг хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулах” гэж тус тус заасан. Зөрчилд холбогдогч нь зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд мөн хуулийн 3.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан тодорхой эрх, үүрэгтэйгээр оролцохоор хуульчилсан бөгөөд эрх бүхий албан тушаалтан болох улсын байцаагч Е-аас уг зөрчилд холбогдогч Ж-д холбогдогчийн эрх, үүргийг танилцуулаагүй, танилцуулсан талаар нотлох баримт байхгүй байх тул уг хүнд холбогдох зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хуульд заасан журмын дагуу явуулсан гэж үзэх үндэслэлгүй байна.

Дээрх байдлаар иргэн Ж нь Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлийн 8-д заасан “усны сан бүхий газарт хог хаягдал хаясан” зөрчил үйлдсэн нь ил тодорхой биш буюу уг зөрчлийг үйлдсэн талаар нотлох баримт хангалттай бүрдээгүй, 7.15 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, шийтгэл оногдуулахаар заасан байхад хохирол, нөхөн төлбөрийн хэмжээг тогтоогоогүй, мөн холбогдогчид зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо эдлэх эрх, үүргийг танилцуулаагүй буюу улсын байцаагч Е-аас уг зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулаагүй болох нь тогтоогдсон.

Өөрөөр хэлбэл, зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэх үндэслэл тогтоогдоогүй байхад хялбаршуулсан журмаар шийдвэрлэж, шийтгэл оногдуулсан нь хуулийн дээрх заалтуудыг зөрчсөн хууль бус байх тул иргэн Ж-д 100,000 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулсан улсын байцаагчийн шийдвэрийг хүчингүй болгуулахаар Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.2 дугаар зүйлийн 8-д заасны дагуу ирүүлсэн прокурорын дүгнэлт үндэслэлтэй.

Бодлого 3

Байгаль орчны хяналтын улсын байцаагч Б нь “Өвөрхангай аймгийн Хужирт суманд үйл ажиллагаа явуулдаг “Т” ХХК нь рашаан сувиллын үйл ажиллагаанаас гарч байгаа эмчилгээний бохир усыг өөрийн эзэмшлийн хашаанд болон нийтийн эзэмшлийн газарт асгасан” гэх зөрчлийн хэрэгт зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийн 7.15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтад заасны дагуу шийтгэл оногдуулжээ. Ингэхдээ уг хэрэгт “Т” ХХК-ийг төлөөлөх эрх бүхий этгээдийг тогтоож гэрч, холбогдогчоор мэдүүлэг аваагүй, зөвхөн “Т” ХХК-ийн жолооч А ажилтнаас холбогдогчоор мэдүүлэг авч, түүний мэдүүлэгт үндэслэн “Т” ХХК-д шийтгэл оногдуулсан. Мөн шийтгэлийн хуудсыг “Т” ХХК-г төлөөлөх эрхтэй эсэх нь тодорхойгүй этгээд болох С-д гардуулсан.

Асуулт:

Энэхүү тохиолдолд байгаль орчны хяналтын улсын байцаагч Б нь процессын ямар алдаа гаргасан бэ?

Хариулт:

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1 дэх заалтад заасан “тухайн хүн, хуулийн этгээдийн зөрчил үйлдсэнийг нотлох баримт бүрдсэн эсэх” гэх асуудлыг бүрэн шалгаж тогтоогоогүй буюу “Т” ХХК-г төлөөлөх эрх бүхий этгээдээс бохир усыг ил задгай асгах талаар заавар, чиглэл, тушаал өгсөн эсэхийг нотлох баримтаар тогтоолгүйгээр “Т” ХХК-д шийтгэл оногдуулж, “Т” ХХК-г төлөөлөх эрхтэй эсэх нь тодорхойгүй этгээд болох С-д шийтгэлийн хуудсыг гардуулж гарын үсэг зуруулсан байна.

3.9 ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГТ ХОРИГЛОСОН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ, ТҮҮНИЙ ШИНЖ, ОНЦЛОГ, АНХААРАХ АСУУДАЛ

3.9.1. Шийтгэл, эрх бүхий албан тушаалтан ба харьяалал, нэр томъёоны тайлбар

Шийтгэл. Зөрчлийн тухай хуулийн 7.17 дугаар зүйлийн Тусгай хамгаалалттай газар нутагт хориглосон үйл ажиллагаа явуулах тохиолдолд зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд дараах шийтгэл оногдуулна. Үүнд:

1. Тусгай хамгаалалттай газар нутагт (1.1) хууль, захиргааны хэм хэмжээний акт, стандарт, дэглэм, горим зөрчсөн, (1.2) менежментийн төлөвлөгөөнд тусгагдаагүй үйл ажиллагаа явуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гучин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2. Тусгай хамгаалалттай газар нутагт хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Зөрчлийг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан ба харьяалал. Зөрчлийн тухай хуулийн 7.17 дугаар зүйлийн Тусгай хамгаалалттай газар нутагт хориглосон үйл ажиллагаа явуулах зөрчлийг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан болон харъяаллыг доорх хүснэгтээр харуулав. Үүнд:

Эрх бүхий албан тушаалтан	Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харьяалал
Зөрчлийн тухай хуулийн 7.17 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутагт хориглосон үйл ажиллагаа явуулах	
Улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч (6.27) Байгаль орчны хяналтын улсын байцаагч (6.37)	Зөрчлийн тухай хуулийн 7.17 дугаар зүйлийн 1 дэх хэсэг
	Зөрчлийн тухай хуулийн 7.17 дугаар зүйлийн 2 дахь хэсэг

Дээрх хүснэгтээр харуулсан Зөрчлийн тухай хуулийн 7.17 дугаар зүйлийн Тусгай хамгаалалттай газар нутагт хориглосон үйл ажиллагаа явуулах ***зөрчлийг*** Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.27-д заасан улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч болон тус хуулийн 6.37-д заасан байгаль орчны хяналтын улсын байцаагч нар бүхэлд нь шалган шийдвэрлэх эрхтэй байна.

Хуулийн нэр томьёоны тайлбар. Зөрчлийн тухай хуулийн 7.17 дугаар зүйлд заасан зөрчилтэй холбогдох нэр томьёог Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд тайлбарласан байдаг бөгөөд тэдгээрийг дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:


“Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөө” гэж тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хамгаалалт, нөхөн сэргээлт, зохистой ашиглалтыг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулан хэрэгжүүлэх үйл ажиллагааны дунд болон ойрын хугацааны төлөвлөгөө бүхий баримт бичгийг,

“Тусгай хамгаалалттай газар нутгийн дотоод бүсчлэл” гэж дархан цаазат болон байгалийн цогцолборт газрын байгалийн хэв шинжийг төлөөлөх онцлог, ховор, нэн ховор амьтан, ургамал, түүх, соёлын дурсгалт зүйлийн байршлыг харгалзан тогтоосон өөр өөр хамгаалалтын дэглэм бүхий газар нутгийн хуваарийг тус тус ойлгоно.

3.9.2. Зөрчлийн ойлголт, шинж ба төсөөтэй гэмт хэргээс ялгагдах шинж

Зөрчлийн тухай хуулийн 7.17 дугаар зүйлийн Тусгай хамгаалалттай газар нутагт хориглосон үйл ажиллагаа явуулах зөрчил нь 2 хэсэг, 2 заалтаас бүрдэх бөгөөд тэдгээр нь тус бүрдээ онцлог шинжтэй юм. Иймд хэсэг тус бүрийг тусгайлан авч үзэх болно.


Зөрчлийн тухай хуулийн 7.17 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил нь 1.1, 1.2 гэсэн хоёр заалтаас бүрдэнэ. Үүнээс энэ хуулийн 7.17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1-д заасан зөрчил нь тусгай хамгаалалттай газар нутагт хууль, захиргааны хэм хэмжээний акт, стандарт, дэглэм, горим зөрчсөн үйлдэл байна.



Хууль, захиргааны хэм хэмжээний акт зөрчсөн үйлдэл гэдэгт Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиас гадна, Байгаль орчны хамгаалах тухай хууль, Усны тухай хууль, Ойн тухай хууль, Амьтны тухай хуулиудын Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуультай холбоотой заалтууд, мөн түүнчлэн тус хуулийг хэрэгжүүлэхээр гаргасан захиргааны дэд акт болох дүрэм, журам, тогтоол, тушаал, захирамж, захиргааны дотоод журмууд хамаарна.

Улсын Их Хурлаас баталсан хуулийг амьдралд хэрэгжүүлэхийн тулд захиргааны байгууллага, албан тушаалтнаас захиргааны акт, шийдвэр гаргадаг. Тухайлбал, тухайн хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой гаргасан УИХ-ын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Сайд нарын тушаал, журам болон аймаг, нийслэлийн ИТХ-ын тогтоол, Засаг дарга нарын захирамж г.м.

Хууль, захиргааны хэм хэмжээний акт зөрчих гэдэг нь маш өргөн хүрээтэй ойлголт бөгөөд захиргааны хэм хэмжээний тухай ойлголттой байх нь тухайн хэрэг, зөрчлийг хууль зүйн дагуу шалган шийдвэрлэхэд ихээхэн дөхөмтэй. Учир нь дээрх захиргааны эрх зүйн хэм хэмжээ нь Үндсэн хууль, бусад хууль, олон улсын гэрээтэй зөрчилдөөгүй, эрх хэмжээний хувьд даваагүй хэм хэмжээ байх бөгөөд түүнийг зөрчил шалган шийдвэрлэх субъект анзаарч мэдэж байх шаардлагатай. Хэрвээ хууль зүйн хүчин чадлын хувьд хууль зөрчин гаргасан захиргааны актыг үндэслэл болгон зөрчлийг шалгаж, шийдвэр гаргавал уг шийдвэр шүүхээр хүчингүй болж шийдвэрлэгдэх, үүний улмаас иргэн, хуулийн этгээд хохирох, улмаар хохирлыг хариуцах үр дагавар ч үүсэж магадгүй.



Зөрчлийн тухай хуулийн 7.17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1-д заасан үйлдэлд энэ хуулийн 7.17 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан тусгай хамгаалалттай газар нутагт хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулахаас бусад тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар хамгаалагдсан эрх зүйн зөрчил, тусгай хамгаалалттай газар нутгийн дэглэм, горим, стандарт зөрчсөн үйлдлүүд хамаарна.

Тусгай хамгаалалттай газар нутагт дэглэм зөрчсөн гэдэгт Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд заасан хамгаалалтын дэглэмүүд, тэдгээрийг зөрчсөн үйлдлийг ойлгоно.

Улсын тусгай хамгаалалттай газар нутгийг дархан цаазат газар, байгалийн цогцолборт газар, байгалийн нөөц газар, дурсгалт газар хэмээн 4 ангилах бөгөөд тэдгээр нь хамгаалалтын дэглэмийн хувьд ялгаатай байдаг.

Дархан цаазат газар, түүний хамгаалалтын дэглэм. Байгалийн бүс, бүслүүрийн онцлог, хэв шинжийг төлөөлж чадах унаган төрхөө хадгалсан байдал, шинжлэх ухааны онцгой ач холбогдлыг нь харгалзан байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах зорилгоор улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг *дархан цаазат газар* гэнэ.

Дархан цаазат газрыг байгалийн хэв шинж, төлөв байдал, хөрс, ус, ургамал, амьтны аймгийн онцлог, хүний үйл ажиллагаанд өртөх байдал зэргийг харгалзан (1) онгон бүс, (2) хамгаалалтын бүс, (3) хязгаарлалтын бүсэд хуваана.

Онгон бүсийн дэглэм. Онгон бүсэд байгалийн унаган төрх, хэв шинжийг нь хадгалах шаардлагад нийцүүлж зөвхөн хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлнэ. Мөн байгалийн төлөв байдлыг нь хөндөхгүйгээр зөвхөн ажиглах хэлбэрээр судалгаа, шинжилгээний ажил явуулж болох бөгөөд үүнээс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглосон байдаг.

Хамгаалалтын бүсийн дэглэм. Хамгаалалтын бүсэд байгалийн унаган төрх, хэв шинжийг нь хадгалах шаардлагад нийцүүлж зөвхөн хамгаалалтын арга хэмжээ авч, мөн байгалийн төлөв байдлыг нь хөндөхгүйгээр зөвхөн ажиглах хэлбэрээр судалгаа, шинжилгээний ажил явуулахаас өөр үйл ажиллагаа явуулахыг хориглосон байна. Харин ургамал, амьтны аймгийн өсөж үржих нөхцөлийг хангах, гамшгийн хор уршгийг арилгахтай холбогдсон биотехникийн арга хэмжээг байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр хэрэгжүүлэхийг зөвшөөрдөг.

Хязгаарлалтын бүсийн дэглэм. Хязгаарлалтын бүсэд байгаль орчинд нь сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр зохих зөвшөөрөлтэйгөөр судалгаа, шинжилгээний ажил, ургамал, амьтны аймгийн өсөж үржих нөхцөлийг хангах, гамшгийн хор уршгийг арилгахтай холбогдсон биотехникийн арга хэмжээ болон хөрс, ургамлын бүрхэвчийг нөхөн сэргээх, ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх, ан амьтны тооллого, тэдгээрийн тоо, нас, хүйс, сүргийн бүтцийг зохицуулах үйл ажиллагааг батлагдсан хөтөлбөр, аргачлалын дагуу явуулах, рашаан, эмчилгээ, сувилгааны

чанартай бусад эрдсийг ашиглах, байгалийн аялал, жуулчлалыг тогтоосон зам, чиглэлээр зохих журмын дагуу зохион байгуулах, аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн түр буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа шинжилгээ хийх зориулалттай орон байр барих, ашиглах, зураг авах, дууны болон дүрс бичлэг хийх, тэдгээрийг зохиол бүтээл туурвихад ашиглах, уул, овоо тахих, уламжлалт зан үйлийн бусад ёслол үйлдэх, нутгийн оршин суугчид ахуйн хэрэгцээндээ зориулан байгалийн дагалт баялаг, эмийн болон хүнсний ургамлыг зохих журмын дагуу түүж ашиглахыг зөвшөөрдөг.

Гэхдээ дээрх үйл ажиллагааг зохих байгууллага, албан тушаалтнаас авсан зөвшөөрлийн дагуу хийх ёстой бөгөөд хэрвээ зөвшөөрөл аваагүй бол зөрчилд тооцогдоно.

Байгалийн цогцолборт газар, түүний хамгаалалтын дэглэм. Байгалийн унаган төрхөө харьцангуй хадгалсан, түүх, соёл, шинжлэх ухааны болон танин мэдэхүй, экологийн хүмүүжилд ач холбогдол бүхий улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг *байгалийн цогцолборт газар* гэнэ.

Байгалийн цогцолборт газрыг байгалийн хэв шинж, ургамал, амьтны аймгийн байршил, түүх, соёлын дурсгалыг нь хадгалах шаардлага, аялал, жуулчлал хөгжүүлэх нөхцөл зэргийг харгалзан (1) онцгой бүс, (2) аялал, жуулчлалын бүс, (3) хязгаарлалтын бүсэд хуваасан байдаг.

Онцгой бүсийн дэглэм. Онцгой бүсэд байгалийн унаган төрхийг нь хадгалах шаардлагад нийцүүлэн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхийн зэрэгцээ байгальд сөрөг нөлөөгүй арга, хэлбэрээр судалгаа, шинжилгээний ажил явуулах, ургамал, амьтны өсөж үржих нөхцөлийг хангах, хөрсийг нөхөн сэргээх, гамшгийн хор уршгийг арилгах арга хэмжээ авч болно.

Аялал, жуулчлалын бүсийн дэглэм. Аялал, жуулчлалын бүсэд байгаль орчинд нь сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр зохих зөвшөөрөлтэйгөөр судалгаа, шинжилгээний ажил, ургамал, амьтны аймгийн өсөж үржих нөхцөлийг хангах, гамшгийн хор уршгийг арилгахтай холбогдсон биотехникийн арга хэмжээ болон хөрс, ургамлын бүрхэвчийг нөхөн сэргээх, ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх, ан амьтны тооллого, тэдгээрийн тоо, нас, хүйс, сүргийн бүтцийг зохицуулах үйл ажиллагааг батлагдсан хөтөлбөр, аргачлалын дагуу явуулах, рашаан, эмчилгээ, сувилгааны чанартай бусад эрдсийг ашиглах, байгалийн аялал, жуулчлалыг тогтоосон зам, чиглэлээр зохих журмын дагуу зохион байгуулах, аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн түр буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа шинжилгээ хийх зориулалттай орон байр барих, ашиглах, зураг авах, дууны болон дүрс бичлэг хийх, тэдгээрийг зохиол бүтээл туурвихад ашиглах, уул, овоо тахих, уламжлалт зан үйлийн бусад ёслол үйлдэх, нутгийн оршин суугчид ахуйн хэрэгцээндээ зориулан байгалийн дагалт баялаг, эмийн болон хүнсний ургамлыг зохих журмын дагуу түүж ашиглах, зөвшөөрөгдсөн газар загас барих зэрэг үйл ажиллагааг зөвшөөрдөг. Гэхдээ эдгээр үйл ажиллагааг зохих байгууллага, албан тушаалтнаас авсан зөвшөөрлийн дагуу явуулах бөгөөд хэрвээ зөвшөөрөл аваагүй бол зөрчилд тооцогдоно.

Хязгаарлалтын бүсийн дэглэм. Дээр дурдсан дархан цаазат газрын зөвхөн хязгаарлалтын бүс, байгалийн цогцолборт газрын онцгой болон аялал, жуулчлалын бүсэд зөвшөөрсөн үйл ажиллагаанаас гадна, уламжлалт аргаар мал аж ахуй эрхлэх, аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн ашиглах барилга байгууламжийг батлагдсан зураг, төсөл, зөвшөөрлийн дагуу барих, батлагдсан зураг төсөл, зохих журмын дагуу зам тавих, тээврийн хэрэгслийн зогсоол гаргах, биеийн тамир, нийтийн арга хэмжээнд шаардагдах талбайг засаж тохижуулах, тухайн нутаг дэвсгэр дэх сууриныг экологийн магадлан шинжилгээ хийж баталсан ерөнхий төлөвлөгөөний дагуу хөгжүүлэх зэрэг үйл ажиллагааг зөвшөөрсөн байна.

Байгалийн нөөц газар, түүний төрөл, дэглэм. Байгалийн тодорхой хэв шинж, аль нэгэн нөөц, баялгийг хамгаалах, хадгалах, нөхөн сэргээх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг *байгалийн нөөц газар* гэнэ. Байгалийн нөөц газрыг дараах 5 төрөлд хуваасан байдаг. Үүнд:

1) Байгалийн унаган төрх, хэв шинжийг хадгалах зорилго бүхий байгалийн иж бүрдлийн нөөц газар
2) Ховор ховордсон ургамал, амьтныг хамгаалах, тэдгээрийн нөхөн үржих нөхцөлийг бүрдүүлэх зорилго бүхий биологийн нөөц газар
3) Эртний амьтан, ургамлын ховор олдворыг байгалийн байдлаар нь хадгалах зорилго бүхий байгалийн түүхэн олдворын нөөц газар
4) Газрын өвөрмөц тогтоц, илэрц, тэдгээрийн бүтцийг байгалийн байдлаар нь хадгалах зорилго бүхий геологийн нөөц газар
5) Мөрөн, гол, усны эх үүсвэрийг хамгаалах зорилго бүхий усны нөөц газар зэрэг болно.

Байгалийн нөөц газрын дэглэм. Байгалийн нөөц газарт хамгаалалтад авсан байгалийн хэв шинж, тодорхой баялгийн төрх байдал, ургамал, амьтны аймгийн байршил, өсөлт, үржилтэд сөрөг нөлөөгүйгээр аж ахуй эрхэлж болно.

Харин байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй барилга байгууламж барих, үйлдвэрлэлийн зориулалтаар газар ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох, ан амьтан агнах, барих, мод, зэгс, шагшуурга бэлтгэх зэргээр байгалийн унаган төрхийг өөрчлөх, мал аж ахуй эрхлэгч малчин өрхөд өвөлжөө, хаваржааны газар олгох, голын усыг бохирдуулах аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

Дурсгалт газар, түүний төрөл, хамгаалалтын дэглэм. Байгалийн өвөрмөц тогтоц, түүх, соёлын ул мөрийг уламжлагдан хадгалагдсан байгалийн байдлаар нь өвлөн үлдээх зорилгоор улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг *дурсгалт газар* гэнэ. Дурсгалт газрыг дараах 3 төрөлд хуваасан байдаг. Үүнд:

1) Байгалийн дурсгалт газар - өвөрмөц тогтоц, илэрц бүхий газар, эртний ургамал, амьтны чулуужсан үлдэгдэл, давхаргазүйн тулгуур зүсэлт зэрэг эрдэс чулуулгийн ховор олдвор, хүрхрээ, хясаа, хавцал, агуй, хад цохио, явар, цонж, төгөл мод, рашаан булаг, баянбүрд, элсэн манхан, солир, солирын цар, өрх, галт уулын тогоо г.м.
2) Түүх, соёлын дурсгалт газар - эртний хүний оромж, отог, сууц, агуй, сүг зураг, хадны бичээс, буган ба хүн чулуун хөшөө, булш бунхан, эртний хот, суурины үлдэгдэл, балгас, хэрэм, цайз, суваг шуудуу, далан, эртний зэр зэвсэг хийж байсан орд, уламжлалт зан үйлтэй холбоотой уул, овоо, тахилга бүхий болон түүхэн чухал үйл явдал болсон газар
3) Дэлхийн болон үндэсний соёлын өвийн дурсгалт газар зэрэг болно.

Дурсгалт газрын дэглэм. Дурсгал газарт хаалт, хашлага барих, сэрэмжлүүлсэн дохио, тэмдэг тавих, түүний хамгаалалтыг нутгийн оршин суугчдад хариуцуулан өгөх зэргээр хамгаалалтын арга хэмжээ авч болно.

Дурсгалт газар дахь байгалийн болон түүх, соёлын дурсгалт зүйлээс 0.1-3.0 км-ийн орчимд сүр бараа, үзэмжийг нь дарах барилга байгууламж барих, газар хагалах, ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох, байгалийн болон түүх, соёлын дурсгалт зүйлийг хөндөх, эвдэх, буулгах, тэдгээрт хохирол учруулахуйц бусад үйл ажиллагаа явуулахыг хориглодог.

Тусгай хамгаалалттай газар нутагт горим зөрчсөн гэдэгт хууль тогтоомж болон хамгаалалтын горимоор хориглосон байгаль орчинд сөрөг нөлөөлөх бусад үйл ажиллагаа явуулах үйлдлийг ойлгоно.

Засгийн газар нь Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд заасан хамгаалалтын дэглэмийн хүрээнд тухайн дархан цаазат газар, байгалийн цогцолборт газрын хамгаалалтын горимыг баталдаг. Тухайлбал, Засгийн газрын 1995 оны 169 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Дархан цаазат газрын хамгаалалтын нийтлэг горим”, 2 дугаар хавсралтаар “Байгалийн цогцолборт газрын хамгаалалтын нийтлэг горим”, 3 дугаар хавсралтаар “Дархан цаазат болон байгалийн цогцолборт зарим газрын тусгай горим”, 4 дүгээр хавсралтаар Байгалийн нөөц болон дурсгалт зарим газрын хилийн заагийг тус тус баталсан байдаг.

Харин аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тусгай хамгаалалттай газар нутгийн талаар нутаг дэвсгэрийнхээ тодорхой хэсгийг орон нутгийн хамгаалалтад авах тухай шийдвэр гаргах, түүний хилийн зааг, хамгаалалтын горимыг тогтоож байхаар заажээ.

Менежментийн төлөвлөгөөнд тусгагдаагүй үйл ажиллагаа явуулсан гэдэгт тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хамгаалалт, нөхөн сэргээлт, зохистой ашиглалтыг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулан хэрэгжүүлэх үйл ажиллагааны дунд болон ойрын хугацааны төлөвлөгөө бүхий баримт бичигт тусгагдаагүй аливаа үйл ажиллагааг ойлгоно.

Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөө гэдэг нь тухайн тусгай хамгаалалттай газар нутгийг байгуулсан зорилгыг хэрэгжүүлэхэд өнөө ба ирээдүйд баримтлах бодлого, стратеги, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон хөгжлийн хөтөч болох үндсэн баримт бичиг юм. Нөгөө талаас менежментийн төлөвлөгөө нь төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх, түүний үр дүнд үндэслэн төлөвлөлтийг сайжруулах, энэ хугацаанд хуримтлуулсан амжилт, сургамжаа бусадтай хуваалцах гэсэн уян хатан, байнгын эргэлттэй бүхэл бүтэн процесс юм.

Тусгай хамгаалалттай газрын менежментийн төлөвлөлтөд төлөвлөгөөний зорилго, зорилт, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалт, хүний нөөц, санхүүжилт, үр дүнг тооцох шалгуурыг тодорхойлсон байна. Энэ төлөвлөгөөг 10 жилийн хугацаатайгаар боловсруулж, тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
Тусгай хамгаалалттай газрын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр ашиг, үр нөлөөг үнэлэх журмыг тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. Батлагдсан журмын дагуу менежментийн төлөвлөгөөг хоёр жил тутамд үнэлж, шаардлагатай тохиолдолд өөрчлөлт оруулна.


Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд Тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, байгаль хамгаалагч нар хяналт тавина.

Зөрчлийн тухай хуулийн 7.17 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан зөрчил нь тусгай хамгаалалттай газар нутагт хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан үйлдэл байна.

Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэдэгт эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжийг агуулаагүй үйлдлийг ойлгоно. Тухайлбал, энэ зөрчилд холбогдох Тусгай хамгаалалтай газар нутгийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан Дархан цаазат газарт хориглох үйл ажиллагаанд хамаарах ашигт малтмал хайх, олборлосон үйлдэл нь Эрүүгийн хуулийн 24.2 дугаар зүйлийн 1-д заасан (*1) тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмалын эрэл хайгуул, олборлолт* хийсэн шинжгүй байна. Мөн дархан цаазат газарт мод бэлтгэсэн үйлдэл нь Эрүүгийн хуулийн 24.6 дугаар зүйлийн 1-д заасан (*1) зөвшөөрөлгүйгээр ойд мод бэлтгэсэн* шинжгүй. Дархан цаазат газарт хөрс, ус, агаар бохирдуулах аливаа үйл ажиллагаа явуулах үйлдэл нь Эрүүгийн хуулийн 24.6 дугаар зүйлийн 1-д заасан (*1) химийн*

хорт, аюултай бодис, аюултай, хортой хог хаягдлыг агаар, газар, газрын хэвлий, усны сан бүхий газар, гол мөрний урсац бүрэлдэх эх, эх үүсвэрийн тэжээгдлийн муж, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хамгаалалтын бүс дотор хаяж хүний эрүүл мэнд, мал, амьтан, ургамал, тэдгээрийн үр удамд сөрөг нөлөөлөл үзүүлэх, өвчин эмгэг үүсгэх, үхэл, мөхөлд хүргэх нөхцөлийг бүрдүүлсэн гэмт хэргийн шинжгүй байхыг тус тус ойлгоно.

Тусгай хамгаалалттай газар нутагт хуулиар хориглосон үйл ажиллагаа гэдэг нь хуульд заасан хориглосон үйл ажиллагаа байна.



Хориглосон үйл ажиллагааг Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд шууд тодорхойлон зааж өгсөн байна. Тухайлбал, *дархан цаазат газарт* дараах үйл ажиллагаа явуулахыг хориглосон байдаг. Үүнд:

- Газар хагалах, ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох, геологийн судалгаа хийх, металл хайгч, химийн хорт болон тэсрэх бодис авч явах, ашиглах, элс, хайрга чулуу авах, мод, зэгс, шагшуурга бэлтгэх, хязгаарлалтын бүсээс бусад газарт зам тавих зэргээр байгалийн төлөв байдлыг өөрчлөх
- Байгалийн дагалт баялаг, эмийн, хүнсний болон техникийн зориулалттай ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх
- Ан амьтны тооллого, тэдгээрийн тоо, нас, хүйс, сүргийн бүтцийг зохицуулахаас өөр зориулалтаар ан амьтан агнах, барих, үргээх, тэдгээрийн үүр, ичээ, нүх, ноохойг хөндөх, эвдэж сүйтгэх
- Хортон шавж, мэрэгчид, түймэртэй тэмцэх, тэдгээрээс сэргийлэх арга хэмжээнд байгаль орчинд сөрөг нөлөөлөх арга, техник, бодис хэрэглэх
- Аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн түр буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа шинжилгээ хийх зориулалтаас өөр барилга байгууламж барих
- Хөрс, ус, агаар бохирдуулах аливаа үйл ажиллагаа явуулах
- Тухайн газрын хамгаалалтын захиргааны зөвшөөрөлгүйгээр нохой дагуулж, буу авч явах
- Аргагүйгээс бусад тохиолдолд тухайн газрын хамгаалалтын захиргаанаас урьдчилан авсан зөвшөөрөлгүйгээр агаарын хөлгөөр буулт хийх, хэт нам өндрөөр нислэг үйлдэх
- Өвөлжөө, хаваржаа, намаржаа, зуслангийн барилга байгууламж барих, зохих зөвшөөрөлгүйгээр мал бэлчээрлүүлэх
- Нуур, мөрөн, гол горхи, булаг, шанд зэрэг ил задгай усыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах
- Хууль тогтоомж болон хамгаалалтын горимоор хориглосон байгаль орчинд сөрөг нөлөөлөх бусад үйл ажиллагаа явуулах зэргийг хориглосон байна.

Байгалийн цогцолборт газарт дараах үйл ажиллагаа явуулахыг хориглосон байна. Үүнд:

- Газар хагалах, ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох, геологийн судалгаа хийх, металл хайгч, химийн хорт болон тэсрэх бодис авч явах, ашиглах, элс, хайрга чулуу авах, мод, зэгс, шагшуурга бэлтгэх, хязгаарлалтын бүсээс бусад газарт зам тавих зэргээр байгалийн төлөв байдлыг өөрчлөх
- Байгалийн дагалт баялаг, эмийн, хүнсний болон техникийн зориулалттай ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх
- Ан амьтны тооллого, тэдгээрийн тоо, нас, хүйс, сүргийн бүтцийг зохицуулахаас өөр зориулалтаар ан амьтан агнах, барих, үргээх, тэдгээрийн үүр, ичээ, нүх, ноохойг хөндөх, эвдэж сүйтгэх
- Хортон шавж, мэрэгчид, түймэртэй тэмцэх, тэдгээрээс сэргийлэх арга хэмжээнд байгаль орчинд сөрөг нөлөөлөх арга, техник, бодис хэрэглэх
- Аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн түр буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа шинжилгээ хийх зориулалтаас өөр барилга байгууламж барих
- Хөрс, ус, агаар бохирдуулах аливаа үйл ажиллагаа явуулах
- Тухайн газрын хамгаалалтын захиргааны зөвшөөрөлгүйгээр нохой дагуулж, буу авч явах
- Аргагүйгээс бусад тохиолдолд тухайн газрын хамгаалалтын захиргаанаас урьдчилан авсан зөвшөөрөлгүйгээр агаарын хөлгөөр буулт хийх, хэт нам өндрөөр нислэг үйлдэх
- Хууль тогтоомж болон хамгаалалтын горимоор хориглосон байгаль орчинд сөрөг нөлөөлөх бусад үйл ажиллагаа явуулах
- Батлагдсан ерөнхий төлөвлөгөө, зураг төсвийг зөрчиж суурингийн нутаг дэвсгэрийг тэлэх, барилга байгууламж барих зэргийг хориглоно.
- Мөн байгалийн цогцолборт газрын онцгой бүсэд өвөлжөө, хаваржаа, намаржаа, зуслангийн барилга байгууламж барих, зохих зөвшөөрөлгүйгээр мал бэлчээрлүүлэх, нуур, мөрөн, гол горхи, булаг, шанд зэрэг ил задгай усыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахыг хориглосон байна.

Харин *байгалийн нөөц газарт* түүний байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй барилга байгууламж барих, үйлдвэрлэлийн зориулалтаар газар ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох, ан амьтан агнах, барих, мод, зэгс, шагшуурга бэлтгэх зэргээр байгалийн унаган төрхийг өөрчлөх, мал аж ахуй эрхлэгч малчин өрхөд өвөлжөө, хаваржааны газар олгох, голын усыг бохирдуулах аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

Мөн *дурсгалт газар* дахь байгалийн болон түүх, соёлын дурсгалт зүйлээс 0.1-3.0 км-ийн орчимд сүр бараа, үзэмжийг нь дарах барилга байгууламж барих, газар хагалах, ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох, байгалийн болон түүх, соёлын дурсгалт зүйлийг хөндөх, эвдэх, буулгах, тэдгээрт хохирол учруулахуйц бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

Тусгай хамгаалалттай газар нутагт *газар ашиглаж байгаа иргэн, аж ахуйн, нэгж, байгууллага* нь (а) ашиглаж байгаа газраа бүхэлд нь буюу зарим хэсгийг бусдад дамжуулан ашиглуулах, (б) тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын дэглэм, горимоор хориглосон, гэрээнд зааснаас өөр буюу байгаль орчинд сөрөг нөлөөлөх үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

Зөрчлийн төсөөтэй гэмт хэргээс ялгагдах шинж. Эрүүгийн хуулийн тусгай ангийн хэд хэдэн заалтад улсын тусгай хамгаалалттай газарт хориглосон үйлдэлийн талаар тусгасан байдаг тул тэдгээрийг Зөрчлийн тухай хуулийн 7.17 дугаар зүйлийн Тусгай хамгаалалттай газар нутагт хориглосон үйл ажиллагаа явуулах **зөрчлийн** шинжтэй харьцуулан доорх хүснэгтээр харуулав.

Хүснэгт 3.8. *Тусгай хамгаалалттай газар нутагт хориглосон үйл ажиллагаа явуулах зөрчлийн төсөөтэй гэмт хэргээс ялгагдах шинж*

Гэмт хэрэг	Зөрчил
Эрүүгийн хуулийн 24.5 дугаар зүйл. Хууль бусаар ан агнах гэмт хэргийн 1 дэх хэсэг: Улсын тусгай хамгаалалттай газар нутагт зөвшөөрөлгүйгээр амьтан агнасан, барьсан	Зөрчлийн тухай хуулийн 7.17 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутагт хориглосон үйл ажиллагаа явуулах зөрчлийн 1 дэх хэсгийн тусгай хамгаалалттай газар нутагт: 1.1. хууль, захиргааны хэм хэмжээний акт, стандарт, дэглэм, горим зөрчсөн 1.2. менежментийн төлөвлөгөөнд тусгагдаагүй үйл ажиллагаа явуулсан үйлдэл
Эрүүгийн хуулийн 24.6 дугаар зүйл. Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийн 2.3 дахь заалт: Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ойд зөвшөөрөлгүйгээр ойд мод бэлтгэсэн	Зөрчлийн тухай хуулийн 7.17 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутагт хориглосон үйл ажиллагаа явуулах зөрчлийн 2 дахь хэсэг: Тусгай хамгаалалттай газар нутагт хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулах

Тусгай хамгаалалттай газар нутагт хориглосон үйл ажиллагаа явуулах зөрчилд тусгай хамгаалалттай газар нутагт хууль, захиргааны хэм хэмжээний акт, стандарт, дэглэм, горим зөрчсөн болон хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан үйлдлүүд хамаарна.

3.9.3. Зөрчлийн зүйлчлэл

Зөрчлийн тухай хуулийн 7.17 дугаар зүйлийн Тусгай хамгаалалттай газар нутагт хориглосон үйл ажиллагаа явуулах зөрчил нь тусгай хамгаалалттай газар нутагт хууль, захиргааны хэм хэмжээний акт, стандарт, дэглэм, горим зөрчсөн, менежментийн төлөвлөгөөнд тусгагдаагүй үйл ажиллагаа явуулсан, тусгай хамгаалалттай газар нутагт хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол зэрэг тодорхой шинжүүдийг зааж Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан байна.

Эрүүгийн хуульд Эрүүгийн хуулийн 24 дүгээр бүлгийн зарим гэмт хэргийг тусгай хамгаалалттай газар нутагт үйлдсэн бол гэж ялгаж заасан, эсхүл үйл ажиллагааны шинж заасан зарим зүйл, заалтаас бусдыг Зөрчлийн тухай хуулиар шийдвэрлэнэ.

3.9.4. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд анхаарах асуудал

Тусгай хамгаалалттай газар нутагт хяналтын үүрэг гүйцэтгэж байгаа зөрчил шалгах эрх бүхий албан хаагч нь тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын дэглэм, горим, стандарт, холбогдох хууль тогтоомж бүрийг сайтар судалж, зохих мэдлэгийг хуримтлуулсан байх зайлшгүй шаардлагатай бөгөөд ингэснээр иргэн, хуулийн этгээдээс явуулж буй үйлдэл нь дээрх дэглэм, горим, стандарт, хуулийн заалтын аль хэсгийг зөрчиж байгааг эрх зүйн талаас нь тодорхойлох мэдлэг, чадвартай болно. Үүнээс гадна, дараах зүйлсийг анхаарч ажиллах нь зүйтэй. Үүнд:

- Тухайн улсын тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан менежментийн төлөвлөгөөний хэрэгцээ, шаардлага, зорилго, үйл ажиллагаа, хэрэгжүүлэгчдийн үүрэг, хариуцлага, хийж гүйцэтгэх ажлын дараалал, төлөвлөгөөг мэддэг байх шаардлагатай.

- Зөрчлийг илрүүлэх, нотлоход онцгой анхаарч, баримтыг бүрдүүлэх, шаардлагатай гэрэл зураг, дүрс бичлэг, аудио болон видео бичлэгийг стандартын дагуу хийж чаддаг байх
- Хориглосон үйл ажиллагаа явуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэсэн заалтыг хэрэгжүүлэхэд Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг бүрийн шинжүүдийг мэддэг байх шаардлага үүснэ.
- Хууль бус үйлдлийг илрүүлэх боломж нь эргүүл, хяналт шалгалтыг хамгийн их байлгах явдал тул эргүүлийг тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ, хүн хүч, нөөц боломждоо тохируулан аль болох их давтамжтайгаар зохион байгуулж байх ёстой.
- Харин эргүүл, хяналт шалгалтыг тогтмол нэг өдөр, цаг хугацаанд хийх нь хууль бус үйл ажиллагааг илрүүлэх явцыг сааруулдаг. Учир нь хууль бус үйл ажиллагаа хийж буй этгээд байгаль хамгаалагч нарын эргүүлийн хэв маягийг урьдчилан таамаглах боломжтой болж, эдгээр өдөр цагуудаас зайлсхийдэг. Тиймээс байгаль хамгаалагч нар нь гэнэтийн байдлаар тогтмол бус, урьдчилан таамаглах боломжгүйгээр өдөр цагийг тохируулах нь зүйтэй юм.
- Төлөвлөгөөт эргүүл, хяналт шалгалтыг сард хоёроос доошгүй хугацаанд хийх нь тохиромжтой. Нэг удаагийн эргүүл, хяналт шалгалт нь 6-8 цаг үргэлжлэхэд болох ба хамгийн ихдээ 2-3 хоног үргэлжилж болно.
- Гэвч нэг удаагийн эргүүл, хяналт шалгалтын туулах зай нь тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ, байгаль хамгаалагч нарын тоо, нөөц боломжоос хамааран харилцан адилгүй байна. Жишээ нь, Говийн Бага дархан цаазат газар нь 19 байгаль хамгаалагчтай, нийт нутаг дэвсгэрийн хэмжээ нь 1.8 сая га гэж бодоход, нэг байгаль хамгаалагч 100,000-110,000 га талбайг хариуцан ажиллах бөгөөд сард 2 удаа төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийхэд нийт 400 км замыг туулж гүйцэтгэхээр байна. Үүнээс гадна, төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хэрэг, зөрчил гарсан, гэнэтийн дуудлага ирсэн юм уу сэжигтэй тохиолдолд хэдэн ч удаа хийх боломжтой.

Бодлого 1

Малчин М нь Ногооннуур сумын Улаанчулуут багийн “Бахлуур” хэмээх Сийлхэмийн нурууны байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүсэд хамаарах газарт уламжлалт аргаар мал маллаж 40-45 жил ажиллаж амьдарч байгаа билээ. Гэтэл тус сум дахь байгаль хамгаалагч А нь 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдөр сумын төвд дуудаж ирүүлэн янз бүрээр дарамтлан, монгол хэл мэдэхгүй намайг хуурч мэхлэн, айлган сүрдүүлж, зарим бичиг баримтад газрын үсэг зуруулан Зөрчлийн тухай хуулийн 7.17 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүсэд зөвшөөрөлгүй малын хашаа барьж хориглосон үйл ажиллагааг явуулсан гэх үндэслэлээр 500,000 төгрөгөөр торгож шийтгэл оногдуулсан юм. Гэтэл Зөрчлийн тухай хуулийн 7.17 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зохих зөвшөөрөлгүй малын хашаа хороо барьсан бол шийтгэл оногдуулах зохицуулалт байхгүй, зөвхөн хориглосон үйл ажиллагаа явуулсан бол шийтгэл оногдуулахаар зохицуулагдсан байна.

Иймд байгаль орчны хяналтын улсын байцаагчийн 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн № 0179607 дугаар шийтгэлийн хуудсыг хүчингүй болгож өгнө үү гэжээ. Шүүх хэрхэн шийдвэрлэх вэ?

Асуулт

1. Дээрх үйлдэл нь ямар хууль тогтоомж зөрчсөн вэ?

2. Энэ зөрчлийг шалгах ажиллагааны үед ямар ажиллагаа явуулах вэ?

3. Дээрх хууль бус үйлдэл нь Зөрчлийн тухай хуульд заасан ямар зөрчил болох вэ? Зөрчлийг зүйлчилнэ үү?
4. Зөрчил үйлдэгчид ямар шийтгэл оногдуулах вэ?

Хариулт

1. Дээрх үйлдэл нь ямар хууль тогтоомж зөрчсөн вэ?
Бодлогын өгөгдөлд байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүсэд гэж тодорхой өгсөн байна. Иймд Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан Байгалийн цогцолборт газарт хориглох үйл ажиллагаанд энэ хуулийн 15,16,17 дугаар зүйлд зааснаас өөр зориулалтаар 1. энэ хуулийн 12 дугаар зүйлийн 1-8, 11-д заасан үйл ажиллагаа явуулах, 2. онцгой бүсэд энэ хуулийн 12 дугаар зүйлийн 9, 10-д заасан үйл ажиллагаа явуулах, 3. батлагдсан ерөнхий төлөвлөгөө, зураг төсвийг зөрчиж суурингийн нутаг дэвсгэрийг тэлэх, барилга байгууламж барих зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглосон.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан Дархан цаазат газарт хориглох үйл ажиллагааны 9 дэх заалтад, мөн түүнчлэн тус хуулийн 18 дугаар зүйлд заасан Байгалийн цогцолборт газарт хориглох үйл ажиллагааны 2-т байгалийн цогцолборт газрын онцгой бүсэд өвөлжөө, хаваржаа, намаржаа, зуслангийн барилга байгууламж барих, зохих зөвшөөрөлгүйгээр мал бэлчээрлүүлэхийг тус тус хориглосон байна.

Харин Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 17 дугаар зүйлд зааснаар байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүсэд (2) уламжлалт аргаар мал аж ахуй эрхэлж болно гэжээ. Иймд малчин М-ийн байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүсэд малын хашаа барьсан нь хориглосон үйл ажиллагаанд хамаарахгүй буюу хууль зөрчөөгүй байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь тусгай хамгаалалттай газар нутгийн зөвшөөрөгдсөн бүсэд тодорхой зориулалтаар ашиглаж болох газар, түүний хэмжээ, ашиглах журам, уг газарт байлгаж болох малын төрөл, тоог тогтоох бүрэн эрхтэй. Мөн тухайн сумын Засаг дарга байгаль, цаг уурын хүндрэл тохиолдсон үед дархан цаазат, байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүс, байгалийн нөөц болон дурсгалт газар, тэдгээрийн орчны бүсэд хамгаалалтын дэглэм, горим, бэлчээрийн нөөц, даацад нийцүүлэн мал бэлчээрлүүлэх, хадлан бэлтгэх ажлыг гэрээний үндсэн дээр харьяалах хамгаалалтын захиргаатай хамтран зохион байгуулах бүрэн эрхийг Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 29[1] дүгээр зүйлд заасан байна.

2. Энэ зөрчлийг шалгах ажиллагааны үед ямар ажиллагаа явуулах вэ?
Болсон үйл баримт нь Зөрчлийн тухай хуулийн 7.17 дугаар зүйлд заасан зөрчлийн шинжийг агуулаагүй тул зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахгүй. Харин бодлогын өгөгдөлд 500.000 төгрөгөөр торгож хариуцлага оногдуулсан зөрчлийн шийтгэлд прокурор дүгнэлт бичиж, харьяалах шүүхэд дүгнэлт гаргана.

3. Дээрх хууль бус үйлдэл нь Зөрчлийн тухай хуульд заасан ямар зөрчил болох вэ? Зөрчлийг зүйлчилнэ үү?
Зөрчил биш тул зүйчлэх шаардлагагүй.

4. Зөрчил үйлдэгчид ямар шийтгэл оногдуулах вэ?
Зөрчлийн тухай хуулийн 7.17 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 18 дугаар зүйл, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 1.5 дахь хэсэгт заасныг тус тус баримтлан гомдол гаргагч малчин М-ийн гомдлын шаардлагыг бүхэлд нь хангаж, Монгол Алтайн нурууны улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны Ногооннуур сум дахь байгаль орчны хяналтын улсын байцаагчийн 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн № 0179607 дугаартай шийтгэлийн хуудсыг шүүх хүчингүй болгоно.

Бодит жишээ 1 **Завхан аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх**

Үйл баримт
Завхан аймаг дахь Тарвагатай нурууны байгалийн цогцолборт газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч 2023 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн 01 бүртгэлийн дугаартай зөвшөөрөлгүй хог хаясан гэх гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж, зөрчилд холбогдогч М-д 2023 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр № 001001 дугаартай шийтгэлийн хуудсаар “Хог хаягдлын тухай хуулийн 6.2.8 зааснаар 300,000 төгрөгөөр торгох” шийтгэл оногдуулж, зөрчлийг шийдвэрлэсэн байна.

Эрх бүхий албан тушаалтан нь 2023 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн № 001001 дугаартай шийтгэлийн хуудасны “Олсон” хэсэгт Хог хаягдлын тухай хуулийн 6.2.8-д заасныг зөрчсөн гэж дүгнэн “Шийдвэрлэх нь” хэсэгт М-д 300,000 төгрөгийн торгох шийтгэл оногдуулсан нь хууль зүйн үндэслэлгүй байна гэж прокурор дүгнэлт гаргаж, шүүхэд ханджээ.

Прокурор дүгнэлтдээ:
- Хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулсан тухай эрх бүхий албан тушаалтны тэмдэглэл, зөрчилд холбогдогчийн эрх бүхий албан тушаалтанд гаргасан хүсэлт, хаясан гэх хог хаягдлын талаарх гэрэл зураг зэрэг нотлох баримтуудаас дүгнэхэд М-д холбогдох хэргийн үйл баримт нь Зөрчлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн **Хог хаягдлын тухай хууль зөрчих зөрчлийн** 7 дахь хэсгийн 7.2-т заасан “*Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь хог хаягдлын талаар хуульд заасан хог хаягдлаа зориулалтын хогийн сав болон цэгт хаях, эсхүл хог хаягдал цуглуулж тээвэрлэх эрх бүхий байгууллагад шилжүүлэх”* гэх зөрчлийн шинжийг агуулж байх үндэслэлтэй байна.
- Энэ нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1-д “тухайн хүн, хуулийн этгээдийн зөрчил үйлдсэнийг нотлох баримт бүрдсэн эсэх”-ийг, мөн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.3-д зааснаар “тухайн үйлдэл, эс үйлдэхүй нь Зөрчлийн тухай хуульд заасан шийтгэл оногдуулах зүйл, хэсэг, заалтад нийцэж байгаа эсэх”-ийг шалгаагүй зөрчлийг,
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар “*Эрх бүхий албан тушаалтан гаргасан шийдвэрийнхээ үндэслэлийг нотлох үүрэг хүлээнэ”* гэж заасны дагуу оролцогчдын эрхийг зөрчсөн, хуулийг нэг мөр хэрэгжүүлэх эрх, үүргээ хэрэгжүүлж чадаагүй зэрэг ноцтой зөрчлийг,
- Эрх бүхий албан тушаалтан нь зөрчилд холбогдогч М-д хуульд заасан эрх, үүргийг нь йтанилцуулсан хэдий ч түүнээс зөрчлийн хэргийн үйл баримтын талаар

тодруулж мэдүүлэг авах ажиллагааг хийсэн эсэх нь тодорхойгүй, хэрэв хийсэн бол холбогдогчийн өгсөн мэдүүлгийг тэмдэглэлээр бэхжүүлж аваагүй атлаа гарын үсэг зуруулсан байгаа нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.8 дугаар зүйлийн 6-д заасан “Эрх бүхий албан тушаалтан мэдүүлгийг асуулт асууж, хариулт авах хэлбэрээр явуулна”, 14-т заасан “Эрх бүхий албан тушаалтан мэдүүлгийг тэмдэглэлээр бэхжүүлж, мэдүүлэг өгсөн хүн гарын үсэг зурж баталгаажуулна” гэснийг,

- Засгийн газрын 2021 оны 135 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлсан “Шийтгэлийн болон шийтгэлээс чөлөөлөх хуудасны маягт, хэрэглэх журмын 2 дахь хэсгийн 2.5-д зааснаар “Эрх бүхий албан тушаалтан шийтгэлийн хуудсыг 3 хувь үйлдэж, эх хувийг материалд хавсаргаж 2 дахь хувийг холбогдогчид өгч, үлдэх хувийг энэ журмын 2.4-т заасан албан тушаалтанд өгч, тооцоо хийнэ” гэснийг зөрчиж 2 дахь хувийг зөрчлийн материалд хавсаргасан зөрчлүүдийг тус тус гаргасан тул хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн нь үндэслэлгүй байна гэж үзлээ.

Хариуцагч Тарвагатайн нурууны байгалийн цогцолборт газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч шүүхэд гаргасан тайлбартаа: ...Прокурорын дүгнэлттэй танилцлаа, прокурорын бичсэн дүгнэлтийг хүлээн зөвшөөрч байна гэжээ.

Шүүх

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэгт “хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хүлээн зөвшөөрсөн нь бусад этгээдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөхөөргүй, хуульд харшлаагүй байвал шүүх хариуцагчийн зөвшөөрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгоно” гэж заасан байна.

Дээрх хариуцагчийн зөвшөөрөл нь шийтгэл хүлээсэн гуравдагч этгээдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөхөөргүй, хуульд харшлаагүй байх тул хариуцагчийн зөвшөөрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох нь зүйтэй байна.

Анхаарах зүйлс

- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.1 дүгээр зүйл.Шийтгэл оногдуулах заалтын 1 буюу Эрх бүхий албан тушаалтан шийтгэл оногдуулахдаа дараах нөхцөл байдлыг тогтоосон байна гээд 1.1. тухайн хүн, хуулийн этгээдийн зөрчил үйлдсэнийг нотлох баримт бүрдсэн эсэх”-ийг тогтоосны дараа шийтгэл оногдуулна гэдэг заалтыг зөрчсөн байна. Иймд нотлох ажиллагаа дээр алдаа гаргасан байна.
- Холбогдогчоос мэдүүлэг авахдаа үйл баримтыг тодруулж, тэмдэглэлд тусгаагүй.
- Засгийн газрын 2021 оны 135 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлсан “Шийтгэлийн болон шийтгэлээс чөлөөлөх хуудасны маягт, хэрэглэх журам”-ын холбогдох заалтыг зөрчсөн буюу хайнга хандсан байна.
- Процесс ажиллагаа явуулахдаа хуулийн заалт бүрийн дагуу шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах ба Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиас гадна, бусад холбогдох эрх зүйн актыг баримтлах шаардлагатай.

Бодит жишээ 2 **Хөвсгөл аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх**

Хөвсгөл аймгийн Улаан тайгын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны байгаль хамгаалагч нь Хорьдол Сарьдагийн дархан цаазат газрын онгон бүсэд зөвшөөрөлгүй буутай явсан гэх Г-06 дугаартай зөрчилд зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж, холбогдогч Д-д Зөрчлийн тухай хуулийн 7.17 дугаар зүйлийн 2 дахь заалтад заасан тусгай хамгаалалттай газар нутагт хориглосон үйл ажиллагаа явуулах зөрчил үйлдсэн гэж үзэж 2024 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр 500 нэгжээр торгох шийтгэл оногдуулсан байна.

Холбогдогч Д-ийн зөрчил үйлдсэнийг нотлох баримт бүрдээгүй буюу зөрчил үйлдэгдсэн газар нь Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд зааснаар улсын тусгай хамгаалалттай газар мөн эсэхийг багаж, хэрэгсэл ашиглан координатыг тогтоох, үүний дагуу холбогдох байгууллагаас лавлагаа авах зэргээр хуулиар буутай (галт зэвсэг) нэвтрэхийг хориглосон газар мөн эсэхийг нотолж тогтоох шаардлагатай ажиллагааг хийж, зөрчлийн шинжийг тогтоох нотлох баримт бүрдээгүй байна. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1 дэх заалтад "*тухайн хүн, хуулийн этгээдийн зөрчил үйлдсэнийг нотлох баримт бүрдсэн эсэхийг эрх бүхий албан тушаалтан шийтгэл оногдуулахдаа тогтоосон байна"* гэж заасныг зөрчсөн байна.

Эрх бүхий албан тушаалтны үйлдсэн шийтгэлийн хуудас нь хуульд заасан үндэслэл журмын дагуу бичигдээгүй дараах зөрчлүүдийг дурдаж байна.

- Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7 дахь хэсгийн 28.7.1-д Зүйлийг дугаарлахдаа зүйлийн дугаарын өмнө нь баруун талдаа цэгтэй тухайн бүлгийн дугаарыг араб тоогоор бичиж, ард нь "дүгээр", эсхүл "дугаар" гэж бичгээр (1 дүгээр зүйл. г.м),
- 28.7.2-т хэсгийг баруун талдаа цэгтэй араб тоогоор (1.1. г.м) гэж хуулийн зүйл, хэсэг заалтыг хэрхэн бичих талаар хуульчилжээ.
- Эрх бүхий албан тушаалтан 2024 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн № 0214683 дугаартай шийтгэлийн хуудасны шийдвэрлэх нь хэсгийн 1 дэх заалтад Зөрчлийн тухай хуулийн 7.17.2-т заасны дагуу гэж бичсэн нь Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу бичигдээгүйгээс зүйл, хэсэг нь ялгагдахгүй, тодорхой бус байна.
- Мөн шийдвэрлэх нь хэсгийн 1 дэх заалтын хоёр дахь агуулгад шийтгэлийн төрлийг хуульд заасан үндэслэл журмын дагуу бичээгүй нь ойлгомжгүй бөгөөд Зөрчлийн тухай хуулийн 1.2 дугаар зүйлийн 2-т заасан зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээг энэ хуулиар тогтооно гэсэн хууль ёсны зарчимд нийцээгүй байна.
- Түүнчлэн шийтгэлийн хуудасны шийдвэрлэх нь хэсгийн 2 дахь заалтын гурав дахь агуулгад зөрчил үйлдэж олсон мөнгөн орлогыг төрийн сангийн 100170000988 тоот дансыг бичсэн нь үндэслэлгүй буюу холбогдогч нь зөрчил үйлдэж ашиг орлого олсон зүйл байхгүй байхад төлүүлэх банк дахь данс бичжээ.
- Зөрчлийн материал болон хэргийн үйл баримтаар холбогдогчид үүрэг хүлээлгэх үндэслэл байхгүй байхад дээрх хэсгийг нөхөж бөглөсөн нь үндэслэлгүй байна.

Иймд эрх бүхий албан тушаалтны холбогдогч Д-д шийтгэл оногдуулсан шийдвэр нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1 дэх заалтыг зөрчсөн байх тул Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.2 дугаар зүйлийн 8 дахь хэсгийг удирдлага болгон Улаан тайгын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны байгаль хамгаалагч, эрх бүхий албан тушаалтан Д-д оногдуулсан 2024 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн № 0214683 дугаартай шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулахаар прокурорын дүгнэлт бичжээ.

Хариуцагч № 0214683 дугаартай шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулахаар прокурор албан ёсоор дүгнэлт гаргаж байгааг хүлээн зөвшөөрсөн байна.

Шүүх

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.1 дэх хэсэгт заасныг удирдлага болгон ЗАХИРАМЖЛАХ нь:

Прокурорын гаргасан 2024 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн № 0214683 дугаартай шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах шаардлага бүхий дүгнэлтийг хариуцагч хүлээн зөвшөөрснийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгосугай.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 69 дүгээр зүйлийн 69.2 дахь хэсэгт зааснаар энэхүү шүүгчийн захирамжийг хариуцагч сайн дурааараа биелүүлээгүй тохиолдолд шүүхийн шийдвэрийн нэгэн адил албадан биелүүлэхийг дурдсугай.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.2 дахь зааснаар хэргийн оролцогчид, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч уг асуудлаар шүүхэд дахин нэхэмжлэл гаргах болон уг захирамжид гомдол гаргах эрхгүй гэж шийдвэрлэжээ.

Хариуцагч Улаан тайгын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны байгаль хамгаалагч нь 2024 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн № 0214683 дугаартай шийтгэлийн хуудсыг хүчингүй болгох тухайгаа холбогдогч Д-д мэдэгдсэн тухайгаа баримтжуулах үүрэг хүлээнэ.

Анхаарах зүйл

- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн журам зөрчсөн байна.
- Хохирол учраагүй байх буюу хэлбэрийн шинжтэй зөрчилд зөвхөн торгууль буюу шийтгэл оногдуулна. Гэтэл торгуулийг төлүүлэхдээ хууль бусаар олсон орлогыг төлүүлэх данс өгч мөнгийг байршуулсан.

Мэдлэг сорих тест

1. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэхгүйгээр, эсхүл зохих байгууллагын шийдвэр гаргуулахгүйгээр үйл ажиллагаа явуулсан бол Зөрчлийн тухай хуулиар яаж шийдэх вэ?

а. Таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно
б. Хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно
в. Хууль бус үйл ажиллагааг зогсоож, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно
г. Хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно

2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй ажилласан, эсхүл уг төлөвлөгөөг хэрэгжүүлээгүй, биелэлтийг тогтоосон хугацаанд гаргаж, холбогдох газарт тайлагнаагүй бол ямар субъектийг хэдэн нэгжээр торгох вэ?

а. Хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно
б. Хүнийг таван зуун таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно
в. Хуулийн этгээдийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно
г. Хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно

3. Ямар үйлдэл, эс үйлдэхүй хийсэн хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох вэ?

а. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тавигдсан шаардлагыг биелүүлээгүй
б. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй ажилласан
в. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний шинжилгээ, хянан магадалгаагаар байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг буруу хийсэн
г. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэхгүйгээр, эсхүл зохих байгууллагын шийдвэр гаргуулахгүйгээр үйл ажиллагаа явуулсан

4. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль хэдэн бүлэг хэдэн зүйлтэй вэ?

а. 6 бүлэг, 30 зүйл
б. 7 бүлэг, 20 зүйл
в. 5 бүлэг, 20 зүйл
г. 5 бүлэг, 30 зүйл

5. Үнэлгээний шинжээч гэж ямар этгээдийг хэлэх вэ?

а. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, үнэлгээний тайланд дүгнэлт гаргах эрх бүхий этгээд
б. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, үнэлгээний тайланд шинжилгээ хийх эрх бүхий этгээд
в. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, үнэлгээний тайланг хянаж, шалгах эрх бүхий этгээд
г. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, үнэлгээний тайланд шинжилгээ хийж, дүгнэлт гаргах эрх бүхий этгээд

6. Олон нийтийн оролцооны асуудлыг журмаар зохицуулах бөгөөд уг журмыг хэн баталдаг вэ?

а. Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
б. Засгийн газрын гишүүн

в. Байгаль орчны асуудал эрхлэх газар
г. Засгийн газар

7. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол ямар хариуцлага хүлээлгэх вэ?
а. Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ
б.Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ
в. Эрүүгийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ
г. Захиргааны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ

8. Аж ахуйн нэгжид байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрхийг мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр хэдэн жилийн хугацаатай олгох вэ?
а. Дөрвөн жилийн хугацаатай олгоно
б. Зургаан жилийн хугацаатай олгоно
в. Таван жилийн хугацаатай олгоно
г. Гурван жилийн хугацаатай олгоно

9. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг хүлээн авсан шинжээч хэдэн өдөрт багтаан үнэлгээний шинжилгээ хийж дүгнэлт гаргах вэ?
а. Ажлын 14 өдөрт
б. Ажлын 20 өдөрт
в. Ажлын 18 өдөрт
г. Ажлын 15 өдөрт

10. Нөлөөллийн үнэлгээ нь ямар үнэлгээнээс бүрдэх вэ?
а. Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнээс бүрдэнэ
б. Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ, байгаль орчны нөлөөллийн дүгнэлтийн үнэлгээнээс бүрдэнэ
в. Байгаль орчны нөлөөллийн хяналтын үнэлгээ, байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээнээс бүрдэнэ
г. Байгаль орчны нөлөөллийн хяналтын үнэлгээ, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнээс бүрдэнэ

11. Хуульд заасан ямар арга хэмжээг зөрчсөн бол Зөрчлийн тухай хуулиар торгодог вэ?
а. Хөрс хамгаалах, хөрсийг нөхөн сэргээх, цөлжилтийг сааруулах арга хэмжээ
б. Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх, цөлжилттэй тэмцэх
в. Цөлжилтийг сааруулах арга хэмжээ, цөлжилтөөс сэргийлэх, хөрсийг нөхөн сэргээх
г. Хөрсийг нөхөн сэргээх, цөлжилттэй тэмцэх, цөлжилтөөс сэргийлэх

12. Дээрх арга хэмжээг зөрчсөн бол ямар шийтгэл хүлээлгэх вэ?
а. Хүнийг жаран нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно
б. Хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг зургаан зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно
в. Хүнийг гучин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно
г. Хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно

13. Хөрсний доройтол, цөлжилтийн төлөв байдлын зэрэглэлийг ямар байдлаар ангилдаг вэ?
- а. сул, дунд, хүчтэй
- б. энгийн, дунд, хүчтэй
- в. сул, хүчтэй
- г. доод, дунд, дээд

14. Хөрсний доройтлын хүчтэй зэрэглэлд тухайн газар нутгийн хөрсний талбайн хэдэн хувь бохирдсон, эсхүл хөрс гүн эвдрэлд орсон, үржил шимт чанараа алдаж ялзмагийн нөөцийн багасалт хэдээс дээш хувьд хүрсэн газар хамаарах вэ?
- а. 40-60%; 50%
- б. 20-40%; 60%
- в. 20-50%; 50%
- г. 30-50%; 40%

15. Хөрсний шинж чанарт гарч байгаа өөрчлөлтийг ..... тогтооно.
- а. хөрсний лаборатори
- б. лаборатори
- в. итгэмжлэгдсэн хөрсний шинжээч
- г. итгэмжлэгдсэн хөрсний лаборатори

16. Хуурайшлын индекс гэж юу вэ?
- а. Тухайн газар нутгийн жилийн тунадасны хэмжээ болон ургамал, хөрсний нийлбэр ууршилт хоорондын харьцааг
- б. Тухайн газар нутгийн 6 сарын тунадасны хэмжээ болон ургамал, хөрсний нийлбэр ууршилт хоорондын харьцааг
- в. Тухайн газар нутгийн жилийн тунадасны хэмжээ
- г. Тухайн газар нутгийн жилийн ургамал, хөрсний нийлбэр ууршилт хоорондын харьцааг

17. Хөрс хамгаалахад хэрэгжүүлдэг нийтлэг арга хэмжээнүүдээс хамааралгүйг ол.
- а. Хөрсийг нөхөн сэргээх
- б. Хөрс хамгаалах чиглэлээр чадавхыг бэхжүүлэх
- в. Дунд зэрэглэлийн доройтол илэрсэн хөрсөнд сааруулах
- г. Усны нөөцийг зөв зохистой ашиглах, хамгаалах, нэмэгдүүлэх

18. Ойн сангийн газрын хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэхэд хэрэгжүүлэх арга хэмжээнүүдээс хамааралгүйг ол.
- а. Мод бэлтгэлийг технологийн дагуу явуулах
- б. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тогтоосон цэгээс бусад газарт хөрсийг хог хаягдлаар бохирдуулахгүй байх
- в. Мод бэлтгэсэн талбайг хуурайшихаас өмнө ойжуулах
- г. Хөрсний ялзмаг, үржил шимийг тогтоох, доройтлоос хамгаалах зорилгоор гуу, жалга үүсэж болох газарт хаалт хамгаалалт хийх, ойжуулах

19. Иргэн, хуулийн этгээд өөрийн хууль бус үйл ажиллагаанаас хөрсийг доройтуулсан бол .....
- а. зөрчлийн хуулийн 7.2 дугаар зүйлийн дагуу шийдвэрлэх
- б. хохирлыг арилгаж, хөрсийг нөхөн сэргээх
- в. хохирлыг арилгаж, тавин нэгжээр торгох
- г. хариуцлага хүлээлгэх талаар эрх бүхий албан тушаалтнаас шаардах

20. Цөлжилтөөс сэргийлэх арга хэмжээ гэж юу вэ?
- а. Доройтсон хөрсийг анхны төрх байдалд нь оруулах, үржил шимийг нь нэмэгдүүлэн сайжруулах үйл явцыг
- б. Цөлжих нөхцөл байдлыг илрүүлэх, мэдээлэх, хөрсийг сайжруулахад чиглэсэн цөлжилтөөс зайлсхийх үйл ажиллагааг
- в. Цөлжилтийн эсрэг техникийн болон биологийн үйл ажиллагаа явуулж, түүний тархалт, идэвхжилт, үйл явцыг удаашруулах, тогтоох арга хэмжээг
- г. Хөрсний доройтол, цөлжилтийн тархалт, идэвхжилтийг бууруулах, зогсоох, сөрөг нөлөөллийг арилгах үйл ажиллагааг

21. Агаар хамгаалах талаар тавигдах шаардлага хангаагүй барилга байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглалтад оруулсан хуулийн этгээдийг ...
- а. гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
- б. гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
- в. таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
- г. нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

22. Хүн амын оршин суугаа орчны агаарыг бохирдуулан хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх нөхцөлийг бүрдүүлсэн бол хүнийг ....
- а. нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
- б. арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
- в. тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
- г. таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

23. “Агаарын бохирдол” гэж ..... ойлгоно.
- а. байгаль орчны бүрэлдэхүүн хэсгийн нэг болох хийн мандлын байгалийн төлөвөөрөө байгаа бохирдуулах хийн хольцыг
- б. хүрээлэн байгаа агаарт шууд хаягдсан, эсхүл физик, химийн урвалын дүнд шинээр үүсэж бий болсон бохирдуулах бодисын агууламж нь агаарын чанарын стандартаас хэтрэхийг
- в. гэж хүрээлэн байгаа агаарт жилд 100 тонноос их аливаа бохирдуулах бодис, эсхүл таван тонноос их аюултай бохирдуулах бодис гаргадаг үйлдвэрлэл, үйлчилгээний болон бусад зориулалтын барилга байгууламжийг
- г. байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан жагсаалтад орсон бохирдуулах бодисыг

24. Агаарт бохирдуулах бодис гаргах, физикийн сөрөг нөлөөлөл үзүүлэх талаар зөвшөөрөлд заасан хэмжээ, нөхцөл, шаардлагыг зөрчсөн бол хүнийг болон хуулийн этгээдийг .....
- а. нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
- б. нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
- в. нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно, нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
- г. нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

25. Агаарын бохирдлын эх үүсвэр бүхий төлбөр төлөгч субъект нь алин вэ?
- а. Аж ахуйн нэгж
- б. Байгууллага
- в. Иргэн
- г. Дээрх бүгд

26. Озон задалдаг, дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй бодис болон бусад орлуулах бодисыг системээс юүлэх, цэвэрлэх, дахин боловсруулах, дахин цэнэглэх, бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжийг суурилуулах, ашиглах, засвар үйлчилгээ хийх, устгах үйл ажиллагааг хэн гүйцэтгэх вэ?

а. Төрийн захиргааны төв байгууллага
б. Төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон мэргэжлийн байгууллага
в. Засгийн газрын гишүүнээс эрх олгосон мэргэжлийн байгууллага
г. Дээрх бүгд

27. Агаарын чанарт сөргөөр нөлөөлж байгаа өөрийн үйл ажиллагааны тухай мэдээлэл, озон задалдаг бодис, түүнийг орлуулах бусад бодис, тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмжийн импорт, үйлдвэрлэлийн тухай мэдээлэл, агаарын бохирдлын эх үүсвэрийн тухай мэдээлэл, агаарт гаргасан бохирдуулах бодисын агууламж, хаягдлын хэмжээ, дотоод хяналтын мэдээг тогтоосон хугацаанд мэдээлээгүй (1.2) зориуд буруу мэдээлсэн, (1.3) нуун дарагдуулсан, эсхүл хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан бол хүнийг .....

а. нөхөн төлбөр гаргуулж, гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
б. учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулна.
в. учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
г. учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

28. “Агаарын бохирдлын төлбөр” гэж ..... ойлгоно.

а. түүхий нүүрс олборлогч, органик уусгагч үйлдвэрлэгч, импортлогч, автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэл эзэмшигч, агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр ашиглах зөвшөөрөл эзэмшигч, агаарын бохирдлын эх үүсвэр хэрэглэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэний агаарт бохирдуулах бодисыг бохирдуулах бодисын хаягдлын стандартад заасан хэмжээнд гаргасан тохиолдолд төлөх төлбөрийг
б. хүрээлэн байгаа агаарт бохирдуулах бодисыг бохирдуулах бодисын хаягдлын стандартад заасан хэмжээнээс хэтрүүлэн гаргасан тохиолдолд төлөх төлбөрийг
в. түүхий нүүрс олборлогч, органик уусгагч үйлдвэрлэгч, импортлогч, автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэл эзэмшигч, хүрээлэн байгаа агаарт бохирдуулах бодисыг бохирдуулах бодисын хаягдлын стандартад заасан хэмжээнээс хэтрүүлэн гаргасан тохиолдолд төлөх төлбөрийг
г. иргэний агаарт бохирдуулах бодисыг бохирдуулах бодисын хаягдлын стандартад заасан хэмжээнд гаргасан тохиолдолд төлөх төлбөрийг

29. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага агаар хамгаалах талаар хуульд заасан бүрэн эрхээс аль нь биш вэ?

а. Агаар хамгаалах талаарх төрийн бодлого, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах
б. Агаар хамгаалахтай холбогдсон дүрэм, журам, аргачлал, зааврыг баталж, хэрэгжилтийг хангах
в. Агаарын бохирдлыг бууруулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг Засгийн газрын болон нийслэлийн бонд гаргах, бусад санхүүгийн эх үүсвэрийг дайчлах замаар шийдвэрлэх
г. Аюултай бохирдуулах бодисын жагсаалтыг батлах

30. Агаарын бохирдлыг бууруулахад дараах үйл ажиллагааг тодорхой үе шаттайгаар хэрэгжүүлдэг. Аль үе шатанд хамаарахгүй вэ?

а. Эрчим хүчний эх үүсвэр, гэр хорооллын цахилгаан дамжуулах болон түгээх сүлжээг өргөтгөх, хүчин чадлыг нэмэгдүүлэх
б. Гэр хорооллын өрхийн газрыг барьцаалах, эдийн засгийн эргэлтэд оруулах замаар уул уурхайн баялгаас бий болох хөрөнгөөс урт хугацаатай, бага хүүтэй зээлийг олгож үл хөдлөх эд хөрөнгө, барилга, орон сууц барих бололцоо, нөхцөл бүрдүүлэх
в. Орон нутагт хөрөнгө оруулалт, ажлын байр нэмэгдүүлэх, бүсийн нэмэгдлийг бий болгож өрх, аж ахуйн нэгж, байгууллагыг нийслэлээс орон нутагт шилжих таатай нөхцөл бүрдүүлэх
г. Түүхий нүүрсийг ахуйн зориулалтаар хэрэглэхээс татгалзаж, цахилгаан, газрын гүний дулаан, хагас коксон болон хийн түлшийг ашиглах

31. Амьтны мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг ямар хуулиар зохицуулах вэ?

а. Амьтны тухай хууль
б. Байгаль орчны тухай хууль
в. Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай
г. Ойн тухай хууль

32. Амьтныг гадаад улсаас оруулах журмыг ямар байгууллага батлах вэ?

а. УИХ
б. Засгийн газар
в. Төрийн захиргааны төв байгууллага
г. Байгаль орчны асуудал эрхэлсэн газар

33. Харь амьтныг ямар байгууллагын зөвшөөрөлгүйгээр нутагшуулах, өсгөж үржүүлэхийг хориглодог вэ?

а. Засаг даргын тамгын газар
б. УИХ
в. Төрийн захиргааны төв байгууллага
г. Эрдэм шинжилгээний байгууллага

34. Амьтны тухай хууль тогтоомж зөрчсөний улмаас амьтны аймагт учирсан хохирлыг хэн нөхөн төлөх вэ?

а. Байгаль орчны яам
б. Засгийн газар
в. Тухайн орон нутгийн байгууллага
г. Гэм буруутай этгээд

35. Амьтны тухай хуулийн холбогдох заалтыг зөрчиж зөвшөөрөл, гэрчилгээ олгосон нь гэмт хэргийн шинжгүй бол албан тушаалтанд ямар хуульд заасан хариуцлага хүлээлгэх вэ?

а. Төрийн албаны тухай хууль
б. Эрүүгийн хууль
в. Зөрчлийн тухай хууль
г. Байгаль орчныг хамгаалах тухай хууль

36. Ямар амьтныг амьдаар нь гадаад улсад гаргах зөвшөөрлийг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний дагуу Засгийн газар олгодог вэ?

а. Ховор амьтан
б. Нэн ховор амьтан
в. Бүх амьтан
г. Амьдаар нь гадаад улс руу гаргадаггүй

37. Харь амьтныг ашиглах журмыг хэн батлах вэ?
а. УИХ
б. Засгийн газар
в. Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
г. Ерөнхийлөгч

38. Амьтны мэдээллийн санд хамаарахыг ол.
а. Амьтны тархац нутаг, нөөц, түүний үнэлгээ
б. Амьтны судалгааны тайлан, мэдээ баримт
в. Амьтан хамгаалах, өсгөн үржүүлэх, ашиглах арга хэмжээний мэдээ
г. Дээрх бүгд хамаарна

39. Иргэн, хуулийн этгээд амьтан ашиглах, агнуурын амьтан агнах, барихад төлбөр, хураамж төлөх үү?
а. Төлнө
б. Төлөхгүй
в. Хуульд энэ талаар заагаагүй
г. Аль нь ч биш

40. Амьтныг эзэмших, ашиглах, агнуур хийх үйл ажиллагааг явуулахдаа амьтны жам ёсны эрхийг хүндэтгэн ямар үйлдэл хийх ёстой вэ?
а. Энэрэнгүй ёсоор хандана
б. Шударга ёсоор хандана
в. Хайхрамжгүй хандана
г. Хүндэтгэлтэй хандана

41. Амьтны тухай хуулийн зорилт нь:
а. амьтныг хамгаалахад оршино
б. өсгөн үржүүлэхэд оршино
в. нөөцийг зохистой ашиглахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино
г. Бүгд зөв

42. Амьтны тухай хуулийн тогтоомж нь:
а. Монгол Улсын Үндсэн хуулиас бүрдэнэ
б. Байгаль орчныг хамгаалах тухай хуулиас бүрдэнэ
в. Тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад актаас бүрдэнэ
г. Дээрх бүгд зөв

43. Амьтны тухай хууль ямар харилцааг зохицуулах вэ?
а. Хүн мал хоёрын хоорондох
б. Хүн гэрийн тэжээвэр амьтны хоорондын харилцааг
в. Мал гэрийн тэжээвэр амьтнаас бусад амьтны хамгаалах өсгөн үржүүлэх түүнтэй нөөцийг зохистой ашиглахтай холбогдсон харилцааг
г. Хүн амьтан хоорондын харилцаа

44. Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга буюу түр нутагшсан хөхтөн шувуу, мөлхөгч, хоёр нутагтан, загас, хавьч хэлбэртэн, зөөлөн биетэн, эгэл биетнийг .....гэнэ.

а. Амьтан
б. Ховор амьтан
в. Нэн ховор амьтан
г. Мал

45. Тухайн амьтны нутагладаг, нүүдэллэдэг, тэдгээрийн амьдрах таатай нөхцөл бүрдсэн газрыг .....гэнэ

а. Бэлчээр
б. Тархац нутаг
в. Бууц
г. Отог

46. Тархац нутагтаа бүхэлдээ эсхүл ихэнх хэсэгт тоо толгой эрс цөөрсөн, ашиглах нөөцгүй, устах аюулд орсон амьтныг ..... гэнэ.

а. Улаан номд орсон амьтан
б. Нэн ховор амьтан
в. Ховор амьтан
г. Агнуурын амьтан

47. Тархац нутагтаа тоо толгой цөөрсөн, нөөц багатай, устах аюулд өртсөн амьтныг ..... гэнэ.

а. Улаан номд орсон амьтан
б. Нэн ховор амьтан
в. Ховор амьтан
г. Агнуурын амьтан

48. Хэвийн өсөлт үржилтийг нь алагдуулахгүй агнах барих боломжтой агнуурын амьтны тоо хэмжээг ..... гэнэ.

а. Агнуурын нөөц
б. Агнуурын амьтан
в. Агнуурын амьтны сүрэг
г. Амьтны нөөц

49. Арьс, үс, мах болон бусад түүхий эдийг нь ашиглахаар агнаж ирсэн уламжлалт амьтан

а. Агнуурын нөөц
б. Агнуурын амьтан
в. Агнуурын амьтны сүрэг
г. Амьтны нөөц

50. Ангийн гаралтай түүхий эдийг ашиглах зорилгоор хуулиар заасан хугацаа, арга хэрэгсэл зөвшөөрлийн дагуу агнуурын амьтныг агнах барих үйл ажиллагааг ..... гэнэ.

а. Ан
б. Агнуур
в. Амьтан барих
г. Ан агнуур

51. Жил бүрийн 12 дугаар сарын 01-ний өдрөөс дараа оны 8 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд ямар агнуурын амьтан агнах, барихыг хориглодог вэ?

а. Ойн буг
б. Хадны суусар
в. Нохой зээх
г. Бор гөрөөс

52. Жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны өдрөөс 1 дүгээр сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд агнахыг хориглосон амьтан алин вэ?
а. Халздай дорго
б. Ойн буг
в. Бор гөрөөс
г. Хадны суусар

53. Агнуурын амьтан айлгах, барихад хориглох арга, зэвсэг хэрэгсэлд хамаарахыг дугуйл.
а. Химийн болон тэсэрч дэлбэрэх бодис тэсэлгээний хэрэгсэл ашиглах
б. Агнуурын амьтны жим дээр нүх ухах, буу сойх занг, сайл тавих
в. Туурайтан амьтныг айлгахад хавх тавих
г. Бүгд зөв

54. Хууль болон гэрээнд өөрөөр заагаагүй бол төлбөрийг бүрэн төлж ан агнах, барих эрхийн бичиг гэрээнд тусгай зөвшөөрөл заасан тоо хэмжээнд багтаан бэлтгэсэн амьтны түүхий эд бэлтгэгч тэдгээрийн .....болно.
а. Өмч
б. Эзэмшилт
в. Ашиглах хэлбэр
г. Бүгд буруу

55. Амьтныг эрдэм шинжилгээний ажил, соёл урлаг, гоо зүйн зориулалтаар ашиглаж болох уу?
а. Болно зарим тохиолдолд
б. Хуульд энэ талаар заагаагүй
в. Хуульд болохгүй гэж заасан
г. Болно

56. Амьтан ашиглах хэлбэрт хамаарахыг ол.
а. Эрдэм шинжилгээний ажил, соёл урлаг, гоо зүйн зориулалтаар ашиглах
б. Хөрс бүрдүүлэх, байгалийг ариутгах, ургамалд тоос хүртээх зэрэг амьдралын үйл ажиллагааны хэрэгтэй чанарыг ашиглах
в. Амьдралын үйл ажиллагааны бүтээгдэхүүнийг авах зорилгоор ашиглах
г. Дээрх бүгд

57. Амьтан ашиглах зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэлд аль нь хамаарахгүй вэ?
а. Амьтан ашиглах шаардлагагүй болсон буюу түүнийг ашиглахаас татгалзсан
б. Амьтан ашиглах эрх олгогдсон хуулийн этгээд татан буугдсан
в. Ан хийх агнуурын бүс нутгаа сум, дүүргийн байгаль хамгаалагчаар заалгасан байх
г. Хууль тогтоомжид заасан төлбөр, хураамжийг төлөөгүй

58. Агнуурын амьтны сан нь ..... .
а. Агнуурын амьтны байршил нутагт агнуурын амьтан амьдрах нөхцөл бүрдсэн газар, ой, ус хамаарна
б. Монгол Улсын нутаг дэвсгэр дэх унаган, нутагшсан буюу нүүдлийн агнуурын хөхтөн амьтан, шувуу, загаснаас бүрдэнэ

в. Арьс, үс, мах болон бусад түүхий эдийг нь ашиглахаар агнаж ирсэн уламжлалтай, агнуурын нөөцтэй амьтныг
г. Улсын хилийн гаднаас зориудаар болон санамсаргүй байдлаар зөөвөрлөгдөн ирж, нутагшиж байгаа амьтны зүйлийг

59. Агнуурын амьтны нөөцийг хамгаалах, тогтвортой ашиглах, ангийн гаралтай түүхий эд бэлтгэх зорилгоор агнуурын бүс нутгийн тодорхой хэсгийг гэрээний дагуу иргэн, хуулийн этгээдэд хэдэн жилээр эзэмшүүлэх вэ?
а. Эхний ээлжид 1 жилийн хугацаагаар, цаашид 10 жилийн давтамжтайгаар 30 хүртэл жилийн хугацаагаар байгуулна.
б. Эхний ээлжид 1 жилийн хугацаагаар, цаашид 10 жилийн давтамжтайгаар 20 хүртэл жилийн хугацаагаар байгуулна.
в. Эхний ээлжид 3 жилийн хугацаагаар, цаашид 10 жилийн давтамжтайгаар 30 хүртэл жилийн хугацаагаар байгуулна.
г. Эхний ээлжид 1 жилийн хугацаагаар, цаашид 5 жилийн давтамжтайгаар 30 хүртэл жилийн хугацаагаар байгуулна.

60. Агнуур зохион байгуулалтыг дараах байдлаар санхүүжүүлнэ.
а. Улсын төсвөөс
б. Иргэн өөрийн хөрөнгөөр
в. Иргэн, хуулийн этгээд гэрээгээр эзэмшиж, ашиглаж байгаа агнуурын бүс нутагтаа хийлгэх агнуур зохион байгуулалтын ажлын зардлыг өөрийн хөрөнгөөр
г. Аль нь биш

61. Агнуурын амьтныг дараах зориулалтаар агнаж, барина.
а. Үйлдвэрлэлийн, ахуйн, тусгай
б. Үйлдвэрлэлийн, тусгай
в. Ахуйн, тусгай, хувийн ашиг сонирхлоор
г. Хувийн ашиг сонирхлоор, үйлдвэрлэлийн, тусгай

62. Агнуурын амьтан агнах, барих гэрээ, эрхийн бичиг, тусгай зөвшөөрлийн загварыг хэн батлах вэ?
а. Сум дүүргийн засаг дарга
б. Төрийн захиргааны төв байгууллага
в. Сум дахь байгаль хамгаалагч
г. А ба В

63. Тухайн жилд тусгай зориулалтаар агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээг төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн ..... батална.
а. Төрийн захиргааны төв байгууллага
б. Сум дүүргийн засаг дарга
в. УИХ
г. Засгийн газар

64. Ахуйн зориулалтаар агнуурын амьтныг агнах, барих нэг удаагийн эрхийн бичгийг Монгол Улсын иргэнд дор дурдсан хугацаагаар олгоно.
а. Шувуу, тарвага агнаж, загас барихад 3 хүртэл хоног
б. Шувуу, тарвага агнаж, битүү туурайтан, загас барихад 5 хүртэл хоног
в. Загас барих, үслэг ан, шувуу 5-7 хоног
г. Тарвага 5 хоног

65. Монгол Улсад түр буюу байнга оршин суугаа гадаадын иргэн Монгол Улсын иргэний адил хэмжээний төлбөр төлж, ахуйн зориулалтаар зөвхөн ..... барьж болно.

а. Шувуу, загас
б. Тарвага
в. Загас
г. Тарвага, шувуу

66. Иргэн нэг удаагийн эрхийн бичгээр хэдэн тарвага агнаж болох вэ?

а. 3 б. 7 в.2 г.5

67. Анчны үнэмлэхийг хэнд олгох вэ?

а. Амьтны амьдрал, биологи, агнуурын уламжлалт соёлын талаар мэдлэгтэй иргэнд олгоно
б. Агнуурын амьтны амьдрал, биологи, агнуурын уламжлалт соёлын талаар мэдлэгтэй, ан агнах, барих арга зүй эзэмшсэн, түүнтэй холбогдсон шалгуурыг хангасан иргэнд олгоно
в. Агнуурын амьтныг ан агнах, барих арга зүй эзэмшсэн, түүнтэй холбогдсон шалгуурыг хангасан иргэнд олгоно
г. Агнуурын зөвшөөрөл хүсэгчид олгоно

68. Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээг хэн тогтоох вэ?

а. Засгийн газар саналыг үндэслэн УИХ тогтооно
б. Сум дүүргийн засаг даргын саналыг үндэслэн Төрийн захиргааны төв байгууллага тогтооно
в. Төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно
г. Засгийн газар дангаар

69. Амьтны нөөцийг хамгаалах зорилго бүхий төрийн бус байгууллага агнуурын нөөцийг хамгаалах талаар дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ (илүүцийг ол).

а. Агнуурын нөөцийг хамгаалах, тогтвортой ашиглах, өсгөн үржүүлэх талаар хуулийн этгээдэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт, сурталчилгаа явуулах, төсөл, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх
б. Амьтныг хайрлах ёс зүй, зан заншил, үндэсний уламжлал, хууль тогтоомжийг сурталчлах
в. Агнуурын нөөцийг хамгаалах, тогтвортой ашиглах, өсгөн үржүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах, ан агнуурын менежментийн төлөвлөгөө боловсруулахад нөхөрлөл, хуулийн этгээдэд дэмжлэг үзүүлэх
г. Амьтны тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, шаардлагатай тохиолдолд асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх

70. Амьтны цуглуулгад ..... хамаарна.

а. Амьтны арьс, үс, чихмэл, яс болон амьтны гаралтай бусад зүйл
б. Эрдэм шинжилгээ, танин мэдэхүйн зорилгоор барьсан амьтан, тэдгээрийн чихмэл, арьс, үс, яс болон амьтны гаралтай бусад зүйлс
в. Эрдэм шинжилгээ, танин мэдэхүйн зорилгоор барьсан амьтан, тэдгээрийн чихмэл
г. Амьтан, тэдгээрийн чихмэл, арьс, үс, яс болон амьтны гаралтай бусад зүйлс

71. Ургамал ашиглах зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага ямар хуульд заасан журмын дагуу шийдвэрлэдэг вэ?

а. Байгалийн ургамлын тухай хууль
б. Зөвшөөрлийн тухай хууль
в. Байгаль орчныг хамгаалах тухай хууль

72. Эрх бүхий байгууллагаас авсан ургамал ашиглах зөвшөөрөл бүхий эрхийн бичгээ бусдад ашиглуулж болох уу?
а. Ургамал ашиглах зөвшөөрлийн эрхийн бичиг авсан бол хэн ашиглах нь хамаагүй
б. Ургамал ашиглах эрхийн бичгийг бусдад шилжүүлэн ашиглуулж болохгүй

73. Ургамал ашиглах зөвшөөрлийг хэд хоногийн хугацаатай, хэдэн удаа сунгахаар олгодог вэ?
а. 60 хоногийн хугацаатай олгож 1 удаа анх олгосон хугацаагаар сунгах
б. 30 хоногийн хугацаатай олгож 2 удаа анх олгосон хугацаагаар сунгах
в. 30 хоногийн хугацаатай олгож 1 удаа анх олгосон хугацаагаар сунгах

74. Ургамлыг түүж бэлтгэх, улсын хилээр нэвтрүүлэх журам, хэмжээ, хугацааг мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн .....тогтооно.
а. Төрийн захиргааны төв байгууллага
б. Засгийн газрын гишүүд
в. Сум, дүүргийн Засаг дарга

75. Ховор ургамалд ..... хамаарна.
а. байгалийн жамаар нөхөн сэргэх чадваргүй, тархац нэн хязгаарлагдмал, ашиглах нөөцгүй, устах аюулд орсон ургамал
б. байгалийн жамаар нөхөн сэргэх чадвар хязгаарлагдмал, тархац, нөөц багатай, устаж болзошгүй ургамал
г. байгалийн жамаар нөхөн сэргэх чадваргүй ургамал

76. Нэн ховор ургамлыг ахуйн хэрэгцээнд ашиглаж болох уу?
а. Нэн ховор ургамал ашиглах зөвшөөрлийн эрхийн бичигтэй бол ахуйн хэрэгцээнд ашиглаж болно
б. Нэн ховор ургамлыг судалгаа шинжилгээний зорилгоор ашиглах тул болохгүй
в. Нэн ховор ургамлыг ашиглахыг хориглоно

77. Байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах ач холбогдолтой нутаг дэвсгэрт нэгэн малчин мал тэжээх зориулалтаар ашиглахыг хориглосон бэлчээр гэдгийг мэдсээр байсан ч мал нь бэлчих газаргүй байсан тул малаа бэлчээсэн тухай гомдол ирсэн. Энэ тохиолдолд ямар арга хэмжээ авах вэ?
а. Зөрчлийн хэрэг үүсгэнэ
б. Хэрэгцээтэй газар тул тохиролцоно
в. Шалгах шаардлагагүй

78. Харь ургамлыг байгальд тарималжуулахад .....талбайг ашиглана.
а. Хөрсний элэгдлээс хамгаалах зурвас газар
б. Зориулалтын хязгаарлаж битүүмжилсэн
в. Гол, горхины эх болон нуур, цөөрмийн эргээс 2 км-ийн доторх газар

79. Ахуйн зориулалтаар ашиглахаар түүсэн ургамлаа үйлдвэрт үйлдвэрлэлийн түүхий эд болгохоор өгч болох уу?
а. Ургамал ашиглах зөвшөөрлийн бичигтэй бол болно

б. Ахуйн зориулалтаар ашиглахаар түүж бэлтгэсэн ургамлыг үйлдвэрлэлийн түүхий эд болгон ашигласан нь хууль бус
в. Гэрээ байгуулсан бол болно

80. Хөнөөлт организм гэж ..... ойлгоно.
а. Монгол Улсын нутаг дэвсгэрт илрээгүй боловч хил дамнан орж ирж аюул учруулж болзошгүй, эсхүл илэрсэн ч өргөн тархаагүй, эрсдэл, нөлөөллийг бууруулах арга нь тодорхой, эрсдэлийн шинжилгээгээр эдийн засгийн хохирол учруулж болзошгүй нь тогтоогдсон хөнөөлт организмыг
б. ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүнд хөнөөл учруулдаг ургамал, амьтны, эсхүл эмгэг төрүүлэгчийн аливаа зүйл, омог, биологийн төрөл, зүйлийг
в. Монгол Улсын нутаг дэвсгэрт өргөн тархсан, урьдчилан сэргийлэх, тэмцэх арга нь тодорхой, эрсдэлийн шинжилгээгээр эдийн засгийн хохирол багатай нь тогтоогдсон хөнөөлт организмыг

81. ..... ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран хөнөөлт организмын төрөл, зүйлээс хамааран хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрийн зааг, орох, гарах хяналтын цэг, дамжин өнгөрөх зурвасын чиглэлийг тогтоож, анхааруулсан тэмдэг байршуулна.
а. Байгаль орчны яам
б. Засгийн газар
в. Аймаг, нийслэлийн Засаг дарга

82. Хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт тухайн шатны Засаг дарга дараах арга хэмжээг зохион байгуулна:
а. хорио цээртэй хөнөөлт организмын төрөл, зүйлийг тодорхойлох, голомт, тархалтыг тогтоох, хязгаарлах, устгах, хорио цээр тогтоосон нутаг дэвсгэр, орох, гарах хяналтын цэг, хорио цээртэй хөнөөлт организм илэрсэн байгууламжид хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын хяналтын доор мэргэжлийн байгууллагаар ариутгал, халдваргүйжүүлэлт, устгалыг хийлгэх
б. хорио цээр тогтоосон нутаг дэвсгэр, орох, гарах хяналтын цэг, хорио цээртэй хөнөөлт организм илэрсэн байгууламжид хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын хяналтын доор мэргэжлийн байгууллагаар ариутгал, устгалыг хийлгэх
в. хорио цээртэй хөнөөлт организмын төрөл, зүйлийг тодорхойлох, тархалтыг тогтоох, устгах хорио цээртэй хөнөөлт организм илэрсэн байгууламжид хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын хяналтын доор мэргэжлийн байгууллагаар ариутгал, халдваргүйжүүлэлт, устгалыг хийлгэх

83. Ургамал хамгаалах бүтээгдэхүүн ..... технологи, стандартыг зөрчсөн, эсхүл зориулалтын бусаар ашигласан бол Зөрчлийн тухай хуулиар торгуулна.
а. Үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, худалдаалах, хэрэглэх заавар
в. Үйлдвэрлэх, тээвэрлэх, худалдаалах
г. Хадгалах, тээвэрлэх, худалдаалах, хэрэглэх заавар, ашиглах

84. Ашиглаж, эзэмшиж байгаа, өмчилсөн газарт нь ургамлын хөнөөлт организм илэрвэл яах вэ?
а. Холбогдох байгууллагад мэдэгдэх
б. Өөр газарт тархахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг шуурхай авах, холбогдох байгууллагад мэдэгдэх
в. Өөрийн өмчилсөн газар илэрвэл аюул учирч болзошгүй тул шууд устгалд оруулна

85. Ургамал, түүнээс гаралтай түүхий эдийг тээвэрлэх, борлуулахдаа хаанаас бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ авах вэ?

а. Тухайн сум, дүүргийн Засаг даргын Тамгын газраас
б. Ургамал хамгаалал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас
в. Засгийн газрын гишүүдээс

86. Ямар тохиолдлоос бусад тохиолдолд хөнөөлт организмыг Монгол Улсын нутаг дэвсгэрт нэвтрүүлсэн, нүүлгэн шилжүүлсэн, хадгалсан, үржүүлсэн, тараасан бол зөрчлийн хэрэг үүсгэх вэ?

а. Сургалтын зорилгоор сорт сонгох, бүтээхэд ашиглахаас бусад тохиолдолд
б. Сургалтын зорилгоор сорт сонгохоос бусад тохиолдолд
в. Албан ёсны сорилт, туршилт, шинжлэх ухаан, сургалтын зорилгоор сорт сонгох, бүтээхэд ашиглахаас бусад тохиолдолд

87. Монгол Улсын нутаг дэвсгэрийн хуурай газар, усны бүх зүйлийн гуурст ургамал, хөвд, замаг, хаг, мөөг болон бичил биетнээс ..... бүрдэнэ.

а. Ургамлын нөөц
б. Ургамлын сан
в. Ургамал
г. Байгаль орчин

88. Ургамлыг түүний нөөц, нөхөн сэргэх чадварыг нь харгалзан дараах байдлаар ангилна. Илүүцийг ол.

а. Элбэг
б. Ховор
в. Нэн ховор
г. Илүүц зүйл байхгүй

89. Ургамлыг хөнөөлт организм, хими, биологийн бодисын хортой нөлөөллөөс хамгаалах, хорио цээр тогтоох ажлыг хэн хийж гүйцэтгэх вэ?

а. Нийслэлийн Засаг дарга
б. Сум, дүүргийн Засаг дарга
в. Баг, хорооны Засаг дарга
г. Иргэдийн төлөөлөгчдийн хурал

90. Нэн ховор ургамал бүхий газрыг ямар зориулалтаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэхийг зөвшөөрөх вэ?

а. Эдийн засгийн аюулгүй байдлыг хамгаалах
б. Ургамал хамгаалах
в. Тухайн ургамал хамгаалах болон нөхөн сэргээх
г. Ургамлын эрүүл мэндийг хамгаалах

91. Байгаль орчны тэнцлийг хангах ач холбогдол бүхий дараах газар нутагт ургамлыг нөөцийнх нь хэмжээг үл харгалзан үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахыг хориглох дараах газруудаас илүүцийг ол.

а. Хот, тосгон, бусад суурины ногоон бүс
б. ол, горхины эх болон нуур, цөөрмийн эргээс 2 километрийн доторх газар
в. Баянбүрд
г. Дээрх бүгд

92. Ургамлыг түүж бэлтгэх журам зөрчсөн, эсхүл ахуйн зориулалтаар ашиглахаар түүж бэлтгэсэн ургамлыг үйлдвэрлэлийн түүхий эд болгон ашигласан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг …….. нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

а. Нэг мянга
б. Хоёр мянга
в. Нэг зуу
г. Хоёр зуу

93. Ургамал хамгаалах бүтээгдэхүүнээс илүүцийг ол.

а. Үйлдвэрлэх
б. Хадгалах
в. Тээвэрлэх
г. Зөөвөрлөх

94. Ургамал, түүнээс гаралтай түүхий эдийг тээвэрлэх, борлуулахдаа хэнээс зөвшөөрөл авах вэ?

а. Тухайн сум орон нутгийн Тамгын газар
б. Тухайн сум орон нутгийн Засаг дарга
в. Тухайн сум орон нутгийн ИТХ-ын дарга

95. Хөнөөлт организмыг Монгол Улсын нутаг дэвсгэрт ямар зорилгоор нэвтрүүлэх, нүүлгэн шилжүүлэх, хадгалах, үржүүлэхийг зөвшөөрдөг вэ?

а. Албан ёсны сорилт
б. Туршилт
в. Шинжлэх ухаан, сургалтын зорилгоор
г. Бүгд зөв

96. Ургамлыг түүний нөөц, нөхөн сэргэх чадварыг нь харгалзан хэд ангилдаг вэ?

а. 3 б. 2 в. 4 г. 5

97. Ургамлыг хамгаалах үйл ажиллагааны удирдлагыг ямар хуулиар зохицуулах вэ?

а. Байгаль ургамлыг хамгаалах тухай хууль
б. Байгаль орчны тухай хууль
в. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль

98. Ургамлыг гал түймэр, хөнөөлт организмаас болон хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс хамгаалах ажлыг хэн хийж гүйцэтгэх ёстой вэ?

а. Сум, дүүргийн Засаг дарга
б. Сум, дүүргийн ИТХ
в. Гэрээний дагуу газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага
г. А болон С хариулт зөв

99. Нэн ховор ургамал бүхий газрыг ямар зориулалтаар эзэмшүүлэхийг зөвшөөрдөг вэ?

а. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага газар нэн ховор ургамлын үйлдвэрлэл явуулах зориулалтаар
б. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нэн ховор ургамал бүхий газрыг тухайн ургамал хамгаалах, нөхөн сэргээх зориулалтаар
в. Бүгд зөв

100. Ургамлын экологи-эдийн засгийн үнэлгээг ямар байгууллага тогтоох вэ?
а. Харьяа дүүрэг, сумын Тамгын газар
б. Төрийн захиргааны төв байгууллага
в. Бүгд зөв

101. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ургамлыг нь үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан газраа зохих журмын дагуу өөрийн хөрөнгөөр нөхөн сэргээх буюу нөхөн сэргэх нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй юу?
а. Үүрэгтэй
б. Үүрэггүй

102. Иргэн ховор ургамлыг өөрийн ам бүлийн хүнсний болон ахуйн бусад хэрэгцээг хангах зорилгоор ашиглаж болох уу?
а. Болно
б. Сум, дүүргийн Засаг даргын зөвшөөрлөөр ашиглаж болно
в. Болохгүй

103. Ургамлыг ашиглах зөвшөөрлийг эрхийн бичгээр олгоно. Эрхийн бичгийг бусдад шилжүүлэн ашиглуулахыг зөвшөөрөх үү?
а. Хориглоно
б. Зөвшөөрнө

104. Ургамлыг хөнөөлт организм, хими, биологийн бодисын хортой нөлөөллөөс хамгаалах, хорио цээр тогтоох ажлыг хэн хийж гүйцэтгэх вэ?
а. Нийслэлийн Засаг дарга
б. Сум, дүүргийн Засаг дарга
в. Баг, хорооны Засаг дарга
г. Иргэдийн төлөөлөгчдийн хурал

105. “....." гэж хүний оролцоогүйгээр байгалийн жамаар ургаж байгаа зүйл ургамлыг ойлгоно.
а. Байгалийн ургамал
б. Байгалийн ургамлын нөөц
в. Байгалийн ургамлыг тарималжуулах
г. Харь ургамал

106. "....." гэж тухайн зүйл ургамлын тархац нутаг дахь нийт хэмжээг ойлгоно.
а. Байгалийн ургамал
б. Байгалийн ургамлын нөөц
в. Байгалийн ургамлыг тарималжуулах
г. Харь ургамал

107. “....." гэж тухайн зүйл ургамлын тархац нутаг, нөөцийн хэмжээг тогтоох зорилгоор хийгдэж байгаа судалгааг ойлгоно.
а. Байгалийн ургамал
б. Байгалийн ургамлын нөөц
в. Байгалийн ургамлыг тарималжуулах
г. Байгалийн ургамлын тархац, нөөцийн судалгаа

108. “....." гэж байгалийн ургамлыг хамгаалах, удмын санг хадгалах, түүхий эд болгон ашиглах зорилгоор тарьж ургуулах, үржүүлэх ажиллагааг ойлгоно.

а. Байгалийн ургамал
б. Байгалийн ургамлын нөөц
в. Байгалийн ургамлыг тарималжуулах
г. Харь ургамал

109. “....." гэж тухайн зүйл ургамлын оршин амьдрах нөхцөл болон экологийн, эдийн засгийн, эрх зүйн, нийгмийн ач холбогдлоор нь үнэлсэн тусгай аргачлалын дагуу тооцсон нэгж жингийн мөнгөн үнэлгээг ойлгоно.

а. Байгалийн ургамал
б. Байгалийн ургамлын нөөц
в. Байгалийн ургамлыг тарималжуулах
г. Ургамлын экологи- эдийн засгийн үнэлгээ

110. “....." гэж улсын хилийн гаднаас зориудаар болон санамсаргүй байдлаар зөөвөрлөгдөн ирж, нутагшиж байгаа зүйл ургамлыг ойлгоно.

а. Байгалийн ургамал
б. Байгалийн ургамлын нөөц
в. Байгалийн ургамлыг тарималжуулах
г. Харь ургамал

111. Ургамлын нөөцийн мэдээллийн сан ямар үзүүлэлтээс бүрдэх вэ?

а. Ургамлын тархац, нөөцийн хэмжээ, түүний үнэлгээ
б. Ургамлын хатаамал, бэлдмэл, үрийн цуглуулга
в. Ургамлын судалгааны тайлан, мэдээ баримт
г. Дээрх бүгд

112. Ургамал ашиглагч нь дараах үүрэгтэй байна.

а. Ургамлын тухай хууль тогтоомжийг биелүүлэх
б. Ургамлыг түүж бэлтгэх, нөхөн сэргээх журмыг баримтлах
в. Журам, зөвшөөрөлд заасан хэмжээ, хугацаанд ургамлыг түүж бэлтгэх
г. Дээрх бүгд

113. Ургамал ашиглах зорилгоор түүний тархац газрыг эзэмшиж, ашиглах тухай гэрээнд дараах зүйлийг тусгана.

а. Тухайн газарт ашиглах ургамлын нэр, ашиглах хэмжээ
б. Ургамлыг ашиглах нөхцөл, болзол
в. Гэрээ байгуулагч талуудын тухайн ургамлыг ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхтэй холбогдсон эрх, үүрэг, хариуцлага
г. Дээрх бүгд

114. Ховор ургамалд байгалийн жамаар нөхөн сэргэх чадвар хязгаарлагдмал, тархац, нөөц багатай, устаж болзошгүй ургамал хамаарна. Ховор ургамлын жагсаалтыг хэн батлах вэ?

а. Засгийн газар
б. УИХ
в. Ерөнхийлөгч
г. Аль нь ч биш

115. Ойд ургаж буй жимс, мөөгийг хэн нэгний зөвшөөрөлгүйгээр түүж ашиглаж болох уу?
а. Ойн дагалт баялаг тул эрх бүхий этгээдээс зөвшөөрөл авна.
б. Ойд ургаж буй байгалийн баялаг тул хамаагүй

116. Гэрээний дагуу эзэмшиж байгаа ойн сангийн тодорхой хэсгийг ой, хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээг ..... хэрэгжүүлнэ.
а. Улсын төсвөөр
б. Өөрийн хөрөнгөөр

117. Ойг хамгаалах арга хэмжээ аваагүй ямар нэгэн хохирол учирсан тохиолдолд зөрчлийн хэрэгт холбогдоно гэж заасан байна. Ойг хамгаалах арга хэмжээнд юу юу ордог вэ?
а. Мод тайрах, ой хээрийн түймэр
б. Өвчнөөс сэргийлэх, хөнөөлт шавж
в. Ой хээрийн түймэр, хөнөөлт шавж, өвчнөөс сэргийлэх

118. Зохих зөвшөөрөлтэйгөөр мод бэлтгэсний дараа мод бэлтгэсэн талбайгаа цэвэрлэх шаардлагатай юу?
а. Мод бэлтгэх зөвшөөрөл зохих хугацаа хэмжээгээр модоо бэлтгэснээр дуусгавар болох тул шаардлагагүй
б. Мод бэлтгэсэн талбайгаа цэвэрлээгүй бол зөрчлийн хэрэг үүсэх тул цэвэрлэх шаардлагатай

119. Ойн тухай хуулийн бүрдэл актуудаас зөвийг нь сонгоно уу ?
а. Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон эдгээрт нийцүүлэн гаргасан бусад хууль
б. Монгол Улсын Үндсэн хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль болон эдгээрт нийцүүлэн гаргасан бусад хууль
в. Ой модны тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль
г. Байгаль орчныг хамгаалах тухай хууль

120. ..... гэж урьд өмнө нь ой байгаагүй газарт таримал ой ургуулахыг хэлнэ.
а. Ойн үржүүлэг
б. Ойн тарилт
в. Ойн тархац
г. Ойн нэмэлт

121. Ойн тухай хуульд тусгагдсан “түймрийн аюултай үеийг” тодорхойлно уу.
а. Жил бүрийн 4 дүгээр сарын 20-ны өдрөөс 8 дугаар сарын 20-ны өдөр хүртэлх хугацаа
б. Жил бүрийн 3 дугаар 20-ны өдрөөс 6 дугаар сарын 10-ны өдөр, 9 дүгээр сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 10-ны өдөр хүртэлх хугацаа
в. Жил бүрийн 4 дүгээр сарын 06-ны өдрөөс 11 дүгээр сарын 01 өдөр хүртэлх хугацаа
г. Тийм үе байдаггүй бөгөөд хуурайшилттай үед л түймэр гардаг

122. Ой зохион байгуулалтын ажлыг хэдэн жил тутамд хийх вэ?
а. 5 б. 10 в. 20 г. 25

123. Тусгай хамгаалалттай газар нутаг дахь ойн хамгаалалтын дэглэмийг ямар хуулиар зохицуулах вэ?
а. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар
б. Ойн тухай хуулиар

в. Газрын тухай хуулиар
г. Байгаль ургамлын тухай хуулиар

124. Ой хээрийн түймрийн аюултай үед ойд зорчих иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг ..... .
а. Хориглоно
б. Хязгаарлана
в. Хязгаарлалт тогтооно
г. Дээрх бүгд

125. Ой хээрийн түймрийн шалтгаан, эзэн холбогдогчийг ямар байгууллага тогтоох вэ?
а. Шүүх байгууллага
б. Цагдаагийн байгууллага
в. Ойг хамгаалах байгууллага
г. Захиргааны байгууллага

126. Иргэний үүрэг аль нь вэ?
а. Холбогдох байгууллагаас ойн нөөц, түүний хамгаалалт ашиглалтын талаар үнэн зөв мэдээлэл авах
б. Ойн нөхөрлөл байгуулах замаар оршин суугаа газрынхаа ойн санг эзэмших, хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ авах
в. Ойн тухай хууль тогтоомжийг сахин биелүүлэх
г. Дээрх бүгд

127. Галын аюултай бодис шатах, тослох материалыг хэрэглэх, тээвэрлэх хадгалах журам горимыг чанд мөрдөж ажиллах нь хэний үүрэг вэ?
а. Төрийн үүрэг
б. Аж ахуйн нэгж, байгууллага
в. Иргэний үүрэг
г. Засгийн газрын үүрэг

128. Ойн экологи-эдийн засгийн үнэлгээнд аль нь хамаарах вэ?
а. Ойн нөөцийн хэмжээ, чанар
б. Хэрэглээний экологи-эдийн засгийн үр өгөөжийг мөнгөн хэлбэрээр илэрхийлэх
в. Дээрх бүгдээр ойн экологи-эдийн засгийн үнэлгээг тогтооно

129. Ойг хамгаалах гэсэн ойлголтод аль нь хамаарах вэ?
а. Ой, хээрийн түймэр болон хөнөөлт шавж, өвчин зэрэг ойн төлөв байдлыг доройтуулах хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх
б. Ойн баялгийг жам ёсоороо нөхөн сэргэх боломжийг алдагдуулахгүйгээр ойн нөөцийн даацад тохируулан зохистой ашиглах
в. Нөхөн сэргээх, тэдгээрт хяналт тавьж гарсан зөрчлийг таслан зогсоох үйл ажиллагааг
г. Дээрх бүгд

130. “ ..... ” гэж мод, бут, сөөг болон бусад ургамал, хаг хөвд, амьтан, бичил биетэн шүтэлцэн орших хам бүрдлийн экологи-газарзүйн онцлог нөхцөл бүхий орчныг ойлгоно.
а. Ойн сан
б. Ой
в. Ойн нөөц
г. Ашиглах нөөц

131. Иргэн Г нь газар ашиглах үед үнэт чулуу олжээ. Найз нь зохих байгууллагад мэдэгдье гэхэд би мэдэгдчихнэ гээд чулууг авчээ. Гэвч Г нь үнэт чулууг мэдэгдэлгүй хадгалсан байжээ. Г-ийн энэ үйлдэл зөрчил мөн үү?

а. Зөрчил мөн
б. Зөрчил биш
в. Газар ашиглах үедээ олсон учир зөрчил биш

132. “Тулга” ХХК нь Орхон аймагт газрын хэвлийг ашиглах явцдаа эвдэрсэн газрыг аюул осолгүй болгож, цаашид ашиглаж болохуйцаар засаж тохижуулсан байжээ. Мөн ашиглаж байх явцад газраас илэрсэн соёлын үнэт зүйлийг улсад тушаахаар болжээ. Энэ нь зөрчил мөн үү?

а. Тийм б. Үгүй

133. Газрын хэвлийг яаж ашигласан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох юу?

а. Зөвшөөрөлгүй дур мэдэн
б. Зөвшөөрөлтэй
в. Тусгай зөвшөөрлөөр
г. Дур мэдэн

134. Ямар зориулалтаар газар доор барих барилга байгууламжийн зураг төсөл зохиох, тэдгээрийг барих, ашиглалтад оруулах талаар хуульд заасан шаардлагыг зөрчсөн хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох вэ?

а. Эрдэс түүхий эдийг боловсруулах
б. Газрын хэвлийг ашиглахаас өөр
в. Ашигт малтмал олборлохоос өөр
г. Ашигт малтмал ухах, олборлох

135. Ямар дүрэм, хэм хэмжээг зөрчсөн бол хүнийг гучин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох вэ?

а. Газрын хэвлийг ашиглах аюулгүй ажиллагааны дүрэм
б. Хэвлийг ашиглах аюулгүй ажиллагааны дүрэм
в. Газрын хэвлийг ашиглах ажиллагааны дүрэм
г. Газрын хэвлийг хамгаалах журам, дүрэм

136. Юуг гэмтээж сүйтгэсэн, баялаг хэсгийг нь сорчлон олборлосон, эсхүл ашигт малтмалын балансын нөөцийг зохистой ашиглах шаардлагыг зөрчсөн, олборлох үед ашигт малтмалын хаягдал, бохирдлыг тогтоосон хэм хэмжээнээс хэтрүүлсэн бол юуг хурааж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох вэ?

а. Ашигт малтмалыг/хууль бусаар олсон орлогыг
б. Ашигт малтмалын ордыг/олсон хөрөнгө, орлогыг
в. Ашигт малтмалын ордыг/ хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг
г. Ашигт малтмалыг/хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг

137. Газрын хэвлийг хамгаалах журам, түүнийг ашиглахад үүсэж болзошгүй аюул осол, хортой нөлөөнөөс юуг хамгаалах шаардлагыг биелүүлээгүй бол хүнийг гучин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор заасан бэ?

а. Ажиллагчдыг
б. Хүн ам болон малыг

в. Ан амьтныг, байгаль орчныг
г. Барилга байгууламжийг
д. а, б, г
е. Бүгд зөв

138. Газрын хэвлийд геологийн судалгаа хийх журам, шаардлагыг зөрчсөн нь ямар үр дагаварт хүргэх вэ?
а. Хайгуул хийсэн ашигт малтмалын нөөцийг буруу тодорхойлох
б. Хайгуул хийсэн ашигт малтмалын нөөцийг буруу үнэлэх
в. Ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барилга байгууламж барих нөхцөлийг буруу тодорхойлох
г. хайгуул хийсэн ашигт малтмалын нөөцийг буруу үнэлж,тодорхойлох
д. б болон в
е. а болон в

139. Газрын хэвлийг ашиглах үед илэрсэн үнэт металл, үнэт чулуу, шинжлэх ухаан, түүх, соёлын үнэт зүйлийг ..... мэдэгдээгүй бол ..... хурааж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно?
а. Зохих байгууллагад/хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг
б. Дэлхийн өвийн үндэсний хороо/хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг
в. Соёл, соёлын өвийн хэлтэст/олсон хөрөнгө, орлогыг
г. Зохих байгууллагад/хууль бусаар олсон орлогыг

140. Газрын хэвлийг ашиглах үед илэрсэн ашиглах үед илэрсэн үнэт металл, үнэт чулуу, шинжлэх ухаан, түүх, соёлын үнэт зүйлийг улсад тушаах хуульд заасан шаардлагыг биелүүлээгүй бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг хэдэн нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хэдэн нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэж заасан бэ?
а. Хүнийг дөрвөн тавин нэгжтэй тэнцэх/хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх
б. Хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх/хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх
в. Хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх/хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх
г. Хүнийг гурван мянган нэгжтэй тэнцэх/хуулийн этгээдийг гурван зуун нэгжтэй тэнцэх

141. Усны нөөцийн менежментийн төлөвлөгөө гэж юу вэ?
а. Сав газрын усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбогдсон үйл ажиллагааг нэгдмэл байдлаар зохицуулах баримт бичиг
б. Худаг, татах, цуглуулах, цэвэршүүлэх байгууламж, түгээх зориулалт бүхий усны барилга байгууламж
в. Бэлчээр, хадлан, тариаланг услах зорилгоор гадаргын болон газрын доорх ус хуримтлуулах, дамжуулах, хуваарилах, түгээх, илүүдэл усыг зайлуулах зориулалт бүхий усны барилга байгууламж, тоног төхөөрөмжийг багтаасан цогцолбор
г. Усны чанарын стандартад нийцэх эсэхийг илэрхийлэх физик, хими, биологийн цогц шинж чанар

142. Улсын усны мэдээллийн сан бүрдүүлэх үзүүлэлт, хөтлөх журмыг хэн батлах вэ?
а. Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална
б. Байгалийн усны нөөцийн дарга батална
в. Байгаль орчны дарга

143. Усны мэдээллийн сангийн мэдээлэлд үндэслэн улсын усны төлөв байдлын тайланг ямар хугацаанд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргадаг вэ?
а. Жил бүр
б. Улирал бүр
в. Сар бүр
г. Долоо хоногт

144. Усны сан бүхий газарт цацраг идэвхт болон химийн хорт бодис, халдвар үүсгэгч, хог хаягдал, хадгалах, машин техник, бохир зүйлс угааж болох уу?
а. Болно
б. Болохгүй

145. Усны тухай хуулийн Гуравдугаар бүлэгт юуг хуульчилсан вэ?
а. Усны нөөцийг хамгаалах, усан орчинг нөхөн сэргээх
б. Усны харилцааны талаарх төрийн болон бусад байгууллагын бүрэн эрх
в. Усны барилга байгууламж

146. Усны эх үүсвэр гэж ..... ойлгоно.
а. Ус хангамжийн эх үүсвэрт ашиглаж байгаа усны нөөц болон гол мөрний урсац бүрэлдэх эхийг
б. Монгол Улсын нутаг дэвсгэр дэх усны сан бүхий газарт байгаа гадаргын ус болон газрын доорх усыг
в. Усны сав газрын экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүйгээр тодорхой хугацаанд ашиглаж болох усны нөөцийн хэмжээг

147. Эрүүл ахуйн бүс гэж ..... ойлгоно.
а. Уусны сан бүхий газар, усны эх үүсвэр, рашааны ордыг хомсдох, бохирдохоос хамгаалах зорилгоор тогтоосон зурвас газрыг
б. Газрын гадарга, түүний хэвлийд бүрэлдэн тогтсон рашаан агуулж байгаа газрыг
в. Ус хангамжийн эх үүсвэр болон рашааны ордыг хамгаалах зорилгоор тогтоосон зурвас газрыг

148. Усны нөөц, түүний сав газрыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулах нь аль хуулийн зорилт вэ?
а. Байгаль орчныг хамгаалах тухай хууль
б. Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль
в. Усан замын тээврийн тухай хууль
г. Усны тухай хууль

149. Монгол Улсын нутаг дэвсгэр дэх усны сан бүхий газарт байгаа гадаргын ус болон газрын доорх усыг ..... гэнэ.
а. Усны сан бүхий газар
б. Усны эх үүсвэр
в. Усны нөөц

150. Баг, хорооны Засаг даргын бүрэн эрхийн илүүцийг сонгоно уу?
а. Нутаг дэвсгэртээ байгаа уст цэгийн ашиглалт, хамгаалалт, эзэмшилтэд хяналт тавих
б. Усны онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг сахиулах
в. Сав газрын менежментийн төлөвлөгөөний төсөл боловсруулах

г. Усны нөөцийг хомсдох, бохирдлоос хамгаалах, зохистой ашиглах, усны орчныг нөхөн сэргээх тухай хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын шийдвэрийн биелэлтийг нутаг дэвсгэртээ зохион байгуулж хангах

151. Сав газрын захиргааны бүрэн эрхэд хамаарах эрхийг сонгоно уу?
а. Нутаг дэвсгэртээ байгаа уст цэгийн ашиглалт, хамгаалалт, эзэмшилтэд хяналт тавих
б. Ус ашигласны болон бохирдуулсны төлбөрийг зохих хууль тогтоомжийн дагуу ногдуулах үндэслэлийг тодорхойлох
в. Усны нөөцийг хомсдох, бохирдлоос хамгаалах, зохистой ашиглах, усны орчныг нөхөн сэргээх тухай хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын шийдвэрийн биелэлтийг нутаг дэвсгэртээ зохион байгуулж хангах
г. Усны онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг сахиулах

152. Аймаг, нийслэлийн байгаль орчны албаны бүрэн эрхээс зөвийг дугуйл.
а. Усны тухай хууль тогтоомжийн биелэлтийн явцад хяналт тавьж, аймаг нийслэлийн засаг дарга, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнах
б. Усны нөөцийг хомсдох, бохирдлоос хамгаалах, зохистой ашиглах, усны орчныг нөхөн сэргээх тухай хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын шийдвэрийн биелэлтийг нутаг дэвсгэртээ зохион байгуулж хангах
в. Усны онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг сахиулах
г. Ус ашигласны болон бохирдуулсны төлбөрийг зохих хууль тогтоомжийн дагуу ногдуулах үндэслэлийг тодорхойлох

153. Сав газрын зөвлөл дараах эрхийг хэрэгжүүлнэ.
а. Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалт, эрүүл ахуйн бүсийн дэглэмийн мөрдөлтөд хяналт тавих
б. Орон нутагтаа ус, рашааныг хамгаалах, зохистой ашиглах нөхөн сэргээх арга хэмжээг сав газрын захиргаатай хамтран хэрэгжүүлэх
в. Усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, усан орчныг нөхөн сэргээх, ус хангамж, ариутгах татуургын болон хаягдал ус зайлуулах үйл ажиллагаанд хяналт тавих
г. Усны онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг сахиулах

154. Усны мэргэжлийн байгууллага нь дараах эрхийг гүйцэтгэнэ.
а. Усны сан бүхий газрын эргээс 50 метрээс доошгүй зайд болон гол мөрний тутамд онцгой хамгаалалтын бүс тогтооно
б. Усны нөөцийн хайгуул, судалгааны ажлыг эрхлэх мэргэжлийн байгууллагын эрхийг зөвхөн дотоодын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид олгоно
в. Усны нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах, үер усны гамшгаас сэргийлэх зорилгоор усны сан бүхий газар, усны эх үүсвэрт онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүс тогтооно
г. Дээрх бүгд зөв

155. Усны нөөцийг хамгаалах, усан орчныг нөхөн сэргээх эрхүүдээс зөвийг дугуйл.
а. Усны сан бүхий газрын эргээс 200 метрээс доошгүй зайд энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрээс 100 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн бүс тогтооно
б. Усны сан бүхий газрын эргээс 50 метрээс доошгүй зайд болон гол мөрний тутамд онцгой хамгаалалтын бүс тогтооно

в. Нийслэлийн ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс, тэжээгдлийн мужийн заагийг байгаль орчны болон газрын харилцааны асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн хамтран тогтооно
г. Дээрх бүгд зөв

156. Усны барилга байгууламж эзэмших, ашиглах эрхийг хэдэн жилийн хугацаагаар олгож сунгадаг вэ?
а. 3 б. 4 в. 5 г. 6

157. Усны аливаа барилга байгууламж нь ..... байна.
а. Эрх олгосон гэрчилгээ
б. Үүрэг хариуцлагатай
в. Паспорттай
г. Эрхийн бичигтэй

158. Усны нөөцийг хуримтлуулах, ашиглах, томоохон уул уурхайн үйлдвэрлэл эрхлэх болон далан, суваг барих төсөлд санал өгөх, ус хамгаалах, зохистой ашиглах шийдвэр гаргахад иргэдийн саналыг тусгуулах зэрэг нь алиныхан бүрэн эрхэд хамаарах вэ?
а. Засгийн газрын бүрэн эрх
б. Аймаг, нийслэлийн байгаль орчны албаны бүрэн эрх
в. Сум, дүүргийн байгаль хамгаалагчийн бүрэн эрх
г. Сав газрын зөвлөлийн бүрэн эрх

159. Усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, усан орчинг нөхөн сэргээх, ус хангамж, ариутгах татуургын болон хаягдал ус зайлуулах үйл ажиллагаанд хяналт тавих эрх нь ямар байгууллагын бүрэн эрхэд хамаарах вэ?
а. Засгийн газрын бүрэн эрх
б. Аймаг, нийслэлийн байгаль орчны албаны бүрэн эрх
в. Сум дүүргийн байгаль хамгаалагчийн бүрэн эрх
г. Сав газрын зөвлөлийн бүрэн эрх

160. Усны сан бүхий газрын эргээс 200 метрээс доошгүй зайд энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрээс хэдэн метрээс доошгүй зайд эрүүл ахуйн бүсийг тогтоодог вэ?
а. 50 б. 100 в. 150 г. 200

161. Хамгаалалтын бүс нь хориглолтын болон хязгаарлалтын бүсээс бүрдэх бөгөөд эрүүл ахуйн бүсийн эргэн тойронд хэдэн метрээс доошгүй зайд хориглолтын бүс тогтоодог вэ?
а. 50 б. 100 в. 150 г. 200

162. Рашааны орд, эх булгийн эргэн тойронд хэдэн метрийн зайнд эрүүл ахуйн бүсийг тогтоодог вэ?
а. 50 б. 100 в. 150 г. 200

163. Ус хэрэглэгч зөвшөөрөл авахдаа..... өргөдөл гаргана.
а. Аймаг, нийслэлийн байгаль орчны албанд
б. Аймаг, нийслэлийн засаг даргад
в. Аймаг, нийслэлийн усны сав бүхий газарт
г. Аль нь ч биш

164. Хаягдал ус хаях, зөвшөөрлийг хоногт 50 шоометрээс их, эсхүл аюултай бохирдуулах бодис агуулсан хаягдал ус гаргадаг ус бохирдуулагчид байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлтийг үндэслэн сав газрын захиргаа, хоногт 50 шоометрээс бага хаягдал ус гаргадаг ус бохирдуулагчид сав газрын захиргааны дүгнэлтийг үн дэслэн.....олгоно.

а. Сум, дүүргийн Засаг дарга
б. Аймаг, нийслэлийн засаг дарга
в. Иргэдийн төлөөлөгчийн хурал
г. Аль нь ч биш

165. …… бусдад худалдсан, эсхүл бусдад шилжүүлсэн, эсхүл усыг үйлдвэрлэлийн зориулалтаар зохих гэрээ, зөвшөөрөлгүйгээр, эсхүл гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашигласан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

а. Ус ашиглах зөвшөөрлийг
б. Ашигт малтмалын зөвшөөрлийг
в. Газрын тосны зөвшөөрлийг
г. Бусад зөвшөөрлийг

166. Усны эх үүсвэрийн бүсийг хэрхэн ангилдаг вэ?

а. Онцгой
б. Энгийн
в. Хамгаалалтын
г. Бүгд зөв

167. Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөө гэж юу вэ?

а. Тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хамгаалалт, нөхөн сэргээлт, зохистой ашиглалтыг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулан хэрэгжүүлэх үйл ажиллагааны дунд болон ойрын хугацааны төлөвлөгөө бүхий баримт бичиг
б. Дархан цаазат болон байгалийн цогцолборт газрын байгалийн хэв шинжийг төлөөлөх онцлог, ховор, нэн ховор амьтан, ургамал, түүх, соёлын дурсгалт зүйлийн байршлыг харгалзан тогтоосон өөр өөр хамгаалалтын дэглэм бүхий газар нутгийн хуваарь

168. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийг хэд ангилдаг вэ? нэрлэнэ үү.

а. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийг 3 ангилдаг. Дархан цаазат газар, байгалийн нөөц газар, дурсгалт газар
б. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийг 4 ангилдаг. Дархан цаазат газар, байгалийн цогцолборт газар, байгалийн нөөц газар, дурсгалт газар

169. Аль нь Дархан цаазат газар вэ?

а. Байгалийн бүс, бүслүүрийн онцлог, хэв шинжийг төлөөлж чадах унаган төрхөө хадгалсан байдал, шинжлэх ухааны онцгой ач холбогдлыг нь харгалзан байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах зорилгоор улсын тусгай хамгаалалтад авсан газар нутаг
б. Байгалийн унаган төрхөө харьцангуй хадгалсан, түүх, соёл, шинжлэх ухааны болон танин мэдэхүй, экологийн хүмүүжилд ач холбогдол бүхий улсын тусгай хамгаалалтад авсан газар нутаг

170. Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах зөвшөөрлийн хугацааг хэдэн жилээр тогтоож өгсөн бэ?

а. Нэг жилээс доошгүй байна
б. Таван жилээс доошгүй байна
в. Гурван жилээс доошгүй байна

171. Тусгай хамгаалалттай газар нутагт ..... үйл ажиллагаа явуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

а. Хуулиар хориглосон
б. Хориглосон
в. Дэглэм зөрчсөн
г. Горим зөрчсөн

172. ..... газар нутагт хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

а. Байгалийн өвөрмөц тогтоц бүхий газар
б. Дархан цаазат газарт
в. Иргэдийн хувийн өмчлөлийн газарт
г. Тусгай хамгаалалттай газар

173. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийг дараах байдлаар ангилна. Илүүцийг ол.

а. Дархан цаазат газар
б. Байгалийн цогцолборт газар
в. Дурсгалт газар
г. Үржил шимт газар

174. Байгалийн тодорхой хэв шинж, аль нэгэн нөөц, баялгийг хамгаалах, хадгалах, нөхөн сэргээх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг ..... гэнэ.

а. Дархан цаазат газар
б. Байгалийн нөөц газар
в. Дурсгалт газар
г. Байгалийн цогцолборт газар

175. Тусгай хамгаалалттай газар нутагт хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан нь ……. хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

а. Иргэний хуулиар хариуцлага
б. Захиргааны хуулиар хариуцлага
в. Эрүүгийн хариуцлага
г. Зөрчлийн хуулиар хариуцлага

Тестийн зөв хариулт

Нэгдүгээр бүлэг

1	2	3	4	5	6	7	8	9	10
г	б	б	в	в	б	а	а	в	в
11	12	13	14	15	16	17	18	19	20
в	г	б	в	б	а	б	а	в	в
21	22	23	24	25	26	27	28	29	30
г	а	б	а	в	а	в	в	а	г
31	32	33	34	35	36	37	38	39	40
г	а	г	г	б	а	б	в	а	а
41	42	43	44	45	46	47	48	49	50
б	в	а	г	а	г				

Хоёрдугаар бүлэг

1	2	3	4	5	6	7	8	9	10
г	а	г	а	а	г	А	а	в	г
11	12	13	14	15	16	17	18	19	20
а	а	а	г	а	г	Г	а	а	г
21	22	23	24	25	26	27	28	29	30
а	а	а	г	Б	в	В	б	в	а
31	32	33	34	35	36	37	38	39	40
г	б	а	г	г	а	б	г	а	а

Гуравдугаар бүлэг

1	2	3	4	5	6	7	8	9	10
в	а	а	в	г	а	б	г	в	а
11	12	13	14	15	16	17	18	19	20
б	г	а	в	г	а	г	б	б	б
21	22	23	24	25	26	27	28	29	30
а	а	б	а	г	б	г	а	в	г
31	32	33	34	35	36	37	38	39	40
б	в	в	г	а	б	г	г	а	а
41	42	43	44	45	46	47	48	49	50
г	г	в	а	б	б	в	а	б	г
51	52	53	54	55	56	57	58	59	60
г	а	г	а	г	г	в	б	а	в
61	62	63	64	65	66	67	68	69	70
а	б	г	а	в	г	б	в	а	б
71	72	73	74	75	76	77	78	79	80
б	б	в	а	б	а	а	б	б	б

81	82	83	84	85	86	87	88	89	90
в	а	а	б	а	в	б	г	б	в
91	92	93	94	95	96	97	98	99	100
г	в	г	а	г	а	а	г	б	в
101	102	103	104	105	106	107	108	109	110
а	б	а	б	а	б	г	в	г	г
111	112	113	114	115	116	117	118	119	120
г	г	г	а	а	б	в	б	а	а
121	122	123	124	125	126	127	128	129	130
б	б	а	а	б	в	б	в	г	б
131	132	133	134	135	136	137	138	139	140
а	б	г	б	а	в	д	б	а	г
141	142	143	144	145	146	147	148	149	150
а	а	а	б	а	а	в	г	в	в
151	152	153	154	155	156	157	158	159	160
б	а	а	б	г	в	в	г	б	б
161	162	163	164	165	166	167	168	169	170
г	б	а	а	а	г	а	б	а	б
171	172	173	174	175	176	177	178	179	180
а	г	г	б	в					

ХАВСРАЛТ



Хавсралт 1. Зөрчлийн тухай хуулийн Долдугаар бүлгийн Байгаль орчин, амьтан, ургамлыг хамгаалах журмын эсрэг зөрчил (7.1-7.18)-ийг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан, түүний харьяалал

Тайлбар: Зөрчлийн тухай хууль нь зүйл, хэсэг, заалтаас бүрдэнэ. Тухайлбал, Зөрчлийн тухай хуулийн 7.7 дугаар зүйл. Байгалийн ургамлын тухай хууль зөрчих (зүйл), 1. Зохих зөвшөөрөлгүйгээр, эсхүл зөвшөөрөлд заасан хугацаа, хэмжээ, ургамал түүж бэлтгэх журам зөрчиж (хэсэг), 1.1. байгалийн ховор ургамлыг ахуйн хэрэгцээнд (заалт) түүсэн, бэлтгэсэн, худалдсан бол хууль бусаар бэлтгэсэн эд зүйлийг хурааж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно г.м.

Зөрчлийн тухай хуулийн зүйл, хэсэг, заалт	Зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтан			
7.1 дүгээр зүйл.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль зөрчих 1.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэхгүйгээр, эсхүл зохих байгууллагын шийдвэр гаргуулахгүйгээр үйл ажиллагаа явуулсан бол хууль бус үйл ажиллагааг зогсоож, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.1	6.40. газар, геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагч 7.1 дүгээр зүйл		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
2.Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй ажилласан, эсхүл уг төлөвлөгөөг хэрэгжүүлээгүй, биелэлтийг тогтоосон хугацаанд гаргаж, холбогдох газарт тайлагнаагүй бол хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.1			~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
3.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тавигдсан шаардлагыг биелүүлээгүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.1			~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
4.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний шинжилгээ, хянан магадлагаагаар байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг буруу хийсэн нь тогтоогдсон бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.1			~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
7.2 дугаар зүйл.Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль зөрчих 1.Хуульд заасан: 1.1.хөрс хамгаалах	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.2			~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~

Зөрчлийн тухай хуулийн зүйл, хэсэг, заалт	Зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтан			
1.2.цөлжилтөөс сэргийлэх	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.2	6.40. газар, геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагч 7.2 дугаар зүйлийн 1.2, 1.3 дахь заалт		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
1.3.цөлжилттэй тэмцэх арга хэмжээний тухай журам зөрчсөн бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.2	6.40. газар, геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагч 7.2 дугаар зүйлийн 1.2, 1.3 дахь заалт		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
7.3 дугаар зүйл.Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль зөрчих 1.Монгол Улсын хуулиар ховор, нэн ховор амьтны жагсаалтад ороогүй боловч Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, эсхүл тэдгээрийн гаралтай эд зүйлийг зохих зөвшөөрөлгүйгээр улсын хилээр нэвтрүүлсэн бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.2. хилийн төлөөлөгч, орлогч, туслагч 7.3 дугаар зүйл	6.11. гаалийн улсын байцаагч 7.3 дугаар зүйл		
7.4 дүгээр зүйл.Агаарын тухай хууль зөрчих 1.Агаарын чанарт сөргөөр нөлөөлж байгаа өөрийн үйл ажиллагааны тухай мэдээлэл, озон задалдаг бодис, түүнийг орлуулах бусад бодис, тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмжийн импорт, үйлдвэрлэлийн тухай мэдээлэл, агаарын бохирдлын эх үүсвэрийн тухай мэдээлэл, агаарт гаргасан бохирдуулах бодисын агууламж, хаягдлын хэмжээ, дотоод хяналтын мэдээг: 1.1.тогтоосон хугацаанд мэдээлээгүй;	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.4	6.11. гаалийн улсын байцаагч 7.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
1.2.зориуд буруу мэдээлсэн; 1.3.нуун дарагдуулсан, эсхүл хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.				

Зөрчлийн тухай хуулийн зүйл, хэсэг, заалт	Зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтан			
2.Агаар бохирдуулах бодисын хаягдлын стандартаас хэтэрсэн бохирдуулах бодис гаргадаг, физикийн сөрөг нөлөөлөл үзүүлдэг тээврийн хэрэгсэл, эсхүл хөдөлгөөнт бусад эх үүсвэр ашиглан агаар бохирдуулсан бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.4			~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
3.Агаар хамгаалах талаар тавигдах шаардлага хангаагүй: 3.1.барилга байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглалтад оруулсан; 3.2.техник, технологи нэвтрүүлсэн бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.4			~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
4.Агаарт бохирдуулах бодис гаргах, физикийн сөрөг нөлөөлөл үзүүлэх талаар зөвшөөрөлд заасан хэмжээ, нөхцөл, шаардлагыг зөрчсөн бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.4			~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
5.Агаарт гаргах бохирдуулах бодис, физикийн сөрөг нөлөөллийг багасгах, цэвэрлэх, хянах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг ашиглах журам зөрчсөн бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.4			~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
6.Хүн амын оршин суугаа орчны агаарыг бохирдуулан хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх нөхцөлийг бүрдүүлсэн бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.4			~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
7.Бохирдуулах бодис гаргадаг, физикийн сөрөг нөлөөлөл үзүүлдэг эх үүсвэр ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж агаар бохирдуулсан бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. */Энэ хэсэгт 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./*	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.4			~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
8.Агаарын чанарыг сайжруулах бүсэд Монгол Улсын стандартаар тогтоосон экологийн хамгийн өндөр ангиллаас доош ангиллын, эсхүл уг ангиллын стандартын шаардлага хангаагүй автобензин, дизель түлшийг жижиглэнгээр худалдан борлуулсан бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно./*Энэ хэсгийг 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн./*	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.4			~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~

Зөрчлийн тухай хуулийн зүйл, хэсэг, заалт	Зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтан			
7.5 дугаар зүйл.Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль зөрчих 1.Агаар бохирдуулсны нөхөн төлбөрөө төлөөгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хорин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.12. татварын улсын байцаагч 7.5 дугаар зүйл,			
2.Агаарын бохирдлын эх үүсвэрийн тухай мэдээлэл, агаарт гаргасан бохирдуулах бодисын агууламж, хаягдлын хэмжээг: 2.1.нуун дарагдуулсан; 2.2.худал мэдээлэл өгсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.12. татварын улсын байцаагч 7.5 дугаар зүйл,			
7.6 дугаар зүйл.Амьтны тухай хууль зөрчих 1.Хугацаа дууссан гэрээ, зөвшөөрлөөр, эсхүл гэрээ, зөвшөөрөлгүйгээр амьтныг: 1.1.ашигласан; 1.2.барьсан; 1.3.агнасан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.6			~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
2.Амьтныг ашиглах, барих, агнах зөвшөөрлийг бусдад шилжүүлсэн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.6			~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
3.Ан агнах, загас барих гэрээ, тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийг бусдад шилжүүлсэн, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ан агнасан, барьсан, зохих гэрээ байгуулахгүйгээр үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнасан, барьсан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.6			~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~

Зөрчлийн тухай хуулийн зүйл, хэсэг, заалт	Зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтан			
4.Агнуурын бүс нутгаас бусад газарт, эсхүл амьтныг агнах хориотой үед, эсхүл хориглосон хугацаанд, эсхүл хориглосон арга хэрэгслээр амьтныг барьсан, агнасан, тээвэрлэсэн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно./*Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./*	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.6			~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
5.Агнуурын амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийн зүйлийг тусгай зөвшөөрөл, гарал үүслийн бичиг, дагалдах тодорхойлолтгүйгээр худалдсан, худалдан авсан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.6			~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
6.Амьтныг зөвшөөрөлгүйгээр нутагшуулсан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.6			~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
7.Харь амьтныг зөвшөөрөлгүйгээр нутагшуулсан, өсгөж үржүүлсэн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно./*Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./*	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.6			~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
8.Энэ зүйлийн 5 дахь хэсэгт зааснаас бусад амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг гарал үүслийн тодорхойлолтгүйгээр худалдсан, худалдан авсан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно./*Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн./*	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.6			~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~

Зөрчлийн тухай хуулийн зүйл, хэсэг, заалт	Зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтан			
9.Амьтны хүрээлэн ажиллуулахад тавигдах шаардлагыг зөрчсөн бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” */Энэ хэсгийг 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар нэмсэн./*	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.6	цагдаагийн байгууллагын эрх бүхий албан хаагч 7.6 дугаар зүйлийн 9 дэх хэсэг	6.44. мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч 7.6 дугаар зүйлийн 9 дэх хэсэг 6.59.эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын 7.6 дугаар зүйлийн 9 дэх хэсэг	~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
7.7 дугаар зүйл.Байгалийн ургамлын тухай хууль зөрчих 1.Зохих зөвшөөрөлгүйгээр, эсхүл зөвшөөрөлд заасан хугацаа, хэмжээ, ургамал түүж бэлтгэх журам зөрчиж: 1.1. байгалийн ховор ургамлыг ахуйн хэрэгцээнд; 1.2. элбэг ургамлыг үйлдвэрлэлийн түүхий эд болгон ашиглах, орлого олох зорилгоор түүсэн, бэлтгэсэн, худалдсан бол хууль бусаар бэлтгэсэн эд зүйлийг хураах хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. */Энэ заалтад 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./*	6.27. улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч 7.7 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.7		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
2.Байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах ач холбогдолтой нутаг дэвсгэр, бэлчээр, хадлангийн газар, мал тэжээх зориулалтаар ашиглахыг хориглосон газар үйлдвэрлэлийн зориулалтаар ургамал түүж бэлтгэсэн, эсхүл мал бэлчээсэн бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.27. улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч 7.7 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.7		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
3.Харь ургамлыг зөвшөөрөлгүйгээр байгальд тарималжуулсан, эсхүл гадаад улсаас оруулсан бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.11. гаалийн улсын байцаагч 7.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.7		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
4.Ургамлыг түүж бэлтгэх журам зөрчсөн, эсхүл ахуйн зориулалтаар ашиглахаар түүж бэлтгэсэн ургамлыг үйлдвэрлэлийн түүхий эд болгон ашигласан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хураах, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.		6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.7		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~

Зөрчлийн тухай хуулийн зүйл, хэсэг, заалт	Зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтан			
7.8 дугаар зүйл.Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль зөрчих */Энэ зүйлийн гарчигт 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./* 1.Ургамлын хөнөөлт организмтай тэмцэх технологи зөрчсөн бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно./*Энэ хэсэгт 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./*	6.48. ургамал хамгааллын хяналтын улсын байцаагч	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.8		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
2.Ургамлын хорио цээр тогтоосон үед баримтлах журмыг зөрчсөн бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно./*Энэ хэсэгт 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан*	6.48. ургамал хамгааллын хяналтын улсын байцаагч	6.27. улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч 7.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.8	~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
3.Ургамал хамгаалах бүтээгдэхүүн: */Энэ хэсэгт 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./* 3.1.үйлдвэрлэх; 3.2.хадгалах; 3.3.тээвэрлэх; 3.4.худалдаалах; */Энэ заалтад 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./*	6.48. ургамал хамгааллын хяналтын улсын байцаагч	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.8		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
3.5.хэрэглэх заавар, технологи, стандартыг зөрчсөн, эсхүл зориулалтын бусаар ашигласан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно./*Энэ заалтад 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./*				
4.Ашиглаж, эзэмшиж байгаа, өмчилсөн газарт нь ургамлын хөнөөлт организм илэрвэл өөр газарт тархахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг шуурхай авах, холбогдох байгууллагад мэдэгдэх хуульд заасан үүргээ биелүүлээгүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно./*Энэ хэсэгт 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./*	6.48. ургамал хамгааллын хяналтын улсын байцаагч	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.8		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~

Зөрчлийн тухай хуулийн зүйл, хэсэг, заалт	Зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтан			
5.Ургамал, түүнээс гаралтай түүхий эдийг тээвэрлэх, борлуулахдаа тухайн сум, дүүргийн Засаг даргын Тамгын газраас бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ аваагүй бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.48. ургамал хамгааллын хяналтын улсын байцаагч	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.8		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
6.Албан ёсны сорилт, туршилт, шинжлэх ухаан, сургалтын зорилгоор сорт сонгох, бүтээхэд ашиглахаас бусад тохиолдолд хөнөөлт организмыг Монгол Улсын нутаг дэвсгэрт нэвтрүүлсэн, нүүлгэн шилжүүлсэн, хадгалсан, үржүүлсэн, тараасан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно./*Энэ хэсгийг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн./* */Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн./*	6.48. ургамал хамгааллын хяналтын улсын байцаагч	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.8		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
7.9 дүгээр зүйл.Ойн тухай хууль зөрчих 1.Зөвшөөрөлгүйгээр ойн дагалт баялаг бэлтгэсэн бол зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. */Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./*	6.27. улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч 7.9 дүгээр зүйлийн 1, 3, 4, 5, 7, 8, 10, 11 дэх хэсэг	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.9		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
2.Гэрээний дагуу эзэмшүүлсэн ойг: 2.1.түүмэр; 2.2.хөнөөлт шавж; 2.3.өвчнөөс хамгаалах арга хэмжээ аваагүй бол учруулсан хохирол нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. */Энэ заалтад 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./*		6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.9		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
3.Зохих зөвшөөрөлтэйгээр мод бэлтгэсэн талбайгаа цэвэрлээгүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.27. улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч 7.9 дүгээр зүйлийн 1, 3, 4, 5, 7, 8, 10, 11 дэх хэсэг	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.9		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~

Зөрчлийн тухай хуулийн зүйл, хэсэг, заалт	Зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтан			
4.Мод бэлтгэх, эсхүл ойн дагалт нөөц ашиглахдаа технологийн горимыг зөрчсөн бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.27. улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч 7.9 дүгээр зүйлийн 1, 3, 4, 5, 7, 8, 10, 11 дэх хэсэг	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.9		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
5.Ойн сан бүхий газарт хориглосон үйл ажиллагаа явуулсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлого, зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгслийг хурааж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.27. улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч 7.9 дүгээр зүйлийн 1, 3, 4, 5, 7, 8, 10, 11 дэх хэсэг	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.9		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
6.Ойн дагалт нөөцийг менежментийн төлөвлөгөөнд туссан хэмжээнээс хэтрүүлэн ашигласан, бэлтгэсэн бол хэмжээнээс хэтрүүлэн бэлтгэсэн эд зүйлийг хурааж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. */Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./*		6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.9		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
7.Ойн сан бүхий газарт гал түймэртэй тэмцэх, түүнээс сэргийлэх талаар хуульд заасан шаардлагыг биелүүлээгүй бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.27. улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч 7.9 дүгээр зүйлийн 1, 3, 4, 5, 7, 8, 10, 11 дэх хэсэг	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.9		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
8.Түймрийн аюултай үед: 8.1.ой, хээрийн бүс нутагт өсвөр, залуу шилмүүст ой, шатсан ой, хуурай, унанги мод ихтэй ой, мод бэлтгэлийн хаягдал, үлдэгдлийг цэвэрлээгүй талбай, өвслөг ургамлын нөөц ихтэй газар, модны доор ил задгай гал түлсэн;	6.27. улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч 7.9 дүгээр зүйлийн 1, 3, 4, 5, 7, 8, 10, 11 дэх хэсэг	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.9		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
8.2.мод бэлтгэлийн талбайг цэвэрлэхдээ шатаах аргыг хэрэглэсэн;	6.27. улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч 7.9 дүгээр зүйлийн 1, 3, 4, 5, 7, 8, 10, 11 дэх хэсэг	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.9		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~

Зөрчлийн тухай хуулийн зүйл, хэсэг, заалт	Зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтан			
8.3.шатах, тослох материал шингээсэн цаас, даавуу, хөвөн, бусад зүйлийг зориулалтын бус газар ил хаясан;	6.27. улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч 7.9 дүгээр зүйлийн 1, 3, 4, 5, 7, 8, 10, 11 дэх хэсэг	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.9		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
8.4.тээврийн хэрэгсэл, бусад техникийг шатахуунаар цэнэглэх үед тамхи татах, цонх, хаалгаар нь шатах, дэлбэрэх аюул бүхий хог хаягдал, үнс, шүдэнз хаях, оч баригчгүй тээврийн хэрэгсэл ашигласан бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.27. улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч 7.9 дүгээр зүйлийн 1, 3, 4, 5, 7, 8, 10, 11 дэх хэсэг	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.9		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
9.Гэрээний дагуу ашиглалт явуулж байгаа газарт түймэр унтраах багаж, хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжийг тогтоосон норм, нормативын дагуу бүрдүүлээгүй, эсхүл түймэр гарсан үед тэдгээрийг ашиглахад бэлэн байлгаагүй бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.17. гал түймрийн улсын хяналтын байцаагч 7.9 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.9		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
10.Ойн тухай хуулиар тогтоосон шаардлагыг биелүүлээгүй бол учруулсан хохирол нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. */Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./*	6.27. улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч 7.9 дүгээр зүйлийн 1, 3, 4, 5, 7, 8, 10, 11 дэх хэсэг	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.9		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
11.Гэрээ байгуулахгүйгээр ойгоос мод бэлтгэсэн, эсхүл гэрээний нөхцөл, болзлыг зөрчин үйл ажиллагаа явуулсан бол хууль бусаар бэлтгэсэн зүйл, олсон орлогыг хураах хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.27. улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч 7.9 дүгээр зүйлийн 1, 3, 4, 5, 7, 8, 10, 11 дэх хэсэг	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.9		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
7.10 дугаар зүйл.Газрын хэвлийн тухай хууль зөрчих 1.Газрын хэвлийг дур мэдэн ашигласан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хураах хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.12. татварын улсын байцаагч 7.10	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.10 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7 дахь хэсэг	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч 7.10 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 5.1 дэх заалт, 8 дахь хэсэг	~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~

Зөрчлийн тухай хуулийн зүйл, хэсэг, заалт	Зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтан			
2.Ашигт малтмал бүхий талбайд барилга байгууламж дур мэдэн барьсан, эсхүл газар доорх усны горимыг ашиглах цооног, геодези, маркшейдерийн тэмдгийг устгасан, эсхүл гэмтээсэн бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.12. татварын улсын байцаагч 7.10	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.10 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7 дахь хэсэг	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч 7.10 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 5.1 дэх заалт, 8 дахь хэсэг	~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
3.Газрын хэвлийд геологийн судалгаа хийх журам, шаардлагыг зөрчсөн нь хайгуул хийсэн ашигт малтмалын нөөцийг буруу үнэлэх, ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барилга байгууламж барих нөхцөлийг буруу тодорхойлоход хүргэсэн бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.12. татварын улсын байцаагч 7.10	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.10 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7 дахь хэсэг	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч 7.10 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 5.1 дэх заалт, 8 дахь хэсэг	~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
4.Газрын хэвлийг: 4.1.ашиглах явцад эвдэрсэн газрыг аюул осолгүй болгож цаашид ашиглаж болохуйцаар засаж тохижуулаагүй;	6.12. татварын улсын байцаагч 7.10	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.10 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7 дахь хэсэг		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
4.2.ашиглах үед илэрсэн үнэт металл, үнэт чулуу, шинжлэх ухаан, түүх, соёлын үнэт зүйлийг зохих байгууллагад мэдэгдээгүй;	6.12. татварын улсын байцаагч 7.10	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.10 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7 дахь хэсэг		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
4.3.ашиглах үед илэрсэн үнэт металл, үнэт чулуу, шинжлэх ухаан, түүх, соёлын үнэт зүйлийг улсад тушаах хуульд заасан шаардлагыг биелүүлээгүй;	6.12. татварын улсын байцаагч 7.10	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.10 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7 дахь хэсэг		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~

Зөрчлийн тухай хуулийн зүйл, хэсэг, заалт	Зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтан			
4.4.ашиглах үед түүнийг хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хураах хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.12. татварын улсын байцаагч 7.10	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.10 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7 дахь хэсэг		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
5.Ашигт малтмал олборлох, эрдэс түүхий эдийг боловсруулах, ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барих барилга байгууламжийн:	6.12. татварын улсын байцаагч 7.10	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.10 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7 дахь хэсэг		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
5.1.зураг төсөл зохиох;		6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.10 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7 дахь хэсэг	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч 7.10 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 5.1 дэх заалт, 8 дахь хэсэг	~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
5.2.тэдгээрийг барих, ашиглалтад оруулах талаар хуульд заасан шаардлагыг зөрчсөн хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.12. татварын улсын байцаагч 7.10	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.10 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7 дахь хэсэг		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
6.Газрын хэвлийг ашиглах аюулгүй ажиллагааны дүрэм, хэм хэмжээг зөрчсөн бол хүнийг гучин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.12. татварын улсын байцаагч 7.10	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.10 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7 дахь хэсэг		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~

Зөрчлийн тухай хуулийн зүйл, хэсэг, заалт	Зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтан			
7.Газрын хэвлийг хамгаалах журам, түүнийг ашиглахад үүсч болзошгүй аюул осол, хортой нөлөөнөөс ажиллагчид, хүн ам болон мал, ан амьтан, байгаль орчин, барилга байгууламжийг хамгаалах шаардлагыг биелүүлээгүй бол хүнийг гучин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.12. татварын улсын байцаагч 7.10	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.10 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7 дахь хэсэг		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
8.Ашигт малтмалын ордыг гэмтээж сүйтгэсэн, баялаг хэсгийг нь сорчлон олборлосон, эсхүл ашигт малтмалын балансын нөөцийг зохистой ашиглах шаардлагыг зөрчсөн, олборлох үед ашигт малтмалын хаягдал, бохирдлыг тогтоосон хэм хэмжээнээс хэтрүүлсэн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.12. татварын улсын байцаагч 7.10		6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч 7.10 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 5.1 дэх заалт, 8 дахь хэсэг	~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
7.11 дүгээр зүйл.Ашигт малтмалын тухай хууль зөрчих 1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч олборлосон ашигт малтмалын хэмжээг нуун дарагдуулсан, эсхүл энэ зорилгоор хуурамч гэрээ байгуулсан, эсхүл үндэслэлгүй бага үнээр борлуулж борлуулалтын орлогыг санаатайгаар бууруулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.12. татварын улсын байцаагч 7.11	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
2.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь: 2.1.ашигт малтмал эрэх, хайх, ашиглахдаа хүлээх нийтлэг үүргийг биелүүлээгүй;	6.12. татварын улсын байцаагч 7.11	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
2.2.хайгуулын, ашиглалтын талаар хуульд заасан мэдээ, тайлан, төлөвлөгөөг хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл хуурамч мэдээ, тайлан гаргасан бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. */Энэ заалтыг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./*	6.12. татварын улсын байцаагч 7.11	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~

Зөрчлийн тухай хуулийн зүйл, хэсэг, заалт	Зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтан			
~~2.3.тусгай зөвшөөрлийн талбайгаас хэтрүүлэн үйл ажиллагаа явуулсан бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.~~ */Энэ заалтыг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./*	6.12. татварын улсын байцаагч 7.11	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
3.Үнэт металл, эрдэнийн чулууны сорьц, чанарыг тогтоолгох, эсхүл бүртгүүлэх журам зөрчсөн бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.12. татварын улсын байцаагч 7.11	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
4.Хайгуулын талбайгаас авсан дээж, сорьц, анхдагч материалыг санаатайгаар устгасан бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.12. татварын улсын байцаагч 7.11	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
5.Ашигт малтмалын балансын нөөцийг зохистой ашиглах шаардлагыг зөрчсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. */Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./*	6.12. татварын улсын байцаагч 7.11	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
6.Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг зохицуулах талаар тогтоосон журам зөрчсөн бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.12. татварын улсын байцаагч 7.11	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
7.Тусгай зөвшөөрөлгүй хүн, хуулийн этгээд хуулиар тогтоосон журам зөрчиж байгалийн үнэт, эсхүл өнгөт чулууг: 7.1.олборлосон;	6.12. татварын улсын байцаагч 7.11	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
7.2.худалдсан;	6.12. татварын улсын байцаагч 7.11	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
7.3.худалдан авсан;	6.12. татварын улсын байцаагч 7.11	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~

Зөрчлийн тухай хуулийн зүйл, хэсэг, заалт	Зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтан			
7.4.тээвэрлэсэн;	6.12. татварын улсын байцаагч 7.11	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
7.5.хадгалсан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. */Энэ заалтад 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./*	6.12. татварын улсын байцаагч 7.11	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
7.12 дугаар зүйл.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль зөрчих 1.Тусгай зөвшөөрөлгүй хүн, хуулийн этгээд: 1.1. түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул хийсэн;	6.12. татварын улсын байцаагч 7.12	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
1.2. түгээмэл тархацтай ашигт малтмал олборлосон, эсхүл борлуулсан;	6.12. татварын улсын байцаагч 7.12	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
1.3. ашигт малтмалын орд ашигласан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.12. татварын улсын байцаагч 7.12	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
2.Хуульд заасан мэдээ, тайлан, төлөвлөгөөг хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл хуурамч мэдээ, тайлан гаргасан бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.12. татварын улсын байцаагч 7.12	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлэхэд нь хууль бусаар саад учруулсан бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.12. татварын улсын байцаагч 7.12	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~

Зөрчлийн тухай хуулийн зүйл, хэсэг, заалт	Зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтан			
4.Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуульд заасан нийтлэг үүргийг биелүүлээгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. Тайлбар: Энэ зүйлд заасан зөрчлийг үйлдсэн бол эрх бүхий улсын байцаагч тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ашигт малтмал хайх, ашиглах үйл ажиллагааг хоёр сар хүртэл хугацаагаар зогсоох ба энэ хугацаанд зөрчлийг засаагүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг энэ хуульд заасны дагуу цуцлах тухай асуудлыг тухайн тусгай зөвшөөрлийн талбай оршиж байгаа аймаг, нийслэлийн эрх бүхий албан тушаалтанд гаргана.	6.12. татварын улсын байцаагч 7.12	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
7.13 дугаар зүйл.Газрын тосны тухай хууль зөрчих 1.Төрийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулаагүй этгээд эрлийн ажил хийсэн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.12. татварын улсын байцаагч 7.13	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
2.Хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулахыг хориглосон, хязгаарласан газар нутагт газрын тосны хайгуул, эсхүл олборлолтын үйл ажиллагаа явуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож хүнийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.12. татварын улсын байцаагч 7.13	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
3.Гэрээлэгч хөрөнгө оруулалт, өмчлөлтэй холбоотой аливаа мэдээллийг Монгол Улсын Засгийн газрын хүсэлтээр гарган өгөх үүргээ биелүүлээгүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.12. татварын улсын байцаагч 7.13	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч	6.41. газрын тос, хийн хяналтын улсын байцаагч 7.13 дугаар зүйлийн 3, 7, 8 дахь хэсэг, 16.5 дахь заалт	~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
4.Эрэл, хайгуул, ашиглалтын ажлын тайлан, холбогдох баримт бичгийн хувийг хуульд заасны дагуу төрийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгөх үүргээ биелүүлээгүй бол тухайн тайлан, баримт бичгийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.12. татварын улсын байцаагч 7.13	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~

Зөрчлийн тухай хуулийн зүйл, хэсэг, заалт	Зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтан			
5.Тусгай зөвшөөрөл эзэмшигч мэдээ, тайлан, төлөвлөгөөг хууль, журам, гэрээнд заасан хугацаанд гаргаж өгөөгүй, эсхүл хуурамч мэдээ, тайлан гаргасан бол тухайн тайлан, баримт бичгийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.12. татварын улсын байцаагч 7.13	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
6.Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч олборлолтын туршилтын хугацааг хэтрүүлж олборлолт явуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.12. татварын улсын байцаагч 7.13	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
7.Тусгай зөвшөөрөл эзэмшигч олборлосон газрын тосны хэмжээг нуун дарагдуулсан, эсхүл хөрөнгө оруулалтын зардлыг зохиомлоор өсгөсөн, эсхүл энэхүү зорилгоор хуурамч гэрээ байгуулсан, эсхүл үндэслэлгүй бага үнээр борлуулж борлуулалтын орлогыг санаатайгаар бууруулсан, эсхүл бууруулахыг завдсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хуулийн этгээдийг тухайн хугацаанд олсон орлогын 50 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно	6.12. татварын улсын байцаагч 7.13	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч	6.41. газрын тос, хийн хяналтын улсын байцаагч 7.13 дугаар зүйлийн 3, 7, 8 дахь хэсэг, 16.5 дахь заалт,	~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
8.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч дотоодын боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах үүргээ биелүүлээгүй, эсхүл биелүүлэхээс санаатайгаар зайлсхийсэн бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.12. татварын улсын байцаагч 7.13	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч	6.41. газрын тос, хийн хяналтын улсын байцаагч 7.13 дугаар зүйлийн 3, 7, 8 дахь хэсэг, 16.5 дахь заалт,	~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
9.Тусгай зөвшөөрөл эзэмшигч хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулахдаа:	6.12. татварын улсын байцаагч 7.13	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
9.1.өөрийн үйл ажиллагаанд шаардагдах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, туслан гүйцэтгэгч сонгохдоо Монгол Улсад бүртгэлтэй татвар төлөгч аж ахуйн нэгжид тэргүүн ээлжид давуу эрх олгох;	6.12. татварын улсын байцаагч 7.13	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
9.2.хөрөнгө оруулалт, борлуулалтын орлоготой холбоотой гүйлгээг Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэх ба уг гүйлгээг санхүүгийн тайланд ил тод, нээлттэй бүрэн тусгах;	6.12. татварын улсын байцаагч 7.13	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~

Зөрчлийн тухай хуулийн зүйл, хэсэг, заалт	Зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтан			
9.3.үйл ажиллагаандаа дэвшилтэт технологи нэвтрүүлэх, Монгол Улсын иргэн-мэргэжилтэн, мэргэжлийн ажилтныг ажилд авах, сургах, дадлагажуулах, газрын тосны салбарт хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа, үр дүнг олон нийтэд таниулахад төрийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах;	6.12. татварын улсын байцаагч 7.13	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
9.4.ижил төрлийн ажил хөдөлмөр эрхлэгч гадаад, дотоодын ажилтны цалин, урамшууллыг тэгш тогтоох, ажилтны хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах;	6.12. татварын улсын байцаагч 7.13	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
~~9.5.төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлгүйгээр хайгуул, ашиглалттай холбогдсон анхдагч, үр дүнгийн тайлан, материалыг гуравдагч этгээдэд дамжуулахгүй байх үүргийг зөрчсөн бол хүнийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.~~ */Энэ заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./*	6.12. татварын улсын байцаагч 7.13	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
10.Хайгуулын ажлын дээж, сорьц, чулуун дээж, анхдагч материалыг үрэгдүүлсэн, эсхүл устгасан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.12. татварын улсын байцаагч 7.13	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
11.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулсан бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.12. татварын улсын байцаагч 7.13	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
12.Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуульд заасан журмын дагуу талбайн хилийн шав тэмдэг тавиагүй, эсхүл шав тэмдгийг шилжүүлэн байрлуулаагүй бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.12. татварын улсын байцаагч 7.13	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
13.Тусгай зөвшөөрөл эзэмшигч үйл ажиллагаандаа 13.1.зөвшөөрөлгүйгээр химийн хорт бодис, бэлдмэл хэрэглэсэн;	6.12. татварын улсын байцаагч 7.13	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.13 дугаар зүйлийн 13 дахь хэсэг, 16.1, 16.3, 16.4, 16.8, 16.10 дахь заалт	~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~

ХАВСРАЛТ

Зөрчлийн тухай хуулийн зүйл, хэсэг, заалт	Зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтан			
13.2.хуулиар хориглосон химийн хорт бодис, бэлдмэл хэрэглэсэн;	6.12. татварын улсын байцаагч 7.13	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.13 дугаар зүйлийн 13 дахь хэсэг, 16.1, 16.3, 16.4, 16.8, 16.10 дахь заалт,	~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
13.3.химийн хорт бодис, бэлдмэлийг хэрэглэхдээ тогтоосон технологийн горим, дүрэм, журмыг дагаж мөрдөөгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.12. татварын улсын байцаагч 7.13	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.13 дугаар зүйлийн 13 дахь хэсэг, 16.1, 16.3, 16.4, 16.8, 16.10 дахь заалт	~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
14.Гэрээлэгч хуульд заасан хугацаанд хөтөлбөр, төсвөө батлуулаагүй бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.12. татварын улсын байцаагч 7.13	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
15.Гэрээнд заасан хайгуулын ажлын доод хэмжээг гүйцэтгээгүй бол хүнийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.12. татварын улсын байцаагч 7.13	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
16.Гэрээлэгч: 16.1.байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ бүрэн гүйцэд биелүүлэх;	6.12. татварын улсын байцаагч 7.13	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.13 дугаар зүйлийн 13 дахь хэсэг, 16.1, 16.3, 16.4, 16.8, 16.10 дахь заалт	~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
16.2.хайгуул, ашиглалтын барилга байгууламжийг татан буулгах баталгаа болгон тухайн жилийн хайгуулын ажлын хөрөнгө оруулалтын 3 хувь, ашиглалтын үед гэрээлэгчид ногдох ашигт газрын тосны 1 хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгийг жил бүр төлөвлөгөө батлагдсанаас хойш 60 хоногийн дотор Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг банкны эскроу дансанд байршуулах	6.12. татварын улсын байцаагч 7.13	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
16.3.байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг стандартын дагуу бүрэн хийж дуусгах;	6.12. татварын улсын байцаагч 7.13	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.13 дугаар зүйлийн 13 дахь хэсэг, 16.1, 16.3, 16.4, 16.8, 16.10 дахь заалт	~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~

Зөрчлийн тухай хуулийн зүйл, хэсэг, заалт	Зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтан			
16.4.хайгуул, ашиглалтын барилга байгууламжийг татан буулгах ажлын зардлыг гаргах;	6.12. татварын улсын байцаагч 7.13	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.13 дугаар зүйлийн 13 дахь хэсэг, 16.1, 16.3, 16.4, 16.8, 16.10 дахь заалт	~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
16.5.хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд шаардагдах автомашин, техник, тоног төхөөрөмж, материал түүхий эд, сэлбэг хэрэгсэл, газрын тосны бүтээгдэхүүнийг импортлохдоо тэдгээрийн нэр төрөл, тоо хэмжээ, нэгж үнийн мэдээлэл, Монгол Улсын нутаг дэвсгэрт барьж байгуулах барилга байгууламжийн зураг төсөл, техникийн баримт бичгийг төрийн захиргааны байгууллагад гаргаж өгөх;	6.12. татварын улсын байцаагч 7.13	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч	6.41. газрын тос, хийн хяналтын улсын байцаагч 7.13 дугаар зүйлийн 3, 7, 8 дахь хэсэг, 16.5 дахь заалт	~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
	6.11. гаалийн улсын байцаагч 7.13 дугаар зүйлийн 16.5 дахь заалт,		6.38. барилгын техникийн хяналтын улсын байцаагч 7.13 дугаар зүйлийн 16.5 дахь заалт	
16.6.газрын тосны нөөцийн хөдөлгөөний тооцоог жил бүр гаргаж төрийн захиргааны байгууллагаар хянуулах;	6.12. татварын улсын байцаагч 7.13	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
16.7.үйл ажиллагааных нь явцад түүх, соёлын олдвор, эд өлгийн зүйл илэрсэн тохиолдолд тухайн газарт явуулж байгаа үйл ажиллагаагаа зогсоож холбогдох байгууллагад даруй мэдэгдэх;	6.12. татварын улсын байцаагч 7.13	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
16.8. ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчныг хамгаалах;	6.12. татварын улсын байцаагч 7.13	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.13 дугаар зүйлийн 13 дахь хэсэг, 16.1, 16.3, 16.4, 16.8, 16.10 дахь заалт	~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
16.9. орон нутгийн хөгжилд сайн дурын үндсэн дээр дэмжлэг үзүүлэх асуудлыг тусгасан гэрээг тухайн тусгай зөвшөөрлийн талбай орших сум, дүүргийн Засаг даргатай байгуулж ажиллах;	6.12. татварын улсын байцаагч 7.13	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~

ХАВСРАЛТ

Зөрчлийн тухай хуулийн зүйл, хэсэг, заалт	Зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтан			
16.10. газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад байгаль орчин, нөхөн сэргээлт, хайгуул, ашиглалтын барилга байгууламжийг татан буулгах асуудлаар тогтмол мэдээлэх үүрэг бүхий ажилтантай байх;	6.12. татварын улсын байцаагч 7.13	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.13 дугаар зүйлийн 13 дахь хэсэг, 16.1, 16.3, 16.4, 16.8, 16.10 дахь заалт	~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
16.11.техникийн осол, саатал, алдагдал урт хугацаанд үргэлжлэн санхүүгийн хүнд байдалд орсон нь тогтоогдсон, эсхүл шүүхийн шийдвэр болон улсын байцаагчийн актаар үйл ажиллагааг зогсоосон, эсхүл давагдашгүй хүчин зүйл, бусад шалтгаанаар хайгуул, бүтээн байгуулалт, ашиглалт, экспортын үйл ажиллагааг зогсоохдоо газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад урьдчилан мэдэгдэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гучин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.12. татварын улсын байцаагч 7.13	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
7.14 дүгээр зүйл.Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль зөрчих				
1.Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулиар хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.41. газрын тос, хийн хяналтын улсын байцаагч 7.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6.42. геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч 7.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
2.Газрын тосны бүтээгдэхүүнийг: 2.1. импортлох;	6.11. гаалийн улсын байцаагч 7.14 дүгээр зүйлийн 2.1			
2.2. үйлдвэрлэх;	6.41. газрын тос, хийн хяналтын улсын байцаагч 2.2, 2.3, 2.4, 2.5			~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
2.3. худалдах;	6.41. газрын тос, хийн хяналтын улсын байцаагч 2.2, 2.3, 2.4, 2.5			~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~

Зөрчлийн тухай хуулийн зүйл, хэсэг, заалт	Зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтан			
2.4. тээвэрлэх;	6.41. газрын тос, хийн хяналтын улсын байцаагч 2.2, 2.3, 2.4, 2.5			~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
2.5. хадгалах техник, технологи болон аюулгүй ажиллагааг хангахтай холбогдсон стандарт, дүрэм, нормыг биелүүлээгүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.41. газрын тос, хийн хяналтын улсын байцаагч 2.2, 2.3, 2.4, 2.5			~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
3.Тусгай зөвшөөрөлгүйгээр: 3.1.газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн;	6.41. газрын тос, хийн хяналтын улсын байцаагч 3.1, 3.3 дахь заалт			~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
3.2.бүх төрлийн шатахуун, тусгай шингэн, шатдаг хийг импортолсон; /Энэ заалтад 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./	6.11. гаалийн улсын байцаагч 7.14 дүгээр зүйлийн 3.2			
3.3. жижиглэнгийн, эсхүл бөөний худалдаа эрхэлсэн бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. Тайлбар: Энэ зүйлд заасан зөрчлийг үйлдсэн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хураах, зөрчлийг арилгах хүртэл үйл ажиллагааг түр зогсооно.	6.41. газрын тос, хийн хяналтын улсын байцаагч 3.1, 3.3 дахь заалт			~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
7.15 дугаар зүйл.Усны тухай хууль зөрчих 1.Хуульд заасны дагуу: 1.1. усыг зөвшөөрөл авснаас өөр зориулалтаар ашигласан;	6.27. улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч 7.15 дугаар зүйл	6.59.эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч 1.1, дэх заалт	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.15 дугаар зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсэг, 5.2, 5.3 дахь заалт, 6, 7, 8, 9 дэх хэсэг	~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
1.2. цооног өрөмдөх зөвшөөрөлгүйгээр газрын доорх усыг ашигласан;	6.27. улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч 7.15 дугаар зүйл		6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.15 дугаар зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсэг, 5.2, 5.3 дахь заалт, 6, 7, 8, 9 дэх хэсэг	~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~

Зөрчлийн тухай хуулийн зүйл, хэсэг, заалт	Зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтан			
1.3. ус ашиглахад тавигдах нөхцөлийг хангуулахаар төрийн албан хаагчийн тавьсан шаардлагыг биелүүлээгүй;	6.27. улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч 7.15 дугаар зүйл		6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.15 дугаар зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсэг, 5.2, 5.3 дахь заалт, 6, 7, 8, 9 дэх хэсэг	~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
1.4. ус ашиглагчийн үүрэг, тавигдах шаардлагыг биелүүлээгүй;	6.27. улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч 7.15 дугаар зүйл		6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.15 дугаар зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсэг, 5.2, 5.3 дахь заалт, 6, 7, 8, 9 дэх хэсэг	~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
1.5. усны эх үүсвэрийн онцгой, эсхүл энгийн хамгаалалтын бүс, эсхүл эрүүл ахуйн бүсийн дэглэмийг зөрчсөн;	6.27. улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч 7.15 дугаар зүйл	6.59.эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч 1.5 дахь заалт	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.15 дугаар зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсэг, 5.2, 5.3 дахь заалт, 6, 7, 8, 9 дэх хэсэг	~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
1.6.ашиглаж дууссан цооногоо битүүмжилж хүлээлгэн өгөөгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.27. улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч 7.15 дугаар зүйл		6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.15 дугаар зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсэг, 5.2, 5.3 дахь заалт, 6, 7, 8, 9 дэх хэсэг	~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
2.Ус ашиглах зөвшөөрлийг бусдад худалдсан, эсхүл бусдад шилжүүлсэн, эсхүл усыг үйлдвэрлэлийн зориулалтаар зохих гэрээ, зөвшөөрөлгүйгээр, эсхүл гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашигласан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.27. улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч 7.15 дугаар зүйл		6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.15 дугаар зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсэг, 5.2, 5.3 дахь заалт, 6, 7, 8, 9 дэх хэсэг	~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~

Зөрчлийн тухай хуулийн зүйл, хэсэг, заалт	Зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтан			
3.Усны эх, ундаргын онцгой хамгаалалтын бүсэд хориглосон үйл ажиллагаа явуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.27. улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч 7.15 дугаар зүйл	6.59.эрүүл ахуй, халдвар хамгаллын хяналтын улсын байцаагч 3 дахь хэсэг	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.15 дугаар зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсэг, 5.2, 5.3 дахь заалт, 6, 7, 8, 9 дэх хэсэг	~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
4.Гол, мөрний урсацын байгалийн үндсэн голдирлыг өөрчилсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.27. улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч 7.15 дугаар зүйл		6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.15 дугаар зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсэг, 5.2, 5.3 дахь заалт, 6, 7, 8, 9 дэх хэсэг	~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
5.Хуульд заасан: 5.1.усны сан бүхий газарт энгийн хамгаалалтын бүс, эсхүл эрүүл ахуйн бүс тогтоох шаардлага биелүүлэх;	6.27. улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч 7.15 дугаар зүйл	6.59. эрүүл ахуй, халдвар хамгаллын хяналтын улсын байцаагч 5.1 дэх заалт		~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
5.2.усны тоо бүртгэл, эрэл, хайгуул, судалгааны тайлан, хяналт-шинжилгээний дүн мэдээ, ус ашиглалтын бүртгэл, хаягдал усны бүртгэлийг хугацаанд нь явуулах;	6.27. улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч 7.15 дугаар зүйл		6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.15 дугаар зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсэг, 5.2, 5.3 дахь заалт, 6, 7, 8, 9 дэх хэсэг	~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
5.3.тайлан, мэдээг гаргаж өгөх журам зөрчсөн бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.27. улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч 7.15 дугаар зүйл		6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.15 дугаар зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсэг, 5.2, 5.3 дахь заалт, 6, 7, 8, 9 дэх хэсэг,	~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~

Зөрчлийн тухай хуулийн зүйл, хэсэг, заалт	Зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтан			
6.Рашааны эх үүсвэрийн хамгаалалтын бүс, хязгаарлалтын бүс, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг зөрчсөн, эсхүл эдгээр бүсэд хориглосон үйл ажиллагаа явуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.27. улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч 7.15 дугаар зүйл	6.59.эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч 6 дахь хэсэг	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.15 дугаар зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсэг, 5.2, 5.3 дахь заалт, 6, 7, 8, 9 дэх хэсэг	~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
7.Рашааныг: ~~7.1.гэрээ, эсхүл зөвшөөрөлгүй ашигласан;~~ */Энэ заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./*	6.27. улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч 7.15 дугаар зүйл		6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.15 дугаар зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсэг, 5.2, 5.3 дахь заалт, 6, 7, 8, 9 дэх хэсэг	~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
7.2.горимын хэмжээнээс хэтрүүлэн гэрээгүйгээр ашигласан;	6.27. улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч 7.15 дугаар зүйл		6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.15 дугаар зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсэг, 5.2, 5.3 дахь заалт, 6, 7, 8, 9 дэх хэсэг	~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
7.3. зориулалтыг дур мэдэн өөрчилсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.27. улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч 7.15 дугаар зүйл		6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.15 дугаар зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсэг, 5.2, 5.3 дахь заалт, 6, 7, 8, 9 дэх хэсэг	~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
8.Усны сан бүхий газарт хог хаягдал хаясан, эсхүл машин техник, бохир зүйл угаасан, эсхүл усны нөөцийг бохирдохоос хамгаалах үүргээ биелүүлээгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.27. улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч 7.15 дугаар зүйл	6.8. цагдаагийн байгууллагын эрх бүхий албан хаагч 7.15 дугаар зүйлийн 8 дахь хэсэг	6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.15 дугаар зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсэг, 5.2, 5.3 дахь заалт, 6, 7, 8, 9 дэх хэсэг	6.59.эрүүл ахуй, халдвар хамгаалллын хяналтын улсын байцаагч 8 дахь хэсэг

Зөрчлийн тухай хуулийн зүйл, хэсэг, заалт	Зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтан			
Энэ хэсэгт 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар “хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх” гэснийг “хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх” гэж өөрчлөлт оруулсан бөгөөд 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./				
9.Ус ашигласны төлбөрийг хугацаанд нь төлөөгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.27. улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч 7.15 дугаар зүйл		6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.15 дугаар зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсэг, 5.2, 5.3 дахь заалт, 6, 7, 8, 9 дэх хэсэг	
7.16 дугаар зүйл.Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль зөрчих 1.Ус бохирдуулагчийн тухай болон хаягдал усны хэмжээ, найрлага, бохирдуулах бодисын тухай мэдээллийг нуун дарагдуулсан, эсхүл худал мэдээлэл өгсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.			6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.16 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг	~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
~~2.Зөвшөөрөлгүйгээр, эсхүл зөвшөөрөлгүй цэгт хаягдал ус нийлүүлсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.~~ *Энэ хэсгийг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./*	6.27. улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч 7.16 дугаар зүйлийн 2 дахь хэсэг		6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.16 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг	~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
3.Ус бохирдуулсны төлбөрийг хугацаанд нь төлөөгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.12. татварын улсын байцаагч 7.16 дугаар зүйлийн 3 дахь хэсэг			
7.17 дугаар зүйл.Тусгай хамгаалалттай газар нутагт хориглосон үйл ажиллагаа явуулах 1.Тусгай хамгаалалттай газар нутагт: 1.1.хууль, захиргааны хэм хэмжээний акт, стандарт, дэглэм, горим зөрчсөн;	6.27. улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч		6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.17	~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~

Зөрчлийн тухай хуулийн зүйл, хэсэг, заалт	Зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтан			
1.2.менежментийн төлөвлөгөөнд тусгагдаагүй үйл ажиллагаа явуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гучин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.27. улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч		6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.17	~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
2.Тусгай хамгаалалттай газар нутагт хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6.27. улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч		6.37. байгаль орчны хяналтын улсын байцаагч 7.17	~~6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч~~
7.18 дугаар зүйл.Генетик нөөцийн тухай хууль зөрчих */Энэ зүйлийг 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн./*				
1.Хуульд заасныг зөрчиж:*/Энэ хэсгийг 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн./* 1.1.генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг тусгай зөвшөөрөлгүйгээр ашигласан;*/Энэ заалтыг 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн./*				
1.2.генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг бусдад дамжуулсан, худалдсан бол зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хурааж, хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна./*Энэ заалтыг 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн./*				
2.Хуульд заасан: */Энэ хэсгийг 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн./* ~~2.1.генетик нөөцийг хилээр нэвтрүүлэхдээ зөвшөөрөл авах;~~ */Энэ заалтыг 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн./* */Энэ заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./*				
2.2.генетик нөөцийг хилээр нэвтрүүлэхдээ генетик нөөцийн биет, эсхүл сорьцын ижил хувийг генийн санд хадгалуулах үүргээ биелүүлээгүй бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг найман мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно./*Энэ заалтыг 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн./*				

Зөрчлийн тухай хуулийн зүйл, хэсэг, заалт	Зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтан			
3.Хуульд заасан:*/Энэ хэсгийг 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн./* 3.1.генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглаж байгаа тухай ажлын тайлан, мэдээгээ хугацаанд нь үнэн зөв гаргаж өгөх;*/Энэ заалтыг 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн./*				
3.2.генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн үнэ цэнэ, үр шимийн талаар эзэмшигчид тайлбарлан таниулах*;/Энэ заалтыг 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн.*/				
3.3. генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэг эзэмшигчийг тогтоох, генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглах урьдчилсан зөвшөөрөл авах журмыг сахин мөрдөх*;/Энэ заалтыг 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн.*/				
3.4.Генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлэх, мэдээллийн нууцыг хадгалах, генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн мэргэжлийн зөвлөлийн дүрмийг сахин мөрдөх үүргээ биелүүлээгүй бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг найман мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торго*но./Энэ заалтыг 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэ*н./				
4.Хуульд заасныг зөрчиж:*/Энэ хэсгийг 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн./*				
4.1.генетик нөөц ашигласны төлбөр, мөнгөн болон мөнгөн бус үр шимийг төлөөгүй;*/Энэ заалтыг 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн.*/				
4.2.генетик нөөцийг ашиглан гаргаж авсан бүтээгдэхүүний борлуулалтын орлогоо мэдүүлээгүй, тоо хэмжээг нуун дарагдуулсан, эсхүл худал мэдүүлсэн;*/Энэ заалтыг 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн./*				
4.3.үр шимийн гэрээнд заасныг зөрчсөн бол хуулийн этгээдийг арван таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно*./Энэ заалтыг 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн.*/				

ХАВСРАЛТ

Хавсралт 2. Байгаль хамгаалагчийн хяналт шалгалт явуулах процесс ажиллагааны талаар хууль тогтоомжоор олгосон эрх хэмжээ

Зөрчлийн тухай хуулиар шалгах зөрчил	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль	Байгаль орчныг хамгаалах тухай хууль	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль	Усны тухай хууль	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
Улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч	Улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч	Байгаль хамгаалагч	Байгаль хамгаалагч	Байгаль хамгаалагч	Байгаль хамгаалагч
7.7 дугаар зүйл. Байгалийн ургамлын тухай хууль зөрчих зөрчлийн 1, 2 дахь хэсэг	1.2.зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх	4) хариуцсан нутаг дэвсгэртээ байгаль орчинд учирч болзошгүй аюулаас сэргийлэх, байгалийн баялгийг хамгаалах арга хэмжээ авах	1/ энэ хууль болон байгаль орчныг хамгаалах бусад хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг таслан зогсоож, гэм буруутай этгээдэд зохих хариуцлага хүлээлгэх	19.1.1.хариуцсан нутаг дэвсгэртээ усны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгах арга хэмжээ авах	8.8.Төсөл хэрэгжүүлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллага нөлөөллийн үнэлгээ хийсэн эсэхэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, ... хяналт тавина.
7.8 дугаар зүйл. Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль зөрчих зөрчлийн 2 дахь хэсэг	1.5. зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааг хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулах	12) хариуцсан нутаг дэвсгэртээ орших гол, мөрөн, нуурт усан замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавих			9.12.Байгаль орчны менежментийн болон уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, ... хяналт тавина
7.9 дүгээр зүйл Ойн тухай хууль зөрчих зөрчлийн 1, 3, 4, 5, 7, 8, 10, 11 дэх хэсэг	5.1 дүгээр зүйл. Эрх хязгаарлах арга хэмжээ 1.1. хүнийг саатуулах		2/ хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих зорилгоор аж ахуйн нэгж, байгууллагад нэвтрэн орох, шалгалт хийх		

7.15 дугаар зүйл. Усны тухай хууль зөрчих зөрчил	1.2. үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох		4/ хууль тогтоомж, хамгаалалтын горимыг зөрчиж байгаль орчинд сөрөг нөлөөлөх үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг түр зогсоох, тэдгээрт хугацаатай үүрэг, даалгавар өгөх, шаардлага тавих		
7.16 дугаар зүйл. Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль зөрчих зөрчлийн 2 дахь хэсэг	1.3. холбогдогчийн баримт бичгийг хураан авах		3/ хууль тогтоомж зөрчсөн сэжиг бүхий иргэний бичиг баримтыг шалгах, түр хураах		
7.17 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутагт хориглосон үйл ажиллагаа явуулах	1.Эрх бүхий албан тушаалтан зөрчлийг шалган тогтоох зорилгоор зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлого, эд зүйл, зөрчил үйлдэхэд ашигласан зэвсэг, хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, уналга, эсхүл зөрчил шалгах ажиллагаанд ач холбогдолтой эд зүйл, баримт бичгийг хураан авна.		Зэвсэг хэрэгсэл, агнасан, түүсэн, бэлтгэсэн зүйлийг хураан авах		
15.2 дугаар зүйл Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд нь саад учруулах 1 дэх хэсэгт заасан зөрчил;	1.Эрх бүхий албан тушаалтан зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг тогтоох зорилгоор үзлэг хийнэ.		Шаардлагатай гэж үзвэл унаа хөсөгт нь үзлэг хийх		
	1.Эрх бүхий албан тушаалтан зөрчил гарсан байдлыг тодруулах, зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдол бүхий баримт, мэдээллийг олох зорилгоор мэдүүлэг авна.				

Хавсралт 3. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны А/189 дүгээр “Байгаль хамгаалагчийг мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр батлах тухай” тушаал ба хавсралтууд

МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2024 оны 03 сарын 29 өдөр Дугаар А/189 Улаанбаатар хот

Байгаль хамгаалагчийг мэргэшүүлэх сургалтын
хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч, аймаг, нийслэл, сум, дүүргийн байгаль хамгаалагч, туслах байгаль хамгаалагч, идэвхтэн байгаль хамгаалагчид зориулсан “Байгаль хамгаалагчийг мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр”-ийг нэгдүгээр хавсралтаар, сургалтад хамрагдсаныг батлах “Гэрчилгээний загвар”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Байгаль хамгаалагчийг мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүрийн ажлын төлөвлөгөөнд тусгах, хэрэгжилтийг хангах, жил бүрийн 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор тайлагнахыг Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлого зохицуулалтын газар (Д.Ганзориг)-т, Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны дарга нар, аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулахад шаардагдах санхүүжилтийг жил бүрийн төсөвт тусгаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Б.Баярмаа)-т, аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга нарт тус тус даалгасугай.

4.Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Т.Гоцбаяр)-т даалгасугай.

Б.БАТ-ЭРДЭНЭ

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
2024 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн
А/189 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧИЙГ МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

НЭГ.СУРГАЛТЫН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь заалт, Байгаль хамгаалагчдын хоёрдугаар чуулганы зөвлөмжийн 1.1, 2.2 дахь заалт болон байгаль орчны салбарын хууль, эрх зүйн орчны шинэчлэл, байгаль хамгаалагчдын дунд явуулсан судалгааны үр дүнг үндэслэн сургалтын хөтөлбөрийг боловсруулла. Тухайлбал, 2023 онд 700 гаруй байгаль хамгаалагчдаас авсан асуулга судалгаагаар, тэдний 90% хууль, эрх зүйн орчны мэдлэг чадвараа сайжруулах, 65% биологийн олон янз байдлын мониторингийн судалгааны арга зүйг эзэмших, 40% галт зэвсэг, бие хамгаалах тусгай хэрэгслийг зүй зохистой хэрэглэх дадал чадварыг эзэмших, 30% нь тухайн орон нутгийнхаа амьтан, ургамлын зүйлүүдийг таньж тодорхойлох, судалгааны багаж хэрэгслийг бүрэн ашиглаж сурах, 20% хэрэг, зөрчил илрүүлсэн тохиолдолд хэргийн газрын үзлэгийг зөв, тодорхой гүйцэтгэх, мөн олон нийттэй харилцах, яриа таниулга хийх зэрэг харилцааны ур чадвараа сайжруулах сонирхолтой байгаагаа илэрхийлсэн байдаг. Иймд олон улсын сайн туршлагаас судалж, энэ бүгдийг өөрийн орны онцлог, нөхцөл байдал, хууль, эрх зүйн орчинтой тусган боловсруулла.

ХОЁР.СУРГАЛТЫН ЗОРИЛГО

Сургалтын хөтөлбөрийн зорилго нь тодорхой үе шаттай, богино хугацааны, системтэй хөтөлбөрөөр байгаль хамгаалагчдын албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүргийг гүйцэтгэхтэй холбоотой практик мэдлэг, ур чадварыг сайжруулж, чадавхжуулахад оршино.

ГУРАВ.СУРГАЛТАД ХАМРАГДАХ АЛБАН ХААГЧИД

Улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч, байгаль хамгаалагч, туслах байгаль хамгаалагч болон идэвхтэн байгаль хамгаалагч нар хамрагдана.

ДӨРӨВ.СУРГАЛТЫН ҮЕ ШАТ, ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА, ДАВТАМЖ

Мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр анхан, дунд, ахисан гэсэн 3 үе шаттай байна. Ажилд анх томилогдож буй байгаль хамгаалагчид анхан шатны сургалтад хамрагдана. Мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр тус бүрийн үргэлжлэх хугацаа 40 цаг буюу ажлын 5 өдрөөс ихгүй байна. Анхан, дунд болон ахисан шатны мэргэшүүлэх сургалтыг жилд нэг удаа зохион байгуулна.

ТАВ.СУРГАЛТЫН ХЭЛБЭР, АРГА ЗҮЙ

Байгаль хамгаалагчийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтыг тухайн орчин нөхцөлд нь оролцооны аргад тулгуурлан дадлага ажил, бодит жишээ, үзүүлэн таниулах материал, хэрэг зөрчлийн тохиолдол дээр хэлэлцүүлэг өрнүүлэх, ярилцах, газрын зураг, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж дээр ажиллуулах зэрэг оролцооны хэлбэрээр зохион байгуулна.

ЗУРГАА. СУРГАЛТЫН ҮНЭЛГЭЭ

Сургалт эхлэхийн өмнөх болон дараах сорилоор байгаль хамгаалагчийг үнэлэх бөгөөд сургалтад хамрагдсан байгаль хамгаалагчид тухайн шатны хөтөлбөрийн агуулгыг

бүрэн эзэмшсэнийг батлах сертификат олгоно. Сорилын үр дүнд анализ хийж хөтөлбөрийг сайжруулах, агуулгад өөрчлөлт оруулах үндэслэл болгон ажиллана.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга нар, Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны дарга байгаль хамгаалагчийн үр дүнгийн гэрээг үнэлэхдээ сургалтад хамрагдсаныг батлах сертификатыг үндэслэн Төрийн албаны зөвлөлийн үр дүнгийн гэрээ дүгнэх журмыг баримтална.

БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧИЙГ МЭРГЭШҮҮЛЭХ АНХАН ШАТНЫ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Үндсэн агуулга	Сургалтын хэлбэр	Цаг	Хэнд хамаарах
Нэг. Байгаль хамгаалагч, түүний ажил үүрэг			
Байгаль хамгаалагч гэж хэн бэ, үнэ цэнэ Байгаль хамгаалагчийн ёс зүйн хэм хэмжээ Байгаль хамгаалагч хүний эрхийг хамгаалагч болох тухай Байгаль хамгаалагчийн эрх үүрэг Байгаль хамгаалагчийн нийгмийн баталга Байгаль хамгаалагчийн албан тушаалын тодорхойлолт, тавигдах шаардлага	Лекц (100%)	6	УБЭБХ БХ ТБХ ИБХ
Хоёр. Байгаль хамгаалагчийн хэрэглэх тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл			
Байгаль хамгаалагчийн нэг бүрийн тусгай хэрэгсэл, тэдгээрийг зөв зохистой ашиглах заавар, зөвлөмж Байгаль хамгаалагчийн хэрэглэх тоног төхөөрөмж, багаж хэрэгслүүд Газрын зургийн төрөл, түүнийг хэрэглэх заавар Луужингаар зүг чиг олох, чиглэл хэмжих заавар Байршил тогтоогч багаж (GPS)-ийн бүтэц, зохион байгуулалт, хэрэглэх заавар Автомат камерын бүтэц, ажиллах зарчим, хэрэглэх заавар Дроны төрөл, бүтэц, ажиллах зарчим, хэрэглэх заавар Гэрэл зургийн аппаратын төрөл, хэлбэр, хэрэглэх заавар	Дадлага (100%)	6	УБЭБХ БХ ТБХ ИБХ
Гурав. Аюулгүй ажиллагаа ба анхны тусламжийн тухай			
Аюулгүй ажиллагааны тухай Анхны тусламжийн хайрцаг, техник Амьтанд хазуулж, хатгуулсан үед үзүүлэх анхны тусламж Ясны хугарал, битүү бэртэл, гэмтлийн үед үзүүлэх анхны тусламж Цус алдах үед үзүүлэх анхны тусламж Ой хээрийн болон орон байрны түймэрт өртөж түлэгдэх үед үзүүлэх анхны тусламж Усанд живсэн хүнд үзүүлэх анхны тусламж Химийн бодист хордох болон химийн бодисын ослын үед үзүүлэх анхны тусламж Цахилгааны ослын үед үзүүлэх анхны тусламж Нүд гэмтэх үед үзүүлэх анхны тусламж Зүрхний даралт өөрчлөгдөх болон зүрхний шигдээсний үед үзүүлэх анхны тусламж Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх	Лекц (30%) Дадлага (70%)	8	УБЭБХ БХ ТБХ ИБХ
Дөрөв. Ажлын зохион байгуулалт, төлөвлөлт, тайлагнал			
Хээрийн судалгааны ажлын зорилго, цар хүрээг тодорхойлж, төлөвлөх Эргүүл хяналтын ажлын зорилго, төрөл, цар хүрээг тодорхойлж, төлөвлөх Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй үйлдлийг бүртгэж тэмдэглэх, мэдээлэх Ажлыг тайлагнах, тайлан бичих заавар, зөвлөмж	Лекц (50%) Дадлага (50%)	4	УБЭБХ БХ ТБХ ИБХ
Тав. Биологийн олон янз байдлын судалгаа, мониторинг (БИОСАН)			

Хөхтөн амьтдын тархац байршил, тоо толгой, нягтшилыг үнэлэх судалгааны арга ○ Цэгэн ажиглалтын арга ○ Шугаман замналын арга ○ Хос ажиглагчийн арга ○ Автомат камерын арга г.м Хээрийн тэмдэглэл хөтлөх, мэдээлэл цуглуулах хуудас бөглөх заавар	Лекц (30%) Дадлага (70%)	6	БХ ТБХ ИБХ
Шувуудын тархац, нягтшилыг үнэлэх судалгааны арга ○ Цэгэн ажиглалтын арга ○ Шугаман замналын арга ○ Дээж талбайн арга г.м Хээрийн тэмдэглэл хөтлөх, мэдээлэл цуглуулах хуудас бөглөх заавар	Лекц (30%) Дадлага (70%)	4	БХ ТБХ ИБХ
Загас, хоёр нутагтан, мөлхөгчдийн тархац, амьдрах орчны сонголт болон нягтшилыг тодорхойлох судалгааны аргууд (дээж талбайн арга, шугаман замналын арга г.м) Хээрийн тэмдэглэл хөтлөх, мэдээлэл цуглуулах хуудас бөглөх заавар	Лекц (30%) Дадлага (70%)	2	БХ ТБХ ИБХ
Байгалийн ургамлын тархац нутаг, ургах орчин, арвийг тодорхойлох судалгааны аргууд (дээж талбайн арга, арвийг тодорхойлох арга г.м) Хээрийн тэмдэглэл хөтлөх, мэдээлэл цуглуулах хуудас бөглөх заавар	Лекц (30%) Дадлага (70%)	4	БХ ТБХ ИБХ
Нийт		**40**	

Тайлбар: Улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч (УБЭБХ), байгаль хамгаалагч (БХ), туслах байгаль хамгаалагч (ТБХ), идэвхтэн байгаль хамгаалагч (ИБХ).

БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧИЙГ МЭРГЭШҮҮЛЭХ ДУНД ШАТНЫ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Үндсэн агуулга	Сургалтын хэлбэр	Цаг	Хэнд хамаарах
Нэг. Байгаль орчны салбарын хууль, эрх зүйн орчин			
Байгаль орчны салбарын бодлого Байгаль орчны салбар дахь олон улсын хамтын ажиллагаа, нэгдэн орсон гэрээ конвенц Байгаль орчны салбарын хууль тогтоомж, эрх зүйн орчин	Лекц (30%) Дадлага (70%)	8	УБЭБХ БХ ТБХ ИБХ
Хоёр. Зэрлэг амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаа			
Зэрлэг амьтан авран хамгаалах үйл ажиллагааны тухай ойлголт Зэрлэг амьтан аварч, асран хамгаалж буй олон улсын сайн туршлага Зэрлэг амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаатай холбоотой Монгол Улсын хууль, эрх зүйн зохицуулалт, багц стандартын тухай Зэрлэг амьтан авран хамгаалагчдын ёс суртахуун ба эзэмшвэл зохих үндсэн мэдлэг, чадвар, дадал Зэрлэг амьтдад үзүүлэх эмнэлгийн анхны тусламж, үйлчилгээ Хөхтөн, шувуу, мөлхөгчид болон хоёр нутагтан амьтдыг аврах, асран хамгаалах	Лекц (50%) Дадлага (50%)	4	УБЭБХ БХ ТБХ ИБХ
Гурав. SMART программын сургалт			
SMART программын үндсэн хэрэглээ, ач холбогдол, танилцуулга SMART программын бүтэц, зохион байгуулалт Газрын зургийг бэлтгэх, нэр оруулж, зураглах SMART программын өгөгдлийн моделиуд, ажиллах зарчим	Лекц (30%) Дадлага (70%)	4	УБЭБХ БХ ТБХ
SMART программын мобайл хувилбарын бүтэц, үүрэг ажиллагаа, холбоос үүсгэх, эргүүлийн хяналтын мэдээг экспорт хийх Тухайн бүс нутагт эргүүл хяналтын ажлыг зохион байгуулах календарчилсан төлөвлөгөө гаргаж, бэлтгэх Тайлангийн загвар, лавлагаа үүсгэх	Лекц (30%) Дадлага (70%)	4	УБЭБХ БХ ТБХ
SMART программыг ашиглан хээрийн эргүүл, мониторингийн ажлыг зохион байгуулах Хээрийн дадлага ажил хийх	Лекц (30%) Дадлага (70%)	8	УБЭБХ БХ ТБХ

Дөрөв. Харилцааны ур чадвар ба хувь хүний хөгжил			
Харилцааны ур чадвар гэж юу? Харилцааны үндсэн ойлголтууд Харилцааны соёл, ёс зүй, зарчим Харилцааны хэлбэр (аман, бичгийн г.м) Гэр бүл болон ажлын байран дахь харилцаа	Лекц (30%) Дадлага (70%)	2	УБЭБХ БХ ТБХ ИБХ
Удирдан, манлайлах чадвар Дотоод, гадаадын түншүүдтэй харилцах арга хэлбэр, зарчим Нутгийн иргэдэд хэрэгцээтэй мэдээллийг бэлтгэж, хүргэх, танилцуулах, ухуулга ярианы аргууд Аман судалгаагаар мэдээлэл цуглуулж, боловсруулах арга техник	Лекц (30%) Дадлага (70%)	2	УБЭБХ БХ ТБХ ИБХ
Сайн зан үйлийг үлгэрлэх, эерэг хандлагатай байх Мэргэжлийн, хүндэтгэлтэй, ёс зүйтэй, хариуцлагатай, хууль ёсны дагуу аюулгүй ажиллах Үр дүнтэй, санаачилгатай ажиллаж, шийдвэр гаргах болон асуудал шийдэхэд оролцох Бусдыг дэмжих, урамшуулах, харилцах, ил тод, шийдэмгий, үнэнч, идэвхтэй байх Хувийн хариуцлага хүлээх, өөрчлөгдөж буй нөхцөл байдалд дасан зохицох зэрэг хувь хүний манлайлах чадварууд	Лекц (30%) Дадлага (70%)	2	УБЭБХ БХ ТБХ ИБХ
Ажлын байрны стресс, түүнийг даван туулах арга, техник Багаар ажиллах, хамтран ажиллах, эелдэг харилцах, анхаарал халамж тавих Хэрүүл маргаанаас зайлсхийх, маргааныг шийдвэрлэх, хамтран ажиллагсадтайгаа маргаан үүсгэхээс урьдчилан сэргийлэх	Лекц (30%) Дадлага (70%)	2	УБЭБХ БХ ТБХ ИБХ
Тав. Хөтөч тайлбарлагч			
Орон нутгийн түүх, соёл, уламжлал, ёс заншил Орон нутгийн чулуун зэвсэг, хүрэл зэвсгийн үеийн онцлох дурсгалууд, булш бунхан, археологийн олдворууд, түүх соёлын дурсгал Байгаль, газарзүйн тогтоц, бүс бүслүүрийн онцлог Нэн ховор, ховор, ховордож буй ургамал, амьтад, тэдгээрийн тархац байршил, амьдралын онцлог Тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн түүх, соёл, байгаль, газарзүйн тогтоц, биологийн олон янз байдлын хамгаалалтын дэглэм, онцлог	Лекц (50%) Дадлага (50%)	4	УБЭБХ БХ ТБХ ИБХ
Нийт		**40**	

Тайлбар: Улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч (УБЭБХ), байгаль хамгаалагч (БХ), туслах байгаль хамгаалагч (ТБХ), идэвхтэн байгаль хамгаалагч (ИБХ).

БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧИЙГ МЭРГЭШҮҮЛЭХ АХИСАН ШАТНЫ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Үндсэн агуулга	**Сургалтын хэлбэр**	**Цаг**	**Хэнд хамаарах**
Нэг. Зөрчил илрүүлэх, шалгах хууль, эрх зүйн үндэслэл, онцлог			
Гэмт хэрэг ба зөрчлийн ялгаа, онцлог Зөрчил илрүүлэх, шалгах хууль зүйн үндэслэл Зөрчлийн тухай хууль, түүний агуулга, зөрчлийн тухай ойлголт, шинж, онцлог Зөрчлийн тухай хуульд заасан зарчим, үйлчлэх нутаг дэвсгэр, хөөн хэлэлцэх хугацаа Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны тухай	Лекц (100%)	3	УБЭБХ БХ
Хоёр. Байгаль орчин, амьтан, ургамлыг хамгаалах журмын эсрэг хэрэг зөрчлийн мэдээлэл цуглуулах, үзлэг хийх арга техник			

Мэдээллийн эх сурвалж, мэдээлэл цуглуулах арга техник Хэргийн газрын үзлэг, арга техник ба аюулгүй ажиллагаа Тээврийн хэрэгсэлд хийх үзлэг, арга техник ба аюулгүй ажиллагаа Галт зэвсэгт хийх үзлэг, арга техник ба аюулгүй ажиллагаа Эд мөрийн баримтад хийх үзлэг, арга техник Шинжилгээ хийлгэх ажиллагаа Мэдүүлэг авах, ярилцлага хийх арга техник Нотлох, хянан шийдвэрлэх ажиллагаа	Лекц (30%) Дадлага (70%)	16	УБЭБХ БХ
Гурав. Байгаль орчин, амьтан, ургамлыг хамгаалах журмын эсрэг зөрчлийн шинж, онцлог, анхаарах асуудал			
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль зөрчих, зөрчлийн шинж, онцлог, анхаарах асуудал	Лекц (30%) Дадлага (70%)	1	УБЭБХ БХ
Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль зөрчих, зөрчлийн шинж, онцлог, анхаарах асуудал	Лекц (30%) Дадлага (70%)	1	УБЭБХ БХ
Агаарын тухай хууль болон Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль зөрчих, зөрчлийн шинж, онцлог, анхаарах асуудал	Лекц (30%) Дадлага (70%)	1	УБЭБХ БХ
Амьтны тухай хууль зөрчих, зөрчлийн шинж, онцлог, анхаарах асуудал	Лекц (30%) Дадлага (70%)	3	УБЭБХ БХ
Байгалийн ургамлын тухай хууль болон Ургамал хамгааллын тухай хууль зөрчих, зөрчлийн шинж, онцлог, анхаарах асуудал	Лекц (30%) Дадлага (70%)	2	УБЭБХ БХ
Ойн тухай хууль зөрчих, зөрчлийн шинж, онцлог, анхаарах асуудал	Лекц (30%) Дадлага (70%)	2	УБЭБХ БХ
Ашигт малтмалын тухай хууль зөрчих, зөрчлийн шинж, онцлог, анхаарах асуудал	Лекц (30%) Дадлага (70%)	3	УБЭБХ БХ
Газрын хэвлийн тухай хууль болон Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль зөрчих, зөрчлийн шинж, онцлог, анхаарах асуудал	Лекц (30%) Дадлага (70%)	1	УБЭБХ БХ
Усны тухай хууль зөрчих, зөрчлийн шинж, онцлог, анхаарах асуудал	Лекц (30%) Дадлага (70%)	3	УБЭБХ БХ
Тусгай хамгаалалттай газар нутагт хориглосон үйл ажиллагаа явуулах, түүний шинж, онцлог, анхаарах асуудал	Лекц (30%) Дадлага (70%)	2	УБЭБХ БХ
Генетик нөөцийн тухай хууль зөрчих, зөрчлийн шинж, онцлог, анхаарах асуудал	Лекц (30%) Дадлага (70%)	2	УБЭБХ БХ
Нийт		**40**	

Тайлбар: Улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч (УБЭБХ), байгаль хамгаалагч (БХ).

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
2024 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн
А/139 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

**БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ**

СЕРТИФИКАТ

№ .....

_____

/овог, нэр/

БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧИЙГ МЭРГЭШҮҮЛЭХ АНХАН ШАТНЫ 40 ЦАГИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДСАН ТУЛ **СЕРТИФИКАТ ОЛГОВ.**

Төрийн нарийн бичгийн дарга .....
/овог, нэр/

.....
/гарын үсэг/

..... он ..... сар ..... өдөр

ХАВСРАЛТ